



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 2



Энэ ертөнцөд Будда, Бодьсадва нар хувилгаан дүрээр залрахдаа Түүний биед зүйл зүйлийн бүхий л хүч дүүрэн агуулагдаж байдаг.

(“Будда бол төгс төгөлдөр гүн билиг ухаан биш”-ээс)



Их Багш нь бидэнд “Жинхэнэ амь нас” өгөх чадвартай байх ёстой бөгөөд биднийг үхэж төрөх сансрын хүрднээс үүрд чөлөөлдөг байх ёстой. Энэ бол “Жинхэнэ Их Багш” юм.

(“Дээд зөвт байдал ба гэгээрлийн хүч Жинхэнэ Их Багшийн дотоодод байдаг”-аас)

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР  
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

Хоёрдугаар боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

## АГУУЛГА

Намтрын өмнөх үг .....	6
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар .....	7
Өмнөх үг .....	10
Будда Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрээгүй .....	11
Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийн Хүч Жинхэнэ Багшийн Дотоодод байдаг (нэг) .....	33
Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийн Хүч Жинхэнэ Багшийн Дотоодод байдаг (хоёр) .....	44
Үхэж, төрөх сансрын хүрднээс туулан гэтлэе гэвэл заавал Арьяабалын бясалгалын аргад найдах хэрэгтэй .....	60
Бясалгал хийхэд хамгийн том харш саад болон Ариун тунгалаг хамаг бодьсадва .....	76
Энэ ертөнцөөс ангижрах үед биднийг зөвхөн үйлийн үр л дагалдана .....	96
Билиг нээгдвэл Бурхан, харанхуй мунхаг бол хамаг төрөлтөн .....	116
Энэтхэг, Хятад, Япон улсын даяаны урсгал яагаад адилгүй байдаг вэ? .....	130
Арьяабалын бясалгалын арга: Дотоодын аялгуу .....	147
Гурван ертөнцийг туулан гэтлэх цорын ганц арга зам .....	161
Хувилгаан бие гэдэг нь тийм ч гайхалтай юм биш .....	177
Ямар хүмүүс төгс баясгалант оронд очиж чадах вэ? .....	193
Веган хоолны ач тус .....	205
Эрүүл мэнд ба хоол хүнс .....	206
Экологи ба хүрээлэн буй орчин .....	209
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд .....	211
Их багш асуултад хариулж байна .....	212
Авшиг хүртэхүй - Арьяабалын бясалгалын арга .....	219
Таван сахил .....	221
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт .....	222
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ? .....	225

## НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар болон энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэгэн бясалгагч Багшийнхаа намтар түүхийг бичихээр томилогджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр нь ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ нээн өгүүлсэн билээ. Энэхүү товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

### Товч Илгээлт

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөгчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэхүү эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

### Хайр Энэрлийн Зам

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн юм. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүүдүүрээр дүүрэн байгааг олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл болон Аялгууг ажиг "Арьяабалын Бясалгалын Арга"-ыг уламжилжээ. Ийнхүү тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк зэрэг таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олонд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл, хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Ноход миний амьдралд”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдаад байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлдээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт манлайллын шагнал”-ыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт шударга үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгчийн шагнал” зэрэг олон цол шагналыг бий болгожээ. Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ийн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн(TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн (НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”,



“Дэлхийн Гэрэлт оюун ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гарга ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

## ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгагай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.

## БУДДА ХАНЬЦАШГҮЙ ҮНЭХЭЭР ТУУЛСАН БОДЬ ХУТАГТ ХҮРЭЭГҮЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй*

*Цаглашгүй гэрэлт бясалгалын төв  
1987 оны 3 дугаар сарын 29*

Өчигдөр багш чинь Жи Лүн-д ном тайлахад нэг хүн: “Бурхан бодьсадва заавал маш их андгай тавьж байж л бурхан болж чаддаг уу? Жишээ нь: газрын зүрхэн бодьсадва (тамын орон хоосртол бурханы хутагт хүрэхгүй) гэж андгайлсан. Авид бурхан хамаг амьтныг гэтэлгэхээр дөчин найман зүйлийн андгай тавьсан” гэж асуусан. Тэр хүн өнөөдөр ном тайлахыг сонсохоор ирээгүй байна. Тэр өдөр ийм асуулт асуухад нь: “Би тун ядарч байна, яримааргүй байна” гэж хариулсан юм. Учир нь урьд нь би аль хэдийн тодорхой ярьчихсан байхад тэр мөн л урьдынхаа асуултыг үргэлж л асуугаад байдаг. Андгайлах нь эгэл хүний үйл хэрэг, бурхан бодьсадва андгайлдаггүй. Урьд нь би их андгай тавьдаг байсан, одоо тэгж зүрхлэхээ больсон. Андгай тавих юу байх вэ дээ, юу хиймээр байна, түүнийгээ л шуудхан хийнэ. Андгайлахгүй. Та нар гэртээ бясалгаж суух үедээ саад төвөг учрах юмуу, хачин байдалд орвол тэр дорхноо: ”Багш аа, түргэн ирж надад туслаач” гэж багшаасаа гуйвал би тэнд суучихаад л эхлээд андгайлах хэрэгтэй юу? Тэгвэл намайг андгайлж дуустал таны байдал бүр ч хүнд хэцүү болох биш үү. Бусдыг аврах үед юу ч бодох хэрэггүй, андгайлах цаг зав хаанаас байх вэ дээ? Гэтэл тэр хүн үүнийг ойлгоогүй юм шиг андгайлах хэрэгтэй юу гэж байнга асуудаг. Газрын зүрхэн бодьсадва бурханы хутагт хүрээгүй байх үедээ тамын орны төрөлтнүүд ихэд зовж байхыг хараад энэрэнгүй сэтгэл төрж, нулимс унаган: “Би бясалгал хийж Мөр (Дао)-ийг олсны дараа лавтай тэр зовлонтой төрөлтнийг гэтэлгэнэ, гэтэлгэж дуусахгүй бол нирваандаа буцахгүй” гэжээ. Арьяабал Бурхан мөн л адилхан, тэрээр гучин хоёр хувилгаан биеэр аливаа төрөлтнийг аварна гэж андгайлжээ, оточ бурхан хамаг төрөлтнийг аврахаар арван хоёр андгай тавьжээ. Авид Бурхан бурхан болоогүй байхдаа хамаг төрөлтнийг аврахаар дөчин найман андгай тавьжээ, гэтэл Будда “Би дөчин найман андгай тавьсан гэдгээ санаж байвал эгэл хүнээс ч дор дэсэдэй болно” гэсэн байдаг.

Тэр хүн бас: “Багш та хамаг төрөлтнийг бүү гэтэлгээрэй гэж яагаад үргэлж ярьдаг юм бэ” гэхэд нь би: “Хамаг төрөлтнийг бүү гэтэлгээрэй гэж ярьсан, та гэтэлгэх дуртай бол гэтэлгэж болно, ямар ч асуудалгүй, гэтэлгэх эсэх нь хувийн хэрэг” гэсэн, тэр хүн багшийн чинь

хэлсэн: “Хамаг төрөлтнийг гэтэлгэхгүй” гэдэг нь “Би хамаг төрөлтнийг гэтэлгэнэ” гэсэн ийм бодолтой байж болохгүй шүү гэсэн утгатайг ойлгоогүй аж, гэтэлгэхэд юу бодож, юу андгайлах хэрэгтэй юм бэ? Энэ нь хооллохтой адил, хоолыг харахаараа иднэ, идэх үедээ андгайлах хэрэг байна уу? Идье гэвэл шууд л иднэ, андгайлмаар юм юу байх вэ дээ, ядарвал унтана, унтахдаа андгайлах цаг зав байхгүй, хамаг төрөлтнийг гэтэлгэх нь маш бачим тулгуу хэрэг тул хоромхон зуур гэтэлгэх хэрэгтэй, юу ч бодоогүй үедээ ч гэсэн гэтэлгэх хэрэгтэй, харин санасан цагтаа л гэтэлгэдэг юм биш, санаж бодсон үедээ л гэтэлгэх гэвэл хамаг төрөлтөн хэдийнээ “баларч дуусчихсан” хэрэг болно шүү. (Бүгд инээлдэв)

Бясалгал маш өндөр төвшинд хүрсний дараа хамаг төрөлтнийг гэтэлгэнэ гэж бодохгүй ч гэсэн тэд аяндаа л гэтэлгэнэ. “Би түүнийг гэтэлгэхээр андгайлж байна” гэж бодох шаардлагагүй, хармагц л аль хэдийн гэтэлгэчихдэг. Түүнийг гэтэлгэхээр андгайлж байгаа бол чамд түүнийг гэтэлгэх хүч чадал байхгүй гэдгээ л илэрхийлж байгаа хэрэг. Энэ хүч чадал нь аяндаа байж төвлөрсөн шугамаар ирдэг ус шиг, цоргыг нь нээмэгц ус аяндаа гарч ирдэг. Ус дамжиж ирэхээс өмнө бид арга бодож, усны суваг малтах юмуу, усны хоолой угсарч байж л устай болно, ус дамжаад ирчихсэний дараа бол юу ч хийх шаардлагагүй, аяндаа л устай болчихно.

Тиймээс багш чинь түүнд: “андгайлбал” (андгайдаа) хүлэгдэнэ, газрын зүрхэн бодьсадва одоо төрөл төрөлдөө тамын оронд, Авид Бурхан төгс баясгалант оронд заларч, хоёулаа “Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрч чадаагүй” гэж хэлсэн билээ. Гэтэл тэр шавь дахин: ”Багш аа, тийм биш байх аа, Авид Бурхан Төгс баясгалант оронд очихоосоо өмнө аль хэдийнээ төгс гэгээрэлд хүрчихсэн” гэв, тэгэхэд би: “Тийм биш ээ, тэд төгс гэгээрэлд хүрээгүй, зөвхөн (Түүнчлэн ирсэн) дэсэд хүрсэн төдий” гэхэд тэр: “Түүнчлэн ирсэн дэс бол төгс гэгээрлийн дэс мөн” гэхэд нь би: “Тийм биш ээ” гэж л хариулсан.

Тэр хүн багшийг нь хятад хэл ойлгодоггүй гэж бодсон болохоор миний ярьсныг сайн ойлгоогүй, үнэндээ би буруу яриагүй, Шагжамуни Бурхан зөвхөн түүнчлэн ирсэн дэсийг олсон төдий, тэр төгс гэгээрлийн хүчийг олсон хэдий ч Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг дэсэд хүрээгүй. Авид Бурхан ч гэсэн Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийн дэсэд хүрээгүй, ном сударт ч түүнийг зөвхөн Бурханы хутгийг л олсон гэж өгүүлсэн байна. Гэвч газрын зүрхэн бодьсадва ч гэсэн бодьсадва болсон төдий, тэр угаас бурхан мөн, одоо бол бодьсадвагийн дэсэд байж, бодьсадвагийн ажлыг хийж байгаа хэрэг. Жишээ нь: Картер бол Америкийн урьдын ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн тушаалаасаа буучихаад одоо өөр ажил хийж байгаа ч байж магад. Газрын зүрхэн бодьсадва бол эрт дээр үеийн бурхан, бясалгал хийж байх үедээ тийм их андгай тавьсан болохоор одоо тамын оронд үлдэх хэрэгтэй болжээ, хэдийгээр тамын оронд байгаа хэдий ч зовиуртай биш, газрын зүрхэн бодьсадва бол энэрэнгүй нигүүлсэнгүй хүч, тамын орноос аврах хүчийг төлөөлж байдаг юм, энэ бол түүний ажил, тэр өөрийн “андгай”-гаасаа болж тэнд хүлэгджээ.

Авид Бурхан бол гэрэл гэгээт хүчний бэлгэдэл, тэр андгай тавьж хамаг төрөлтөнд гэрэл гэгээтэй орныг нээж, хамаг төрөлтөнд тусалж, төгс баясгалант оронд мэндлэхэд нь тусалдаг болохоор хэзээ ч Ханьцашгүй үнэхээр төгс туулсан бодь хутагт хүрэхгүй юм . Арьяабал бодьсадва ч мөн адил, тэр үлэмж нигүүлсэнгүй сэтгэлийг төлөөлж, аливаа төрөлтнийг гэтэлгэж, хамаг төрөлтөн юу хүснэ, түүнийг нь өгдөг. Учир нь тэр хамаг төрөлтөн юу хүснэ, түүнийг нь өгнө гэж андгайлсан болохоор заримдаа өгсөн зүйлс нь хамаг төрөлтний хувьд тийм ч их ач тустай биш байдаг. Жишээ нь: зарим муу санаатай хүн бодьсадвагаас өөрийн дурласан хүнтэйгээ шууд гэрлэх гэж чин сэтгэлээр гуйсны ачаар хүсэл нь биелчихнэ, гэвч тэр охин нь түүнд угаас дургүй болохоор гэрлэсний дараа жаргалтай байж чадахгүй нь мэдээж шүү дээ, бас нэг жишээ: зарим хүн хэдийгээр бясалгал хийдэггүй ч нэг өдөр өлсөж үхмээр болохдоо бодьсадвагаас чин сэтгэлээсээ бага сага ч гэсэн мах соёрхохыг гуйсны ачаар хүсэл нь биелж мэднэ. Гэвч энэ бүхэн нь тэдний хувьд ямар ч ач тусгүй. Арьяабал Бурхан тун нигүүлсэнгүй сэтгэлтэй гэж бид ярьдаг, түүний нигүүлсэнгүй сэтгэл нь хамаг төрөлтөн юу хүснэ, түүнийг нь өгдөг. Оточ Бурхан мөн л ийм, хамаг төрөлтөн юу хүснэ, түүнийг нь өгдөг. Оточ Бурханы сударт хамаг төрөлтөн ховорхон идээ, амтат хоол гуйвал түүнийг нь өгч, дараа нь дахин “алгуураар” үнэн ёс ярьж сонсоно гэж бичсэн байдаг. Гэтэл энэхүү “алгуур” гэдгийг чухам хэдий болтол хүлээх билээ, тоолшгүй асанга галав өнгөртөл хүлээж ч магадгүй. Учир нь Арьяабал Бурхан зовлон зүдгүүрээс аврах хүчийг төлөөлдөг болохоор идэх мах, гэрлэх ураглах, нэр хүнд, ашиг олз олох, эсвэл энэ ертөнцийн эд зүйлс гэх мэтийг гуйвал бүгдийг нь өгч магад. Оточ Манал Бурхан өвчин зовлонгоос аврах хүчийг төлөөлж, хэн нэг хүн өвчин тусаад чин сэтгэлээсээ түүнд гуйж даатгавал зөн билгийг нь мэдрэх болно. Заримдаа эмч өвчтөнийг эмчилж байх үедээ өөрөө төрөлхийн авьяас чадвартай болсон юм шиг байдаг ч үнэндээ бурхан бодьсадвагийн хүч өвчтнийг аварсан байдаг. Эмч зөвхөн бурхан бодьсадвагийн багаж л болсон хэрэг, өвчтөн үнэнхүү чин сэтгэлээсээ бодьсадвагаас аврал гуйсан болохоор оточ бурхан өөрийн хүчээ эмчид дамжуулж, өвчтөнийг түргэн эдгэрүүлдэг, үүнийг эмч мэддэггүй, харин өвчтөнийг эмчилчихлээ л гэж боддог. Тэр ч байтугай заримдаа эмч огт эмчилгээ хийгээгүй байтал харин өвчтөн хэдийнээ эрүүл болчихдог, иймэрхүү тохиолдол тун олон байдаг, тийм биш үү? Учир нь Оточ Бурхан хамаг төрөлтөн зовлонтой болж, чин үнэнээсээ гуйвал, хоромхон зуур ч гэсэн надтай холбогддог л юм бол би өөрийн хүчээ илгээж, түүнийг аварна гэж андгайлсан байдаг. Арьяабал Бурханд даатгавал мөн л ийм, түүний хүч чадал хязгаарлашгүй болохоор хоромхон зуур ч гэсэн холбогдож чаддаг л юм бол хангалттай аварч чадна. Гэвч өөрийн хүчиндээ түшиж бурхан бодьсадватай холбогдох нь тийм ч хялбар биш, иймээс бурхан бодьсадва хувилгаан биеэрээ энэ ертөнцөд залрах хэрэгтэй, тэгээд хэрэв түүнтэй л холбогдож чадвал юу гуйсан ч бүгд л ач тустай юм, гагцхүү төгс баясгалант орны бурхан бодьсадвад даатгавал зөн билигтэй болоход тун ч хялбар биш.

Нэгэн амьд сэрүүн байгаа бодьсадвад зүйл бүрийн хүч байдаг, оточ бурханы хүчтэй, Авид бурханы хүчтэй, Арьяабал бурхан, Очирваань бурхан, Манзушир зэрэг бурханы хүч бүгд байдаг. Тэр бол ерөнхий төлөөлөгч мөн, Гадна талаас нь харахад энгийн хүний бие цогцостой байдаг хэдий ч дотор талд нь харин ямарваа хүч бүгд байдаг. Яг л маш үнэтэй бэлгийг муу баглаа боолтоор боочихсон юм шиг, үнэндээ дотор нь ховор үнэт эрдэнэс дүүрэн байгаа, хэрэв ийм үнэтэй эрдэнэсийг боолтоор боохгүй бол шуудангийн газар хүрэхээс нь өмнө хулгайчид алдаж, юу ч үгүй болно, иймээс боолтоор боож, давхар баталгаат захидалтай илгээх хэрэгтэй, ингэвэл замын дундаас хулгайчид алдахгүй болно.

Бурхан бодьсадва хувилгаан биеэр энэ ертөнцөд залрах үед түүний бие цогцост зүйл бүрийн чадал дүүрэн байдаг, ямар л бол ямар хүч цөм байдаг болохоор багшдаа даатгавал нилээд түргэн, Арьяабал Бурханд даатгавал нилээд удаан байх бөгөөд зөн билиг мэдэгдэхгүй байж ч магад гэдгийг та нар мэддэг. Гэвч багшаасаа сурсны дараа Арьяабал Бурханаас гуйвал бас зөн билиг мэдэгдэнэ, учир нь энэ үед та аль хэдийн арван зүг, гурван цагийн бурхадтай холбогдчихсон болохоор хэнээс нь ч аврал гуйсан тэд бүгд мэддэг. Жишээ нь: та эрх мэдэлтэй, хүч чадалтай сайдтай найзалж, түүнээс тусламж хүсэх шаардлага гарвал утасдмагц туслагчаараа чиний хэргийг шийдвэрлүүлж өгнө, та юу хүссэн ч тэр бусдад түүнийг зарлигдан танд тусална, эсвэл туслагч нь утас авахад би даргын чинь найз гэж ярьсан ч тус болно. Тэр ч байтугай яриагүй ч тэр бас мэдчихнэ, учир нь сайдтай найз болоод маш удчихсан болохоор таныг сайн таньдаг, тун хүндэтгэдэг. Ингэснээр утас авмагц тэр дороо дуугаар чинь таньж, танд туслах болно. Хэрэв сайдыг танихгүй бол тэгж сайн тусалж чадахгүй.

Багшаасаа авшиг хүртсэний дараа бас тэгж бурхан бодьсадвагаас аврал гуйвал маш түргэн зөн билиг мэдэгдэнэ, авшиг хүртэхээс өмнө зөн билгийг мэдрэхэд маш удаан, тэр ч байтугай зөн билиг ер байхгүй, авшиг хүртсэний дараа бол сайдыг таньдагтай адил хэнд ч тусалж болно. Багшид чинь ялгаварлах сэтгэл байхгүй. Жишээ нь: Оточ Бурханд гай барцадыг зайлуулахаар даатгах юмуу, уул усанд мөргөж залбирах, их нигүүлсэнгүй тарни уншвал бүгд ач тустай, гэтэл урьд нь юунд ч мөргөсөн ямар ч тус нэмэргүй байсан. Учир нь энэ хүчтэй аль хэдийн холбогдчихсон болохоор шаардлагатай үед нээмэгцээ л ашиглаж болно.

Анх эхлээд манай энэ ууланд усгүй байжээ, тэр үед усны хоолой байсан ч нээлээ гээд жилийн турш дусал ч ус байгаагүй, хожим нь хэдэн арван мянган төгрөг зарцуулж байж л усны хоолойгоор дамжуулжээ, тиймээс одоо усны цоргыг нээмэгц ус урсаж, ямар ч саваар хэдий чинээ их ус авсан ч болно, тэр ч байтугай бяцхан хүүхдээр ус авчруулж ч болно. Учир нь аль хэдийнээ устай болсон болохоор хэн ирж нээсэн ч болно. Үүнтэй адил, энэ туслах хүч аль хэдийн бий болчихсон болохоор юу ч гуйсан бүгд ач тустай. Арьяабал Бурханаас аврал гуйвал тэр бас туслахаар ирнэ. Гэвч бас багш, багшийн хүч тусалж байгаа юм гэж хэлсэн ч болно. Учир нь танд тусламж хэрэгтэй л бол багшдаа даатгахгүй

ч гэсэн бас тусална. Орчлонгийн систем ийм л байдаг, мэдвэл хэрэглээд барахгүй, мэдэхгүй бол жаахан ч атугай хэрэглэж чаддаггүй, үнэхээр харамсалтай.

Багш чинь Жи Лун-д байх үедээ Арьяабал Бурхан, Авид Бурхан ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагт хараахан хүрээгүй гэж ярьсан чинь тэр хүн мөн л түүнчлэн ирсэн бол Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрсэн гэж ном сударт тэмдэглэсэн байна шүү дээ гэж багштайгаа маргаж мэтгэлцдэг, аль сударт ингэж тэмдэглэснийг би мэдэхгүй. Бурхан Багш. Түүнчлэн ирсэн, Ялж төгс нөхцсөн, Амарлингуй оршигч, Бүхнийг айлдагч, Чадагчийн эрхэт, Ертөнцийг болгоогч, Ханьцашгүй жолоодогч, Төрөлхийтнийг номхотгогч, Тэнгэр хийгээд хүмүүний багш гэсэн 10 зүйлийн хүндэтгэлийн нэртэй. Энд Бурхан Багшийг төгс гэгээрсэн гэж нэрлээгүй, гэтэл мөн л итгэхгүй: “Багш хятад хэл ойлгохгүй байж магад, тиймээс Бурхан Багш төгс гэгээрэлд хүрснийг мэдэхгүй байна” гэж авшигтанд ярьсан байна. Би хэдийгээр хятад хэл ойлгохгүй ч самгарьд хэлийг сайн ойлгоно, самгарьд хэл хятад хэлнээс бүр ч оновчтой. (бүгдээрээ инээлдэв) Хятад хэлээр бичсэн ном судар бүгд л самгарьд хэлнээс орчуулагдсан, зарим нь эхлээд самгарьд хэлнээс түвд хэлээр орчуулагдаж, гурав, дөрвөн гар бичмэл дамжжээ. Үүний зэрэгцээгээр би бас вьетнам, англи, самгарьд хэл судалдаг, ингэвэл нилээд баталгаатай (бүгдээрээ инээлдэв), зөвхөн хятад хэл сурах нь тийм ч найдвартай биш.

Төгс гэгээрэл ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг нь нэг зүйлийн төвшин болохоор Шагжамуни Будда: “Бурханд итгэдэг ч бурханыг ойлгохгүй бол бурханыг гүтгэж байгаа хэрэг” гэжээ. Тэр өөрийгөө оройн дээд төгс гэгээрэл-ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагт хүрсэн гэж яриагүй, “Би сар биш, зөвхөн сарыг заадаг гарын журуу төдий, миний заасан зүгт харвал сарыг харж чадна” маш тодорхой ярьсан байдаг. Сар бол “Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг” мөн, Шагжамуни Будда зөвхөн Бурханы хутагийг олсон төдий. Бурхан багш бол аугаа их Төгс Гэгээрсэн Их Багш мөн, гэвч та ямар ч төвшинд байлаа гэсэн эгэл хүний хувцас өмсөж, хувилгаан биеэрээ энэ ертөнцөд ирдэг л юм бол “Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг” биш болчихно, Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийг олсон хүн эгэл хүний хувцас өмсөж болдоггүй болохоор бууж ирэхдээ эрхбиш бурхан бодьсадва болж хувирах хэрэгтэй. Ингэж байж л хамаг төрөлтнийг гээлгэж чадна, эгэл хүний хувцас өмсвөл ихдээ л Бурхан бодьсадва гэж хэлж болно, харин Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг гэж хэлж болохгүй.

Бид бүгд л Авид Бурханыг шижир алтан биетэй гэж магтдаг, тэр махан биеийн хувцас өмсдөггүй боловч өөрийн биеийн хувцас өмсдөг. Ямар ч хувцас өмссөн бай дуутай, дүрстэй байгаа л бол ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг биш. Авид Бурхан бас нэгэн алтан өнгөтэй бие цогцсоор баруун зүгийн Төгс баясгалант оронд ном тайлж, хамаг төрөлтнийг өөрийн нутаг орондоо дагуулан очдог болохоор зөвхөн дээд дэсийн төрөлтөнд зааж сургадаг дээд дэсийн ертөнцийн багш гэж ярина.

Яг л бага сургуулийн багш, дунд сургуулийн багш, их сургуулийн багш гэж ангилдагтай адил. Авид Бурхан бол эндхийн судалгааны газрын багштай адил, Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрээгүй, мөн хамаг төрөлтнийг гэтэлгэж байгаа бол Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт биш, бясалгал дээшилсний дараа Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийг таньж мэдэх болно. Гэвч Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрэхгүй.

Энэхүү “Мөр” Дао (Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг) хэзээд оршин байдаг, төрөхгүй, үхэхгүй, хиртэхгүй ариусахгүй, арвидахгүй хомсдохгүй. Орчлонгийн хамаг бодис энэхүү “Мөр” (Дао)-өөс ирсэн боловч бид “Мөр” (Дао)-өөс нэгэнт салчихсан болохоор дахин “Мөр” болох боломж байхгүй. Жишээ нь: бяцхан хүүхэд эхийнхээ хэвлийгээс мэндэлсэн боловч хэзээ ч дахин буцаж эхийнхээ биеийн нэг эрхтэн байх боломжгүй, тэр аажмаар өсөж торнино, бие махбод нь эхийнхээ цустай холбоотой хэдий ч дахин буцаж эхийнхээ биеийн эс болох боломжгүй. Үүнтэй адилаар бид хэзээ ч Үнэхээр Туулсан Бодь Хутагт болж чадахгүй, бид зөвхөн танин мэдэж болно, энэ дэс, энэ төвшин, Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийг танин мэдэж болно. Гэвч Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг нь бас нэг зүйлийн багахан дэс юм, бясалгал бол зах хязгааргүй. Хэрвээ нэгэн Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг гэж байдаг бол яг л байшинд дээвэр байдаг шиг зах хязгаартай болж, алгуурхан бясалгах хэрэгтэй болно, тэгэхгүй бол хэзээ нэгэн өдөр бясалгал маань хамгийн дээд Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийн дэсэд хүрэх үед хиймээр ажилгүй болж, тун уйтгартай санагдана (бүгдээрээ инээлдэв), алгуур аажмаар л бясалгах хэрэгтэй болно. Бяцхан хүүхэд чихэр хүлхэхтэй адил алгуур удаан хүлхэх хэрэгтэй, яагаад гэвэл түүнд ганцхан чихэр байгаа болохоор идээд дуусчихвал өөр хүлхэх чихэр байхгүй болно. Тиймээс гартаа атгаж, алгуур аажмаар хүлхэх хэрэгтэй.

Бидний бясалгал ч ийм, хэрэв нэгэн дээвэртэй, жинхэнэ Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийн суудал биднийг дээш гарч суухыг хүлээж байгаа бол одоо алгуурхан бясалгах хэрэгтэй. Учир нь бодьсатва болсны дараа удалгүй бурхны хутагт хүрэх болно, бурхны хутагт хүрсэн дараа удалгүй Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрнэ, тэр үед хийчихмээр ажилгүй болчихно, тэгвэл тун уйтгартай болох биш үү? Бясалгалд зах хязгаар гэж байдаггүй, бясалгал дээшилсний дараа Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг ч хуурмаг болохыг ойлгох болно. Гэвч үүнийг зохистой үгээр дүрслэн илэрхийлэхийн аргагүй болохоор зөвхөн Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг бол хамгийн дээд төвшин гэж л ярьдаг. Ингэж ярьж байгаа нь хамаг төрөлтнийг гэтэлгэхэд хялбар дөхөм болгохын төлөө л юм. Хэрэв тэдэнд бясалгал зах хязгааргүй гээд хэлчихвэл айгаад урам зориггүй болж: “Ийм юм бол чухам хэзээ болтол бясалгаж, хамгийн дээд төвшинд хүрч чадах юм бэ? (бүгдээрээ инээлдэв) за, бясалгахаа больё, дэндүү ядаргаатай юм, би дорхноо амжилтанд хүрч, дорхноо хамгийн дээд зүйл нь юу болохыг нь мэдмээр байна, хэрэв бясалгахад зах хязгааргүй,



хамгийн дээд төвшингүй юм бол би бясалгахгүй” гэж бодох болно.

Хамаг төрөлтөн үнэхээр тун яаруу, бас тун ч их ядарсан болохоор хамаг төрөлтнийг аялдан дагахын төлөө Багш чинь: “Яарах хэрэггүй, удалгүй амжилтанд хүрнэ” гэж ярьдаг. Хэрэв тэд: “Би Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрнэ” гэвэл багш чинь бас: “болно, болно, түргэхэн шиг бясалгавал хүрч чадна” гэж хэлдэг. Учир нь хамаг төрөлтний сэтгэлийн тэнхээ тун сул дорой, тэсвэр тэвчээрээр дутмаг болохоор багш нь: “Зах хязгааргүй, хэлбэр дүрсгүй” (бүгдээрээ инээлдэв) гэж ярьвал тэд сонсонгуутаа дорхноо зориг алдарч, бясалгах дургүй болно. Тэд тийм урт бөгөөд хол, хязгааргүй асанга галавын хэр урт удаан бясалгалын явцыг хүлцэн тэвчиж чадахгүй. Тиймээс бясалгалын явцад нирваан, төгс баясгалант орон зэрэг маш олон оронд та нар амсхийж болно. Тиймээс Шагжамуни Будда та нар төгс баясгалант оронд хүрч алгуур аажмаар бясалгаж болно, тэнд зовлон гэж байхгүй, тун баяр жаргалтай байдаг гэсэн байна. Хамаг төрөлтөн сул дорой болохоор Төгс баясгалант орон байдаг гэдгийг сонсонгуутаа, уухай, Төгс баясгалант оронд хүрч амсхийсэн ч болох юм байна гэдэг.

Би гэрээс гарахаас өмнө мөн л тийм бодолтой байсан, заримдаа ихэд ядарч туйлдана, бясалгах нь тун ч зүдгүүртэй, тун ч ядаргаатай санагдана: “Одоохон ангижирсан ч яахав, намайг сайхан амруулаасай, энэхүү зовлонг ертөнцөөс түр зуур ч гэсэн мултарч чадвал сэтгэл минь ханачихна, эсвэл Төгс баясгалант оронд хүрч бага ч болов амсхийгээд дараа нь дахиад ирсэн ч болно” гэж би өөртэйгээ ярьдаг байсан. Учир нь хүн болох нь үнэхээр зүдгүүртэй учраас горьдлого тасарч, туулан гэтлэхийг хүсэн мөрөөдөж, бусдыг авран туслахыг хүсэн мөрөөдөж, өдөр бүр чармайн бясалгадаг байжээ. Гэсэн ч үр дүн гэмээр зүйл байгаагүй, маани тарни уншсан ч зөн билиг мэдэгдэхгүй, модон бурхантай ярьсан ч хариулт гэмээр юм алга, би түүнийг харна, тэр намайг харна (бүгдээрээ инээлдэв), өдөр бүр царай төрх нь ийм, ямар ч хувиралтгүй, уйлсан ч тэр огт хөдөлдөггүй хэвээрээ, үнэхээр мөс шиг хүйтэн сэтгэлтэй байхад сөхөрч мөргөсний хэрэг юун?

Нэг өдөр би маш их уурлаж, өнөөдөр би мөргөхөө болилоо (бүгдээрээ инээлдэв), маани тарни уншихгүй, даатгаж мөргөхгүй, бясалгаж суухгүй, юу ч хийхгүй гээд модон бурхныг хараад л сууж байлаа. Модон бурхан ч намайг хараад л байлаа (бүгдээрээ инээлдэв), тэр үеэр бурхан бодьсадва надаас айсан байхаа (бүгдээрээ инээлдэв), жаахан зөн билиг мэдрэгдэх болов, би дэндүү их уурласан болохоор жаахан зөн билиг мэдрэгдэх болжээ.

Тэр өдөр би тун их баярлав, учир нь энэ бол гэнэтхэн ирсэн зөн билиг, тухайн үед төгс гэгээрсэн багшийн удирдан дагуулал байгаагүй болохоор яахаа мэдэхгүй айн сандарч: “За одоо боллоо! Надад дэндүү өндөр төвшин хэрэггүй” гэсэн чинь дорхноо унаж, дахиад ямар ч зөн билиг мэдрэгдэхээ больсон. Үнэхээр харамсалтай, хэрэв тэр үеэр Арьяабалын номын цогцосыг бясалгаж байсан бол үргэлжлүүлэн дээш явахад ямар ч асуудалгүйгээ мэдэж байх байсан, гэтэл тэр үед өнчрөн ганцаардаж, унаад далайд живчихвэл төвөг болно гэж тун их санаа зовж,

дахин дээш явж зүрхлээгүй, тиймээс би “за одоо боллоо” гэсэн чинь дорхноо уначихсан.

Өнөөдөр би та нарт Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хэзээ ч хүрч чадахгүй гээд ярьчихлаа, одоо та нарт бясалгая гэж бодогдож байна уу? Уг нь яриагүй нь дээр байсан юм, яривал та нар гэртээ хариад үргэлжлүүлэн бясалгахгүй болж магадгүй. (бүгдээрээ инээлдэв) Санаа зоволтгүй, ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагт хүрч чадна даа чадна, гэвч та нарын дэс чинь өндөр биш болохоор бүрэн дүүрэн ойлгож чадахгүй. Бид Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрээгүй хэдий ч Арьяабалын номын цогцосыг бясалгаж байгаа нь тун ч аз жаргалтай, энэ тоост хорвоод амьдарч байлаа ч гэсэн бясалгал хийж байгаа болохоор маш олон асуудлыг шийдвэрлэж чадна, маш эрх чөлөөтэй амьдарч болно. Мэдээж Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хүрэхэд тийм ч хялбар биш, гэвч бие махбод эрүүл саруул, оюун ухаан баяр баясгалантай байгаа нь бидний нирваан, бидний диваажин юм. Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг болон Будда хоёрын аль нь өндөр вэ гэдэг нь тэр хоёрын хоорондын хэрэг.

Өчигдөр нэг хүн надаас: “Эзэн Бурханы дэс нь өндөр үү? Буддагийн дэс өндөр үү? гэж асуухад нь энэ бол тэр хоёрын хоорондын хэрэг, адилтгах гэвэл бас тэр хоёрын л хэрэг, би мэдэхгүй гэж хариулсан. Хэрэв тэр хоёр хоорондоо адилхан гэвэл бололгүй яахав, хамаарах хэрэггүй. Ингэж асуух нь хүүхэд шиг л байна, тийм үү? үгүй юу? Бясалгаж байгаа мөртлөө ийм асуултаас салж чадахгүй “Чухам Бурханы дэс өндөр үү? Эзэн Бурханы дэс өндөр үү?” гэж байнга мэтгэлцдэг, Эзэн Бурханых өндөр гэж түүнийг хэлэхэд би: “За тийм” гэж хариулдаг, тэгэхэд тэр: “Гэтэл та Бурханых өндөр гэж байнга хэлдэг биш үү” гэсэнд би: “За тийм” гэсэн, чухам яаж хариулахаа мэдэхгүй юм.

Бурхан гэж юу вэ гэвэл амьд байгаа Багшийг л хэлнэ, энэ талаас нь ярьвал Будда Эзэн Бурханаас өндөр болно, учир нь Эзэн Бурхан харагддаггүй, түүнээс аврал гуйхад тусалдаггүй, намайг дагуулж туулан гэтэлгэнэ үү гэж гуйсан ч гэтэлгэдэггүй, зөвхөн багш чинь чамайг туулан гэтэлгэнэ гэж амладаг. Тиймээс Багшийгаа Эзэн Бурханаас дээд гэж үздэг, тэд шүлэг дуулал бичиж, Эзэн Бурханд санал гомдол тавьдаг хэдий ч харин Багшийгаа Эзэн Бурханаас дээд гэж сайшаан магтдаг, тэдний бичсэн нэг бадаг шүлгийн утга нь: Эзэн Бурхан намайг үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдүүлж, тоох ч үгүй, ойшоох ч үгүй, хайнга ханддаг, энэрэлт Багш минь л намайг үхэж, төрөхийн гав гинжээс сулласан, ингэх тусам би ачит Багш таныгаа аялан дуулмаар ч үг олдохгүй байна гэсэн байдаг. Энэ бол нэг энэтхэг хүн гэгээрснийхээ дараа бичсэн шүлэг юм.

Эзэн Бурхан тус үгүй, ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг ч тус үгүй. Энэ нь яг л агаартай адил, агаар дотор хүчилтөрөгч, нүүрстөрөгч байдаг, мэдээж усны бүрэлдэхүүнд H<sub>2</sub>O байгаа хэдий ч бид агаараас ус гуйвал лавтай цангаж үхнэ, агаар дусал ус ч өгч чадахгүй, мөс авъя гэсэн ч өгч чадахгүй, агаарын бүрэлдэхүүнд ус болон мөс байдаг ч шууд ашиглаж чадахгүй, эрхбиш хүчилтөрөгч болон нүүрстөрөгч нэгдээд ус

болсны дараа л хоол унд базаах, хувцас хунар угаах юмуу, унд цайнд ашиглана, тун хэрэгцээтэй зүйл болж чадна.

Усгүй бол бид цангаж үхэхэд хүрнэ, агааргүй бол оршин амьдарч чадахгүй, хэд хоног хоол идэхгүй байж болно, харин хэд хоногоор ус уухгүй байж чадахгүй, учир нь бие махбодын 70-аас илүү хувь нь ус, хэрэв ус дутагдвал бие махбод хатахад хүрнэ. Агаарын бүрэлдэхүүн устай адилаар, гэвч ус тун хэрэгцээтэй, агаар бас чухал боловч зөвхөн амьсгалахад хэрэглэгдэхээс биш усыг орлуулан ууж болохгүй, агаарыг заавал ус болгож хувиргасны дараа ашиглаж болно. Үүнтэй адилаар Эзэн Бурхан буюу Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг хэмээгч нь ямар ч тус үгүй. Бурхан бодьсадва болж хувирсны дараа л бидэнд ач тустай болдог. Тиймээс төрөл төрөлд бурхан бодьсадва эрхбиш хувилгаан биеэр энэ ертөнцөд бууж ирэх хэрэгтэй байжээ, бурхан бодьсадва зөвхөн төгс баясгалант оронд л байдаггүй, зарим нь энэ ертөнцөд амьдарч байдаг. Яг англичууд бүгд англи улсад л амьдардаггүй, зарим нь бас энд амьдардаг. Америкчууд ч бас бүгд л америкт амьдардаг биш, энд амьдардаг нь ч бас байна. Африк тивд бас маш олон гадаадын хүн байдаг, учир нь африк тив хөгжлөөр буурай орон болохоор өндөр хөгжилтэй маш олон орон их хэмжээгээр машин тоноглол, элдэв материал, шатахуун зэргийг зөөвөрлөн оруулж, хөгжихөд нь тусалдаг. Бурхан бодьсадва ч мөн ийм, тэд цөм төгс баясгалант орондоо суудаг биш, тэдний зарим нь бас энэ ертөнцөд бууж ирэн бидэнд тусалдаг, төрөл төрөлд бурхан бодьсадва хувилгаан биеэр бууж ирдэг, ном буурах цаг үед бүр ч их байдаг, ямар ч бодьсадва бүгд л тун яаруу бөгөөд ажлын шинж чанар нь өөр өөр, тэд цаг завгүй яардаг боловч хамаг төрөлтнийг мөн л гэтэлгэж дуусдаггүй, бодьсадвад маш олон хүч чадал байдаг боловч нэгэн махан цогцос болж хувирдаг, махан цогцосын хязгаарлалтаас болоод авшиг хүртэхээр дамжуулж байж л хамаг төрөлтөнтэй холбогдож чаддаг, ингэснээр л тэдэнд тусалж чадна. Холбогдохоос өмнө тийм ихээр тусалж чадахгүй, учир нь хамаг төрөлтний толгой тархи тун зөрүүд, яг л хооронд нь зузаан хэрмээр заагласан юм шиг байдаг. Багш чинь туслах гэсэн ч тусалж чаддаггүй, авшиг хүртээх үеэр багш чинь энэ хэрмийг бага зэрэг эвддэг, гэвч зарим хүний хэрмийг мөн л эвдэж чаддаггүй. (бүгдээрээ инээлдэв)

Хэдийгээр маш олон бодьсадва хувилгаан биеэр энэ ертөнцөд бууж ирдэг боловч махан биеийн хязгаарлалтаас болж дэндүү ихээр ашиглавал тун ядаргаатай санагддаг, хамаг төрөлтний үйл түйтгэр дэндүү их болохоор бие махбод нь тэсвэрлэхийн аргагүй болж, тун зүдэргээнтэй санагддаг. Хэрэв нэг шавь нь тун чармайлттай, тун хичээнгүй бсалагадаг бол тэр бодьсадва шавиараа дамжуулан өөр хүмүүст тусалж болдог. Гэвч тэдний ихэнх нь бүгдээрээ тун залхуу хойрго болохоор гаднах хүмүүсийг аврахын зэрэгцээгээр шавь нартаа тусалж, тэдний төлөө эрхбиш бүр ч ихээр чармайн ажиллах хэрэгтэй болдог тул тун цаг завгүй болж, маш их ядардаг. Хэдийгээр маш их ярьдаг хэдий ч сонсдог хүн тун цөөхөн, шавь нар нь жаахан ч гэсэн бясалгаж байвал тун аштай хэрэг болно, зарим хүн авшиг хүртсэний дараа зугтааж, хэзээ дахин буцаж ирэх нь мэдэгдэхгүй үнэн төвөгтэй хэрэг болдог.

Бурхан бодьсадва ажлын багаа дагуулж, энэ ертөнцөд ажиллахаар бууж ирдэг, гэтэл ирснийхээ дараа дэлхийн өнцөг булан бүрээр тархан явдаг болохоор гэртээ буцах үедээ тэднийгээ хайгаад олохоо больдог. Энэ нь яг л бяцхан хүүхдийг дагуулж гадаа тоглохоор гарахтай адил, зуун хүн дагуулж гарсан болохоор мэдээж зуун хүнээ дагуулж буцах хэрэгтэй, гэтэл зарим нь замын дундаас эгнээнээсээ салж, өөр орноор орж, өөр улс, цэцэг ургамал сонирхдог болохоор хоолойгоо хаттал хашгирсан ч буцаж ирэхээ мэддэггүй, бүгдээрээ буцаж ирэхгүй л бол буцаж болохгүй, заавал хайж олох хэрэгтэй. Гэтэл дөнгөж нэгийг нь хайж олтол нөгөө нэг нь зугтана, бүгдийг нь хамтад нь дагуулж явахад тун ч бэрх.

Хоньчин хонин сүргээ хайхад бас ч амаргүй, зарим хонь нь хэдийнээ сайн дадуулсан болохоор ийш тийш гүйлддэггүй, зарим хонь нь том болоогүй болохоор нилээд омголон. Хэрэв номхон хонь байвал өөр хонио дагуулж хотондоо буцдаг, омголон хоньд нь харин хотондоо буцахгүй, бусдыгаа дагуулж өөр тийшээ зугтчихдаг, ийм байдал тохиолдвол хоньчинд төвөг удна.

Одоо та нар Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагийг ойлгосон уу? Өнөөдөр Багш чинь баяртай байгаа учир жаахан ярилаа. Тэгэхгүй бол тийм асуулт асуух нь нээрээ залхмаар хэрэг, би хариулах тун ч дургүй, дараа дахиад ийм асуулт асуувал багш чинь сандлаар зодно. (бүгдээрээ инээлдэв) Хятадад “Бодьдармаа дундад улсад юу хийхээр ирэв?” гэдэг ном хаялцаан байдаг, шавь нь байнга ингэж асуугаад байхаар багшийнх нь эгдүү ихэд хүрч сандал, эсвэл бэрээгээр шавийнхаа толгойг цохиж, билиг нээгдүүлдэг гэдэг, дотоодын билиг ухааныг нь нээгдүүлж чадахгүй болохоор аргагүй толгойг нь гаднаас нь хагалах л хэрэг гарна. (бүгдээрээ инээлдэв) ингэвэл жаахан ухаарч магад.

Бодьдармаа хятадад ирсэн нь тэдэнд юуны хамаа байх вэ, гэтэл одоо болтол мөн л ингэж ном хаялцдаг хүмүүс байдаг, үүнээс тэдний дэс нь ямар байгааг та нар ойлгож болно. Гэтэл тэд харин үүндээ тун бардамнаж “би” ном хаялцаж, үг хаялцаж байна (бүгдээрээ инээлдэв) гэж боддог. Би америкт байхдаа хятадын нэгэн номын багшийн сүмд сууж байлаа, түүний бясалгалын газарт хүн болгон ном хаялцаанд оролцож болдоггүй, зөвхөн “дээд дэс”-ийн шавь нар нь оролцож болдог гэж тэр хэлсэн. (Багш инээв) Тэр үед би тун ч урам хугарав, учир нь тэр намайг ном хаялцаанд оролцуулаагүй. (бүгдээрээ инээлдэв)

Би бас ном хаялцахыг туршиж үзье гэж гуйсан ч нэмэр болоогүй болохоор: “За яахав, миний дэс өндөр биш болохоор Арьяабалын аргаараа л бясалгаж байх хэрэг болжээ” гэсэн. (бүгдээрээ инээлдэв)

Одоо болтол мөн л “Бодьдармаа хятадад юу хийхээр ирэв” гэх ном хаялцаан байдаг, гэхдээ тэд маш төв чанга, ном хаялцаад нилээд удсаны дараа хариултыг нь лавтай мэднэ гэж боддог. Хариулт байж ч магад, гэвч аливаа асуулт болон хариулт нь мөн л доод дэсэд, оюун ухааны тэмцэлд багтдаг гэдгийг санаж байгаарай! Тэдний хувьд шал дэмий асуултанд оролцолдох нь ямар ач тустай вэ? Ийм дэс нь хэр зэрэг вэ гэдгийг одоо та нар тодорхой ойлгосон байх аа.

Тэд мэддэггүй болохоор өдөржингөө харилцан нэгнээсээ асуудаг, хэрвэ ингэж асуугаад байвал хэзээ нэг өдөр толгой нь дэлбэрч мэднэ, тиймээс үүнээс болж солиорсон хүн тун олон, тэдний гурав хоног, долоо хоногийн даяаны үеэр зарим хүн уйлж, зарим нь инээж, бас зарим нь уурлаж, зарим нь орилж чарлаж байдгийн шалтгаан нь дэндүү их шахамдуулахын дээр өөр арга зам олддоггүй, яг л нэг хүнийг хана руу харуулан зогсоогоод заавал урагшаа яв гэж албадахтай адил, мэдээж гэсвэрлэж чадахгүй болохоороо солиорчихдог. Үгүй бол ном хаялцаанаа хагас дутуу орхих юмуу, нэг зүйлийн дэсийг олчихлоо гэж бодол санаандаа төсөөлөн боддог, ингэхлээр бардамнах сэтгэл амархан төрдөг.

Хятадууд мэтгэж маргах дуртай байдаг ч юм болов уу? Тэдний дэндүү их асуулт нь Энэтхэгээс ирсэн тэр Их Багш нарын ойг гутаамаар болж, уурлах, ядрахын эрхээр: “За та гэртээ хариад үүгээр ном хаялцаарай! Энэ бол тун сайн ном хаялцаан шүү, та өөрөө өөрөөсөө асуу! Тэгээд хариултыг нь олсны дараа багшдаа ирж яриарай!” гэдэг, ингэвэл л түүнийг маш түргэн хөөн явуулж чадна. (бүгдээрээ инээлдэв) Уг нь зүгээр л нэг ном хаялцаанаар багш нь шавь нарынхаа дэсийг шалгах, эсвэл шавь нь багшаасаа сурахаас өмнө багшийнхаа дэсийг шалгахын тулд юм, энэ нь зөвхөн тухайн үеийн багш шавийн хоорондох бясалгалын тухай асуулт, хариулт төдий л зүйл, харин ном болгож “хаялцах” хэрэг явдал биш.

Урьдын номын багш нар ийм ой гутам асуултанд байнга шахагдаж, ихэд ядардаг байжээ. Тэр өдөр бидний нэг авшигтан дүүфүү худалдсан тухай үлгэр ярьсан, нэгэн номын багш шавийнхаа асуултад маш ядарч, шавиа харангуут айдаг болжээ, тиймээс тэр дүүфүү худалддаг нэг хүнийг хайж олоод түүгээр шавийнхаа асуултыг хариулуулдаг болжээ, ингэснээр жаахан амсхийх цаг завтай болсон хэрэг, яагаад гэвэл шавь нь өдөр бүр эгэл хүний асуулт асууж, бусдынхаа толгойг өвтгөдөг байж.

Миний шавь нар бас заримдаа тийм толгой өвдмөөр асуулт тавьдаг, учир нь ном сударт хүлэгдээд салж чадахгүй, дэндүү ухаан муутай, дэндүү зөрүүд, ном сударт баригдаад салахын аргагүй болохоор нь би аргагүй: “Гэртээ хариад энэ асуултыг ном хаялцаан болгож өөрөөсөө асуу” гэж л хэлдэг. Ингэвэл надад арай амар хялбар болдог. Багш чинь угаас ном хаялцахыг сургадаггүй, одоо харин сургадаг болжээ, учир нь түүнд Арьяабалын номын цогцосыг заахын аргагүй, заасан ч ойлгодоггүй, заавал энд ирж, багштай чинь маргалддаг болохоор аргагүйдээ л түүгээр ном хаялцуулж, өөрөө өөрөөс нь асуулгаж, тодорхой хариулттай болсныхоо дараа дахин багшдаа ир гэдэг. Энэ нь нэг зүйлийн сагааруулах арга л даа, гэрт нь буцаачихвал би амсхийж чадна (бүгдээрээ инээлдэв), тэр бас өөрөөсөө асуух боломжтой болно, өөрөөсөө асуусаар байгаад тархи толгой нь дэлбэрч ч мэднэ. Тэгвэл дахиад эгэл хүний эрдэм мэдлэгийн тухай асуулт асуухаа болино, ингэснээр л түүнд Арьяабалын номын цогцосыг сургаж болно, ингэж ном хаялцвал жаахан ач тустай бөгөөд хамгийн дээд номын цогцосыг бясалгахаас өмнөх ариутгалын бэлтгэл хийж болно, гэвч энэ талаар би өөрөө ч гэсэн тийм их итгэдэггүй. Урьдын энэтхэгт ном хаялцаан байгаагүй, хятадад л байдаг бөгөөд хамаг

төрөлтний нөхцөл байдалд зохицуулсан байдаг, учир нь хятадууд ийм байдлаар бясалгах дуртай болохоор хүсэл сэтгэлд нь нийцүүлж, өөрөөс нь асуулгана, ингэвэл номын багш нар нилээд тайван чөлөөтэй болж чадна (бүгдээрээ инээлдэв). Тэгэхгүй бол тэр байнга ирж: “Бодьдармаа хятадад юу хийхээр ирсэн бэ?”, “Хэн бурхныг дурсаж байгаа вэ” гэх мэтийн зүйл зүйлийн залхуу хүрэм асуулт тавьдаг.

Хятадад өөр бас ном хаялцаан байдгийг та нарын хэн нь санаж байна вэ? (Нар хаана байдаг вэ?) энэ бол бас жаахан хэрэгтэй асуулт, номын багш нар шавийнхаа дэсийг ойлгож, ер нь нарыг харсан эсэхийг мэдэхийн тулд ийм асуулт асуудаг. Өөр зүйлийн ном хаялцаан байна уу? (Шавь: Нохойд бурхан чанар бий юү?) Тухайн үед Зов жү хуврагаас: “Өөр номын багш нохой бурхан чанартай гэж хэлсэн байхад та яагаад бурхан чанаргүй гэж хэлнэ вэ” гэж асуухад номын багш түүний асуултад дур нь гутаад шууд үгүй гэж хариулсан аж.

Ийм байхад хожмын хүмүүс мөн л тийм ном хаялцаж, хэдэн зуун жил өнгөрчихөөд байхад бас л нохойн хойноос хөөцөлдөх хүмүүс их байна. (бүгдээрээ инээлдэв), хөөрхий нохой эрхбиш тоолшгүй төрөлтнийг дагах хэрэгтэй байжээ. Өөр зүйлийн ном хаялцаан бас байна уу? Бүгдийг нь багшдаа яриарай, учир би ийм зүйлд ер сонирхдоггүй болохоор мартчихжээ, ном хаялцааныг бүгдийг нь хөөцөлдөж, толгой тархиа үймүүлдэггүй. Өөр ном хаялцаан бас байна уу? (Шавь: Аав, ээжээсээ төрөхөөс өмнөх уг дүр) “Би хэн бэ” гэдэгтэй бараг адил. Японд “Юуг байхгүй гэдэг вэ?” гэх маягийн ном хаялцаан байдаг, уг нь “Байхгүй гэж юу вэ?” байснаа хожим нь хасагдаад зөвхөн “үгүй” болжээ, “Үгүй” гэдэг авиа нь хоолойноос авиа болж гарахдаа □ × ийм болж хувирчээ, тэд өдөр бүр тэгж уншдаг (бүгдээрээ инээлдэв), долоо хоногийн даяаны үеэр шөнө дөл болчихсон байхад бас л □ ×, □ × гэх дуу дуулдаг.

Өмнөд Солонгост бүр ч нэртэй нэг зүйлийн ийм ном хаялцаан байдаг, “Нэг муур, хулгана хоёр байжээ, хулгана нь муурын аяганаас юм хулгайлж идэхийг завдтал муур гүйж ирэхэд муурын сав хагарав”. Энэ ном хаялцаан нь ямар утгатай вэ? Та нар мэдэх үү? (Шавь: Хулгана савыг хагалав гэж хариулав), (бүгдээрээ инээлдэв) Хулгана аяга хагалав гэсэн үү? Ийм тэнэг хариулт байж болох уу? Энэ бол өнөөдрийн та нарын ном хаялцааны агуулга юм. Ном хаялцах уу? Өмнөд Солонгос улсад маш алдартай номын багш тусгайлан ийм ном хаялцааныг сургадаг, одоо америкт сууж байна, олон шавьтай, дэлхийд алдартай номын багш.

Хожим би бас тэгж ном хаялцахыг сургана аа. Шавь нар нь бүгд хариулж чадахгүй болохоор багшийгаа тун сүрхий гэж боддог, хариултыг нь зөвхөн багш нь л мэднэ, өөр хэн ч мэдэхгүй. Хожим би ном хаялцахыг сургавал нилээн ач тустай байх, ингэвэл гүтгэх хүн байхгүй, миний бодлоор хятадууд маргах тун дуртай, тэднээр ном хаялцуул, тэгвэл үг ярихын аргагүй болно, маргахаар иргэсэд хэлээ хазаж явах болно.

Өмнөд Солонгосын тэр ном хаялцааны утгыг та нар мэдэх үү? (Шавь: Савыг хагалсан үйл хэргийн учир шалтгааныг эцэст нь тултал судлах гэсэн санаа гэж хариулав), Та нааш ир! (Багш хонхоороо толгойг

нь цохив) (бүгдээрээ инээлдэв) Бид жүжиг тоглож байна, эртний номын багш, шавь нарын хоорондох холбоог жүжиглэж үзүүллээ, өөр тоглох хүн бас байна уу? Билиг нээгдэх хүсэлтэй хүн байна уу? (бүгдээрээ инээлдэв), өнөөдөр тун ч хөгжөөнтэй ням гараг боллоо. Бид ном хаялцах тухайд дадлага хийлээ. (бүгдээрээ инээлдэв) (Шавь: Эрт дээр үед шавьд нь ийм асуулт тулгарвал багшдаа дөхөж очин багшийнхаа гараас хонхыг нь булаагаад багшийнхаа толгойг цохидог байсан), (Багш инээгээд хонхоо шавьдаа өгч), нааш ир, та ингэх нь зөв гэж бодож байвал би толгойгоо танаар дуртайяа цохиулна. (бүгдээрээ инээлдэв)

Саяхан ярьсан “Хулгана, муур хоёр”-ын ном хаялцаан нь маш алдартай, Америкт түүний шавь нар нь бүгд л энэ ном хаялцаанд оролцдог, өдөр ч хаялцана, шөнө ч хаялцана, долоо хоногийн даяаны үеэр ч хаялцана, даяан дуусах үеэр ч хаялцана, даяан дууссан хойно ч үргэлжлүүлэн хаялцана, долоо хоногийн даяаны үеэр хаялцаад дуусахгүй бол хэдэн жилийн дараа дахиад л хаялцана. Та нарын дунд ном хаялцаж байсан хүн байна уу? Одоо хариулж зүрхлэх хүн байхгүй болжээ. (бүгдээрээ инээлдэв) Үнэн хэрэгтээ ийм ном хаялцаанд оролцсоны хэрэг юун?, ярингуут буруутчихдаг, гэвч ярихгүй бол нэгэнт билиг нээгдчихсэн гэдгийг илэрхийлэхгүй, учир нь тэр ойлгодоггүй болохоор ярьдаггүй гэнэ. Ярьсан ч буруу, ярихгүй ч буруу, тиймээс шавь нь яриагүй байхад номын багшийнх нь саваа хэдийнээ шавийнх нь толгойд буучихсан байдаг.

“Бодьдармаа хятадад юу хийхээр ирсэн бэ?” Ийм номыг хаялцаад яах юм? Энэ бол 2000 жилийн тэртээх өөр хүний хэрэг, бидэнд ямар ч хамаагүй, иймээс тийм ном хаялцаанд оролцох нь ач тусгүй, дэсээр тун доор, яг л хүүхдийн тоглоомтой адил. Миний бодоход Арьяабалын номын цогцосыг бясалгавал юун түрүүнд толгой өвдмөөр асуултанд хариулах шаардлагагүй, гэвч юуг ч бүгд мэднэ. Би Өмнөд Солонгосын тийм ном хаялцаанд оролцоогүй, тэр их номын багшаас суралцаагүй боловч бас мэднэ, заавал ийм ном хаялцаанд оролцох хэрэг юун?

Арьяабалын номын цогцосыг бясалгагчид багшийн зааврыг сонсохгүй, чармайн бясалгахгүй бол дахин буцаж ирээд хүн болж, багшийгаа хайж олоод дахин авшиг хүртэнэ, дахин бясалгана, хэрэв ахиад сайн бясалгахгүй бол дахин нэг удаа, хоёр удаа, ихдээ дөрвөн удаа буцаж ирнэ, гэвч гурван муу заяанд унахгүй, тийм учраас л “дээшээ дөрвөн энэрэлийг хариулж, доошоо гурван муу заяанаас аварна” гэдэг. Хэн ч бай Арьяабалын номын цогцосыг бясалгасны ачаар гурван муу заяанд унаж, зовлон амсахгүй, хамгийн муудлаа л гэхэд хүн болно, хүн болсон ч бас тун сайн хүн болж, зовлон багатай мөртлөө лавтай жинхэнэ багшийг хайж олох боломжтой байж, өөр хүнтэй адилгүй байдаг. Учир нь жинхэнэ багшийг дагаж бясалгавал Тэрээр бидний урьдах төрлийн муу үйлийн үрийг ариутган цэвэрлэдэг, тиймээс гурван муу заяанд унадаггүй, бясалгалаар сайн ч бай, муу ч бай, муу үйлийг чинь бүгдийг нь ариусгадаг. Гэвч багшаасаа урван тэрлэгч юмуу, багшдаа итгэдэггүй хүн ийм байж чадахгүй, учир нь тэр өөрөө багшаараа туслуулахгүй, өөрөө зургаан муу заяанд унах дуртай, тэр ч байтугай гурван муу заяаны



Аль ч шашны эзэнд итгэсэн болно, хамгийн чухал нь та өөртөө итгэж, өөрийнхөө жинхэнэ уг чанарыг хайж олох явдал юм.

(“Буддын шашинтан гэж хэн вэ?”-ээс)





Энэ дэлхий дээр хүн болгон өөрийн илүүдсэн эд зүйлсээ бусдад хуваан эдлүүлбэл гараг дэлхий маань амар амгалан, баяр жаргалаар дүүрч, дайн дажин ба хулгай зэлгий алга болно.

(“Ямар хүмүүс Төгс баясгалант оронд очиж чаддаг вэ?”-ээс)

хүрдэнд ээлжлэх дуртай болохоор багш чинь түүнийг албадаж болохгүй. Жишээ нь: та дэлгүүрт очиж бараа худалдаж аваад буцаж ирсэний дараа худалдаж авсан бараандаа дургүй хүрч болно, уг нь авахдаа тун дуртай байж л дээ, гэтэл одоо дургүй нь хүрсэн болохоор бараагаа дэлгүүрийн эзэнд буцаана, мэдээж дэлгүүрийн эзэн барааг нь буцаан авч мөнгийг нь эргүүлж өгөх л хэрэг болно.

Үүнтэй адил, багшийгаа дагаж бясалгах дургүй, багшаасаа урван тэрсэлж, гадна гарч багшийгаа гүтгэдэг мэтийн хүн байвал мэдээж багш чинь үйл түйтгэрийг нь өөрт нь буцаана, би бусдыг албадаж болохгүй. Тэр угаас үйл түйтгэрээ авч ирээд багшаасаа эрх чөлөө худалдан авсан хэрэг, хожим нь эрх чөлөөнд дургүй болоод багшдаа буцааж өгч байгаа болохоор үйл түйтгэрийг нь ч буцаах хэрэгтэй болдог. Тоост энэ хорвоод бурхан больсатва бусдыг албадан байж аварч болдоггүй, өөрийн бодол сэтгэлээ өөрчлөх дуртай бол аварч болно, тэгэхгүй бол бусдыг албадаж болохгүй, хэрэв тэр залхуу хойрго, хичээнгүйлэн бясалгахгүй байсан ч багшдаа итгэдэг л бол гурван муу заяанд унахгүй, өөрийн үйл түйтгэрээ буцааж авахгүй. Багшдаа итгэдэггүй, багшийгаа гүтгэдэг хүмүүс ч гэсэн бас буянтай болдог, гэвч тэд эрхбиш удтал хүлээсний дараа л дахин багштайгаа учрах бөгөөд багш нь бас тэдэнд хайнга хандахгүй. Гэтэл энэ үйлийн үрийг өөрөө зохиосон болохоор үйл түйтгэрээ буцааж авах хэрэгтэй, би бас яах ч аргагүй, хэзээ нэг өдөр тэр өөрийн алдаа буруугаа ойлгож, тоост хорвоогоос уйдаж залхахаараа чин сэтгэлийн угаас багшаасаа тусламж гуйх тэр үед дахин дээш дагуулан гарч болно. Багш нь түүнийг мартсандаа биш, үүнийг тэр өөрөө сонгосон болохоор ингэж байгаа л хэрэг юм шүү дээ. Ийм байдал нь хичээнгүйлэн бясалгадаггүй боловч багшийгаа хүндэтгэж, багшдаа итгэдэг хүнийхтэй адилгүй, хэдийгээр чармайн бясалгадаггүй боловч өөрөө аврагдах дуртай болохоор багш чинь аварна.

**Асуулт:** Багш аа, би танд хэдэн удаа шавилан суралцаж байгаа вэ?

**Их Багш:** Хамгийн ихдээ дөрвөн удаа буцаж ирнэ гэж саяхан ярьсан, гэвч та тав дахь удаагаа болчихжээ. (Бүгдээрээ инээлдэв) Таны нэр чинь “Wu” (тав гэсэн утгатай) болохоор дахин нэг удаа ирэх хэрэгтэй, (бүгдээрээ инээлдэв) дахин хоёр удаа ирвэл ирсэн хойноо WU ER (хоёр дахь тав гэсэн утгатай) гэж өөрчлөх хэрэг гарах байх. Багш чинь зүгээр тоглосон юм даа, та нар дахин буцаж ирэхгүй шүү дээ! Ном балрах үе, буцаж ирмээр ертөнц байхгүй.

**Асуулт:** Бие цогцос байхгүй бол бясалгахын аргагүй гэж та ярьсан, энэ үгийн утгыг би сайн ойлгохгүй байна, тийм юм бол тэнгэрийн төрөлтөн бясалгаж чаддаггүй юм уу?

**Их Багш:** Тийм. (Ном сударт тэмдэглэснээр маш олон тэнгэрийн төрөлтөн ном сонсохоор ирдэг гэдэг) Тэд зөвхөн ном тайлахыг сонсдог, гэвч бясалгаж чаддаггүй, Арьяабалын номын цогцосыг бясалгаж чаддаггүй, учир нь тэдэнд гар гэж байхгүй, чих нь чих биш, нүд ч нүд биш. (Тэд билиг ухаанаараа сонсож чаддаг уу?) Мэдээж сонсож чадна, гэвч нөхцөл байдал нь адилгүй, тэнгэрийн төрөлтөн урьд нь багшаас чинь сурч байсан бол үргэлжлүүлэн бясалгаж болно, энэ нь өөр хэрэг.

Энгийн тэнгэрийн төрөлтөн бясалгаж чаддаггүй, дотоодын аялгуугаа сонсож чадахгүй юм чинь яаж бясалгах вэ?

Тэд өөрсдөдөө тохирсон дэсийн бясалгал хийдэг, жишээ нь, тэнгэрийн төрөлтөн энд ирж багшийн чинь ном тайлахыг сонсдог, Арьяабалын номын цогцосыг сонсдог, тэд хамгийн дээд төвшин, жинхэнэ нирваанд хүрэх тун дуртай, гэвч өөрөө Арьяабалын номын цогцосыг бясалгаж чадахгүй, чин сэтгэлээсээ бясалгахыг хүсвэл дахин ирж, хүн болох хэрэгтэй, тэгээд зохистой хувь барилдлагыг хүлээж байгаад ямар аав, ээж сайн бэ гэдгийг харна, хүн болсны дараа жинхэнэ багшийг хайж олж байж л суралцдаг, нэгэнт багшаас чинь сурчихсан тэнгэрийн төрөлтөн бол өөрийн дэсээ үргэлжлүүлэн бясалгана. Диваажинд бас сургууль байдаг, гэвч сургагчаас бусад хүнийг оруулдаггүй. Жишээ нь: та дунд сургуулиа төгсөөгүй бол их сургуульд ойрхон амьдардаг хэдий ч тэнд очиж суралцаж болохгүй, их сургуулийн өрөөг цэвэрлэдэг ажилчин байлаа ч их сургуулийн оюутан болчихдоггүй, учир нь тийм дэсэд хүрээгүй болохоор ойлгодоггүй.

**Асуулт:** Аялгууны урсгалын дотор бүх хүн төрөлтөн хамгийн дээд хэсгийг олсон гэж багш та ярьсан байдаг? Тийм юм бол энэ аялгууны урсгалын доторх тэнгэрийн төрөлтний дэс нь биднээс доор уу?

**Их Багш:** Аялгууны урсгал дотор тэд зөвхөн их сургуулийн өрөөнд амьдардаг, эсвэл их сургуулийн ойролцоо амьдардаг төдий, харин их сургуулийн жинхэнэ оюутан биш, тиймээс юу ч сурч чадахгүй, ойлгов уу?

**Асуулт:** Бид Арьяабалын номын цогцосыг бясалгахгүй бол аялгууны урсгал дотор байж чадах уу?

**Их Багш:** Аялгууны урсгал дотор байдаг, гэвч бас байхгүй. Тэнгэрийн төрөлтөн мөн л ийм, аялгууны урсгал дотор байгаа гэж хэлж болохгүй, учир нь хүн бүхэнд бүгдийнх нь дотоодод аялгуу байдаг боловч Төгс Гэгээрсэн Багш нээж өгөхгүй бол сонсож чадахгүй, тиймээс тэд аялгууны урсгал дотор байхгүй гэж хэлдэг, Төгс Гэгээрсэн Их Багш хаалгыг онгойлгосон үед л аялгууны урсгал дотор байж чадна. Тэнгэрийн төрөлтөн үлэмж их буянаараа сайн оронд амьдардаг хэдий ч энэ аялгууны урсгалыг нээж чадахгүй. Хүмүүс ч адилхан, хүн бүхэн сонсож чаддаг, учир нь бүгд энэ аялгууны урсгал дотор байгаа юм чинь, гэвч заавал Төгс Гэгээрсэн Их Багш байж гэмээнэ л “билгийн мэлмийг нээж чадна”, энэ бол тун өвөрмөц үйл хэрэг, номын багш болгон нээж чаддаг ч юм биш, зөвхөн жинхэнэ багш л нээж чадна, энэ бол орчлон хорвоогийн жам ёс, харин багш чинь өөрөө зохиож бүтээсэн юм биш, мөн ганц, хоёр хүн зохион бүтээчихсэн ч юм биш. Яг л амтат жүрж таривал мэдээж амтат жүржийн жимс ургахтай адил, энэ бол байгалийн хууль, яагаад амтат жүржийн модонд амтат жүрж ургадаг вэ? гэж битгий асуугаарай. Жүржийн үр нь жүржийн жимс дотор байдаг, жүржийн мод ч жүржийн үрээс нахиалан ургадаг, гэвч бид амтат жүрж идье гэвэл тэр дороо л жүржийн үрийг заглаад идчихээр болчих юм биш, харин үрийг нь тарьсаны дараа мод болон ургаж, жимсний мод аажмаар бүдүүрч, цэцэг дэлгэрч, жимс нь боловсорсны дараа л идэж болно.

Энэ бол орчлонгийн жам ёс, яагаад ийм байдгийг багшаасаа асуухын хэрэггүй, багш чинь мэдэхгүй, ийм асуултад хариулах дур сонирхолгүй. Бодьдармаа хятадад юу хийхээр ирсэн бэ? Жүржийн модонд яагаад алим ургадаггүй вэ? Яагаад тийм их удаж байж бүдүүн мод болдог вэ? Яагаад эхлээд цэцэглэсний дараа жимс ургадаг вэ? Энэ бүхэн нь багштай чинь ямар ч холбогдолгүй, надад жүрж байвал би шууд л идчихнэ, би өөрөө яршиг төвгийг эрж хайхгүй. Мэдээж бидэнд бүгдэд нь бурхан чанар байдаг, гэвч бясалгахгүй бол хөгжин дэвшиж чадахгүй. Бид аялгууны урсгал дотор байдаг боловч жинхэнэ багш хаалгыг онгойлгож өгөхгүй бол аялгууны урсгал дотор орж чадахгүй.

**Асуулт:** Арьяабалын номын цогцосыг бясалгасны дараа хувь хүний бясалгалын дэсэд нийцүүлж багш биднийг дагуулан нэгдүгээр ертөнц, хоёрдугаар ертөнц, гуравдугаар, тавдугаар ертөнцөд очдог, тавдугаар ертөнцөд хүрсний дараа л жинхэнээр туулан гэтэлсэнд тооцогддог. Гэтэл ховдог, хилэн, мунхаг нь тун их бөгөөд ааш муутай хүн хэдийгээр Арьяабалын номын цогцосыг бясалгаж байгаа боловч асуурийн оронд очдог, тэгвэл та түүнийг тэндээс аврах уу?

**Их Багш:** Аварна, тэнд бас сургууль байдаг, тэрээр өдөр бүр сургуульд очиж уурлаж хилэгнэх ажил хэргийг судалж суралцана. (бүгдээрээ инээлдэв).

**Асуулт:** Багш аа, дөрөвдүгээр ертөнц гэж зах хязгааргүй, түнэр харанхуй орон. Дээшээ гарч чадахгүй байгаа хүн тэнд байдаг уу?

**Их Багш:** Байгаа, хэрэв та нар тэнд унавал багш чинь мөн л тосч авна. (Тэгвэл сайн юм байна, тун ч баталгаатай юм байна. Багштай уулзсан маань мөнх настай даатгалын компанид орсонтой адил аж) Тийм, хэзээ ч аюулгүй, мөнгөгүй ч гэсэн баталгаатай байж чадна, чамайг зуун жилийн даатгалаар даатгаж тусалсан хүн байвал та лавтай үнэхээр гайхалтай гэж бодно, гэтэл багшийн чинь даатгалд хэмжээ хязгаар гэж байхгүй, мөнгөөр худалдан авч чадахгүй, үнэнхүү гайхалтай. Иймээс би та нарт баяр хүргэх ёстой, бид завшаан хайж, бүх шавиа цуглуулж, баяраа тэмдэглэе! Болох уу? (Болно, багшийн мэндэлсэн өдрийг тохиолдуулж тэмдэглэе). Би төрсөн өдрөө тэмдэглээгүй их удчихжээ, гэрээс гарагсдад төрсөн өдөр гэж байдаггүй, (Шавь: Өнөө жил заавал тэмдэглэх хэрэгтэй, мөнх настай даатгалын компанийн даргын төрсөн өдрийг тэмдэглэе!). Би ингэх дургүй, миний төрсөн өдрийг тэмдэглэмээр зүйл байхгүй. (Шавь:- Би энэ дэлхийд хүн болсон цагаас өдий хүртэл хамгийн баяртай цаг мөч гэвэл Багш тантайгаа уулзсан явдал болно. Хамгийн их баярласан цаг бол авшиг хүртэх үе, хамгийн сайн өдөр бол авшиг хүртсэн өдөр, авшиг хүртсэний дараа үхэж, төрөхөөс мөнхөд чөлөөлөгджээ. Багшийн мэндэлсэн өдөр бол бидний төрсөн өдөр мөн, Төгс баясгалант оронд заяасан өдөр мөн).

**Асуулт:** Мял (Милрайба) богд мах иддэг байсан гэж би бусдаас сонссон юм, үнэн үү?

**Их Багш:** Тэр ганцхан удаа идсэн, түүнд тэр өдөр идмээр юм байсангүй, анчин түүнд нэг хэсэг мах өгсөнд талыг нь идээд үлдсэнийг нь уулын агуйнхаа ар талд тавьжээ, гэтэл маш олон хорхой гарч ирээд

тэр хэсэг махыг идчихжээ, маргааш нь тэр идэх гэтэл маш олон хорхой байхыг хараад: “За үүнийг та нарт өргөн барья?” гэжээ. Мах идсэний дараа тэр маш их шаналан зовж, хамаг бие нь өөр болчихсон шиг санагджээ. (Тэр Бурханы хутагт хүрээгүй байхдаа идсэн үү?) Тийм, тэр үед тэрээр уулын агуйд бясалгаж байжээ, өдөржин бясалгадаг болохоор нэг удаа мах идэх нь хамаагүй, мах идсэний үйл түйтгэрийг тун хурдан угааж цэвэрлэхинэ гэж бодоод идчихсэн. Бид өдөржин мах иддэг, бясалгадаггүй (бүгдээрээ инээлдэв) болохоор мэдээж идэж болохгүй. Тэрээр ууланд амьдардаг болохоор агаар цэвэр, бохирдолгүй, тэндхийн уур амьсгалыг бохирдуулах хүн байхгүй, тэр нээрээн бага зэрэг мах идсэн. Харин бид идсэн байвал бас тийм ч их асуудал үүсэхгүй, гэвч бие махбод маань мөн л үйл түйтгэрээс болж шаналан зовно. Харин бид мах идэж болохгүй, яагаад гэвэл бидний буяныг түүнийхтэй адилтгахын аргагүй.

**Асуулт:** Сонссоноор бол үлэмж эрдэмт номын эзэн бас мах иддэг гэсэн, тийм үү?

**Их Багш:** Тэр Мял богд бурхантай адилгүй, маш олон удган, бөө нар бас мах иддэг, тэд ид шидтэй, энэ нь бясалгалын ямар нэгэн төвшинд хүрсэн гэдгийг илэрхийлж чадахгүй, тэд хүчтэй ч жинхэнээр туулан гэтэлсэн гэдгийг илэрхийлж чадахгүй.

**Асуулт:** Нууц тарнийн бясалгалтан зарим номын эзэд хэдийгээр мах иддэг боловч, гурван ертөнцөөс гэтэлж чаддаг гэж хүмүүс хэлдэг, тийм үү?

**Их Багш:** Тэд юу ярих нь тэдний хэрэг, би шүүмжлэн яримааргүй байна, тэдэнтэй санал нэгдэхгүй ч байж магад. Би гэрээс гарахаас өмнө аль хэдийнээ ургамал хоолтон байсан. Би германд нууц тарни бясалгаж байхдаа нэг ламаас: “Ургамал хоол идэх нь сайн уу? Мах идэх нь сайн уу? гэж асуухад тэр: “Мах идэх нь муу” гэсэн. Би яагаад муу вэ? гэж асуухад: “Учир нь энэ бол хамаг төрөлтийн мах” гэсэн. “Тэгвэл та ургамал хоолтон уу? Махан хоолтон уу? гэж асуухад тэр “Би мах иддэг” гэв. Яагаад гэсэнд тэр “Би хар багаасаа дадаад аль хэдийн дадал болсон болохоор өөрчлөхийн аргагүй” гэж хариулсан, (Мял богдын нууц тарнийн бүлэгтний дөрөвдүгээр үеийн өвгө багш, тэр бас мах иддэг)

Энэ тухай би саяхан ярьчихсан, тэр ганцхан удаа идсэн, тэрээр: “Өнөөдөр би яагаад эгэл хүн шиг мах идэж байна вэ? гэж шүүрс алдаж байжээ. Мял богд хоол бадарлахаар гарах болгонд бүгд л ургамал хоол авчирдаг гэдгийг түүний намтрыг уншвал мэдэж болно, гэхдээ энэ тухай маш тодорхой ярьсан байдаг. Нэг удаа гэртээ очиж авга эгчтэйгээ уулзжээ, тэгээд авга эгчээсээ хоол бадарласанд өгөөгүй мөртлөө түүнийг сүрхий загнаж, тэр ч байтугай зодсонд Мял богд авга эгчдээ нэг бадаг дуу өргөсөн байна, түүний дуунд авга эгчийнх нь сэтгэл хөдөлж, хоол хүнс ихээр өгчээ, гэхдээ энэ нь бүгд л ургамал хоол байжээ. Гэтэл одоо харин эмх замбараагүй болсон, японы хуврагууд мах идэж, архи уух, гэрлэхэд ямар ч асуудалгүй, одоо зарим сүм хийдэд бас ургамал хоол иддэг, энэ нь мөнгө багатай учраас л ургамал хоол иддэг хэрэг аж.

Philip Karleau гэдэг америк хүн японд очиж арван гурван жил даяан

бясалгал хийгээд нэгэн ном бичжээ. Тэр ярихдаа японд даяан бясалгаж байхдаа маш олон сүм хийдээр явж байхад бүгд ургамал хоол иддэгийг хараад тун баярлажээ, гэтэл харин түүнд мах чанаж өгсөнд: “Яагаад та нартай адил ургамал хоол идэж болохгүй билээ?” гэж асуужээ, тэгэхэд нь тэд: “Танай америкчууд мах иддэг дадалтай болохоор мах чанасан юм” гэжээ, “Би бас ургамал хоол иднэ” гэж тэр хэлэв. Гэвч зарим газрын хуврагууд сүмдээ загас юмуу, мах худалдан авчраад иддэг.

Нөгөө америк хүн: “Өнөөдөр та нар яагаад мах идчихэв? Уг нь та нар чинь ургамал хоол иддэг биш үү?” гэж асуусанд тэр хувраг: “Тэр өдөр мах худалдан авах мөнгөгүй болохоор ургамал хоол идсэн, өнөөдөр мөнгөтэй болсон болохоор мах идэх боллоо, заримдаа бид бусад ном гүрэм үйлдвэл тэд өргөл барьц өргөдөг болохоор мах идэх мөнгөтэй болдог, эсвэл тэд загасны мах, өөр бусад хүнсний зүйл өгдөг, заримдаа бид бас жигнэмэг, эсвэл ургамал хоолоор мах сольж иддэг” гэжээ. Үүнийг сонсоод америк хүнд маш аймаар санагджээ, тэр даяан бясалгаж дөнгөж эхлээд байсан тул буддын шашны тухай ямар ч ойлголт байсангүй. Тэр өөрөө ургамал хоолтон, өөр хүн түүнийг гадаад хүн учраас мах идэх дуртай гэж бодсон болохоор түүнд мах чанаж өгөхөд тэр: “Би мах иддэггүй шүү, ургамал хоол идэх дуртай” гэж хариулжээ. Тэр өөрийн бичсэн номдоо бясалгалтан ургамал хоол идэх хэрэгтэй гэсэн үзлийг баримталж, гэрээс гарагсад нигүүлсэнгүй сэтгэлгүй гэж зэмлэн буруутгажээ, нэг хүн гадна талдаа нэгэнт нигүүлсэнгүй сэтгэлгүй болчихвол дотоод сэтгэл нь ямар байдгийг төсөөлөн мэдэж болно гэж тэр үздэг. Түүний үзлийг би сайшаан дэмжинэ, тэр бясалгалдаа тун мэрийлтэй, хэдийгээр бясалгалын арга нь биднээс ондоо боловч ариун цайлган сэтгэлтэй, мах идэх, архи уух, гэрлэхийг дэмждэггүй, өөрөө гэрээс гарагчийн хувцас өмсдөггүй боловч өөрийгөө хэдийнээ хувраг гэж тооцдог. Ингэх нь америкт нилээд хялбар дөхөм байдаг гэж тэр ярьжээ. Японд байхдаа тэр нэгэнт арван сахил хүртэж, хувраг болсон байна. Японы хуврагууд зөвхөн арван сахил хүртдэг, эрэгтэй, эмэгтэй бүгд адилхан, хоёр зуун тавин сахил хүртдэггүй боловч мөн л хувраг болчихдог. Бясалгал нь эмх замбараагүй бол хоёр зуун тавин сахил хүртсэн ч ямар ч хэрэгцээгүй. Одоо японы байдал ч гэсэн эх захгүй, зарим сүм хийдийнх нь маш хичээнгүйлэн бясалгадаг хэдий ч өөр бусад сүм хийд нь бүгд ном гүрэм үйлдэж, мөнгө хураах, том сүм хийд байгуулах, гэрлэх ураглах, номын хурал хурах гэхчилэн тун хөгжөөн наргиантай байдаг.

Мах их идэж, архи уусан уур амьсгал нь мах иддэг чөтгөр болж хувиргана, тэр нь хүний махаар хооллох тун дуртай байдаг гэж энэтхэгийн Ленк сударт өгүүлсэн байдаг. Хүний амь хороох нь яг л мах идэхтэй адил бусдын амь насыг хөнөөдөг, тэр үед цус сорогч чөтгөртэй ямар ялгаа байх вэ? Энэ ертөнцийг харахад маш олон улс оронд өдөр бүр тоолшгүй олон хүн хөнөөгдөж, яг л амьтныг алахтай адил байдаг, Ленк судрын гол санаанаас үзвэл энэ нь мах идсэнээс болсон үйл түйтгэр биш үү? Өөрөөсөө асуу. Хамаг төрөлтөн дэндүү ихээр мах идвэл хожим дайн дажин ихтэй оронд төрж, өөрийн үйл үрээ эдлэх болно.

Мах их идвэл бясалгал лавтай сайн биш, нэгэнт гэрээс гарагчийн хувцас өмсөж, бодьсадвагийн сахил хүртэж, хамаг төрөлтийг гэтэлгэхээр андгайлсан байтлаа харин мах идэж, архи ууж яаж болох вэ? Үйл үрийг тарьчихсан болохоор үр дагавартай болох нь зөв, тиймээс өнөөдрийн иймэрхүү гунигт байдал үүсжээ. Энгийн хүн бол бас яахав, хувраг хүн ингэж болохгүй, энх амар, эрхэм дээд л байх хэрэгтэй, аливаа үйл явц жаахан ч атугай эрхэм дээд энх тайван биш бол яриангүй улс орноо бүхэлд нь хордуулна, заримдаа ганц, хоёр хүн байлаа ч гэсэн улс орноо бүхэлд нь дампууралд хүргэнэ, учир нь үйл түйтгэр нь дэндүү их болчихно.

Гэтэл нэг их бясалгалтан харин улс орноо бүхэлд буян хишигтэй болгож, хаа хүрсэн ч тэр орон дорхноо адилгүй болж, дэс нь даруйхан дээшилдэг, үүнийг бид эгэл хүний нүдээр харж чадахгүй, гэвч бясалгалтан хүн харж чаддаг. Их бясалгалтан нэг оронд хүрвэл эхлээд тэр орныг харахад тун эмх замбараагүй, хэрүүл маргаанаар дүүрэн, эсвэл санал шүүмжлэл ихтэй байж ч магад, учир нь ад чөтгөр тэндээс салах дургүй байдаг ч албадлагаар салж оддог болохоор сул дорой хүнийг ашиглан хэрүүл маргаан үүсгэж, саад хийдэг. Гэвч гажуу буруу зүйлс зөв ёсыг ялж чаддаггүй, хэсэг хугацаа өнгөрсний дараа тэд гэтэлгэгдэнэ, тэгвэл уур амьсгал ондоо болж, маш цагаан цайлган, амар амгалан болж, хөгжин цэцэглэж, хүн ам нь олширно. Тиймээс бурхан хаа хүрнэ, тэр орон буянтай болно гэдэг үнэн хэрэг билээ. Урьд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш ном тайлахаар америкт очжээ, түүнтэй хамт явж чадаагүй шавь нь гэрээсээ багшийнхаа аяны явцыг газрын зургаас харахын зэрэгцээ багшийнхаа замыг өнөөдөр энд хүрнэ, маргааш тэнд хүрнэ гэхчилэн нарийвчлан тооцжээ. Нэг өдөр тэрээр бясалгаж суухдаа багшийнхаа явж өнгөрөх орныг бороо хуртай байхыг харав, уг нь энэ орон нь гантай, хуурайшилтай байжээ, гэтэл багш нь хаа хүрнэ, тэнд хур бороо орж, өөр бусад газар нь ган гачигтай байжээ. Тиймээс нэгэн их багшийн адислалын хүч нь хязгаарлашгүй, юугаар ч хэмжихийн аргагүй.

Урьд нь нэгэн номын Их Багш ямар нэгэн оронд хүртэл тэр орон нь угаас усгүй байснаа тэр Их Багшийг очсоны дараа гэнэт уух устай болсон гэдэг, энэ бол үлэмж буян хишиг болно. Тансан ламын намтарт тэмдэглэснээр Тансан лам Энэтхэгт очоод нэгэн газраар өнгөрчээ, тэр газар нь уулан дээр байдаг бөгөөд нэг голтой юм байж, тэр газрын хүмүүсийн ярьснаар ерөөс ус байгаагүй аж, гэтэл нэг өдөр нэг хэсэг наймаачин тэр орноор өнгөрөхдөө уух ус дутагдан цангаж үхэх шахжээ, тэдэнтэй нэг хувраг хамт явж байж, тэр хувраг угаас мөнгөгүй, ядуу хоосон, бусдын өгсөн хоол ундаар амь зогоодог байжээ.

Тэр наймаачид тэнд хүрсний дараа уух ус олдохгүй болохоор бачимдан сандарч нөгөө хуврагаас: “Бид бүгдээрээ тун их санаа зовж байхад та харин амгалан тайван суух юм, та яаж ус хайж олохыг мэдэх үү, эсвэл ойр хавиар ус байгаа эсэхийг мэдэх үү? Бидэнд туслаач, бүгдээрээ цангаж үхэх боллоо шүү” гэж гуйжээ. Тэгэхэд нөгөө хувраг: “Ус хайж олж болно, гэвч та нар бурхан, ном, хуврагийг шүтэн дагаж,

таван сахил (амь хороохгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, худал ярихгүй, архи уухгүй) гэж андгайлах хэрэгтэй, ингэвэл би та нарт ус олж уулгаж чадна” гэжээ.

Наймаачид бүгдээрээ зөвшөөрч, гурван эрдэнийг шүтэн дагаж, таван сахил хүртсний дараа нөгөө хувраг дээш гарахдаа: “За ууланд авирч гарсны дараа та нар миний сахилын нэрээр тэр, энэ багшаа та даруйхан бидэнд тусалж, хангалттай ус өгнө үү? гэж чанга дуугаар хашгирвал устай болно” гэжээ. Өнөө хуврагийн хэлснээр хийсэнд үнэхээр ус урсан гарч иржээ. Гэвч тэд удтал хүлээсэн боловч нөгөө номын багш харагдахгүй болохоор дээш авиран гараад хартал тэр аль хэдийн нас барсан байжээ. Учир нь тэр байсан буянаа бүгдийг нь хэрэглэж дуусгажээ. Тиймээс ид шид хэрэглэх нь тийм сайн биш. Гэвч заримдаа бодьсадва дэндүү нигүүлсэнгүй, хүмүүсийн цангаж үхэхийг харж түвдэхгүй болохоор ид шидээр ус хувилган тэдэнд уулгадаг, гэвч “би үзлээрээ” ид шид хэрэглэсэн болохоор “би үзлээрээ” төлж дуусгах хэрэгтэй. Нэг ид шид хэрэглэвэл нэг амь насаа алдана, ингэх нь нь тийм ч их үнэ цэнэгүй, хэрэв тэр амьд байгаа бол үргэлжлүүлэн бясалгаж болно, бясалгалаараа Будда болж болно, жишээ нь: Арьяабалын номын цогцосыг уламжилж, маш олон төрөлтнийг гэтэлгэж болно. Гэтэл хамаг төрөлтөн бүгд л материаллаг зүйл гуйдаг болохоор багшийн бие махбод ямар байсан ч, үр дүн нь ямар байсан ч заримдаа тэр багш ярихаасаа ичдэг, тиймээс ид шидээр ус хувилгасныхаа дараа тэр нас барсан байна.



## **ХАНЬЦАШГУЙ ҮНЭХЭЭР ТУУЛСАН БОДЬ ХУТАГИЙН ХҮЧ ЖИНХЭНЭ БАГШИЙН ДОТООДОД БАЙДАГ (нэг)**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэйи, Цаглашгүй гэрэлт бясалгалын төв  
1987 оны 4 дүгээр сарын 12*

Авид Бурхан бол хамгийн төгс төгөлдөр нь биш, тэр бол зөвхөн бурхны нэг зүйлийн дэсийг төлөөлдөг төдий, Арьяабал Бурхан мөн л нэг зүйлийн дэсийг буюу чанарыг төлөөлдөг, бид нигүүлсэнгүй сэтгэлийг бясалгаад төгс төгөлдөр болбол Арьяабал бурханы дэсийг олно. Арьяабал бурханы дэс гэж юу вэ гэвэл хамгаас энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл өргөж, төгс төгөлдөр болох үедээ хамаг төрөлтний зовлонт гуйлтын дууг олж сонсдог, аливаа аялгууны дэс хөгжөөд төгс төгөлдөр болох нь Арьяабал бурханы дэс болно. Авид Бурхан мөн л адилхан. Тэр бол ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн зөвхөн нэгээхэн хэсэг нь, Арьяабал бодьсадвагийн нэгэн адил Авид Бурханы дэс нь ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг дахь байр суурь бол хамгийн гэрэлтэй, хамгийн гялбаатай, туйлын гэрэлтэй, туйлын гялбаатай, туйлын нам жим, туйлын гоё сайхан талыг төлөөлдөг. Тиймээс бид түүний алдрыг Амитаба (Amitabha, монголчууд бас Аминдаваа ч гэдэг) гэж магтан сайшаадаг билээ.

Бид ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийг нэгэн Төгс төгөлдөр байр суурь гэж үзвэл, Авид Бурхан нь онцгой гэрэл гэгээ цацруулж, хүмүүсийг дагуулан өөрийн орондоо аваачиж, үргэлжлүүлэн бясалгал хийлгэхийг хариуцдаг. Арьяабал Бурхан харин хүмүүсийн зовлонт гуйлтын дууг сонсох явдлыг тусгайлан хариуцаж, түүнээс аврал гуйдаг л юм бол хамаг төрөлтний ямар ч зовлон байсан хүрч очдог. Зарим хүн эмгэнэн зовж, хүлцэн тэсвэрлэж чадахгүйдээ Арьяабал Бурханаас аврал гуйвал тэр дорхноо тусална, Арьяабал бурханыг харж чадахгүй ч байж магад, гэвч түүний хүч бидний байгаа газрыг гэрэлтүүлж, боломжийнхоо хэрээр бидэнд тусалдаг, заримдаа түүний тусламж нь бидний гуйснаас ондоо байдаг хэдий ч боломжийнхоо хэрээр, юугаар тусалж чадах нь вэ түүгээрээ тусалдаг. Тиймээс ихэнх хүн Арьяабал Бурханд даагдах дуртай. Мэдээж түүнд хүч чадал байдаг, гэвч бидний гуйж олсон зүйл маань оройн дээд төгс гэгээрлийн нэг л хэсэг төдий, учир тэр үед маш их зовж байсан болохоор зовлон зүдгүүрээс авардаг Арьяабал Бурханд даагдадаг.

Гэвч бурханыг харж, өөрсдийнхөө гэрэл гэгээтэй орныг харж,

өөрсдийнхөө хэн болохоо мэдье гэвэл Авид Бурханд даатгах хэрэгтэй, тэрээр гэрэл цацруулан биднийг өөдрөг сэргэлэн ухаантай болгоно, Авид Бурхан бидний дотоодод байгаа гэрлийг жинхэнэ ёсоор таньж мэдрүүлдэг. Харин Оточ Бурхан бол гэрэл цацруулан бидний бие махбодыг эрүүлжүүлж, урт наслуулж, гай зовлонгоос ангижрахад тусалдаг, тэрээр мөн л оройн дээд төгс гэгээрлийн нэг хэсэг болно. Мэдээж өөр бурхад ч бас бий, жишээ нь, Манзушир Бурхан билиг ухааныг төлөөлж, билиг ухаанаа нээх, ном судрыг ойлгох, ямар нэгэн үйл хэргийг ойлгох гэвэл бидэнд тусалж, нилээн түргэн ойлгуулдаг. Очирваань Бурхан харин асар их хүчийг төлөөлдөг, бид хүч чадал мөхөсдөж, сул дорой санагдаж, өөрсдийнхөө үйл түйтгэр юмуу, харш саадаа ялан дийлэхийн аргагүй болох үеэр Очирваань Бурханд даатгавал бидэнд хүч чадал ордог.

Эдгээр нь ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн нэгээхэн хэсэг төдий, хэрэв бид Арьяабал Бурханд даатгавал Авид Бурханыг мартчихдаг, Авид Бурханд даатгавал Оточ Манал Бурханыг мартчихдаг, Оточ Манал Бурханд даатгавал Очирваань Бурхан, эсвэл Манзушир Бурханыг мартчихдаг, өдөр бүр тасралтгүй даатгадаг хэдий ч мөн л маш олон бурханы хүч чадал, өөр бурхад чанарыг алдагдуулдаг, тэгвэл явал зохилтой вэ?

Хэрэв бидэнд цаг зав байвал заримдаа Авид Бурханыг дурсаж, заримдаа Арьяабал Бурханыг дурсаж болно, заримдаа оточ бурханыг дурсаж болно, заримдаа Очирваань Бурхан, эсвэл Манзушир Бурхан гэх мэтээр дурсаж болно. Гэтэл ихэнх хүнд цаг зав байдаггүй, гэхдээ Авид Бурханыг дурсах үедээ зөвхөн түүний алдрыг унших төдий биш, бас төгс баясгалант оронд очих тарнийг унших хэрэгтэй, Оточ Бурханыг дурсахдаа бас гай барцадыг арилгаж, нас уртасгах тарни унших хэрэгтэй, Арьяабал Бурханыг дурсахдаа бас маш олон нууц тарни унших хэрэгтэй, Очирваань Бурханд бас өөрийн гэсэн тарни байдаг, хотол элбэрэлт бодьсадаад бас өөрийнх нь андгай бий, Манзушир Бурхан бас өөрийн тарнитай, тийм олон тарнийг нэг нэгээр нь унших гэвэл чухам хэзээ уншиж дуусах вэ?

Гэхдээ сайшаан магтах, даатгах үедээ заавал чин сэтгэлээсээ байвал ач тустай, гэтэл бид даатгах үедээ чин сэтгэлээ хичнээн цаг барьж чаддаг билээ? Тун бага, тийм үү? Жишээ нь: Таван минут даатгах гэвэл нэгхэн минут нь л чин сэтгэлээс үнэн байж магад, тэр ч байтугай ганцан секунд ч байж чадахгүй ч байж мэднэ, учир нь сэтгэл нь тайвширч чаддаггүй, өдөржингөө эр нөхөр, эхнэр хүүхэд, арилжаа наймаа гэхчилэн олон зүйлийг бодсоор, анхаарал төвлөрч чаддаггүй, иймээс ихэд даатгадаг боловч зөн билиг тийм ч их байж чаддаггүйн шалтгаан нь өдөр бүр дэндүү их яарч, үймсэн сэтгэлээ тайвшруулж чаддаггүй, тайван болъё гэвч болж чаддаггүй. Жишээ нь: дугуй унах, машин жолоодох, онгоцоор нисэх зэргээр түргэн урагшилж байснаа зогсооё гэвэл тэр дорхноо зогсоож чадахгүй, алгуураар хурдаа удааршруулж байж л зогсооно. Гэтэл бидний бодол санаа мөн л тайван болж чадахгүй, нөгөө л ажлаа эхлүүлдэг болохоор хэзээ ч зогсоохын аргагүй. Яагаад гэвэл бидний цаг

зав тун хязгаартай бөгөөд өөрсдөө маш яаруу, заримдаа хоол идэх зав ч байхгүй, идлээ ч гэсэн есөн шидийн юм боддог, хоол идэж байх үеэр хүн ирж үймүүлнэ, төвөг удна, утсаар дуудлага ирнэ, эсвэл тэдэнтэй ярина, хоол идэхийн зэрэгцээ хүнтэй ярилцдаг наймаачид бүгд л ийм байдаг. Хоолны газарт зочдыг урьж залдаг нь хоол идэхийн төлөө биш, харин наймааны тухай ярилцахын төлөө байдаг, хоол идэхийн зэрэгцээ наймаагаа ярилцдаг. Өөрсдийнхөө махан биеэ сайн харж харгалзаж чадахгүй юм чинь “сүнсэн бие” (билиг ухаан эсвэл сүнс гэж ярьдаг)-ээ харгалзахыг бүр ярихын ч хэрэггүй, энэ бие цогцос бол харагддаг, баригддаг, бас мэдрэгддэг, заримдаа өвдөж, заримдаа өвчилдөг гэвч бид тийм ч сайн харж харгалзаж чаддаггүй юм чинь тэр харагддаггүй, баригддаггүй сүнслэг бие буюу билиг ухааныг яаж харгалзаж чадах билээ? Тиймээс төрөл төрөлдөө бурхан чанараа хайж олдоггүй, хамгийн хүчтэй, хамгийн гэрэл гэгээтэй орноо хайж олдоггүй, төрөл төрөлдөө үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэж, энэ ертөнц, энэ материаллаг зүйлд хүлэгддэг, бурхан бодьсадваад даатгасан ч нэмэргүй, учир нь анхааралтай даатгаж чаддаггүй, анхааралтай байя гэсэн ч болдоггүй, зөвхөн нөхцөл байдал маш бачим тулгуу болох үедээ даатгавал бас жаахан зөн билигтэй болж мэднэ. Яагаад гэвэл тэр үеэр байдал маш аюултай бөгөөд өөр арга зам байхгүй болохоор энэ ертөнцийн бүх зүйлийг цөмийг нь огоордог, өөр сонголт байхгүй болчихсон болохоор аргагүйн эрхэнд энэ ертөнцийг огоорч, энэ ертөнц угаас биднийх биш гэдгийг ойлгодог. Үхэл, амьдралын уулзвар дээр зөвхөн энэ амь насаа аврах хэрэгтэй болохоор тэр үед л даатгавал жаахан зөн билиг мэдэгддэг нь чин сэтгэлээс даатгаснаас болдог юм.

Энгийн үед даатгахдаа дотоодоосоо гуйхаа мартчихаад бүгд л гадна талын бурхан, модон бурхныг харж, гадна талыг л чухалд үздэг, бүгд л бурхны хөрөг зургийг харж, түүнээс тусламж гуйдаг болохоор даатгасан ч нэмэргүй байдаг, ихэнх зөн билиг нь бурхны хөрөг зураггүй үед л үүсдэг. Жишээ нь: өвчлөх үеэр орондоо хэвтэж, нүдээ анин Арьяабал Бурханд даатгавал зөн билигтэй болдог, харин заавал сүмд очиж бурхны хөрөг зургийг харвал зөн билигтэй болдог юм биш. Учир нь зөн билиг бол бурхны хөргөөс ирдэг юм биш, хувхай мод яаж адислах вэ? Угаас нэг хэсэг мод байсныг огтолж тайран дахин сийлбэрлэж байж бурхны хөрөг болгож хувиргадаг. Гэхдээ тэр нь бидэнд тусалж чаддаггүй, эсрэгээрээ харин “дотооддоо хандаж уг чанараа ажих”-ад саад болдог, сэтгэлээ цөмийг нь гадагш сарниулж, модонд хандуулан гадна талыг хөөцөлдөнө.

Үнэндээ аливаа зөн билиг дотоод сэтгэлээс ирдэг, Бурхан бидний дотоодод байдаг бөгөөд Эзэн Бурхан ч бидний дотор байдаг. Исүс Христ: “Диваажин та нарын дотоодод байгаа” гэж хэлжээ, Шагжамуни Бурхан ч “Бурхан сэтгэлд байгаа” гэжээ, гэтэл бид харин дотоодоосоо хайхгүй, гадна талын модон бурхнаас хайдаг, ингэж яаж болох вэ? Тиймээс сүм хийдэд очиж мөргөөд тийм ч их зөн билигтэй болж чадахгүй, учир нь бид сэтгэлээ гадагш хандуулаад “дотооддоо хандаж уг чанараа ажих”-гүй байгаа болохоор ихэнх гуйлт бүгд маань тийм ч их ач тусгүй. Жишээ

нь: бид цаг завтай байгаад өдөр бүр залбиран аль ч бурханд даатгасан ч ямар ч нэмэр болдоггүй. Учир нь сэтгэлээ цөмийг нь гадагшаа хандуулдагаас болж байгаа хэрэг. Бурхны хөрөг зураг ид шидтэй болоод амьд хүн болж хувирлаа ч гэсэн тэр нь мөн л хуурмаг бурхан, модноос бүтсэн бурхан юм чинь яаж үнэн байж чадах вэ? Бидний бие махбодоос хувиран гарч ирсэн бурхан бүгд л найдваргүй байтал модоор бүтсэн бурхан яаж найдвартай байх вэ? Тийм бурхад бүгд л хий бодлоос үүссэн болохоор жинхэнэ бурхан биш.

Модон бурхан бидэнд тусалж чадахгүй, тэгсэн мөртлөө харин бидний яагаад хүлээсэлдэг вэ гэвэл бидний сэтгэл тэр чигээрээ гадагшаа хандсан болохоор өөрийн биеэ хайж олдоггүй. Жишээ нь: багш чинь нэг малгай өмсөж байлаа гэхэд өдөржингөө анхаарлаа гадагшаа сарниулдаг болохоор малгайгаа хаа байгааг санахгүй, малгай угаас багшийн чинь толгойд байгааг ч мартчихдаг. Тиймээс гаднах үзэмж байдал малгайг хайж олоход тусалж чадахгүй бөгөөд анхаарлыг өөр тийш шилжүүлж, малгай угаас толгой дээр байгааг мартуулж, толгойдоо малгай өмссөн эсэхийг ч мартуулдаг.

Яг л нүдэндээ шил зүүдэг зарим хүн шилээ гартаа атгачихаад бусдаас миний шил хаана байна, харав уу? Надад тусалж шилийг минь хайгаарай гэдэгтэй адил, тэгээд туслах хүн үгүй бол өөрөө удтал хайсан ч олдоггүй, хэрэв өөр нэг хүн шил чинь энэ байгаа юм биш үү гэж хэлэх үед өө тийм байна, би яасан эргүү толгой вэ гэж ухаардаг.

Үүнтэй адилаар, өөрийн биеэ хайх юмуу, бурханд даатгах үедээ сэтгэлээ гадагш шилжүүлж болохгүй, сэтгэлээ гадагшаа сарниах нь буруу номтон болно. Учир нь Мөр (Дао) дотоодод байдаг, диваажин ч дотоодод байдаг, бурхан сэтгэлд байдаг, тэднийг хайя гэвэл дотоодоосоо хайх хэрэгтэй. Дотоодод гэхээр бас дотоод биш, зохистой үгээр илэрхийлэхийн аргагүй болохоор л дотоод гэж ярьж байгаа хэрэг, тиймээс та нар дотоод гэдгийг гэдэс дотор, эсвэл аль нэг дотоод эрхтэнд байгаа гэж битгий бодоорой.

Яагаад дотоод гэж хэлдэг вэ гэвэл бид үргэлж ийш, тийшээ хардаг нь бүгд гадна тал, одоо эргэж өөрийнхөө биеэ харах хэрэгтэй болохоор дотоод гэж хэлдэг. Хэрэв гадна талын бурхны хөргийг хараад дадчихвал дахин өөрсдийнхөө дотоодыг харах гэвэл тун ч хялбаргүй, аль хэдийн дадал зуршилтай болчихсон болохоор бурхны хөргийг л харахгүй бол хүлээн зөвшөөрч чаддаггүй.

Энэ нь яг л гэрлэхтэй адилхан, эхнэр, нөхөр хоёр хэдэн арван жил хамт амьдраад хэдийнээ дасчихсан болохоор нэг өдөр эхнэр нь, эсвэл эр нөхөр нь гэнэт зугтчихвал тэд маш их шаналан зовдог, хэрэв угаас ганцаар амьдраад дадчихсан бол бусдын зугтахыг харсан ч санаа зовдоггүй, хичнээн олон хүн салж одож, хичнээн олон хүн дахин буцаж ирсэн ч бидэнд өчүүхэн ч нөлөөлөхгүй, сэтгэл шаналахгүй. Үүнтэй адилаар сэтгэлээ гадагш нь сарниулж дадаагүй бол дотоод сэтгэлээ ажихад тун хялбар болно. Хэрэв гадагшаа хараад дасчихвал дотоодын уг чанараа ажихад тун бэрх болно.

Бясалгал хийхэд мөн л ийм, “сэтгэлээ” доод дэсийн төвд

төвлөрүүлээд дадал болчихсон байвал дараа нь хамгийн дээд төв хэсэгтээ төвлөрөх гэвэл тун амаргүй болдог. Тиймээс бясалгахгүй бол бас яахав, бясалгал хийе гэвэл хамгийн дээд номын аргыг бясалгах хэрэгтэй. Жинхэнэ ёсоор багштай уулзаагүй бол бясалгахгүй байх нь хамгийн сайн, тэгэхгүй бол бясалгах тусам яршиг төвөг их болж, эцсийн эцэст бидэнд саад харш болж хувирдаг. Сэтгэлээ доод төвшний эрхтэндээ хандуулаад дадчихсан болохоор эрхбиш нэг хэсэг хугацаанд дадуулж байж л өөрчилж чаддаг. Гэтэл тийм бясалгалын аргаар бясалгаагүй хүний хувьд өөрийн бурхан чанараа эрж олоход маш түргэн байдаг, тиймээс дур зоргоороо бясалгавал өөрсдөдөө саад хийнэ. Зарим хүн олон төрлийн номын цогцосыг бясалгах дуртай, ихэнх нь ид шидтэй болдог, гэвч тэр ид шид нь эсрэгээр буруу номтон болгож, буруу номлол тийш хөтөлнө, ид шидэд шунаж, хий хуурмагийг бодох дуртай, тархи толгой нь дэндүү их төөрөлдөхийн эрхээр жинхэнээр туулан гэтлэх зорилгоо мартдаг, тиймээс ид шидийг бясалгах нь ямар ч ач тусгүй, харин хор хөнөөлтэй.

Хэн нэг хүн ид шидтэй, бусдын өвчнийг эмчилж чаддаг, өнгөрсөн, одоо, ирээдүйг нь харж чаддаг, эсвэл бусдын өмнөөс ямар нэгэн үйл хэргийг хийж чаддаг гэж үргэлж л сонсогддог, тэд ид шидийг ил тод үзүүлдэг болохоор тун их нэрд гардаг. Үнэндээ энэ нь тийм ч сүрхий юм биш, надад тийм хүн тун өрөвдөлтэй санагддаг, туулан гэтэлж чаддаггүй, тун олон саад бэрхшээл тохиодог, хичнээн олон жилийг өнгөрүүлсэн ч туулан гэтэлж чаддаггүй. Гурван ертөнцийн доторх өчүүхэн ид шидэд хүлэгддэгээс болоод салж чаддаггүй, туулан гэтлэхийн аргагүй, өөрөө туулан гэтэлж чаддаггүй төдийгүй өрөөл бусдыг ч туулан гэтэлгэж чадахгүйд хүрдэг, тийм ид шидэд шунамагц жинхэнээр туулан гэтэлгэх бясалгалын аргыг бясалгахад тун бэрх болно, яг л хүүхэд тоглоомдоо дэндүү сэтгэл татагдан суралцахгүй, дэвшиж хөгжиж чадахгүй болдогтой адил.

Хүүхэд чихэр бурамд тун дуртай, тэгээд их идсэний дараа хоол идэхээ больж, шүд нь хорхойтож, шим гэжээл дутагддаг. Эсвэл угж хөхөх дуртай хүүхэд шиг угжгүй үедээ гарынхаа хурууг хөхөөд байвал гарын хуруу нь улам жижигхэн болоод харахад муруй сарий, ажил хийхэд саад болно. Аав, ээж нь энэ муу дадал зуршлыг нь өөрчлөх гэвэл бас ч тун бэрх, удтал дадуулж байж л өөрчилж чаддаг. Угаас ингэж дадуулах шаардлагагүй, учир нь гарын хурууг үсэг бичих, ажил хийхэд ашигладгаас биш, угж болгон хөхөж болохгүй, гэвч аль хэдийн дадал суучихсан болохоор жинхэнэ ажлаа мартчихжээ. Тиймээс өөрчлөх хэрэгтэй. Бас нэг жишээ нь, хүүхэд гадаа зайрмаг худалдаж байгаа чимээг сонсонгуутаа дорхноо сэтгэл татагдан худалдаж авахгүй ч гэсэн харахаар очдог, ээж нь хоолоо бэлэн болгоод удтал хүлээсэн ч хүүхэд нь хоолоо идэх дургүй болдог, хөнгөн зууш нь хоолноос бүр ч сэтгэл татах хүчтэй, ид шидийн байдал нь хөнгөн зууштай адил. Яагаад гэвэл тэр нь ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн дотор байдаггүй, ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг нь тийм ил тод ид шидийг багтаадаггүй. Их Багш нарт хамгийн дээд ид шид байгаа хэдий ч

хэрэглэх үеэр нь хэн ч мэддэггүй бөгөөд ”би” ид шидтэй гэдгээ хүмүүст мэдэгдэхийн төлөө биш байдаг. Харин хамаг төрөлтийг аварна, үхэж, төрөхөөс ангижруулахын төлөө л гэх ганцхан зорилгоор ид шид хэрэглэдэг. Гэхдээ бусдын өчүүхэн өвчнийг эдгээхийн төлөө ид шид хэрэглэдэггүй, иймээс тиймэрхүү энгийн ид шидтэй адилгүй. Хэрэв ид шидийг жинхэнээр хэрэглэе гэвэл эхлээд бурхан бодьсадвагийн дэсийг олсны дараа хэрэглэж болно. Бурхан бодьсадвагийн дэсийг олохоос өмнө хэрэглэх нь бүгд л адын ид шид, бүгд л хий бодол, бүгд л хүүхдийн тоглоом төдий.

Хүний тархи толгойд хүч чадал их байдаг, миний ярьж байгаа нь уураг тархи шүү, харин сэтгэл биш, хятад хэлэнд аливаа юмыг бүгдийг сэтгэл гэж нэрлэх дуртай, бид ямар ч бясалгалын аргыг бясалгасан ч бай, “билгийн мэлмий”-гээс доош бясалгаж байгаа л бол бүгд энэ Mind (тархи толгой)-д багтана. Ингэх нь Бурханы Мөр (Дао)-ийг бясалгаж байгаа биш, харин буруу номлолыг бясалгаж байгаа хэрэг юм. Үнэндээ буруу номлол гэхээр бас буруу гэмээр зүйл биш, ид шид нь орчлонгийн дунд зөвхөн тун доод дээд харьяалагддаг. Тийм өчүүхэн ид шид нь том ид шид шиг харагддаг боловч үнэндээ ямар ч найдваргүй.

Яг бяцхан хүүхдийг харахад том хүнтэй төстэй, гадаад төрх нь адилаватар боловч том хүний ажлыг хийж чадахгүй, тиймээс мэдээж ондоо байдаг, учир нь хүүхдийн хүч чадал хараахан бүрэлдээгүй, машин жолоодож чаддаггүй, тоглоомын жижигхэн хуванцар машинаа л жолоодож, тун ч омголон давхидаг, ном уншиж чаддаг хэдий ч зөвхөн хүүхдийн ном сэтгүүлийг уншдаг, үсэг бичиж чаддаг хэдий ч хэдхэнийг л бичиж чаддаг, тиймээс том хүнтэй адилгүй.

Тархи толгойд харьяалагддаг ид шид нь мөн л гурван ертөнцийн дотор байдаг, гэтэл ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг нь гурван ертөнцийн гадна байдаг. Тиймэрхүү өчүүхэн ид шид нь гурван ертөнцийн дотор хүлээсэлдэг, гэтэл Их Багш нарын ид шид нь Авид бурханы ид шид, Арьяабал Бурханы ид шид, Оточ Бурханы ид шид, Очирваань Бурханы ид шид, Манзушир Бурханы ид шид бөгөөд энэ бол хамгийн дээд ид шид мөн. Харагддаггүй, баригддаггүй, магадлах аргагүй Тэднийг ид шид хэрэглэх үед хэн ч мэддэггүй, тэнгэрийн төрөлтөн ч мэдэж чадахгүй, эгэл хүмүүс бүр ч мэдэхийн аргагүй.

Ид шид хэрэглэх үед эгэл хүмүүс ч гэсэн бүгд мэдэж, магадалж чаддаг юм бол, тэр нь жинхэнэ ид шид биш гэдгийг мэдэж болно, яг л хүүхдийн тоглодог хуванцар машин шиг, харахад жинхэнэ машинтай төстэй боловч чадамж нь маш их зөрүүтэй, тоглоомын машин нь жижигхэн бөгөөд хэрэгцээгүй. Их Багш нарт ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн ид шид байдаг боловч өөрсдөө харин ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг биш, учир нь тэд ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн хүчийг олсон болохоос ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг болоогүй юм. Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг мөн нь мөн, гэвч бас биш, яагаад гэвэл энэ махан бие байгаа үед ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг биш, гэтэл түүний бие махбодод аливаа хүчин чадал бүрэн байдаг. Авид Бурхан, Арьяабал Бурхан, Оточ

манал Бурхан, Манзушир Бурхан бүгд тэр мөн, тиймээс оройн дээд төгс гэгээрэл ханьдашгүй үнэхээр туулсан бодь хутаг нь хүний бие махбодоор дамжиж л ажилладаг гэж хэлж болно.

Энгийн үед бид ганцхан бурхнаас аврал гуйвал тийм ч их нэмэргүй. Авид Бурханд даатгах үед түүнийг харж чадахгүй болохоор бидний тархи толгой тийм ч ихээр холбогдож чадахгүй, тэгэхээр тийм их зөн билиг мэдрэгддэггүй. Бид Арьяабал Бурханыг харж чадахгүй, Оточ Бурханыг харж чадахгүй, өөр бусад бурхан бодьсадваг харж чадахгүй болохоор яаж даатгасан ч тийм их зөн билиг мэдрэгддэггүй. Хэрвээ нэг хүн тэр бурхадыг төлөөлж, энэ ертөнцөд заларвал л бид түүнтэй холбогдож чадна.

Хүн бас ийм, ойр дотнын хүнээ бодох үеэр нүдээ анимагц дорхноо санаж олдго. Гэтэл ерөөс танихгүй хүнийг дүрслэн бодох боломж байж болох уу? Бодох боломж ч байхгүй юм чинь сэтгэл төвлөрч яаж чадах вэ? Сэтгэл төвлөрч чадахгүй бол зөн билиг мэдрэгдэж чадахгүй. Тиймээс бурхан бодьсадваг төлөөлдөг нэг хүн энд ирэх хэрэгтэй, ингэснээр оточ бурханыг дурсах үеэр дорхноо санаж төсөөлнө, оточ бурханыг санаснаар түүний хүчийг биедээ шингээж, бидний өвчин эдгэрнэ. Тиймээс бид өвчнөөс аврагдах гэж даатгах үедээ энэ ертөнц дэх оточ бурханыг төлөөлдөг амьд багшид даатгавал ач тустай, учир нь түүний биед аливаа хүч чадал цөм байдаг, бидэнд төвөг бэрхшээл тохиолдох үед түүнээс гуйдаг л юм бол тэрээр Арьяабал Бурханы хүчийг бидэнд дамжуулах буюу бид түүний бие дэх Арьяабал Бурханы хүчийг шингээн авдаг. Түүний бие цогцос нь бидэнтэй адил бөгөөд бидэнтэй тун ойр дотно болохоор харилцан ойлголцоход маш хялбар, түүнд даатгадаг л юм бол бидэнд тусална. Яг л утасддагтай адилхан, түүний утсыг авмагц дорхноо холбогдож чадна, учир нь аль хэдийн танилцаж, харилцаа холбоотой болчихсон болохоор санаж олоход тун хялбар.

Бид зовлонд унах үед Арьяабалын хүчийг биедээ татдаг, хэрэв билиг нээгдэх гэвэл эрхиш гэрэл гэгээ хэрэгтэй, тиймээс Авид Бурханы гэрлийг татдаг, билиг ухаантай больё гэвэл Манзушир бурханд даатгана, хүчин чадалтай болж бусдад туслая гэвэл Очирваань Бурханы хүчийг татна, зөвхөн ганцхан хүнд даатгасан төдийхөн байлаа ч харин юу хүснэ, түүнийгээ олж чадна. Тиймээс багш өвчин зовлонгоос аварлаа гэж зарим хүн хэлдэг, үнэндээ би авраагүй, ид шид гаргаж, өвчин зовлонгоос нь авраагүй. Гэтэл нэгэн жинхэнэ Их Багшид ийм хүчин чадал бүрэн байдаг, түүнд даатгадаг л юм бол тэр хүч чадал аяндаа тусална, багш чинь юу ч хийх хэрэггүй, ид шид хэрэглэх шаардлагагүй, ид шид үзүүлэх нь хүүхэд тоглоомын машинаараа тоглохтой адил гэж би нэгэнт ярьсан.

Нэгэн Их Багшийн ид шидийг ид шид гэж хэлж болохгүй, тэр нь хамгийн дээд адислах хүч юм, хүнийг аварна, гэвч авардаггүй, энэ нь энгийн авралт биш. Зарим хүн бясалгаж суугаа үедээ багш бол зургадугаар үеийн өвөг багш Хүй Нэн, эсвэл Их Багш Ин Гуан, Бодьдармаа, Шагжамуни Бурхан, Очирваань Бурхан, Газрын зүрхэн Бодьсадва, Авид Бурхан, Арьяабал Бурхан мөн болохыг хардаг, үнэндээ

багш чинь нэг л хүн байдаг хэдий ч хүн бүрт ондоо ондоо харагддаг, гэхдээ би тэр хүнд Арьяабал Бурхан, нөгөө хүнд Авид Бурхан болж хувиран харагдаж байгаа юм биш, харин “дотоодын багш”, төгс төгөлдөр хүчээс хувиран харагдаж байгаа билээ. Ийнхүү хүн бүр зөвхөн жижигхэн хэсгийг л харж байгаа төдий, тиймээс тэд багш бол тийм, ийм байдалтай гэж ярьдаг, багшийгаа бүхэлд нь харж чаддаггүй, зөвхөн чих, гар гэх мэтийг нь л хардаг, үнэндээ хөл, толгой гэх зэрэг нь байх боловч харин дотоодын зүйлийг нь харж чаддаггүй.

Энэ бол бидэнд яагаад заавал нэгэн Их Багшийн хайр хэрэгтэй байдгийн шалтгаан юм. Учир нь түүнд ямарваа хүчин чадал бүрэн байж, бид юу хүснэ, түүнийг маань өгдөг, тэрээр юу ч хийх шаардлагагүй, түүнд төгс төгөлдөр хүчин чадал байгаа болохоор аливаа зүйл нь аяндаа бүтэж байдаг. Яг л цэцэг шиг, бидэнд зориудаар анхилуун үнэр ханхлуулах шаардлагагүй, цэцэг угаас анхилуун үнэртэй болохоор аяндаа сайхан үнэр сэнгэдэг. Зандан модны сайхан үнэр нь бас зориудын биш, эсвэл бид ямар нэг зүйл үйлдсэнээс болсон биш, харин аяндаа, угаасаа тийм анхилуун үнэртэй. Үнэртэй ус бас л адилхан үнэртмэгц сайхан үнэр сэнгэнэж, ер хүсээгүй ч гэсэн сайхан үнэртэй, үнэртэй ус өөрөө юу ч бодохгүй ч сайхан үнэр сэнгэнэж л байдаг. Усны урсгал бас тийм, зориудаар чанга дуу чимээ гаргаж, би бол ус гэдгээ бидэнд мэдүүлдэггүй, зориудаар ус хувиран бидэнд уулгадаг биш, тэр угаас ус болохоор бид ууя гэвэл шууд л ууж болно, харин зориудын биш бөгөөд тэгэх ч шаардлагагүй, ус хайгаад олдог л юм бол ууж болно.

Үүнтэй адилаар, Арьяабал Бурханд даатгах үед бас нэгэн амьд бурхныг хайх хэрэгтэй, тэрээр Арьяабал Бурханы хүчийг энд авчирч, бидэнд дамжуулж чаддаг, Авид Бурханд даатгах үед ч гэсэн бас ийм хүнийг эрэх хэрэгтэй, учир нь тэр бас Авид Бурханы хүчийг энд авчирч чадна, Оточ Бурханд даатгах үед мөн тийм хүнийг эрэх хэрэгтэй, түүний цүнхэнд бас Оточ Бурханы хүч байдаг. Яг л их дэлгүүрт аливаа зүйл бүрэн байдагтай адил, дүүфүү, ямар нэг эд зүйл худалдан авъя гэвэл бүгд байдаг. Мэдээж дүүфүү зардаг дэлгүүрээс бас дүүфүү худалдан авч болдог боловч их дэлгүүрт юм юм байдаг болохоор маш дөхөм хялбар.

Бид бурхан бодьсадвад даатгах үед зөвхөн нэгээхэн хэсэгт нь даатгадаг төдий, хэрэв бүхэлд нь даатгая гэвэл хамгийн сайн нь төрөл бүрийн адислах хүчтэй нэгэн амьд бурхныг хайх хэрэгтэй. Жишээ нь: нэг хүн зөвхөн нигүүлсэнгүй сэтгэлтэй болохыг хүсэх, эсвэл зовлонгоос ангижрахыг хүсвэл яриангүй Арьяабал Бурханд даатгаж болно. Зөн билигтэй болох эсэх нь та нарын чин сэтгэлээс шалтгаална. Төгс баясгалант оронд заяахыг хүсвэл Авид Бурханд даатгаж болно, гэвч төгс баясгалант оронд очиж чадах эсэх нь ондоо зүйлийн хэрэг явдал.

Гэтэл бид Авид Бурхан, эсвэл Арьяабал Бурханы хүч бүрэн байдаг хүнийг хайж олбол нилээд баталгаатай, учир нь тэр энэ ертөнцөд оршин амьдарч байдаг. Бид Авид Бурхан, Арьяабал Бурханд даатгах үедээ харж чадахгүй бөгөөд туслах эсэхийг нь ч мэдэхгүй. Гэтэл бурхан бодьсадвагийн хүч бүрэн байгаа нэгэн амьд хүн бидэнтэй адил энэ ертөнцөд амьдран оршиж харагддаг бөгөөд баригддаг, түүнд нууц



гэмээр зүйл байдаггүй, бид нэгэнт мэдчихсэн тэр хүн нуун далдалъя гэж бодовч ямар ч нэмэргүй, ингэснээр л бид итгэж найдмаар оронтой болж чадна, тиймээс нилээд баталгаатай. Бурхан бодьсадвад даатгаа гэвэл бас тийм хүнийг эрх хэрэгтэй, учир нь тэр Авид Бурхан, Арьябал Бурхан, Оточ Бурханаас томилсон бүрэн эрхт төлөөлөгч юм, түүнд хүч чадал өгдөг. Жишээ нь: заримдаа улсын хаан ажилтай болоод өөрийн биеэр очиж чадахгүй байлаа ч элч томилон зарлигийн бичгээ илгээж болно. Хууль зөрчсөнөөс болж алах ялахаар шийтгэгдэх болсон ялтныг хаан өршөөсөн байвал элч томилон зарлигийн бичгээ илгээж болно. Томилогдсон элч мориор довтолгон ялтныг шийтгэхээс нэгхэн минутын өмнө цаазын талбайд амжиж хүрээд: “Түр хүлээж байгаарай хааны зарлигийн бичиг хүрч ирсэн” гэж чанга дуугаар хашгирдаг. Ингэснээр хүмүүс бүгдээрээ газар сөхрөн хааны зарлигийн бичгийг хүндэтгэн тосч, ялтныг алж зүрхлэхгүй, үг ярьж зүрхлэх хүн үгүй болно. Томилогдсон элч мэдээжээр хаан биш байлаа ч хааны зарлигийн бичигтэй, хааны эрх мэдэл, хүч чадлыг төлөөлдөг болохоор бүгд сөхрөн ялтан ч хааны өршөөлөөр аврагддаг.

Тиймээс хүнийг аварья гэвэл хааны өршөөл хайрласан зарлигийн бичиг авч яваа элчийг эрвэл арай түргэн байдаг, учир нь хаан хаана байгааг мэдэхгүй, мэдлээ ч гэсэн аварч амжихгүй, холын ус цангасан хүнд нэмэр болдоггүй, тэгэхлээр хааныг хүлээвэл бүр ч төвөгтэй болно. Хаан залрахдаа олон хүнээр хамгаалуулдаг бөгөөд түргэн явах боломжгүй, иймээс элч томилон зарлигаа илгээвэл нилээд түргэн, элч хэдийгээр хаан биш боловч хааныг төлөөлөн ялтныг аварч чадах бөгөөд түүнд хааны эрх мэдэл бүрэн байдаг.

Үүнтэй адилаар, нэгэн амьд сэрүүн байгаа Их Багш хэдийгээр Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг биш боловч, түүнд ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн хүч бүрэн төгс байдаг, учир нь ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн шинж чанар болон эрх мэдлээ бүгдийг түүнд өгсөн болохоор хэнийг ч чухам аварч чадна. Тиймээс ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг биш, гэхдээ бас мөн гэж багш чинь ярьж байгаа юм. Ингэж ярихыг сонсоход тун зөрчилтэй юм шиг санагддаг, та нар ойлгох эсэхийг би мэдэхгүй.

Миний шавь нар долоо хоногийн даяаны үеэр бүгдээрээ өөрсдийнх нь хүч улам хөгжин дэвшиж, улам их болсныг ойлгож мэджээ. Энэ хүч хаанаас ирсэн бэ, жишээ нь, нэгэн том цахилгаан станц буюу цахилгаан үүсгүүрээс нэг ширхэг цахилгаан утас залгахивал бүх улс орон нэлэнхүйдээ гэрэлтэй болж, хоол цай хийх, ус буцалгах, дуу хураах гэхчилэн юу ч хийж болно. Цахилгаан утас бүдүүн байх тусам дамжих цахилгааны хүч их болно, цахилгаан утас дэндүү нарийн байвал цахилгааныг их хэрэглэх үед шатчихдаг, цахилгаан утас маш бүдүүн, цахилгаан үүсгүүрийн хэмжээтэй ойролцоо байвал маш олон зүйлд ашиглаж болно. Жишээ нь: энэ цахилгаан үүсгэгч нь бүх улсыг хангалттай үйлчилж чадахад хүрвэл бидний цахилгаан утас ядаж л бүх тосгоныг хөгжүүлж чадна. Тэгэхгүй бол бясалгал хийсний хэрэг юу вэ? Цахилгааныг ашиглаж чадахгүй бол цахилгаан үүсгүүр байсан

ч хэрэгцээгүй, бидний гэр мөн л харанхуй хэвээр, өдөр бүр цахилгаан үүсгэгчээс гуйсан ч тэр биднийг цахилгаанаар хангахгүй, учир нь цахилгаан утас байхгүй болохоор юу ч хийж чадахгүй.

Нэгэн жинхэнэ Багшийн ахмад шавь нь хаа очно, тэр газар ондоо болж, адислагддаг. Түүнийг ирмэгц тэр газар дорхноо өөр болдог гэж бид сонссон. Шавь нь байтлаа ийм их адислах хүчтэй байгаа юм чинь багшийг нь бүр ч ярих юм биш, иймээс бид юу ч сурсан үр дүнтэй байх эсэхийг анхаарах хэрэгтэй. Харин маани тарни унших, нууц тарни бясалгах, даяан бясалгах гэх мэтчилэн сохроор бусдыг даган дуурайж болохгүй, ингэсний эцэст цагаа талаар үрэх болно. Багшаасаа дөнгөж эхлэн сурч байгаа шавь байтлаа адислах хүчтэй байдаг, тиймээс бясалгалын энэ аргыг сурах нь ач тустай, зөн билигтэй, жинхэнэ бясалгалын арга мөн гэдгийг та өөрөө ч гэсэн ойлгодог. Тэгэхгүй бол энэ номын ач буян, адислах хүчийг яаж мэдэх вэ? Жишээ нь: нилээд хэдэн сар ажилласан байхад дарга маань цалин өгөхгүй юм бол тэр чухам мөнгөтэй юу, үгүй юу? Үйлдвэр нь сайн уу? гэдгийг яаж мэдэж чадах вэ? Мөнгөтэй гэж тэр надад ярьдаг боловч харин бидэнд цалин өгөхгүй, бүгдээрээ өлсөж үхэх шахсан байхад мөн л мөнгө өгөхгүй юм бол дарга гэж хэлж болох уу? Бусдыг мэхэлж байгаа, тэр ч байтугай, өөрөө ядуу хоосон амьтан байж ч мэднэ. Хоёулаа адилхан ядуу байтал бид түүнийг дарга гэж бодох нь дэндүү тэнэг хэрэг биш үү? Дарга бологсод үлэмж их мөнгөтэй, долоо хоног, эсвэл сар болгон биднийг жаахан цалинжуулж, амьдралыг минь залгуулах хэрэгтэй, долоо хоногоор ажил хийлгэхчээд мөнгө өгөхгүй юм бол бид түүнийг хүндэтгэсний хэрэг юун, дарга болгох хэрэг байна уу?

Үүнтэй адил, нэг хүнийг өөрсдийнхөө багш болгож хүндэтгэн тахих гэвэл түүний хүч чадлыг сайтар ойлгож, ядаж л хожим бага зэрэг хүчтэй байж чадах эсэхийг нь шалгах хэрэгтэй, ингэж байж л бидний багш болох ёстой. Багш хүн билиг ухаанаар гүн, дээсэр биднээс өндөр, хүчээр биднээс их болохоор багш гэж хүндлэн дээдэлдэг. Харин багш болгоныг хармагц сөгдөн мөргөж, шүтэн дагаж шавь нь болдог юм биш, ингэсний эцэст тэрээр бидэнд юу ч өгч чадахгүй, бидэнтэй адил үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэж, бидэнтэй адил харанхуй мунхаг гурван ертөнцөд зовлон амсвал багш гэж тахих хэрэг юун.

(Ши) гэдэг нь багш гэсэн утгатай, (Пү) гэдэг нь аав гэсэн утгатай (Ши пү) нь багшилж, биднээс илүү ихийг мэдэж, биднийг удирдан дагуулж чадна гэсэн утгатай, тиймээс багш гэж хүндэтгэн дууддаг. Үүний зэрэгцээ тэр бол бас бидний аав, учир нь биднийг төрүүлж “шинэ амь нас” олгож чаддаг.

Тиймээс нэгэн багш бол бидэнд “жинхэнэ” амь нас олгож чаддаг, төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэхээс ангижруулах ёстой, ингэснээр нь л “жинхэнэ” багш болно. Ингэж чадахгүй бол бусдын багш болох хэрэггүй, үсээ хусуулж, бусдаар хүндлүүлэхээр л багш болчихдог юм биш. Тайваньд багшийн тухай ухагдахуун тийм ч тодорхой биш, хэн ч бай хамаагүй, үсээ хусуулсны нь дараа түүнийг багш гэж дууддаг, ингэж санаан зоргоор дуудаж байгааг нь үргэлж сонсдог, тийм багш бол

зөвхөн нэг зүйлийн дуудлага нэр төдий, харин жинхэнэ багшийн хүч чадал түүнд үнэндээ байхгүй.

“Багш” гэж хүндэтгэн дууддагийн шалтгаан нь тэр биднийг удирдан дагуулж туулан гэтэлгэдэг, биднийг заан жолоодож, өөрсдийнх нь ”багш” (эсвэл жинхэнэ бие, жинхэнэ эзэн, уг дүр гэхчилэн нэрлэдэг)-ийг, өөрсдийнхөө багшаа хайж олоход тусалдаг, “аав” гэж хүндэтгэн дууддагийн шалтгаан нь тэр яг аав шиг бидний ”жинхэнэ бие”-ийг төрүүлж, мөнхийн амь нас олгодог. Эгэл хүмүүсийн аав бологсод ядаж амь, махан бие олгож чадна, гэтэл нэгэн энгийн багш юу ч олгож чадахгүй, мэдээжээр бидэнд махан бие ч олгож чадахгүй, “жинхэнэ бие”-ийг ч өгч ч чаддаггүй, тэр ч байтугай өөрийнхөө жинхэнэ биеийг хайж олж ч чадахгүй юм чинь, бидэнд жинхэнэ бие олгож яаж чадах вэ? Тиймээс ийм хүн хүн жинхэнэ багш биш, ойлгож байна уу?

## ХАНЬЦАШГҮЙ ҮНЭХЭЭР ТУУЛСАН БОДЬ ХУТАГИЙН ХҮЧ ЖИНХЭНЭ БАГШИЙН ДОТООДОД БАЙДАГ (хоёр)

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй, Цаглашгүй гэрэлт бясалгалын төв  
(Эх нь хятад хэлээр)  
1987 оны 4 дүгээр сарын 19*

Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг гэдэг юу болохыг та нар мэдэх үү? Нэгэн Католик шашинтан, хэрэв Буддын шашны нэрд дургүй юмуу, хэрэглэж дадаагүй бол ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийг “Эзэн Бурхан” гэж дуудаж болно. Луузын сургаалтан (Бумбын шашин), “Мөр” (Дао) гэж дуудаж болно. Самгарьд хэлээр ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийг Маха Пражна Парамита (Maha Prajna Paramita) гэдэг, зүрхэн сударт түүнийг билиг барамид гэж нэрлэдэг. Билиг барамидыг самгарьд хэлээр Маха Пражна Парамита гэдэг.

Одоо багш чинь бурхан бол Маха Пражна Парамита биш, бас мөн гэж ярьж байна. Миний ярьж байгаа бурхан гэдэг нь амьд сэрүүн байгаа бурхныг хэлж зааж байгаа юм, харин Төгс баясгалант орны бурхныг зааж байгаа биш. Төгс баясгалант орны бурхан болон амьд сэрүүн байгаа бурхан бүгд л бас Маха Пражна Парамита биш. Яагаад гэвэл нэгэн амьд бурханд амьд чанар бүрэн байдаг, түүний биед одоогийн бурхан, урьдын бурхан, ирээдүйн бурхан болон арван зүг, гурван цагийн бурхад байдаг бөгөөд маш олон бодьсадва, маш олон луугийн сахиуст ном хамгаалагч байдаг, аливаа зүйл, аливаа ер бусын хүч бүгд байдаг гэж өнгөрсөн долоо хоногт ярьсан. Тиймээс хэн нэгэн хүнийг аварья гэвэл авшиг хүртсэн эсэхийг нь хамааралгүй тэр дор нь аварч чаддаг.

Ихэнх хүн авшиг хүртэх гэдэг юу болохыг мэддэггүй. Зургадугаар үеийн өвгө Хүй Нэн Багшийн “Ном эрдэнэ мандал” сударт “Сэтгэлийн авшиг уламжлах” гэж ярьсныг бид “авшиг хүртэх” гэж хялбарчлан нэрлэжээ. Авшиг хүртэх гэдэг нь ном уламжлах үед хамгийн дээд номыг уламжилж, бидний билгийн мэлмий - номын нүдийг нээдэг. Энэ “номын нүд” (багш билгийн мэлмийгээ заав) энд байдаг, буддын шашинтан бүгд мэднэ, Шагжамуни Бурханы магнайны голд нь нэгэн толбо байдаг нь гуравдугаар нүд, эсвэл номын нүд болно. Эртний даяаны бүлэгтний өвгө багш нар “түүнчлэн ирсэн” (билгийн мэлмийг нууцлах аргыг Махакашибаас эхлэн уламжлав) гэж байнга ярьдаг нь ийм учиртай. Гэтэл одоогийн хүмүүсийн ихэнх нь үүнийг ойлгодоггүй, бясалгалын арга тун олон байдаг хэдий ч бүгд энэ “билгийн мэлмийг нууцлах

аргатай” холбоогүй, “Билгийн мэлмийг нууцлах арга”-ын уламжлал тасарчихсан шиг байна.

Библи сударт: “Хэрэв нүд чинь нэг болж хувирвал бүхий л бие махбод гэрэл гэгээтэй болж хувирдаг гэж өгүүлсэн байдаг. Энэтхэгийн шашинд бас адилхан зүйлийг ярьжээ, тэд Тисра Тил (Tisra Til) гэж ярьдаг, энэ бол самгарьд үг, мөн л нүд гэсэн утгатай юм. Үнэндээ аливаа шашин угаас адилхан, эртний бясалгалтнууд бүгд л жинхэнэ номын аргаар бясалгаж байжээ. Бясалгалын ямар нэг дэсэд хүрвэл эхлэн ном дэлгэрүүлдэг, тиймээс зарим Их Багшийн дэс нь нилээд өндөр, заримынх нь нилээд доор байж магад, энэ нь тэдний өөрсдийнх нь бясалгалын чармайлт хэр зэрэг байгаагаас шалтгаална, харин бясалгалын арга нь адилгүйгээс болсон юм биш.

Багш чинь та нарт “Аливаа бясалгалын арга нь Арьяабалын бясалгалын арга мөн” гэсэн гарын авлагыг хэвлэн тараасан. Гэртээ хариад уншаарай. Өнөөдөр, ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийн сайн болон муу талыг ярина гэж амласан болохоор тэдний дэсийг ярихгүй, нэгэн Их Багшийн дэсийг мэдь гэвэл түүний сургаал номлолыг уншвал л магадалж чадна. Долоо хоногийн даяаны үеэр багш чинь зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн Багшаасаа бадар аяга, орхимж тосон авсан үеийнх нь дэс нь ямар байсан гэдгийг ярьсан. Түүний бичсэн шүлгээс дэсийг нь мэдэж болно, үүнийг багштайгаа долоо хоногийн даяанд оролцсон хүмүүс бүгд мэднэ. Урьдын номын багш нар ямар ахуй ойлголт буюу билиг нээгдсэн байдалтай болох үеэ бүгд л бичиж тэмдэглэдэг байсан болохоор багш нь харангуутаа шавийнхаа дэсийг мэдчихдэг. Бид авшиг хүртсэний дараа мөн л ийм, ахуй ойлголттой болвол бичиж тэмдэглэдэг, тэгвэл багш нь та нарын дэсийг мэддэг, үүнийг хэн ч мэхэлж чадахгүй, учир нь худал ярьж болохгүй гэдгийг бясалгалтнууд бүгд мэднэ, их худал ярьвал ямар үр дүнд хүрэхийг мэдэх үү? (Тамд унана гэж нэг шавь хариулав) Зөв, тамд унана. Их худал ярих гэдэг нь юу вэ гэвэл өөрөө тийм дэсэд хүрээгүй байтлаа харин хэдийнээ хүрчихсэн гэж бусдыг мэхлэхийг хэлнэ. Дотооддоо хараагүй байтлаа би хэдийнээ харчихсан гэж бусдыг мэхэлдэг, бясалгаж суух үедээ бурхан бодьсадваг хараагүй байтлаа харсан гэж бусдыг мэхэлдэг, ингэх нь хамгийн их худал ярьсан хэрэг болно. Их худал ярьвал яришиг болно, хүнд ялд унаж, тамын оронд очно, тийм биш үү, тиймээс худал ярьж болохгүй.

Урьдах долоо хоногт яагаад амьд сэрүүн бурханыг Маха Пражна Парамита мөн, гэвч бас биш гэж хэлсэн бэ? Өнөөдөр дахиад нарийн тайлбарлая. Маха Пражна Парамита-г зарим хүн “Эзэн Бурхан”, зарим хүн “Мөр” гэж нэрлэдэг.

Би одоо нэг цагариг хүрээгээр түүнийг төлөөлүүлье. Цагариг хүрээний дотоод тал нь ижил, буруу хоёр талтай, нэг тал нь сайн, нэг тал нь муу, бид энэ орчлонг ажиглавал өдөр болон шөнөтэй, сайн болон муу хүнтэй, диваажин болон тамын оронтой, зарим орон үзэсгэлэнтэй, зарим орон муухай гэх мэт байдаг, эдгээр нь бүгд энэ “Мөр”-өөс үүсэлтэй, энэ Маха Пражна Парамита-гаас үүсэлтэй, энэ том билиг ухаанаас

үүсэлтэй. Хэрэв эндээс үүссэн биш юм бол хаанаас үүссэн байх билээ?

Нэг Эзэн Бурхан байна гэж таамаглавал эдгээрийг бүгдийг нь тэр бүтээжээ, иймээс тэр тун сайн бөгөөд бас тун муу, хамгийн сайн нь тэр бөгөөд хамгийн муу нь ч тэр, тэр диваажинг бүтээж, хүмүүсийг баяр жаргалтай байлгадаг, бас тамын орныг бүтээж хүмүүсийг шийтгэж тарчилган зовоодог, энэ тоост хорвоог бүтээхдээ бас л зовлон зүдгүүртэй болгосон, заримдаа бид жаргалтай байдаг ч тийм ч удаан жаргаж чаддаггүй, ихэнхдээ зовж шаналдаг. Иймээс Маха Пражна Парамита угаас сайнтай, муутай байдаг. Луузын шашны арга билгийн зураг нь мөн л ийм, цагаригийн дотор цагаан болон хар хоёр талтай, хар талд нь жижигхан цагаан толботой, цагаан талд нь бас жижигхэн хар толбо байдаг нь ийм учиртай.

Хар ба цагаан нь арга болон билгийг төлөөлдөг, харанхуй бүдэг, бохир зүйлс, үйл түйтгэр, зовлон зүдгүүр, дарамт шахалт бүгд л билгийн талд багтана. Арга бол гоё сайхан, гэрэл гэгээ, гоо үзэсгэлэн, амар тайван, баяр баяслгалан, тав тухыг төлөөлдөг. Үнэндээ сайн хүч, муу хүч, эсвэл арга, билиг гэж нэрлэх нь бүгд адилхан утгатай. Тиймээс аль шашин нь сайн, аль шашин нь муу гэж маргалдах хэрэггүй, өөрсдөө бясалгаж энэ дэсэд хүрсний дараа яагаад арга, билиг байх хэрэгтэй вэ гэдгийг ойлгоно. Хэн ч бай түүнд энэ нууцлаг түлхүүр байдаг л юм бол бидэнд тусалж, орчлонгийн энэ нууцлаг орныг нээж, биднийг дагуулан арга, билиг хоёр тал бүрмөсөн тэнцвэржсэн байдалд хүрч чадна. Тэрээр буддын шашинтан, католик шашинтан, луузын сургаалтны аль нь ч байсан хамаагүй, ийм чадвартай л бол удирдан дагуулагч Их Багш мөн.

Маха Пражна Парамита угаас сайн биш, учир нь тэр бидэнд муу нөхцөл байдал бий болгожээ, тэр байхгүй бол бид тамд унах ёсгүй бөгөөд улмаар там ч байхгүй болно, угаас бид энэ ертөнцөд ирэх дургүй байсан ч байж магад, гэвч тэр харин биднийг энд ирүүлсэн байна. Зарим хүн хүний төрөл авах үнэхээр дургүй, хүний орчлонд төрөх үеэр нь энд ирэх дуртай эсхийг нь асуусан хүн байхгүй. Энэ орчлон ертөнцөд үнэхээр тун үзэсгэлэнтэй, гоё сайхан орон маш олон байгаа хэдий ч бас тамын оронтой, гаслант оронтой, төрөх, өтлөх, өвчлөх, үхэх дөрвөн зовлон байдаг. Энэ байдлыг нь чухам хэн зохиосон бэ?, мэдээж Маха Пражна Парамита бий болгожээ. Учир нь аливаа шашныхан бүгд л орчлонгийн хамаг бодис энэ мөрөөс үүсэлтэй гэж ярьдаг, энэ мөрийг Библи сударт “Эзэн Бурхан” гэж нэрлэж, Эзэн Бурхан орчлонгийн хамаг бодисыг бүтээв гэж ярьсан байдаг. Шагжамуни Бурхан энэ мөрийг харин Маха Пражна Парамита ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг, их билиг ухаан, хамгийн дээд хүч гэж нэрлэсэн нь үнэндээ бүгд адилхан. Яагаад их билиг ухаан гэж хэлдэг вэ гэвэл тэр аливааг бүтээж чаддаг болохоор л их билиг ухаан гэж хэлдэг, самгарьд хэлээр Маха Пражна Парамита гэдэг, Маха гэдэг нь их гэдэг утгатай, Пражна гэдэг нь билиг ухаан гэсэн утгатай, Парамита гэдэг нь төгс төгөлдөр гэсэн утгатай, бүгдээрээ нийлээд Их Төгс төгөлдөр Билиг ухаан гэсэн утгатай. Маха Пражна Парамита-г хятад хэлээр орчуулбал 摩诃般若波罗蜜多 гэсэн утгатай, тэр дэндүү том болчихсон болохоор аливааг бүтээж чадна.

Диваажингийн орон, тамын орныг бүтээж чаддаг, тиймээс сайныг ч, муугий нь ч бас бүтээдэг, тийм юм чинь сайн гэмээр юу байх вэ? Учир нь бид бүгдээрээ баяр баясгаланд дуртай, зовлон зүдгүүрт дургүй. Тамын оронд дуртай хүн байвал гараа өргө, байхгүй биз дээ? Тамын оронд дуртай хүн байдаггүй боловч үнэн хэрэгтээ тамын орон оршдог. Тамын оронд дуртай эсэхийг нь Тэр биднээс асуудаггүй, шууд л бүтээж, тамын орон тэнд биднийг хүлээж байдаг. Жаахан хичээн болгоомжлохгүй бол тамд уначихна.

“Газрын зүрхэн Бодьсадвагийн судар”-ыг та нар уншсан уу? Газрын зүрхэн Бодьсадва: “Тоост хорвоогийн хүмүүсийн бодол бүхэн нь маш олон үйл түйтгэр зохиодог, үйл түйтгэр зохиохгүй бодол гэж нэг ч байхгүй” гэжээ. Ийм юм бол явал зохилтой билээ? Бид төрмөгцөө тамын оронд унахаар тогтчихов уу? Хэрэв бодол бүхэн маань үйл түйтгэр зохиодог юм бол хэзээ ч эндээс салж чадахгүй биш үү.

Библи сударт бас: “Бид төрмөгцөө өвгө дээдсийнхээ ял гэмийг үүрчихсэн байдаг” гэжээ. Тэгвэл эндээс чухам хэзээ салж явж чадах вэ? Өвгө дээдсийн ял гэм гэж юуг хэлдэг вэ? Буддын шашинд үйл үрийн төлөөс гэж хэлдэг. Өвгө дээдэс гэдэг нь бидний өөрсдийн урьд төрлүүдийг хэлж байгаа хэрэг, урьд төрөлдөө бид үйл түйтгэр бүтээсэн болохоор одоо төрөл авсан хойноо энэ үр дагавраа эдлэх хэрэгтэй. Библи сударт бас “As you sow, so shall you reap” гэжээ. Энэ нь “Ямар үр тарина, тийм үйл хураана” гэсэн утгатай. Ихэнх католик шашинтан зөвхөн буддын шашинд үйлийн үр эргэж ирдэг гэж ярьдаг, католик шашинд үйлийн үр эргэж ирэх талаар яриагүй гэж үздэг. Гэтэл Библи сударт та ямар үйл тарина, тийм үртэй болно гэж маш тодорхой өгүүлсэн байдаг, энэ нь үйл үр биш юм уу? Күнз: “Өөрийн дургүй үйлийг өрөөлд бүү албад” гэжээ, энэ нь өөрийн дургүй аливаа үйл хэргийг өөр бусдад битгий үйлд гэсэн утгатай. Ингэснээр өөрсдийн “дургүй” нөхцөл байдлаас зайлсхийх болно. Энэ нь мөн л үйл үрийн сургаал номлол юм.

Гэтэл үнэндээ үйл үрийн сургаал номлолыг аль ч шашинд дурьдсан байдаг, зөвхөн заримд нь нилээд тодорхой дурьдаж, зарим нь тийм ч тодорхой ярьсангүй. Гэвч үйлийн үрийг ганцхан төрөлдөө харж чаддаггүй болохоор зарим хүн өөрөөсөө, эсвэл багшаасаа: “Яагаад зарим хүн насан туршдаа муу үйл хэрэг үйлдэж, нүгэл хилэнц их хийж, өглөг үйлддэггүй, бурханд мөргөдөггүй, ямар ч шашныг шүтдэггүй, ямар ч багшаас суралцаагүй хэрнээ тав тухтай баян тансаг амьдардаг вэ?” гэж байнга асуудаг.

Бидний одоо сууж байгаа байшинг гэрийн эзэн нь худалдчихсан болохоор миний хэдэн шавь багштайгаа хамт өөр бясалгалын төв хайх л болж дээ. Гэтэл удтал хайгаад олдохгүй болохоор тэд: “Багшаа тэд бүгдээрээ тийм хар санаатай, урхи тор хийн бяцхан шувуу барьж, том шувуудад нь идүүлдэг, тахиа ална, гахай тэжээнэ, ийм байлаа ч тийм том газартай, тийм тансаг орчинд жаргана, гэтэл бидний бясалгалтанд буян гэмээр юм байхгүй, суух газар ч олдохгүй” гэж багшдаа гомдоллосон. Үнэндээ энэ бүхэн нь яримаар ч юм биш, өчүүхэн буян төдий, маргааш галын аюулд өртвөл бүгд шатаж, юу ч үгүй хоосон болчих биш үү?

Заримдаа ой шугуйд түймэр гарч, бүхнийг шатаачихаж мэднэ. Тайваньд онцгойлон хуа лиа хэмээх газар хөдлөлт ихтэй, газар хөдөлбөл гэр орныг нурааж, олон хүн үхдэг, япон улсад мөн л ийм, тиймээс тансар оронд тав тухтай амьдрах нь буянд тооцогдохгүй, зөвхөн хүн болон тэнгэрийн төрөлтний буян төдий, урьд төрөлдөө буян их үйлдсэн байж ч мэднэ, Жишээ нь: өглөг өгөх, сүм хийд байгуулах гэх мэт, тиймээс одоо нилээд их мөнгөтэй болсон байж ч мэднэ. Гэтэл бидний буян бол чанагуух ертөнцийн буян, бид бясалгал хийсний дараа үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэхээсээ өнө мөнхөд ангижирах болно. Ийнхүү гэрэл гэгээтэй оронд амьдарч, харанхуй бүдэг орноос үүрд мөнхөд холбоо тасарна, энэ бол бидний буян юм. Бидний буян бол орчлонгийн сайн оронд амьдарна, тэр бол бурхны орон мөн. Энэ мөр дотор цагаан хэсэг нь Бурханы орон, туулан гэтлэх орон, хар хэсэг нь үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэх орон, түүнд диваажин, тамын орон, хүмүүн болон тэнгэрийн төрөлтний буян, үйл үрийг багтаадаг. Тоост хорвоо бол яг нэгэн сургууль шиг хамаг төрөлтнийг сургадаг орон юм. Тэд суралцаж дуусаад харанхуй орны байдлыг жинхэнээр ойлгосныхоо дараа дахин гэрэл гэгээтэй оронд очдог.

Энэ ертөнцөд ч мөн л ийм, та суралцаж дуусвал сургуулиа төгсөж, сургууль, багшаасаа салж, багшаараа дахин зодуулж, загнуулахгүй, тийм олон ном бичиг уншихаа больж, дахиад докторантад суралцан хуульч болно, эсвэл өөр ажил хайж дарга болно, том улс төрч болно, тэр ч байтугай ерөнхийлөгч болно. Ямаршуу байр суурьтай болсон ч урьд нь лавтай суралцаж байсан түүхтэй, сургуульд сууж байсан үе ч бас тун зүдгүүртэй, тун хичээнгүйлэн суралцаж, өдөр бүр эрт босч, орой унтана, ихэд зовж зүдэрч, олон жилээр чармайсны ачаар сая нэг доктор, эсвэл эмч болж чаддаг.

Бурханы дэсэд хүрэхэд мөн л ийм, энэ ертөнцөд ирж суралцах хэрэгтэй, тэгээд бясалгал хийж бурхан болсны дараа гэрэл гэгээтэй оронд очдог. Тиймээс нирваандаа буцсан бурхан төгс төгөлдөр гүн билиг ухаан биш, учир нь түүнд хоёр чанар бүрэлдээгүй, мэдээж тэр өөрөө дуртай бол төгс төгөлдөр гүн билиг ухааны дэсэд хүрч болно. Нэгэн амьд сэрүүн бурхан бол төгс төгөлдөр гүн билиг ухаан мөн, гэвч бас биш, учир нь төгс төгөлдөр гүн билиг ухаан бол сайн хүч болон муу хүч хоёуланг нь багтаахаас гадна төгс чадвартай хүч чадалтай, гэхдээ нэгэн амьд сэрүүн бурханд ямар ч хүч байгаа боловч зөвхөн сайн хүчийг хэрэглэдэг, түүний сэтгэл, шинж байдал нь бүгд энэ сайн хүчний дотор байдаг, тиймээс тэр бол төгс төгөлдөр гүн билиг ухаан мөн гэж багш чинь нэгэнт ярьсан. Түүнд энэ эрх мэдэл байдаг болохоор хүнийг аварч чадна, харанхуй орноос цагаан оронд тэднийг дагуулан аваачиж чадна, тамын орноос диваажинд аваачиж чадна, гэвч төгс төгөлдөр гүн билиг ухаан доторх, эвдэж сүйтгэдэг хүчийг ашигладаггүй, тиймээс түүнийг төгс төгөлдөр гүн билиг ухаан биш гэдэг.

Амьд сэрүүн бурхан бол яг л хааны өршөөлийн зарлиг бичгийг биедээ авч яваа элчтэй адил, түүний ажил бол хүн аврах төдий гэж урьд долоо хоногт багш чинь нэг зүйрлэл ярьсан. Хаан хүн аварч чаддаг бөгөөд



бас хүн алж чаддаг, тэр өөрөө хууль дүрэм мөн байж, хууль дүрмийг дураараа өөрчилж болдог. Гэтэл хааны элч бол зөвхөн хүмүүнийг аврах гэдэг ганцхан зорилготой, тухайн үед хааны эрх мэдэлтэй, түүнийг ирэх үеэр бүгдээрээ сөгдөж, хааны зарлигийн бичгийг биедээ авч яваа болохоор мөд алагдах хүнийг аварч чаддаг. Гэвч тэр хаан шиг тийм муу хүн биш, хүний амыг хороодоггүй, нэгэн амьд сэрүүн бурхан, эсвэл нэгэн амьд байгаа багш мөн, иймээс зөвхөн хүн авардаг, тэрээр төгс төгөлдөр “гүн билиг” (хамгийн дээд дэс) ухааныг аль хэдийнээ олж хамгийн дээд эрх мэдэл болон чадвартай болсон, гэвч тэр муу талыг нь ашигладаггүй, зөвхөн сайн талыг нь л ашигладаг. Тиймээс Энэтхэгчүүд нэгэн амьд сэрүүн бурхан, эсвэл амьд байгаа жинхэнэ багшийг тун ихээр сайшаан магтаж, чухам ямар үг хэлээр илэрхийлэхээ олж яддаг.

Ном сударт ч гэсэн нэгэн жинхэнэ Их Багш, эсвэл амьд Бурхантай уулзах нь хамгийн их буян, Бурхан, эсвэл жинхэнэ Багштай уулзахгүй бол туулан гэтлэхийн аргагүй гэж өгүүлсэн байдаг. Бурхан гэдэг нь самгарьд хэлээр buddha, үүнийг будда гэж хэлж бичдэг, их гэгээрсэн хүн, эсвэл хашир суусан хүн, билиг ухаантай хүн, юуг ч мэдэж, юуг ч ойлгодог хүн гэсэн утгатай.

Хятадад бас нэг “Лууз” гэж байдаг нь үнэндээ лууз гэдэг нэртэй биш, түүний нэр Ли Эр (Li Er), гэтэл хожим нь хүмүүс “Лууз” гэж хүндэтгэн дууддаг болсон. Яагаад гэвэл тэр бол нэгэн багш, өндөр настай бөгөөд маш гүн билиг ухаантай сүнс, юуг ч бүгдийг мэддэг, бүх хүн хүндэлдэг болохоороо ингэж дууддаг, учир нь хятадад настнуудыг тун хүндэлдэг, дорно дахины хүмүүс бүгд ийм. Энэтхэгт ч мөн л ийм, сэргэлэн ухаантай билиг ухаантай хүнийг бид “цэцэн мэргэн өвгөн” гэдэг.

Миний өвгө Багш амьд сэрүүн байхдаа нэгэн шавьтай байсан, мөн ч ухаантай өвгөн байжээ, тиймээс авшигтнууд түүнийг бүгдээрээ buddha гэж дууддаг нь бурхан гэсэн утгатай биш, харин их билиг ухаантай гэж сайшаан магтаж байгаа хэрэг билээ. Үнэндээ тэр насаар тун залуу, тиймээс buddha гэдэг нь зөвхөн Шагжамуни Бурханыг хэлдэг биш бодь мөрийн зэргийг олсон хүн, өөрөөр хэлбэл ихэд билиг нээгдсэн хүн, Маха Пражна Парамита дэсэд хүрсэн хүн, ийнхүү “гүн билиг” ухаантай бүх хүнийг Buddha, хятад хэлээр орчуулбал 佛 хялбарчлаад бурхан гэж нэрлэдэг. Гэтэл одоогийн буддын шашинтнууд бүгд л зөвхөн Шагжамунийг л Бурхан мөн гэж үздэг, яагаад гэвэл тэр хамгаас илүү нэрд гарч 2000 гаруй жил өнгөрчихсөн байхад тун нэр алдартай хэвээр байна. Жишээ нь: Богд гэгээнтэн гэж яримагц дорхноо Луузыг санадаг, учир нь тэр зохиол бичих авьяас чадвартай, ахуй ойлголтоо бичиж тэмдэглээд үлдээснийг хожмын хүмүүс уншсаны дараа түүнийг хосгүй их богд гэгээнтэн гэж үздэг болохоор тун нэрд гарч, одоо болтол түүний бичсэн “Мөр ёсны судар”-тай адилгаж чадмаар хүн гараагүй. Үнэндээ Луузын шашинтнуудад дэсээр түүнтэй ойролцоо хүмүүс их байсан хэдий ч тэд бичиж тэмдэглэх дургүй, эсвэл бичиж чаддаггүй юмуу, бясалгалын аргыг уламжилмаар гарамгай шавь байгаагүй ч байж ч магад, тиймээс Лууз шиг тэгж их нэрд гараагүй. Бас нэг жишээ нь:

зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн бол хятадын хамгийн алдартай номын багш болно. Даяаны бүлэгтэнд маш олон номын багш байдаг боловч Бодьдармаа, Хүй Нэн хоёр хамгаас алдартай, яагаад гэвэл тэд өөр өөрийн өвөрмөц шинж байдалтайгаас болжээ. Бодьдармаа бол эхэлж хятадад ирсэн бөгөөд есөн жил хана руу харж бясалгаж суусан болохоор тун нэрд гарчээ. Зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн гэрээс гараагүй байхдаа увш (гэртээ суугаа гэрээс гарагч) байдлаар тавдугаар өвгө Багш Хун Рень-ний бясалгалын газар хүрч шавилжээ. Тэгээд өдөр бүр гал тогооны өрөөнд будаа нүдэж, дөнгөж наймхан сар болоод сургуулиа төгсгөж, багшаасаа орхимж болон бадар аягыг уламжлан авчээ. Бичиг мэддэггүй нэг түлээчин, дөнгөж наймхан сар суралцаж, өдөр бүр будаа нүдсэн байтлаа уг чанаараа хараад Бурханы хутагт хүрчээ. Нээрээ сонин юм байна, тиймээс тэр хоёр тун их нэрд гарчээ.

Даяаны бүлэгтэнд мэдээжээр, бас өөр өвгө багш нар зөндөө байдаг. Жишээ нь: Күй Ке, Сен Зан, Доо шин гэх зэрэг байдаг. Гэвч тэд тийм ч онцгой биш болохоор нэрд гараагүй. Бодьдармаа, Хүй Нэн хоёр угаас дорно дахины улс орон, жишээ нь Хятад, Вьетнамд л нэр алдаршсан төдий. Гэтэл өрнө дахинд бурхны ном уламжлагдсаны дараа тэд дэлхий дахинд алдаршжээ. Шагжамуни Бурхан ч бас дэлхий дахинд алдартай, учир нь угаас хааны хүү хэдий ч улс орон, эхнэр хүүхэд, нэр алдар, эд мөнгө, байр сууриа бүгдийг нь огоорч, зургаан жил гаруй хагуужилтай бясалгаж, нас залуу атлаа тийм их номын сэтгэлтэй байсан болохоор тун их нэрд гарчээ.

Үүнээс гадна Шагжамуни Бурхан нирваандаа буцсанаас 300 жилийн дараа Энэтхэгт маш алдартай нэгэн Аа Юй гэдэг хаан байжээ, тэр угаас хэрцгий догшин зантай байснаа хожим нь нэгэн буддын шашны төгс гэгээрсэн их багшийн удирдан дагууллаар билиг нээгдэж, цэвэр ариун сэтгэлтэй хүн болж хувирчээ. Урьд нь тэр хэрцгий догшноороо нэрд гарсан байснаа хожим нь харин өрөвч зөөлөн сэтгэлээрээ нэрд гарчээ. Ийнхүү тэр хаан номын ач буяныг хариулахын төлөө Буддын шашныг маш олон оронд уламжлан дэлгэрүүлснээр Шагжамуни Бурхан бүр ч нэрд гарчээ.

Урьд нь Шагжамуни Бурхан зөвхөн Энэтхэгт л нэр алдартай байсныг Аа Юй хаан харин дэлхийд алдаршуулжээ. Яагаад гэвэл тэр үед Шагжамуни Бурхан нирваандаа буцаад дөнгөж 300 жил болж байсан бөгөөд лөв номтны цаг үе, шавь нар нь ном уламжилж, номын чанар өөрчлөгдөөгүй байжээ. Тиймээс Аа Юй хаан Шагжамуни Бурханы шавиас нь суралцсан болохоор мэдээж бодь мөрийг олсон бөгөөд гэгээрч чадсан, тэр ихэд билиг нээгдэж гэгээрсэн хүн болохыг нь түүний бичиж тэмдэглэсэн зүйлээс ойлгож болно. Хожим нь тэр бүх зүрхэн тамираа шавхан байж буддын шашныг маш олон оронд уламжлан дэлгэрүүлж, хүүгээ Шри Ланка улсад хүргүүлж, өөр бусад хүү, хамаатан саднаа Бирм, Тайланд улсад хүргүүлж, ном дэлгэрүүлжээ. Ингэснээр дэлхий дахинаа хүмүүс Шагжамуни Бурханыг мэддэг болжээ.

Хэрэв Аа Юй хаан байгаагүй бол Шагжамуни Бурхан Энэтхэгийн өөр бусад их багш нартай адил зөвхөн Энэтхэгт нэр алдарших байсан

байж ч магад. Энэтхэгт өөр бусад ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагийг олсон их багш бас байдаг. Жишээ нь: Kabir, Tulsidas зэрэг. Гэтэл тэд зөвхөн Энэтхэгт л нэр гарсан төдий, учир нь тэдэнд Аа Юй хаан шиг шавь байсангүй, үнэндээ тэдний ярьсан сургаал номлол нь Шагжамуни Бурханы ярьсантай адилхан байдаг ч яг л Бодьдармаа болон зургадугаар үеийн өвгө багш Хүй Нэн шиг өгүүлэл зохиол тийм ихээр бичиж үлдээгээгүй, учир нь Шагжамуни Бурхан бүгдийг нь аль хэдийнээ ярьчихсан болохоор тэд Бурхан Багшийн ярьсныг эшлэн бага зэрэг тайлбарлавал л хангалттай болно.

Шагжамуни Бурхан дөчин есөн жил ном уламжлахдаа диваажин, тамын орон, асурийн ертөнц гэх мэтчилэн бүх зүйлийг ярьчихсан болохоор хожмын хүмүүс Бурхан Багшийн айлдварын агуулгыг эшлэн хэрэглэвэл хангалттай болох нь тэр. Гэвч ном тайлахад л найдах нь билиг нээгдүүлж гэгээрүүлж чадахгүй, ном тайлах нь зөвхөн сургаал номлол төдий, эрхбиш бас бясалгалын арга болон чармайн бясалгах хоёрыг уялдуулж байж л хангалттай болно. Шагжамуни Бурхан амьд сэрүүн байсан үед ч мөн адилхан, шавь нартаа олон төрлийн бясалгалын аргыг сургахын зэрэгцээ сургаал номлолыг суралцуулж, хоёланг нь уялдуулж байжээ, яг л эмч хүн шиг, заавал эмнэлэгт очиж дадлага хийх хэрэгтэй, ном уншихын зэрэгцээ дадлага хийнэ, тэгэхгүй бол сайн эмч болж чадахгүй.

Мөрийг олоход ч мөн л адилхан, бид христын шашин, буддын шашин, луузын шашин, исламын шашны алиныг нь ч шүтсэн хамаагүй, ном судрыг нь сайн ойлгохгүй, тэдгээр шашны эздийн жинхэнэ уг санааг нь буруугаар ойлговол бид мөрийг мөн л хайж олохгүй, ном судрыг жинхэнээр ойлгоё гэвэл нэгэн жинхэнэ багш, Buddha, нэгэн амьд сэрүүн багшийг хайх хэрэгтэй. Тиймээс Шагжамуни Бурхан: “Бурханы хүч адислахгүй бол хамаг төрөлтөн бясалгал хийгээд Бурханы хутагт хүрэх боломжгүй” гэжээ. Түүний санаа нь амьд сэрүүн бурхныг хэлж зааж байна, учир нь Buddha бол амьд сэрүүн бурхан мөн гэж би саяхан ярьсан билээ, энэ нь амьд байгаа жинхэнэ багш гэсэн утгатай.

Энэтхэгт ийм үйл хэргийг хүмүүс цөм ойлгодог, учир нь Энэтхэг бол төрөл төрөлдөө сүнслэг дадал бясалгал хийдэг ариун дагшин орон, тэд хаа хүрсэн ч бясалгал хийдэг хүнтэй тааралддаг, энэ хүмүүсийн бясалгалын дэс нь ямар байлаа ч ядаж л хүмүүсийг бялгал хийхийг сануулдаг. Та хэрэв Энэтхэгт хүрвэл хаа сайгүй шар хувцастай хүмүүс, өөрөөр хэлбэл хуврагуудыг харна, тэд ийш тийшээ байнга явдаг болохоор хаа сайгүй тааралдана. Одоо тэдний зарим нь цагаан хувцас өмсдөг боловч гэрээс гарагсад биш гэж хэлж болохгүй, харин гэрээс гарагсад мөн, тэд өөр шашны бүлгийн хүмүүс болохоор цагаан хувцас өмсдөг. Төвдөд бас ийм, цагааны шашин, шарын шашин, улааны шашин гэх мэт байдаг, шашны эзэн нь ямар өнгийн хувцас өмсөнө шавь нар нь бас тэднийг хүндэтгэхийн тулд бас тийм өнгийн хувцас өмсдөг, тиймээс ондоо ондоо шашны бүлэг болж хувирчээ. Багш нь Америкт байхдаа бас япон улсын нэгэн гэрээс гарагч цагаан хувцастай явааг харсан, дотор талдаа цагаан хувцастай, гадна талдаа бараан өнгийн нөмрөгтэй байв.

Одоогийн японы гэрээс гарагчдын ихэнх нь л цагаан хувцастай байдаг нь шашны эзэд нь цагаан хувцас өмсдөгөөс болсон байж магад.

Тиймээс Энэтхэгт гэрээс гарагсадтай хаа сайгүй тааралддаг, тэд нэг зүйлийн цэвэр ариун, эрхэм дээд бясалгалын амьдрал, нэг зүйлийн билиг ухаантай хүнийг төлөөлдөг. Уламжлалт бясалгалаас шалтгаалан Энэтхэгчүүд бүгдээрээ нэгэн амьд сэрүүн бурхныг хүндэтгэхийг сайн мэднэ, Энэтхэгийн бясалгал, эсвэл бясалгаж суух тухай номыг уншвал бүгд л нэгэн амьд сэрүүн бурхан, амьд сэрүүн жинхэнэ багшийг сайшаан магтсаныг мэдэж болно, “Та хэрэв диваажинд хүрэх, эзэн бурхантай уулзах, будда болох, хамгийн эрхэм дээд төрөлтөн болье гэвэл багшийн чингэ адислах хүч байхгүй бол та юу ч олж чадахгүй” гэж тэд хэлдэг. Яагаад вэ гэвэл, жишээ нь: Ананд Шагжамуни Бурханыг олон жилээр асран харгалзаж, өдөр бүр Бурхан Багштай хамт байлцаж, сургаал номлолыг нь олон удаа сонсож, тун олон бясалгалын аргыг мэддэг бөгөөд Шагжамуни Бурханы аливаа сургаал, номлолыг бүгдийг ойлгож, бүхнийг цээжилж байсан ч гүн билиг ухааныг олж чадаагүй. Шагжамуни Бурхан нирваандаа буцсаны дараа хуврагууд анх удаа бүгдээрээ цугларч, ном судрыг эмхэтгэн бичих үеэр л билиг нь нээгджээ. Яагаад билиг нээгдэв гэвэл эцэс сүүлд нь Шагжамуни Бурхан түүнд Арьяабалын бясалгалын аргыг уламжилснаар билиг нээгдэж гэгээрчээ, урьд нь харин билиг нь нээгдээгүй байж. Тэрээр бүх шавь нарын дотор хамгийн сүр жавхлантай, хамгаас их сонсож, одоогийн дуу хураагчаас ч сайн цээжлэх чадвартай байж, юуг ч сайн цээжилдэг, дуу хураагч заримдаа саад гарах, дуу хурааж чадахгүй болох, эсвэл хураасан дуу нь тод сонсогдохгүй байдал үүсдэг, хэрэв хуурцгийн чанар муу бол бас хураасан дуу нь тод сонсогдохгүй, цахилгаангүй үед бас дуу хурааж чаддаггүй.

Гэтэл Анандын цахилгаан байнгын бөгөөд бас маш сайн хураадаг, тиймээс ном судар Шагжамуни Бурханы үеэс одоо болтол уламжлагдан бидэнд лавлагаа болж чадсанд бид Анандад баярлан талархах ёстой. Учир нь Ананд хамгийн сайн дуу хураагч байж, Бурхан Багшийн айлдварыг бүгдийг нь хураачихсан байдаг.

Ананд тун цэцэн сэргэлэн, ихийг сонссон ид шидтэй хүн, Анандад ид шид байдаг гэж гурав хоногийн өмнө багш чинь ярьсан. Ананд чанагуух ертөнцийн ид шидтэй байж, шоронд нисэн хүрч, Войдехи. хатанд ном тайлж сонсгосон байна, Тийм агуу их бясалгалтан байтлаа мөн л билиг нээгдэн гэгээрч чадаагүй, заавал Арьяабалын бясалгалын аргыг нэг хэсэг хугацаанд бясалгасны дараа сая билиг нээгджээ.

Яагаад Арьяабалын бясалгалын аргыг бясалгаж байж л сая билиг нээгдэж чаддаг гэж би ярьсан бэ? Учир нь Ананд өдөр бүр Бурхан Багшийг асран хамгаалсан бөгөөд маш олон номын аргыг бясалгасан байна. Жишээ нь: амьсгалын арга, тарни унших, маани унших, Арьяабал Бурханы нэрийг унших, Арьяабал Бурханд мөргөх, Авид Бурханы нэрийг унших гэх мэт олон бясалгалын аргыг бүгдийг нь сурсан, Шагжамуни Бурхан “Цаглашгүй насан хутагт бурханы судар”- ыг тайлах үеэр Ананд хамт байсан бөгөөд Молом тойн (м. Модгальяна, с. Maudgalyāyana/ mulian)-той хамт Войдехи хатныг хорьж байгаа шоронд нисэн хүрч,

хатантны хамт Бурхан Багшийг дурссан байна. Зөвхөн Бурхан Багшийг дурсаад хангалттай болчихдог бол яагаад үргэлжлүүлэн Авид бурханыг дурсан уншаагүй вэ? Яагаад “Цаглашгүй насан хутагтын сударт”-т заасан аргаар Авид бурханыг төсөөлөн бодохыг бясалгаагүй вэ? Яагаад бас Арьяабалын бясалгалын аргыг бясалгав гэвэл тэр бясалгалын арга нь хангалттай биш, төгс сайн биш, зөвхөн Арьяабалын бясалгалын арга нь хамгийн дээд хамгийн төгс төгөлдөр номын цогц болно. Шагжамуни Бурхан ямарваа судрыг тайлах үеэр, эсвэл ямарваа тарни, ямарваа бясалгалын аргыг заах үеэр Ананд үргэлж л дэргэд нь байсан, тэр бүх бясалгалын арга хангалттай сайн байсан бол Шагжамуни Бурхан хамгийн сүүлд Анандад Арьяабалын бясалгалын аргыг уламжлах шаардлагагүй байсан. “Баатар явагч их хөлгөн судар”-т (Śūrangama) хорин таван бодьсадва өөр өөрийн бясалгалын аргаа ярихад Манзушир Бурхан зөвхөн Арьяабалын бясалгалыг аргыг сайшаан магтжээ, Шагжамуни Бурхан бас зөвхөн Арьяабалын бясалгалын аргыг сайшаан магтаж, бурхан больё гэвэл заавал Арьяабалын бясалгалын аргыг бясалгах хэрэгтэй гэж хамаг төрөлтнийг зоригжуулжээ. Шагжамуни Бурхан хэрвээ Анандыг хайрлаагүй бол түүнд энгийн бясалгын аргыг сургана, тэгэхээр Ананд билиг нээгдэх боломжгүй. Тиймээс Шагжамуни Бурхан Анандад Арьяабалын бясалгалын аргыг уламжилж ихэд билиг нээгдүүлжээ.

Иймээс Энэтхэгийн мөр ёсыг хайгчид нэгэн жинхэнэ Багшийг хайж, түүнд шавилан сууж, энэ гүн билиг ухааны бясалгалын аргыг уламжлахыг гуйдаг, ингэснээр л сая туулан гэтэлж чаддагийг бүгд мэддэг, багшаа баярлуулж, багш нь түүнийг хайрлах, адислах энэ бясалгалын аргыг уламжлах билиг ухааны хаалгыг нээх, туулан гэтэлгэх нь хамгийн ачтай хэрэг, түүний төлөө юу хийсэн ч дуртай гэж боддог болохоор Багшийгаа Эзэн Бурханаас дээд, төгс төгөлдөр гүн ухаанаас дээд гэж сайшаан магтдаг. Яагаад гэвэл Эзэн Бурхан тэднийг энэ харанхуй бүдэг, зовлонг ертөнцөд ирүүлсэн байхад Багш нь харин үхэж, төрөх сансрын хүрднээс гэтэлгэдэг.

Энэтхэгчүүд багшийгаа Гүрү гэж нэрлэдэг, энэ нь балар харанхуйг зайлуулагч гэсэн утгатай, хятад хэлэнд “Төгс Гэгээрсэн Их Багш” гэж нэрлэдэг, учир нь тийм багш биднийг гэгээрүүлж билиг нээгдүүлж чаддаг, “悟” гэдэг ханз үсэг нь гэгээрэх гэсэн утгатай, тиймээс багш хүн бидний билгийг нээгдүүлж чадвал Төгс Гэгээрсэн Их Багш, жинхэнэ Багш, эсвэл Гүрү болно. Учир нь бид хичнээн их ач гавьяа, хичнээн их буян хишиг үйлдэж, хичнээн том сүм хийд байгуулж, хичнээн их өглөг үйлдсэн ч бүгд л өнгөн талын зүйл, багш маань бидэнд хаалгыг онгойлгох түлхүүрийг өгч, биднийг оруулахгүй бол бясалгах боломж яаж байж чадах вэ? Жинхэнэ Багшийн адислал гэдэг бол багшийн хайр, багшийн адислах хүчийг хэлнэ, энэ бүхэн байхгүй бол бид туулан гэтэлж чадахгүй. Хичнээн их сүм байгуулж, хичнээн их өглөг үйлдсэн ч жинхэнэ багшаас танд хамгийн дээд бясалгалын аргыг уламжлахгүй л бол мөн л туулан гэтлэхийн аргагүй. Тиймээс эртний Энэтхэгт өөрсдийнхөө бүх эд хөрөнгийг жинхэнэ багшдаа бүгдийг нь өргөдөг, мөр ёсыг олохын

төлөө халуунд халж, хүйтэнд хөрч, зовлон зүдгүүрийг ханатлаа амсаж, жинхэнэ багш юу хий гэвэл түүнийг нь биелүүлж, багшийнхаа ямарваа шалгалтыг хүлцэн тэсвэрлэдэг. Энэ нь туулан гэтэлгэдэг хамгийн төгс төгөлдөр бясалгалын аргыг “гуйх”-ын төлөө байжээ. Жишээ нь: Мял богд зовлон зүдгүүрийг долоон жил амсаж, багшийнхаа хатуу шалгалтыг хүлцэнгүй тэсвэрлэжээ. Багш нь учир шалтгаангүйгээр зодно, үгүй бол загнана, өдөр болгон байшин бариулна, барьж дууссаны нь дараа зориудаар нураалгаж, дахиад л бариулна, юу хийсэн ч бүгд л буруу, долоон жил ингэж ажилласны дараа багш нь түүнд ном уламжилжээ. Урьдын бясалгалтны “мөр ёсыг хайх сэтгэл” ийм байснаас л амжилтад хүрч чаддаг, алдар нэрээ хойчдоо үлдээж чаддаг, тэгээд ч тэдний нэрийг одоо хүртэл мэдэж байгаа бөгөөд нэр алдартай хэвээр байна.

Иймээс ганц хоёрхон удаа бясалгамагцаа багшийгаа гүтгэн гүжирдэж, бусдыг дорд үздэг хүн хэзээ ч, юу ч олж чадахгүй. Багш нь хэрэв нигүүлсэнгүй бол түүнийг харж харгалзана, асуурийн оронд аваачиж ч магад, ингэх нь түүний хувьд тун ачтай хэрэг гэж хэлж болно, тэгэхгүй бол тамын орноос хэзээ ч салж чадахгүй, Учир нь багшийгаа гүтгэдэг хүн төрөл төрөлдөө жинхэнэ багшийгаа эрж олж чаддаггүй, тэр ч байтугай, жинхэнэ багшийн нэрийг ч сонсох аргагүй юм чинь нэгэн жинхэнэ багштай тааралдахыг бүр ч ярихын ч хэрэггүй.

Өнөөгийн хүмүүсийг сургахад тун хэцүү, одоо цөвүүн цаг, улс орон бүр адилгүй, соёл иргэншил нь ч адилгүй, хүмүүсийн ааш араншин адилгүйгээс болдог ч байж мэднэ. Тиймээс Энэтхэгийн хүмүүсийг сургахад нилээд хялбар, Энэтхэг төрөл төрөлдөө бясалгал хийсээр ирсэн ариун дагшин орон, тэндхийн хүмүүс хар багаасаа ургамал хоол идэж, ном сударт суралцсан болохоор заангуут нь хүлээн авдаг. Тэд маш даруу, мөр олох хүсэл бат чанга, мөрийг хайгсад сэтгэл өндөр, суралцаагүй ч мөрийг хайх сэтгэл нь тун өндөр болчихсон байдаг, багштайгаа уулзахаасаа өмнө нэгэнт тун даруу төлөв болчихсон байдаг.

Тиймээс Энэтхэгт багш, Төгс Гэгээрсэн Их Багш ном тайлж дууссаны дараа хэдэн мянган хүн, эсвэл хэдэн зуун хүнд авшиг хүртээж болно, тэр ч байтугай заримдаа тосгоны бүх хүн, хөгшин залуу, эрэгтэй, эмэгтэй, муур, нохой (хүмүүс инээлдэв) цөм авшиг хүртдэг. Муур, нохой хүртэл авшиг хүртэхийг нь харахад тун сүр жавхлантай, учир нь тэд аль хэдийн бэлэн болчихсон, яг л тариачин хүн хөрсөө сайтар зөөлрүүлж, бордож, бүгдийг бэлэн болгосон болохоор үр цацмагц ургадагтай адилхан.

Хятад, Вьетнам, Тайваньд ном уламжилахад ер нь амаргүй байдаг. Тиймээс Бодьдармаа хятад улсад ирээд ном уламжлахад тун бэрх байсан тул есөн жил хана ширтэн бясалган суужээ, бясалгалаар тийм сайн, хэдий хичээл зүтгэлтэй байсан ч ердөө л тавхан сайн шавьтай байжээ. Тэр дэсээр маш өндөр, ном тайлахдаа гарамгай, агуу их бясалгагч болохыг бүгд сайн мэддэг. Гэвч ном тайлахыг нь сонсох хүн өдрийн од шиг цөөн. Лиан Үү Ди хаан ч зөвхөн хүн, тэнгэрийн буянд л шунасан болохоор энэхүү хамгийн дээд бясалгалын аргыг ойлгож чадаагүй, өөр хүмүүс ч гэсэн Бодьдармаагаас суралцаагүй, сонсоход тэр хэдийгээр

Шаолин хийдэд суудаг боловч суралцах гэж ирдэг хүн байгаагүй, зөвхөн Хүй Ке болон өөр дөрөв, нийт таван хүн ирж, түүнд шавилсан гэдэг, Хүйдээ тэр тав ч бас бүгд Шаолин хийдийн хүмүүс биш байжээ, яагаад гэвэл Хүй Ке бол Шаолин хийдийн хүн биш, харин өөр газраас ирж, Бодьдармаагаас суралцсан байна.

Тиймээс жинхэнэ Багштай хамт амьдарч байсан ч тийм их тус нэмэргүй гэдгийг үүнээс ойлгож болно. Бодьдармаа тийм зүдгүүртэйгээр хичээнгүйлэн бясалгадгийг Шаолин хийдийн гэрээс гарагсад өдөр бүр хардаг боловч сэтгэл нь өчүүхэн ч хөдөлсөнгүй, тэдний хувьд ном судар уншиж, сайн байна уу гэтэлгэгч Авид бурхан, сайн байна уу гэтэлгэгч Арьяабал Бурхан гэж даатган мөргөж, “Очироор огтлогч судар”, “Олонх бурхант судар”-т мөргөж, уул ус, хувхай ясанд мөргөчихвөл хангалттай болох нь тэр гэж бодон жинхэнэ Багш дэргэд нь байсан ч мэддэггүй байжээ. Есөн жил гаруй хана ширтэн бясалгаж суусан хэдий ч ердөө л тавхан шавьтай байжээ, гэхдээ Бодьдармаа сүм хийдэд суудаг, харин энгийн газар сууж байгаагүй. Хэрвээ загасны мах, амьтны мах худалддаг хүмүүстэй хамт амьдарч байсан бол бас ч яахав, тэр хүмүүс бясалгалын тухай мэддэггүй юм чинь бид ойлгож болно, гэвч сүм хийдийн хүмүүс нь мэддэггүй гэхлээр нээрэн итгэж ядмаар. Тиймээс тэд ном сударт дэндүү их баригдаж, ном судар уншиж, ном сударт мөргөвөл бурхны оронд төрж чадна гэж бодон сэтгэлээ дотооддоо хандуулдаггүй болохоор ойлгодоггүй.

Тэд өдөржин өнгөн талын ном сударт баригдан өөр хүмүүстэй адил хоол иднэ, унтана гэхчилэн нэг насаа бардаг. Тэр бол Хятад орон, харин Энэтхэг биш болохоор сургахад тун амаргүй. Их Багш нарын ихэнх нь бүгд л Энэтхэгтэй холбоотой болохыг бид өнгөрсөн түүхээс мэдэж болно, Шагжамуни Бурхан Энэтхэг хүн, Есүс Христ ч гэсэн Энэтхэг болон Түвд орны хилд хүрч, Хималай ууланд арван хэдэн жил бясалгасан байна. Тиймээс Их Багш нар бүгд л Энэтхэгээс үүсэлтэй, эсвэл Энэтхэгээс ирсэн Их Багшид шавилсан, үгүй бол Энэтхэгт очиж суралцсан байдаг. Хятадад Ниү Тоу фа Рун (Үхэр толгойт номын багш) гэдэг нэг тун алдартай даяанч багш байдаг нь мөн л Энэтхэгийн нэгэн гэлэнгээс 比丘 суралцсаны дараа тийм дээд дэсэд хүрчээ. Хятадын өөр бас тун олон их багш бүгд л Энэтхэгийн их багш нартай холбоотой байдаг, өвгө багш нар нь Энэтхэг хүн, эсвэл Энэтхэгийн багшаас суралцсан байдаг. Шагжамуни Бурхан дөчин есөн жил Энэтхэгийг тойрон аялж, ном тайлахдаа тухайн үеийн Энэтхэг шашны хамгаас бишрэн шүтдэг шүтээнийг үгүйсгэсэн, тэрээр мөргөж сөгдөх, эсвэл мухар сүсэг мэтийн өнгөн талын зүйлсийг ихэд эсэргүүцэн бясалгагч заавал өөрийн биеэ таньж, өөрийн бясалгалаа түшиж, дотооддоо хандаж, өөрийн уг чанараа хайх нь л сая жинхэнээр бясалгаж байгаа явдал болно, гадна талын бурханд мөргөөд “мөр ёс”-ыг олж чадахгүй, мөргөж байгаа бурхан чинь амьд байж байж л сая адислах хүчтэй байж чадна гэж өдөр бүхэн ярьсан байдаг.

Багш чинь Тайваньд эхлэн ном уламжлаад удаагүй байхад гүтгэлэг доромжлол намайг даруй амьсгалахад ч бэрх болгосон, бясалгагч угаас

сайхан сэтгэлтэй, бусдыг гүтгэдэггүй, үг хэлээр дайрахгүй байх нь зөв. Шагжамуни Бурхан Энэтхэгт ном уламжилж, тухайн үеийн мухар сүсэг болон бишрэн шүтдэг шүтээнийг нь үгүйсгэж, хүмүүст өөрийн бурхан чанараа олохыг сургажээ, ингэсэн ч гэсэн Шагжамуни Бурхан дөчин есөн жил аюулгүй амьдарч чаджээ, яагаад гэвэл Энэтхэгчүүд их цагаан цайлган, маш уужуу сайхан сэтгэлтэй, дургүй байлаа ч гэсэн эхлээд шалгаж нягталж сонсдог болохоор буруу аргаар бясалгаж байсан олон хүн хожим нь Шагжамуни Бурханы шавь болсон байдаг.

Энэтхэгчүүдийг сургахад тун хялбар, тухайн үед тэд жинхэнэ Багштай тааралдаагүй байсан болохоор бурхны хөрөгт мөргөдөг байсан ч байж магад, гэтэл үнэн ёсыг хайж олсныхоо дараа тэд сонсдог, өөрсдөө бясалгадаг, тиймээс Шагжамуни Бурхан дөчин есөн жил аюулгүй амьдарч чаджээ, харин Есүс Христ ном дэлгэрүүлээд дөнгөж гурван жил гаруй болоод загалмай модонд цовдлогдсон билээ, яагаад гэвэл Есүс Христ бол Еврейчүүдэд ном уламжилсан, тэндхийн нөхцөл байдал, хүмүүсийн сэтгэл, ёс заншил Энэтхэгтэй адилгүй. Шагжамуни Бурхан ном уламжлах үеэр Энэтхэг шашинтан түүнийг Вишну гэж хүндэтгэн дууддаг байсан, энэ нь Энэтхэг шашинтнуудын хамгаас бишрэн шүтдэг гурван шүтээн (Шива, Вишну, Эсэрваа (Брахма) тэнгэр)-ий нэг болно, Энэтхэгт Вишну нь хамгийн эрхэм дээд байр суурь, маш өндөр шүтээн буюу Эзэн Бурханыг төлөөлдөг, Шагжамуни Бурхан ном уламжлах үеэр тэд бас түүнийг бурхан гэж дууддаг, хэдийгээр уламжилсан номын агуулга нь тэдний ойлгодог номын агуулгатай адилгүй боловч Шагжамуни Бурханыг Вишну-гаас амилсан амьд дүр, тэднийг сургахаар энэ ертөнцөд ирсэн гэж итгэдэг болохоор Шагжамуни Бурханыг тун их хүндэтгэдэг.

Есүс Христийг ном уламжлах үедээ шинэ зүйлийн сургаал номлолыг заагаагүй гэж ярьдаг, түүний сургаал номлол нь эрт дээр үеийнхэнтэй адилхан, зөвхөн эртний ном судрыг нилээд тодорхой тайлбарласан төдий. Тэр өөрийгөө Эзэн Бурханы багаж, Эзэн Бурханы томилгоогоор энд ном уламжлахаар ирсэн гэдэг, гэсэн ч Еврейчүүд түүнийг дээрэлхүү, ааг омог ихтэй гэж загалмайд цовдолсон билээ.

Шагжамуни Бурхан болон Есүс Христ хоёр адилхан номыг уламжилж, адилхан үнэн ёсыг ярьсан боловч нэг нь дөчин есөн жил амьдарч, нөгөө нь гуравхан жил гаруй л амьд явж чадсан нь үнэхээр өрөвдмөөр, яагаад гэвэл ёс заншил, хүмүүсийн сэтгэл санаа адилгүйгээс болжээ. Шагжамуни Бурхан тийм олон хүнд ном уламжилсан ч ямар ч асуудалгүй байхад Бодьдармаа, Есүс Христ, Мухамед нар харин тийм ч олон хүнд ном уламжилж чадаагүй нь нөхцөл байдал болон амьдралын орчин өөр байснаас болсон хэрэг.

Буддын шашин Түвд оронд уламжлагдсаны дараа бас чанар нь өөрчлөгдөж, ламын шашин болж хувиран зарим шашны бүлэг нь бас мах идэж, архи ууж, гэрлэж болохыг зөвшөөрдөг болжээ. Тиймээс түвдүүд буддын шашныг шүтдэг гэж хэлж болохгүй, харин ламын шашинтан гэж хэлэх нь зөв юм. Буддын шашин Япон улсад уламжлагдсаны хойно бас чанар нь өөрчлөгдөж, самурайн оюун санаа холилдсон шашин болжээ,



тиймээс Японы шашныг буддын шашин гэж ярьж болохгүй, учир нь Японы хуврагууд мах, загас идэж, архи ууж, гэрлэж болдог.

Буддын шашны гэрээс гарагчид угаас ингэж болдоггүй, гэтэл буддын шашин бусад оронд уламжлагдсаны дараа бүгд л чанар нь өөрчлөгдөж, ламын шашин, Самурайн шашин болж хувирчээ. Самурайг та нар мэдэх үү? Энэ нь мэдээжээр буддын шашин биш. Энэтхэгийн буддын шашинтнууд угаас маш цагаан цайлган, сайн санаатай, мах идэж, архи уух, хүн алах хэрэг огт байхгүй. Шагжамуни Бурхан Япон, эсвэл өөр оронд хүрч очин ном уламжилсан бол бас ч тийм хурдан түргэн, тийм амар төвшин байх аргагүй бөгөөд дөчин есөн жил амьд явах боломжгүй, учир нь орон нутгийн зан заншил, хүмүүсийн сэтгэл адилгүйтэй холбоотой, хэрвээ тухайн орны нөхцөл байдалтай зохицохгүй бол оршин тогтнож чадахгүй.

Багш чинь ганцаараа бол буддын магтаал дуулах хэрэггүй, гэрээс гарагчийн хувцас ч өмсөх хэрэггүй. Гэвч Хятадад ном уламжлахад та нар ийм байдалд дуртай болохоор би бас хүмүүсийн хүслийг дагадаг, учир нь та нарт таалагдахгүй бол сурах дургүй болчихно, тийм учраас гадна талаа өөрчлөхийн зэрэгцээ дотоодоо бас өөрчлөх хэрэгтэй, хятад хоол идэж, хятад хэл сурч, хятад хувцас өмсөж, хятадын ёс заншилд суралцана, хэрвээ одоо Энэтхэг улсын түүх, эсвэл Вьетнам улсын түүхийг ярьвал шавь нар маань даруй багш байнга гадаад улсын түүхийг ярьж, хятадын түүхийг ярихгүй байна гэж дургүйцдэг, Гуан Гүний үлгэрийг ярьлаа ч харин вьетнамын Гуан Гүнийг ярилаа гэнэ. (Бүгд инээлдэв)

Багш чинь хятад хувцас өмсөж, зүс царай ч хятад хүн шиг бөгөөд будаа иддэг болохоор нэгмөсөн хятад хүн шиг болсон байна, яагаад гэвэл хятадуудад туслая гэж байгаа болохоор гадна талаа ч бага зэрэг өөрчлөхөд асуудалгүй. Гэвч багшийн чинь сургаал ёс хятадын одоогийн буддын шашинтай адилгүй, ном уламжлах үеийн хүч нь хятадын хүч биш, (Бүгд инээлдэв) харин бурхны хүч, Эзэн Бурханы хүч юм. Багшийн чинь заадаг бурхныг дурсах арга нь мөн л хятадын одоогийн сургадаг аргатай адилгүй, үүнийг тэд ойлгодоггүй болохоор багшийг чинь буруу номтон гэж хэлдэг. Шагжамуни Бурхан амьд байх үедээ бас зөвхөн дурсахыг заасан төдий биш, заримдаа бас шал шүүрд, шал шүүрд гэж уншихыг сургаж байжээ, энэ нь мөн л нэг зүйлийн түр зуурын бясалгалын арга болно, тийм юм бол багш чинь бусдад таван бурхны нэрийг сургах нь яагаад бясалгалын арга биш болчихов? Яагаад ийм түргэн буруу номтон болоод хувирчихав? (Бүгд инээлдэв).

Жинхэнэ үнэн бодит байдлыг тодорхой ойлгохгүйгээр ам нээмэгц бусдыг дайрдаг хүмүүс ч бас хамгийн дээд номын аргыг сурахаар энд ирдэг, гэвч багш чинь мөн л сэтгэл үл түвдэн түүнд ном уламжилдаг, учир нь багш чинь бодьсаввагийн зам мөрийг дагаж байгаа болохоор хамаг төрөлтөнд ялгаварлах сэтгэл үүсгэж болохгүй. Гэд дэндүү их мах идэж, буян хишиг тун бага болохоор багшаас чинь сурахын аргагүй, амьд бурханд шавилахын аргагүй. Энэ бясалгалын аргаар бясалгагчид их олон, ганцхан Энэтхэгт хэдэн арван мянган хүн бясалгаж байгаа хэдий ч гүгтэдэг хүмүүс нэг ч байхгүй, гэтэл Европ тив болон Америк

тивд ном уламжлах үеэр хүмүүс тэр дорхноо дайралт хийдэг нь үнэхээр яршиг төвөг ихтэй. Багш чинь энд тийм олон хүнийг сургаагүй байтал аль хэдийн дайралтанд өртөж гүтгэгдэж гүжирдүүлчихжээ. Учир нь энэ орон бол Энэтхэг биш, үнэн ёсыг ойлгодог хүмүүс маш цөөн, нийтийн үйлийн үр нь их хүнд, та нарын үйл түйтгэр тийм их биш байж ч магад, гэвч энэ улс орны хүмүүстэй хамт амьдарч байгаа болохоор эндхийн нийтийн үйлийн үртэй холбоотой, тэд мах идэж, бид иддэггүй боловч энэ оронд хамт амьдардаг тул мах идэж, архи уудаг тэр хүмүүс бидэнд гэр байшин барих, зам засах, тариа тарих, ногоо ургуулахад туслах нь зайлшгүй, тэгэхлээр тэдний уур амьсгал, орчин нь бидний хүнс ногоо, зам, уул, ус, цахилгаан, гэр байшинд нөлөөлнө.

Ургамал хоолны газарт ч гэсэн тэр мах идэж, архи уугчид тамхи татахын зэрэгцээ ургамал хоол хийж бидэнд идүүлдэг, бас нэг талдаа мах шарахын зэрэгцээ нөгөө талдаа ургамал хоол шарж байж ч магад, заримдаа ургамал хоол хийхээ мартаад мах шарчихсан байж ч мэднэ. Зарим хүн угаас ургамал хоолны газар ажиллуулж байснаа орлого муу болохоор нь махан хоол хийдэг болчихож, нэг талд нь махтай хоол, нөгөө талд нь ургамал хоол хийнэ, тэгээд бясалгагч хүнд баригдаж болохгүй гэж боддог, тиймээс ургамал хоолны газар нь махан хоолны газар болж хувирахад асуудалгүй, орлого нь их л бол хангалттай. (Бүгд инээлдэв).

Тиймээс бид хичээн бясалгахгүй, бясалгалдаа дэвшихгүй бол энэ ертөнцөд дорхноо бохирдоно, энэ ертөнцийн нийтийн үйлийн үр тун их, бүх дэлхийд бясалгагч хүн хичнээн байгаа билээ? Ном сонсох дуртай хүмүүс хэр их байна вэ? Ихэнх хүн ном сонсох ч дургүй юм чинь зам мөрөө өөрсдөө чармайн засах, бясалгаж суух, ургамал хоол идэх талаар бүр ч ярих хэрэггүй. Ном сонсдог хүмүүс маш цөөхөн, диско бүжиглэдэг хүмүүс нь маш олон байна, зурагтаар ч гэсэн ном тайлсан хөтөлбөрийг сонирхдог хүмүүс ч гэсэн цөөхөн, гэтэл Америкийн кино үйлдвэрийн нэрт жүжигчид, эсвэл алдартай кино ирвэл тэр даруй маш олон хүн үзэх гэж ирдэг, тэгээд сонирхохын зэрэгцээ бургер иддэгээ европчууд болон америкчуудтай адил байж л цаг үеийн аясыг дагаж чадна гэж үздэг.

Одоогийн залуус явган явахын зэрэгцээ хөгжим сонсдог, тэднийг бясалгаж суу гэхээр сууж чаддаггүй, яагаад гэвэл тэдэнд сармагчин шиг л нааш цааш байнга хөдөлдөг (Бүгд инээлдэв) дадал аль хэдийн суучихсан. Ингэж байж яаж бясалгал хийж чадах вэ, бясалгадаг хүмүүс тун цөөн байдаг болохоор нийтийн үйлийн үр нь маш хүнд болчихдог учраас бидний бясалгалд бас тэр нь их нөлөөлдөг.

Тиймээс энд ном уламжлах нь үнэхээр хэцүү ажил, Энэтхэгт харин нилээд амар хялбар, тэнд их халуун боловч хүмүүсийн сэтгэл санаа нь сэрүүн тунгалаг байдаг, хахир хүйтэн орны агаарын дулаан дэндүү хүйтэн байдгаас ч болдог байж ч магад, хүмүүсийн сэтгэл дэндүү хүйтэн, дотно халуун сэтгэлтэй болж чадаагүй л байна. Иймээс Шагжамуни Бурхан урт насалж, Есүс Христ харин богино насалжээ. Бодьдармаа ч гэсэн хятадад хүрч ном уламжилсан болохоор бас л бэрх хэцүү байжээ. Зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн хятадын өмнө газарт хүрч ном уламжлахад мөн л амаргүй байжээ. Одоо тэр их нэр

алдартай байгаагийн шалтгаан нь нь энэ Зургаа дахь өвгө Багш нэг боть “Ном эрдэнэ мандал” судар “六祖坛经”-ыг хойчийн хүмүүст бичиж үлдээснээс болжээ, тэгээгүй бол бид түүний хэн болохыг таних ч үгүй, түүнд тийм их шавь байгаа ч үгүй, зөвхөн хятадын өмнөд газрын хэдэн мянга, эсвэл хэдэн арван мянган хүн л бишрэн шүтдэг төдийхөн байсан.

Тэд бясалгаж суугаа үедээ ахуй ойлголттой, Хүй Нэн багшийн хүчийг мэддэг болохоор түүнийг бишрэн шүтдэг, тэгээгүй бол юундаа бишрэн шүтэх билээ? Орхимж болон бадар аяга нь нэг хүний бясалгалын дэсийг гэрчилж чаддаг бол хэн ч гэсэн орхимж болон бадар аягыг хулгайлаад л өвгө багш болчихож болно. Тиймээс Хүй Нэн Багшид сэтгэгдэшгүй хүч чадал байдгийг тэд лавтай мэддэг болохоороо сая бишрэн шүтсэн хэрэг, гэвч тухайн үед бас түүнийг гүтгэдэг хүмүүс их байжээ. Умард орны Shen Xiu шавь нар зүйл зүйлийн аргаар түүнийг гүтгэн гүжирдэж, буруу номтон гэж ярьдаг байжээ, үнэндээ Хүй Нэн багшийн сургаал ёс нь мөн л тавдугаар үеийн өвгө багшаас уламжилсан, адилхан багш, адилхан сургаал ёс, адилхан бясалгалын арга байсан хэдий ч харин буруу номтон гэж шүүмжлүүлж байжээ. Яагаад вэ гэвэл энэ бол хятад орон, харин Энэтхэг биш, миний хэлж байгаа нь зөвхөн хятадууд ч биш, Вьетнамчууд ч ийм, ном уламжлахад амаргүй. Гэвч Вьетнамд бясалгагчид олон байдаг, уужуу сэтгэлтэй, яагаад гэвэл маш олон буддын шашинтан католик шашны сүм дуганд очдог бөгөөд католик шашинтнууд ч бас буддын шашны сүм хийдэд очдогийг би Вьетнамд харсан билээ.

Германд байхад тэд намайг Вьетнамын нэг жижигхэн сүмийн тэргүүн болгохоор урьсан, тэгээд дөнгөж хэдхэн сар болж байтал та нар: Багш аа! Бушуухан ирээч ээ гэж байнга утасдаад байсан. Тэр үед германд ямар ном хурсан ч католик шашинтнууд бүгдээрээ ирж сонсдог, зэргэлдээ католик шашныхан ном хурвал бурхны шашинтнууд бүгдээрээ очиж ном сонсож, хамтдаа идэж уун наргиж цэнгэдэг. (Бүгдээрээ инээлдэв) Гэвч тэднийг харахад бясалгал хийх хүсэл тийм ч их биш болохоор тэднээс салж одсон, харин зөвхөн та нар багшийгаа дуудахлаар л буцаж ирсэн хэрэг биш, нөгөө нэг шалтгаан нь тэднийг сургахад тун бэрх байдгаас болсон юм. Иймээс хүмүүсийг сургахад тун ч амар хялбар биш, Энэтхэгчүүдийг сургахад харин нилээд хялбар гэж багш чинь боддог.

## ҮХЭЖ, ТӨРӨХ САНСРЫН ХҮРДНЭЭС ТУУЛАН ГЭТЛЭЕ ГЭВЭЛ ЗААВАЛ АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГАД НАЙДАХ ХЭРЭГТЭЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар*

*Тайванийн Пин Хү хот*

*(Эх нь хятад хэлээр)*

*1987 оны 2 дугаар сарын 14*

Энэ настан багшаас шалтгаалаад Пин Хү хотод би оройтож ирлээ, тэр бол Пин Хү хотын хамгийн эхний авшиг хүртсэн хүн бөгөөд жинхэнэ гэрээс гарагч, сэтгэл нь хов хоосон. Уг нь тэр өөрөө л авшиг хүртэх бодолтой байсан ч харин шавь нараа дагуулж ирээд авшиг хүртлээ. Ихэнх хүн шавь нарыгаа өөрсдийн хувийн эд хөрөнгө хэмээн үзэж, халаасандаа байлган бусад хүмүүст булаалгахаас эмээдэг, гэтэл энэ настай номын багшид тийм санаа байгаагүй, өөрөө сайн арга зам хайж олоод тэр дорхноо шавь нараа ч дагуулж ирсэн байна. Би өөрөө шавь нартай болно гэж огт бодоогүй, гэтэл түүний шавь нар одоо харин бид хоёрын авшигтан болсон байна. Тэднээс болоод би бас өөр хүмүүстэй танилцсан, тиймээс би дахин Пин Хү хотод ирлээ, тиймгүйсэн бол одоог хүртэл Пин Хү хот хаана байдгийг мэдэх ч үгүй байхсан.

Ау Лак буюу Вьетнамын нутаг нэгтэнтэйгээ уулзахаар би анх Пин Хү-д ирсэн юм, тэднийг энд амьдардаг гэдгийг сонссон хэдий ч хаана амьдарч байгааг нь мэдээгүй, олон жилийн өмнө миний сахил хүртсэн Багш маань захидал илгээж, Вьетнамын дүрвэгсэд Тайванийн Пин Хү-д амьдарч байгааг та мэдэх үү? Тэдэнтэй очиж уулзсан уу? гэж асуухад би мэдээгүй гэсэн, би Тайваньд хэд хэдэн удаа ирсэн ч, ирэх бүртээ бясалгаж суудаг л төдий, бясалгаагүй үедээ шал шүүрдэхээс биш өөр газарт огт очиж үзээгүй. Харин Багш намайг дүрвэгсэдтэй уулзаарай гэж хүссэн учир би зөвшөөрсөн билээ. “Энд аль нэг арал дээр Вьетнамын дүрвэгсэд суудгийг та нар мэдэх үү?” гэж би нэг шавиасаа асуулаа, Учир нь Пин Хү арлын Вьетнам дуудлага болон Хятад дуудлага адилгүй, тухайн үед Хятад хэлээр яаж хэлэх ёстойг би мэдэхгүй байсан, гэвч шавь маань миний санааг ойлгож, “Пин Хү арал мөн үү?” гэсэнд би: “Мөн байх, тэнд очиж үзмээр байна, та намайг дагуулж очиж болох уу?” хэмээн ярилцаж, бид хоёр ингэж анх Пин Хү-д очсон юм. Тэр үед хэнийг ч таньдаггүй байсан, гэвч Вьетнамын дүрвэгсэдтэй уулзахаар аль хэдийн нэрээ бүртгүүлэн маш олон эд зүйл худалдан авч, мөнгө болон Арьяабал бурханы хөрөг хүргэхэд бэлэн болсон байлаа, тиймээс дүрвэгсэдийг хариуцдаг төвийн цэргийн алба хаагч машин явуулж,

онгоцны буудлаас биднийг тосож, дүрвэгсэдийн төвд хүргэсэн. Тэд бид хоёрыг цэргийн зочид буудалд байрлуулахаар зохицуулсан, нэг хоногт гурван зуун юань, маш хямдхан бөгөөд гурван том өрөөтэй болохоор бидэнд арай л том санагдсан. Угаас дарга, сайд нар байрладаг юм байж, тэдний зохицуулсны дагуу бид тэнд орж байрласан. Дөнгөж нэг хоноод надад таагүй болов, гэрээс гарагч хүн яаж зочид буудалд хонож болох вэ? Ичмээр хэрэг мэт тун тавгүй санагдав. Би: “Хоёр хоног суумаар сүм байдаг болов уу?, хайж үзье” гэж шавьдаа хэлсэн. Зочид буудлын өрөөнд хоол хийж идэж болохгүй, мөн бид ургамал хоол иддэг учраас шавь маань бэлэн гоймон худалдан авахаар явлаа. Яг тэр үед нэгэн гэрээс гарагчтай тааралдаж, яагаад бэлэн гоймон идэж байгааг асуусанд шавь маань нөхцөл байдлаа түүнд хэлсэнд, нөгөө гэрээс гарагч: “Багш чинь хаана сууж байгаа вэ?” гэж асуусанд “Зочид буудалд байгаа” гэж шавь маань хэлжээ, гэрээс гарагч “Энд та хоёр сууж болох нэг сүм бий, та хоёрт тав тухтай байж магадгүй, бас өдөр бүр бэлэн гоймон идэх шаардлагагүй, бэлэн гоймон байнга идвэл биед чинь муу” гэжээ.

Тэгээд өнөөх гэрээс гарагч бид хоёрыг өөрийн суудаг сүмд дагуулж ирсэн юм, өдөр бүр үдийн хоолны үеэр л би түүнтэй тааралддаг. Учир нь би өглөөнөөс үд болтол бясалгаж, оройн хоолны дараа бага зэрэг амсхийгээд үргэлжлүүлэн бясалгаж суудаг. Тэр намайг хараад ямар сонин хүн бэ? Үдийн хоолны үеэр ганц удаа л харагдаад бусад цагт үргэлж бясалгаж суудаг, эсвэл унтдаг, ийм гэрээс гарагчийг өмнө нь ерөөсөө үзээгүй дээ гэж боджээ. Та ямар аргаар бясалгадаг вэ? гэж тэр надаас сониучирхан асуусанд, би хариулаагүй, харин би түүнээс “Та ямар аргаар бясалгадаг вэ?” гэж асуухад “Би гуч гаруй жил маани тоолж уншиж байна” гэв. Би мөн түүнээс “ахуй ойлголттой болсон уу?” гэж асуухад “болоогүй” гэв, “Та ингэж бурхныг дурссанаар Төгс Баясгалант оронд очиж чадна гэдэгтэй итгэдэг үү? гэж асуухад тэр “ахуй ойлголт үзээгүй болохоор би Төгс Баясгалант оронд очиж чадахгүйдээ тун их санаа зовж байна” гэсэн.

Үүнийг сонсоод миний сэтгэлд маш их гуниг төрсөн. Тэр “Би нэгэнт насан өндөр болсон бөгөөд ийм олон жил бясалгасан боловч Төгс Баясгалант барууны оронд очиж чадах эсэхээ мэдэхгүй байна, Учир нь ямар ч нотолгоо байхгүй болохоор маш зовниж байна” гэж надад ярьсан юм. Гэрээс гарч, маани тоолж, нэгэнт гуч гаруй жил болсон хэдий ч бас л үхлээс айна, нас барсныхаа хойно Төгс баясгалант оронд очиж чадах эсэхээ мэдэхгүйдээ эмээнэ. Би энэ байдлыг нь сонсоод түүний төлөө санаа зовж, сэтгэл минь ихэд хөдлөв, “Та Төгс Баясгалант оронд очье гэвэл ямар аргаар “Бурханыг дурсах”-аа мэдэх хэрэгтэй, Учир нь та буруугаар дурсаж байгаа болохоор ахуй ойлголт байхгүй байгаа юм гэж тэр үед би хар аяндаа хэлж орхисон. “Ямар аргаар бурханыг дурсан санавал зохистой вэ?” гэж тэр надаас үргэлжлүүлэн асуухад би түүнд Арьяабалын бясалгалын аргыг зааж өгсөн. Тухайн үед би Арьяабалын арга гэж хэлээгүй, зүгээр л: “Та ингэж бясалгавал лавтай Төгс Баясгалант оронд хүрч чадна” гэсэн. Би та нарт хэлье, нэрийдэл нь ондоо боловч бясалгах арга нь бүгд адилхан. Тухайн үед би настан багшид зөвхөн

төгс баясгалант орныг л ярьснаас биш Арьяабалын бясалгалын талаар яриагүй, Тэр ч бас Арьяабалтын бясалгалын аргын талаар мэдэх шаардлагагүй, Тэр ахуй ойлголттой болж, бурхан болон бурхны гэрлийг харж чадвал л хангалттай, ингэвэл тэр маш баярлаж, сэтгэл ханамжтай болно. Тэр Төгс баясгалант оронд очих дуртай болохоор би Арьяабалын номыг ярих юмуу, “Баатар явагч их хөлгөн судар” гэхчилэн төвөгтэй нэршил хэлсэнгүй, Тэр багшид нь их итгэдэг, ёс суртахуунаар сайн, ном уламжилсны дараа ахуй ойлголт сайн, энэ бясалгал нь түүний хувьд хамгийн сайн арга гэдгийг аль хэдийн мэдчихсэн болохоор мөн л шавь нараа дагуулж ирээд багшаас чинь ном уламжлахыг хүссэн, ингэсний эцэст одоо улам бүр их хүнтэй болсон байна. Настан багш байгаагүй бол та нарт надтай уулзах боломж байхгүй байх байсан, Пин Хү хаана байдгийг ч би мэдэхгүй юм чинь энд ирж ном тайлах тухай бүр ярихын ч хэрэггүй. Би бас аяллаар явах тийм их дуртай биш, одоо “хөгширчээ” (багш инээв), өмнө нь залуу байхдаа дэлхий даяар тойрон аялах тун дуртай, олон оронд очиж байсан, одоо ядраад хаана ч очих дургүй болсон. Залуу байхдаа олон орноор аялан тамхи тагдаг хүмүүстэй хамт явсан ч тоодоггүй байсан, одоо нас ахиад тамхины үнэр үнэртмэгц, бие тавгүйтнэ, тиймээс залуу хойрго, ийш тийш явах дургүй болсон байна. Гэвч хүмүүс чин сэтгэлээсээ багшаас чинь гуйсан учраас би хүрч ирлээ.

Ямар нэг газар очих бүрт бие маань тавгүйтэж, хожим хаашаа ч очихгүй гэж хэлдэг ч бас л мартчихдаг, хүн уривал би тэр даруй очдог, Хэрэв аяллын явцад зовуурьт байдлаа байнга санаж байвал ууландаа бясалгаж суухаас өөр хаана ч очихгүйсэн, багш чинь улам бүр залуу болжээ, настай хүн юм чинь дээ (Багш инээв). Арьяабал Бурхан яагаад эмэгтэй хүний дүртэй байдгийг мэдэх хүн байна уу? Сонсоход эмэгтэй хүн бурхан болж чаддаггүй гэдэг, ийм байтал тэр яагаад эрэгтэй хүн болоогүй вэ? Эрэгтэй хүн болсон бол хүмүүс ихэд хүндэтгэж болох байтал яагаад эмэгтэй хүний дүртэй болов? (Эмэгтэйчүүдийг гэтэлгэхийн төлөө гэж нэг хүн хариулав). Эрэгтэй хүн эмэгтэйчүүдийг гэтэлгэж чадахгүй гэж үү? (Голдуу үйл түйтгэр маш хүнд эмэгтэй хүмүүсийг гэтэлгэхээр ирсэн гэж нэг хүн хариулав).

Бүсгүйчүүд яагаад үйл түйтгэрээр тун хүнд байдаг хэрэг вэ? Энэ чинь зөвхөн цуу яриа л төдий. Бид ер нь хүмүүс юу ярина, түүнд нь дорхноо итгэж, өөрсдөө сайн боддоггүй. Бүсгүйчүүдийн үйл түйтгэр яагаад тийм их байдаг хэрэг вэ? Тэд ямар муу үйл хийсэн юм бэ? Бурхан, Бодьсадва нар бүгд эмэгтэй хүний хэвлийгээс мэндэлсэн байхад эцэст нь эмэгтэй хүний үйл түйтгэр хүнд гэж хэлэх нь ачлалгүй хэрэг биш гэж үү? Бусдын ингэж ярихад та итгэдэг бол би итгэдэггүй. Бид юунд ч итгэлээ гэсэн заавал ноголгоотой байх ёстой, сонсонгуутаа л итгэх хэрэггүй, Хэрэв тэд чамайг бирд гэж хэлбэл, чи бас итгэх үү? Тийм учраас мухар сохроор итгэх хэрэггүй, сохроор итгэх, эсвэл мухар сүсэг бидэнд хортой, муугаар нөлөөлнө.

Эмэгтэй хүмүүс байхгүй бол бурхан байхгүй гэдгийг мэдэж авах хэрэгтэй, Шагжамуни Будда ч мөн адил эмэгтэй хүний хэвлийгээр дамжин мэндэлсэн юм. Бүсгүйчүүд бол хүн төрөлхтний хамгийн их

ачтан, эмэгтэй хүний үйл түйтгэр маш хүнд гэж ярих нь үнэхээр хэлээр үйлдэх аймшигтай нүгэл хилэнц болно. Миний бодлоор Шагжамуни Будда ингэж яриагүй, үүнийг хойчийн хүмүүс л өөрсдөө нэмсэн байна.

Бидний ном тайлахыг сонсож байгаа байдлыг харвал эрэгтэйчүүдийн үйл түйтгэр харьцангуй их юм шиг байна. Ном сонсохоор ирэх эрэгтэйчүүд маш цөөхөн. Угаас дөрвөөс таван эрэгтэй хүн багшаас чинь Арьяабалын бясалгалын аргыг сурахаар ирсэнээс хамгийн сүүлд ганцхан хүн үлджээ, бусад нь бүгд эмэгтэй, энд байгаа хүмүүсийн ихэнх нь эмэгтэй байна, эмэгтэйчүүд ном сонсох тун дуртай байдаг нь ёс суртахуунаар өндөр дээд байгаа хэрэг биш гэж үү? Тэдний мөр ёсыг хайх сэтгэл нь эрэгтэйчүүдийнхээс илүү, үүнээс үзвэл эрэгтэй хүний үйл түйтгэр эмэгтэй хүнийхээс их. Уучлаарай, би ингэж л ярина.

Зарим эрэгтэй хүн гадуур зугаа цэнгэлд шунаж, найз нартайгаа хөзөр тоглож, элдэв замбараагүй зүйл хийдэг. Бүсгүйчүүд харин энд ирж ном сонсдог, тэд өдөржин цаг завгүй ажиллаж, алба ажилтай байгаа бүсгүйчүүдийн зарим нь ажлаа тараад гэртээ ирснийхээ дараа бас гэр бүлээ харж хандана, нөхөр болон хүүхдийнхээ оймсыг угаана. Бүсгүй хүн өршөөнгүй, энэрэнгүй, тусархаг, өгөөмөр гэсэн дөрвөн цаглашгүй сэтгэлтэй болохоор бурхан бодьсадвагийн сэтгэлд тун ойр байдаг. Үүнийг та нарт лавлагаа болгон ярьж байгаа юм, багшдаа битгий уурлаарай. “Дөрвөн цаглашгүй сэтгэл”-ээр ном сонсвол сайн, багшдаа уурлавал тотгорлогдоно. Тиймээс эрэгтэйчүүд уурлаж болохгүй, багш нь зөвхөн та нарт лавлагаа болгон ярьж байгаа л төдий юм.

Гэхдээ эрэгтэйчүүд бүгд саад тотгортой гэсэн үг бас биш, өнөөдөр бас хоёр эмэгтэйд саад тотгор тохиолдсон байна, нэг нь авшиг хүртэх цагийг андуурч сонсжээ, нөгөө нь сэрүүлэг тавьсан ч сэрүүлэг нь дугарсангүй. Уг нь сэрүүлэгтэй цаг хоёрыг бэлтгэсэн байтал хоёул хоёулаа дугарсангүй, нэг нь дугарахгүй бол бас яахав, итгэж болно, хоёул хоёулаа дугараагүй нь бас сонин юм. Энгийн үед тэр гурван цагт сэрдэг байсан, өнөө өглөө авшиг хүртэх өдөр, таван цаг болчихсон байхад босож чадаагүй, долоон цагт энд ирэхэд нь нэгэнт авшиг хүртэх цаг өнгөрч, авшиг хүртэж амжсангүй, уурлаад ямар ч нэмэргүй болжээ.

Угаас тэр ургамал хоолтон болоод олон жил болсон ч, өчигдөр орой гэртээ хариад андуурч махтай шөл ууснаас болоод өнөөдөр хоёр сэрүүлэг нь хоёулаа дугарсангүй гэж тэр өөрөө ярьсан. Ганц балга махтай шөл андуурч уусан төдийд үйл түйтгэр тийм их болж байгаа юм чинь өдөр бүр мах идвэл ямар болох бол гэдгийг та нар маш тодорхой ойлгох хэрэгтэй. Бас нөгөө эмэгтэй нь өнөөдөр энд ном сонсож байна, тэр ургамал хоол идэхээр багшид чинь аль хэдийн амалсан, гэтэл гэртээ хариад найз нартайгаа хамт мах идсэний дараа арьс нь харшилтай болжээ, тиймээс одоо бага зэрэг мах идэж ч зүрхлэхгүй болсон. Үнэн шүү.

Мах идэх нь үнэндээ аймшигтай, гэвч бид тийм мэдрэмтгий биш учраас мах идэх нь хичнээн их үйл түйтгэртэйг мэддэггүй. Хамаг төрөлтөн маш өрөвдөлтэй, харахаар нулимс минь урсдаг, учир нь дэндүү харанхуй мунхаг, юу ч ойлгохгүй, хичнээн ярьсан ч мөн л ойлгодоггүй.

Өчигдөр орой харахад уг нь арван нэг, хоёр хүн авшиг хүртэх байсан, өнөөдөр өглөө зөвхөн зургаахан хүн ирснийг хараад нулимс унагамаар болж, гурван хоног ном тайлж, маш тодорхой, маш ойлгомжтой ярьсан, та нар ч гэсэн сайн ойлгосон, одоо ургамал хоолтон болоод багшаас сурна гэж хэлсний эцэст харш саад тохиолдож, гэнэтийн хувиралт гарчээ, ингэснээр та нарын сэтгэл шаналсан төдийгүй багшийн чинь сэтгэл бүр ч илүү шаналж байна.

“Хамаг төрөлтний нулимс далайн уснаас ч их” гэж Шагжамуни Будда айлджээ, гэтэл миний бодлоор бурхан бодьсадвагийн нулимс хамаг төрөлтнийхөөс ч их. Урд нь би хамаг төрөлтний гаслан зовуурийг хараад өөрөө бүр зовниж, байнга нулимс унаган чин сэтгэлээр төгс гэгээрсэн их багшийг хайж, мөр ёсыг олохын төлөө олон орноор явж, зовлон зүдгүүрийг амсахдаа жинхэнээр бурханы хутагт хүргэж чаддаг номыг хайж олохыг бодсон, зөвхөн бурханы хутагт хүрч чадсан тэр цагт л асар их хүчээр хамаг төрөлтнийг туулан гэтэлгэж чаддаг юм.

Хайж олсны дараа мөн л нойр хоолгүй, юуг ч үл хайхран шаргуу бясалгав. Бясалгал амжилтад хүрч бага зэрэг ололттой болмогц энэ эд хөрөнгөө тэр даруй хамаг төрөлтөнтэй хуваалцахыг хүссэн билээ. Гэтэл хүмүүс ойшоохгүй, ойлгохгүй, билиг ухаангүй байхыг үзээд багш чинь бүр илүү нулимс асгаруулсан. Тиймээс хамаг төрөлтөн хичнээн зовлонтой ч бурхан бодьсадва нарын зовлонтой харьцуулшгүй юм, хамаг төрөлтний зовлон тогтворгүй, өнөөдөр зовж байснаа маргааш нь баярлачихдаг, учир нь харанхуй мунхаг болохоор өнөөдөр зовлонтой санагдаж байснаа маргааш нь үзэсгэлэнтэй эмэгтэйтэй учирч, амттай хоол идэж, сайн хэрэг тохиолдвол баярлачихна.

Гэтэл бурхан бодьсадва нэгэнт гэгээрчихсэн болохоор өнөөдөр баярлаж байснаа маргааш нь зовох боломжгүй. Хамаг төрөлтний гаслан зовлонг өдөр бүр харж, өдөр бүр уйлна, тэдний өмнөөс уйлдаг хэрэг. Энэ талаар Шагжамуни Будда ярихаа мартчихсан байж магад, зөвхөн хагасыг нь л ярьжээ (Багш инээв), тэр хамаг төрөлтний нулимс далайн уснаас ч их гэж хэлснээс биш, бурхан бодьсадвагийн нулимс хэр их байдгийг ярихаа мартжээ. Ярилаа ч гэсэн хамаг төрөлтөн итгэхгүй гэж бодсон байж ч магадгүй, тиймээс яриагүй байх.

Өнөөдөр харин багш чинь та нарт ярьж өгье. Бясалгал хийж бурханы хутагт хүрсний дараа хамаг төрөлтнийг зовохыг хараад сэтгэл шаналахгүй бүгд л мод шиг болчих юм биш, бурхан бодьсадвагийн хувьд гаслан зовлонтой байх эсэх нь ерөөсөө адилхан хэдий ч хамаг төрөлтний зовохыг харахад мөн л нулимс асгаруулдаг. Мэдээж энэ нь хүн төрөлхтний эмзэг зөөлөн зүрх сэтгэлээс болсон нулимс биш боловч тиймэрхүү нигүүлсэнгүй сэтгэлээс ундарсан нулимс ч гэлээ мөн л гаслантай.

Бурхан бодьсадва хамаг төрөлтнийг санан дурсах нь яг л аав, ээж нь үр хүүхдээ санан дурсахтай адилхан гэж Бурханы сударт тэмдэглэсэн байдаг. Гэтэл бид харин тэднийг санаж дурсдаггүй учраас бясалгах дургүй. Бидний хувьд махан биеийн аав, ээж, эр, эмийн харилцаа, найз нөхдийн хоорондох нөхөрлөл болон хувь хүний нийгэм дэх байр суурь,



эд хөрөнгө гэх зэргийг бурхан бодьсадва нараас ч илүү чухалчилдаг.

Зарим хүн ургамал хоол идвэл хүмүүс дооглохоос эмээнэ, эхнэр нь уурлаж хоол хийж өгөхгүй байх гэхээс эмээнэ, эхнэр, нөхөр нь гэр бүл салахаас айна, архи ч уухгүй, тамхи ч татахгүй болохоор найз нь түүнийг огт хэрэггүй хүн, эр хүн биш гэж бодохоос айна, ургамал хоолтон болсны дараа ажлаа алдахаас айна, учир нь одоо байгаа ажил нь маш сайн, аюулгүй, ургамал хоол идвэл ажилд нь саад болох ч юм билүү, өөр ажил олдохгүй болж, өлсөж үхэхэд хүрнэ. Ингэж боддог нь бурхан бодьсадва нараас илүү энэ дэлхийд итгэдгээс болжээ, чин сэтгэлээсээ мөр ёсыг хайгч хүнийг бурхан бодьсадва үхлийн аюулд хүргэх ёсгүй. “Өөрөө дурлан өлсгөлөн зовлонг хүлцэн байж бурханы хутгийг олж, үхэж, төрөхийн сансрын хүрднээс өнө мөнх ангижирна”, тухайн үед би яг л тийм итгэл зоригтой байсан болохоор юуг ч хайхралгүй мөр ёсыг хайсан билээ.

Урьд нь би Германд байхдаа баян тансаг амьдралтай байсан, гэвч гэр бүлээсээ салах үедээ хов хоосон, ирээдүй маргаашийн тухай ч бодоогүй, хожмын амьдралд маань ямар зүйл тохиолдохыг ч мэдэхгүй, гадаад улсад очоод өлсөж үхэх эсэх, гудамжны гуйлгачин болох эсэхээ ч мэдэхгүй байсан хэдий ч эцэст нь хаана ч очсон ямар ч асуудал үүсээгүй, хаана ч амгалан тайван, мөнгө төгрөгтэй эсэх нь ч ер хамаагүй байсан. Христос шашны Библи сударт “Эхлээд өөрсдийнхөө диваажинг хайж ол, тэгвэл аливаа бүхэн чамд ирэх болно” гэжээ.

Бид билгийн мэлмийгээ нээгээгүй болохоор өнгөрсөн, одоо, ирээдүйгээ харж чадахгүй, биднийг ямар нөхцөл байдал хүлээж байгааг мэддэггүй. Харанхуй мунхаг хүмүүс бүгд л бага зэрэг мах идэх нь ямар хамаа байх вэ гэж боддог, ирээдүйн үр дагавраа харж чаддаггүй болохоор үр дүн нь ямар хүнд байхыг мэддэггүй. Гэтэл бурхан бодьсадва нар харж чаддаг, хамаг төрөлтийг харанхуй мунхагаасаа болж зовлон амсахыг харж зүрхлэхгүй болохоор зовж зүдрэн байж тэдэнд үнэн ёсыг ярьж сонсгодог хэдий ч тийм их нэмэр болдоггүй, тиймээс л бурхан бодьсадва нар уйлдаг юм.

Энэ нь яг л бид бяцхан хүүхэд аюултай тоглоомоор тоглож байхыг харж байгаатай адил, бяцхан хүүхэд тэр газрыг аюултай гэдгийг нь мэдэлгүй очиж тоглодог, ямар аймшигтай үр дүнтэй гэдгийг нь мэддэггүй. Гэтэл аав, ээж нь нэгэнт том хүн болж, тийм зүйлээр тогловол тун аюултай, тун аймшигтай гэдгийг мэддэг болохоор хүүхэд нь хатуухан сургаалыг нь сонсох дуртай эсэхийг хайхралгүй ярьж хэлэх хэрэгтэй бөгөөд хөндлөнгөөс оролцоход нь дуртай эсэхийг үл хайхран заавал оролцох хэрэгтэй, учир нь хүүхдээ зовлон амсахыг харж тэсэхгүй. Эцэг, эх ингэх нь ерөөс үр хүүхдээ аврахын төлөө болохоос биш, харин өөрсдөд нь ач тустай байдгаас болсон зүйл огт биш.

Үүнтэй адил, бурхан бодьсадва нар, эсвэл их багш нар байнга ирж буцаж хүмүүсийг авардаг нь тэдний хувьд өөрсдөд нь ямар нэгэн ач тустай байдгаас болсон юм биш, бясалгаад өндөр зэрэгт хүрсэн хүмүүс, эсвэл бурхан бодьсадвагийн хувьд бүхий л орчлонг олсон ч сэтгэл тагагддаггүй, тэр ч байтугай эгэл ертөнцийн нэр хүнд, эд хөрөнгө,

эрэгтэй, эмэгтэйн харилцаа гэх мэт нь сэтгэлийг нь ер булааж чадахгүй. Тэд зовж зүдрэн байж хамаг төрөлтийг сургадаг нь зөвхөн нигүүлсэнгүй сэтгэлээс л болсон төдий, өөр ямар ч зорилго байхгүй, хэрвээ өчүүхэн төдий аминчхан сэтгэл өвөрлөсөн бол хичнээн сонголонтой сайхан зүйл ярилаа ч эрт, орой хэзээ нэгэн цагт хүмүүс бүгд гадарлах л болно, бясалгалаар өндөр хүмүүс тиймэрхүү нэр хүнд, эд мөнгөд шунадаггүй.

Гэвч ямар ч байлаа гэсэн өнөөдөр багш чинь маш их баяртай байна, ийм олон хүн ном тайлахыг сонсохоор хүрэлцэн ирсэнд миний сэтгэл тун их хөдөлж байна, ёс суртахуун болон бясалгалын тухай сонсох дуртай хүмүүс бас их байгаа, та нарын одоогийн нөхцөл байдал мөн тийм ч аятайхан биш байж ч магад, гэвч тэглээ ч гэсэн мөр ёсыг маш их хүсэн эрмэлзэж байгаад чинь сэтгэл догдолж байна.

Орчлон дэлхий бидний бие махбодтой холбоотой, эндээс доош (багш билгийн мэлмийгээ заав) хөлийн ул хүртэл ялгаруулах систем л юм. Жишээ нь: нулимс, нүдний нуух, нус, шүлс, хөлс, өтгөн, шингэн гэх мэт билгийн нүднээс дооших эрхтэн бүгд л ялгаруулах систем болно. Тиймээс ямар ч бясалгалын аргаар бясалгасан бай билгийн нүднээс дооших төвтэй холбоотой л бол бүтэх, тогтнох, эвдрэх, хоосрох дотор байгаа билээ.

Йогийн маш олон систем, бясалгалын систем, эсвэл өөр номын аргын ихэнх нь бүгд л энэ мөнхийн бус бие махбодын бясалгалд найддаг, амьсгал, хамрын үзүүрээ ажих, наран сүлжээгээ ажих, хэлээр тагнайгаа тулахад найддаг нь бүгд л мөнх бус. Хэлээр тагнайгаа тулахаар рашаан ус ирдэг юм биш, рашаан ус бол бясалгаж суугаа үеэр аяндаа бий болно. Хэрвээ хэлээр тагнайгаа тулвал рашаан ус биш, шүлс гарна. Рашаан гэж бодсон ч мөн л худал юм. Зүрхээ ажих, хамрын үзүүрээ ажих, наран сүлжээгээ ажих, тэр ч байтугай зарим ёогийн систем нь бас бэлэг эрхтэн дээр бясалгадаг, эдгээр нь бүгд мөнх бус, бүгд л тун доод төвшнийх болно, бие махбодын хувьд эдгээр эрхтэн нь нэгэнт доод хэсэгт багтдаг юм чинь бясалгал ер дээшлэхгүй.

Бидний бие махбодод толгой бол хамгийн дээд, заримдаа ямар нэгэн асуудалтай болбол хөмсгөө зангидах нь бодлоо төвлөрүүлж байгаагаас болдог, хүн болгон бүгд л ингэдэг. Тэгвэл бид аль эрхтэнээрээ сэтгэдгийг та нар бод! Энд (багш билгийн мэлмийгээ заав) боддог юм биш үү? Эсвэл хамраараа боддог юм уу? Сэтгэлээрээ боддог уу? Сэтгэл бол хайр сэтгэл, хэрэв хүний сэтгэл хүндэрвэл хайр сэтгэл ч бас хүндэрдэг, хайр сэтгэл дэндүү хүндэрвэл ялгаж салгах чадвар болон саруул ухаан, шийдвэр тодорхой биш болно. Тиймээс эмэгтэйчүүдийн хайр сэтгэл хүнд болбол, үйл түйтгэр их гэж ихэнх хүн ярьдаг нь үүнээс л болсон байх. Эмэгтэй хүн амархан нулимс унагадаг, энэ нь эрэгтэй хүмүүс зүрх сэтгэлгүй гэсэн үг биш, гэвч тэд нулимс унагаж зүрхлэхгүй. Учир нь эрэгтэй хүн нулимс унагах нь тун ичгүүртэй хэрэг, том эр хүн, баатар хүн уйлдаггүй юм гэж аав, ээж нь хар багаас нь сургадаг, ингэж дасгалжуулсан болохоор том болсон ч уйлдаггүй, уйлсан ч сэтгэл дотроо л уйлдаг, нулимс унагадаггүй. Би ч гэсэн ингэж чадна, би бас сэтгэлдээ уйлж чадна, асуудалгүй. Гэвч би уйлъя гэвэл шууд л уйлна, нулимсаа

хорьсны хэрэг юу билээ? Уйлахдаа уйлж, баясахдаа ч баясна.

Ингэх нь “би” гэх сэтгэлдээ захирагдаж байгаа хэрэг биш, “сэтгэл”-ээрээ бодоход хүрвэл зүрх сэтгэл их сул дорой болж хувирна. Гэхдээ Арьяабалын бясалгалыг бясалгавал, ухамсраа дээд хэсэг (билгийн мэлмийгээ заав) дээр байлгаж чадвал сул дорой болохгүй. Гэвч дотоодын ахуй ойлголтыг дүрслэхэд тун бэрх бөгөөд тодорхой ярих аргагүй. Багш нь зөвхөн Арьяабалын бясалгалын аргаар бидний Mind (зүрх сэтгэл, санаа бодол, тархи толгой)-оо ариусгаж, түүнийг сургаж байж л санаа сэтгэлийг саруул уужим болгож чадна гэж та нарт хэлдэг. Ингэснээр тийм сул дорой болохгүй бөгөөд тодорхой сэтгэж, өөрийгөө захирах чадна.

Урд нь тэр энд (багш зүрхний хэсгээ заав) хоригдож, зургаан мэдрэхүй, зургаан ялгаруулах системийн нөлөөнд байжээ, одоо энд (багш билгийн мэлмий хэсгээ заав) шилжсэн болохоор үйл хэрэг, ёс зүйг нилээд тодорхой харж, жаахан баяр баясгалантай болно. “Сэтгэл”-ээ энд (билгийн мэлмий)-ээ хандуулбал тэр бидний бясалгал, дадалд тусалж, хамгийн дээд төвшинд хүргэж, доош уруу татагдахгүй болно.

Сэтгэлээ билгийн мэлмийдээ хандуулбал сэтгэл маш их баясаж, маш олон зүйлийг ойлгож, гурван ертөнцийг түргэхэн шиг даван туулж чадна. Тэр үед эгэл хүний тархи толгой оршихоо больж, гурван ертөнцөөс гаднах бүх зүйл бидний сүнслэг бие, уг дүр, бидний эзэн болно. Бидний эзэн энэ “Mind”-тай адилгүй, энгийн үгээр яривал “сүнс” болон “сүг сүлд” болно, сүнс бол эзэн, сүг сүлд бол Mind болно. Хэрэв тархи толгой туслахгүй бол бид бясалгаж чадахгүй. Тиймээс бие, хэл, сэтгэл гурвыг бүгдийг нь бясалгах хэрэгтэй, гэвч “сэтгэл”-ийг захирахад тийм амар биш, үүнийг эмнэг адууг сургахтай адил заавал нэг сурамгай адуучин сургаж байж л сая номхтгож чадна.

Үүнтэй адилаар Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж байж л сая бидний Mind (тархи толгой)-д тусалж эх нутагт нь буцааж чадна. Нутагтаа буцах үед сүнслэг биеийн зарлигийг ойлгоно. Тиймээс эрт дээр үеийн хятадууд “миний сэтгэл тун тайван бус байна” гэж хэлдэг байж, эрхбиш “сэтгэл”-ээрээ бясалгаж байж л сая нам тайван болж чадна. Учир нь тархи толгой бас тэнд байдаг болохоор тархи толгой, үзэл санаа гэж ярьдаггүй, зөвхөн сэтгэл л гэж ярьдаг. Эртний хүмүүс бясалгалаар нилээд сайн байсан болохоор нэгэн үзүүрт сэтгэл, чин сэтгэлээр бясалгах гэх мэтийн одоо хэрэглэдэг үгийг зохион гаргажээ, энэ үгс нь бүгд л тун утга учиртай билээ.

Тиймээс ямар ч системийг бясалгаж байлаа гэсэн билгийн нүднээс доош бол мөн л хүмүүн төрөлхтний хайр сэтгэлтэй холбоотой байж, мөн л гурван ертөнцийн дотор захирагдана. Заримдаа бид хар дарсан зүүд зүүдэлдэг нь бидний эзэн бие юмуу тархи толгой (Mind) наран сүлжээд очсоноос болдог, тиймээс хар дарж, муу муухайг хардаг нь бүгд л наран сүлжээний хэсгээс үүсэлтэй, үнэндээ ямар нэгэн газар очиж зовлон амссан, эсвэл жаргал эдэлсэн хэрэг биш, “Аливаа бүхэн сэтгэлээс үүдэлтэй” гэдэг нь ийм утгатай юм.

Унтаж байх үед үхсэнтэй ижил болж, өөрийгөө захирах хүч

чадалгүй болдог. Ахиухан бясалгасан хүн унтдаггүй, Учир нь сүнсэн бие нь дээш гараад энэ (билгийн мэлмий) дээр очсон байдаг. Бясалгахад заримдаа бие махбодод хүнд байдаг нь бид сэтгэлээ дээд тал (билгийн мэлмий)-даа байлгаж чадалгүй доошоо энд (наран сүлжээ) татдагаас болсон хэрэг, тиймээс эрхбиш сайтар бясалгаж байж л сая хүч чадал нэмэгдэж, дээш татаж чадна. Дээш гарахад тийм хялбар биш, доош буухад тун хялбар. Тиймээс ихэнх хүн бясалгахад хүндрэлтэй байдалд орж, өөрийн мэдэлгүй унтдаг нь сэтгэл нь дээд төвшинд очоогүй, бүгд гурван ертөнцийн дотор байгаагаас болж байгаа хэрэг.

Хэрэв сэтгэлээ билгийн мэлмий, эсвэл бурхны нүд, номын нүдэн дээрээ байлгавал яриж төвөггүй болж, унтахгүй байсан ч хамаагүй, өдөржингөө үзэл ухамсар нь маш саруул сэргэг байдаг. Хэрэв бид одоо дээш гарч чадвал ямар ач тус хүртэх вэ? Дээд талын төвшин гэдэг нь огтхон ч билгийн нүдний хэсгийг зааж байгаа биш, гэвч энд нэг хаалга байдаг болохоор эндээс гарч явж болдог.

Бидний биед өөр бас маш олон хаалга байдаг, бүгд өөр өөр төвшинд хүрэх сүв юм. Хэрвээ өөрийн биеэ захирч чадахгүй бол, бясалгахгүй бол, өөрсдийн сэтгэлээ, эзнээ, тэрхүү Mind (тархи толгой)-ыг билгийн мэлмийдээ төвлөрүүлж, дараа нь эндээсээ гарахыг дасгалжуулахгүй бол нас барах үедээ өөр сүвээр гарах боломж их байдаг.

Хамгийн муу байдал нь доод сүвээр гарах юм, энд (хамрын үзүүрээ заав)-ээс гарах нь бүгд маш доод төвшин болно. Билгийн нүднээс дооших сүвээр гарах дараалал нь тэнгэрт мэндлэх, хүний төрөл авах, асури, бирд, адгуус, тамын орон гэх мэтээр дараалдаг. Тиймээс хүн нас барсны дараа толгойн оройн хэсэг нь халуун хэвээр байвал бурхны оронд мэндэлснийг илэрхийлж байна гэж хүмүүс ярьдаг. Иймээс бидний сүнс (бидний эзэн) бие махбодоос салах үеэр мэддэг ч бай, мэддэггүй ч бай, энэ гяндангаас мултарч чадах ч бай, чадахгүй ч бай, бид түүнийг билгийн мэлмий, өөрөөр хэлбэл бурхны нүдэндээ байлгах хэрэгтэй, бусдыг нь дараа ярья. Ямар ч номын аргаар бясалгасан бай хамаагүй сэтгэлээ билгийн мэлмийдээ байлгах нь диваажин болон өндөр төвшинд тун ойр болсон байдаг. Зөвхөн эндээс (билгийн нүд) л бид гурван ертөнцийг даван туулах завшаантай болж чадна, билгийн мэлмийн хэсэгт нүдэнд үл харагдах сүв байхаас гадна, нүд, чих, ам, хамар, хошного нь бүгд сүвтэй.

Хэдийгээр билгийн мэлмийд нүд болон хаалга байхгүй гэж ярьдаг ч үнэндээ бас хаалга байдаг, хаалттай байгаа болохоор л харагддаггүй, хэрвээ нэг гэгээнтэнтэй учирвал тэр бидний өмнөөс хаалгыг маань нээж өгч чаддаг. Хаалгыг нь онгойлгох гэдэг нь билгийн мэлмийг ухаж малтах биш, сүнсэн биеийн “нүд”-ийг нээх явдал юм, харин махан биеийн нүд биш. Гэтэл хэний билгийн нүд нь нээгдсэн, хэнийх нь нээгдээгүйг билгийн нүд нь нээгдсэн хүмүүс мэддэг. Бусад номын арга нь бүгд л хамар, нүд, амьсгалаа ажигладаг, эсвэл сэтгэлээ ажиг, мэдрэмж болон биеийн байдлаа ажиг, наран сүлжээгээ ажиг, бэлэг эрхтэнээ ажиг гэх мэт.

За одоо би та нараас асууя. Бид анхаарлаа хаана хандуулна, сэтгэл

чинь тэнд татагддаг, тийм үү? үгүй юү? Тэгвэл мөнх бус газарт анхаарлаа хандуулсны хэрэг юу билээ? Хэвлий (наран сүлжээ), хэл, хамар, ам юуг төлөөлж байна вэ? Бурханыг төлөөлдөггүй, билиг ухааныг ч төлөөлдөггүй, хамрын нүх угаас нээлттэй байдаг. Буян хишиггүй хүмүүс нас барсныхаа дараа сүнс нь хамрын нүхээр нь гардаг. Тиймээс Mind (тархи толгой)-гоо хамрын үзүүр, ам, наран сүлжээ гэх мэтэд хандуулах шаардлагагүй, тэр өөрөө гарч чадна.

Наран сүлжээгээ ажих нь мөн л хуурмаг төвшин, тэнд маш халуунаас гадна бас тамын орны төвшин байдаг, амьсгал, наран сүлжээндээ хандуулах нь доод дэс болно. Бид сул дорой, хүндрэл бэрхшээлтэй болох үедээ бас наран сүлжээнд оччихдоогоо жинхэнэ бясалгагч хүн мэддэг, бясалгал өндөр биш бол мэдэж чадахгүй. Одоо бид хараахан бясалгаагүй, сул дорой, хүндрэл бэрхшээлтэй болоогүй байхад энэ (наран сүлжээ)-нд анхааралаа хандуулж юу хийх вэ? Энд ямар ч хэрэг байхгүй, маш их хүч байж л сая нээж чадна. Ямар ч зүйл дээр бясалгасан бай, бүгд хүчтэй болдог, чихэн дээр бясалгавал хүчтэй болно, сэтгэл дээр бясалгавал хүчтэй болно, наран сүлжээн дээр бясалгасан ч хүчтэй болно, гэвч энэ хүч нь гурван ертөнцийн доторх хувилгаан хүч бөгөөд туулан гэтлэхтэй хамаагүй.

Бид өөрсдийн эзэн бие болон уураг тархиа дасгалжуулж, эрх чөлөөтэй болохын тулд эрхбиш эхлээд эрх чөлөөтэй байдалд дадуулах шаардлагатай, гэхдээ бид сэтгэлээ, анхаарлаа гаднах нэг газар хандуулах хэрэгтэй, гэсэн ч бас дотор юм. Хэдийгээр гадна тал гэж ярьдаг хэдий ч үнэндээ сүнслэг бие дотор байдаг, ийм байж л тэр сая эрх чөлөөтэй байж чадна. Учир нь энэ бие махбод бол гяндантай адил болохоор биеийн аль ч төвд байсан бүгд гяндан дотор байж, хаана ч орсон бай мөн л энэ гэрийн дотор байдаг.

Туулан гэтлэе гэвэл энэ гэр, энэ байшин, энэ гяндангаас гарах хүсэл эрмэлзэлтэй байх хэрэгтэй. Ялтан бүгд гяндангаас гарах хүсэлтэй байдаг, Бид гянданд үлдэхийг яахин хүсэж мөрөөдөж болох билээ? Ингэх нь зүйд нийцэхгүй. Тиймээс жинхэнэ сайн номын арга нь хүмүүс өөрийн биеэ харж хандах болон дасгалжуулж байж эрх чөлөөтэй байдалд дадуулж сургана, өдөр бүр эндээс гарах ёстой, гарах хэрэгтэй, энэ мөнх бус, зуун жилийн бие цогцосыг тоож хамаарах хэрэггүй гэж толгой тархиндаа өдөр бүр хэлбэл зохино.

Өчигдөр багш чинь та нарт хаашаа харахыг заасан, багшийнхаа зааснаас өөр аль ч хэсгээ харж болохгүй гэдгийг та нар бүгд мэдсэн. Гэвч авшиг хүртээгүй хүмүүс гэртээ харьсны дараа багшийн сургаал ёсонд хангалттай итгэлгүй бол ингэж чадахгүй. Учир нь сүнс, эсвэл бидний эзэн гарах үед нөхцөл байдлыг ойлгоогүйгээс болж яахаа мэдэхгүй бол яана, та нарын бие махбод үнэнхүү цэвэр ариун болоогүй, мөн л мах идэж, архи ууж, тамхи татдаг учир маш олон муу сүнсийг биедээ татаж, биднийг буруу газар дагуулж очдог.

Багшийн чинь сургадаг Арьяабалын бясалгалын арга нь аливаа бүхнийг багтаадаг, хамгаалах хүчтэй, замын хөтөч ч бас байдаг, зүйл зүйлийн төвшнийг маш тодорхой хэлсэн байдаг. Тиймээс та нар

төөрөлдөхгүй, хаана хүрснээ бүгд мэднэ, ямар төвшинд хүрсэнээ бүгд ойлгож чадна. Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулж байгаа хоёр хүн ижилхэн төвшинд хүрсэн байвал харсан зүйл нь бүгд ижил, хэрвээ хуурмаг төвшин бол харсан зүйл нь яг ижил байх боломжгүй. Учир нь Арьяабалын бясалгалын аргаар бясалгагчид адил дэсэд хүрвэл адилхан хүслэнт ахуйтай тааралддаг, энэ нь яг л Пин Хү-гээс Тайбэй хүрэхтэй адил, тэр замаар өнгөрдөг л юм бол лавтай адилхан замын тэмдгийг олж харна.

Тиймээс бидний бясалгалын аргыг бясалгагчид тун аюулгүй, замд байх бүх байдлыг та нарт ярьчихсан, хэрвээ шийвэрлэж чадахгүй бэрх асуудал тохиолдвол дотоодын багш чинь хамгаалж, гадна талд бэрх нөхцөл байдал тохиолдвол гадна талын багш чинь тусална, тиймээс ямар ч асуудал үүсэхгүй.

Хэрэв бид жинхэнэ сайн бясалгалын аргыг сонгохгүй мухар сохроор бясалгавал тун олон бэрхшээл тохиолдоно. Учир нь сүнс (эсвэл эзэн) бие махбодоос гарах үе нь нас барахтай адил байдаг. Сайн замчлагч байхгүй бол маш олон асури төрөлтөн, ад чөтгөр биднийг дагуулж “тоглох”-оор ирдэг, тэд Арьяабал бурхан, Авид бурхан, сахиулсан тэнгэр болж хувираад биднийг мэхэлдэг, бас үзэсгэлэнтэй сайхан хүслэнт ахуйг хувиргаж үзүүлнэ, бид тэднийг дагаж очсоны дараа тэд даруй баригдаж, энэ үзэсгэлэнтэй хүслэнт ахуй нь дахин угийн аймшигт байдалдаа буцаж хувирдаг, гэвч тэр үед нэгэнт урхинд орчихсон учир зугтаж амжихгүй болно.

Тиймээс бясалгал хийж, жинхэнээсээ туулан гэтлэхэд заавал туршлагатай замчлагч хайж олох хэрэгтэй, тэрээр зам сайн мэддэг, замын дундах олон зүйлийн нөхцөл байдлыг гарын алга шигээ сайн мэднэ, биднийг яаж хамгаалахаа ч сайн мэдэж, биднийг төөрөлдүүлэхгүй. Замчлагчийн хамгаалалт болон халамж дор байж л бид сая сэтгэл амар бясалгаж чадна. Гэвч ихэнх хүн өөрсдөө сохроор бясалгаж, эсвэл буруу багшийг эрж олоод буруу бясалгалын аргаар бясалгасан учраас бясалгах тусам саад тотгор их болж, хожим нь мэдрэлийн өвчтэй болж хувирдаг, учир нь ад чөтгөрийн саадад гацдаг.

Бясалгал хийхэд хялбар биш, учир нь та нар үнэн болон хуурмаг хүслэнт ахуйг ялгах аргагүй, Арьяабалын бясалгалын аргыг уламжлах үеэр багш чинь нэг зүйлийн түлхүүр өгдөг, тийм учраас үнэн болон хуурмагийг яаж ялгаахаа мэддэг болно. Гэтэл ихэнх бясалгалын аргад үнэн болон хуурмагийг ялгаж таних ийм төрлийн хүч байхгүй, тэд бясалгахыг зааж сургадаг ч хэсэг хугацаанд бясалгасны дараа нэг дэсэд хүрээд л зогсчихдог, эс бөгөөс бас төвөг бэрхшээл учирдаг.

Зарим хүн маани унших дуртай болохоор өчигдөр багш чинь бас та нарт “маани унших”-ыг заасан, тиймээс та нар багшийнхаа заасан аргаар “Бурханыг дурсаж” болно, хэрэв ямар нэгэн асуудалтай болвол багшаасаа тусламж гуйж болно. Гэвч өөр хүмүүст энэ аргыг зааж болохгүй, тэдний нөхцөл байдал та нарынхтай адилгүй болохоор төвөг болно. Та нар энгийн үед энэ аргаар бурхныг дурсаж болно, гэвч ингэснээр хамгийн дээд оронд хүрч чадахгүй, хамгийн дээд оронд очье

гэвэл мөн л дотоодын аялгуугаа ажихад найдах хэрэгтэй.

Учир нь бясалгаад нэг дэсэд хүрэх үеэр бид бодол санаагүй болно, нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлгүй болох үеэр аялгуунд найдаж дээш таагдан гарна. Өөр аргаар бясалгавал нэгэн дэсэд хүрээд зогсчихдог. Жишээлбэл: амьсгалын аргаар бясалгах нь бас самадид орж, тун таатай болдог хэдий ч хэсэг хугацаа өнгөрсний дараа амьсгалгүй болж, чулуу шиг хөдлөхөө болино, амьсгалгүй, бас найдах зүйлгүй болно, тэр үед самадид орох нь буруу биш юм, гэвч бясалгал нь дэвшиж чадахгүй, тэндээ гацаад дахин дээшилж чаддаггүй.

Арьяабалын аргаар бясалгахад багш чинь та нарт гурван зүйлийн аргыг заадаг, тэр дундаа хоёр зүйлийн арга нь хамгийн өндөртөө зөвхөн биднийг гурван ертөнцийн доторх хамгийн дээд оронд хүргэдэг. Гэтэл гурван ертөнцийг даван туулахад “Аялгуу” болон багшийг түшиглэх хэрэгтэй. Гурван ертөнцийн гадна аялгуугүй, гэрэлгүй нэгэн орон байдаг гэж багш нь та нарт хэлсэн. Тэр үед заавал багшийн заавар байх хэрэгтэй, тэгэхгүй бол үргэлжлэн дээш гарч чадахгүй. Тиймээс бас багш болон хамгаалах хүч байх хэрэгтэй.

Гурван зүйлийн бясалгалын аргыг багш чинь ярьсан, гэсэн ч багш чинь багтчихлаар дөрвөн төрлийн бясалгалын арга болдог, багш байхгүй бол арга байхгүй, учир нь аялгуу, гэрэл аль нь ч байхгүй болохоор тийм хялбархан дээш гарч чадахгүй, бясалгаад тэнд хүрэх үед гацчихаад замаа олохгүй, хаана байгаагаа ч мэдэхгүй, бас найдвартай тод аялгуу ч байхгүй. Тэр орон хав харанхуй, түүнийг л даван туулж чадвал сая аюулгүй болдог.

Ариун орон болон бохир орон нь энэ харанхуй ертөнцөөр зааглагдаж байдаг, бохир орны хүмүүс ариун оронд хүрч чаддаггүй бөгөөд ариун орны хүч бохир оронд ирж чаддаггүй, Учир нь бохир оронд ирэх үедээ аль хэдийн бохирдчихсон байдаг. Хэрвээ бурхан бодьсадвагийн хүч бохир орныг адислаж, хамаг төрөлтөнд туслая гэвэл заавал махан биеэр дамжуулах хэрэгтэй. Тиймээс бурхан бодьсадва заавал хүн болон хувилж байж л сая хамаг төрөлтнийг гэтэлгэж чаддаг. Түүний гадна дүр төрх нь эгэл хүмүүстэй адил боловч дотоодод нь Эзэн Бурханы хүч байдаг. Жишээ нь, уулан дээрх ус маш цэвэрхэн хэдий ч цэвэрхэн усны хоолойгоор дамжуулахгүйгээр байшин луу шууд урсгавал ус бохирдож, уух аргагүй болно, яагаад гэвэл хотын зам маш бохир учраас усны чанар ихэд бохирдоно. Бурхан бодьсадвагийн хүч мөн адил, ариун оронд байхдаа маш цэвэр ариун, харин бохир оронд ирвэл ашиглахын аргагүй болдог.

Тиймээс жинхэнэ цэвэр ариун хүчийг хэрэглэхийн тулд заавал Төгс Гэгээрсэн Багшийн махан биеэр дамжуулах ёстой, тэр ийм төрлийн хүчийг авчраад энэ ертөнцөд хуваан өгч, бурхан бодьсадвагийн хүчийг бохирдуулахгүй байж чадна, яг усны хоолойтой адилаар дотоодын цэвэр ариун хүчийг хамгаалдаг. Ийм учраас бид амьд Бурхан, энэ ертөнцийн жинхэнэ Багшийг сайшаан магтдаг. Бурхан бодьсадва ариун орноос гэрэл цацруулан шууд л энэ ертөнцөд ирвэл болчих байтал яагаад бас Шагжамуни Бурхан болон урьд цагийн маш олон Их Багш хамаг

төрөлтнийг гэтэлгэхээр энэ дэлхийд ирдэг вэ?

Та нар авшиг хүртэх үеэр жинхэнэ цэвэр ариун Эзэн Бурханы хүч, өөрөөр хэлбэл бурхны аялгууг олж сонсдог, хэрвээ жинхэнэ багш дамжуулахгүй бол энэ бурхны аялгуу энэ ертөнцөд ирсэн ч үргэлж ертөнцийн дуу чимээ болон хувирдаг. Бидний сонсдог жижигхэн шувуудын жиргээ, усны чимээ, далайн түрлэгийн чимээ гэх зэрэг нь бүгд л цэвэр ариун бурхны аялгуу биш, ертөнцийн энэ дуу чимээг сонсоод туулан гэтэлж чадахгүй бөгөөд самадид орсон шиг баяр баясгалантай байж чадахгүй, дээд төвшинд хүрч гүн билиг ухааныг ухаарч, бурхны орны төвшнийг ойлгож чадахгүй, бурхнаас суралцаж чадахгүй.

Арьяабалын аргыг бясалгах үеэр сонсдог аялгуу бол дотоодын сүнсэн биеийн цэвэр ариун дуу аялгуу болно, “Хотол зохилдогч зүйл” болон “Тайхамшигт лянхуа цэцгийн номын шастир” (法华经)-г ярьсан сүмийн хонхны дуу, хэнгэргийн дуу, аянгын дуун, далайн түрлэгийн дуун, Эсэрвагийн эгшиг, чанагуух ертөнцийн ялгуусан дуун зэрэг нь бүгд л Шагжамуни Бурханы шавь нарын авшиг хүртэх үеийн ахуй ойлголт болно. Тухайн үед тэд дөнгөж авшиг хүртэж, ахуй ойлголтоор тийм өндөр биш байсан ч өөр өөрийн ахуй ойлголтоо бичиж тэмдэглэжээ. Бид одоо “Хотол зохилдогч зүйл”-ийг уншдаг нь бусдын ахуй ойлголтыг уншиж байгаа хэрэг, “Хотол зохилдогч зүйл” нь Бурхан Багш цаглашгүй сэтгэлт Бодьсадвад ярьсан айлдвар мөн, тиймээс энэ бол цаглашгүй сэтгэлт Бодьсадвагийн авшиг хүртэх үеийн ахуй ойлголт болно. Авшиг хүртэх үед ямар ахуй ойлголттой байна, түүнийгээ л бичиж тэмдэглэдэг.

Яг л та нар өглөө авшиг хүртэх үеэр ахуй ойлголттой болсонтой адил юм, нөхцөл байдал бараг адил, “Чин Хай багш аялгуу ажих тухай ярих үед тийм тийм аялгуу сонсов” гэж өөрсдийнхөө ахуй ойлголтоо бичиж тэмдэглэж болно, тэгснээр энэ нь “Хотол зохилдогч зүйл” дэх ахуй ойлголттой бараг адил болно, гэвч өнөөдрийн та нарын ахуй ойлголт мөн л дээд дэс биш. Зарим хүн гэртээ харьсны дараа сонууч сэтгэлээр ахуй ойлголтоо бичиж тэмдэглэж магадгүй, багш чинь бас өөрсдөөр чинь ахуй ойлголтыг чинь тэмдэглүүлнэ, гэвч ахуй ойлголт бусдад ярьж болохгүй, бичиж дуусахаараа багшдаа хураалга, өөрсдийн дэсээ магтаж болохгүй, яривал та нар саад тотгортой болно.

Хойч үеийн хүмүүс та нарын бичсэн ахуй ойлголтыг харвал багшийг чинь та нарт гаднах дуу чимээг заажээ гэж бодно, үнэндээ энэ нь та нарын дотоодын сүнсэн биеийн ахуй ойлголт мөн, ойлгохгүй хүмүүс харин Эсэрваа тэнгэр, далайн түрлэгийн дууг хамгийн дээд төвшнийх гэж үздэг, үнэн хэрэг дээрээ энэ нь дөнгөж эхэлж байгаа төдий юм. Бүр ч өндөр төвшинд нэн өндөр дэсийн аялгуу байдгийг та нар бүгд мэднэ, өнөөдөр өглөө авшиг өгөх үеэрээ багш чинь та нарт аль хэдийн хэлсэн билээ. Уг нь судар номд найдах нь буруу биш боловч судар номд тэмдэглэсэн зүйлс бол Шагжамуни Бурханы шавь нарын авшиг хүртэх үеийн ахуй ойлголт, дөнгөж эхлэх үед тэдний дэс нь тийм өндөр биш байсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Өнөөдөр өглөө та нар авшиг хүртэх үеэр зарим хүн цаглашгүй сэтгэлт Бодьсадватай адилхан ахуй ойлголттой болсон биш гэж үү? Хожим нь тэр бясалгалаар өндөр болж,



дэс нь адил биш болжээ. Авшиг уламжлах үеэр зарим хүн тухайн үеийн цаглашгүй сэтгэлт бодьсадвагаас ч өндөр ахуй ойлголттой байсан гэж би та нарт хэлсэн. Та нарт багшийнхаа сургаал номд эргэлзэх, эсвэл бурхны номыг ахиухан судлах сонирхол байвал бурхны судар ном нь та нарт тусалж, багшийн чинь ярьсан сургаалыг бас бага сага нотолно. Ингэснээр л та нар сая багшийнхаа заасан номыг жинхэнэ мөн эсэхийг нь мэдэх болно.

Багш яагаад ном гүрэм унших нь хэрэггүй, ном судар хэрэггүй гэж хэлснийг одоо та нар ойлговол зохино, учир нь бусдын ахуй ойлголт нь бидэнд хамаагүй. Жишээ нь: өнөөдөр та нар багшийнхаа ярьж заасан бүхнийг, авшиг хүртэх үеийн ахуй ойлголтоо бичиж тэмдэглээд нэг газарт тавьсныг найз чинь хараад гэртээ аваачиж, өдөр бүр чиний ахуй ойлголтыг уншлаа гэхэд түүнд ямар ач тустай байх вэ? Ийм нөхцөл байдал нь ихэнх хүн “Хотол зохилдогч зүйл”-ийг уншдагтай адилхан, ямар ач тус байх вэ? Их уншвал эрч хүчээ л барах хэрэг. Ном судар нь тийм ч их хэрэгцээгүй, үнэн шүү. Багш чинь та нарт үнэн үг хэлэх хэрэгтэй, Та нар намайг алахаас би айхгүй. (бүгд инээлдэв)

Саяхан амьд байгаа багшийг ярилаа, одоо амьд байгаа Гэгээнтэн нь урьд цагийн бурхнаас ч илүү байдаг. Тиймээс махан биетэй багш байж байж л сая энэ цэвэр ариун хүчийг хүмүүст уламжилж чадна. Гэвч тэр зөвхөн “хүмүүс”-т л өгч чаддаг, сэтгэлээс сэтгэлд уламжлахад үг хэл хэрэглэдэггүй, учир нь зөвхөн хүн л энэ хүчийг хүлээн авч чадна, өөр төрөлтөнд энэ “сэтгэл” байхгүй, амьтны үзэл ухамсар тийм хүчтэй биш болохоор багш чинь авшиг хүртээвэл тэд ойлгохгүй, ойлгосон ч энэ хүчийг хадгалах аргагүй юм. Хүний биед маш олон багаж байдаг, энэ бие махбод байж байж л сая тэр хүчийг хүлээн авахын зэрэгцээ хураан хадгалж чадна.

Тиймээс бурхан бодьсадва нар энэ ертөнцөд ирэхдээ эрхбиш махан биетэй байж л сая цэвэр ариун хүчийг өөр хүмүүст дамжуулж чадна. Яг л усны хоолой шиг, усны хоолой нь тийм ч сайн биш боловч усны чанарыг хамгаалж, ус дамжуулахын тулд хэрэглэдэг, хэрвээ усыг өөр зүйлээр дамжуулбал үр дагавар нь тийм сайн биш. Учир нь усны чанар, цэвэр байдлыг хангаж, гадаад орчны бохирдлоос сэргийлэхийн тулд усны тусгай хоолойг ашигладаг.

Хүний бие ч адил, тусгайлан тийм хүчийг ашиглаж, тэр хүчийг хамгаалахаас гадна бас энэ хүчийг бусдад хувааж өгч чаддаг. Нэг усны хоолойг хэд хэдэн усны хоолой болгон салаалж болно, гэсэн ч усны чанар нь адил учир маш олон газарт дамжуулж болно.

Орчлон ертөнц нэгэн асар том цахилгаан станц бөгөөд аливаа бүхэн энэ цахилгаан станцаар бүтээгджээ. Амь амьдрал, амьтад, орчлон, нар, сар, од зэрэг нь бүгд л түүнээс үүсэлтэй. Тэр бол төрөхгүй, мөхөхгүй, бохирдохгүй, ариусахгүй, нэмэгдэхгүй, хасагдахгүй, хичнээн хэрэглэсэн ч дуусахгүй ямар ч асуудалгүй. Гэвч энэ том хүчтэй холбогдоогүй бол бид тун өнчрөн ганцаардсан амьдрал болж хувиран ихэд зовж шаналж, саад ихтэй, төвөг ихтэй болж, гүн билиг ухаангүй, зөвхөн өчүүхэн хүч, өчүүхэн билиг ухаанаа ашиглаж, тийм нөхцөл байдлыг чадан ядан

даван туулдаг. Гэтэл тэр том хүчтэй холбогдчихвол бид юу ч хийх шаардлаггүйгээр аливаа саад бэрхшээлийг аяндаа даван туулж чадна.

Тиймээс энэ агуу их хүчтэй холбогдох хэрэгтэй, ингэснээр өөрийгөө аврах төдийгүй, мөн тоолшгүй олон төрөлтөнд тусалж чадна, учир нь тэр үед асар их хүчтэй болдог. Та нар дөнгөж сая авшиг хүртсэн ч гэсэн хамаг төрөлтөнд тусалж чаддаг, зөвхөн тийм их хүчтэй биш ч гэсэн. Бясалгах тусам улам их хүч нэмэгдэж, төвшин нь дээшилж, улам их хүчирхэгждэг. Тиймээс ихэд гэгээрсэн хүн энэ ертөнцийг адислаж чаддаг бөгөөд олон төрөлтөнд тусалж чаддаг, хамаг төрөлтнийг адисласнаа мэдэхгүй ч гэсэн хамаагүй. Шагжамуни Бурхан: “Хамаг төрөлтнийг гэтэлгэх гэсэн хэдий ч гэтэлгэгдсэн төрөлтөн байхгүй” гэж ярьсан байдаг. Үүний утга нь: хамаг төрөлтнийг гэтэлгэх нь гэтэлгээгүйтэй адилхан, хамаг төрөлтөнд туслахдаа өөрсдөө мэдээгүй ч байж магад, учир нь тэр үед бид энэ “би” оршин байгааг мэдэрдэггүй.

Авшиг хүртсэн хүмүүс одоо нэгэнт цахилгаантай болжээ, бага ч гэсэн өөрсдийн садан төрлөө адислаж чадна, тиймээс авшигтнуудын таван үеийн өвгө дээдэс бүгд төрөл дэвшдэг, хамгийн багадаа таван үеэрээ төрөл дэвшдэг бөгөөд хожим нь бас энэ ертөнцөд их тусалдаг. Учир нь цахилгаан станцтай холбогдсон болохоор тун их хүчтэй болсон байна. Жишээ нь, энэ гэрт тийм олон гэрэл байгаагүй, гэтэл цахилгаан станцад нэг цахилгааны утас залгасны дараа дахин хэд хэдэн цахилгааны утас салаалан залгавал хөргөгч, цахилгаан сэнс, микрофон, цахилгаан цаг, суурин утас, зурагт, цахилгаан гэрэл, будаа агшаагч гэх зэргийг бүгдийг нь ашиглаж болно, энэ нь цахилгааны утас цахилгаан станцтай холбогдсноос болж байгаа юм.

Нэг хүн авшиг хүртэснээр түүний таван үеийн өвгө дээдэс нь бүгд төрөл дэвшдэг бөгөөд маш олон хамаатан садан, найз нөхдөдөө тусалж чаддаг, хэнийг ч байсан бага зэрэг өрөвдсөн л бол тэр хүн буян хишигтэй болчихдог, гэвч тэр хүн өөрөө мэддэггүй, ийм буян нь тийм ил тод харагддаггүй. Жишээ нь: тэр нэг хүн хүнд байдалд орсноо Арьяабалын аргаар бясалгагч хүнд хэлээд удаагүй байтал нөхцөл байдал нь аажмаар сайжирдаг, шалтгааныг тэр өөрөө ч мэддэггүй. Энэ нь Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүний биед их багшийн хүч шингэсэн байдаг, тэдэнд буян хишгээсээ бага зэрэг өгдгөөс болж байгаа юм. Бясалгах тусам улам их хүчтэй болж, хэзээ нэгэн өдөр бид бурханы хутагт хүрч, их багш болтлоо хөгжинө, ингэснээр та нар хүчээ өөр хүмүүст уламжлан өгөх бөгөөд тэр үед төгс төгөлдөр хүчтэй болсон тул хичнээн хүмүүст дамжуулан өгсөн ч адислах хүч багасдаггүй.

Энэ нь яг л хэрэглээд барахгүй их мөнгөтэй байхтай адил, өөр хүмүүст хувааж өгсөн ч болно. Гэвч одоо л дөнгөж ажиллаж эхэлж байгаа болохоор тийм их мөнгөтэй болоогүй, зөвхөн өөрөө хэрэглэх болон гэр бүлдээ туслах мөнгөтэй л болсон хэрэг, хожим нь ажиллах тусам мөнгө хуримтуулсаар их мөнгөтэй баян хүн болж, өнчин хүүхэд, бэлэвсэн бүсгүй, өвчтөн, ядуучууд гэх мэт хүмүүст өглөг үйлдэж болно.

Бясалгагч хүний нөхцөл байдал ийм юм, бусдад өглөг буяныг үйлдэж болно. Одоо та нар бүгд ойлгосон уу? (Бүгд ойлгосон гэж

хариулав) Баярлалаа. Та нар бүгд гэгээрчээ. (Бүгдээрээ инээлдэв) Би хятад хэлээр илэрхийлэх чадвартаа ихэд гайхаж байна, ингэж шууд илэрхийлж, та нарт тийм түргэн ойлгуулж чадсан минь үнэхээр итгэмээргүй санагдаж байна, бид хувь барилдлагатай байдгаас болсон байх. Учир нь ном тайлах үеэр би чухам яаж хэлбэл та нарт ойлгуулж чадах билээ гэж бодож байсан, хялбар биш шүү. Багш нь ярих үед энэ бүхэн аяндаа ундарч гарсан болохоор ярьж дууссаны дараа ийм шулуухан ярьж чадсандаа тун их гайхаж байна. Арван зүгийн бурхад адисласны ачаар ийм хялбархан илэрхийлж, тийм хурдан ойлгуулж ярьж чадсан тул та нарын билиг ухааныг бас адислаж чадсан байна.

Би диваажин болон арван зүгийн бурхан бодьсадва нарт маш их талархаж байна.

## **БЯСАЛГАЛ ХИЙХЭД ХАМГИЙН ТОМ ХАРШ СААД БОЛОН АРИУН ТУНГАЛАГ ХАМАГ БОДСАДВА**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй*

*(Эх нь хятад хэлээр)*

*1986 оны 12 дугаар сарын 17*

Хөгжмийн зэмсэг нь хүмүүст дотоодын сонсголонтой сайхан аялгуугаа бүү март гэдгийг сануулж байдаг, яагаад гэвэл дотоодын аялгууг бас сонсож болдог. “Олонх бурхант судар”-т бодьсадвагийн дэсэд хүрвэл тийм аялгууг сонсож чадна, гэхдээ чихний сонорыг гэмтээдэггүй, диваажин, тамын орон болон маш олон дэсийн диваажин, маш олон дээд зэргийн төвшнийг харж чаддаг хэдий ч бас нүдийг гэмтээхгүй, учир нь тэдгээрийн хэлбэлзэл нь эгэл хүмүүсийн хэлбэлзэлттэй адилгүй гэж өгүүлсэн байдаг.

Зарим хүн авшиг хүртээгүй ч, бясалгал хийдэг л бол сэтгэл нь тайван болох үедээ хааяа бас дотоодын сонсголонтой сайхан аялгууг сонсож чаддаг, гэвч ийм ахуй ойлголттой хүмүүс их цөөхөн, тийм хүмүүс нь өмнөх олон төрөлдөө бясалгал хийж байсан учраас ийм төрлийн чадвар урьд үеэс нь нөлөөлжээ, гэвч ихээхэн бясалгаж байж л сая тийм аялгууг сонсож чадна. Гэхдээ тийм хүмүүс өөрсдийн сонсдог аялгуугаа захирч чадахгүй, сонсьё гэсэн цагтаа сонсож чаддаг юм биш.

Гэтэл авшиг хүртсэн хүмүүс үүнтэй адилгүй, хэзээ л бол хэзээ сонсож болно, учир нь тэр нь нэгэнт бидний эд хөрөнгө болчихсон болохоор хэзээ ч гэсэн ашиглаж болно. Санамсаргүй гэнэт аялгуу сонсогдоод дараа нь гэнэт тасарсан ч мөн л өөрийн эд хөрөнгө хэвээр байдаг, учир нь бид сонсохыг хүссэн үедээ ч биш, ямар ч үед дотоодын аялгуугаа сонсож болно.

Авшигтан хүн ямар ч үед аялгууг сонсож чадна, бодьсадвагийн дэсэд хүрвэл тийм аялгууг сонсож чаддаг гэж “Олонх бурхант судар”-т өгүүлсэн байдаг. Зарим хүн авшиг хүртээгүй болохоор урьд нь бурхан бодьсадва болон их бясалгагч нар энэ ертөнцийн хөгжмийн зэмсэгийг ашиглан дотоодын аялгууг дуурайлгаж, хүмүүст сонсгодог байжээ, ингэснээр бидний дотоод чихний сонорыг сэргэг байлгаж, олон жилээр сонсоны дараа дотоодын аялгуугаа сонсож чадах боломжтой болох бөгөөд нилээд билиг ухаантай болж, бясалгал хийж, “жинхэнэ багш”-ийг хайх хүсэлтэй болдог.

Тиймээс энэ ертөнцийн хөгжмийн зэмсэг нь бас ач тустай, зарим хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн дуу чимээ нь дотоодын аялгуутай

төстэй байвал бас бага зэрэг ач тустай, дэсээр тийм өндөр биш хүмүүст үнэхээр ач тустай.

Бидний сонссон даяаны тухай нэг үлгэрт: Нэг өдөр нэгэн номын багш бясалгаж суух үедээ хөршийн гэрээс гарах хонхны дууг гэнэт сонсож, тэр агшинд билиг нь нээгджээ, гэвч билиг их нээгдсэн, эсвэл бага сагахан нээгдсэнийг мэдээгүй хэдий ч ядаж л бага зэрэг ч гэсэн билиг нээгджээ. Тиймээс энэ ертөнцийн хөгжмийн зэмсэг нь хүмүүсийн дотоод мэдрэмжийг сануулдаг бөгөөд дуудан сэрээж, бидний дэсийг бага зэрэг дээшлүүлж, билиг ухааныг нэмэгдүүлдэг, ингэснээр хожим их багшийн сургаал номыг хүлээн авч ойлгож чадна.

Хэрвээ өөртөө найдан бясалгавал дотоодын аялгууг сонсох нь тун бэрх, учир нь нэгдүгээрт, эрхбиш маш их бясалгаж байж сая дотоодын аялгуугаа сонсож чадна. Хоёрдугаарт, сонсож чадсан ч ямар аялгуу нь дээд дэсийн аялгуу, ач тустай, ямар аялгууг сонсох нь чухал, ямар аялгууг сонсож болдоггүй гэдгийг мэддэггүй, тиймээс замаасаа төөрч буудилдаг.

Аялгуу нь олон төрөл, бурхны аялгуу байхаас гадна бас адын аялгуу ч байдаг, жинхэнэ аялгуу байхаас гадна хуурамч аялгуу ч бий, тиймээс өөрсдөө бясалгавал нилээд хэцүү, заавал нэгэн “жинхэнэ багш”-ийг хайвал зохино, тэр бидэнд ном уламжилж чадах хүчтэй, ном уламжилсных нь дараа бид дотоодын дуу аялгуугаа сонсож чаддаг юм, ингэвэл нилээд аюулгүй, учир нь тэр биднийг харж харгалзана, ямар аялгуу нь нилээд сайн, ямар аялгуу нь нилээд өндөр дэсийн, ямар аялгуу нь нилээд доод дэсийнх, ямар аялгууг сонсож болохгүй, ямар аялгуу нь аюултай гэдгийг хэлж өгдөг, харин сонссон аялгуу бүхэн бүгд сайн гэсэн үг биш.

Шагжамуни Бурхан “Олонх бурхант судар” болон “Баатар явагч их хөлгөн судар” бол хамгийн дээд судар гэж ярьсан байна, үүнийг багш чинь бас эвшөөрнө, учир нь энэ хоёр сударт тэр чигтээ бясалгалын тухай өгүүлдэг, “Олонх бурхант судар”-т бас бясалгалын ахуй ойлголтын тухай бага зэрэг ярьсан байна. Бидний ахуй ойлголт нь ном сударт өгүүлэнтэй адил эсэхийг “Олонх бурхант судар”-аар лавлагаа болговол мэдэж болно. Эс бөгөөс ном, багш болгон бүгд л өөрсдийнхөө номыг хамгийн дээд гэж хэлдэг, бид ямар аргаар тэдний ном нь сайн, эсвэл бидний ном нь хамгийн дээд болохыг баталж чадах вэ? Тиймээс “Олонх бурхант судар” бол үнэхээр хамгийн дээд судар мөн, та нар заваараа уншаарай. “Олонх бурхант судар”-ыг дураараа бусдад өгч болохгүй гэж Шагжамуни Бурхан бас хэлсэн байдаг. Учир нь ном судрын гүн нууцлаг утгыг ойлгохгүй бол гүтгэнэ, “Олонх бурхант судар”-ыг гүтгэвэл маш их үйл түйтгэртэй болно.

“Олонх бурхант судар”-ыг та нар уншиж байсан уу? (Уншаагүй гэж нэг хүн хариулав) Тэгвэл гэртээ хариад уншаарай. Учир нь ном сударт тиймэрхүү дотоодын ахуй ойлголт, бурхан бодьсадвагийн ахуй ойлголтыг энгийн хүмүүс мэдэж чаддаггүй, тийм аялгууг сонсож чаддаггүй, тийм аялгууг сонсож чадахгүй бол хичнээн жил бясалгасан ч хэрэггүй, ахуй ойлголттой байж чадахгүй гэж өгүүлсэн байдаг.

Тиймээс Шагжамуни Бурхан “Олонх бурхант судар”-ыг айлдах үеэр таван мянга гаруй гэлэн, гэлэнмаа, увш, увшинз болон гэртээ суугаа бодьсадва номын хурлын талбайгаас салж оджээ. Учир нь Шагжамуни Бурханд итгээгүй аж, тийм дээд номын арга байдагт итгээгүй, ийм дээдийн ном үнэхээр байсан юм бол урд нь яагаад огт сонсож байгаагүй билээ гэсэн сэжиг төрсөн байна.

Шагжамуни Бурхан “Олонх бурхант судар”-ыг айлдах үеэр салж одсон тэр гэлэн, гэлэнмаа нар бурхан багшийн шавь биш байж мэднэ, яагаад гэвэл тухайн үед бас тун олон гэрээс гарагчид байсан бөгөөд нөхцөл байдал нь одоогийнх шиг гэрээс гарагч болгон л багшийн чинь шавь, эсвэл багштай чинь адил бясалгалын аргыг бясалгадаггүй байсан ч байж мэднэ. Энэтхэгт одоо ч гэсэн гэрээс гарагч их байгаа хэдий ч бүгд л Арьяабалын бясалгалын аргыг бясалгадаг биш, “Олонх бурхант судар”-г ярьсантай адил дотоодын сонсголонтой сайхан аялгуугаа сонсож чаддаггүй, тиймээс тэд мөн л бодьсадвагийн дэсэд хүрээгүй байдаг. Жишээ нь: багш чинь заримдаа та нарт тарааж өгдөг номын онцгой тайлбарт ахуй ойлголтын талаар бага зэрэг ярьсан байдаг, багш чинь угаас ахуй ойлголтоо ярьдаггүй, гэвч авшиг хүртсэн шавь нарт илгээх болохоороо заримдаа бас бясалгалын ахуй ойлголтыг бага зэрэг ярьдаг, ингэж ярьсныг та нар гаднах хүмүүст харуулбал багшийн чинь юу ярьж байгааг огт мэдэхгүй, харин буруугаар ойлгож мэднэ.

Тиймээс бидний хувилан тараасан номын онцгой тайлбарыг угаас шинээр авшиг хүртсэн хүмүүст өгдөггүй, заримдаа та нар хамаатан садан болон найз нартаа өгч мэднэ, гэвч та нар өөрсдөө өгснөөс биш бид тэдэнд өгсөн биш, уг нь та нарт л өгсөн хэрэг, учир нь та нарыг бясалгуулж, ахуй ойлголт гэдэг нь ямаршуу болохыг мэдүүлэхийн төлөө билээ. Энэ нь энгийн хүмүүсийн зар сурталчилгаа шиг хэдий чинээ олон хүн мэдвэл төдий чинээ сайн, дахин дахин хэдэн мянга, хэдэн арван мянгаар нь хэвлүүлж, олон орны өч төчнөөн хүмүүст тараах нь сайн гэдэгтэй адилгүй зүйл.

Тиймээс Шагжамуни Бурхан: “Олонх бурхант судар”-ыг бусдад дураараа өгч болохгүй” гэж хэлсэн нь ийм утгатай билээ. Учир нь Бурхан багш “Олонх бурхант судар”-ыг шавь нартаа, нэгэнт ахуй ойлголттой болчихсон хүмүүст л хандаж ярьжээ, ойлгож байна уу? Тэр дээд дэсийн бодьсадва нарт, Арьяабалын бясалгалын аргыг бясалгадаг шавь нартаа ярьсан, харин гаднах хүмүүст яриагүй, учир нь гаднах хүмүүс Шагжамуни Бурханы юу ярьж буйг ойлгохгүй. Ямар аялгууг сонсож, ямар диваажинг харсан, яагаад харж чаддаг, яагаад сонсож чаддаг, яагаад энгийн хүн бодьсадва болж хувирах гэх зэргийг огт ойлгодоггүй болохоор гүтгэж гүжирдэнэ, “Олонх бурхант судар”-ыг гүтгэвэл тун хүнд үйл түйтгэртэй болно.

Багш чинь та нарт хэвлүүлж өгсөн онцгой тайлбар нь мөн л адил гаднах хүмүүст харуулах гэсэн зүйл биш. Та нар авшиг хүртсэний дараа багшдаа итгэдэг бол төгс баясгалант оронд очиж, үүрд туулан гэтэлж чадахыг гарцаагүй батална гэж багш чинь ярьсан. Багшийнхаа махан биед итгэх биш, харин бясалгалын аргад итгэнэ, багшийнхаа сургаал

ёсонд итгэнэ, багш чинь та нарт ёс дүрмийг хэрхэн сахиx, сахилаа хэрхэн сахиxыг сургана, таван сахилаа тодорхой чанд сахиx хэрэгтэй, амь хороохгүй, хулгай хийхгүй, архи уухгүй, худал ярихгүй, садар самуун явахгүй, өдөр бүр эрхбиш хэдэн цагаар бясалгах тухай сургасан байдаг, багшийнхаа заасан бүхнийг та нар эрхбиш тодорхой ойлгож, үнэнч байх хэрэгтэй. Ингэх нь сайн, багшдаа итгэж байгаа хэрэг, харин энэ хүнд итгэх биш. (Багш өөрийн биеэ заав) Гэтэл та нар энэ замаар замнах дургүй, гадуур гарч гүтгэн дайрах гэхчилэн авирлавал тун хүнд үйл түйтгэр бүтээнэ, үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэхийг та нар өөрсдөө зориудаар сонгож, өөрсдөө доош унах гэсэн болохоор багш чинь бас хөндлөнгөөс оролцохын аргагүй, учир нь үүнийг та нар өөрсдөө сонгосон байдаг. Бурхан бодьсадва ч бусдын ухамсарт хөндлөнгөөс оролцож болохгүй, хамаг төрөлтөн юу хийх хүсэлтэй бол түүнийг нь хийлгэнэ, гэхдээ аль зам нь сайн, аль зам нь муу гэдгийг тэдэнд ярьдаг хэдий ч аль замаар явахыг нь эрхбиш өөрсдөөр нь сонгуулах хэрэгтэй байдаг.

Шагжамуни Бурханы тухайн үеийн нөхцөл байдал ч гэсэн мөн адил, харин бурхан бодьсадва хамаг төрөлтнийг шийтгэж байгаа хэрэг биш. Хамаг төрөлтөн “Олонх бурхант судар”-ыг гүтгэсэн болохоор бурхан уурлахдаа түүнийг шийтгэж, эсвэл хордуулдаг юм биш, бурхан бодьсадва хамаг төрөлтнийг айлган сүрдүүлэхгүй. Гэвч энэ гурван ертөнц дотор мөн л адын эзний хууль дүрэм үйлчилдэг болохоор та дээш гарч бурхан бодьсадвагаас суралцах гэвэл тэр бас зөвшөөрдөг, учир нь бурхан бодьсадва чамайг нэгэнт шавиа болгочихсон бол адын эзэн яах ч аргагүй бөгөөд хөндлөнгөөс оролцож чаддаггүй. Гэтэл та бурхан бодьсадвагаас өөрөө дуртайяа салж одоход хүрвэл адын эзэн тэр даруй таныг дахин захирах болж, бүр ч их саад төвөг учруулж, биднийг зовоох болно.

Тиймээс хэзээ ч гэсэн бид багшийнхаа сургаал ёсыг зөрчиж, багшийнхаа заасан сахил дүрмийг мөрдөхгүй бол та нар даруй өөрсдөдөө төвөг удна, сахилаа сахидаггүй хүмүүс багшийнхаа ярьсан бүхэн үнэн эсэхийг ойлгох болно. Авшиг хүртсэний дараа сахилаа сахиxгүй, бясалгахгүй, мах идэж эхэлсэн хүмүүсийн царай ямар шуухан байдаг бол? Багшийнхаа үгийг сонсдоггүй хүмүүсийн амьдрал ямаршуухан байдаг бол? гэдгийг та нар харж болно, тэдний царай авшиг хүртэх үеийнхтэй нь адилгүй харагдаж, гэрэл гээгээгээ алдаж, үг ярих нь ч урьдийнхтайгаа адилгүй болж, цэвэр ариун биш, гэрэлгүй бүүдгэр харагддаг.

Тиймээс яршиг төвгийг та өөрөө эрж олдог, бурхан бодьсадва ийм хүмүүсийг яах ч аргагүй. Бид өөрсдөө бурхан бодьсадвагаас намайг дээшээ түргэн шиг дагуулж гараарай гэж байнга гуйдаг боловч харин чармайх дургүй, гэтэл бодьсадва ирчихсэн байхад бид тоох ч үгүй, ийм юм чинь ямар арга байх вэ? Багшийнхаа ном тайлсан агуулгыг бусдад дураар өгч болохгүй, зөвхөн нөгөө этгээд чинь дэсээр тун өндөр хүн гэж мэдвэл л өгч болно, тэгэхгүй бол тун төвөгтэй болно, яагаад гэдгийг багш нь та нарт ярьа. Жишээ нь: бид өвдсөний дараа хамгийн сайн эмнэлэг

хараахан таараагүй, хамгийн сайн эмчийг хайж олоогүй үедээ хүсэл санаа өвөрлөн олон газраар хайдаг тийм уу? Үгүй юү? Гэвч хамгийн сайн эмчтэй тааралдсан ч түүнийг танихгүй. итгэхгүй болохоор түүгээр эмчлүүдлэхгүй, ингэвэл энгийн эмч ерөөс эмчлэхийн аргагүй. Хэрвээ хүнд өвчин биш бол хамгийн сайн эмчийг хайж олохоос өмнө бас олон газраар очиж, сайн эмчийг хайж болно, гэтэл өвчин тун хүндэрчихсэн бол эрхбиш хамгийн сайн эмчийг түргэн хайж олох хэрэгтэй, тэгвэл сая өвчнөөс аварч чадна. Гэвч хамгийн сайн эмч дэргэд чинь ирчихсэн байхад харин тоох ч үгүй, итгэдэг ч үгүй юм бол үхлээ хүлээх л хэрэг болно.

Үүнтэй адилаар бурхан бодьсадвагийн хувилгаан бие, хамгийн дээд номыг хайж олохоосоо өмнө өөр бусад бясалгалын аргыг аажмаар хайж, хэзээ нэгэн өдөр бурхан бодьсадва лавтай биднийг аврахаар ирнэ гэж итгэж болно. Гэтэл нэгэнт хайгаад олчихсон байтал өөрсдөө харин татгалзахад хүрвэл хэн биднийг сургаж чадах вэ? Хэн биднийг аварч чадах вэ? Ойлгож байна уу? Тиймээс авшиг хүртсэний дараа эрхбиш өөрсдөө бясалгаж, өөрсдөө ойлгох хэрэгтэй, багш чинь тийм ихийг ярих аргагүй, миний хувьд нэгэнт дэндүү их ярьчихлаа, заримдаа ярьж болохгүй нууц зүйлийг ч ярьчихдаг, ийм байтал мөн л итгэхгүй байвал ямар ч аргагүй.

Учир нь одоо бол цөвүүн цаг үе, маш олон бурхан бодьсадва хувилгаан биеэрээ энэ ертөнцөд бууж ирдэг боловч хамаг төрөлтнийг мөн л гэтэлгэж дуусдаггүй. Шагжамуни Бурхан амьд үедээ ч гэсэн тийм олон хүнийг гэтэлгэж чадаагүй. “Олонх бурхант судар”-ын “Газар доороос илрэн гарахуй” бүлэгт Шагжамуни Бурхан: “Танга мөрний элс мэт олон бурхан бодьсадва цаг үе болгонд газар доороос илрэн гарч, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг” гэж ярьсан байдаг. Тэгвэл тэд бүгд хаачив? Тийм олон бодьсадва нарын ядаж яагаад ганцханыг ч харж чаддаггүй билээ?

Бодьсадва байдаг бөгөөд бид бас харж чадна, гэтэл зөвхөн бид итгэдэггүй, яагаад гэвэл бодьсадва хувилгаан биеэрээ энэ ертөнцөд ирэхэд ихэнх хүний хүсэж санадаг алтан шаргал өнгийн биеэр илэрдэггүй, харин ерөөсөө энгийн хүнтэй адил байх ёстой, хамаг төрөлтний ач тусын төлөө бодьсадва олон зүйлийн нөхцөл байдалд зохицон биеэ хувилдаг, ийм болохоор бид түүнийг яаж таньж чадах билээ?

Тиймээс хэн нэгэн хүн биднийг заан удирдаж, ном сударт тэмдэглэсэн шиг ахуй ойлголт бага зэрэг олгож чадвал түүнд итгэвэл зохино, учир нь бид өөрсдийнхөө ахуй ойлголтоо ном сударт тэмдэглэсэнтэй адил эсэхийг жишиж адилтгаж болно, хэрвээ адилхан бол итгэвэл зохино, тэгэхгүй бол хэдий болтол хүлээж байж сая итгэхэд хүрэх юм бэ? Хэн чухам биднийг итгүүлж чадах юм бэ?

Мэдээж, хүн бүхэн өнөөдрийн бидний очиж эмнэлэгт уулзсан тэр номын эгч шиг хувилгаан багш нь ирээд өвчнөөс нь авардагийг харж чаддаггүй. Учир нь та нарын дэс чинь тийм өндөрт хүрээгүй болохоор харж чадахгүй. Гэвч дэс чинь өндөр биш байлаа ч гэсэн бясалгах



хэрэгтэй бөгөөд өөр бусад өндөр дэсэдэй хүмүүст итгэх хэрэгтэй, тэд ахуй ойлголттой бөгөөд багшийгаа хэн болохыг мэднэ, үгүй бол хүн бүр ном сударт найдан бясалгавал болчихно, багшаар заан жолоодуулах хэрэг юун? Багш чинь ямар ахуй ойлголттой гэж ярьсан байвал та нар лав тийм ахуй ойлголттой болж чадна, багш чинь юу ярина, та нар тийм зүйлтэй болно, энэ бүхэн хангалттай нотолгоо болж чадахгүй гэж үү? Эс бөгөөс хэзээ багшид итгэж чадах билээ?

Энэ ертөнцөд бурхан бодьсадвагийн хүчний хөгжил хязгаартай болохоор увдис шидийн хүчийг ашиглаж болохгүй, та нар түүнд итгэвэл та нарт ач тустай, итгэхгүй бол бас ямар ч аргагүй. Гэтэл дотоодын багш тун хүчтэй, хүч чадал нь асар их, тэр бодьсадва юм чинь төвөг бэрхшээл учрах үед түүнд даатгавал чамд тусалдаг, гэхдээ харж чадахгүй ч гэсэн хамаагүй, чин сэтгэлээсээ даатгавал лав ирнэ. Жинхэнэ төвөг бэрхшээлтэй болох, эсвэл аюултай байдал тохиолдох үед түүнээс тусламж гуйж болно, эсвэл заримдаа ямар нэгэн асуудалд эргэлзээ төрөх үед дотоодын хувилгаан багшаасаа тусламж гуйж болно.

Гадна талын багш чинь тийм их зүйлийг ярьж чадахгүй, дотоодын хувилгаан багш чинь юуг ч ярьж болно, та нар харж чадахгүй боловч бас түүнд хэлж ярьж болно, ярьсныг чинь тэр сонсоно, Тайвань хэлээр, хятад хэлээр, англи хэлээр гэхчилэн ямар ч хэлээр ярьсан бүгдийг ойлгоно. Гадна талын багш чинь энэ ертөнцөд амьдардаг учраас хүчний хөгжил нь хязгаартай болохоор эрхбиш нэгэн энгийн хүн болж, энэ дэлхийн хүмүүстэй адилхан эгэл жирийн дүртэй харагдах ёстой байдаг, гэтэл дотоодын багш бол сэтгэгдэшгүй ач буян болон хүч чадалтай байдаг болохоор түүнд итгэ, их эргэлзэж болохгүй.

Та нар багшийгаа дагаж бясалгахгүй бол өөр бясалгалын аргын сайн эсэхийг өөрсдөө ялгаж чадахгүй. Сайн, мууг эгэл хүмүүс мэдэж чадахгүй, ихэнх номд ерөөс жинхэнэ ахуй ойлголт гэмээр зүйл байдаггүй гэж багш чинь та нарт шууд л хэлье. Багшийн чинь энэ бясалгалын аргаар бүр ч илүү олон төрөлтийг гэтэлгэж чадахгүй нь даанч харамсалтай, учир нь хүмүүс амар хялбар итгэдэггүй.

Гэтэл авшиг хүртсэн хүмүүс гүн итгэвэл зохино, тэгвэл та нарт маш их ач тустай. Багш чинь бас их ярьж болдоггүй, ахуй ойлголтыг угаас бусдад ярьж болдоггүй, багш чинь хэрвээ бүх шавь нараараа өөрсдийнх нь ахуй ойлголтыг яриулбал та нар сонссоныхоо дараа ажлаа бүгдийг огоорч, эр нөхөр, эсвэл эхнэрээ хаяад багшийнхаа энд суучихаж магадгүй, ингэвэл төвөгтэй болно. (Бүгд инээлдэв) Тиймээс ахуй ойлголтоо ярьж болохгүй, өөрсдөө бясалгаж, өөрсдөө ахуй ойлголттой бол, өөрийн хүсэж санасан ахуй ойлголттой болж чадахгүй ч гэсэн итгэвэл дараа нь ахуй ойлголттой болно.

Зарим хүн багштай чинь уулзахаасаа өмнө олон янзын элдэв бусын шид хүчийг бясалгаж байжээ. Бясалгалын аргыг бясалгахдаа хэрвээ сайн бясалгахгүй бол ад наалдана, ойлгож байна уу? Бясалгагч хүний хамгийн их айдаг нь шидийн хүч хэрэглэх явдал, зарим хүн багштай чинь тааралдахаас өмнө зөн билгийг эмх замбараагүй бясалгаж байжээ, ямар нэгэн тарни уншиж, гараараа мутарлага хийж, өвчин эмнэх буюу

ад чөтгөрийг хөөх гэх мэт. Тийм хүмүүс одоо бидний бясалгалын аргаар бясалгавал дөнгөж эхлэх үеэрээ маш олон саад төвөгтэй учирдаг, учир нь урд нь доод дэсийн чөтгөрт итгэдэг байсан болохоор одоо тэднийг үймүүлэн саатуулж, дэсийг нь дээшлүүлдэггүй, гэвч багшдаа итгэж Арьяабалын бясалгалын аргыг үргэлжлүүлэн бясалгадаг л юм бол хэсэг хугацаа өнгөрсний дараа ямар ч төвөг саад байхгүй болдог.

Учир нь урд нь түүнийг ашиглан бусдын өчүүхэн өвчнийг эмчилж, ад чөтгөрийг хөөж байжээ, одоо тэр бясалгалыг чинь саатуулж, дэсийг чинь дээшлүүлэхгүй, чамайг дээш гаргахгүй байгаа. Хэрэв та багшдаа үнэнхүү итгэхгүй бол түүнд татагдаад явчихна.

Яагаад гэвэл бие цогцос чинь таны гэр юм, хэнийг ч гэсэн гэртээ урьж болно, гэхдээ багш нь ямар хүн байлаа ч зочин урихыг чинь хориглож болохгүй, тэр бол чиний гэр болохоор хэнийг урьж залах нь чиний хувийн хэрэг, чиний эрх мэдэл, багш чинь тийм болхи толхи, тийм ёсгүй дүр эсгэж, зочныг чинь хөөн явуулж болохгүй. Гэтэл багшдаа чин үнэнээсээ итгэдэг хүнд багш нь лавтайяа тусална, багшдаа итгэдэггүй хүн харин ад чөтгөрт итгэвэл ад чөтгөр танд тусална, гэхдээ туслах тусам саад төвөг их болно.

Зарим хүн урд төрөлдөө бага зэрэг бясалгал хийсэн болохоор одоо энэ ертөнцөд дахин ирэхэд нь урд төрлийн бясалгалын хүч нь мөн л бага сага үлдсэн байдаг. Гэвч жинхэнэ багштай уулзахаас өмнө хүчтэй байсан ч бүгдийг талаар үрж, харанхуй бүүдгэр хүч болж хувиран ад чөтгөрт ашиглуулсан байдаг, хожим багштайгаа уулзаж бясалгахыг бодсон ч бас тун бэрх. Багшдаа үнэнхүү итгэхгүй, багшийнхаа хүчинд чин сэтгэлээр найдахгүй бол тийм харш саадыг туулан давахад тун ч хэцүү, ад чөтгөрийн саад маш их.

Зарим хүн бясалгал хийгээд бага зэрэг хүчтэй болмогцоо ихэд бардамнаж, өөрийн чадварыг гайхуулахыг санаархаж, гэрт чинь ад чөтгөр байна, эрхбиш ийм тийм тарни унших хэрэгтэй гэх зэргээр бусдад ярьдаг, хүмүүс тоох ч үгүй байхад харин өөрөө эрээд очдог, ингэх нь хамгаас яршигтай хэрэг.

Бясалгал хийхэд хялбар биш, гэвч бас тун хялбар. Бусдын үйл хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх нь хялбар биш, ингэх нь тийм ч амархан биш болохоор л хялбар биш гэдэг. Бусдыг сургахгүй байх нь бас л амаргүй, дөнгөж эхлэн бясалгаж байгаа хүмүүс амаа барих гэдэг нь тун амаргүй хэрэг. (хүмүүс инээлдэв) Бясалгал нь бага зэрэг ахуй ойлголттой, бага зэрэг хүчтэй болонгуут хүмүүст гайхуулах дуртай болохоор бясалгалын хүч нь хэр их байлаа ч гэсэн бүгдийг ад чөтгөрт сонсгочихдог, ингэснээр тэр тантай тоглох дуртай болж: “Уухай! Энэ хүн тун бардам, дэгсдүүлж ярих дуртай юм, за! Чамтай гайгүй нэг тоглоно доо” гэж боддог, бага чөтгөрийн чадвар нь хүрэлцэхгүй болохоор элэг доог болгож чаддаггүй, гэтэл тэр өөрийн “дарга”-аа эрж олоод дараа нь чамайг элэглэн тоглоно, чөтгөр бас олон зэрэг дэсэдэй, тиймээс бид: “Мөр ёсон хэдий өндөр бол, адын саад төдий их” гэж байнга ярьдаг. Тиймээс бид хичээн сэрэмжилж, чимээгүйхэн сэм бясалгавал зохино, зарим хүн бясалгаад ямар ч үр дүнд хүрээгүй байхад улс даяар бүгд

мэдчихсэн байдаг (Бүгд инээлдэв), наад зах нь бүх тосгон, эсвэл ойр хавийнх нь хүмүүс бүгд мэдчихдэг, өөрөө тийм ч ихээр бясалгадаггүй, бусдад элдэв зүйлийн тарни заадаг, хэрвээ гэрээс гарагч уншвал бас яахав, гэрээс гараагүй хүн харин ад чөтгөрт өглөг үйлдэх тарни уншина (Бүгд инээлдэв), өөрөө буянгүй байтлаа ад чөтгөрт юугаараа өглөг үйлдэх билээ дээ, чиний бэлтгэсэн хоолыг чөтгөр яаж идэх вэ? Өөрт тань идмээр хоол хүнс ч хангалттай биш байж магад, тэгтэл бас чөтгөрт идүүлэх нь үнэхээр хачин.

Өөрөө хангалттай буянгүй атлаа замбараагүй юм хийх нь тун аюултай, хожим нь бясалгал чинь бага зэрэг өндөр болох үед тэд чамайг доош татна, яагаад гэвэл урд нь та чинь тэдний найз байсан, одоо та зугтан далдалж, гэрээ нүүлгэчихсэн болохоор мэдээж дургүй нь хүрнэ, урд нь тэр чамайг захирч байсан бөгөөд та түүнийг их хүндэлж, хүндэтгэн мөргөж байсан, өөр чөтгөрийг хөөж явуулахын төлөө түүнээс тусламж гуйж байжээ, одоо харин түүнийг хүндлэхээ больж, туулан гэтэлж, үхэж, төрөх сансарын хүрднээс мултарч, гурван ертөнцийг даван туулж, түүнээс бүр ч өндөр болохыг санаархаж байгаа болохоор мэдээж дургүй нь хүрч чамд төвөг удна.

Тиймээс бясалгал хийхэд хамгийн аюултай нь “амаа барьж” чадахгүй явдал юм. Зарим хүн дэндүү их ярьж, ахуй ойлголтоо бүгдийг бусдад хэлчихдэг бөгөөд ямар хүчтэй, ямар зөн билигтэй гэхчилэн бүгдийг нь ярьж, хүн асуугаагүй байхад өөрөө аль хэдийн ярьчихсан байдаг. Ийм хүн бусдад ярих хамгаас дуртай, гэрийнх нь амьсгал орчин сайн биш, харанхуй бүүдгэр, ад чөтгөртэй байна, надаар бушуу ийм тийм тарни уншуулж, чөтгөрт ингэж тэгж өглөг үйлд гэж хэлдэг, энэ бол бусдын үйл хэрэгт хөндлөнгөөс оролцож байгаа хамгийн төвөгтэй хэрэг мөн. Өөрийн чинь хүч нь хангалттай биш байтал харин: би бясалгал хийдэг шүү. Миний дэс тун өндөр гэж бусдад ярьдаг, энэ бол хамгийн муу хэрэг мөн. Дэгсдүүлж ярьсан үгийг чинь хэлж дуусахаас нь өмнө чөтгөр аль хэдийн саад тавьчихсан байдаг.

Гэгээнтэнтэй ойр дотно байх дургүй, харин ад чөтгөртэй хамт байх дуртай, өсгөж дэврүүлж ярих нь мөн нэг төрлийн адын саад, адын хандлага мөн, харин бурхан бодьсадвагийн хандлага биш, ойлгож байна уу? Дэгсдүүлж ярих нь нэг зүйлийн доод дэс, тун доод дэсийн хувь чанар, тун муу хандлага юм. Тиймээс та нар бясалгал хийхдээ өсгөж дэврээж ярих дуртай хүмүүсийг харвал хамгийн сайн нь холдож, бохирдохоос хичээн сэргийлж, “өсгөж ярих” өвчин нь халдварлахаас зайлахыг хичээгээрэй.

Өсгөж дэгсдүүлж ярьдаг хүмүүсийн одоо байгаа дэс нь зүгээр байж ч магадгүй боловч улам бүр адын саад ихтэй болдог, адын саад байхгүй ч гэсэн хожим дээгүүр төвшинд хүрэх үед хүрсэн төвшнөө удаан хадгалж чадахгүй, учир нь бясалгалаа эзэмших хүч нь хүрэлцэхгүй болохоор хүрсэн төвшиндөө удаан байж чаддаггүй, ойлгож байна уу? Хэрвээ хүрсэн төвшнөө даван туулж чадахгүй бол илүү өндөр төвшинд яасан ч хүрч чадахгүй? Энэ нь ердөө л “ам”-аа хамхиж чадаагүйгээс шалтгаалсан хэрэг, хэрвээ одоо амаа хамхиж чадахгүй бол хожим

бурхан болвол яах билээ? Бурхан болчихсон байтлаа юугаа ч нуулгүй яриад байж яаж болох вэ? Иймэрхүү өсгөж дэгсдүүлж ярьдаг бурхан ямар ач тустай байх вэ?

Бясалгагч хүн чимээгүйхэн сэм бясалгавал зохино, тиймээс багш нь та нарыг бясалгалын арга болон ахуй ойлголтоо бусдад ярихыг зөвшөөрдөггүй, гэвч заримдаа үнэхээр зориудаар биш, санаандгүй ярьсан байвал бас уучилж болох бөгөөд багш нь бас тэгж хатуугаар хандахгүй. Учир нь заримдаа шавь минь хувилгаан багш ирж, түүнийг аврах, эсвэл туслахыг хараад сэтгэл нь дэндүү их хөдөлдөг болохоор багштайгаа уулзангуут дэргэд нь хүн байгаа эсэхийг хайхралгүй, догдолсон сэтгэлээ дарж чадалгүй ярьчихдаг. Энэ нь сэтгэл догдолсондоо аяндаа ярьсан хэрэг юм, харин өсгөж дэгсдүүлэн ярьж байгаа юм биш, ийм байдлыг бага зэрэг ярихад хамаагүй.

Гэтэл өөрөө өсгөж ярих нь хамгийн төвөгтэй хэрэг, өсгөж ярих үед ад ирж, бидний бясалгалын ач буян, бясалгалын хүчийг нь аваад явчихдаг бөгөөд тэгээд бидэнд саад бэрхшээл тохиолдвол, дараа нь эрхбиш дахин А, Б, В-гээсээ эхлэн суралцах хэрэгтэй болно, бясалгалаа эзэмших хүч хангалттай биш болохоор хүрсэн төвшнөө эзэмшихэд тун бэрх байдаг. Бясалгалаа эзэмших хүчээр хангалттай биш бол дээд зэргийн дэсэд тогтвортой байж чадахгүй, дээд зэргийн дэсэд хүрэхэд эрхбиш бясалгалаа эзэмших хүч хангалттай байх хэрэгтэй.

Энэ нь бидний ажил хэргээ шийдвэрлэдэг байдалтай адил, жишээ нь та улс орны нууцыг хамгаалах газарт ажиллаж байвал өндөр дээд байр суурьтай биш боловч маш чухал албан тушаалд хамаарна, гэтэл та улсын нууцыг хамгаалахгүй бол эрдмийн цол чинь хичнээн их, ажлаа хэр сайн хийдэг байсан ч хожим засгийн газраас чамайг улсын нууцыг хамгаалах алба тушаалд байлгаж зүрхлэхгүй, учир нь та “ам”-аа хамхиж чаддаггүй, дэндүү их ярьсаар байгаад улсын хамаг нууцыг задруулчихвал яах вэ? Тиймээс танд тийм өндөр алба тушаал хариуцуулж болохгүй.

Бясалгагч ч бас адилхан, ямар ч үр дүнд хүрээгүй байж, тэгж их өсгөж дэврүүлж ярьсан болохоор хэн чамайг бурхан болгож зүрхлэх вэ? Бясалгалын явц дахь маш олон орон, маш олон зүйл, маш олон дэсийг та нар хараахан мэддэггүй байсан. Бодьсадвад тун олон зэрэг дэс байдаг, анхан шатны бодьсадва, хоёрдугаар дэсийн бодьсадва...; наймдугаар дэсийн бодьсадва, аравдугаар дэсийн бодьсадва, махасадва гэхчилэн байдаг бөгөөд бодьсадва махасадва бол хамгийн дээд бодьсадва юм, тэр бол аливаа бодьсадвагийн дарга нь болно.

Гэвч бас нэг төрлийн бодьсадваг харахад хүнийг аварч гэтэлгэдэггүй юм шиг байдаг, бид түүнийг “Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва” гэж нэрлэдэг, тэдний ач буян их далай шиг өргөн дэлгэр, ариун бөгөөд амарлингуй тайван болохоор ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг бодьсадва гэдэг. Тэдний хүч чадал их далайтай адил, ажил нь маш аниргүй нам жим, яг л ариун тунгалаг нам тайван ус шиг, оршиж байгааг нь хэн ч мэдэрч чаддаггүй. Гэтэл хувилгаан биет бодьсадваг бид мэдэж чадна, ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва бол энгийн махасадвагаас дээд дэсийнх болно.

Энэ орчлонд бидний амжилтад хүрч чаддаг дэс маш олон бий, бидний олж хүрвэл зохих байр суурь тун олон байдаг. Тиймээс бясалгалаар бага байтлаа онгирсоны хэрэг юу билээ? Өчүүхэн зөн билгээ хоолойгоо хатгал ярьж, өнгөрсөн, одоо, ирээдүйгээ бага сага харах нь ямар ач тустай вэ? Маргааш энэ ертөнц сөнөнө гэдгийг урьдчилан мэдсэн ч бид юуг ч өөрчлөх аргагүй, эсрэгээрээ өнөөдрөөс маргааш болтол энэ хугацаанд ухаангүй айж, унтаж ч чадахгүй, хоол идсэн ч амтгүй болно, гэтэл юу ч мэдээгүй байгаа хүмүүс харин амар тайван нойрсож, наад зах нь хорин дөрвөн цаг амирлангуй жаргана.

Тиймээс өнгөрсөн, одоо, ирээдүйг мэдэх нь үнэхээр хэрэгцээгүй, ирээдүйгээ урьдчилан тогтоох гэвэл одооноос эхлэн хийх хэрэгтэй, өдөр тутмын амьдралдаа нэгэн ёс суртахуунтай хүн болж, багшийнхаа сургасан “таван сахил”-аа тодорхой сахиж, амь хороохгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, худал ярихгүй, архи уухгүй гэхчилэн таван сахилаа чанд сахивал болчихно, сахилыг дэндүү их ярьсны хэрэггүй, таван сахилаа чанд сахиж чадвал багшдаа итгэхгүй байсан ч хамаагүй, Арьяабалын бясалгалын аргыг бясалгахгүй, үхэж, төрөхөөс туулан гэтлэхгүй байсан ч хамаагүй.

Багшдаа итгэдэггүй хэдий ч эрхбиш сайн хүн болох хэрэгтэй, таван сахилыг чанд сахивал наад зах нь хожим дахин хүний төрөл олж чадна, тэгэхгүй бол яах ч аргагүй болно. Багш чинь та нарт ямар нэг муу сургаал ёсыг сургаагүй, та нар багшийнхаа энэ хүнд нь итгэхгүй байж магадгүй, гэвч багшийнхаа сургаал ёсонд итгэвэл зохино, багш нь ерөөсөө л сайн сургаал ёсыг л заадаг. Хүний ёсоор явах нь тун хялбар, таван сахилыг тодорхой сахьдаг л бол хожим яршиг төвөггүй болно, таван сахилыг чанга сахьдаг л бол Арьяабалын бясалгалын аргыг бясалгаагүй ч гэсэн хүний төрөл авч чадна, тэгэхгүй бол дахин хүний биеийг олж төрөх нь тийм хялбар биш.

Хүний бие цогц маш ховор үнэ цэнэтэй, хүмүүний биегүй бол зургаан мэдрэхүйн эрхтэн байхгүй учраас бясалгаж чадахгүй. Зургаан мэдрэхүйн эрхтэн, зургаан мэдрэмж нь мэдээж хамгийн төвөгтэй харш саад болохыг бид бүгд мэднэ, гэвч бид бясалгахдаа эрхбиш тэдгээр эрхтэнийг ашиглах хэрэгтэй, зургаан мэдрэхүйн эрхтэн, зургаан мэдрэмж байхгүй бол бид бас бясалгаж чадахгүй, ойлгож байна уу? Дотоодын аялгуугаа сонсоход угаасаа чихээ хэрэглэдэггүй, гэвч чих байхгүй бол яаж сонсох билээ? Бясалгаж суугаа үедээ харсан төвшнийг нүдээрээ хардаг биш, гэвч энэ махан бие үгүй бол бас харж чадахгүй бөгөөд бурхны хүслэнт ахуйг харж чадахгүй, диваажин болон тамын орны байдлыг мэдэхгүй, төгс баясгалант орон ямаршуухан гэдгийг мэдэхгүй, тийм биш гэж үү? Тиймээс хүний бие бол маш ховор үнэ цэнэтэй.

Хүний төрлийг алдахад маш амархан, хүний төрлийг олоход маш бэрх, бурхан бодьсадва болоход бүр ч хэцүү, энгийн бодьсадва болох нь нэгэнт тун хэцүү юм чинь Ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва болоход бүр ч олон төрлийн төвөг бэрхшээлтэй. Нэгэн “Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва” нь хэлбэр дүрсгүй,

хамгийн дээд бодьсадва болоход эрхбиш маш олон сэтгэгдэшгүй, дүрслэхийн аргагүй хатуу шалгалтыг даван туулах хэрэгтэй, гэхдээ даван туулахад маш хэцүү байдаг. Энэ ертөнцөд бид нэгэнт хэдэн зуу мянган жилээр үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдсэн байлаа ч гэсэн тийм хатуу чанга шалгалтыг огт сонсоогүй бөгөөд сонсох ч боломж ч байхгүй.

Хэрвээ бид ном их уншсан бол урдын бясалгал хийдэг Их Багш нар сүнслэг дадал бясалгал хийх явцдаа бүгд л ямар ямар шалгалтыг туулж, ямар ямар зовлон зүдгүүрийг амссан бэ гэдгийг мэддэг, түүний доторх хамгийн хүнд, хамгийн зовууртай шалгалт нь ч гэсэн Ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадвагийн туулсан сорилт шалгалт хэр их, хэр хатуу гэдэгтэй харьцуулшгүй.

Ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва бараг бурхантай ойролцоо болчихсон байдаг, гэвч бурхан бол “хөдөлдөггүй”, харин Ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва бол “хөдөлдөг”, тэд орчлонгоор тойрон аялж, орчлонг харж харгалзан эмх замбараагүй, дүрэм журамгүй болгодоггүй, тэдний үүрэг хариуцлага бол энэ орчлонг харж харгалзах явдал болно. Гэтэл Бодьсадва Махасадва бол хүнийг авран туслах сүнс байж, тэднийг дагуулан буцна, төгс баясгалант оронд очих хүсэлтэй хүн байвал бодьсадва махасадвагаас суралцаж болно, тэд хувилгаан биеэр тоост хорвоод ирж, хүмүүсийг дагуулан сүнсний нутаг, тэнгэрийн орон, төгс баясгалант оронд буцдаг.

Ердийн үед та нар ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва гэж уншдаг хэдий ч тэд чухам хэн болохыг нь мэддэггүй, та нарын өмнө илрэн харагдлаа ч гэсэн мэдэхийн аргагүй. Хэн нь чухам ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва болохыг зөвхөн Бодьсадва Махасадва л мэддэг. Энгийн хүн мэдэх боломжгүй, учир нь тэд зэрэг дэс болон хүчээ ил болгодоггүй, харахад тун энгийн байж, нэгэн эгэл жирийн хүнээс ч энгийн, тэд энэ ертөнцөд ирлээ ч гэсэн бодьсадва гэдгийг нь хэн ч мэддэггүй, тэд өчүүхэн ч ид шид харуулдаггүй, дув дуугуй ажилладаг тул эгэл хүмүүс огт мэддэггүй.

Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадвагийн ажил төрөл нь Бодьсадва Махасадватай адилгүй, бусдын үйлийн үрд хөндлөнгөөс огт оролцдоггүй. Гэтэл Бодьсадва Махасадва бол оролцож болно, ойлгож байна уу? Тэр тамын орны төрөлтнийг диваажинд аваачиж чадна, үйл үйтгээрээр хүнд хүнийг төгс баясгалант оронд аваачиж чаддаг. Гэтэл ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадвагийн хувьд энэ байдлыг хажуугаас нь харах төдийхөн байж, огт хамаардаггүй, тэдний ажил бол энэ орчлонгийн үйл ажиллагааг харгалзан орчлонгийн оршин тогтнолыг хамгаалах явдал, тэд хүнийг авардаггүй, та өлсөхийн туйлд хүрэх, эсвэл тамын галд шарагдлаа ч гэсэн хамаардаггүй. Эгэл хүний хувьд ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва тун хүйтэн сэтгэлтэй юм шиг байвч үнэндээ тийм биш, ажил төрөл нь ондоо болохоор л ийм байдаг хэрэг.

Гэвч Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болоход тун амаргүй, та нар шалгалтыг нь давж чадахгүй байх гэж би бодож байна.

Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болоход эрхбиш маш хатуу, маш чанд дадлагажилтыг даван туулах ёстой байдаг. Тиймэрхүү зовлонт дадлагажилтын аргыг үг хэлээр ярьж илтгэхийн аргагүй, эгэл хүмүүс сонсоо ч үгүй, төсөөлөн бодохын ч аргагүй. Яг л армид, бас явган цэрэг, далайн цэрэг, агаарын цэрэг, тагнуулын цэрэг гэхчилэн ижил бус цэргийн сургагч байдагтай адил. Үүнээс гадна бас хамгийн аюултай онцгой цэргийн анги гэж байдаг, тэр ч байтугай тэд харилцан аалдах сургуулилт хийдэг, ийм цэргийн ангийн дасгалжуулалт нь хамгийн зүдгүүртэй, тийм үү? үгүй юү?

Бодьсадва болоход бас адилхан, адил бусын дэсэд адил бусын дасгал боловсролыг хүлээн авдаг. Тиймээс Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болоход эрхбиш маш зүдгүүртэйгээр бясалгах хэрэгтэй, гэхдээ маш зүдгүүртэй бясалгаснаас болж л сая Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болж чаддаг юм биш, гэвч Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болоход заавал хамгийн зүдгүүртэй бясалгалыг хүлцэн тэсвэрлэх хэрэгтэй. Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болоход эрхбиш онцгой сонголтгоор дамжин сонгогдсон байх ёстой, харин ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва больё гэж хүссэнээр л болчихдог юм биш, нэгэн бясалгагч хүн гурван ертөнцийг даван туулаагүй бол сонгогдох боломж байхгүй.

Ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва нарыг тавдугаар ертөнцөөс сонгосон байдаг, гурван ертөнцийн дотор ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болж чадахгүй. Учир нь гурван ертөнцийн дотор бол мөн л үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэж, энэ ертөнц дэх хичээлээ сурч дуусаагүй болохоор хамгийн хатуу чанга сургаалыг хүртэхээр сонгогдож чадахгүй. Ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болоход эхлээд заавал тавдугаар ертөнцийн бодьсадва болох хэрэгтэй, тэгээд өөрсдөө дуртай бол сонгогдох эрх бүрэн байх болно, гэтэл сонгогдсоны дараа бас хамгийн хатуу чанга дасгалжилтыг давж туулах ёстой бөгөөд энэ дасгалжуулалт нь тамын орны системээс ч хэцүү мөртлөө зовууртай байдаг.

Бясалгал маш олон дэс байдаг, бясалгалын зам маш урт болохоор дөнгөж эхлэн бясалгаж байгаадаа битгий онгирч бардамнаарай. Ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй гэж багш чинь ярьж байгаа нь та нарын хувьд л ач тустай хэрэг, харин багштай чинь ямар ч холбогдолгүй, та нар ярих дуртай юм бол бас яахав, улс даяар зарласан ч болно, багшид чинь ямар ч асуудал үүсэхгүй, гэтэл өөрийнхөө эрдэнэсийн сангаа ил болговол өөрийгөө л хорлосон явдал болно.

Тиймээс чимээгүйхэн бясалгах хэрэгтэй, учир нь дэсээ баталж, алгуур аажмаар дээшлүүлж байж бурхан болно, бодьсадва махасадва болно, дээд дэсийн бодьсадва болно. Дөнгөж эхлэн бясалгаж байгаа атлаа бага зэрэг зөн билигтэй болонгуут сэтгэл тогтохоо байж, гадагш гарч өөрийгөө зарлан сурталчилчихдаг, тийм хүмүүс найдвартай биш гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Нэгэн жинхэнэ бясалгагч тийм хүмүүсийг хармагцаа харш саадтай, бидний ярьдаг “даяаны өвчин”-д нэрвэгдсэн гэдгийг мэдэх болно.



Хүмүүс сонсох дуртай эсэх нь хамаагүй, бясалгагч хүн өөрийн мэддэгээ ярих нь зөв, гэхдээ үнэнээр ярих нь бясалгагч хүний үүрэг хариуцлага мөн.

(“Энэ ертөнцөөс ангижрахад зөвхөн үйлийн үр л дагалдах болно”-ээс)





Агуу гэгээрсэн хүн энэ ертөнцийг адисалж, олон төрөлтнүүдэд тусалж байдаг, гэхдээ хүмүүс адислагдсанаа заримдаа мэддэггүй.

(“Үхэж төрөхөөс гэтэлгэгдэхийн тулд гарцаагүй Арьяабалын бясалгалын аргад найдах хэрэгтэй”-ээс)

Даяаны өвчингүй хүмүүс гадагш гарч өсгөж дэврүүлж ярьдаггүй, ойлгож байна уу? Бясалгагч хүмүүс тун даруухан, бясалгал өндөр болох тусмаа улам даруухан болж, өөр хүмүүс бидний бясалгадагийг мэдэх, бидний хүч хэр их гэдгийг мэдэхээс болгоомжилдог. Зарим хүн дөнгөж эхлэн бясалгаж байх үедээ бас сайн байснаа бага зэргийн дэсэд хүрч, бага зэрэг ахуй ойлголттой болмогц хаа сайгүй сайрхан ярьдаг, ингэж дэндүү их ярьснаас болоод адын саадтай болж, дэс нь дээшлэх тусам адын саад нь улам их болдог.

Тиймээс бясалгал хийхэд хамгаас айх зүйл нь өөрийн ахуй ойлголтоо ярих явдал болно, дэндүү их ярьсны дараа ахуй ойлголтын чанар нь хувирч, зөв бус болдог, үгүй бол ахуй ойлголтгүй болж, зөвхөн хий бодол төдийхөн болно, учир нь бясалгалаа эзэмших хүчээ бүгдийг нь үрээд дуусгачихсан болохоор сүнслэг мэдрэмж, орчин байдал эвдэрдэг, сүнслэг мэдрэмж (онгод)-ийн ахуй орчинд уг нь нэг давхар хамгаалалтын хана байдаг ч өөрөө дэндүү их ил болгосон тул ад чөтгөр цоолон ордог.

Тиймээс бясалгал хийхэд хамгаас аюултай нь онгирч бардамнах хандлага бөгөөд бардамнах тусам яршиг төвөгтэй болдог. Бясалгагч хүн нэгэн багшид итгэх нь хялбар бус гэдгийг би мэднэ, тиймээс та нар багшдаа итгэхгүй бол бас та нарын буруу биш, бүгд л ном буурах цаг үеийн орчин байдлаас болсон тул одоо үеийг цөвүүн цаг үе гэж нэрлэдэг шүү дээ.

Бясалгал хийх нь амаргүй хэрэг, “Баатар явагч их хөлгөн судар”-г: “Цөвүүн цаг үед нэг хүн чин сэтгэлээсээ хичээнгүйлэн бясалгадаг л юм бол бага зэрэг бясалгасан төдий байлаа ч гэсэн бурхан бодьсадва ихээр тусална” гэж өгүүлсэн байдаг. Гэтэл ийм чин сэтгэлтэй бөгөөд итгэлтэй, жинхэнээр бясалгадаг хүн тун цөөн, ихэнх хүн бүгд л нилээд хялбар, зам тухтай замыг сонгож, дэндүү зовлон зүдгүүртэй, дэндүү хатуу хөтүү замаар явах дургүй. Бидний бясалгалын аргаар бясалгахад эрхибиш цэвэр ургамал хоол идэх хэрэгтэй мөртлөө өдөр бүр хамгийн багадаа хоёр цаг хагасын хугацаагаар бясалгаж суух хэрэгтэй, үүнээс гадна бас амь хороож болохгүй, худал ярьж болохгүй, садар самуун явж болохгүй, хулгай хийж болохгүй, архи ууж болохгүй гэх мэт нь ихэнх хүний хувьд дэндүү хатуу, дэндүү зүдгүүртэй юм шиг санагддаг.

Гэтэл энэ ертөнцөд нэг хүн доктор, эмч, эсвэл хуульч болж, нийгэмд бага зэрэг байр суурьтай болъё гэвэл эрхбиш маш их зовлон зүдгүүрт суралцах хэрэгтэй, тийм биш үү? Бурхан бодьсадва болох, үхэж төрөхөөс ангижрах, энэ төрөлдөө туулан гэтлэхэд зовлон зүдгүүр эдлэхгүй байж яахин болох билээ?

Цөвүүн цаг үед бид чин сэтгэлээсээ бага зэрэг хичээнгүйлэн бясалгадаг л юм бол бурхан бодьсадва ихэд тусалдаг, энэ нь тун аз завшаантай хэрэг, үгүй бол та нар хоёр цаг хагас бясалгах нь тийм ч хэцүү хэрэг биш. Шагжамуни Бурхан өдөржин бясалгаж суудаг байсан, маш олон хүн арван хэдэн цаг, хорин цаг бясалгаж суудаг ч үр дүн гэмээр зүйл байхгүй, хэрвээ бурхан бодьсадва нар хүчээрээ туслахгүй л юм бол бидний бясалгалд үр дүн гэмээр зүйл байхгүй.

Үнэндээ бясалгал хийх нь зүдгүүртэй биш, гэтэл бардамнах хандлагыг арилгахад нилээд хэцүү, энэ амаа хамхихад бүр ч хялбар биш, сайрхаж бардамнах болон өсгөж дэгсдүүлж ярих хандлагыг өөрчлөхөд хамгийн хэцүү. Бясалгал нь тийм ч их ахуй ойлголтгүй, дэс нь ч ахиц дэвшилтгүй хүмүүс бүгд л бардамнах хандлага болон дэндүү их ярьдагаас болж байгаа юм шүү, тийм ч их бясалгаагүй хэр нь харин тийм их ярьчихсан байна шүү дээ.

Шагжамуни Бурхан бас шавь нарынхаа өсгөж дэврээж ярихыг хориглодог, Молом тойн (Модгальяна) зөн билигтэй ч Бурхан Багш хэрэглэхийг нь зөвшөөрдөггүй байжээ. Багш чинь бас адилхан тэгж сургадаг, их бясалгавал аяндаа зөн билигтэй болно, гэвч өсгөж дэгсдүүлж ярьж болохгүй, бусдын бодлыг мэдэж чадах зөн билигтэй байсан ч хүмүүст ярьж болохгүй, үгүй бол хүмүүс чамаас айн сүрдэж, уулзах болгондоо юу бодож байгааг нь мэдчихээс айна, тэгвэл чамтай уулзаж зүрхлэх хүн байх уу? Тийм биш үү? Үгүй юү?

Хувилгаан хөлт, тэнгэрийн нүд гэх мэт зөн билгийг ч бусдад мэдүүлж болохгүй, хэлсний дараа өөрийгөө л хорлохоос өөр ямар ч ач тус байхгүй, зарим хүн атаархаж, өөрсдөөс нь дээгүүр байгаад дургүй нь хүрдэг, тэдний дургүй үйл хэргийг яривал арга бодож, хар зүгийн шидээр биднийг хорлоно. Яг л Молом тойн (Модгальяна) шиг зөн билгээ ашигласны эцэст гадаад номтны хэрэглэсэн хар шидэд хорлогдсонтой адил болно. Тиймээс багш нь та нарт бясалгалын дэсээ бусдад мэдэгдэж болохгүй гэж үргэлж хэлдэг. Гэвч зарим хүн ийм алдаа буруугаа засдаггүй, энэ бол түүний хувийн зан чанар, засахад бэрх болохоор төвөг ихтэй. Тийм хүмүүсээс хамгийн сайн нь хол байж, үгийг нь битгий сонс, тэгэхгүй бол халдварт өвчин шиг халдварлана.

Ад чөтгөрийн саадтай хүмүүстэй хамт байх, тэр ч байтугай хамт байхгүй ч гэсэн ойр суудаг л юм бол аль хэдийн тал хувиар халдварлачихдаг. Та нэгэн өвтөнийг үзэхээр очоод түүнтэй хамт байвал өвчний талыг нь авч, үйл түйтгэрийнх нь тал хувийг өөртөө хураачихдаг. Тиймээс бурхан бодьсадва яагаад хувилгаан биеэр энэ ертөнцөд ирэхдээ эхийн хэвлийгээс мэндэлсний дараа бас эгэл хүн болчихдог билээ? Эхлээд эгэл хүн болно, дараа нь бясалгал хийж бурхан бодьсадва болж хувирдаг. Учир нь бурхан бодьсадвагийн хувилгаан бие ч бясалгал хийхгүй бол мөн л энэ ертөнцөд бохирдоно. Жишээ нь: Шагжамуни Бурхан бол гэрэл гэгээг хамгаалах бодьсадва, ТУШИТА (TUSITA) тэнгэрийн орноос бууж иржээ, тэр угаас энэ ертөнцөд хүн аврахаар ирсэн, энэ бол түүний ажил юм. Гэтэл тэр мэндэлснийхээ дараа гуч насалтлаа хамаг төрөлтөнд ач тустай хэрэг ер хийгээгүй, хааны хүү болохоороо хийх ажил хэрэг гэх юм байхгүй, өдөр бүр ертөнцийн жаргалыг эдлэн бясалгал гэж юу болохыг ч мэддэггүй байжээ.

Тэр мэндлэх үедээ долоо алхаж, өөрийгөө хэн болохоо мэдэж байсан бөгөөд “Тэнгэр газрын дунд би бол хамгаас эрхэм дээд нь” гэж хэлжээ. Гэтэл том болсныхоо дараа бас л харанхуй мунхаг, тэр ч байтугай, энгийн хүмүүсээс бүр ч харанхуй мунхаг, тийм олон үзэсгэлэнт хүүхэн хань бараа болж, өдөр бүр ертөнцийн жаргалыг эдэлж, юу ч боддоггүй

байж. Тав тухтай амьдралын орчноор хүрээлэгдэн аав, ээжийн хайраар эрх танхи өсөж, зарц нараараа асруулдаг, аливаа нэг муу нөхцөл байдлыг түүнд огт мэддэгдэггүй, бясалгал хийхийг ерөөс сануулдаггүй байсан, тиймээс гуч насалтлаа эгэл хүн хэвээр байжээ.

Тэр бол их бодьсадвагийн хувилгаан, өнө эртэд хэдийн бурхан болчихсон гэлээ ч энэ ертөнцөд мэндэлснийхээ дараа эгэл хүн болох хувь заяанаас зайлж чадаагүй. Тиймээс энэ ертөнц үнэхээр аймшигтай, бурхан бодьсадва энд ирээд мэндэлсэн ч бясалгал хийхгүй бол лав төөрөлдөнө. Тиймээс ямар байлаа ч гэсэн заавал дахин бясалгах хэрэгтэй.

Хүн бүхэнд “Бурхан чанар байсаар байтал бид яагаад мөн л эгэл хүн хэвээр байдаг вэ?” гэж та нар багшаасаа байнга асуудаг. Учир нь энэ ертөнцөд ирсний дараа эгэл хүнд “халдварлагдаж”, эгэл хүнд “гэтэлгэгддэг”. Энэ ертөнц бол халдварт өвчний оронтой адил, уг нь ганцхан хүн өвчинд нэрвэгджээ, дараа нь хоёр, гурван хүн өвчилж, улмаар бүр ч олон хүнд халдварлаж, эцэс сүүлд нь бүх улс орноороо өвчинд нэрвэгддэг, тэр ч байтугай заримдаа нэг хотын хамаг хүн, амьтан бүгд үхэж дуусдаг, үүнээс халдварт өвчин үнэхээр аймшигтай гэдгийг харж болно.

Үүнтэй адилаар, бурхан бодьсадва энэ ертөнцөд ирэхдээ хэрвээ бясалгал хийхгүй бол мөн л эгэл хүн болж хувирдаг. Бид үнэндээ бүгд л бурхан, бүгд бурхан чанартай байтлаа яагаад мэддэггүй юм бэ, харж чаддаггүй юм бэ? гэвэл энэ ертөнцөд “гэтэлгэгддэг” маш уджээ, одоо дөнгөж эхлэн бясалгаж байгаа болохоор яаж хурдан мэдэж чадах билээ? Гэвч чармайн бясалгадаг л юм бол хожим бодьсадва болж чадна, “бясалгавал бодьсадва болж, бясалгахгүй бол эгэл хүн болно” гэдэг нь үнэхээр оносон үг, өөр яримаар юм үгүй.

Та нар хар л даа. Шагжамуни Бурхан ч гэсэн зургаан жил бясалгаж байж л сая бурханы хугтийг олжээ, Есүс Христ арван хэдэн жил бясалгасны эцэст сая тийм агуу Их Багш болжээ, тийм үү? үгүй юү? Зургадугаар үеийн өвгө багш Хүй Нэн тавдугаар үеийн өвгө багштайгаа уулзах үед нэгэнт билиг нээгдсэн байсан, гэвч тавдугаар үеийн өвгө багшаас түүнд ном уламжилсны дараа мөн л заавал арван зургаан жил нууцаар бясалгах хэрэгтэй байжээ. Бодьдармаа тухайн үед хамаг төрөлтнийг гэтэлгэж чадахгүй байжээ, учир нь хүч нь хангалттай биш байсан ч байж магад (Багш инээв), ном тайлахад сонсох хүн байхгүй болохоор есөн жил хананд ярьжээ, сонсоод байхад тэр удаан хугацаагаар бясалгаж сууснаасаа болоод хожим нь алхаж чадахаа больсон гэдэг, хойч үеийн хүмүүсийн харсан зураг нь бүгд л түүний алхаж буй байдлын зураг байдаг бөгөөд тухайн үед хувилгаан биеэр харагдсан байна.

“Сайнтай нөхөрлөвөл сарны гэрэл, муутай нөхөрлөвөл могойн хорлол” гэдэг нь муу санаатантай хамт байвал муу хүн болж, сайн санаатантай хамт байвал сайн хүн болж хувирна, гэгээнтэнтэй хамт байвал цэцэн мэргэн болж хувирна, мэдлэгтэй хүнтэй хамт байвал бага сага юм сурдаг, тэнэг хүнтэй хамт байвал бид бас тэнэг болно гэсэн утгатай. Англи хэлээр сайн ярьдаг хүн гучин жил ярихгүй бол бас

мартчихдаг, англи хэлээр эрхиш өдөр бүр ярьж боловсрох хэрэгтэй, англи хэлээр ярьж чадахгүй хүнтэй удаан хугацаагаагаар хамт байвал хожим бас англи хэлээр сайн ярьж чадахгүй болно.

Яг л би одоо Вьетнам хэлээрээ тийм урсам сайхан ярьж чаддаггүйтэй адил, яагаад гэвэл удаан хугацааны турш яриагүй болохоор л тэр, тэр ч байтугай, англи хэлээр ч сайн ярьж чадахгүй болжээ (бүгдээр инээв), гэтэл Америкт очоод хэдхэн хоносны дараа сайн ярьдаг болчихдог, өдөр бүр ингэж хятад хэлээр яривал гучин жилийн дараа англи хэлээр бага сага ч ярьж чадахаа больж мэднэ. Бясалгал хийх ч адилхан, хэн нэгэнтэй хамт байхаар яваандаа түүнтэй адилхан болчихож ч мэднэ, тиймээс бясалгал хийхдээ хичээн болгоомжилж байж л “жинхэнэ багш”-ийг сонгох хэрэгтэй.

Та нар одоо бас Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болмоор байна уу? (Болно гэж нэг хүн хариулав), гэтэл зарим хүн багшдаа бага зэрэг загнуулмагц дорхноо уруу царайлчихдаг, ийм байж яаж ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болох вэ? (Бүгд инээлдэв), ийм бодьсадва болоход хялбар биш, та нар ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болохоор андгайлбал яршиг болно, энгийн нэгэн багш болоход яршиг төвөг ийм их байхад чинь ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болоход ямар байх бол? Энэ орчлонд буддагаас гадна хамгийн дээд байр суурьтай нь ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва юм. Орчлонд хамгийн дээд байр суурь нь будда, төгс төгөлдөр гүн билиг ухаан юм, дараа нь ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва юм, ойлгож байна уу? Тэр бол орчлонгийн хууль дүрмээс хэтийдэж, диваажин болон тамын орноор очих нь яг л бид дэлгүүрээс ногоо худалдан авахтай адил, хаа очиж, юу хийх нь өөрийн дур, түүнээс дээд зүйл байхгүй, учир нь бурхан угаас сэтгэл татагддаггүй, төгс төгөлдөр гүн билиг ухаанд бүр ч сэтгэл татагддаггүй, тиймээс үнэн хэрэг дээрээ ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва хамгийн дээд нь болно.

**Асуулт:** Багш аа, Бурхан ганцхан байдаг уу?

**Их Багш:** Тийм биш, бурхан гэдэг нь энэ хүчийг л хэлж зааж байгаа юм. Жишээ нь: англи улсад мэдээж хатан хаан бол хамгийн дээд байр суурьтай, гэвч тэр юу ч хийдэггүй, засаг төрийн хэрэгт оролцдоггүй, зөвхөн хамгийн дээд байр суурийн төлөөлөгч л төдийхөн. Гэтэл Тэтчер хатагтай хамгийн алдартай бөгөөд улс болгон бүгд мэддэг, ерөнхий сайдын албан тушаалд байгаа хүмүүс бүгд л хамгаас алдартай, хатан хаанаас ч алдартай байж, юу хийхийг хүсвэл түүнийгээ хийж, хүн болгон түүнээс сүрддэг. Мэдээж хатан хааны байр суурь нь хамгийн өндөр хэдий ч ерөнхий сайдынх шиг эрх мэдэл байхгүй, тийм үү? үгүй юү? Хатан хаан олон газраар явж, төрийн үйл хэрэгт оролцдоггүй бөгөөд ямар нэгэн хууль дүрмийг өөрчилдөггүй. Гэтэл ерөнхий сайд аливаа үйл хэргийг зохицуулах ёстой, түүний байгаа байдал нь тун хатуу, заримдаа бусдын эсэргүүцэлтэй тулгарна, Жишээ нь: Тэтчер хатагтай бол нэрд гарсан хатуу чанга шийдвэр гаргадаг ерөнхий сайд билээ, хүмүүс түүнийг төмөр хатагтай гэж дууддаг, учир нь эрс хатуу хандлагатай, эрх

мэдэл ихтэй, ямартаа л английн хатан хаан яах ч аргагүй болохдоо: “Та битгий ийм хатуу байгаач дээ, жаахан зөөлөн хандах ёстой шүү” гэсэн ч, ерээс тал хардаггүй, тийм биш үү?

Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва мөн л адилхан, энэ орчлонд түүний хүч хамгийн их, та нар ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болох хүсэлтэй бол илүүхэн чармайх хэрэгтэй. Гэвч та нар тиймэрхүү хамгаас хатуу бөгөөд зүдгүүртэй дасгалжуулалтын системийг тэвчиж чадахгүй байх гэхээс би айж байна, тиймээс аажмаар бясалга, эхлээд бодьсадва болж, дараа нь дахин аажмаар дээшлээрэй. Гэхдээ үнэн сэтгэлээсээ андгайлбал хэзээ нэгтээ, лав ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болж чадна, ямар нэгэн үр дүнд хүрэхээр зориг шийдэж шулууддаг л юм бол лавтай хүрч чадна, гэвч тийм түргэн биелэгдэхгүй, дараа төрөлдөө, эсвэл хэдэн төрөл авсаны дараа ч биелэгдэж магад, гэсэн ч дуртай л бол хэзээ нэгэнтээ лавтайяа биелнэ.

**Асуулт:** Ариун тунгалаг амарлингуй тайван их далай хамаг Бодьсадва энэ ертөнцөд ирдэг үү?

**Их Багш:** Ирнэ шүү. Яагаад ирэхгүй гэж? Тэр хаа ч оршдог. (Энэ ертөнцөд ирэхдээ бас үйл түйтгэртэй болдог уу? Бохирддог уу?). (Бүгд инээлдэв) Бохирдохгүй, энэ ертөнцөд ирэхдээ үйл түйтгэр байдаггүй, бохирддоггүй. (Тэр бас хувилгаан биеэр энэ ертөнцөд ирдэг үү?) Тэр хувилгаан биет Бодьсадва Махасадватай адилгүй, тэр өөрөө хууль дүрэм мөн, өөрийн гэсэн хүч чадал, зөн билиг бүрэн төгс байж, яаж л хувилъя гэвэл тэгж хувилж чаддаг. Гэхдээ зөн билиг, хүч чадал, эрх мэдэл нь хэзээ ямагт оршиж байдаг, энэ талаар энгийн бодьсадватай адилгүй. (Тийм юм бол би ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва болмоор байна), та тийм хүсэлтэй юм байна гэдгийг би мэднэ (Бүгд инээлдэв), гэвч тийм хялбар биш, эхлээд тавдугаар ертөнцөд хүрчих, дараа нь дахин энэ талаар бодоорой.

**Асуулт:** Багш аа. Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва энэ ертөнцөд ирэхдээ эхийн хэвлийгээр дамжиж байж өсөн бойждог уу?

**Их Багш:** Зарим нь тэгдэг, харин бүгдээрээ тэгэх шаардлагагүй, энэ талаараа энгийн бодьсадватай адилгүй (Тэр зөвхөн ажиллахын төлөө л энэ ертөнцөд ирдэг үү?) Тийм, тэд эрх дураараа ирж, буцаж байдаг. (Тэгвэл энгийн бодьсадва ирэхдээ эхлээд заавал хэвлийд орох хэрэгтэй, тийм үү?) Тийм, энгийн бодьсадва эхлээд хэвлийд орох хэрэгтэй, гэтэл Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва тэгэх шаардлагагүй, юунд хувирья гэвэл түүндээ хувирч чадна, хоромхон зуур ялаа, чулуу гэхчилэн болон хувирч чадах бөгөөд энэ чулуу, эсвэл ялааны дотоодод хүч байдаг. Юунд хувирсан ч тэр өөрийгөө ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва гэдгээ бүрэн мэдэж байдаг бөгөөд эрх дураар орших, эсвэл устан арилж, хүнд хувилъя гэвэл хүний дүрстэй болж, нохойд хувилъя гэвэл нохойн дүрстэй болдог. Гэхдээ хувилсан нохой нь энгийн нохой биш байж, үйл түйтгэр гэх юм юу ч байдаггүй, хүн боллоо ч гэсэн өөр хүний үйл түйтгэр халдварлахгүй, нийгэмд бохирлогдохгүй. Юунд хувилсан ч гэлээ түүний ухамсар нь бүрэн дүүрэн сэргэг хэвээр байдаг. Ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва бол хамгийн дээд байр

сууринд байдаг, хамгийн дээд Эзэн Бурхан үнэхээр байгаа бол тэрээр Эзэн Бурханаас жаахан л зөрөөтэй, Эзэн Бурхан бол нэгдүгээр, тэр бол хоёрдугаар ойлгож байна уу?

**Асуулт:** Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва хаана очиж дадлагаждаг вэ?

**Их Багш:** Дээд зэргийн төвшний дасгалжуулалтад суралцдаг (Тэр үргэлж ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва хэвээрээ байх уу? Хамгийн эцэст бас бурхан болдог уу?) Ариун тунгалаг амарлингуй тайван бодьсадва хэвээр байдаг, гэхдээ бурхан болсон ч болно, гэвч тэгэх шаардлагагүй.

**Асуулт:** Багш аа. Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва гаднах орчинд огт сэтгэл татагддаггүй гэж та ярьсан. Хэрвээ ямар нэгэн төрөлтөн хувилгаан биет Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадвагаас аврал эрвэл тусалдаг уу?

**Их Багш:** Тусалдаггүй. (Яагаад тусалдаггүй юм бол?) Учир нь бодьсадва нарын ажил төрөл нь өөр өөр (Гэхдээ тэр ажлынхаа далимаар аварч болохгүй гэж үү!) Аварч юу хийх вэ? Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва хувь хүнтэй хамаагүй, тэр бүхий л орчлонг харж харгалздагаас биш, ганц хоёр хүн, эсвэл хэсэг бүлгийг харгалзахгүй, тэр бодьсадва Махасадватай адилгүй. (Үхэх гэж байгаа хүнийг харвал мөн туслахгүй юу?) Яаж аврах вэ? Та эмч биш бол бусдын өвчнийг эмчилж чадах уу? Тэр тийм ажлыг хийж болохгүй, маш яаруу учир ганц, хоёр хүний үйл хэргийг хамаардаггүй, бүхий л ертөнцийг ч хамаардаггүй, маш яаруу болохоор ганц, хоёрхон хүнийг хамаарах цаг зав байхгүй.

**Асуулт:** Багш аа. Та нэг жишээ ярьж, Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадвагийн сурдаг хатуу дасгалжуулалтын байдлыг тайлбарлаж өгнө үү?

**Их Багш:** Үүнийг ярихын аргагүй, учир нь энэ ертөнцөд тийм дасгалжилтын систем байхгүй. (Бүгд инээлдэв) Тийм дасгалжуулалт нь тамын орноос ч хэцүү бөгөөд зовлонтой, та нар төсөөлөн бодохын ч аргагүй гэж би саяхан ярьчихсан. (Тийм дээд ертөнцөд яагаад бас тийм муу зүйл байдаг юм бэ?) Энэ бол муу хэрэг биш, заавал хийх хэрэгтэй дасгалжуулалт л юм.

**Асуулт:** Хүн бүхэн бүгд л Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва болж болох уу?

**Их Багш:** Үүнийг та өөрөө л сонгоно, сонгогдсоны дараа тэд чамайг аажмаар дасгалжуулна. (Хэн сонгодог вэ?) Ариун тунгалаг амарлингуй тайван Бодьсадва сонгоно, тэр шаардлагагай хүнээ сонгодог бөгөөд бид урьдчилан мэдэх аргагүй, сонгогдсоныхоо дараа л бид мэдэх болно, учир нь ямар нэгэн шалгалт, эсвэл ямар нэгэн зовлонг туулдаг, гэтэл энэ ертөнцөд байгаа та нар сонгогдох боломжгүй, үүнийг багш чинь баталж чадна (Бүгд инээлдэв), эрхбиш тавдугаар ертөнцөд хүрснийхээ дараа дахин ярих хэрэгтэй, гурван ертөнцийг туулсны дараа сонгогдох боломжтой.

## ЭНЭ ЕРТӨНЦӨӨС АНГИЖРАХ ҮЕД БИДНИЙГ ЗӨВХӨН ҮЙЛИЙН ҮР Л ДАГАЛДАНА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Жи Лун*

*(Эх нь хятад хэлээр)*

*1986 оны 12 дугаар сарын 5*

Өнөөдөр бол маш онцгой өдөр, хамаг бодьсадва болон таалал төгссөн энэ гэрийн эзний энэрэл хайранд баярлан талархах зорилгоор Буддын магтаалыг нилээд удаан дууллаа. Ихэнх хүн төрөх, өглөх, өвдөх, үхэхийн зовлонг мэддэггүй, гэтэл цаг нь болохоор бид мэдэх болно. Бурхан Багшийн ярьсан бүхэн бүгд үнэн, хүний амьдрал мөнх бус, төрөх, өглөх, өвдөх, үхэх бол дөрвөн их зовлон, хэн ч зайлахын аргагүй гэж Бурхан багш айлджээ.

Гэтэл бид өдөр бүхэн цаг завгүй ажиллаж, зовлон гэмээр зүйл тохиолддоггүй, тохиолдлоо ч гэсэн удалгүй өнгөрч оддог болохоор мартчихдаг. Хэзээ нэгэн өдөр бидний хамгаас хайртай, хамгаас хүндтэй хүмүүс энэ ертөнцөөс ангижирч, биднээс холдон одох үед ямаршуухан сэтгэгдэл төрдөг бол? Энгийн зовлон бол тийм гүн сэтгэгдэл үлдээдэггүй, удалгүй мартчихдаг. Гэхдээ “Бясалгал хийх хэрэг юу билээ? Тэгж их зовж зүдэрч яах юм? Бурханыг дурсах, бурханд итгэх, ном сонсох, бясалгаж суух гэх зэрэг нь ямар ач тустай билээ?” гэж ярьж ч магад, өнгөн талаас нь харахад хэрэгцээгүй юм шиг ч үнэн хэрэгтээ ач тустай.

Энэ ертөнцөд бид юутай байлаа ч гэсэн нас барах үедээ хамаг юмаа орхиод явна, хамгаас хайртай хүн, хамгаас чухалд үздэг эд хөрөнгө, хамгийн ховор нандин зүйл, тэр бүхнээ авч явж чадахгүй, тэр үед тун ч өнчрөн ганцаардаж, хамт явах дуртай хүн байхгүй, дуртай байлаа ч явж чадахгүй. Жишээ нь: хань ижил маань нас барах үеэр хамт явахыг хүсэвч явж чадахгүй. Бас нэг жишээ нь: эр, эм, эсвэл хос хоёр өнө мөнх хамт амьдрахын төлөө нэг дор амиа хорлодог хэдий ч үхсэнийхээ дараа адилхан замаар явж чаддаггүй, хувь хүний үйлийн үр өөр өөр болохоор нэг нь зүүн тийшээ, нөгөө нь баруун тийш явчихаж ч магад.

Бид бурхны магтаал дуулан бурхан бодьсадваг олон мянган жилээр сайшаан магтсан ч тэдний энэрэл хайрыг хэзээ ч хариулахын аргагүй, бурхан бодьсадва байхгүй бол бид зовлонгоос мултрахын аргагүй, баяр жаргал, эрх чөлөөг хэзээ ч олж чадахгүй. Тиймээс ганц хоёр үг, эсвэл ганц хоёр бадаг дуу, ганц хоёр ёслол мөргөл нь тийм ч хангалттай биш, гэвч бас хангалттай, учир нь түүнийг санан дурсвал хоромхон зуур ч гэсэн хангалттай, бидэнд туслахаар ирнэ гэж Авид Бурхан хэлсэн байна.



Гэсэн ч тийм олон хүн хэдэн арван жилээр бурхныг дурссан байтал нас барах үед нь тэр бүхэнд бурхан туслахаар ирэхгүй байж ч мэднэ, энэ нь дурсан санах хэмжээ нь хангалттай биш байдгаас болсон ч байж мэднэ, эсвэл бурхантай холбогдож чадаагүйгээс шалтгаалдаг. Энгийн үед бид түүний алдар нэрийг дурсаж, алдрыг нь сайшаан магтдаг, гэвч түүний хүчтэй холбогдохгүй бол бидэнд туслахаар ирэхгүй ч байж мэднэ.

Авшиг хүртсэн шавь маань нарын зарим нь одоо нэгэнт нас барсан байна, тэднийг нас барах үеэр бурхан бодьсадва лав туслахаар ирнэ. Авшиг хүртэх үеэр багш чинь бас та нар хожим лавтай ариун оронд мэндэлж чадна гэж ярьсан, та нар тэр нэгэнт нас барсан шавь нарын таалал төгсөх үеийн байдлыг нь харсан бол мэдэж болно, энэ нь сонссон төдий зүйл биш. Сонссон хэрэг явдал бидэнд сэжиг төрүүлж ч магадгүй, харин мэдсэний дараа сэжиг төрөхөө болино. Мэдэх болон сонсох хоёр нь адилгүй, мэдэх болон итгэл төрөх нь мөн л адилгүй, итгэл төрөх нь зууны ерөн хувь байж магад, харин мэдэх нь зууны зуун хувь юм.

Бурхны ном судрыг уншвал, Авид Бурханыг дурсах, бурханд мөргөх, бурханд итгэх гэх мэт байвал энэ ертөнцөөс салсны дараа хэзээд дахин буцаж ирэхгүй, бурхантай хэзээд хамт байх болно гэж Бурхан багш ярьсан байдгийг олж мэднэ. Бурхан багшийн ингэж ярьсанд бид итгэдэг хэдий ч тосохоор ирснийг нь өөрийн биеэр харах шиг үнэн бодитой биш, бурхан биднийг тосохоор ирнэ гэж мэддэг бол бүр ч илүү бат итгэх бөгөөд бурханд бүр ч ихээр баярлан талархаж, итгэл маань улам ч бат болно.

Тайбэй хотын нэг хүн багшаас нь авшиг хүртсэнээс хойш хоёр долоо хоногийн дараа би герман улсад очсон, тэгээд дахин хоёр долоо хоног өнгөрсний дараа тэр нас баржээ. Тухайн үед би Тайваньд байгаагүй боловч тэр нас барах үедээ Арьяабал Бурхан түүнийг тосохоор ирснийг харжээ, гэхдээ тэр үед ухаан нь тун сэргэг байсан болохоор хамаатан садандаа: “Бодьсадва иржээ, Арьяабал Бурхан ирсэн байна” гэж хэлсэн бөгөөд ярьж дууссанаа дараа огт зовлонгүйгээр тун амгалан тайван, баяр баясалтай таалал төгсжээ.

Тиймээс төрөх, өтлөх, өвдөх, үхэх явцад төрөхдөө зовж магад, өтлөхдөө ч гэсэн тун их зовж мэднэ, өвдөх нь яриангүй бүр ч зовууртай, гэтэл “үхэх” нь харин зовууртай ч биш байж мэднэ, гэхдээ бид үхэхийн зовлонгоос зайлсхийж болно, хэрвээ бурхан бодьсадватай холбогдчихвол тун баяртайгаар насан эцэслэх бөгөөд энэ ертөнцөөс салж одох үед бурхан бодьсадвагийн хамгаалалт байвал яг л унтаад дахин сэргэж байгаа шиг өчүүхэн ч зовууртай санагддаггүй бөгөөд амьд байгаа үеэсээ бүр илүү баяр хөөртэй байна.

Авшиг хүртсэн хүмүүс нэгэнт бэлтгэчихсэн байдаг, юунд бэлтгэдэг вэ гэвэл авшиг хүртэх үед багш чинь аль хэдийн үйл түйтгэрийн хүлээсийг нь тайлчихсан байдаг, тиймээс аливааг сэтгэлээр зохиосон гэж хэлдэг, “аливааг сэтгэлээр зохиосон” юм бол сэтгэлээр засан сэлбэх хэрэгтэй, харин үг хэлээр ярьж болохгүй.

Тиймээс ном уламжлах үед багш чинь үг ярьдаггүй, ном

уламжлахаас өмнө та нарт ойлгуулахын тулд л бага зэрэг ярьдаг, гэвч жинхэнээр ном уламжлах үед юу ч ярьдаггүй, учир нь “сэтгэл”-ээр засан сэлбэнэ. Гэхдээ энэ “сэтгэл” нь бас багшийн чинь сэтгэл биш, багшид чинь сэтгэл байдаггүй, багшийн чинь сэтгэл хаа сайгүй оршин байдаг, бурхан бодьсадватай хамт байдаг, гэвч энэ ертөнцөд байдаггүй бөгөөд энэ махан бие биш, багш чинь угаас байдаггүй, “байдаг” гэдэг нь харагддаг болохоор л “байдаг” хэрэг, тэгэхгүй бол угаас хэлбэр дүрсгүй болохоороо байдаггүй юм. Хэрвээ үг хэлээр ярьж илэрхийлэх гэвэл “сэтгэлээр сэтгэлд уламжлах” гэж ярих хэрэгтэй.

Угаас “сэтгэл” гэж байдаггүй, гэвч бас байхгүй гэж хэлж болохгүй, хэрвээ байдаггүй гэвэл ямар ном уламжлах вэ? Гэтэл энэ номыг ярьж чадахгүй, энэ бол дүрсгүй номын бие бөгөөд багшийнх нь ном биш, өнө мөнх оршдог ном, бурхан бодьсадвагийн ном, их багш нарын ном, энэ хүч нь ч багшийн чинь хувь хүний хүч биш, энэ бол арван зүг, гурван цагийн бурхад, арван зүг, гурван цагийн бодьсатва нар багшийн чинь бие цогцосыг ашиглан энэ хүчийг хамаг төрөлтөнд уламжилж байгаа хэрэг билээ. Яг л дууны хуурцаг шиг, эхлээд дууны долгионыг хурааж авсны дараа сонсогчдод дахин дамжуулдаг.

Тиймээс нэг хүн ийм хүч чадалтай гэж ярих нь лавтай үнэн биш, тийм их хүчтэй хүн байдаггүй, энэ бол хувь хүний асуудал биш. Гэвч бясалгал хийгээд ямар нэг дэсэд хүрвэл эгэл хүний “би” нь хоосон болж хувираад “би” нь хоосон, хүн нь ч хоосон болох үеэр бид хамаг бурхан, хамаг бодьсадвагийн дамжуулах хоолой болж, бурхан бодьсадвагийн хүчтэй уусан нэгдэнэ, тэр үеэр та юу хүснэ, түүнийгээ олж, хэнийг ч аварсан болно, зарим хүний үйл түйтгэрийг ариусгаж ч чадна, залбиран даатгах юмуу, ямар нэгэн юм хэрэгцээ шаардлагатай гэж бодох ч хэрэггүй, бодмогц биелэгдэж, тэр ч байтугай эцэс сүүлд нь ямар ч бодол байхгүй болдог. Хүмүүсийг гэтэлгэнэ, гэвч гэтэлгэгдэх хүн байхгүй, гэтэлгэнэ гэх бодол ч байхгүй болж, аливаа бүхэн хоосон болдог хэдий ч аливаа бүхнийг олж чадна.

Тийм хүнийг бид мөр ёсыг олчихсон буюу бурханы хутагт хүрсэн, Их Багш болсон гэх зэргээр нэрлэдэг. Гэтэл тэр өөрөө юу ч боддоггүй, өөрөө Их Багш мөн гэж ч боддоггүй, “би” гэх үзэл бодол огт байдаггүй, бид тийм хүнтэй ойр дотно байвал маш их буянтай болно, учир нь тийм хүн бол нэгэнт “өөрийн” гэх бодол үгүй болж, бурхан бодьсадватай нэг цогц болчихсон, “хувь хүн”-ий үзэл бодол нь бүрмөсөн алга болчихсон байдаг.

Гэтэл энэ ертөнцөд тэр мөн л энгийн хүнтэй адил харагдаж, юм ярих, хоол идэх гэхчилэн энгийн хүнтэй адил үйл хэргийг хийдэг хэдий ч “мэдрэхүй” нь оршдоггүй бөгөөд сүнс нь ч байхгүй болчихсон, тэр бол нэгэн “хувь хүн” биш, тэр байдаггүй, гэвч хаа ч сайгүй байж байдаг, та түүнийг харья гэж боддог л юм бол хаана ч бай илэрч чаддаг. Үүнийг үг хэлээр ойлгомжтой тайлбарлахын аргагүй, учир нь та нарыг буруу ойлгохоос эмээсэн болохоор л бага сага ярьж байгаа хэрэг, миний ярьсныг та нар ойлгосон эсэхийг мэдэхгүй, үг хэлээр үнэхээр ярьж хэлэхийн аргагүй, ярья гэсэн ч тун хялбар биш.

Хүн болгоны үйл түйтгэр даанч их, хэрвээ бурхан бодьсадва хүчээрээ туслахгүй бол бид туулан гэтлэхийн аргагүй бөгөөд дээш гарах боломжгүй. Мэдээж бид өөрсдийн хүчинд найдах нь буруугүй, гэвч авшиг уламжилсны дараа л сая өөрсдийн хүчиндээ найдаж болно, авшиг уламжлагаас өмнө бол өөрийн чинь хүч тийм ч найдвартай биш. Учир нь төрөл болгондоо бид хүн болж амьдарсан болохоор урьдын төрөл төрлийн үйл түйтгэр бидний ард хүлээж байдаг бөгөөд үүнээс гадна бас энэ төрлийн маань тогтсон үйлийн үр болон тэр дороо илрэх үйл түйтгэр бидний мөрөн дээр ачаалаастай байж байдаг.

Үйл түйтгэр бол муу хэрэг үйлдсэний үр дагавар мөн, тиймээс үйл түйтгэр, эсвэл үйлийн үр гэж нэрлэдэг. Муу үйлийн үрийг бидний сэтгэл шингээн авч, бидний дотоодод байгаа зургийн аппарат бичиж тэмдэглэдэг, хожим нь бид үгүйсгэхийн аргагүй болдог, учир нь юу хийсэн ч бүгдийг бичиж тэмдэглэж, шингээгээд авчихсан байдаг. Энгийн дууны хуурцаг нь заримдаа эвдэрч бичиж чадахгүй юмуу, бичсэн дуу нь устаж мэднэ, гэтэл дотоодод байгаа дууны хуурцаг хэзээ ч эвдэрдэггүй болохоор бичсэн зүйлийг нь үгүйсгэхийн аргагүй. Нэгэн хүн хүн болж төрөх үеэр төрөл төрөлдөө хураасан сайн, муу үйлийн үр дагавраа дагуулж ирдэг, үүнийг бид үйл түйтгэр гэж хэлдэг, энэ “урьдын үйл түйтгэр” нь бидний яг ард дагалдаж (наалдчихсан мэт), “тогтсон үйл” нь мөрөн дээр, “тэр дорхноо илрэх үйл түйтгэр” нь бидний өмнө хүлээж байдаг болохоор явж чаддаггүй, эдгээр үйл түйтгэрийг чухам хэзээ болтол бүгдийг төлж дуусгах билээ? Хэзээ ч дуусгаж чадахгүй. Тиймээс бурхан бодьсадва хувилгаан биеэрээ энэ ертөнцөд ирж, биднийг гэтэлгэж, бидэнд тусалж, биднийг авран дээш гаргадаг, тэгэхгүй бол хэзээ ч салж явахын аргагүй.

Мэдээжээр, бурхан бодьсадва хаа сайгүй оршдог хэдий ч бид эрээд олохгүй, харж чадахгүй, учир нь бидний нүд бол махан нүд, хардаг зай хязгаартай, их холдоо л эндээс тэнд байгаа зүйлсийг харж чадна, тэр ч байтугай холыг харах талаар дуранг ч гүйцэхгүй, бурхан бодьсадваг харах талаар бүр хэлэх ч хэрэггүй, бурхан бодьсадва бидний өмнө илэрсэн ч мэдэхийн аргагүй. Хэн ч бай бурхан бодьсадвагаас аврал гуйх болгонд бүгд ирдэг бөгөөд элдэв зүйлийн хэлбэр дүрсээр хувилж ч магад, харин заавал энд байгаа Арьяабал Бурханы хөрөгтэй адил дүрсээр илэрдэг юм биш, гэвч энэ нь мөн бурхан бодьсадвагийн хувилгаан биеийн нэг төрөл юм. Бурхан бодьсадва хувилгаан биеэрээ илрэх үед зарим хүн мэддэггүй, тэгээд буцсаных нь дараа би тийм чин сэтгэлээсээ даатган залбирч байхад бурхан бодьсадва яагаад ирсэнгүй вэ? гэж гомдоллодог, ирдэг шүү! Гэхдээ хэдэн удаа ирснийг нь ч бид мэддэггүй, харж ч чаддаггүй, учир нь Арьяабал бурханыг бид ер нь ийм тийм хувцастай, үс гээгээ ингэж янзалсан байдаг гэх мэтээр өөрийн санаж төсөөлсөн дүрээр илрэхийг хүсэж эрмэлздэг, хэрвээ ийм дүрээр илрэхгүй бол бид таньдаггүй. Гэтэл бид Арьяабал Бурхан “гучин хоёр лагшин дүртэй”, Шагжамуни Бурхан “үй түмэн хувилгаан биетэй”, Авид Бурхан “гэрлээс тоолшгүй олон бурханд илэрч, хязгааргүй олон бодьсадва болон хувилдаг” гэдгийг мартчихжээ. Бурхан бодьсадва бүхэн бүгд л хөрөг зураг дээрхтэйгээ адил дүрсээр харагддаггүй, харин

тун энгийн байдалтай харагдаж ч магадгүй.

“Хотол зохилдогч зүйл”-д: “Хамаг төрөлтнийг гэлэн, гэлэнмаа болж гэтэлгэх хэрэгтэй байвал Арьяабал Бурхан гэлэн, гэлэнмаад хувиран тэднийг гэтэлгэж, увш, увшинз болж гэтэлгэх хэрэгтэй бол увш, увшинзад хувиран тэднийг гэтэлгэдэг, сайд болж гэтэлгэх хэрэгтэй бол Арьяабал Бурхан сайдад хувиран тэднийг гэтэлгэдэг, тэр бас боол буюу луу, тэнгэр, бярман гэх зэрэгт хувиран хамаг төрөлтнийг гэтэлгэдэг” гэж өгүүлсэн байдаг. Тиймээс хэн нь буруу номтон, хэн нь зөв номтон гэдгийг мэдэхийн аргагүй. Хэн ч байлаа гэсэн бидний билгийг нээгдүүлж чадах л юм бол ямар дүр төрхтэй байсан ч хамаагүй бүгд л хувилгаан биет Арьяабал Бурхан мөн.

Мөр ёсыг хайхад хамгийн чухал ёс дүрэм бол бусдыг шүүмжлэхгүй мөртлөө “сэтгэл” нээлттэй, хөгжилтэй байх хэрэгтэй, энэ бол маш чухал хэрэг. Сэтгэл саруул уужим байж, юунд ч дэндүү баригдаж болохгүй, “тэр бол бярман болохоор түүнээс сурахгүй, тэр бол гэрээс гарагч биш болохоор түүний үгийг сонсохгүй, тэр бол гэлэнмаа болохоор түүнээс сурахгүй, заавал гэлэнгээс сурна, учир нь гэлэнмаа ач буянаар гэлэнг гүйцэхгүй” гэх мэтээр бусдыг шүүмжилж болохгүй.

Асуудал нь бидний сэтгэл дэндүү баригдмал, дэндүү давчуу байдаг, харин бурхан бодьсадва тусалдаггүйд байгаа юм биш. Эгэл хүмүүс бусдыг нэвт таньж чаддаггүй, ерөөсөө нэг зүйлийн үзэл баримтлалд баригдаж, багш нар заавал ийм байдалтай байх хэрэгтэй, бодьсадва тийм байдалтай байх хэрэгтэй, бодьсадвагийн хувийн чанар ийм байх хэрэгтэй, үргэлж бал бурам шиг аятай сайхан үг ярих хэрэгтэй гэж үздэг, энэ бол эгэл хүмүүсийн үзэл бодол, үнэн хэрэг дээрээ тийм биш байж ч магадгүй.

Тиймээс эрхбиш “номд найдахаас биш хүмүүст найдахгүй” байх хэрэгтэй, бид ном хайхаар ирсэн, энэ ном, номын ёсыг хайж байгаа болохоор хувь хүний асуудлыг нь битгий хараарай. Бурхан бодьсадва энэ ертөнцөд ирж хүнийг сургахад тун амаргүй байдаг, янз бүрийн номын аргыг ашиглах хэрэгтэй, заримдаа эрхбиш эелдэг зөөлөн аргаар сургаж, хүмүүсийг зоригжуулж, итгэл хүсэлтэй болгож, заримдаа хатуу аргаар хүмүүсийг сэхээрүүлэх хэрэгтэй байдаг.

Учир нь хүн болгоны үйл түйтгэр адилгүй бөгөөд төрөл төрлийн үйл түйтгэр тун их байдаг, “үйл түйтгэр угаас хоосон” гэж багш чинь байнга ярьдаг хэдий ч бид тийм дээд хараахан хүрээгүй, хүмүүсийн тал хагасаас илүү нь архад юмуу, бодьсадвагийн дээд хүрээгүй, бурхны дээд ч хүрээгүй болохоор өөрсдөө үйл түйтгэр байхгүй гэдгээ ойлгох боломжгүй, багшийнхаа ярьсанд итгэдэг ч, магадгүй, та нарын сэтгэл мөн л цэвэр ариун биш, нэгэн үзүүрт сэтгэлээр итгэхийн аргагүй болохоор энэ ертөнцөөс салах үед үйл түйтгэрийн үр дагаврын хүчинд доошоо татагдан доогуур төвшинд унаж, зовлонтой оронд очдог. Бурхан бодьсадва үргэлж гэрэл цацруулан хамаг төрөлтнийг авран дээш гаргадаг хэдий ч бид үйл түйтгэрийнхээ хүчинд доош татагддаг болохоор бурхны хүчийг хүртэхийн аргагүй болдог.

Буддын шашны нууц тарнийн бүлгийн “Жүн ин деду” (Бадам

лянхуагаас төрсөн их багшийн бүтээл) гэдэг номд хүн нас барах үедээ цагаан, хөх, улаан, алтан шаргал, ногоон гэх мэтийн олон өнгийн гэрэл хардаг гэж өгүүлсэн байдаг. Туйлын их гэрэлтэй, туйлын их гялбаатай нь бурхны гэрлийн цацраг юм. Арай уян зөөлөн, бидний нүдэнд нилээд тааламжтай нь асури, бирд, там, хүний төрлийн гэрэл болно. Гэвч бид мэддэггүй болохоороо нас барах үедээ эерүү зөөлөн гэрэл, өнгийг харвал тийшээ дагаад явчихдаг, ингэснээр маш тусгүй хэрэг болж, тэр даруй хүн, асури, бирд, адгуусын төрөл авч, тэнгэр, төгс баясгалант оронд мэндэлж чаддаггүй.

Яагаад гэвэл баатарлаг эр зоригоор дутмаг учир бурхантай ойртоход хялбар биш, бие махбодын хүч нь хүрэлцэхгүй болохоор туйлод их гэрэл, туйлын их гялбаа, асар том хүчийг тэвчиж чаддаггүй, бурхны хүч нүдэнд таагүй байдаг хэдий ч энэ гэрэл бол туулан гэтэлгэх хүчтэй болохоор сүнсийг өнө мөнхийн баяр жаргалтай ариун дагшин оронд тосон аваачдаг.

Гэвч ихэнх хүн нас барах үедээ оюун санаа нь үхмэл байдалд ороод юу ч мэддэггүй, учир нь амьддаа бясалгал хийгээгүй, өөрийн ухамсраа ариусгаагүй, оюун санаагаа ариусгаагүй болохоор нас барах үедээ яахаа мэддэггүй. Их Багш зааж удирдахгүй, бурхан бодьсадва тосохгүй бол сүнс хаашаа яахаа мэддэггүй, тав тухтай газар хармагцаа юуг нь ч бодолгүй тийшээ очдог.

Хүмүүс тав тухтай байдалд дуртай, энэ ертөнцөд ч мөн л адил, гэрэл гялалзсан газар очиж, хөгжилдөн наргих дуртай, тав тухтай байшинд амьдарч, тааламжтай оронд нойрсож, амтат идээ идэх дуртай. Нас барсныхаа дараа мөн л адилхан, тааламжтай газар хармагц тийшээ очдог, гэтэл тааламжтай газар бүхэн хамгийн сайн газар гэж хэлж болохгүй.

Биднийг нас барах үед бурхан бодьсадва бүгд л гэрэл цацруулан тосохоор ирдэг, гэтэл эгэл хүмүүс бурхны гэрлийг тэвчдэггүй болохоор тосоод очиж чаддаггүй. Харин бурхан бодьсадва бидний үйл түйтгэр их байгааг харчихаад нас барах үед тосохоор ирдэггүй юм биш, тосохоор ирдэг бөгөөд хувилгаан биеэрээ ирдэг, гэвч сүнс маань харж чаддаггүй, бурхан бодьсадва гэрэл цацруулан ирдэг боловч бид өөрсдөө тэвчиж чаддаггүй.

Тиймээс хүмүүс амьд байх үедээ бясалгах хэрэгтэй. Бясалгахад эрхи биш бие, хэл, сэтгэл гурван талаар бясалгах хэрэгтэй, энэ гурвын аль нэгийг нь бясалгахгүй бол нас барах үед мөн л үйл түйтгэрт доош татагддаг, бие, хэл, сэтгэл гурвын хоёр нь нэгэнт ариусчихсан ч нөгөө нэгийг нь сайтар бясалгаагүй бол мөн л үйл түйтгэрт доош татагдана. Жишээ нь: “Хэл”-ээ тун сайн бясалгаж, амьддаа бусдыг шүүмжилдэггүй юмуу, сэтгэлийг нь сэвтүүлдэггүй, бусадтай маргаж, хэл ам болдоггүй, ингэснээр хэлний талаар маш ариусаж, хэлний нүгэлгүй болвол, нас барах үедээ хэлний нүглээс болж доош татагдахгүй. Сэтгэлээ бас бясалгаж, “сэтгэл” тун ариун тунгалаг, муу санаа өвөрлөдөггүй бөгөөд бусдыг хорлох гэх мэт зүйлийг боддоггүй бол “сэтгэл” ариуссанд тооцогдоно. Хэл болон сэтгэл хоёр маш сайн хэдий ч биеийн талаар

ариусаж чаддаггүй, яагаад ариусаж чадсангүй вэ? Жишээ нь: мах их идэж, архи уусан болохоор бие махбод ариун биш, бие чинь хэдийгээр ариун биш боловч бурхан ямар ч ялгавргүйгээр мөн л гэрэл цацруулан биднийг аврахаар ирдэг, гэтэл бид нас барах үедээ өвчин эмгэгт ороогдож, дэндүү их архи ууснаас болж, үхмэл байдалд ороод сэргэлэн биш болсон байж мэднэ. Буддын шашны судар номд ч гэсэн архи уугчид энэ төрөлдөө тун олон төвөг бэрх, өвчин зовлонд ороогдох мөртлөө дараа төрөлдөө дахин төрөл авахдаа сэргэлэн биш тэнэг болдог гэж өгүүлсэн байдаг, ийм нөлөө нь зөвхөн энэ төрөлд ч биш, олон төрөл дамжин нөлөөлдөг. Тиймээс бурхны сахилд бурхны шавь бологсад архи ууж болохгүй гэж тогтоожээ. Мах идэх талаар “Линжиа судар” (“Leng-jiā sutra”)-т Шагжамуни Бурхан маш тодорхой ярьсан байдаг. Учир нь мах идвэл үйл түйтгэр их болж, үр дагавар нь тун аюултай, тиймээс Бурхан багш шавь нараа мах идэж болохгүй гэж үүрд хорьжээ. Үүнээс гадна “Баатар явагч их хөлгөн судар”, “Брахмажала судар” (“Brahmajā-lā-sūtra”)-т бас мах идэж болохгүй гэж өгүүлсэн байдаг, өөр бас маш олон сударт энэ талаар бүгдэд нь бага зэрэг дурдсан байна, гэтэл “Линжиа судар”-т хамгаас тодорхой, хамгаас ойлгомжтой ярьжээ, “Баатар явагч их хөлгөн судар” ч мөн адилхан.

Бурхан бодьсадва бидний мах иддэг, эсвэл ургамал хоол иддэг эсэх, үйл түйтгэр нь хэр их гэдгийг тоож хамаардаггүй. Гэвч хэл болон сэтгэлийн талаар л бясалгаж, биеийн талаар бясалгаагүй бол үйл түйтгэр мөн л доош татаж, нас барах үеийн дэсэд нөлөөлнө, учир нь энэ бол байгалийн хууль юм. Мах идэж, архи уувал бие цогцсоо гэмтээнэ, тэгэхээр оюун санаа юмуу, сүнсний талаар ярилгүй, зөвхөн бие махбодын талаар ярьсан ч үр нөлөө нь их билээ.

Нэг хүн нас барах үед бие махбодын өвчин зовлонгоо тэсвэрлэхийн аргагүйдэж, ихэд зовж шаналснаас болоод “сэтгэл”-ээ төвлөрүүлж чаддаггүй. Заримдаа нэг хүн өвчилбөл оюун санаанд нь нөлөөлдөг, заримдаа толгой нь бага зэрэг өвдсөн ч бодож сэтгэх талаараа тийм сайн биш болдог бөгөөд сэтгэл нь төвлөрч чаддаггүй. Эсвэл бие махбод өөр зүйлийн өвчинд нэрвэгдвэл санаа бодол ч сэргэг биш болж, юм ярихдаа ч гэсэн энгийн үеийнх шиг урсам сайхан ярьж чадахгүй болдог, учир нь бодол санаа төвлөрч чадахгүй, нэг талаар арилжаа наймаагаа бодож, нөгөө талаар өвчин зовлонгоо боддог. Тиймээс бие, хэл, сэтгэлээ бүгдийг нь бясалгах хэрэгтэй, гэхдээ маш тодорхой бясалгах хэрэгтэй.

“Цаглашгүй насан хутагт Буддын судар”-т дээд төвшний дээд хэсгээр мэндлэх, доогуур төвшний доод хэсгээр мэндлэх хүртлэх энэ завсар хоорондох зай маш урт байдаг гэж Бурхан Багш ярьсан байдаг. Мэдээж аль аль нь ерөөсөө л төгс баясгалант оронд байгаа хэдий ч хоорондоо маш хол зайтай байдаг, тус сударт бас доогуур төвшний доод хэсгээр мэндлэх хүн тэнд хүрмэгцээ Бурхантай уулзаж чаддаг юм биш, эрхбиш лянхуа цэцгийн дотор амьдарч, урт удаан цаг хугацааг туулж, лянхуа цэцэг дэлгэрэх үеэр л сая бурхныг харж чаддаг, гэхдээ харсан нь зөвхөн бурхны төлөөлөгч төдийхөн байж, жинхэнэ бурхныг харж чаддаггүй гэж өгүүлсэн байдаг. Дээд төвшний дээд хэсгээр мэндэлбэл

Авид бурханыг тэр даруй харж чаддаг. Тиймээс доод төвшний доод хэсгээр мэндлэх болон дээд төвшний дээд хэсэгт мэндлэх хоёрын ялгаа зөрөө тун их юм.

Бясалгадаггүй хүмүүс бол гэрийнхнийхээ бясалгалын буянд найдах юмуу, нэг багшийн хүчинд найдвал бас төгс баясгалант оронд мэндэлж болно, мэдээж энэ багш эрхбиш асар их буянтай байж л сая ингэж чадна, гэхдээ дээд төвшний дээд хэсэгт мэндлэх дээд хүрэхийг нь баталж чадахгүй, жинхэнээр хичээнгүйлэн чармайн бясалгадаг хүмүүс дээд төвшний дээд хэсэгт мэндэлж чадна, тэгэхгүй бол шударга биш болно. Нэг хүн үйл түйтгэрээр тун их байгаа атлаа доогуур төвшний доод хэсэгт мэндэлж чадах нь тун ч азтай хэрэг, бясалгал хийдэггүй хүмүүсийн хувьд заавал ийм буяныг хураасан байх хэрэгтэй, жишээ нь, нэгэн Их Багштай уулзан золгосон, эсвэл хамаатан садан нь бясалгал хийдэг байж л сая төгс баясгалант оронд мэндэлж чадна, тэгэхгүй бол тамд унах юмуу, эсвэл дахин хүний төрөл авч зовлон амсах, тэнэг мунхаг адгуусны төрөл авах гэх мэт зүйл тохионо. Тиймээс төгс баясгалант оронд мэндэлж чадвал дэндүү азтай хэрэг. Бид яагаад дээд төвшний дээд хэсгээр мэндлэх хэрэгтэй вэ, яагаад багшийгаа заавал дагаж, чармайн бясалгах хэрэгтэй вэ гэвэл дээд төвшний дээд хэсэгт мэндлэхийн тулд л юм, дээд төвшний дээд хэсэгт мэндлэх нь ямар ач тустай вэ? Доогуур төвшний доод хэсэгт мэндлэх нь бас төгс баясгалант оронд хүрч чаддаг байтал яагаад заавал дээд төвшний дээд хэсэгт мэндлэх хэрэгтэй юм бэ гэвэл дээд төвшний дээд хэсэгт мэндэлвэл билиг ухаан нээгдэж, даруй бурхан болж чаддаг юм.

Бясалгал хийх нь зөвхөн өөрсдийнхөө төлөө биш, хэрвээ тийм юм бол багш чинь шавь нараа дагуулж дээш гарахад ямар ч асуудалгүй, гэхдээ зөвхөн доогуур төвшний доод хэсгээр мэндэлж л мэднэ, гэвч ингэсэн ч бас тун аюулгүй болчихно, учир нь ингэснээр зовлонгүй, төрөх, өглөх өвдөх, үхэхийн зовлонд өртөхгүй болж, тэнд аажмаар бясалгаж, мянган жил, арван мянган жил, дүнчүүр жил бясалгасан ч болно. Тиймээс бид ганцаараа дээш гарах гэвэл ямар ч асуудалгүй бөгөөд нэг их яарсны хэрэг алга.

Гэтэл зарим хүн ихэд бачимдан машид яарч байгаа билээ, учир нь тэр өөр төрөлтнийг гэтэлгэх хэрэгтэй, хамаг төрөлтний зовлонг хараад өөрөө зовж байгаа юм шиг байдаг болохоор түргэхэн бурханы хутагт хүрье гэж чин сэтгэлээсээ хичээнгүйлэн бясалгадаг. Бурхан болох гэж юуг хэлдэг вэ гэвэл Их Багш (самгарьд хэлээр Buddha гэдэг) болно, их мэдлэгтэн болно, Buddha гэдэг нь ихэд билиг нээгдсэн хүн гэдэг утгатай. Их Багш болсны дараа өөрийн хамаатан саднаа гэтэлгэх төдийгүй тун олон өөр төрөлтнийг гэтэлгэж чадна.

Тиймээс авшиг хүртсэний дараа таван үеэрээ төрөл дэвшдэг, яагаад тэр вэ? “Нэг хүн мөрийг олбоос есөн үеэрээ төрөл дэвшдэг” гэсэн үг байдаг, тиймээс авшиг хүртсэний дараа таван үеэрээ төрөл дэвшинэ гэж багш нь ярьсан хэрэг, дэндүү хольг ярих хэрэггүй, хамгийн багадаа таван үе чинь төрөл дэвшинэ. Үүнээс дээших дөрвөн үеийнхний төрөл дэвших байдал нь тухайн хувь хүний бясалгалын байдлаас тогтоогдоно.

Гэхдээ хамгийн багадаа таван үеэрээ лавтай төрөл дэвшинэ.

Нэг хүн авшиг хүртэсний дараа таван үеэрээ төрөл дэвшиж чаддаг байхад бурханы хутагт хүрсний дараа ямар байхыг та нар төсөөлөн бодоорой. Багшаасаа авшиг хүртсэн болгон таван үеэрээ төрөл дэвшинэ, энэ нь юуг илэрхийлж байгаа вэ гэвэл нэгэн их багш маш олон хүнийг гэтэлгэж чаддаг, гэхдээ нэг хүн гэтлэгдвэл түүний 5 үе нь бүгд төрөл дэвшинэ. Тиймээс маш олон хүн гэтлэгдэнэ гэж ярьдаг. Тиймээс та нар өөрсдөө багш болох нь тун сайн биш үү? Тэгвэл бас маш олон хүнийг гэтэлгэж чадна, харин зөвхөн өөрийн төрөл саднаа гэтэлгэх төдийхөн биш, өөрсдийн дайсан, эсвэл ихэд хорсон заналхийлдэг хүмүүсийг ч гэсэн гэтэлгэх хэрэгтэй, энэ бол үнэн бодит үйл хэрэг мөн. Жишээ нь: зарим хүн багшийгаа гүггэж, багшдаа ихээр хорсдог, багшдаа хэдий чинээ их хорсвол төдий их буянтай болно, учир нь багшдаа хорсох үедээ багшийгаа санаж бодож байдаг, багшийгаа санан дурсахгүйгээр яаж хорсож чадах билээ? Түүнийг санаж, санах тусмаа хорсоно, ингэснээр Их Багшийн буян түүн лүү цалгидаг. Тиймээс хамаг төрөлтнийг гэтэлгэх маш олон номын арга байдаг, зарим хүнд хорсол хэрэгтэй, тэгэхгүй бол чамайг санан дурсахгүй, чамайг санан дурсах үеэрээ буянтай болдог. Учир нь бид нэг хүнийг хайрлах үеэр бодол сэтгэл, толгой тархи, бие махбод бүгд л хайрласан хүн лүүгээ ханддаг, хэн нэгэнд хорсохдоо ч бас л ийм байдаг, тийм үү? үгүй юү? Сэтгэл санаа, толгой тархи маань бүгд л тэр хүмүүст хандаж, хооллохдоо ч тэр, унтахдаа ч тэр мартаж чаддаггүй, тийм үү? үгүй юү? Тийм бол сайн юм байна, хорсох үеэрээ санан дурсана, санаж дурсахлаар буянтай болно, хэн нэг хүнийг санаж дурсвал түүнд нөлөөлнө.

Бурхан бодьсадва маш олон номын аргаар хүмүүсийг гэтэлгэдэг, заримыг нь хайраар, заримыг нь хорслоор, заримыг нь сайшаан зоригжуулж, эелдэг зөөлөн үгээр ухааруулж, заримыг нь зэмлэн буруушааж байж занал хорсол төрүүлнэ, чамайг зүрхээ эмзэглэтэл бодно, ингэснээр бас буянтай болдог. Тиймээс бурхан бодьсадва заавал еелдэг зөөлөн байх хэрэгтэй биш, “номд найдахаас биш хүмүүст найдахгүй” гэдэг нь ийм утгатай.

Гэтэл эгэл хүмүүс бусдыг сайн таньж чаддаггүй, хэн нэг хүн биднийг дагуулж төгс баясгалант оронд хүрч чадна гэдгийг сонссон мөртлөө бидэнд бага сага нотолгоо харуулж чадах чадвар байж гэмээнэ л сая түүнд итгэдэг, тэгэхгүй бол түүнийг чухамдаа бурхан мөн эсхийг яаж гэрчилж чадах билээ? Учир нь бид эгэл хүмүүс болохоор бусдыг сайн таньж чаддаггүй. Гэвч өөрийн шууд мэдрэмжээрээ, зургаа дахь мэдрэмжээрээ сэрж мэдэж болох бөгөөд хэн нь нилээд онцгой, хэн нь дэмий гэдгийг мэдэрч чаддаг, тийм үү? үгүй юү? Ярьсан зүйлийн агуулгыг нь сонсоод хүнийг нь харахаар бага зэрэг ойлгож болно.

Одоо энд ном сонсож байгаа хүмүүсийн дунд зарим нь багшийнх нь ярьж байгаа сургаал ёсонд дургүй хүн байж ч мэднэ, яагаад гэвэл багш чинь мах идэж, архи ууж болохгүй гэж ярьдаг болохоор дургүй нь хүрдэг, үнэн хэрэгтээ үүнийг багш чинь ярьсан биш, харин Бурхан Багш “Линжиа судар”, “Баатар явагч их хөлгөн судар”, “Брахмажала



судар” гэсэн гурван сударт энэ тухай дурьдсан байдаг. Хятадад “Хамаг төрөлтний амийг хороохгүй бол дэлхий дахинд дайн дажин гэж хаанаас байх вэ?” гэсэн үг байдаг, үүнийг хэн хэлснийг би мэдэхгүй, гэвч энэ үг тун алдартай.

Тиймээс багшдаа хорсох хэрэггүй, дургүй хүрч болохгүй, учир нь багшийн чинь ярьсан бүхэн үнэн, мах идэж, архи ууж болохгүй гэдэг нь эрт дээр үеийн богд гэгээнтний ярьсантай бүгд адилхан, Шагжамуни Бурхан, Есүс Христ болон хятадын болон дэлхийн бусад улс орны эрт дээр үеийн богд гэгээнтэн бүгд л адилхан зүйлийг өгүүлжээ, харин багш чинь одоо л ингэж ярьж байгаа юм биш, би зөвхөн өмнөх үеийн хүмүүсийн ярьснаас сурсан, эрт дээр үеийн богд гэгээнтнүүдийн өгүүлснээс үзээд эртний хүмүүсийн ном судрыг уншсаныхаа дараа та нарт хэлж ярьж байгаа билээ, хэрвээ дургүй бол бас хамаагүй, юу ч бодох хэрэггүй.

Багш чинь бас ихэнх хүний адил та нарт ертөнцийн жаргалыг эдлэхийг сургаж чадна, мах идэж, архи уусан ч болно, нас барах үеэр Авид Бурхан тосохоор ирнэ шүү гэж хэлэх тун дуртай, ингэх нь миний хувьд бүр ч хялбар бөгөөд төвөггүй. Яг л та нарын мэддэгчлэн ертөнцийн хүмүүсийн ихэнх нь жаргаж цэнгэх дуртай, ихэд идэж уух дуртай, миний одоо ярьж байгаа сургаал ёс нь тэдний дур таашаалын яг эсрэг болохоор мэдээж дургүй нь хүрнэ. Гэвч бясалгагч хүн эрхбиш үнэн үг ярих хэрэгтэй, өөрөө эхлээд бясалгах хэрэгтэй, “үйл ажиллагаагаа хянан засах” хэрэгтэй, өөрөө бясалгаж байж амжилтанд хүрсний дараа л сая өөр хүний бясалгалд тусалж чадна, тэгэхгүй бол гэрээс гарсан ч ямар ч хэрэггүй.

Бясалгагч хүн өөр хүний дуртай эсэхээс хамааралгүй мэдэхийнхээ хэрээр л ярих хэрэгтэй, гэхдээ үнэн үг ярих нь бясалгагч хүнд байвал зохих үүрэг хариуцлага юм. Багш чинь хэрвээ бусдын дур хүслийг татах гэсэн бол тийм хатуу аргаар сургах хэрэг юу билээ? Маш олон номын багш юмуу, багш шиг, тэд тун олон шавьтай, учир нь тэд тийм олон зүйл ярьдаггүй, тун амархан, та юу хийх дуртай бол түүнийгээ хийж болно, тэгээд онцгой зүйл сургадаггүй, ингэх нь яршиг төвөг багатай бөгөөд хүмүүс баярлаж талархана, тэдний ажил төрөл нь ийм байж ч магад, гэтэл миний ажил бол нилээд онцгой, заавал үнэн бодит зүйлийг л ярих ёстой байдаг.

Католик шашны Библи сударт мах идэж, архи уудаг хүнтэй битгий хамт байгаарай, цуст идээг битгий идээрэй гэж өгүүлсэн байдаг, гэтэл зарим католик шашинтан Библи судрыг хайнга уншиж, утга санааг нь сайн ойлгодоггүй. Буддын шашинтан мөн л адилхан, бурхны судрыг сайтар судлан уншдаггүй, ихэнх бясалгагч “Баатар явагч их хөлгөн судар”-т дуртай байдгийн шалтгаан нь энэ судар бол бясалгагч хүний хувьд хамгаас чухал судар юм. Гэсэн ч уншихдаа мөн л хайнга уншиж, Бурхан багш яагаад мах идэж болохгүй гэж хэлсэн байдгийг сайн судалдаггүй, энэ тухай ярьсан хэсгийг нь маш түргэн уншаад өнгөрчихдөг.

“Линжиа судар” бол Бодьдармаа хятадад уламжилсан нэгэн боть

маш чухал судар, маш олон хүн Бодьдармаад дуртай байж, хамгаас чухал, хамгаас алдартай гэж үздэг, тэр бол хятадын даяаны хамгийн анхны номын багш. Гэтэл хүмүүс уг судрыг уншихдаа мөн л хайнга уншиж, мах идэх тухай ярьсан хэсгийг нь огт уншдаггүй бөгөөд юу ярьсныг нь ойлгодоггүй. Тэгээд эртний хэл гүн нууцлаг, ойлгоход бэрх гэж шалтагладаг, үнэн хэрэгтээ эртний хэл бас тийм ч хэцүү биш, яагаад ойлгодоггүй билээ? Үнэндээ тэд өөрсдөө ойлгохыг боддоггүй, тогтоохыг хүсдэггүй. Тиймээс багш чинь байнга сануулж, ахин дахин ярих ёстой, гэхдээ шинэ зүйл яриагүй, бүгд л эрт дээр үеийн сургаал ёс, бүгд Бурхан багш, Есүс Христийн ярьж байсан сургаал номлол, Хүй Нэн, Бодьдармаа, Бай жан нарын ярьсан зүйл, нэгэн Их Багш гарч ирэх болгондоо бүгд л адилхан сургаалыг номлодог, одоо багш чинь дахин яримааргүй байна, яривал зохих чухал зүйлийг Их Багш нар бүгдийг нь ярьчихжээ, ийм байтал хамаг төрөлтөн мөн л сонсдоггүй. Хүмүүс гэж ийм л байдаг, хичнээн удаа уншлаа ч гэсэн ойлгохыг хүсдэггүй бөгөөд сэтгэлдээ тогтоох дургүй, хэдэн удаа сонсчихсон байтлаа мөн л мартчихдаг болохоор ахин дахин ярих хэрэгтэй, гэхдээ бүгд л адилхан зүйлийг ярьдаг юм.

Хэрвээ хэн нэг хүн бясалгах дургүй бол юу хийсэн ч болно. Гэтэл төгс төгөлдөр, эрхэм сайхан болох хүсэлтэй бол хамаг Бурхан, хамаг Бодьсадва, Есүс Христэй адил аргаар, эрт дээр үеийн их багш нартай адилхан номын аргаар бясалгах ёстой. Зургадугаар үеийн өвгө багш Хүй Нэн “Ном эрдэнэ мандал судар”-т: тэр анчидтай хамт амьдарч байсан ч мах иддэггүй, яагаад мах иддэггүй юм бэ гэж хүмүүс асуухаар нь ходоод гэдэс маань архаг өвчтэй болохоор махыг шингээж чаддаггүй гэж хариулдаг гэж бичсэн байдаг. Хүй Нэн бол алдар хүндтэй нэгэн даяанч, хятадад хамгийн их нэрд гарсан даяанч болохыг та нар мэднэ, тэр нэгэнт бүрмөсөн билиг нээгдчихсэн мөртлөө бас мах идэж зүрхлэхгүй байжээ. Тиймээс та нар багшдаа мах идсэн ч бясалгаж болно гэж битгий яриарай. Ямар бясалгал хийх хэрэг вэ? Тийм хүн Хүй Нэн Багшийн бясалгалын дэсэд хавьтаж ч чадахгүй байтлаа яагаад мах идэж зүрхэлдэг хэрэг вэ? Хүй Нэн тухайн үед аль хэдийн багшийнхаа орхимж болон бадар аягыг залгамжилж, зургадугаар үеийн өвгө Багш, асар их хүчтэй Их Багш болчихсон хэдий ч мөн л “баригдахгүй” байж зүрхлэхгүй байсан бөгөөд мах идэх болон идэхгүй нь адилхан гэж хэлж зориглохгүй байжээ.

Гэтэл зарим хүн сүнслэг дадал бясалгал хийхэд багшдаа баригдаж болохгүй, мах идэх болон идэхгүй байх нь адилхан, аливааж сэтгэлээр зохиодог гэж ярьдаг. Тэр өөрөө сэтгэл гэгч юу юм, сэтгэл яаж зохиодгийг ойлгодоггүй. Зургадугаар үеийн Өвгө Багш Хүй Нэн ярьж зүрхлэхгүй, Шагжамуни Будда бурханы хутагт хүрсэн байтлаа ярьж зүрхлэхгүй байхад бидэн шиг энгийн хүн яагаад бясалгагч хүн мах идэх, мах идэхгүй талаараа баригдаж болохгүй, аливааж сэтгэлээр зохиосон гэж ярьж зүрхлэнэ вэ? Олон хүн багшид чинь ингэж ярихаар би аргагүйдээ толгой сэгсрэх хэрэг гардаг. Миний шавь нарын дунд бас ийм хүмүүс байдаг бөгөөд өөрийгөө бясалгалаар маш өндөр дэсэд хүрсэн гэж боддог, энэ багшийн санаа бодол дэндүү хуучин, цаг үеэсээ хоцорсон,

дэндүү баригдмал байна гэж элэг барьдаг. Хүмүүс дэндүү омгорхог сагсуу, омгорхог зан бол бидний хамгаас хүнд үйл түйтгэр, хамгийн их харш саад билээ. Нэг хүн тун олон гэм буруу гаргаж болно, эсвэл маш олон төрөлтний амийг хөнөөсөн ч байж мэднэ, угаас туйлын харанхуй мунхагаасаа болж муу хэрэг их үйлддэг, гэсэн ч алдаа буруугаа хоромхон зуур ч атугай харамсан гэмших юмуу, бясалгал хийх бодол төрдөг л юм бол бурхан бодьсадва асар их хүчээрээ тусалж, тэр хүний төрөл төрлийн үйл түйтгэрийг нь угаан цэвэрлэдэг юм шүү.

Авшиг уламжлах үеэр урьдын олон төрлийн үйл түйтгэрийг бүгдийг нь угаан цэвэрлэж, ямар ч үйл түйтгэр үлдээлгүй ариусгадаг, үүнийг би бурхан бодьсадвагийн өмнө та нарт баталж чадна. Гэтэл харин омгорхог бардам зантай хүний үйл түйтгэрийг ариусгаж чадахгүй, бардам хандлагатай байх нь яг л эхлээд маш зузаан хэрэм босгочихоод өөрийгөө хүрээлчихсэн юм шиг байдаг, бурхан бодьсадвагийн адислах хүч энэ хэрмийг нь нэвтлэхэд тун бэрх. Ихэнх хүн тийм ч их бясалгаагүй байтлаа харин бясалгахад баригдаж болохгүй гэж ярьж явдаг, ингэж ярьж зүрхэлдэг Их Багш байдгийг ерөөсөө ч сонсоогүй. Шагжамуни Бурхан мах идэж зүрхлэхгүй байгаа бол бид ч бас идэж болохгүй. Бид өөрийгөө бурхны шашинтан гэж нэрлэдэг бол Шагжамуни Бурханы сургаалыг сахиж хэрэгтэй, тэр ном судартаа: “Ямар ч нөхцөл байдалд ч гэсэн бид мах идэж болохгүй, бодьсадвагийн нигүүлсэнгүй сэтгэлээс суралцаж, бурханы хутагт хүрэхийг хүсдэг бол хаана ч бай, хэзээ ч бай бүгд мах идэж болохгүй” гэж тодорхой хэлжээ, ийм байхад бид мах идэж яаж зүрхлэх билээ?

Хүй Нэн Багш ч гэсэн тийм төвөг бэрхшээлтэй нөхцөл байдалд байхдаа мөн л мах идэж зүрхлээгүй байхад бид идэж зүрхлэж яаж болох вэ? Гэтэл зарим хүн дөнгөж эхлэн бясалгаж байгаа мөртлөө “баригдаж болохгүй” гэж онгирдог, нэгэн харанхуй мунхаг, бясалгадаггүй хүн, бурхны сургаал ёсыг огт ойлгохгүй хүн ингэж ярьж байгаа бол бас уучлан өршөөж болно. Гэтэл нэгэнт бясалгагч болчихсон бөгөөд багш нь байнга зааж сургасаар байхад мөн л ийм юм ярих нь үнэхээр өр өвдмөөр хэрэг, учир нь би гэх үзлээр дэндүү их, дэндүү бардам болчихжээ.

Бага зэрэг баригдахад хамаагүй, “баригдах”-гүй гэх нь харин төвөгтэй хэрэг. Үйлийн үр гэж юу вэ гэдгийг өөрөө ойлгохгүй, үйл үрээс давчихсан дээд дэсэд хүрээгүй байх үедээ бага зэрэг баригдаж, ном судрын ёсоор бясалгах нь хамгийн сайн. Багшийнхаа ярьсныг алдаа буруутай байж магад гэж санаа зовж байвал заавал сонсох албагүй, гэвч та нар ном судрыг өөрөө уншиж болно, Бурхан багш, Есүс Христ болон богд гэгээнтнүүд юу ярьсныг уншаад түүнийг дагаж бясалгаж болно.

Хүний биеийг олсныгоо яасан ч дэмий хоосон талаар өнгөрөөж болохгүй, хүний биеийг алдвал дараа дахин олж чадах эсэхийг хэн ч мэдэхгүй. Тэнгэрийн төрөлтөн болсон ч тийм их ач тусгүй, диваажин хэдийгээр энэ ертөнцөөс баяр жаргалтай байдаг ч бясалгахад амаргүй, яагаад гэвэл хүний биегүй бол бясалгаж чадахгүй, тэнгэрийн буянаа эдэлж дуусахаар дахин энэ ертөнцөд унаад хорхой шавж болчихож ч мэднэ.

Урьд нь Энэтхэгийн нэгэн Их Багш шавьтайгаа нэг улс оронд хүрчээ, тэгээд нэг чийгийн улаан хорхой байхыг хараад: “Энэ чийгийн улаан хорхой (Sakro devānām indrah) саяхан Түшигт тэнгэрийн орноос унасан юм шүү дээ” гэж шавьдаа хэлжээ. Саяхан Түшигт тэнгэрт байснаа одоо унаж ирээд чийгийн улаан хорхой болжээ, ийм юм чинь сайн гэмээр юу байх вэ дээ? Тэнгэрийн төрөлтний буян дуусах үед таван зүйлийн муу илрэл үүсэж, ихэд зовж шаналдаг гэж ном сударт өгүүлсэн байдаг. Энгийн хүмүүс нас барах үедээ мөн л ихэд зовдог ч наад зах нь дараа чухам хаана төрөл авахаа харж чаддаггүй.

Эгэл хүмүүсийн ихэнх нь харанхуй мунхаг, үйл түйтгэр их болохоор нас барсны дараа даруй тамд унаж, энэ ертөнцөд хоромхон зуур ч үлдэж чаддаггүй, үйл түйтгэр их бол биеэсээ салсан сүнс нь замаа алдаж, хаа сайгүй тэнэж, чухам хаана дахин төрөл авахаа мэддэггүй. Тэгээд сансрын хүрдэнд эргэлдэх цаг нь болох үеэр л дахин төрөл авдаг, гэхдээ хүний төрөл авах, амьтан болох, эсвэл бирд болохоо мэддэггүй. Буян ихтэй хүнийг нас барах үед бурхан бодьсадва даруй тосохоор ирдэг, гэвч ийм байдал маш цөөн тохиолдоно, бурхан бодьсадва тийм хялбархан тосохоор ирж чаддаг бол энэ ертөнцийн хүн ам ийм ихээр нэмэгдэх боломжгүй болно шүү дээ.

Бурхныг дурсдаг хүн улам нэмэгдэж байхад хүн ам яагаад улам олон болоод байгаа билээ гэвэл буруу аргаар дурсдаг, үнэн сэтгэлээсээ дурсдаггүй болохоор бурхан бодьсадватай холбогдож чаддаггүй. Яг л телефон утсаар холбогдохтой адил, хоёр этгээд хоёулаа телефон утастай байгаа хэдий ч утасны дугаарыг нь мэдэхгүй бол харилцан дуу дуугаа сонсож чадахгүй, харилцан холбогдож чадахгүй болохоор ямар ч ач тусгүй.

Тиймээс хүний төрөл олж энэ бие цогцостой болсон нь тун эрхэм нандин зүйл. Энэ талаар Шагжамуни Бурхан нэг зүйрлэл хэлсэн байдаг нь, хүний биеийг олж төрөх нь яг л гүн далайд байгаа нэг сохор яст мэлхий зуун жилд нэг удаа далайн гүнээс хөвөн гарч ирэхтэй зэрэгцэн нэг модон хавтас мөн л зуун жилд нэг удаа хөвөн өнгөрөхтэй тааралдаж, энэ сохор яст мэлхий хөвөн гарч ирэхдээ тэр модон хавтасны нүхээр нэвтлэн гарах ёстой байдагтай адил ховорхон тохиолдол мөн гэжээ. Хүн болох нь ийм ховор нандин, тийм амаргүй, учир нь хүн болж байж л бурханы хутагт хүрч чаддаг. Тэнгэрийн төрөлтөн юмуу, өөр төрөлтөн болчихвол бурхан болж чаддаггүй, тиймээс хүний биеийг олох нь тун ховор нандин тохиолдол юм. Хэрвээ яаж бясалгахаа мэдчихвэл хүн бүхэн бүгд л бурхан болж чадна. Яаж бясалгахаа мэдэхгүй бол хүний биеийг олчихсон ч ямар ч ач тусгүй.

Төрөл болгондоо дахин хүн болж заяавал бурхан болж чадах аз тохиолтой болдог, гэвч хүний төрөл авах болгондоо үргэлж л маш олон харш саадтай учирч, адын саадад ихэд хүрээлэгдэж, гэгээрсэн бясалгалгагчтай уулзахын аргагүй, дээд зэргийн бясалгалын аргыг мэдэх аргагүй болдог. Тиймээс туулан гэтэлж чадахгүй байдаг нь үнэхээр харамсмаар хэрэг билээ. Гэгээрсэн бясалгалгагчтай уулзлаа ч гэсэн мөн л сэжиг төрөх хандлагатай болж, заавар зааварчилгаанд нь тэр даруй итгэж

чаддаггүй, гэсэн ч гэгээрсэн бясалгагчтай уулзах нь ер нь уулзаагүйгээс илүү сайн, учир нь ямар байлаа ч гэсэн түүний нөлөөгөөр буяны үр бага сага олж, хэзээ нэгэн цагт энэ үрээ хэрэглэх хүсэлтэй болох үедээ даруй ашиглаж болно. Гэтэл гэгээрсэн бясалгагч зөвхөн буяны үр өгдөг төдий, харин бид ашиглах гэвэл эрхбиш өөрсдөө үрээ тарьж, өдөр бүр усалж харж хандах хэрэгтэй. Яг л хүн бидэнд жүржийн үр өгсөн байхад тарих ч үгүй, услах ч үгүй бол жүржийн мод ургах боломжгүйтэй адил, харин хэзээ нэгэн цагт жүржийн үрээ тарьж, өдөр бүр усалдаг л юм бол жүржийн мод ургаж чадна.

Энэ нь яг л гэгээрсэн бясалгагчийн буяныг хүртэхтэй адил, түүнд итгэх, эсвэл сэжиг төрөхийн аль нь байсан хамаагүй тэрээр биднийг адислаж, өөрийн дэс, хүч чадал, буян хишгээ өгдөг. Жишээ нь: бид үнэртэй усны дэлгүүрт ороод юу ч худалдан аваагүй байсан ч дэлгүүрийн ажилтан бидний биед үнэртэй усаа туршиж үзэхээр бага зэрэг цацдаг, ингэснээр бидний биеэс ч анхилам үнэр сэнгэнэх болно. Бас нэг жишээ нь, бид хүрхрээний ойр очвол хүрхрээний доорх усанд орохгүй ч гэсэн ус бидний бие дээр сүрчигдэн түсрэгдэж, хувцас норж, сэрүүн тааламжтай санагдана.

**Асуулт:** Тэнгэрийн төрөлтөн болон бурхны төвшин хоёр ямар ялгаа зөрөөтэй вэ?

**Их Багш:** Тун их зөрөөтэй. Тэнгэрийн төрөлтний дэс нь очсоныхоо дараа заавал буцаж ирэх хэрэгтэй байдаг, тэнд үлдэж болдоггүй. Бурхны төвшинд хүрвэл дахин буцаж ирэхгүй, буцаж ирье гэвэл бас болно, ирэхгүй байж ч болно. Тэнгэрийн төрөлтөн цаг нь болж, буянаа эдэлж дуусах үедээ энэ ертөнцөд заавал буцаж ирэх ёстой байдаг. Тэнгэрийн төвшин бол гурван ертөнцийн дотор, үхэж, төрөх сансрын хүрдэн дотор байдаг. Бурханы төвшин бол гурван ертөнцөөс дээш, үхэж, төрөх сансрын хүрднээс гадна байдаг, тиймээс энэ хоёрын зөрөө тун их.

Түшигт тэнгэрийн төрөлтөн ч гэсэн унаж ирээд чийгийн улаан хорхой болдог гэж би саяхан ярьсан, гэвч бурхан бодьсадва тэгэх боломжгүй. Бурханы хутагт хүрсний дараа өөрсдөө хамаг төрөлтнийг гэтэлгэхээр буцаж ирнэ гэж андгайлсанаас бусад нь энэ ертөнцөд хэзээ ч дахин буцаж ирэхгүй, үхэж төрөхийн сансрын хүрднээс үүрд ангижирдаг, андгай өргөн бууж ирээд хамаг төрөлтнийг гэтэлгэхийн шалтгаан нь хамаг төрөлтнийг гаслант ертөнцөд зовж шаналахыг харж сэтгэл түвдэхгүйгээс болдог.

**Асуулт:** Үйлийн үр устдаггүй гэдэг нь буддын шашны сургаал ёс, гэтэл багш ярихдаа дээд төвшинд үйл түйтгэр ер байдаггүй гэсэн байна, үйл түйтгэр угаас хоосон бөгөөд үйлийн үр устдаггүй гэдэг нь өөр төвшинд харьяалагддаг, энэ талаар би тийм ч сайн мэдэхгүй, багш та жаахан ярьж бидэнд ойлгуулахсан болов уу?

**Их Багш:** Үйл байвал лав үртэй болно, үйл үгүй бол үр ч үгүй гэж ярьж болохгүй, энэ ертөнцөд үйл байдаг бөгөөд үр ч байдаг, үйлийн үргүй бол энэ ертөнц оршин байж чадахгүй.

Үйлийн үрийг тун амархан харж болно, жишээлбэл, энэ ертөнцөд та хүн зодвол нөгөө хүн чинь лав таныг зодъё гэж бодно, тэр ч байтугай

үнэхээр зодож ч мэднэ, энэ бол үйлийн үр мөн. Та жүржийн үр тарьвал мэдгээ жүржийн мод ургана, энэ бол үйлийн үр мөн. Та ажил хийвэл мөнгөтэй болно, хийхгүй бол өлсөж үхэхэд хүрнэ, энэ бол бас л үйлийн үр мөн, гэхдээ бүгдийг нь тун түргэн харж чадна. Гэрлэвэл лавтай нэг эхнэртэй болно, гэрлэхгүй бол эхнэргүй, тун амархан. Муу хэрэг хийвэл муугаар нөлөөлж, сайн хэрэг хийвэл мэдээжээр сайнаар нөлөөлнө, энэ нь мөн л үйлийн үр, гэвч эдгээр нь бүгд л гурван ертөнцийн доторх үйлийн үр юм.

Бид угаас эгэл хүмүүс биш, энгийн хүн ч биш, өөрсдийгөө энгийн хүн гэж үздэг болохоор л эгэл энгийн хүмүүс болчихдог, өөрсдийгөө эгэл хүмүүс гэж боддог бол бид хэзээ ч бурхан болж чадахгүй. Элсийг чанаад чанаад хоол болгож чадахгүй, элс бол элс, хоол бол хоол, будааг боловсруулахаас өмнө элстэй адил, чулуу шиг хав хатуу бөгөөд гадуураа бүрхүүл хальстай хэдий ч хальснаас нь салгаж боловсруулсны дараа чанавал хоол болчихдог. Гэтэл элсийг чанах, хуурах, шарах, эсвэл тээрэмдээд нунтаг болгосон ч мөн л элс хэвээрээ, хэзээ ч будааны нунтаг болж чадахгүй. Үүний эсрэгээр хоолыг яаж ч чанасан хэзээд хоол хэвээрээ, будааг нунтагласан ч идэж болно, харин элсийг нунтаг болгосон ч идэж болохгүй.

Тиймээс багш чинь хэдийгээр та нар угаас бурхан мөн гэж хэлдэг ч итгэдэггүй, учир нь цаг нь болоогүй бөгөөд өөрсдөө угаасаа бурхан мөн гэдэгтэй итгэх тэр дэсэд хүрээгүй байна. Гэсэн ч бид бол эгэл хүмүүс биш, энэ бие цогцос ч гэсэн тийм энгийн биш гэж би баттай хэлж чадна. Энэ бие цогцос бол тун нууцлаг, тос нэмэх хэрэггүй, юу ч хийх шаардлагагүй боловч зүрх чинь өдөр бүр цохилон хэлээрээ өдөр бүр элдэв зүйлийн амтыг амталж, исгэлэн, чихэрлэг, гашуун, шорвог, хүйтэн, халуун гэхчилэн ялгаж чаддаг. Хүний биеийн эдгээр эрхтэн яагаад тийм их гайхалтай чадвартай байдаг вэ гэвэл бид билиг ухаантай, билиг барамидтай, гэтэл зарим энгийн хүн энэ ертөнцөд байхдаа бясалгал хийдэггүй, буян хишгээр бага болохоор билиг барамиддаа тийм ихээр ашиглаж чаддаггүй, зөвхөн тун багаханьг, чадварынхаа багахан хэсгийг л ашигладаг. Юуг ч бүгдийг мэдэж, бүгдийг ойлгож чаддаг нь гүн билиг ухаан юм. Хүн төрөлхтөн одоо билиг ухааныхаа өчүүхэн хэсгийг ашиглаж байгаа хэдий ч нэгэнт тийм ихийг мэдэж, тийрэлтэт сум хийж, саран дээр очиж, хиймэл дагуул, сансарт хөлөг нисгэж, дэлхийн бөмбөрцгийг тойрон зугаалж, нисэх онгоц, галт тэрэг, шумбагч онгоц зохиож бүтээсэн гэх зэрэг маш олон үйл хэрэг хийж чаддаг. Ийм өчүүхэн, энгийн билиг ухаанаар нэгэнт ийм олон зүйл бүтээж чадсан юм чинь өөрсдийнхөө хамгийн дээд билиг ухаанаа хайж олбол ямаршуухан болдог бол? Бид бол эгэл хүмүүс биш, бид бол үлэмж их билиг, үлэмж их ухаанаас төрсөн, бурхны орноос ирсэн билээ. Тэгээд энд ирсний дараа маш олон эд зүйлд сагааран чадвараа ашиглаж чаддаггүй. Яг л хуурай газар амьдардаг хүн далайд орсны дараа өөрийн чадвараа бүрэн дүүрэн хэрэглэж чадахгүй болчихдогтой адил, учир нь бид угаас усанд амьдардаг биш болохоор хүчилтөрөгчийн хоолой, шумбагчийн хувцас мэтийн багаж хэрэгсэл ашиглах хэрэгтэй. Багаж хэрэгсэл бүрэн байлаа

ч чадвараа мөн л бүрэн ашиглаж чаддаггүй бөгөөд хуурай газар байгаа шиг эрх дураар хэрэглэж чадахгүй.

Үүнтэй адил, бид бурхны орноос энэ ертөнцөд ирсэн нь туршлага хайж, туршлагад суралцахын төлөө, өөрсдөд маань ямар далдын хүч байгааг таньж мэдэхийн тулд юм. Бурхны оронд бид бурхан мөн гэдэг нь буруу биш, гэвч ямар ч ач тусгүй, яагаад гэвэл бидэнд ямар чадвар, ямар хүч, ямар билиг ухаан байгааг мэддэггүй, бурхны оронд тэдгээр чадварыг хэрэглэх шаардлагагүй болохоор хүн, тэнгэр, амьтан болох хэрэгтэй, наян дөрвөн мянган төрлийн төрөлтөн болж туршлагад суралцдаг нь билиг ухаанаа хэр их, яаж ашиглахаа ойлгохын тулд юм. Тэгэхгүй бол хүн болсны хэрэг юу билээ? Хүн болох нь тун ач тустай, хүн болж дууссаны дараа гэртээ буцаж бурхан болно, тэр үед гүн билиг ухаантай бурхан болж, өөрийн бурхнаа таних болно.

Урьд нь бурхан байхдаа бурхан гэдгээ мэддэггүй, өөрийгөө ямар хүн болохоо ч мэддэггүй байжээ. Бурхан угаас хов хоосон, ирдэггүй бөгөөд буцдаггүй, юунд ч сэтгэл татагддаггүй, гэвч үүнийгээ хүн болсны дараа л мэдэж чаддаг болохоор нилээд ач тустай. Бид бурхнаас төрсөн, хожим мөн л бурхан болно, хүнээс бурхан болж байж л сая бурхныг жинхэнээр нь ойлгож чадна. Угаасаа нэгэнт бурхан байсан, тийм биш бол яаж ч бясалгалаа гэсэн бурхан болж чадахгүй, учир нь элсийг чанаад хоол болгож чадахгүй. Бид угаас эгэл хүмүүс биш болохоор үйл түйтгэргүй гэж хэлдэг, бурхан яагаад үйл түйтгэртэй байж болох билээ? Үйл түйтгэр нь бүгд хуурмаг зүйл.

Бид яг л жүжиг тоглодогтой адил, угаас энгийн хүмүүс байтлаа жүжигт тоглох үедээ эрхбиш янз бүрийн дүрд тоглох хэрэгтэй болно, муу хүн, сайн хүн, хаан, дээрэмчин, хүн алсан ялтан, сайхан сэтгэлтэй хүн, гэлэн, гэлэнмаа гэхчилэн олон дүрд тоглодог, ямар ч дүрд тоглосон бүгд л жүжиг төдийхөн бөгөөд тоглож дууссаны дараа дахин урдын амьдралдаа буцаж энгийн хүн болдог.

Зарим гарамгай жүжигчин жүжгийн үйл явцад сэтгэлд хоногштол тоглохдоо өөрөө эзэн хаан, эсвэл муу хүн болчихсон шиг санагддаг, ингэснээр бид түүнийг гайхалтай сайхан тоглож, жүжгийнхээ үйл явдалд бүрмөсөн орж чадсан гэж сайшаан магтдаг. Жүжигчин жүжгийн үйл явцад бүрмөсөн орох үедээ үйлийн үртэй болдог, учир нь тэр хүний амь хороосон болохоор өшөөтөн нь өс хонзон нэхдэг, эсвэл сэтгэлтэй хүн нь өөр хүнд хайр сэтгэлтэй болсон тул жинхэнээрээ сэтгэл зовж, уйлдаг гэх мэт. Заримдаа заавал өөр хүнтэй зодолдож тэмцэлдэх дүрд тоглох ёстой үедээ үнэнээсээ уурладаг, гутаан доромжлохыг ханатал амссан хүний дүрд тогловол маш эмгэнэн зовсон байдалд ордог. Гэтэл сэргэг байдалд орж, жүжгийн тайзнаас бууж, ус ууж амсхийх үедээ өөрөө жүжгийн үйл явдалд дэндүү орж, үнэн бодит амьдрал дахь “би” бол харин жүжгийн доторх тэр хүн биш гэдгээ ойлгодог, тиймээс жүжиг дэх дайсантайгаа гар барилцан мэндчилж, амжилттай тоглолоо гэж харилцан зоригжуулдаг, гэвч жүжгийн тайз руу дахин буцмагц бодол сэтгэгдэл нь дахин өөр болж, жүжгээ дахин хянамгай тоглож эхлэх

хэрэгтэй.

Бидний байдал мөн л адилхан, хүний төрөл авах үедээ бурхан гэдгээ санахаа больж, бурхан чанар гэж юу юм гэдгийг мэддэггүй. Хэрвээ мэдлээ гэхэд хүний амьдралаар сайн сайхан амьдарч чаддаггүй, яаж амьдрахаа ч мэддэггүй. Хүн болж амьдрах нь зүүд шиг угаасаа ямар ч хэцүү асуудал байдаггүй, өөрийн биеэ жинхэнээр таних нь маш сонирхолтой бөгөөд баяр баясгалантай, нэг зүйлийн үйл хэрэг мөн. Гэсэн ч хүний амьдралаар хянамгай амьдрах хэрэгтэй, яг л алдартай жүжигчин жүжигт тоглохтой адилхан, тайзнаас бууж хөшигний ард очоод нөгөө этгээдтэйгээ ярилцах үед жүжгийн дүрээ аль хэдийн санахаа больдог хэдий ч хэдхэн минутын дараа дахин тайзандаа буцаж гарвал мөн л урьдахтайгаа адилхан байдалд орж, сэтгэл төвлөрч тоглох хэрэгтэй.

Бидэнд ч бас адилхан, анхаарал хандуулмаар хэрэг гэж байдаггүй. Бясалгал хийх нь өөрийгөө дуудан сэрээж, хэн болохоо ойлгохын тулд л юм, жүжиг доторх дүрдээ баригдаж, дэндүү ихээр гуньж зовж болохгүй, бид чухам хэн болохоо сайн харж, жүжиг тоглож байгаа төдий, харин жүжиг доторх хүмүүс биш, А авгай, В авгай, С авгай гэх тэр бүхэн биш, бид бол эгэл хүмүүс биш гэдгээ ойлгохын төлөө, тиймээс өөрийгөө эгэл хүн биш гэдгээ таньж чадах болтлоо чармайн бясалгах хэрэгтэй, ингэснээр тун баяр баясгалантай болж, юу хийсэн ч болно, ямар ч зовлон гэж байхгүй.

Ингэж сайн ойлгосон ч бид өөрийн үүрэг хариуцлагаа сайтар биелүүлэх ёстой, харин өөрийгөө бурхан гэдгийг ойлгочихсон гээд хүн болсныхоо үүрэг хариуцлагаа сайн гүйцэтгэхгүй байж болохгүй. Тиймээс Шагжамуни Будда бурхан болсныхоо дараа багш хүний үүрэг хариуцлагаа гүйцэтгэхийн тулд шавь нараа мөн л загнадаг байжээ, харин хамаг амьтад бүгд бурхан, юу бясалгасан ч болно гэж яриагүй. Бурхан багш Ананд, Рахул нарыг загнадаг байсан бөгөөд өөр шавь нараа ч ихэд загнадаг байжээ. Нэг өдөр Бурхан багш шавь нар нь үгийг нь сонсохгүй болохоор сэтгэл тун гутарч, шавь нараасаа салан ууланд ганцаараа гурван сар амьдарчээ, анхандаа шавь нар нь түүнийг эрээд олохгүй байж, хайж олсныхоо дараа буцахыг гуйснаар Бурхан багш хүлээн зөвшөөрчээ, тэгээгүй бол тэр буцаж ирэхгүй байсан.

Бурханы хутагт хүрэх нь буруу биш, гэвч хүн болж амьдардаг л юм бол энэ ертөнцөд үүрэг хариуцлагатай болдог, багш болохдоо эрхбиш нэгэн сайн багш болох хэрэгтэй, би нэгэнт бурхны хутагт хүрсэн болохоор юуг ч тоож хамаарахгүй гэж ярьж болохгүй, үүрэг хариуцлага чинь юу байна, түүнийгээ үргэлжлүүлэн гүйцэтгэж, үргэлжлүүлэн биелүүлэх ёстой. Нэгэн элбэрэлтэй хүү, нэгэн сайн эр нөхөр, сайн эхнэр, сайн багш болж, загнах хэрэгтэй хүнээ загнаж, тайтгаруулах хэрэгтэй хүнээ тайтгаруулна, зөвхөн сэтгэлдээ бүрмөсөн ойлгож, өөрийгөө хэн гэдгээ мэднэ, өөрийн уг чанараа ойлгосны дараа үүрэг хариуцлагадаа тэгж ихээр баригдахгүй болно. Билиг нээгдсэний дараа гаднаас харахад билиг нээгдээгүй үетэйгээ адилхан, урд нь юу хийж байснаа одоо мөн л тэгж хийнэ, гэвч хийх үедээ тодорхой ойлгож, хариуцлагаа хянамгай



гүйцэлдүүлдэг хэдий ч түүндээ баригддаггүй.

**Асуулт:** Хүн бясалгал хийхдээ аливаа бүхнээ хоосон болгох хэрэгтэй гэж Буддын сургаалд байнга ярьдаг, явал хоосон болсонд тооцогдох вэ? Хэрхэн хоосон болж чадах вэ? Аливаа бүхэн нэг, нэг бол аливаа юм бүхэн мөн гэдгийг яаж тайлбарлах вэ?

**Их Багш:** Та үүнийг яагаад асууж байна вэ? (Би нэг судар номыг уншихдаа харсан юм) Иймэрхүү ном нь бясалгалаар өндөр хүн, баригдаж хүлэгддэггүй хүмүүст хандаж бичсэн ном юм, учир нь судар номын агуулга болгон нь энгийн хүмүүст хандаж ярьсан байдаг юм биш. Их Багш нар ном тайлахдаа заримдаа ганц хоёр шавьдаа, эсвэл дэсээр адил нэг бүлэг шавь нартаа хандаж ярьсан байдаг, гэтэл хойч үеийн хүмүүс ном судрыг уншихдаа эхнээс нь дуустал уншсан ч утга санааг нь ойлгодоггүй, учир нь тийм дэсэд хүрээгүйгээс болж байгаа юм. Одоо багш нь таны асуултад хариулсан ч ямар ч нэмэргүй. Та бясалгаад тийм дэсэд хүрэх үеэр би бас ном сударт ярьсан шиг таныг хоосон болоорой, огоороорой гэж ярьж ч магад, гэтэл одоо бол энэ асуулт чамтай ямар ч холбогдолгүй.

Энэ хоёр асуултыг би хариулах дургүй байна, учир нь гэвэл та нарт ач тустай эсэхийг би мэдэхгүй, үг хэлээр мэтгэж маргах нь тийм ч их ач тустай биш. Заримдаа шавь нь бясалгаж суухдаа бага зэрэг ахуй ойлголттой болж, ямар нэгэн дэсэд хүрч ч магад, тэгээд багшдаа очиж: “Багш аа! Би ийм тийм юм харсан, ийм тийм мэдрэмжтэй болсон, энэ нь юуг илэрхийлж байгаа бол? Ямар дэсэд хүрсэн бол?” гэж байнга асуудаг, тэр үед багш нь: “Бүгдийг огоор, бүх юм угаас хоосон, ямар ч утга учир байхгүй болохоор баригдах хэрэггүй, бясалгал чинь нэг л төвшинд гацаж болохгүй, таны харсан чинь тийм ч өндөр төвшин биш, бүгдийг хоосон байлга” гэж хэлж магадгүй.

Учир нь ихэнх хүн бага зэрэг ахуй ойлголттой болмогц тэр төвшиндөө хүлэгдээд дахин дээшилж чадахгүй болдог, бидэнд ахуй ойлголт их байна, өчүүхэн төдий ахуй ойлголт нь тийм ч сүрхий юм биш, хамаарах хэрэггүй, хоосон байлга гэдэг нь ийм утгатай билээ.

Хоёрдугаар асуулт, нэг бол аливаа бүхэн мөн, аливаа бүхэн бол нэг юм гэдэг нь бидний ярьдаг аливааг сэтгэлээр зохиосон гэдгийн утгатай адилаар. Хамгийн доод дэсэд хандаж хариулбал өөрөө бясалгавал өөрөө мэдэж чадна гэсэн үг, өндөр шиг дэсэд хандаж хариулбал бясалгал өндөрссөний дараа юуг ч бүгд мэдэж чадна гэсэн үг. Энэ хариултыг би дахин тодорхойлох дургүй байна, яагаад гэвэл та нар ойлгохгүй болохоор андуурал үүсэхээс эмээж байна.

Хамаг төрөлтөн бол гүн билиг ухаанаас үүсэлтэй, энэ “нэг”-ээс үүсэлтэй болохоор хамаг ном бол нэг, нэг бол хамаг ном мөн гэж ярьдаг. Эзэн Бурхан, эсвэл Төгс төгөлдөр гүн билиг ухаан, Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг бол хамгийн дээд байр суурь мөн. Католик шашинтнууд Эзэн Бурхан гэж нэрлэдэг, учир нь тухайн үеийн тэр орны хүмүүс Эзэн Бурханд итгэдэг болохоор Эзэн Бурхан гэдэг нэрийг хэрэглэхгүй бол тэд Есүс Христийн үгийг сонсохгүй, Католик шашинтныг сургахдаа би мөн л Эзэн Бурхан гэж ярьдаг, яаж ч ярьсан

хамаагүй, хамаг төрөлтөнд ач тустай л бол болчихно, тэд Оройн дээд төгс гэгээрэл-Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг гэж ярих дургүй юм чинь Эзэн Бурхан гэж ярьсан ч болно, болохгүй юм гэж хаана байх вэ дээ? Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг бол хамгийн дээд нь, бурхан Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутагт хараахан хүрээгүй, бодьсатва дэсээр бурханаас бага зэрэг доор, гэхдээ бодьсатва тун олон дэстэй, зарим нь дэсээр өндөр, зарим нь дэсээр доор, оройн дээд гүн нууцлаг номыг та нар мэддэггүй болохоор ойлгож чадахгүй.

Католик шашны ном судрыг эрт дээр үед нэгэнт ихэд засаж өөрчлөн маш олон сургаал ёс нь алдагджээ, учир нь дэсээр доор хүмүүст үлгэр түүх ярих хэрэгтэй байж ч магад, гэтэл дэсээр жаахан өндөр хүмүүст Есүс Христчүүд ч дээд зэргийн сургаал ёс ярьдаг, харин зөвхөн шавраар хүн бүтээсэн үлгэрийг л ярьдаг төдий биш. Билиг нээгдэж гэгээрсэний дараа бид Библи судар юмуу, Бурханы судрыг уншвал ойлгоцын хувьд урьдынхтайгаа адилгүй болно.

Энэ Төгс төгөлдөр гүн билиг ухаан бол хамгийн дээд нь мөн, үүнийг бид хамгийн дээд зэрэг дэс гэж орчуулдаг, хамгийн дээд нь Эзэн Бурхан биш үү? Эзэн Бурхан бол Католик шашинд хамгийн дээд төлөөлөгч нь болно, гэтэл энэ Эзэн Бурхан бол нэг хүн биш, сүсэгтнүүд өөрсдийн буруу ойлголтоороо Эзэн Бурханыг хүнчилж, өөрсдийн хий бодлоороо хувь хүний төсөөлсөн бодолд харьяалагдах Эзэн Бурханыг зохион бүтээжээ.

Тиймээс бид одоо Эзэн Бурхан гэж сонсмогц тун мэдрэмтгий байдаг, учир нь өөрсдийн үзэл бодлоороо ийм Эзэн Бурханыг бүтээж, нэгэн Эзэн Бурханы төлөв байдлыг зохион бүтээжээ, Эзэн Бурхан ийм дүр байдалтай биш, Эзэн Бурхан бол төгс төгөлдөр гүн билиг ухаан, төвийг сахих хүч мөн, тэр маш олон юм бүтээж чаддаг, тэр ч байтугай бүхий л орчлонг бүтээдэг, гэвч юунд ч сэтгэл татагддаггүй, түүний ажил нь зөвхөн бүтээгч төдий, та сайн ч бай, муу ч бай, түүнд хамаагүй, бид хэзээ гэртээ буцахыг тэр бас тоож хамаардаггүй, гэхдээ хэзээ нэг өдөр буцах учиртай байдгийг маань мэддэг, та өөрийн гэх чөлөөт бодол санаатай болохоор өнөөдөр буцах, маргааш буцах, дараа жил буцах, зуун жил, мянган жил, эсвэл хичнээн жилийн дараа буцсан ч бүгд болно. Бидэнд үлэмж их хүч чадал байгаа, дураараа сонгож болно, тиймээс Шагжамуни Бурхан: “Бид энэ төрөлдөө бурханы хутагт хүрч чадна” гэжээ.

Гэвч хүн болгон энэ төрөлдөө бурханы хутагт хүрч чаддаггүй, учир нь өөрсдөө сонгодоггүй, гэгээрсэн бясаллагчтай уулзаагүй, эсвэл өөрөө тийм түргэн буцах дургүй байж ч магад, яагаад гэвэл энэ ертөнцөд сэтгэл хоргодож, гэртээ буцъя гэж санаж боддоггүй, туулан гэтлэхийг боддоггүй, бурханы дэсэд хүрэх дургүй, энд үлдэж ертөнцийн жаргалыг эдлэх дуртай хүмүүс их байдаг, энэ нь мөн л бидний өөрсдийн сонголт, Эзэн Бурхан таныг маргааш, эсвэл дараа жил буцах хэрэгтэй гэж яриагүй, Эзэн Бурхан бол төвийг сахидаг.

Энэ Төгс төгөлдөр гүн билиг ухааныг хүн болгон олж чаддаг хэдий ч хүмүүс олохыг боддоггүй, билиг ухааныг хүсэмжлэн санах нь

хувь хүний асуудал, харин Эзэн Бурханы асуудал биш. Хожим бүх зүйл энэ “нэг”-д буцах хэрэгтэй болно, гэвч бүгдээрээ адилхан нэг өдөр л буцчихдаг юм биш, харин түргэн удаанаараа ялгаатай, та хэзээ ч буцсан болно, төв голчийг чанга барьдаг “нэг” үүнийг тоож хамаарахгүй, учир нь түүнээс үүсэлтэй болохоор хожим мэдээж түүн лүү буцаж ирэхийг нь мэддэг, тиймээс “нэг” бол аливаа бүхэн мөн, аливаа бүхэн бол “нэг” мөн гэж хэлдэг.

**Асуулт:** Багш аа! Бид заавал католик шашныг шүтэх, эсвэл буддын шашин шүтэхэд хүлэгдэх албагүй, тийм үү?

**Их Багш:** Тийм, маш зөв, нэг зүйлд баригдах албагүй, та юуг ч шүтсэн болно, бид бүгдээрээ энэ үлэмж их хүчээс үүсэлтэй, түүнийг Бурхан чанар, Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг, Эзэн Бурхан, Мөр гэж нэрлэж болно, үүнийг тэр хайхарч хамаардаггүй, гол нь та өөрийнхөө хэзээ буцах вэ гэдгээ хамаарах хэрэгтэй.

## БИЛИГ НЭЭГДВЭЛ БУРХАН, ХАРАНХУЙ МУНХАГ БОЛ ХАМАГ ТӨРӨЛТӨН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй*

*(Эх нь хятад хэлээр)*

*1986 оны 12 дугаар сарын 1*

Билиг нээгдэж гэгээрсэн хүн бол хамаг төрөлтнийг цөмийг нь бурхан мөн гэж үздэг, та нар жинхэнэ чин сэтгэлээр бясалгаад хэзээ нэг өдөр ийм дэсийг ойлгож, хамаг төрөлтөн бүгд бурхан, бүгд бодьсадва мөн юм байна гэдгийг мэдэх болно. Бурхан үгүй бол хамаг төрөлтөн байж чадахгүй, хамаг төрөлтөн үгүй бол бурхан байж чадахгүй, бурхан бол жинхэнэ төрөлтөн, хамаг төрөлтөн бол жинхэнэ бурхан мөн, үүнээс бусад үйл хэргийг дахин яриад байх юм байхгүй, учир нь хамаг төрөлтөн өөрийгөө бурхан гэдгээ мэддэггүй болохоор бурхан бодьсадва хувилгаан биеэр ирж тэднийг сургах хэрэгтэй, тэгээд өөрийгөө бурхан гэдгээ ойлгох хүртэл нь аажмаар сургаж, удирдан дагуулах хэрэгтэй болдог.

Хамаг төрөлтөн угаас нэгэнт бурхан, хэрвээ ойлгож чадвал даруй бурхан болж, ойлгохгүй бол мөн л эгэл хүн хэвээрээ байна, энэ бол тун амархан хэрэг. Бурхан болон эгэл хүний ялгаа зөрөө нь мэдэх болон мэдэхгүйдээ л байгаа юм, бурхан бол өөрийгөө бурхан гэдгээ мэддэг төрөлтнүүд, хамаг төрөлтөн бол үүнийгээ мэддэггүй бурхан, ялгаа нь эндээ л байдаг. Бурхан, эсвэл гэгээрсэн хүний хувьд түүнийг гүтгэдэг хүмүүс ч гэсэн бурхан мөн, тэр гүтгэдэг хүмүүст тэд жаахан ч өшөө хорсол өвөрлөдөггүй, мөн л ихэд хайрласаар байдаг бөгөөд адислаж, түргэн гэгээрээсэй гэж бурхан бодьсадвагаас тусламж гуйдаг. Жишээ нь: хэрвээ бид олон хүүхэдтэй бол бие махбод нь эрүүл саруул хүүхдээ хайрлан халамжилж, харж харгалздаг, гэхдээ өвчтэй хүүхдээ бүр ч илүү халамжлан хайрлаж, онцгой ихээр харж ханддаг, тийм биш үү? Бүгдээрээ л өөрийн хүүхэд боловч өвчтэй хүүхдээ илүүтэй харж ханддаг.

Одоо бол цөвүүн цаг үе болохоор бусдыг жинхэнээр сургахад тун амар биш, тиймээс миний бодлоор Гуан Чин өвгөн хувраг тийм ч олон хүнийг сургаагүй, ер нь л бурхныг дурсуулдаг байжээ, хожим бич ч гэсэн ингэж магад, “Амар байна уу Авид бурхан” гэж уншуулна, яагаад гэвэл хамгийн дээд номыг сургах нь дэндүү төвөгтэй. Гуан Чин өвгөн хувраг ч гэсэн: тухайн үеийнхээ хүмүүсийг “Мөр ёсыг хайх сэтгэл тун бага, өмнөх хүмүүсийн арван хувийн нэгэнд ч хүрэхгүй” гэж хэлсэн билээ. Энэ талаар надад ч гэсэн ийм бодол төрсөн, ингэж ярьж байгаа нь

хүмүүсийг дорд үзсэн хэрэг биш, харин үнэн бодит байдал нь л энэ юм.

Тайваньд урьд нь хэдэн Их Багш байсан, тэд гүн нууцлаг номын аргыг заагаагүй, гэхдээ тэд гүн нууцлаг гайхамшигт номыг мэддэг эсэхийг нь би мэдэхгүй, юу ч гэсэн заасан хүн байхгүй юм шиг байна, тиймээс Тайваний хүмүүсийн тал хагасаас илүү нь гүн нууцлаг номын аргыг мэддэггүй, тэгэхлээр “Оройн дээд гүн нууцлаг гайхамшигт ном”-ыг заахад тун ч амаргүй бөгөөд хамаг төрөлтөн амархан хүлээж авахгүй. Эрт дээр үед ч гэсэн хамгийн дээд бясалгалын аргыг уламжлах нь мөн л тун нууцлаг үйл хэрэг байжээ, хамгийн дээд бясалгалын аргыг хайж олоход тийм хялбархан биш бөгөөд хүн бүр хайгаад олчихдог ч юм биш.

Тиймээс эртний хүмүүс ном хайхад эрхбиш уул давж, ус гатлан хээр хонож, хэц дэрлэн байж л багшийгаа хайх хэрэгтэй байжээ, энэ тухай үлгэр домгийг та нар их олон сонссон байх. Хичнээн их хэцүү бэрхийг туулж, хичнээн их зовлон зүдгүүрийг амсаж байж л сая жинхэнэ Багшийг хайж олдог, хайж олсныхоо дараа мөн л багшийгаа дагаж олон жилээр хамт амьдардаг, харин уулзангуут даруй ном уламжилдаггүй байж, тэгээд бас удаан хугацаагаар туршин шалгаж, багшдаа зөвшөөрөгдсөний дараа л ном уламжилдаг. Тиймээс эрт дээр үед ном хайхад тун амаргүй байжээ.

Бидний сонссоноор Хуй Ке номын багш ном хайх үедээ гүн цасанд сөхөрч, цас өвдгийг нь давчихсан байхад Бодьдармаа мөн л тоохгүй, хамаарах ч үгүй байжээ, тэгээд гурав хоног өнгөрсний дараа Хуй Ке өрөөсөн гараа огтолж гурван эрдэнэд өргөл болгон өгсөнөөр л Бодьдармаа түүнийг ширвэн харж: “Танд юу хэрэгтэй юм бэ?” гэж асуужээ, энэ нь Бодьдармаа нигүүлсэнгүй сэтгэлгүйдээ биш, харин тэрээр тухайн үеийн хүмүүсийн мөр ёсыг хайх сэтгэлийг хараад маш ихэд урам хугарчээ, нэг улсын хаан эзэн гэгдсэн Лиян Ү Ди хүртэл зөвхөн хүний болон тэнгэрийн буянд шунаж, жинхэнэ нирвааныг хайгаагүй байв.

Тэр цаг үеийн хүмүүсийн ихэнх нь бүгд л хүн болон тэнгэрийн буянд шунаж, сүм хийд байгуулах, өргөл барьц өргөх, ном гүрэм үйлдэх, ном судрын утгын тухай маргах гэх мэтийн зүйл үйлддэг байжээ, ойлгож байна уу? Өөрсдөө бясалгадаггүй, гэгээрдэггүй. Тиймээс Бодьдармаа нуун далдалж, есөн жил хана руу харан бясалган сууж, үг ч ярьдаггүй, хүнийг ч сургадаггүй байжээ. Бодьдармаа нигүүлсэнгүй сэтгэлгүйдээ биш, бурхан бодьсатва төрөл төрөлд тийм нууцлаг байж, хүмүүст хамгийн дээд бясалгалын аргыг сургадаггүйгээс болсон ч юм биш, харин сургахын аргагүй, сургамар байлаа ч хамаг төрөлтөн хүлцэн тэсвэрлэж чаддаггүй, хүлээж авдаггүй болохоор ямар арга байх билээ дээ.

Багш чинь Тайваньд байх үедээ ч гэсэн хүмүүсийг сургамааргүй байсан хэдий ч, хожим нь зарим хүний чин сэтгэлтэй байдал, тухайн үедээ хүмүүс үнэн сэтгэлтэй байхыг харсан болохоор жаахан илээр ном уламжилсан, гэтэл дөнгөж жаахан ил болмогц аль хэдийн төвөг учирч, даруй асуудалтай болов. Нэгдүгээрт, тэд, тийм сайн ном хаанаас байж болох вэ? Тийм хялбархан сурч чадах уу? гэж эргэлздэг Хоёрдугаарт, ийм бясалгалын арга байсан бол Тайваньд яагаад заах хүн байгаагүй

вэ?, Гуравдугаарт, Тайваньд дэсээр өндөр хувраг их байгаа атал яагаад энэ бясалгалын аргыг мэддэггүй билээ гэж ярьдаг.

Тэд багшид чинь итгэдэггүй, авшиг хүртсэний дараа таван үеэрээ төрөл дэвшиж, өөрсдийгөө туулан гэтэлгэж чаддаг гэдэгт итгэдэггүй. Багш чинь ном уламжлах үеэр та нар ямар ахуй ойлголттой болж чадна гэж багш чинь ярьж байгаа бол та нар яг тийм ахуй ойлголттой болж чадах юм. Энэ нь багшийнх нь хэлж ярьсан нь үнэн болохыг илэрхийлж байгаа билээ, ойлгож байна уу? Багшийн чинь ярьсан бүхэн бүгд үнэн, ийм байтал мөн л эргэлздэг хүмүүс байдаг, тэд зөвхөн ном сударт л итгэж, хоёр мянга таван зуун жилийн тэртээх Шагжамуни Бурханд итгэдэг. Шагжамуни Бурхан жинхэнэдээ хэн болохыг мэддэггүй.

“Хотол зохилдогч зүйл”-д: “Арьяабал бурханы нэрийг уншвал ширүүн галд орсон ч шагахгүй, гүн усанд унасан ч живэхгүй бөгөөд гүехэн газар очно” гэж өгүүлсэн байдаг. Гэтэл галд орвол даруй шагчихдагийг та нар тодорхой мэднэ, ийм байтал хүмүүс мөн л итгэсэн хэвээр байдаг нь мухар сүсэг биш гэж үү?

Багшийгаа дагаж энэ бясалгалын аргаар бясалгавал даруй зөн билиг мэдрэгдэж, ахуй ойлголттой болно гэж багш чинь ярьсан байвал та нар үнэхээр тийм үр дүнд хүрдэг, ийм байтал хүмүүс мөн л багшид нь итгэдэггүй, зөвхөн Арьяабал Бурханд итгэж, тиймэрхүү ном сударт итгэдэг, нотолгоо өгч чадахгүй, үр дүн байхгүй бол бодьсадва яаж туслах вэ? Багшийн чинь ярьсан болон “Хотол зохилдогч зүйл”-д өгүүлсэн хоёрын аль нь илүү үнэн бодит байдаг билээ? Аль нь даруй нотолгоотой болж чаддаг билээ? Аль нь даруй үр дүнтэй болж чаддаг билээ гэдгийг та нар тодорхой мэднэ.

Ихэнх хүн бүгд л “Хотол зохилдогч зүйл”-д итгэж, багшид чинь итгэдэггүй, энэ нь бас аргагүй (Шавь: Би багшдаа итгэнэ гэж хариулав), таныг надад итгэдгийг би мэднэ, гэвч бурхан бодьсадва хүмүүсийг сургахад үнэхээр амаргүйг би та нарт ярьж байна, ойлгож байна уу? Түүнд та ингэж бясалгавал даруй ахуй ойлголттой болно гэж сургадаг боловч мөн л итгэдэггүй, харин нотолгоотой болгож чаддаггүй, ахуй ойлголттой болгож чаддаггүй судар номд л итгэдэг. Тэд номын багшид ялгаварлах сэтгэл гаргаж, энэ бол Вьетнамын номын багш, тэр бол Хятадын номын багш, хятадад номын багш нар тийм их байхад яагаад харин энэ бясалгалын аргыг мэддэг хүн нэг ч байхгүй байна вэ? Тиймээс лав буруу номтон гэж ялгаварладаг.

Гэтэл нөгөө талаар харин Энэтхэгийн Шагжамуни Бурханд итгэж, хоёр мянга таван зуун жилийн тэртээх Энэтхэг хүнд итгэж, одоо байгаа Вьетнамын номын багшид итгэдэггүй нь зөвхөн тэр бол гадаадын иргэн учраас тэр юм, урдын Шагжамуни Бурхан энэ бясалгалын аргыг мэддэг гэж итгэдэг хэдий ч одоогийн Вьетнам хүмүүс мэдэх боломжгүй гэж боддог, гэхдээ хоёр мянга таван зуун жилээс нааш бол зөвхөн Шагжамуни Бурхан л мэдэж, өөр хүмүүс огт мэддэггүй, зөвхөн Хятадын номын багш л мэдэх боломжтой, Хэрвээ Хятадын номын багш мэдэхгүй бол Вьетнамын номын багш ч мэдэх аргагүй гэж боддог (Бүгд инээлдэв) тийм үү? үгүй юу? Энэ бол үнэхээр арга барагдам хэрэг.

Ялгаварлах сэтгэлтэй байх нь тун яршигтай, бурхан бодьсадвад ялгаварлах сэтгэл байдаггүй, гэтэл эгэл хүмүүст байдаг болохоор төвөгтэй. Бурхан бодьсадва хүмүүсийг гэтэлгэхдээ мэдлэгээр хэр өндөр, дэсээр хэр зэрэг, үйл түйтгэрээр хэр их гэдгийг нь ер тоож хамаардаггүй, хайхрах ч үгүй. Гэтэл хамаг төрөлтөн хайхардаг, тэд өөрсдийнхөө үйл түйтгэр тун хүнд гэдгийг тоодоггүй, зөвхөн номын багшийн сургаал нь буруу гэдгийг л тоодог. Тэд бурхны сургаал ёсыг тийм ч их ойлгодоггүй, өөрийнх нь бясалгалын дэс нь хэр зэрэг вэ гэдгийг ч мартчихсан байдаг. Тэр өөрийнхөө харанхуй мунхагийг санахгүй, харин өөр номын багшийг харанхуй мунхаг гэж шүүмжилдэг, тэр бол Вьетнам хүн, эсвэл Энэтхэг хүн, тэр бол гэрээс гарагч, эсвэл гэрээс гараагүй, тэр бол өөрөө үсээ хуссан, эсвэл өөр хүнээр хусуулсан гэхчилэн шүүмжилдэг, ийм хэрэг явдал бол гэгээрэхтэй огт холбоогүй.

Хүй Нэн Их Багш багшаасаа номын дээл болон бадар аягыг уламжилж авах үедээ мөн л гэрээс гараагүй, үсээ хусуулаагүй байжээ, гэвч тавдугаар үеийн Өвгө Багш Хун Рэнь номын дээлийг нэгэнт түүнд уламжилчихсан байна, тэгээд арван зургаан жилийн дараа л гарч ирээд ном уламжилж хүмүүсийг сургаж, тэгснийхээ дараа Баолин хийдийн ламаар үсээ хусуулжээ, учир нь үсээ хусуулахгүй бол жинхэнэ гэрээс гарагчид тооцогдохгүй болохоор даруй үсээ хусуулж, жинхэнэ номын багш болжээ. Үүнээс бид үсээ хусуулж байж л билиг нээгдэж гэгээрч чадна гэдэг үг буруу болохыг мэдэж болно.

Өнөөдөр миний нэг шавь Гуан Чин өвгөн хуврагийн ном тайлсан тэмдэглэлийг уншжээ, тэгээд түүний ярьсан нь миний ярьсантай адил болохыг мэдсэн байна, тэр: “Яаж бясалгахаа мэдэхгүй бол гэрээс гарагч боллоо ч гэсэн тун харамсмаар хэрэг” гэжээ. Үнэхээр тийм, жинхэнээр бясалгахгүй бол гэрээс гарсан ч хэрэггүй, энэ “Мөр” (Дао)-ийг мэдэхгүй бол мөн л “буруу номтон” болно, учир нь энэ “Мөр” дотор байхгүй болохоор буруу номтон болно. Харин буддын шашин бол зөв номтон, католик шашин бол буруу номтон гэж болохгүй, энэ тухай би олон удаа ярьсан, Их Багш нарын ярьсан сургаал ёс бүгд л адилхан, гэвч бид эрхбиш хангалттай өндөр дэсэдэй болж байж л сая ойлгож чадна, дэсээр өндөр биш бол ойлгохын аргагүй, ойлгож байна уу?

Хэрвээ гэрээс гарагч байж л сая бясалгаж чаддаг, гэрээс гарахгүй бол бясалгаж чадахгүй гэвэл Вималакирти Их Багш хаанаас ирсэн бэ? Та нар Вималакирти Их Багшийг мэдэх үү? Тэр мөн л гэрээс гараагүй. Хэрвээ эмэгтэй хүн бурханы хутагт хүрч чадахгүй, гэгээрч чадахгүй гэвэл лусын охиныг юу гэх вэ? “Олонх бурхант судар”-т лусын охиныг найман настайдаа бурханы хутагт хүрсэн гэж тэмдэглэсэн байна, лусын охин бол эмэгтэй хүн бөгөөд наймхан настай, гэхдээ бас хүн биш боловч бурханы хутагт хүрч чадсан байна.

Ихэнх хүн угаас луу, тэнгэрийн ном хамгаалагч луу бурхан болж чаддаггүй, зөвхөн хүн л бурханы хутагт хүрч чаддаг, гэхдээ эрэгтэй хүн л бурханы хутагт хүрч чаддаг гэж ярьдаг, энэ бол буруу, зөвхөн багш чинь ингэж хэлж байгаа юм биш, Бурхан Багш ч гэсэн ингэж ярьсан байна. Хэрвээ зөвхөн эрэгтэй хүн л бурхан болж чаддаг юм бол “Олонх

бурханта судар” дахь лусын охин бурханы хутагт хүрсэн тухай үлгэр байхгүй байх байсан. Гэхдээ “Вималакирти судар-т”: “эрэгтэй, эмэгтэй гэж байдаггүй” гэж өгүүлсэн байна, үнэхээр тийм, угаас эрэгтэй гэж байхгүй, эмэгтэй гэж байхгүй, зөвхөн энэ уг дүр, энэ билиг барамид л байдаг.

Зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн тавдугаар өвгө Багшаас ном уламжлахыг гуйх үед: “Та бол вьетнам хүн юм чинь яаж бурханы хутагт хүрч чадах билээ?” гэж тавдугаар өвгө Багш хэлсэнд: “Хүмүүсийг өмнөдийн, умардын гэж ялгадаг, гэтэл бурхан чанарт ялгаа үгүй” гэж зургадугаар өвгө Багш хариулжээ. Үүнтэй адилаар бид бас хүмүүсийг эрэгтэй, эмэгтэй, Тайваньчууд, Вьетнамчууд гэхчилэн ялгадаг боловч “Бурхан чанар”-ыг нь ялгах аргагүй гэж хэлж болно, тэгээд хүйс, улс орон зэрэг нэг талд баригддаг юм бол бурхан чанараа эрж олохгүй, жинхэнэ багшийг хайж олохгүй. Учир нь багш чинь энэ махан бие биш, та нар ч гэсэн эцэс сүүлдээ энэ багшаас салж, өөрсдийнхөө багш болж, өөрсдийнхөө эзнээ хайж, хамгийн сүүлд өөрсдийнхөө багш болох хэрэгтэй.

Тиймээс багш чинь зөвхөн нэгэн дуу чимээ дамжуулагч төдийхөн, яг л шууданчтай адилхан, танд захидал хүргэхийг хариуцдаг, захидлаа та дараа нь аажимдаа уншиж болно, гэхдээ та эхлээд шууданчид аяга цай уулгаж, бага зэрэг жигнэмэг идүүлж, жаахан мөнгө өгсний дараа түүнд баярлалаа гэж хэлж магад, ингэсний дараа шууданч мөн л танайхаас гарч, өөрийн ажлаа үргэлжлүүлэх ёстой, учир нь өөр хүмүүсийн “захидал”-ыг хүргэх ёстой. Та өөрийн захидлаа заавал өөрөө унших хэрэгтэй, учир нь энэ хуудас захидал нь чамтай холбоотой, харин шууданчтай холбогдолгүй. Шууданч захидлыг чинь чамд дамжуулахад ямар ч асуудалгүй. Хамгийн гол нь чамд юуг сургаж чадах эсэх, сургадаг зүйл нь судар номтой зохицолдох эсэх, чамд ном уламжлах үед ахуй ойлголт чинь ном сударт ярьсантай адилхан байх эсэх нь л хамгаас чухал асуудал. Харин түүнийг эрэгтэй юмуу, эмэгтэй юмуу? Өмнөдийн хүн үү? Умардын хүн үү? Аль улсын иргэн бэ? гэх мэтийг тоох хэрэггүй, энэ асуудал бол ерөөсөө чухал биш.

Ном судрыг дэндүү их уншвал хожим ном судартаа баригдаад юуны төлөө уншиж байгаагаа мэдэхгүй болно. Ном судар нь угаас нэг хуудас газрын зураг шиг бидэнд лавлагаа болж, эртний их багш, бодьсатва болон бясалгагч нар билиг нээгдэж гэгээрэх үедээ ямар ахуй ойлголттой байсан гэдгийг мэдүүлдэг төдий зүйл. Тэгвэл одоо бид тэдэнтэй адилхан ахуй ойлголттой болж чадах болов уу? Энэ нь л ном судар уншихын зорилго билээ. Тэгэхгүй бол ном судар уншихад буян гэмээр юм алга, жаахан ч буян хураахгүй гэж би үнэнийг хэлье. Судар ном унших, маани тарни уншаад буян хураана гэж бүү бодоорой. Ямар буян хураах билээ?

Зурмал жигнэмэг нь хоол хүнс болж чадахгүй гэж Бодьдармаа хэлсэн байна, тиймээс тэр “Нирваан судар”-ыг шатаах гэжээ, учир нь нэг хүн өдөр бүр “Нирваан судар”-ыг уншаад байхлаар нь Бодьдармаа түүнээс юунд үүнийг уншиж байгаа юм бэ? гэж асуухад: “Үүнийг уншвал туулан гэтэлж, үлэмж их буянтай болно” гэж хариулжээ, тэгэхэд



нь Бодьдармаа: “Судраа нааш өг! Түүнийг чинь шатааж орхиё. Зурмал жигнэмэг хоол хүнс болж чаддаггүй” гэсэн байна.

Тиймээс судар ном унших нь тийм ч их ач тустай биш, ном судар уншин өдөр бүр амар сайн уу гэтэлгэгч... гэж уншдаг боловч харин судрын утга санааг ойлгодоггүй, “бодол санаа” нь ч эмх замбараагүй байх юм бол ямар ч нэмэргүй, ингэх нь дууны хуурцгийг ч гүйцэхгүй, дууны хуурцаг биднээс ч сайн уншдаг, андуу буруу унших боломжгүй.

Гэтэл бид заримдаа уншихын зэрэгцээ унтчихдаг болохоор буруу уншдаг, уг нь дараачийн өгүүлбэрийг нь унших байсан ч харин “бодол санаа” нь өөр зүгт зугтчихдаг, ингэснээр төвөгтэй болж мэднэ, ингэж эмх замбараагүй уншиж байгааг бурхан бодьсадва харвал уурлаж ч мэднэ, тийм үү? (Бүгд инээлдэв), тэд уурлахгүй байж ч магад, гэвч ном хамгаалагч луу сахиус уурладаг, бидний болгоомжгүй, хүндэтгэлгүй байгааг хараад бидэнд төвөг удаж мэднэ, буян хурааж чадахгүйн дээр бас яршиг төвөгтэй болно, гэвч энэ нь бага хэрэг, тоох хэрэггүй.

Бясалгал хийхдээ ялгаварлах сэтгэлтэй байж болохгүй, түргэн огоорох нь илүү дээр, энэ талаар сайн ойлгохгүй бол ном судар ч бидэнд төвөг тарьж, ном сударт баригдмал болж хувирна. Тиймээс ном судар тийм ч их хэрэгтэй биш, ийм ялгаварлах сэтгэл нь бидэнд ямар ч ач тусгүй, хэдий түргэн огоорч чадвал төдий түргэн бурхан болж чадна гэх мөртлөө хожим нь энэ “бурхан” нь ч гэсэн үгүй болчихдог юм чинь хамаг төрөлтөн гэж хаанаас байж болох билээ? Хамаг төрөлтөн байхгүй юм чинь эрэгтэй, эмэгтэй, Вьетнам, Тайвань гэх мэтийн ялгаа гэж хаанаас байж болох вэ?

“Байхгүй” гэдэг нь хов хоосон болчихсон гэдгийг илэрхийлж байгаа юм биш, харин энэ “ялгаварлах сэтгэл” байхгүй, улс орны хил хязгаар гэж ялгаж салгах бодол байхгүй гэсэн үг, ойлгож байна уу? Улс болгон нэг байшинтай адил, жишээ нь та хоёр давхар байшинд амьдарч байвал хоёр давхар нь хоёулаа л чиний гэр, та байнга дээшээ, доошоо өгсөж уруудаж байхад ямар ч онцгой бодол төрдөггүй нь энэ нь давхар байшин байхгүй, хоёр давхар нь хоорондоо ялгаагүй гэдгийг илэрхийлж байгаа хэрэг биш, дээд давхар болон доод давхарт нь өөр өөрийн онцлог байгаа боловч чиний хувьд ямар ч онцгой санагддаггүй, ойлгож байна уу?

За! Одоо би та нарт жаахан гүн шиг сургаал ёсыг ярина, учир нь та нар яагаад “бурхан бол хамаг төрөлтөн”, “хамаг төрөлтөн бол бурхан” гэж хэлдэг вэ? Хамаг төрөлтөн яагаад ер нь бурханы хутагт хүрч чаддаггүй вэ? Хамаг төрөлтөн яагаад мөн л хамаг төрөлтөн, бурхан мөн л бурхан хэвээрээ байдаг вэ? гэж асууж магадгүй, тийм үү? үгүй юу? Их Багш нар яагаад бүгд л хамаг төрөлтөн угаас бурхан мөн гэж ярьдаг вэ? Угаасаа бурхан юм бол энэ ертөнцөд ирээд хамаг төрөлтөн болсны хэрэг юу вэ? Учир нь заавал энэ ертөнцөд бууж ирээд суралцах хэрэгтэй, дараа нь сая өөрсдийгөө “бурхан” гэдгийг танина, энэ бол маш нууцлаг хэрэг, гэхдээ үнэн хэрэгтээ үнэхээр ийм л юм.

Бид хэрвээ нэгэн цагт гэрэл гэгээтэй оронд төрж өсөн тэнд л амьдарч байсан бол гэрэл гэгээ гэж чухам юу болохыг мэддэггүй, ойлгож байна

уу? Тэгээд хэзээ нэгэн өдөр гэрэл гэгээгүй харанхуй оронд төрснийхөө дараа уул нь гэрэл гэгээтэй оронд амьдарч байснаа мэдэж, ингэснээр гаднах орчин харанхуй байдгийг мэдэх болно. Үүнтэй адилаар хамаг төрөлтөн байхгүй бол бид бурхан гэж юу болохыг мэдэж чадахгүй. Тиймээс энэ ертөнцөд бууж ирээд “бурхан болох”-од суралцах хэрэгтэй, өөрсдийгөө бурхан гэдгээ танихад суралцах, өөрсдийнхөө байр суурь, бурхан чанар, хүч чадал, уг дүрээ танихад суралцана, ойлгож байна уу? Угаасаа нэгэнт бурхан юм, бясалгал хийсний дараа л бурхан болдог юм биш, угаасаа бурхан биш юм бол бясалгал хийсэн ч бурхан болж чадахгүй, бясалгал хийхээр л бурхан болчихдог юм биш.

Бурхан бол Будда, бурхан бол сэтгэгдэшгүй үйл хэрэг мөн, бидний хүч чадал, авьяас чадвар, зовлон зүдгүүр, даатгал гуйлт, чанга дуугаар унших, чанга дуугаар дуулах, хатуу бясалгалын арга, эсвэл хүндэтгэл болон даруу хандлага, ёс суртахуунтай амьдрал гэх зэргийн туслалцаатайгаар олж чаддаг юм биш, ингэж болдоггүй. Хүний амьдралаар амьдрахад нэгэн ёс суртахуунтай хүн болох хэрэгтэй бөгөөд мэрийн бясалгах хэрэгтэй, гэхдээ мэрийн бясалгаснаар л бурхан болчихдог юм биш, тийм биш, Будда бол нэгэнт бурхан, аль хэдийн бурханы хутагт хүрчихсэн байдаг, харин ямар нэгэн юмаар бурхныг бүтээж болдоггүй, гэтэл тийм бясалгалын аргыг хэрэглэхгүй бол бас бурхан болж чадахгүй, учир нь тийм бясалгалын арга, тийм сургаал ёс нь биднийг өөртөө дадуулж, биднийг дуудан сэрээж, өөрөө бурхан мөн гэдгийг мэдүүлдэг.

Урьд нэгэн түүх байжээ, нэг баян хүн хоёр хүүтэй, тэр хоёр хоёулаа л хөрөнгөтэй чинээлэг, цэцэн цэлмэг, хоёулаа л баян тансаг гэрт төрж өсжээ. Нэг өдөр дүү нь гадаад орон луу явж, өөр хэв маягийн амьдралыг ойлгож мэдье гэж бодоод энэ байдлаа аавдаа хэлжээ.

Гадаад оронд очсоны дараа зовлон зүдгүүрийг ханатал амссан боловч маш олон ёс зүйд суралцсан болохоор улам цэцэн сэргэлэн, улам билиг ухаантай, улам ажилсаг болжээ, маш олон нөхцөл байдлыг ойлгож, өөрийн далд чадвараа ч танин мэджээ, урьд нь ийм чадвартай байснаа ерөөс мэдээгүй байсан аж, учир нь гэртээ байх үедээ баян тансаг амьдарч, аливаа хэргийг боол зарц, ажилчид нь хийж, өөрөө юу ч хийдэггүй, шаардсан бүхэн нь бүгд байдаг болохоор өөрт нь ямар чадвар байдгийг огт мэдээгүй юмсанж. Гадуур гарч амьдралыг ойлгосны дараа угаас өөрт нь сэтгэгдэшгүй чадвар, сэтгэгдэшгүй авьяас билиг ийм их байгааг мэджээ, тиймээс тэр ихэд баярлаж, улам их ойлгох болжээ.

Гэтэл энэ ёс учрыг ойлгохоос өмнө тэр маш олон зовлон зүдгүүрийг туулж, хамгийн эцэст нь хүнд өвчинд нэрвэгдэх, мөнгө дутагдах, харж харгалзах хүнгүй, орогнох гэр орон ч үгүй, бас өөр хүмүүс муугаар хандах гэх зэрэг хамгийн хүнд бэрх нөхцөл байдал тохиолджээ, ингэснээр тэр гэр орноо туйлаас санан үгүйлэх болов. Тиймээс тэр үргэлжлүүлэн ингэж амьдарч болохгүй, заавал гэр лүүгээ буцах хэрэгтэй, гэртээ байх үед баян тансаг амьдарч байснаа яагаад гадаа гарч гуйлгачин шиг болж хувирав гэж бодож эхэлжээ. Тэр үеэр гэрээ ихэд санан дурсаж, гэр лүүгээ буцахыг бодож, гэрийнхээ хүмүүстэй холбогдохыг хүсчээ.

Тэгээд гэртээ ирэхэд аав нь ч халуун дотноор угтан авсан бөгөөд маш их баярлаж, даруй хамгийн гоё сайхан хувцас өмсгөн хамгаас амттай хоол идүүлж, хамгийн үнэтэй бэлэг өгч, тансаг сайхан их дайллага хийн хүүгээ угтжээ.

Тэр үед том хүү нь ааваасаа: “Та яагаад надад зориулж дайллага хийгээгүй вэ? Яагаад онцгой эд зүйлс өгөөгүй вэ? Өдийг хүртэл би танд чин үнэнчээр хандаж, танаас ер салаагүй, өдөр бүр асарч, ойр дотно явсан байтал яагаад юу ч өгөөгүй вэ?” гэж асуужээ, тэгэхэд аав нь: “Миний бүх юм бүгд та нарынх шүү” гэж хариулжээ.

Ах, дүү хоёрын байдал нь урьдынхтайгаа огт адилгүй болжээ, дүү нь юугаар ч дутаагүй, мөн л урьдынхтайгаа адилхан байгаа хэдий ч ахаасаа давуу талтай болсныг та нар мэдэж байна уу? Ахаасаа илүү зүйл нь гэвэл амьдралыг ойлгож, илүү цэцэн сэргэлэн, билиг ухаантай, илүү ажилсаг болж, өөрөө бүр илүү ухааран гэгээрч, өөрийн биеэ бүр илүү ойлгож таних болжээ, тийм үү? үгүй юу? Гэтэл ах нь харин хайрлахын зоргоор эрх танхи өссөн хүү тул тав тухтай амьдардаг хэдий ч түүний хувьд ямар сайн тал байх билээ? Зөвхөн тав тухтай амьдрах нь хэрэгцээгүй, тийм биз? Ах нь дүүтэйгээ адилхан баян тансаг хэдий ч дүүгээсээ билиг ухаанаар дутмаг, дүү нь одоо тун олон учир явдлыг ойлгон өөрийгөө бүр илүү ухааран таньж, бүр илүүгээр биеэ дааж амьдрах болсон байхад ах нь харин юу ч мэдэхгүй яг хэвээрээ.

Будда угаас Бурхан гэдэг нь зөв хэдий ч хамаг төрөлтөн болж байж л сая өөрийгөө бурхан гэдгээ мэдэж чадна, хамаг төрөлтөн болохгүй бол мэдэж чадахгүй, ойлгож байна уу? Хамаг төрөлтөн болоогүй л бол өөрсдөө бурхан байх нь ямар ч хэрэгцээгүй. Тиймээс бид тоост хорвоод ирж суралцах хэрэгтэй, хүн болоход суралцана, зовлон зүдгүүртэй байдлыг суралцана, ингэснээр л сая “баяр жаргал” гэж юу болохыг ойлгож чадна, “мөнх бус”-ын нөхцөл байдлыг суралцаж байж л “үүрд мөнх” гэж юу вэ гэдгийг ойлгож чадна, энэ “харанхуй мунхаг” ертөнцийг судалж суралцаж байж л сая “билиг ухаан” гэж юу болохыг мэдэж чаддаг.

“Төгс төгөлдөр”-т суралцахаас өмнө хэдийгээр бурхан мөн хэдий ч бас л “харанхуй мунхаг бурхан” хэвээрээ байдаг, тэгээд алгуураар урьдынхтай яг адилхан “гэгээрсэн бурхан”, жинхэнэ бурхан болж хувирна. Угаасаа бид юугаар ч дутаагүй байдаг, харин билиг нээгдэж гэгээрэх үед л ийм болдог юм биш, зөвхөн өөрсдөө мэддэггүй л байсан хэрэг, ойлгож байна уу?

Билиг нээгдэхээс өмнө болон хойно бүгд адилхан, урьд нь хэдий хэр их хүч чадалтай байсан, гэгээрсэний дараа мөн л тийм их хүч чадалтай болдог, зөвхөн урд нь тийм их хүч чадалтай байгаагаа харахан мэдээгүй л байдаг, одоо харин мэдэж авчээ. Тиймээс Шагжамуни Бурхан: “Нисваанис бол Бодь мөр мөн”, “Хамаг төрөлтөн бол Бурхан мөн” гэж өгүүлсэн байна. Бурхан Багш худлаа ярих ёсгүй, өнөөдөр багш чинь үүний утга санааг та нарт тайлбарлаж өгье. Яагаад бурхан бол хамаг төрөлтөн гэдэг вэ? Бурхан яагаад энэ ертөнцөд ирээд хамаг төрөлтөн болж, тийм их зовлон амсдаг билээ?

Үнэндээ зовлон нь зовлон биш, бид юм суралцаж байгаа хэрэг, энэ нь яг л сургуульд сууж суралцаж байгаатай адил, бага сургууль, дунд сургууль, их сургуулийн алинд нь ч суусан бүгд л тийм ч хялбар биш, гэвч энэ төрлийн хичээлээ суралцаж дуусгаад бид нилээд цэцэн сэргэлэн болж, том хүн болсны дараа өөрийн гэх байр суурь болон өөрийн биеэ түших чадвартай болдог тул суралцахгүй бол болохгүй, суралцахгүй бол өөрөө ямар чадвартайгаа мэдэж чадахгүй.

Аливаа төрөлтөн бүгд бурхан чанартай гэвэл угаас нэгэнт бурханы хутгийг олчихсон байдаг, тийм юм бол яагаад эмэгтэй хүн бурхан болж чадахгүй гэж хэлдэг вэ? Энэ бол шал утгагүй дэмий хэрэг, бурхан болдогоороо л болно, ямар ч ялгаварлах зүйл байдаггүй. Тиймээс зөв номтон, буруу номтон бүгд л мөр ёсон мөн, сайн ч бай, муу ч бай бүгд л бурхан мөн, сайн, муу гэж байдаггүй гэж та нарт олон удаа ярьсан билээ, гэтэл энэ бол хамгийн дээд төвшин юм, бид энэ төвшинд хүрэхээсээ өмнө эрхбиш суралцах хэрэгтэй бөгөөд сайн үйл үйлдэх хэрэгтэй, харин сайн, муу бүгд адил юм чинь суралцах шаардлагагүй, ямар ч байлаа гэсэн нэгэнт бурхан юм чинь бясалгах шаардлагагүй гэж ярьж болохгүй, ингэж бодож болохгүй, ойлгож байна уу?

Бид угаасаа бурхан мөн, гэлээ ч гэсэн бас бясалгах хэрэгтэй, яагаад гэвэл бид өөрсдөө бурхан мөн гэдгээ бас жинхэнээр нь ойлгоогүй байгаа, тийм үү? үгүй юу? Багш чинь ингэж яривал та нар итгэнэ, учир нь та нар багшдаа итгэдэг, гэвч та нар мөн л өөрийн биеэ жинхэнэ ёсоор таниагүй байгаа болохоор бясалгах хэрэгтэй, тэгэхгүй бол бид зовлон ихтэй болно, өөрийн биеэ танихаас өмнө бусдад бага зэрэг загнуулмагц сэтгэл шаналж, өөр хүн биднийг заналхийлбэл бид бас түүнийг заналхийлдэг, учир нь хамаг төрөлтөн бүгд бурхан мөн гэдгийг таньж мэдээгүй байсаар, хамаг төрөлтөнд эрх тэгш хандах сэтгэлд хүрч чадаагүй, ялгаварлах сэтгэлээ огоорч чадаагүй байдаг. Тиймээс эрхбиш бясалгах хэрэгтэй бөгөөд юунд ч сэтгэл татагдалгүй, хамаг төрөлтийг харахаараа өөрийгөө харж байгаа шиг болтлоо бясалгаж байж л сая өөрийн биеэ жинхэнээр ойлгосонд тооцогдоно. За юу! Та нарт асуулт байвал одоо асууж болно.

**Асуулт:** Бид Гэрэл, Аялгуут тэнгэрээс бууж ирсэн юм байж, энэ “гэрэл” болон “аялгуу” нь материалаг зүйлд харьяалагдах уу? Бурханы хутагт хүрсний дараа гэрэл болон аялгуу байхгүй болох уу? Эсвэл бурхан тиймэрхүү материалаг дүрстэй байж болохгүй юу?

**Их Багш:** Таны асуултыг аль хэдийнээ хариулчихсан шүү дээ, Гэрэл, аялгуут тэнгэр бол бурханы ертөнц биш, энэ бол бурхны ертөнц мөн гэж би яриагүй, Гэрэл, аялгуут тэнгэрийг “Агата” сударт дурджээ. Бидний энэ ертөнц дөнгөж эхлэн бүрэлдэх үеэр тэнгэрийн төрөлтөн Гэрэл, аялгуут тэнгэрээс бууж ирээд энд амьдарсан байна, харин бурхан бууж ирсэн биш, ойлгож байна уу? Гэрэл, аялгуут тэнгэрийн төрөлтөн бас л бурхан мөн хэдий ч бурханы хутагт хүрээгүй, тэд одоогийн хүмүүсээс дэсээр жаахан өндөр, гэвч дэлхийн бөмбөрцөг дээрх таван төрлийн үр тариаг идсэний дараа биеийн бүтэц нь явандаа болхи бүдүүлэг болж, дэс нь улам доошилж, эцсийн эцэст балар эртний хүмүүсийн байдалтай

болж хувирчээ. Тэр үед Гэрэл, аялгуут тэнгэрийн төрөлтөн бас бурхан биш байсан, гэвч Гэрэл, аялгуут тэнгэрийн ертөнцөд хэдэн Бурхан хувилгаан биеэр хүрч очин тэднийг сургасан ч байж магад, ойлгож байна уу?

Энэ нь бидний энэ ертөнцөд бурхан бодьсадва хувилгаан биеэр ирэн хүн болж хувираад хүнийг гэтэлгэдэгтэй адилхан. Бурхан бодьсадва хаа ч гэсэн оршдог. Тиймээс “Agama” сударт тэмдэглэснээр энэ ертөнц дөнгөж эхлэн бүрэлдэх үеэр хүнгүй байжээ, тэр үед Гэрэл, аялгуут тэнгэрийн орны хүн энд ирж амьдарсан байна, тэд бол буянтай тэнгэрийн төрөлтөн бөгөөд тун их гэрэл гэгээтэй байж, биеэс нь цацарсан гэрэл эргэн тойрныг нь гэрэлтүүлдэг, тухайн үед нар, сар гэж байгаагүй, тэд энд ирээд хэсэг хугацаа өнгөрсний дараа сониуч сэтгэл төрж, энэ ертөнцийн юмнаас идэж эхэлжээ, маш олон зүйлийг хараад туршин шалгаж идсээр улам их идэх болж, эцэс сүүлдээ бие нь бохир бүдүүлэг болон хувирч, хамгийн эхэн үеийн гэрэл гэгээтэй бие цогцосоо алджээ, тиймээс нисэж чадахаа больж, гэрэл нь яваандаа бүдгэрч, хамгийн сүүлд нь балар эртний хүн дүртэй болж хувирчээ.

Гэхдээ хүн болгон нь тийм дүртэй болж хувираагүй, зарим нь юм идээгүй учраас бие нь урьдын адил гэрэлтэй хэвээр үлджээ, тэд Гэрэл, аялгуут тэнгэрийн орондоо байх үедээ нэгэнт бурхан бодьсадвагаас сурч байсан болохоор энэ ертөнцөд ирсэн үед нь бурхан бодьсадва ч бууж ирээд тэднийг сургасан байж ч магад. Бие нь гэрэлтэй хүмүүс нилээд түргэн сурч чаддаг бөгөөд сурч дууссаны дараа элэг нэгтэндээ ном уламжлахад ямар ч асуудалгүй. Хэрвээ хүн нь хүнийгээ сургаж болдог юм бол Гэрэл, аялгуут тэнгэрийн орны хүмүүс яагаад хүн сургаж болохгүй билээ? Тийм үү? Үгүй юү? Энэ дэлхийд бурхан бодьсадвагийн хувилгаан байдаг юм бол Гэрэл, аялгуут тэнгэрийн оронд яагаад байж болохгүй билээ? Энэ дэлхийд бясалгаж чаддаг юм бол Гэрэл аялгуут тэнгэрийн оронд яагаад бясалгаж болохгүй билээ? Ойлгож байна уу?

Гэрэл, аялгуут тэнгэрийн орон нь бидний хүрэх хамгийн эцсийн орон биш, бидний уг дүрийн эх нутаг ч биш, гэхдээ бид тэндээс унаж ирсэн, учир нь тэр үед бурхан болоогүй, ердөө л Гэрэл, аялгуут тэнгэрийн оронд амьдарч байжээ, энэ ертөнцөд унаж ирээд хүн болж хувирсан байна, хэрвээ сайтар бясалгахгүй бол маргааш амьтан, өвс ургамал болон хувирчихаж ч магадгүй. Бурхан больё гэвэл ядаж л эхлээд хүн болох хэрэгтэй, тэгээд бурхан болсныхоо дараа дахин ирж хүн болоход асуудалгүй. Бурханы хутгийг олсны дараа юу хийсэн ч болно, одоогоор бурхны хутагт хүрээгүй байгаа хэдий ч хүн болж чадаж байгаа юм чинь бурхны хутгийг олсны дараа яагаад хүн болж чадахгүй байх билээ? Бурхны хутагт хүрсний дараа хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд нэгэн эрх чөлөөтэй хүн болдог, гэхдээ эрхбиш нэгэн “гэгээрсэн бурхан”, “хүч чадалтай бурхан” болох хэрэгтэй, энэ бол жинхэнээр бурхны хутагт хүрэх явдал мөн.

Ихэнх бурхан өөрийгөө бурхан гэдгээ мэддэггүй болохоор нисваанистай байдаг, хэрвээ өөрийгөө бурхан гэдгээ мэдэхгүй бол энгийн төрөлтөнтэй адил ямар ч хэрэггүй, ойлгож байна уу? Тиймээс

Шагжамуни Бурхан: “Хүний бие тун эрхэм нандин, хүн болохгүй бол бурхан болж чадахгүй” гэжээ, тэнгэрийн элч, эсвэл өөр төрөлтөн биднээс бүр илүү зөн билигтэй байж ч магад, гэвч тэд бурхан болж чаддаггүй, учир нь хүн болж байж л сая маш олон үйл хэрэгт суралцах тохиолтой болж чаддаг.

Диваажинд дэндүү баяр жаргалтай, бидэнд бясалгал хийхийг сануулах нөхцөл байдал байхгүй. Тамын оронд дэндүү зовлонтой болохоор бясалгаж чадахгүй. Тоост хорвоод зовлон зүдгүүр, баяр жаргал, эндүүрэл андуурал, харанхуй мунхаг, билиг ухаан, билиг нээгдэх, билиг нээгдэхгүй гэх мэтийн маш олон адилгүй нөхцөл байдал байдаг болохоор бид олон төрлийн амьдралын нөхцөл байдлаас маш түргэн суралцаж, хангалттай материал дундаас олон зүйлийг ойлгон таньж, өөрийгөө дадуулж чадна, ингэснээр бид бясалгал хийж бурханы хутагт хүрэх тохиолтой болж чадна, өөр ертөнцөд ийм боломж байхгүй. Тиймээс хүний бие тун эрхэм нандин тул аз тохиолоо сайтар ашиглан түргэн бясалгах хэрэгтэй, хэрвээ багшийгаа дагаж бясалгах дургүй бол өөр номын багшийг эрж олоод бясалгаарай. Ямар ч аргаар бясалгасан ч болно, бурханы хутагт хүрч чаддаг л юм бол болох нь тэр, гэхдээ бурхны хутагт хүргэж чадах бясалгалын аргыг ойлгодог бөгөөд та нарыг дагуулан туулан гэтэлгэж чадах багшийг хайж олоход тун ч амаргүй.

**Асуулт:** Хамаг төрөлтөн угаас бурхан байтлаа яагаад бас бясалгах хэрэгтэй вэ?

**Их Багш:** Бурхан өөрийгөө бурхан гэдгээ мэддэггүй болохоор хүн болох хэрэгтэй, хүн, бурхан хоёрыг жишиж адилтгаж байж дараа нь алгуураар бясалгаж, бурхны хутагт хүрэхийг мэдэж чаддаг. Тиймээс “дэлхий дахин угаас амгалан” гэж ярьдаг. Угаас нэгэнт бурхан юм байж, бясалгасан ч бурхан, бясалгаагүй байсан ч бурхан мөн, гэвч бясалгахгүй бол “харанхуй мунхаг бурхан”, бясалгасны дараа өөрийн биеэ таньчихдаг болохоор “гэгээрсэн бурхан”, “билиг ухаантай бурхан” болно, яг л багшийн чинь саяхан ярьсан ах дүү хоёрын үлгэртэй адил.

**Асуулт:** Бясалгалыг яаж хийдэг вэ?

**Их Багш:** Та маани тарни уншиж, Авид бурханыг дурсах нь илүү сайн (Бүгд инээлдэв), (Би очирын хувилгаан тарни уншдаг), багшийн чинь заасан тарни юм уу? (надад хүн заасан юм), тэгвэл битгий унш. Багшийнхаа заасан бүхнийг дураараа битгий өөр хүмүүст заа, өөр хүмүүсийн чамд заасан очирын хувилгаан тарнийг ном бичиг уншаад сурсан байж ч магадгүй, энэ нь багшийн чинь чамд уламжилсан тарнийн байдалтай адилгүй, ойлгож байна уу? “Ум мани бадмэ хум” гэх тарнийг бүгдээрээ сайн мэдэх байх, гэхдээ багш чинь чамд шууд уламжилсан тэр үед л хүчтэй байдаг юм, ном бичгээс сурснаас ондоо, тиймээс бусдад сургаж болохгүй, ярьж болохгүй.

**Асуулт:** Ойрын үед Тайваньд зөн билиг ихэд дэлгэрч байна, ийм зөн билиг нь та нарын бясалгын аргаас ямар ялгаатай вэ?

**Их Багш:** Тайваньд зөн билиг ихээр дэлгэрч байна аа, та зөн билиг бясалгамаар байна уу? (Бүгд инээлдэв) Сурах хүсэлтэй байвал очиж сураарай. Багшаасаа асуух хэрэг юу вэ? Би бусад хүн зөн

билгийг бясалгахыг дэмжихгүй, гэхдээ бид зөн билиггүй юм биш, гэвч ашигладаггүй, зөн билиг нь тийм ч сүрхий юм биш, зөн билгийг ашиглах нь зөвхөн биднийг тун доогуур дэсэд хүлэх л төдий зүйл, ойлгож байна уу? Учир нь хамгийн дээд дэсэд зөн билиг байдаггүй, юу ч байдаггүй, бясалгах нь хамгийн дээд төгс төгөлдөр төвшинд хүрэхийн төлөө, тиймээс бид иймэрхүү зөн билгийн үйл хэргийг тоож хамаардаггүй. Зөн билиг нь мөн л гурван ертөнцийн дотор байдаг, зөн билгийг сурах юмуу, ашиглавал гурван ертөнцийг даван туулж чадахгүй, хамгийн дээд төвшинд хүрч чаддаггүй.

Гэвч зөн билиг нь бас хэрэгтэй, зарим хүн зөн билгээр тоглох дуртай, гэхдээ би шавь нарыгаа зөн билиг сурахыг дэмждэггүй, зөн билиг хэрэглэхийг хориглодог. Бясалгал хийвэл лав зөн билигтэй болно, бага сага ч гэсэн бүгд байх болно, гэвч бид ашигладаггүй, байлаа ч гэсэн хэрэглэдэггүй, гэхдээ зориудаар зөн билигт суралцдаг ч үгүй, ашигладаг ч үгүй.

**Асуулт:** Шунал, хилэн, мунхагийг яаж засах вэ? Яаж шийдвэрлэвэл зохих вэ?

**Их Багш:** Бид өөрөө өөрийгөө танин эзэмдэх хэрэгтэй, бясалгал хийх нь бага зэрэг ач тустай, (билиг ухаанаараа түүнийг хянан засаарай), (Гэтэл би үргэлж чин сэтгэлээсээ өөрийгөө хязгаарлаж чаддаггүй, ер нь шунахай сэтгэлээ эзэмдэж чаддаггүй, жишээ нь, заримдаа бусдад туслах гэхээр харин сэтгэлдээ дургүй хүрч, яалаа гэж туслах юм бэ? Туслахгүй байж болохгүй юу гэж сэтгэл дотроо зөрчилдөж, чин сэтгэлээсээ бусдад тусалж чаддаггүйг яана).

**Их Багш:** Та хүч чадалгүй болохоор чин сэтгэлээсээ хийж чаддаггүй, гэсэн ч өөрийгөө албадан байж бусдад туслах нь ерөөс туслаагүйгээс илүү дээр, ядаж л нөгөө этгээд чинь таны тусыг хүртэж чадна, гэхдээ зарим хүн бидний сайхан сэтгэлийг ашиглаж муу хэрэг үйлддэг. Тиймээс бусдад туслахдаа нөхцөл байдлыг харж хэрэгтэй. Өөрийгөө албадаж байж бусдад туслах нь тун сайн, зарим хүн өөрийгөө ерөөс албаддаггүй, бусдад тусалдаггүй, гэтэл та бусдад туслах дургүй хэдий ч өөрийгөө албадан байж тусалж байдаг чинь нэгэнт дэвшилттэй болж, өөрийн залхуу хойрго дадал зуршлаа хязгаарлаж чадсаныг илэрхийлж байгаа хэрэг. Аминч үзлийг өөрөө бага зэрэг хязгаарлаж болдог, аажмаар өөрийгөө хязгаарлаж, өөрийгөө өөрчилж, өөрөө улам сайжирсаар байгаад хэзээ нэгэн өдөр өөрийгөө албадалгүй, аяндаа хийх болно.

Яг л дөнгөж эхлэн машин жолоодож сурах үед олон талын дүрэм горимыг анхаарах хэрэгтэй болж, яаж жолоодохоо сайн мэддэггүйтэй адил, гэвч өдөр бүр дадуулаад байвал аажмаар улам сайн жолоодох болж, эцэс сүүлд нь хар аяндаа барьж, юм ярихын зэрэгцээ машинаа жолоодоход ямар ч асуудалгүй болдог. Дөнгөж эхлэн сурах үед юм ярихгүй байсан ч сайн жолоодож чаддаггүй, тийм үү? үгүй юү? Хүн бас ийм, заавал мэрийж чармайх хэрэгтэй, харин хүн болж төрмөгцөө л амжилтад хүрсэн амьд бурхан болчихдог юм биш. Тиймээс дадуулах тусам аяндаа болж, хожим нэгэн зүйлийн дадал зуршил болж хувирдаг.

Та маш үнэнч, өөрийн дутагдал, шунал, хилэн, мунхаг тань их гэдгээ нуулгүй ярьж байгаа нь тун сайн, ийм зориг зүрхтэй хүн хэр их байдаг билээ? Дутагдалтай тал байгаа хэдий ч бас сайн тал байна. Та өөрийн дутагдлаа мэдэж байгаа болохоор бардамнаж омгорхдоггүй. Өөрийн дутагдлаа мэддэггүй хүн л хамгаас яршигтай. Ингэснээр бардам зантай болдог, өөрийн дутагдлаа мэдвэл даруу хичээнгүй болж, гэмшиж ухаарах болно. Даруу хүн бясалгаж чаддаг байхад бардам зантай хүн чаддаггүй. Бардам зан бол бясалгал хийхийн хамгийн их саад харш юм, бардам зангаасаа болоод бусдаас асуух дургүй, багш чинь “би”-гээс дээд, “би”-гээс илүү ихийг мэддэг, “би”-г удирдан залж чаддаг гэдэгт итгэдэггүй, ингэх нь хамгийн их харш саад мөн.

**Асуулт:** Бид гэртээ Арьяабал Бурхан болон Шагжамуни Бурханы хөргийг шүтэн тахиж, өглөө оройдоо мөргөвөл энэ нь сайн уу, муу юу?

**Их Багш:** Тун сайн, гэвч “сэтгэл”-ээрээ мөргөх хэрэгтэй, (Ямар нэг төвөг бэрхшээлтэй болбол түүнээс тусламж гуйж болох уу?) тэгэх ёстой, урд нь би бас ингэдэг байсан, одоо ч мөн адилхан, зөвхөн гаднаас харахад л өөр байгаа юм шиг төдий. Одоо би сэтгэлдээ мөргөж, сэтгэлдээ гуйдаг, Арьяабал бурханы хөрөг зургийг шаарддаггүй, тэгсэн ч адилхан гуйж болно шүү дээ. Би хорин дөрвөн цагаар бодьсадвад даатгадаг, гэхдээ урд нь төвөг бэрхшээл тохиолдох үед л даатгаж, энгийн үедээ мартчихдаг байсан, тэгээд төвөг бэрхшээл тохиолдмогч тэр даруй Арьяабал бурханы хөргийн өмнө сөгдөж, даатган мөргөдөг, бэрхшээл тохиолдоогүй үед тоох ч үгүй, бүтэн жилээр ч түүнийг ойшоодоггүй байдаг байжээ (Бүгд инээлдэв), одоо бол багш чинь хорин дөрвөн цагаар Арьяабал бурханд даатгадаг ч хүмүүс харж чаддаггүй. Урд нь хүмүүс миний даатган мөргөдгийг хараад чин сэтгэлээсээ Арьяабал бурханд итгэдэг гэж боддог байжээ, одоо харин Арьяабал бурханд даатгаахаа больсныг хараад багшийг чинь буруу номтон гэж үздэг, гэхдээ би одоо урьдынхаасаа бүр ч илүү чин сэтгэлээсээ, бүр ч хянамгай даатгадгийг тэд мэддэггүй болохоор миний дотоодын байдлыг сайн ойлгодоггүй.

Арьяабал бурханд даатгахдаа заавал бодьсадвагийн хөрөг зургийн өмнө мөргөн даатгах албагүй, гэтэл хамаг төрөлтөн сул дорой болохоор дөнгөж эхлэх үед өнгөн талын бурхны хөрөгт найдахгүй бол бодол сэтгэлээ төвлөрүүлж чадахгүй, хянамгай няхуур даатгаж чадахгүй байдаг. Тиймээс дөнгөж эхлэх үед өнгөн талын хэлбэр дүрстэй зүйлс шаардагдана, тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа хэлбэр дүрс, дуу чимээгүй ч гэсэн адилхан бясалгал хийж, даатган мөргөж болдог.

Гэтэл зарим хүн үүнийг ойлгодоггүй, харин багшийг чинь буруугаар ойлгон Арьяабал бурханд даатгадаггүй, бурхны хөрөгт хүндэтгэн мөргөдөггүйг хараад буруу номтон байна гэж үздэг, яагаад ийм буруу ойлголт төрж болох билээ? Угаас бүгд л “мөр” (Дао) байтал яагаад буруу номтон болж болох билээ? Гэтэл хамаг төрөлтний дэс нь адилгүй болохоор энэ ёсыг хүн болгоныг ойлго гэж шаардах боломжгүй, багшийнхаа хэлсэн санааг ойлгож байна уу? Одоогоор ойлгож байгаа хэдий ч маргааш болохоор бүгдийг нь мартчихдаг, нөгөөдөр дахиад л багш бол буруу номтон мөн (Бүгд инээлдэв) гэж, хоёр хоногийн дараа



ахиад л багш бол зөв номтон гэж бодно, дараа жил нь болохоор багшийн дэс тун өндөр гэж бодож ч магадгүй. Ингэж байнга солигдоод байдаг нь ерөөс та нарын үзэл бодлоос л болдог, багш чинь угийн хэвээрээ, өнөөдөр болон маргааш, эсвэл нөгөөдөр бүгд адилхан. Гэтэл та нарын дэс чинь адилгүй болохоор ойлгохгүй байгаа юм. Ихэнх хүн одоо багшдаа загнуулаад урам муутай байгаа хэдий ч дараа жил болохоор харин багшдаа баярлан талархах болно, учир нь дэс нь өөр болсон болохоор бодол санаа нь ч дагаад дээшилж өөрчлөгддөг.

## ЭНЭТХЭГ, ХЯТАД, ЯПОН УЛСЫН ДАЯАНЫ УРСГАЛ ЯАГААД АДИЛГҮЙ БАЙДАГ ВЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Жилонд  
(Эх нь хятад хэлээр)  
1987 оны 3 дугаар сар*

Аливаа бясалгалын арга бүгд сайн, ном хаялцах нь ч сайн, бурхныг дурсаж, бурханд мөргөх нь ч сайн, нууц тарни, ил тарнийн бүлэг, даяаны бүлэг, цао тонгийн бүлэгтэн гэхчилэн аливаа бясалгалын арга нь бүгд сайн, зарим хүн бүр дэлгэрэнгүйгээр: аливаа шашин бүгд сайн, буддын шашин сайн, католик шашин сайн, бумбын сургаал ч гэсэн сайн гэж ярьдаг, гэвч яагаад сайн байдгийг нь огт ойлгодоггүй. Ярихад тун амархан, бүх юм бүгд сайн, аливаа шашин, аливаа урсгал бүлэг бүгд сайн гэж ярьдаг хэдий ч сайн нь чухам хаанаа байгааг нь өөрсдөө мэддэггүй, сайн гэж ярьдаг хэдий ч цаанаа эргэлзэн тээнэлзэж, санаа нь тогтворгүй болохоор олон газраар хайж, чухам хаа хүрч, аль урсгалыг нь сонгож, ямар аргаар бясалгавал хамгийн сайн гэдгийг мэддэггүй.

Аливаа шашин угаас бүгд сайн гэж өчигдөр багш чинь ярьсан, гэвч улирч хувирсаар байгаад одоо харин улам л муу болжээ, одоо ямар ч шашин бүгд л хамгийн анхны үеийнх шигээ тийм сайн биш болсон байна. Ингэж ярихаар аль ч шашныхан бүгд багшийг чинь хайж ирэхээс айж байна (Бүгд инээлдэв). Яагаад сайн биш вэ, сайн гэвч бас сайн биш, жинхэнэ багш байхгүй болохоор сайн биш байгаа юм. Бид бурханд мөргөх, эсвэл маани тарни унших, ном судар унших, ном судар судлах, тэнгэр бурхан, Есүс Христэд даатгах зэрэг нь бүгд л анхан шатны дэс төдий, дараа нь бид заавал өөрийн биеэ хайж олох ёстой байдаг, тэгэх үед тэр аргууд бүгд хангалттай биш болдог болохоор сайн биш гэж хэлж байгаа юм. Гэхдээ хамгийн төгс төгөлдөр, хамгийн дээд зорилгын талаар ярьсан ч хангалттай сайн биш.

Учир нь Шагжамуни Бурхан өдөр бүр бурханд мөргөж, бурхныг дурсаж байж л бурхны хутагт хүрсэн гэж бид ерөөсөө сонсоогүй. Зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн ч гэсэн өдөр бүр бурханд мөргөж, маани тарни уншиж, судар ном судлан уншиж байж л сая зургадугаар үеийн Өвгө Багш болсон гэж огт сонсоогүй, тэрээр нуун далдалж, өөрийнхөө бясалгаж байгааг ярьж зүрхэлдэггүй байсан бөгөөд ургамал хоол иддэг гэдгээ ч бусдад мэдэгддэггүй байсан тул тиймэрхүү хөгжөөнтэй бясалгалын аргыг бясалгаж бүр ч зүрхлэхгүй (Бүгд инээлдэв). Есүс Христ ч гэсэн өдөр бүр уул, усанд сөгдөн мөргөх,

эсвэл ном сударт мөргөн ном судрыг судлан байж л Эзэн Бурханы хүү болж чадсан гэж сонсоогүй, тийм үү? үгүй юү? Тэр ингээгүй, анх эхлэн бясалгаж үеэрээ тэд ингэдэг байсан ч байж магадгүй, гэвч эцэс сүүлд нь бүгд л бясалган сууж, өөрөө өөрийгөө эрж хайж байж л сая бурханы хутагт хүрч, мөр ёсыг олж чаджээ.

Шагжамуни Бурхан зургаан жил гаруй хатуужилтай бясалгаж, унтахдаа ч гэсэн хэвтэж зүрхэлдэггүй байжээ, Есүс Христ бас бясалгаж суудаг байсныг яаж мэдэж болох вэ гэвэл Есүс Христ ном дэлгэрүүлэхээсээ өмнө элсэн цөлд дөч хоног нойр хоолгүй бясалгаж суусны дараа сая ном тайлахаар явжээ. Нэг хүн элсэн цөлд дөч хоног битүүмжлэн сууж байснаас нь бид түүнийг олон жилээр бясалгаж байсныг нь ойлгож болно, харин тэр гэнэт диваажингаас унаж ирсэн биш. Зөвхөн дөч хоног л бясалгаж суугаад Есүс Христтэй адил дэсэд хүрч, ном дэлгэрүүлж чадах тийм боломж байхгүйг бид бүгд мэднэ.

Зургаадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн арван зургаан жил гаруй нууцаар бясалгал хийж байсан бөгөөд өдөр бүр бясалган сууж байж л сая Төгс Гэгээрсэн Их Багш болж чадсан. Гэтэл зарим хүн харин зургадугаар үеийн өвгө Багш Хүй Нэн бясалгаж суугаагүй гэж ярьдаг, тэр бясалгаж суусан, яагаад гэвэл нэг хүн түүнээс: “Та бясалгаж суух үедээ юм хардаг уу?” гэж асуухад: “Би бясалгаж суух үедээ юм хардаг, бас хардаггүй” гэж хариулжээ. Бодьдармаа ч гэсэн хана руу харан есөн жил бясалган суужээ. Энэ Их Багш нарын түүхээс бурхны хутагт хүрэх, эсвэл мөр бүтээх гэвэл заавал бясалгаж суух хэрэгтэй гэдгийг баталгаатай ойлгож болно. Гэхдээ бясалгалын талаар маш олон шашны урсгал бүлэг байдаг бөгөөд маш олон бясалгалын арга байдаг. Тиймээс бид яаж бясалгаж суувал зохилтой вэ гэдгийг өөрөөсөө туршин асуух хэрэгтэй.

Өчигдөр багшийн чинь та нарт тараасан ном тайлсан материалд аливаа бясалгалын арга нь бүгд л Арьяабалын бясалгалын арга мөн (Агшин зуур гэгээрэх түлхүүр, нэгдүгээр богийн долдугаар хэсэг) гэж ярьсан байгаа, та нар уншсан уу? Уншсан хүн байвал урьд цагийн Төгс Гэгээрсэн Их Багш нар бясалган сууж байсан эсэхийг өнөөдөр мэдчихсэн байгаа. Тэд мөн Арьяабалын бясалгалын аргыг бясалгадаг байсныг ном тайлсан материалыг уншаад мэдэж болно, тиймээс багш чинь өнөөдөр дахин нуршихаа болье! Өнөөдөр би Арьяабалын бясалгалын арга нь яагаад тийм их ач тустай байдаг вэ гэдэг талаар ярина.

Бидний сонссоноор тун олон номын багш өөр өөр бясалгалын аргыг сургадаг байсан, эхлээд үүнийг ярихгүй, бурхныг дурсах талаар ярь. Ихэнх хүн бурхныг дурсах нь даяаны бүлэг биш, харин ариун орны бүлэг гэж үздэг, бурхныг “дурсах” нь мөн л даяаны бүлэг мөн, хүмүүс ойлгодоггүй болохоор ариун орны бүлэг болж хувирчээ, ойлгосны дараа бас л даяаны бүлэг мөн, бясалгалаар өндөр болсны дараа аливаа бясалгалын арга нь анх эхэндээ бүгд л Арьяабалын бясалгалын арга байсан гэдгийг мэдэх болно, бурхныг дурсах нь мөн л ийм.

Бурхныг дурсах нь одоо урьдынхтай адилгүй болжээ, өнөөдөр бурхны алдрыг уншиж байгаа болохоос биш, харин “Бурханыг дурсаж” байгаа юм биш. Бурхны алдрыг унших гэж юу вэ гэвэл ном уншихтай

адил чанга дуугаар уншихыг хэлнэ. Ном аялгуулан унших гэдэг бол бидэнд ямар эргэлзээ байна, эсвэл ном судрын утгыг бодох үеэр ном судрыг санан дурсахыг хэлнэ, ном судар унших гэдэг нь хуудас дараалан уншихыг хэлнэ, ном аялгуулан унших гэдэг нь чанга дуугаар уншихыг хэлнэ, тиймээс “на ; ; мү ; ; а ; ; ви ; ; да ; ; бурхан ” гэж унших нь мөн л бурхныг аялгуулан уншиж байгаа хэрэг болно, ойлгож байна уу?

Бурхныг дурсах нь ийм биш юм, дурсах гэдэг нь санаж дурсахын “дурсах” юм, хэрвээ нэг хүн, эсвэл нэг юмыг санаж дурсах гэвэл эхлээд таньдаг байж л сая санаж дурсаж болно, танихгүй бол яаж санаж дурсах билээ? Би чанга дуугаар бурхны нэрийг уншихгүй, сэтгэлдээ чимээгүй уншина гэж хэллээ ч зөв биш, учир нь Авид бурхныг танихгүй юм чинь яаж “унших” юм билээ? Нэгэн үзэсгэлэнтэй бүсгүйтэй танилцаагүй байж гэртээ харьсны дараа яаж санан дурсаж чадах билээ? Юуг бодож, юуг дурсах билээ? Багшийнхаа ярьж байгааг ойлгож байна уу? Хүмүүс хоорондоо харилцан танилцаагүй бол дурсаж чаддаггүй юм чинь тийм дээд төвшинд байгаа бурхныг танихгүй бол яаж “дурсах” билээ? Тиймээс өнөөдрийнх бол бүгд “бурхныг аялгуулан унших” болохоос биш, “бурханыг дурсах” биш юм.

Бурхныг дурсах нь угаасаа Арьяабалын арга мөн, Арьяабалын бясалгалын аргыг яагаад бурхныг дурсах ном гэдэг вэ гэвэл бясалгагч билиг нээгдсэний дараа бурхантай холбогдож, бурхан чанар, бурхны хүчтэй холбогддог, тэр үед бид “бурхан чанар”-ыг хайж олсон шиг санагдана, өдөр бүр санан дурсаж болно. Үнэнчээр хичээнгүйлэн бясалгадаг бөгөөд үлэмж их буянтай хүн багшаас чинь суралцсаны дараа цаг завгүй, тогтсон цагаар бясалгаж чадахгүй болох тэр үед яг л хоол идээгүй юм шиг сонин санагддаг, энэ нь “санаж дурсах”-аас болжээ.

Өмнөх номын багш нар бүгд л: “Даяан үг хэл хэрэглэдэггүй” гэж ярьдаг, тийм үү? үгүй юү? Үнэхээр тийм юм бол одоо харин: “Наму Авид бурхан” гэж энэ ертөнцийн үг хэлээр аялгуулан унших болжээ. Хэрвээ үг хэл хэрэглэхгүй гэвэл ном хаялцах нь ч буруу, ном сударт мөргөх нь ч буруу болно, энэ бие цогцосоор бясалгаж, бие цогцосоор мөргөж байж яаж бодь мөрийг олж чадах билээ? Бурхныг аялгуулан унших, эсвэл ном хаялцах зэрэг нь бүгд л үг хэл хэрэглэдэг, амьсгалаа тоолох нь ч гэсэн анхаарлаа энэ бие цогцост хандуулдаг, амьсгал бол мөнх бус зүйл, биеийн хийг дасгалжуулах, эсвэл ямар нэг дасгал хийх зэрэг нь бүгд энэ мөнх бус бие цогцосоороо бясалгадаг, нэг зүйлийн мөнх бус зүйлээр төгс төгөлдөр өнө мөнхийн байр суурийг хэрхэн олж чадах билээ?

Бидэнд одоо “бясалгал хийх арга хэмээгч” зүйл маш олон байдаг, зарим нь ном сударт мөргөж, зарим нь ном судар судална, зарим нь бурхныг аялгуулан уншиж, зарим нь бурханд залбирч, зарим нь уул ус, хувхай яс, шарил гэх мэтийг шүтэн тахидаг, шарил бол яснаас бий болдог, шарилд мөргөх нь бидний хувьд хувхай ясанд мөргөж байгаатай адил.

Уул, усыг шүтэн тахиx нь маш сайн бясалгалын арга гэвэл өндөр настан, эсвэл бие тааруухан, хөлгүй хүн ууланд очиж мөргөх боломжгүй,

тэгвэл яаж бясалгах билээ? Хэрвээ ном хаялцах нь хамгийн сайн бясалгалын арга гэвэл тэр талаар тийм ч их мэдлэггүй бөгөөд өөрөөсөө тийм айхтар асуулт асууж чадахгүй хүмүүс яаж бясалгах вэ? Хятад хэл ойлгохгүй, эсвэл тэр Их Багшийн хэлийг ойлгохгүй байж мэднэ, тэгвэл яаж бясалгах билээ?

Багш чинь И Ландад ном тайлах үеэр нэгэн сүмийн их лам: “Ном судраа багш болго!” гээд шавь нарыгаа багшийн чинь ном тайлахыг сонсохгүй байжээ. Тэрээр ном судрыг багш болгож, ном судар байвал хангалттай болох нь тэр гэж үздэг байна, за, тэгвэл ном судар унших нь төгс төгөлдөр бясалгалын юм арга гэвэл зарим хүн бичиг үсэг мэддэггүй, ном уншиж чаддаггүй бол яаж бясалгах билээ? Амьсгалаа бясалгах аргыг ч гэсэн ойлгож байж л сая бясалгаж чаддаг, тэгвэл дүлий хүн яаж бясалгах бэ? Сохор хүн юу ч уншиж чаддаггүй, юу ч ярьсан ойлгохгүй, дүлий, бас сохор юм бол яаж бясалгах билээ? Бяцхан хүүхэд яаж бясалгах билээ? Томчууд олон цагаар сууж чадахгүй бол яаж бясалгах вэ? Завилж сууж чадахгүй бол яаж бясалгах вэ? Хөлгүй бол яаж бясалгах вэ?

Одоогийн даяан бүгд л завилж суух Очир завилгааг чухалд үзэж, огтхон ч хөдлөхгүй суувал бурхан болж чадна гэж үздэг. Гэтэл зарим хүн Очир завилгаагаар сууж чаддаггүй, цэргийн алба хааж байхдаа хөлөө тайруулсан юмуу, өвчнөөс болж өрөөсөн хөлөө тайруулсан байж ч магадгүй, тиймээс завилж суух боломжгүй бол яаж бясалгах билээ? Зөвхөн Арьяабалын бясалгалын арга л хэнд ч тохирно, саяын дурьдсан тэр эрхтэн дутуу хүмүүс ч гэсэн бясалгаж болно, багшийнхаа ярьсан санааг ойлгож байна уу?

Одоо Энэтхэгийн даяаны талаар ярья. Буддын шашны даяан нь угаас Энэтхэгээс уламжлалтай, Буддын шашны бясалгал болон Хятадын Бумбын шашны үзэл санааг уусган нэгтгээд Хятадын даяан болж хувирчээ, Энэтхэгийн бясалгалын арга бол маш уян хатан, Энэтхэгийн бясалгагч тун эерэг зөөлөн байж, загнах зодох асуудал тийм их байдаггүй. Гэтэл Энэтхэгийн уян зөөлөн бясалгалын арга нь Хятадад уламжлагдсаны дараа нилээд хатуу ширүүн болж хувирчээ. Тиймээс эртний номын багш нар шавь нараа зоддог байсан гэж бид сонссон билээ.

Буддын шашин Төвөдөд уламжлагдсаны дараа мөн л тун ширүүн болж хувирчээ, тиймээс Мял Богдын багш нь өдөр бүр түүнийг загнаж, зоддог байжээ. Тэгээд олон жил зодож загнасны дараа түүнд ном уламжилсан билээ. Даяан нь Японд уламжлагдсаны дараа бүр ч хэцүү болон хувирч, загнаж зодох төдийгүй хүн алдаг нь ч бас бий болжээ. Тиймээс урд нь зарим Япон хүн ном хаялцахдаа сайн хаялцаж чадахгүй бол багшийнхаа өмнө хэвлийгээ хүүлж амиа хорлодог гэдэг, үүнийг сонсоод миний хамаг бие дагжин чичирсэн, бясалгал хийж байгаа аглаа яагаад тийм хэрцгий, тийм ширүүн байж болох вэ? Үнэхээр ийм юм бол би ч гэсэн бясалгаж зүрхлэхгүй.

Яагаад улам бүр хэцүү болсон бэ? Энэтхэгт ийм байдал байхгүй, Хятадад уламжлагдсаны дараа заавал ихэд загнаж зодох хэрэгтэй, Авид

Бурхан гэж нэг удаа уншвал эрхбиш гурван хоног амаа зайлах хэрэгтэй. Төвөдөд уламжлагдсаны дараа хэдэн жилээр хүн зодох хэрэгтэй болж, Японд уламжлагдасны дараа хэвлийгээ хүүлж хагалах болов. Яагаад ийм болж хувирав? Хэн мэдэх вэ? Мэдэх хүн байхгүй юу? За! Би тайлбарлаж өгье.

Учир нь Энэтхэг бол төрөл төрөлдөө сүнслэг дадал бясалгал хийдэг ариун дагшин орон байж, тэндхийн хүмүүс хар багаасаа эхлэн ургамал хоолтон бөгөөд сахил хүртчихсэн байдаг. Миний өвгө Багш нар тав, зургаан наснаасаа эхлэн нэгэнт бясалгаж суудаг байжээ. Тайваньд багш чинь бас зургаан наснаас дээших хүүхдүүдэд ном уламжилсан байдаг, тэд бас бясалгаж суудаг бөгөөд ахуй ойлголтоор тун сайн байв. Энэтхэгчүүд бясалгал хийхийг сайн ойлгодог, бяцхан хүүхэд тийм ихээр бясалгаж суудаггүй байж магад, гэвч анхнаасаа л ургамал хоол идэж, шоргоолж, шумуулыг ч алж зүрхэлдэггүй бөгөөд шумуул ч гэсэн тэднийг хаздаггүй, тэд ууланд бясалгаж суухад могой хүртэл хатгаж хаздаггүй, бар ч гэсэн тэдэнтэй найзалж, тоглохоор ирдэггүй (бүгд инээлдэв), яагаад ийм байдаг билээ гэвэл тэд хар багаасаа ургамал хоолтон болсон болохоор цэвэр ариун уур амьсгалыг нь амьтан хардаг ч өөрийг нь хараагүйтэй адил байдаг. Амьтад бидэн рүү дайрдаг нь бид өөрсдөө тайван амгалан биш, аймшигтай бөгөөд айдастай уур амьсгал, орчин үүсгэдэг болохоор амьтад хармагц эсэргүүцэх бодол төрдөг, гэтэл бясалгал хийдэг хүмүүсийн хувьд нэгэнт цэвэр ариун болж, тийм хэрцгий хүч байхгүй болохоор амьтад эсрэгүүцэхгүй бөгөөд түүн лүү дайрах бодол төрөхгүй. Жишээ нь: бид эхлээд нэг хүнийг зодох юмуу, загнасны дараа тэр хүн сая биднийг эсэргүүцэх юмуу, хариу зоддог, хэрвээ эелдэг дотно хандвал ямар ч асуудал үүсэхгүй. Үүнтэй адил, амьтад ч гэсэн хүмүүсээс айдаг бөгөөд хүмүүсийн амьсгал, орчныг үнэрлэж мэддэг. Тиймээс бясалгалаар өндөр эртний хүний амьсгал, орчин маш эерэг зөөлөн болохоор болжмор шувуу, араатан амьтад хүртэл түүнд ойртох дуртай байдаг гэдэг, энэ бол их бясаллагчийн тухай бидний сонссон зүйл. Гэхдээ Энэтхэгт одоо ч гэсэн мөн л ийм, Гуан Чин өвгөн хувраг ч гэсэн урьд нь ийм байжээ.

Яагаад гэвэл Энэтхэг бол төрөл төрөлдөө бүгд л бясалгал хийдэг ариун дагшин орон мөн болохоор тиймэрхүү амьсгал, орчин нь бидний эндхийнхтэй адилгүй, Энэтхэг улсын хүмүүсийн зууны ерөн хувь нь одоо ч гэсэн ургамал хоолтон байж мах иддэггүй, хэдэн мянган жилийн турш ийм байсан, тиймээс амьсгал, орчин нь маш эерэг зөөлөн байдаг. Хималай уул бол төрөл төрөлдөө бясалгал хийдэг ариун дагшин орон мөн байсан, тэндхийн амьсгал, орчин хэзээ ч бохирдох боломжгүй, учир нь Хималай ууланд авирч гарахад маш бэрх, өвлийн улиралд авирч гарах боломжгүй, зуны улиралд ч гэсэн авиран гарахад маш бэрх.

Би Хималай ууланд явганаар авирч гарах үед хэдийгээр зуны улирал байсан ч мөн л маш бэрх байсан, харин хүн бүр авираад гарчихаж чаддаг юм биш, машинаар ч гэсэн тийм хол, тийм нууцлаг газар хүрч чаддаггүй, нисэх онгоцоор ч гэсэн тийм оронд хүрэхийн аргагүй, тэд чухам хаана нуугдан бясалгаж байгааг ойлгохын аргагүй, мэдэхийн ч

аргагүй. Тиймээс бясалгал хийдэггүй тэр олон төрлийн санаа бодолтой хүмүүс тэндхийн бясалгалын амьсгал, орчныг эвдэх боломж байхгүй.

Энэтхэгийн хүмүүс маш цэвэр ариун сэтгэлтэй, тэд нэгэн багшийг дагаж бясалгавал багш нь тийм хэрцгий аргаар сургадаггүй, учир нь шавь нар нь өөрсдөө нэгэнт цэвэр ариун, үйл түйтгэр бага болчихсон, багшийгаа дагаж бясалгах үед багшдаа ямар ч яршиг төвөг тарьдаггүй, багш шавийн хооронд угаас нэгэнт эв найрамдал байдаг болохоор буруугаар ойлгох, эсвэл уурлах явдал тийм их гардаггүй.

Тэд ёс суртахууны талаар хар багаасаа нэгэнт өөрийгөө дадуулж, сэтгэл нь тун ариун болчихсон бөгөөд хожим гэрлэсэн ч тэр, гэрлээгүй ч тэр, хэзээ нэгэн цагт гэрээс гарагч болно гэдгээ тодорхой ойлгож байдаг, ихэнх нь ийм бодолтой байдаг. Тэд гэрээс гарахгүй байж мэдэх хэдий ч гэртээ байхаасаа л нэгэнт бясалгаад эхэлчихсэн байдаг. Учир нь хар багаасаа аав, ээжийгээ дагаж бясалгадаг болохоор бясалгал хийх, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх, адислах хүч, туулан гэтлэх гэх зэрэг нь тэдний хувьд бүгд л тун ижил дасал, тун энгийн бөгөөд аяндаа хэрэг болсон байдаг. Тиймээс Энэтхэгт багш шавь хоорондоо бат бөх бөгөөд эерэг зөөлөн, ойр дотно байдаг.

Гэтэл Буддын шашин Хятад, эсвэл Түвд, Вьетнам, Япон зэрэг оронд уламжлагдсаны дараа амьсгал, орчин нь адилгүй болж хувирчээ. Миний таньдаг нэгэн багш Энэтхэгийн нэг тосгонд очиж, ном тайлах үеэр ганцхан хоногийн төдийд л тэр тосгоны эрэгтэй, эмэгтэй, хөгшин залуу, тэр ч байтугай нохой, гахай, галуу, нугас нь хүртэл бүгд ном уламжлахыг гуйжээ, ном уламжлах үеэр тосгоны хэдэн мянган хүн хамт цугларч, хүчтэй өсгөгчөөр ярьж ном уламжилсан байна. Олон хүнийг бүгдийг нь харахын тулд миний Багш маш өндөр суудалд залран хэдэн мянган хүн хамтдаа ном хүртсэн байна.

Яагаад хэдэн мянган хүн хамт сурдаг вэ? Яагаад тийм амархан байдаг вэ? гэвэл тэд аль хэдийн бэлтгэгдчихсэн, ургамал хоол иддэг мөртлөө нэгэн “Гүрү”, нэгэн Их Багш ирж тэднийг удирдан жолоодохыг хүсэн хүлээдэг байжээ. Тиймээс ийм нэг багш заларч ном тайлмагц тэд даруй ойлгодог бөгөөд ахуй ойлголттой болдог, гэхдээ Багшийн минь биеэс гэрэл цацрахыг, эсвэл өөр байдлыг нь харж чаддаг ч байж мэднэ, тэгээд дорхноо итгэдэг болохоор Багш минь нэг удаад хэдэн мянган хүнд авшиг хүртээж, ном уламжилж чадсан хэрэг.

Хэдэн мянган хүн хамт суун авшиг хүртэх тийм сүр жавхлант байдал нь маш үзэсгэлэнтэй. Тэд эрэгтэй, эмэгтэй хоёр хэсэг болон сууна, хэдийгээр тун ядуу бөгөөд энгийн хувцастай хэдий ч хамгийн гоё хувцсаа өмсөж, Багшийн маань ном тайлахыг сонсдог, эрэгтэйчүүдийн хувцас засал нь тун сүр жавхаатай, нэлэнхүйдээ цав цагаанаар хувцасласан нь тун гоё харагдана, эмэгтэйчүүдийн хувцас нь ч адилхан, гагцхүү олон янзын хурц өнгөтэй боловч тун цэвэрхэн бөгөөд үзэсгэлэнтэй харагдана.

Тэд бүгдээрээ аниргүй нам жим болж, огт хөдлөлгүй сууна, тэр ч байтугай ялаа, шумуулын хүнгэнэн нисэх дуу сонсогдмоор тийм нам жим, тэд Багшийг маань тэгж л их хүндлэн шүтэж, хүсэн хүлээж, бүх тосгоноороо авшиг хүртэж, нохой, муур, галуу, нугас нь хүртэл ирж

ном сонсдог (Бүгд инээлдэв), үүнийг хараад би машинд сэтгэл догдолсон бөгөөд тун ч сайхан санагдсан. Тиймээс Энэтхэгт ном уламжлахад тун хялбар, Шагжамуни Бурхан амьд байх үедээ Энэтхэгийн бүх газраар тойрон ном уламжилжээ, ингэснээр тэнгэрийн орны бүх төрөлтөн болон арван зүг, гурван цагийн бурхад цөм түүнийг хамгаас сайн, хамгаас мундаг, таван цөвүүн цаг үеэр ном тайлж, ном уламжилж чадсан гэж шагшин магтжээ, учир нь оройн дээд бясалгалын аргыг тайлбарлахад хүмүүсийн ойлгох нь тун хүнд хүчир, хүлээж авахад хамгийн бэрх хэцүү билээ. Гэвч миний бодлоор Шагжамуни Бурхан бас тийм ч сүрхий биш, учир нь түүний амьдарч байсан үе бол номын өрнөл бадралын цаг үе, хүмүүсийн сэтгэл маш ариун байжээ, хоёр мянга таван зуун жилийн өмнө хүмүүсийн сэтгэл хичнээн хэрцгий байсан ч өнөөгийн хүмүүс шиг ийм хэрцгий биш, тийм үү? үгүй юү?

Урд нь нэг хүн хэрцгий байсан бол зөвхөн өөрөө л мэддэг, эсвэл хамаатан садан, хөрш айл, найз нөхөд нь мэддэг төдийхөн байсан бөгөөд ихдээ л хорь, гучин хүнд нөлөөлдөг. Гэтэл өнөөдөр хэвлэл мэдээлэл ихэд хөгжин тархсан болохоор ганц хоёр муу хүн байвал сонин, телевиз, радио гэх зэргээр дамжин тэр даруй маш олон хүнд нөлөөлдөг, тиймээс нэг хүн буруудвал олон хүнд нөлөөлдөг. Та нар хар л даа! Одоо дууны хуурцаг, радио, телевиз, сонин, утас гэх зэрэг нь бидэнд хялбар дөхөм нөхцөл байдлыг хангадаг хэдий ч зарим хүн бас үүнийг ашиглан муу хэрэг үйлдэхэд тун амар хялбар болсон байна. Тиймээс өнөөдөр сөрөг муу мэдээ маш түргэнээр дамжин тархаж, маш олон хүнд нөлөөлөхийн зэргэцгээгээр тэд даган дууриадаг.

Золоор Шагжамуни Бурхан Энэтхэгт ном уламжилсан, тэнд төрөл төрөлдөө бясалгал хийдэг ариун дагшин орон байж, хүмүүсийн сэтгэл маш цэвэр ариун болохоор ном уламжлахад мэдээж тун хялбар дөхөм байжээ. Миний таньдаг багш ч гэсэн Энэтхэгт ном уламжлахад мөн л тун амархан байсан тул тийм ч сүрхий санагддаггүй, хэрвээ хятадад хүрч очин ном уламжилбал тэр үед л түүнийг сүрхий гэж ярьж болно гэж би боддог.

Энэтхэгт нэг удаад хэдэн мянган хүнд ном уламжлахад хэн ч сэжиглэдэггүй бөгөөд гүтгэдэггүй, гэтэл хятадад ном уламжилсан бол таван жилийн дотор ганц хоёрхон шавьтай байж ч мэднэ (бүгд инээлдэв). Тиймээс Бодьдармаа есөн жил хана ширтэн суусан ч тавхан шавьтай болжээ.

Энэтхэгийн даяан яагаад хятадад уламжлагдсаны дараа хүн загнаж, хүн зоддог болж хувирсаныг одоо та нар ойлгосон байх! Энэ нь тэд үйл түйтгэрээр дэндүү их, хар багаасаа нэгэнт мах идчихсэнээс болжээ. Энэтхэгийн даяан Японд уламжлагдсаны дараа бүр ч хэцүү болсон байна, учир нь урьд нь тэдэнд бусдыг ялан дийлэх өрсөлдөөний зориг санаа дэндүү их байснаас ч болсон байж ч мэднэ. Тиймээс ном хаялцаад хариулж чадахгүй болох үед тэр ч байтугай хэвлийгээ хагалж амиа хорлодог. Тийм болохоор “ном” аль оронд уламжлагдвал тэндхийн зан заншил тун амархан нөлөөлдөг, тийм үү? үгүй юү? Даяан бясалгал нь Энэтхэгт маш эерэг зөөлөн байснаа хятадад уламжлагдсаны дараа



нилээд ширүүн болж хувиран Японд уламжлагдсаны дараа бүр ч хэцүү байдалд оржээ.

Сонссоноор бол Шагжамуни Бурхан ном уламжлах үед лянхуа цэцгийн тайзнаа залардаг гэсэн, тэгвэл лянхуа цэцэг нь ямар санааг илэрхийлж байгаа билээ гэвэл түүний шавь нар нь багшийгаа шүтэн биширдэг болохоор суудлыг нь цэцгээр засан чимэглэж, цэцгээр тахьдаг байжээ. Гэхдээ зөвхөн Шагжамуни Бурханыг л ингэж хүндлэн тахидаг төдийгүй, одоо ч гэсэн ийм уламжлалтай, миний таньдаг хэдэн багш ном уламжлах үеэр хүмүүс бас яг л шинэ бэрийн өрөө шиг үзэсгэлэнтэйгээр засаж чимсэн байдаг. Жишээ нь, ямар нэгэн улс оронд хүрч ном тайлах үед шавь нар нь эхлээд нэгэн эзгүй газар хайж олоод өндөр том тайз босгож, эргэн тойронд нь хамгаас гоё шинэхэн цэцэг дүүрэн өрж, үзэсгэлэнтэй сайхнаар засаж чимсэн байдаг. Заримдаа өндөр тайзны өмнө “Ийм, ийм номын багш” буюу “Багшийгаа халуунаар угтъя!” гэж цэцгээр чимэглэн бичдэг. Заримдаа маш урт даавуу, эсвэл хивс дэвсэж, дээр нь цэцэг өргөдөг. Мэдээж үргэлж ингэдэггүй, энэ нь тус орны зан заншлаас шалтгаалдаг.

“Багшийн мэндэлсэн өдөр”-ийн баяраар шинэ цэцгийг хивсэн дээр эгнүүлэн тавьж, “Багшийг халуунаар угтъя”. “Төрсөн өдрийн мэнд хүргэе” гэж чимэглэн бичдэг, гэхдээ маш уртаар эгнүүлэн тавьж, багш нь “цэцгийн мандал” дундуур алхаж, өндөр тайзан дээр гаран лянхуа цэцгийн суудалдаа залардаг, лянхуа цэцгийн тайз гэдэг нь үүнээс үүсэлтэй. Энэтхэгт одоо ч гэсэн ийм байдал байгаа, тэдний багшдаа зориулсан тайз нь заримдаа яг л нэг бут лянхуа цэцэг шиг харагддаг, тэгээд эргэн тойронд нь цэцгээр хүрээлсэн тайзанд багшийгаа суулгадаг.

Энэтхэг бол гантай хуурай орон болохоор цэцэг нилээд үнэтэй бөгөөд ховор байдаг, тэд чухам хаанаас тийм олон цэцэг олдгийг би мэдэхгүй, одоо бид цэцгээр бурхны хөргийг тахьдаг нь Энэтхэгийн уламжлалт зан заншлаас үүсэлтэй. Тэд цэцгээр “амьд бурхан”-ыг тахидаг байсан, одоо ч гэсэн адилхан, бурхдаа цэцгээр тахьдаг, нэгэн багш ном тайлах үед тэд бүгд л хүж болон цэцэг өргөж, тайзанд суух үед нь бие дээр нь, хөлийнх нь өмнө цэцэг цацдаг, заримдаа түүний бие дээр дүүрэн цэцэг цацаж, “солонгон цэцэгт багш” болгочихдог, ингэх нь сая “шүтэн тахиухуй” болно, одоогийн хүмүүс бүгд л шүтэн тахиж гэдгийг ойлгодоггүй.

Энэ хэдэн багш хаа ч хүрсэн, тэд бүгд л үлэмж их ургамал хоол бэлтгэж, багш нараа хүндэтгэн зочилдог, ингэх нь бурхадыг шүтэн тахиж байгаа явдал юм. Тэд ямар ч сахиус, ямар ч бурхны хөрөгт мөргөдөггүй, амьд байгаа Төгс Гэгээрсэн Их Багшийг дагасны дараа бурхдын хөрөг зурагт мөргөх юмуу, рашаалах нь ер хэрэггүй гэдгийг мэдчихдэг болохоор уулын шүтээнээ тоохоо больж, дахин рашаалж угаалгүй ялзруулж орхидог.

Багшийгаа хайж олохоосоо өмнө тэд бүгд л модон бурхан, чулуун бурханд мөргөдөг байсан. Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олсныхоо дараа шинэхэн цэцэг болон жимсийг тэр багш нарын өмнө өрж тавьдаг, онцгойлон төрсөн өдрийн баярыг бүр ч ихээр тэмдэглэдэг, тэр багш

нарын төрсөн өдрөөр авшиг хүртэх хүмүүс хамгаас олон байдаг, учир нь Их Багшийн төрсөн өдөр бол хамгаас буянтай, хамгаас бэлгэ дэмбэрэлтэй өдөр бөгөөд маш их адислах хүчтэй, энэ өдөр асар олон тэнгэрийн төрөлтөн, бодьсадва хүрэлцэн ирж, тэрхүү “амьд бурхан”-д баярын өдрийн мэнд хүргэдэг, бидний тэнгэрийн нүд нээгдчихсэн бол үүнийг харж чадна.

Тиймээс тэд Их Багшийн төрсөн өдрийг тохиолдуулан авшиг хүртэхээр ирдэг. Хэдэн мянга, хэдэн арван мянган хүн хүрэлцэн ирж Их Багшид төрсөн өдрийн мэнд хүргэдэг, харин эндхийнх шиг ганц хоёрхон хүн, эсвэл зуу, хоёр зуун хүн л ирдэг төдий биш, Энэтхэгт хэдэн арван мянган хүн ирдэг юм шүү! Тиймээс тэд эхлээд заавал нэг хэсэг эзгүй газар хайж олоод өндөр том тайз босгож, өнгийн цэцгээр засаж чимэглэдэг, хүмүүс ч гэсэн өөрсдөө майхан босгож, хоёр, гурав хоног сууж, өдөр бүр багштайгаа хамт дуу дуулан төрсөн өдрийн мэнд хүргэж, өөрсдийнхөө түүхээ ярьж, багшаасаа сурсны дараа ач тусыг нь хүртээд амьдрал нь яаж хувирсан, дотоодын багшийнх нь хүч яаж тусалсан гэхчилэн ярьдаг, гэхдээ яримагцаа нулимс асгаруулдаг, тэд бол багшийгаа жинхэнээр хүндэтгэн хайрладаг болохоор “саваа” хэрэглэх шаардлагагүй, тэд Багшийг минь хармагц нүд салгалгүй ширтдэг, учир нь нилээд удалт уулзаагүйгээс болсон хэрэг.

Энэтхэгийн газар нутаг өргөн уудам болохоор багштай уулзахад тийм ч хялбар биш, өдөр бүр уулзах боломж ер байхгүй. Тиймээс багшийг минь хармагц нүд салгалгүй ширтэж, багш хаа очно, тэнд дагалдан очдог, тэгээд багшийн нүдийг харж харж, сэтгэл хангалуун болсныхоо дараа л гэртээ буцдаг, багшийн мэлмийг харахаас нааш ерөөсөө салж явдаггүй.

Багштайгаа хамт амьдарч байлаа ч гэсэн мөн адилхан, Багш маань ном тайлахаар гарах болгонд шавь нар нь бүгд л хаа хол хүртэл үдэн мордуулж, тэргэнийх нь хойноос гүйлддэг, заримдаа Багш маань зориудаар унаа хөсгөө алгуур явуулж, шавь нартаа харуулдаг, түргэн гүйдэг зарим шавь нь багшийгаа бусдаас илүү харж чаддаг. Багштайгаа байнга хамт амьдардаг хэдий ч бас л ийм байдаг, учир нь багш нь ном тайлахаар өөр оронд хүрч, арав хоног, хоёр долоо хоног, эсвэл нэг сар болж ч магад, тиймээс явах үед нь шавь нар нь багшийгаа үдэж мордуулдаг.

Багш нь буцаж ирэх үед шавь нар нь мөн л баярлан угтаж, унаа хөсөг дээр нь шинэхэн цэцэг өрж, бясалгалын газраа хүрэх үед бүх шавь нь бүгд багшдаа ёслол мөргөдөг. Энэ бол Энэтхэгийн шавь нар билээ, багш шавь хоорондоо ийм гүн зузаан хүндэтгэн хайрлах сэтгэлтэй болохоор мэдээж саваа хэрэглэх шаардлагагүй, тийм үү? үгүй юү? Бас загнаж зэмлэх ч шаардлагагүй, нэгэнт маш тодорхой уйлчихсан байхад загнаж зодох хэрэг юун? Тиймээс Энэтхэгт саваа хэрэггүй, аль ч бясалгалын төвд очсон ч саваа гэмээр юм юу ч харагдахгүй, саваа гэж юу болохыг тэд мэдэх ч үгүй, эсрэгээрээ харин чамаас саваа гэж юу вэ гэж асууна.

Тэд бүгд л чин сэтгэлээсээ мөр хайхаар ирдэг бөгөөд багш нь

ном уламжлах гэж ирэхээс өмнө аль хэдийн нэг нэг эгнээгээр огтхон ч хөдлөлгүй нам жим сууж байдаг, багш нь хүрч ирлээ ч гэсэн шуугилдан үймэлддэггүй. Харин эндхийн шавь нар багш нь ирэхээс өмнө үймэлдэн шуугиж, хаа ч очсон чимээ шуугиан их, сүрлэг жавхлантай уур амьсгал өчүүхэн ч байхгүй бөгөөд ном хайх хүндэтгэлийн хандлагаар дутмаг байдаг. Тиймээс зарим нь авшиг хүртсэний дараа зугтаж, гадаа гарч багшийгаа гүтгэн багшийгаа гадаад номтон, дотоод номтон, дунд номтон, хойт номтон гэхчилэн элдвээр шүүмжилдэг. (Бүгд инээлдэв)

Шагжамуни Бурхан Тайвань буюу Хятад, эсвэл Вьетнамд хүрч ном уламжилсан бол би нээрэн сүрхий юм байна гэж алга ташин сайшаан магтана, Энэтхэгт ном уламжлахад тун ч хялбар байдаг. Би ч гэсэн Энэтхэгт хүрч ном уламжилсанд тун сүрхий болсон, үнэн шүү. Тэнд Энэтхэг хэлээр ярьж чаддаг л бол ном дэлгэрүүлэх нь тун хялбар хэрэг болно.

Над шиг ийм эгэл хүн ч гэлээ, бас гурван Энэтхэг шавьтай ч гэлээ тухайн үед би зориудаар ном дэлгэрүүлээгүй, харин тэд надаас гуйхын эрхээр л би аргагүй ном уламжилсан, тэнд би ганц хоёр хоног л өнжсөн төдийхөн болсон ч харин чин сэтгэлт гурван шавьтай болжээ, ганц, хоёр хоног өнжөөд л тэднээс салж одсон хэдий ч тэд одоо болтол мөн л захидал ирүүлж, мэнд усаа мэдэлцэж байдаг бөгөөд урьдынх шигээ машид хүндэтгэдэг, тэгээд гурван жил өнгөрөөд тэднийг үзэхээр очсонд даруй: “Их Багш буцаад ирсэн байна!” гэж чанга дуугаар хашгирахад тосгоны бүх хүн мэдээд их багшийг харахаар бүгдээрээ гүйлдэн ирсэн, ийм их шүү (Багш гараараа дүрслэн харуулав), (Бүгд инээлдэв) Би тун их ичсэн, уулзаагүй нилээд удчихсан, гурван жил болчихсон болохоор уг нь чимээгүйхэн ирээд л тэдэнтэй уулзаж, ямаршуухан бясалгаж байгааг нь харах гэсэн хэрэг. Тэд бүгдээрээ намайг мартчихсан байх гэж бодсон, гэтэл санаснаас тэс өөр, тэд харин уулга алдан олон хүн “Их Багш”-ийг (бүгд инээлдэв) харахаар гүйлдэн иржээ.

Тэд яагаад тийм их хүндэтгэх сэтгэлтэй байдаг вэ? Бясалгахдаа яагаад загнаж зодох номын аргыг хэрэглэх шаардлагагүй байдаг вэ? гэвэл тэд нэгэнт дэс өндөр болчихож, модон бурхан нэмэргүй, амьд сэрүүн байгаа бурхан л ач тустай гэдгийг ойлгодог, энэтхэгчүүд багш нь бол “Бурхан” мөн болохыг мэддэг, хэрвээ дэс нь өндөр биш байсан бол тийм байдлыг ойлгохгүй, мөн л ном судар, модон бурхан, чулуун бурхандаа мөргөсөөр бурхан хаана байгааг мэдэхгүй байх байсан. Тэд “Бурхан сэтгэлд байгаа”-г хайж олоогүй боловч наад зах нь гадна байгаа “Амьд бурхан”-ыг таньдаг, иймээс бясалгал нь нэгэнт өндөр дээд хүрчээ гэж ярьж болно.

Хэдэн арван жилээр бясалгасан ч модон бурханд мөргөсөн хэвээр бол бясалгаж яаж чадах билээ? Модон Бурхан үг ярьж чадахгүй, ном хаялцахад асуултанд хариулж чадахгүй, адислаж чадахгүй, бясалгалд тусалж чадахгүй, Зөвхөн “Амьд сэрүүн байгаа Бурхан” л тусалж чадна. Тиймээс Энэтхэгчүүдийг бясалгахад загнаж зодох шаардлагагүй, дэс нь аль хэдийн өндөр болчихсон, иймэрхүү хэрэг явдлыг дахин ярих шаардлагагүй, тэд багшийгаа тэгж их хүндэлдэг нь нэгэнт ойлгочихсоныг

нь илэрхийлж байгаа хэрэг, тиймээс юу ч ярих шаардлагагүй, өөрсдөө үргэлжлүүлэн бясалгавал болчихдог.

Адилхан нөхцөл байдал, адилхан багш байлаа ч гэсэн хэрвээ Хятадад бол шавь нараа ихэд зодож загнах хэрэг гарна. Яагаад гэвэл багшийгаа хүндэлдэггүй, жинхэнээр бясалгал хийх гэдэггүй, шавь нар нь багштайгаа мэтгэж маргалдах дуртай, багш нь ингэж хий гэвэл шавь нар нь: би бодвол тэгж хийх нь л зөв гэдэг. Өдөр бүр мэтгэж маргаад дуусдаггүй, учир нь дэс нь дэндүү доор болохоор багш нь тусалмаар байвч өөр арга олддоггүй, тиймээс өдөр бүр загнаж зодох л хэрэгтэй болно, тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа шавийнх нь үйл түйтгэр нь жаахан хөнгөрч, “би гэх үзэл” нь бага зэрэг багасдаг, яагаад гэвэл багш нь зодож загнах аргаар түүнийг сургаж дадуулах хэрэгтэй, тэр үед л жинхэнэ ёсоор бага зэрэг ойлгож чаддаг.

Тиймээс Хятадын эртний номын багш нар бүгд нилээд ширүүн номын аргыг хэрэглэдэг байсан нь үүнээс шалтгаалжээ. Хятад, Вьетнам, Япон гэх мэтийн дорно дахины хүмүүс ном зохиол, эрдэм мэдлэгийн зүйлсэд сонирхолтой бөгөөд маргах дуртай. Гэтэл мэдлэг юмуу, ном зохиол нь мөн л гурван ертөнцийн дотор байж, мөн л ертөнцийн эрдэм мэдлэгт харьяалагдахаас биш туулан гэтлэхтэй холбоогүй.

Энэтхэгчүүдийн хувьд мэдлэг, мөнгө зэрэг нь чухал биш, харин туулан гэтлэх, бурханы хутагт хүрэх нь л хамгийн чухал байдаг. Тэдний улс орон нь нилээд ядуу хоцронгуй байж ч магад, гэвч тэд маш баяр жаргалтай, гуниж зовдог энэтхэгчүүдийг би тун цөөхөн харсан, гэр бүл нь хичнээн ядуу, эсвэл хичнээн баян чинээлэг, байр суурь нь хичнээн өндөр, эсвэл доор байлаа ч бүгд л өөдрөг царайтай, тун баяртай байгааг нь байнга хардаг, учир нь тэдний сэтгэл гэнэн цайлган, “сэтгэл цэвэр ариун бол улс гүрэн төвшин амгалан”, тиймээс хэдэн мянган жилээр тэнд дайн дажин тун бага, дотоодын дайн тун цөөн байжээ, ойрын жилүүдэд л гадаад улсын нөлөөнөөс болж дайн үүсдэг болжээ.

Хэдэн мянган жилээс нааш Энэтхэгчүүдийн ихэнх нь бүгд л ургамал хоол иддэг байсан, одоо ийм байдалтай болж хувирсан нь үнэхээр сэтгэл шаналмаар хэрэг. Гэвч бас аргагүй л дээ. Цөвүүн цаг үед хаа ч гэсэн бохирдох нь гарцаагүй. Одоо манай дэлхий алгуураар амар төвшин биш болж байна, та нар сонин уншвал мэдэж болно, атом болон цөмийн бөмбөгийг дэндүү ихээр туршин ашигласнаас болж, дэлхийн бөмбөрцгийн гаднах хамгаалалтын давхарга цөөнгүй газраа цоорсон байна, хэрвээ даруйхан нөхөн сэлбэхгүй бол бид тун түргэнээр нас барж, энэ ертөнцөөс салан одож, бурхныг дурсахгүй ч гэсэн бүгдээр гар гараа барилцан хамтаар таалал төгсөж мэднэ. (Бүгд инээлдэв)

Энэтхэгт тэд модон бурхныг тоодоггүй, харин амьд бурхныг хүндэтгэн шүтдэг. Өөр бусад улс оронд харин амьд бурхныг тоохгүй, модон бурхныг хүндлэн хайрладаг. Тиймээс Энэтхэгийн даяан, Хятадын даяан болон Японы даяан бүгд өөр ондоо байдгийн шалтгаан нь Энэтхэгийн шавь нар бурхан хаана байдгийг мэддэг, тэд өөрсдийнхөө дотоодын хамгийн дээд бурхан чанараа хараахан таньж мэдээгүй боловч ядаж л гаднах амьд бурхан, нэгэнт бурханы хутагт хүрсэн бурхныг

таньдаг.

Гэтэл даяаны урсгал Хятадад уламжлагдсаны дараа бясалгалтнууд модон бурханд мөргөхийн зэрэгцээ буцаж ирээд дахин амьд бурхантайгаа мэтгэлцэж маргалддаг, багшийнхаа санааг ойлгож байна уу? Японд бас ийм, нэг хэсэг модыг хичээнгүйлэн хүндэтгэж, гэртээ авчраад гоёж чимэглэн ёслол мөргөдөг, тэгээд маргааш нь дахин багш дээрээ ирж маргана, дараа нь дахин гэртээ буцаж очин модон бурхандаа мөргөнө, багштайгаа маргана, модон бурхандаа мөргөнө гэх мэтээр байн байн ингэж ээлжилдэг юм чинь зодохгүй бол яаж сургаж чадах вэ?

Тиймээс урьдын номын багш нар бүгд л тун ширүүн, шавь нь асуулт асуувал даруй сандал, модон бороохойгоор толгойг нь цохьдог гэж бид “даяан”-ны тухай үлгэр түүхээс үзэж сонссон билээ. Ийм нэг үлгэр байдаг. Нэг шавь нь номын багшаасаа: “Бодьдармаа хятадад юу хийхээр ирсэн бэ?” гэж гурван удаа асуухад багш нь: “Тэр сандлыг нааш нь аваад өг” (Бүгд инээлдэв) гэжээ, шавь нь сандлыг багшдаа өгсөнд багш нь түүнийг сандлаар зодсон байна, учир нь хариулахын аргагүй болохоор зодох л хэрэг. Бодьдармаа Хятадад юу хийх гэж ирсэн нь бидэнд ямар хамаа байх вэ? Тийм олон зүйл асуух хэрэг юун? Үүнд асуумаар юу байгаа юм бэ? Зодуулж байж л сая “нээгдэж” чаддаг аж, тийм үү? үгүй юу? Дотоодыг нь нээж чадахгүй юм чинь гадна талыг нээх хэрэгтэй болно. (Бүгд инээлдэв) Энэтхэгт ийм явдал байдаггүй, “Би хэн бэ?”, “Бодьдармаа хятадад юу хийхээр ирсэн бэ?”, “Хэн бурхныг дурсаж байгаа вэ?” гэх мэтийн ном хаялцаан байдаггүй. Хятадууд ийм зүйлд дуртай болохоор номын багш нар хамаг төрөлтний үзэл бодлыг аялдан дагахын төлөө ном хаялцах, үг хаялцах болж хувирчээ, дараа нь “толгойг нь цохиж зодох” (Бүгд инээлдэв) болж хувирав, хожим нь наран сүлжээгээ ажсан ч билгээ нээж чадахгүй болохоор наран сүлжээгээ “хагалах” л хэрэг болжээ (Бүгд инээлдэв), яагаад гэвэл асуултаар нээж чадахгүй бол энд (багш хэвлийгээ заав) нь хагалах хэрэгтэй, тэгвэл ядаж л хэвлий нээх нь билиг нээхээс илүү хялбар болно. Дотоодын номыг сургаад байхад хүлээн зөвшөөрөхгүй болохоор нь гадна талын зүйлийг л сургана, тиймээс бясалгах тусам гадагшаа хандах болжээ.

Гуан Чин өвгөн хувраг юу бясалгадаг байсныг та нар мэдэх үү? Тэр өөрөө маш хичээнгүйлэн чармайж бясалган суудаг хэдий ч олон хүн түүнээс яаж бясалгах тухай асуухлаар: “Наму Авид бурхан” гэж унш гэж сургадаг байжээ, тийм үү? үгүй юу? Учир нь тэднийг сургах өөр арга байхгүй гэдгийг тэр сайн мэддэг байсан хэрэг.

Би ч мөн адил, олон хүн надаас бясалгах тухай асуухаар: “Наму Авид Бурхан гэж уншаарай” гэдэг, яагаад гэвэл өөр зүйл ярихын аргагүй, үнэн ёс яривал тэд гадаа гарч, энэ хүн бол буруу номтон, бурхныг дурсахыг заахгүй, харин аялгуу ажиг гэнэ үү, тийм юм заадаг гэнэ, Тайваньд бясалгалаар өндөр хувраг их байхад ийм бясалгалын арга байдгийг яагаад сонсоогүй байдаг хэрэг вэ? гэж гүтгэдэг, тиймээс ийм бясалгалын арга нь лав буруу номтны мөн гэсэн шийдвэр гаргадаг. Хүмүүсийн хувийн тогтсон үзэл ийм хэцүү болохоор багш чинь бас сургах аргагүй. Учир нь бид гадна талд харьяалагдах олон зүйлийн

юманд хүлэгдвэл бясалгах тусам гадагшаа хандах болчихдог. Жишээ нь, зарим хүн багшийгаа дагаж бясалгая гэвэл мэдээж багшдаа тун дуртай, бясалгасны дараа үр дүнтэй болж, багшийгаа хэн болохыг мэддэг бөгөөд ихэд хайрладаг, энгийн үед цаг завгүй болохоор багштайгаа уулзахаар ирж чадахгүй, тиймээс багшийнхаа гэрэл зургийг нь аваад гэртээ очсоны дараа харж суудаг. Гэтэл зарим хүн багшаас чинь суралцаагүй ч авшиг хүртсэн хүмүүс багшийнхаа хөргийг хардгийг дуурайж, багшийн заасан Авид Бурханыг дурсах гэдэг нь ийм юм байна гэж боддог, тэгээд бас багш ч адилхан, зураг ч адилхан юм чинь бид хоорондоо ямар ялгаа байх вэ? гэж ярьдаг, мэдээж адилгүй, авшиг хүртэх болон хүртэхгүй нь мэдээж адилгүй.

Тиймээс хүмүүсийг сургах гэдэг бол тийм ч амаргүй үйл хэрэг мөн, авшиг хүртсэн шавь ч гэсэн, түүнд нэгэнт өөрийн уг дүрээ эрэх аргыг сургачихаад байхад уг дүрээ мөн л таньж чадахгүй: “Миний бурхан чанар хаана байгаа вэ? Хэзээ эрж олох вэ? Би хэзээ билиг нээгдэж чадах вэ?” гэж байнга асуудаг, багш чинь өчигдөр нэгэнт авшиг уламжилсан байхад өнөөдөр мөн л: “Би багшаас суралцвал хэзээ билиг нээгдэж чадах вэ?” гэж асуудаг, өнөөдөр ингэж асууна, дараа жил нь мөн л: “Багш аа! би яагаад бас л билиг нээгдээгүй байна вэ? Миний уг дүр хаана байна вэ? Өөрийн биеэ яаж эрж олж чадах вэ?” гэж асуудаг.

Ийм хүн уг дүрээ эрж олсон ч таньж чаддаггүй, учир нь уг дүрээ мартаад дэндүү удчихаж, аль хэдийн өгөршин ялзарчихжээ, тэгээд хайж олох үед дэс нь дэндүү доор болохоор харж чаддаггүй, тийм хүн дэс нь тун доор хэдий ч мөн л бясалгаж болдог бөгөөд туулан гэтэлж болно, багшаасаа суралцаж авшиг хүртсэний дараа мэдээж туулан гэтэлж чадна, дэс нь урьдынхтайгаа адилгүй болно, энэ нь түүний хэр зэрэг их хичээнгүйлэн бясалгах байдлаас болно.

Маш олон төрлийн бясалгалын арга, жишээлбэл: ном хаялцахад наад зах нь бага зэрэг мэдлэгийн зохих төвшинтэй юмуу, маргаж мэтгэх дуртай байж л сая оролцож чадна. Ном судрыг судлахад мэдлэгтэй байж л судалж чадна. Үүнээс ондоо наран сүлжээгээ ажих, амьсгалаа ажих, хувхай ясыг ажих, бохир зүйлийг ажих, Наму Авид бурханыг төсөөлөн бодох гэх мэт олон олон арга бас байдаг гэж саяхан багш чинь ярьсан билээ.

Аливаа бясалгалын аргыг ер нь үг хэлээр ярьж таниулах хэрэгтэй байдаг бөгөөд нөхцөлтэй, чадвартай байх хэрэгтэй, саян дурдсан бясалгалын арга нь зургаан эрхтэн заавал бүрэн бүтэн байж гэмээнэ л бясалгаж чадна, багшийнхаа санааг ойлгож байна уу Нүдтэй атлаа дүлий байж болохгүй, хэлний язгуур юмуу, хамрын язгуураа бясалгагчдын хамар болон хэлний чадвар заавал бүрэн байх хэрэгтэй, зарим хүн хамар нь монхор биш навтгар бол хамраа яаж ажиж чадах вэ? Ойлгож байна уу? Машины ослоор хамраа тайруулсан байвал хамрын үзүүрээ яаж ажих вэ? Тэгвэл төгс төгөлдөр биш болчихно.

Наран сүлжээгээ ажихад ч гэсэн яаж ажихаа ойлгож мэдэж байж л сая ажиж чадна, хэрвээ тэнэг хүн, эсвэл дүлий, сохор хүн байвал наран сүлжээгээ ажихыг яаж тайлбарлах вэ? Энэ нь тун ээдрээтэй хэрэг, наран

сүлжээгээ ажиг нь тун амаргүй хэрэг, харин дур зоргоороо ажиж чаддаг юм биш. Наран сүлжээг угаас хоол шингээхэд ашигладгаас биш, харин ажигхад хэрэглэдэг биш, гэхдээ наран сүлжээ бол доод төвшинд багтдаг. Аль хэсгээ ажна, нас барах үед тэр хэсэгтээ очдог, учир нь нас барах үед бид бодол санаагаа хаана хандуулна, тэндээ л очдог, тийм үү? Үгүй юү? Наран сүлжээгээ ажвал дахин төрөл авах үед юу болж төрдөг вэ? Хэвлий дэх хорхой, туузан хорхой болно. Аль хэсгээ ажна, тэндээ очдог болохоор хянуур болгоомжтой байх хэрэгтэй.

Хамраа ажвал дахин буцаж ирэх үедээ нус буюу хамрын үс болж хувирна. Зүрхээ ажвал буцаж ирэх үедээ зүрх болж хувирна, зүрхний дотор юу байдаг вэ гэвэл цус, мэдрэл, судас зэрэг бүгд л хэрэгцээгүй зүйл байдаг шүү дээ. Тэр бүх харанхуй бүүдгэр, мөнх бус, эгэл хүний хэсгээ ажаад ямар хэрэг байх бэ?

Хамар, амьсгал, зүрх, наран сүлжээгээ ажаад бурхан болж чаддаг гэж төсөөлөн бодлоо ч бүрэн тодорхой тайлбарлахын аргагүй, учир нь зарим хүн сохор, дүлий, харж ч чадахгүй, юм ярьж чаддаггүй бол түүнийг яаж сургах вэ? ойлгож байна уу? Гэтэл багшид чинь нэг зүйлийн бясалгалын арга байгаа, сохор, дүлий хүмүүс ч гэсэн бясалгаж чаддаг, тэд бясалгахад ямар ч асуудалгүй, гэхдээ надад бас сохор, дүлий шавь байдаг бөгөөд бүгд ахуй ойлголттой байж чадсан, сохор хүн ч гэрэл харж, бурхан чанараа харж чаддаг, дүлий хүн дотоодын аялгуугаа сонсож чаддаг, үг хэл хэрэглэхгүй ч ном уламжилж болно, нэгэн сохор, дүлий хүнд багш нь бас авшиг хүртээж чадна, тэр хүн эрүүл саруул хүнтэй адилхан ахуй ойлголттой болдог.

Тиймээс Арьяабалын бясалгалын арга бол хамгийн төгс төгөлдөр арга, ямар ч хүн бясалгаж болно, хүүхэд ч гэсэн бясалгаж болно, багшид чинь зургаан настай шавь байдаг, тэдний ахуй ойлголт нь “Хотол зохилдогч зүйл”-д ярьсантай адилхан. Наян настай ахмад настан ч бясалгаж болдог бөгөөд адилхан ахуй ойлголттой болдог. Ингэснээр сая төгс төгөлдөр бясалгалын арга болж байгаа хэрэг, тэгэхгүй бол хөлгүй хүн завилж чадахгүйгээсээ болоод ном хаялцаанд оролцохын аргагүй. Мэдлэггүй хүн, дэндүү нас ахисан хүн бол бас ном хаялцаж чадахгүй. Эсвэл хүүхдэд ном хаялцахыг яаж заах бэ? Наран сүлжээгээ ажигхыг яаж заах бэ? Өвчтөн яаж завилж суух бэ? Хөлгүй хүн яаж завилж суух вэ? Тиймээс нэгэн төгс төгөлдөр бясалгалын арга нь шашны тухай ойлголттой эсхийг нь ч ялгалгүй, аль ч нийгмийн давхаргын хүмүүс, эрэгтэй, эмэгтэй, ахмад настан, залуус, сохор, дүлий, хэлгүй, хөлгүй хүмүүс сурахад бүгдэд нь тохирно, Ийм бясалгалын арга бол зөвхөн Арьяабалын бясалгал юм. Аливаа нэг бясалгалын арга нь мөн л зургаан сав эрхтэнээ ашиглаж бясалгадаг юмуу, тархи толгойгоороо төсөөлөн боддог бол төгс төгөлдөр бясалгалын арга биш.

Иймээс Арьяабалын бясалгалын арга нь төрөл төрөлд хамгийн дээд бясалгалын арга болох нь үүнээс тодорхой байна. Учир нь зөвхөн энэ бясалгалын арга л жинхэнэ бурхны хутагт хүргэж чаддаг, өөр бясалгалын арга нь бүгд л тийм ч их ач тустай биш, ихэнх нь төсөөлж таамаглан боддог төдийхөн, учир нь Арьяабалын бясалгалыг эрж

хайгаад олохгүй болохоороо таамаглан боддог, гэхдээ эртний хүмүүс ингэж бясалгадаг байсан ч байж магад, тиймээс өөрсдөө олон хэлбэрийн бясалгалын аргыг зохион бүтээж, дур зоргоороо бясалгадаг. Жишээ нь, талх хийх аргыг мэдэхгүй болохоор бусдыг гурилаар хийхийг нь хараад мөн дуурайж хийдэг, ингэснээр талх ч биш нэг юм хийчихдэг. Намайг анх Англи улсад очих үед миний суугаа газрын ойр хавиас амттай сайн талх олдохгүй байсан, Шигунд байх үедээ идэж байсан шиг тийм амттай Франц талх байгаагүй. Гэтэл Англи улсын том хотод л тийм талх олдоно, бусад өөр газар тийм талх байхгүй, зардаг нь бүгд дэндүү зөөлхөн, яг л бидний энд иддэг талх шиг, түүнд би тийм ч их дуртай биш, харин Франц талханд дуртай, тиймээс өөрөө хиймээр байдаг, гэвч хийх аргыг нь мэдэхгүй, ер туршиж үзээгүй байлаа. Вьетнамд байхад манайхны аливаа ажлыг бүгдийг нь зарц үйлчлэгч хийдэг байсан болохоор би гадаад улсад очоод хамгийн түрүүнд өөрөө хоол хийж сурсан, тэр үед зарц үйлчлэгч байхгүй болохоор юм бүхнээ өөрөө хийх хэрэгтэй болсон.

Тэгээд би талх хийх аргыг сурахаар очлоо, анхны хийсэн талх маань хатуу, хав хар (Бүгд инээлдэв), хоёр дахь нь жаахан сайжирч кофены өнгөтэй болов, гурав дахь талх маань хагас нь кофений өнгөтэй, талх хагас нь чухам ямар өнгөтэй болохыг өөрөө ч мэдээгүй, нэг юм л хийж орхижээ (Бүгд инээлдэв) гэхдээ цагаан өнгөтэй биш. Дараа нь би зэргэлдээ айлынхнаас асууж байж хийх аргыг нь мэдэж авсан, тэдний хийсэн нь маш сайн, талх хийх аргыг тэднээс сурсны дараа эхний удаад тийм ч сайн хийж чадаагүй, гэвч өмнөхөө бодвол нилээд сайжирч, харахад талх шиг, идэхэд ч талх шиг амтагдах болсон.

Багшийн зааваргүй болохоор урд нь хийсэн талх маань амнаас уначихмаар, бусдын талх хийхийг харахад тун амар хялбар санагдан гурилаа усаар зуураад нухсаны дараа гараараа дарж нимгэлээд зуухандаа хийж шарвал болчих нь тэр гэж бодож байсан, тэгсэн чинь харин түлэгдтэл нь шарчихжээ. Үнэндээ тийм ч амархан биш, хийх үйл явцад нь маш олон нарийн ширийн зүйл байдаг. Жишээ нь: хэдий хэмжээний гуриланд хэдий чинээ ус, хэдий хэр чихэр, хэдий хэр давс, исгэгч хэрэглэх, гурилаа хэр хатуу зуурах, хэр удаан амрааж дарах, шарагчид хэр удаан шарах, хэдэн градусын халуунд шарах гэх мэт, ингэж хийсэн талх хөөж, амттай болдог. Тиймээс талх хийхэд тийм ч амар биш. Урьд нь би гурилаа усаар зуураад нухсаны дараа нимгэлээд шарагчид хиймэгц болчихдог гэж бодож байжээ, тэгсэн чинь чулуу шиг хатуу талх хийчихсэн, үнэндээ чулуу ч биш, харин хав хатуу, хав хар талх, идсэний дараа удалгүй гэдэс өвдөж, тэр ч байтугай ангижирчихаж ч магад (Бүгд инээлдэв), тиймээс идэж зүрхлээгүй, хожим нь зэргэлдээ айлаас сурсны дараа тун түргэн хийж чаддаг болсон билээ.

Талх хийхэд хүртэл заавал багш эрэх хэрэгтэй байгаа юм чинь бурхны хутагт хүрэхэд багшийг эрж хайхгүй байж болох уу? Нэгэн жинхэнэ багшийг хайж олоод заалган замчлуулах хэрэгтэй биш үү? Надад талх хийх аргыг заасан зэргэлдээ айлынхандаа би тун их баярлан талархдаг, хожим нь тэр бас олон төрлийн жигнэмэг хийх аргыг зааж өгсөн, би талх юмуу, жигнэмэг хийх болгондоо түүнд жаахныг хүргэж



өгдөг байлаа, тэгээд одоо болтол баярлан талархсаар явдаг. Гэтэл хэрхэн бурхны хутагт хүрэхийг суралцахдаа харин багшийгаа мартчихдаг, багшаасаа Бурханы хутагт хүрэх аргыг суралцсаны дараа мартчихдаг, багшаасаа бясалгалын аргыг сурсны дараа юуг ч тоож хайхрахаа больдог. Дөнгөж эхлэн бясалгаж байгаа үед багштайгаа байнга ойр байх хэрэгтэй, анх эхлэн бясалгаж байгаа хүмүүст олон асуудал тулгарна, гэвч “Бодьдармаа Хятадад юу хийхээр ирсэн бэ?” гэх мэтийн эх захгүй юм асууж болохгүй, тэгвэл багш чинь бас сандал эрэх хэрэг гарна. (Багшийн хамт бүгд инээлдэв)

Зарим хүн “Багш аа! Бурхан болон Тэнгэрийн эзний аль нь өндөр вэ?” гэх мэт бүр ч илүү сонин асуулт асуудаг, тийм асуултад багш чинь бас сандал хайна (Бүгд инээлдэв). Үүнийг асуух хэрэг юун? Өөрийнх нь дэс нь тэнгэрийн эзний гутлыг нь ч шүргэж чадахааргүй байтал ийм юм асууж юу хийх вэ? Түүний дэсэд хүрэх үед аяндаа мэдэх болно, одоо түүний гутлыг нь цэвэрлэмээр байсан ч биднээр цэвэрлүүлэх дургүй шүү дээ!

Улс бүрт гутал цэвэрлэдэг тусгай хүмүүс байдаг, тэд замын хажууд суугаад бидний гутлыг гялалзтал цэвэрлэх гэж хүлээдэг. Бид дөнгөж эхлэн бясалгаж, тэдний гутлыг нь цэвэрлэх дэсэд ч хүрээгүй байтлаа бурхан өндөр үү, тэнгэрийн эзэн өндөр үү гэж асууж юу хийх вэ? Өдөр бүр тийм асуудлаар маргалдах юмуу, Эзэн Бурхан бий юу? үгүй юу? Эзэн Бурхан дээд нь үү, Бурхан Багш дээд нь үү гэж асуудаг, ингэх нь үнэхээр цагаа талаар үрж байгаа хэрэг юм, тиймээс дэндүү их нэр томъёо байхаар заримдаа багшийн чинь ой гутдаг.

Зарим нь багшаас чинь: “Лууз болон Бурханы аль нь дээд вэ?” гэж асуудаг, дэндүү олон нэр, дэндүү олон шашны урсгал бүлэгтэй болчихжээ, үнэхээр ядаргаатай, тэд Луузын “Мөр ёсны судар”-ыг ойлгодоггүй болохоор тийм асуулт асуудаг. Эзэн Бурхан дээд, эсвэл Бурхан Багш дээд гэдэг нь бидэнд ямар хамаа байх вэ? Би одоо тэр хоёрын хэнийг нь ч тоохгүй, дэсээр хэн нь дээр, хэн нь доор болохыг тэр хоёрыг хамт байх үед нь л адилтган жишиж чадна, тиймээс үүнийг надаас асууж юу хийх вэ? Ойлгож байна уу? Бурхан хэрвээ Эзэн Бурхантай дайтах, эсвэл адилтгах гэвэл тэр хоёрын хоорондын хэрэг, багштай чинь холбоо хамаарал байхгүй, та нартай ч холбоогүй, ийм асуулт асуувал номын багш нар сандал, саваагаар биднийг зодно.

Гэхдээ багшийн чинь бясалгалын газарт саваа гэх юм байхгүй хэдий ч би өөр юмаар зодно, энд жимс их байна (Бүгд инээлдэв), та нарыг асууж дуусахаас чинь өмнө нь би эхлээд жимс чулуудчихна, ингэвэл үйл түйтгэр чинь түргэн ариусна. Энд би чулуудахгүй, учир нь энэ миний бясалгалын газар биш. Харин өөрийн газартаа бол шиднэ, жимсээр зодуулсан хүмүүс бүгд баярлана, тэд багшийн чинь шидсэн жимсэнд тун дуртай байдаг юм. (Багш инээв)

Энгийн бясалгалын аргын ихэнх нь бүгд л А.Б.В-гийн шатанд байгаа бөгөөд дөнгөж эхлэн бясалгах үед л хэрэгтэй байдаг гэдгийг та нар одоо ойлгосон байх! Тиймээс “Баатар явагч их хөлгөн судар”-т Шагжамуни Бурхан Арьяабалын бясалгалын арга бол хамгийн дээд

арга мөн гэж сайшаан магтсан байна, ингэж хэлсэн нь буруу биш, багш чинь бясалгасан болохоор мэднэ, миний шавь нар ч бясалгаж байгаа болохоор бүгд мэднэ, бясалгадаггүй, байнга ирдэггүй, багшийн зааврыг дагадаггүй зөрүүд шавь нарыг сандлаар зодсон ч билгийг нь нээж болдоггүй, тиймээс ахиухан гэгээрч чаддаггүй (Бүгд инээлдэв), зөвхөн бага зэрэг нээгдэж, дараа нь дахин хаагдчихаж мэдэх болохоор төвөгтэй. Хэрэв жинхэнээр хичээнгүйлэн бясалгадаг хүн бол Арьяабалын бясалгалын арга нь хамгийн дээд, хамгийн төгс төргөлдөр бясалгалын арга болохыг мэднэ.

Одоо асуулт байвал асууж болно, гэхдээ “Бодьдармаа Хятадад юу хийхээр ирсэн бэ?” гэж асууж болохгүй. (Бүгд инээлдэв) Ном хаялцахад оролцож байгаа хүмүүс их байна, ямар ач тустай байдгийг нь би мэдэхгүй, гэтэл тун олон номын багш үүнийг сургасаар байдаг нь цагаа үрж байгаа хэрэг, хэрвээ Бодьдармаа дахин төрөл арилжиж ирээд бидэнд сургавал сая жинхэнэ ач тустай. Гэвч бид харин Бодьдармаа одоо хаа байгаа вэ? Би түүнийг эрж байна гэж асууж болно, энэ ертөнцөд амьд байгаа Бодьдармааг хайж олох нь л хамгийн сайн ном хаялцаан юм, харин хоёр мянган жилийн тэртээх нэгэнт таалал төгссөн, бидэнтэй ямар ч холбоо хамааралгүй хүний төлөө толгой тархиа хагартал бодох хэрэггүй.

## АРЬАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА: ДОТООДЫН АЯЛГУУ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй хот  
(Эх нь хятад хэлээр)  
1987 оны 4 дүгээр сарын 16*

Ном тайлах нь зохиол бичиж, шүлэг найруулахтай адилхан, заримдаа юу ч бичмээргүй, заримдаа онгод орохоор хагас шөнийн дотор маш олон сайхан зохиол юмуу, шүлэг бичихдэг. Гэхдээ шүлгийн онгод шидтэн Ли Байн байдал нилээд онцгой, сонсоход тэр заавал согтуу байх үедээ л хамгийн яруу сайхан шүлэг бичиж чаддаг гэдэг, яагаад вэ гэвэл ихэнх хүний үзэж байгаагаар бол Ли Бай согтуу үедээ “би гэх үзэл”, ичих бодол, тархи толгойгоо бүрмөсөн мартчихдаг болохоор тэр үед л жинхэнэ яруу сайхан шүлэг ундардаг гэдэг. Үнэн хэрэгтээ тийм биш байх. Яруу найрагч архи уудаг нь ер нь энэ нийгэмд итгэл алдаж, өөрийгөө олохгүй болохоор түр зуур мансууран өөрийгөө тайтгаруулж, эгэл ертөнцийн уйтгар гунигийг мартахын тулд юм. Хэрвээ нээрэн өөр бусад шүлэгчдээс энэ тухай асуувал тэд: “Тархи толгой сэргэг үеэр л шүлэг бичиж чаддаг, аяндаа л бичихдэг” гэж хэлэх болно.

Багшийн чинь ном тайлах нь мөн аяндаа л болдог, хэрвээ өнөөдрийн ярих агуулгаа өчигдөр бэлтгэж яривал тийм сайн ярьж чаддаггүй, харин аяндаа яривал хамгийн сайн байдаг, учир нь бэлтгэх үедээ бүгдийг нь эгэл хүний тархи толгойгоор боддог болохоор тийм сайн ярьж чаддаггүй, тиймээс багш чинь ном судар харчихаад ном сударт ярьсан ёсоор ном тайлахыг та нар тун цөөхөн харсан, хэрвээ ном сударт ярьсны дагуу эхлээд бэлтгэж байгаад яривал хүн төрөлхтөний мэргэжлийн чанартай ажил болчихдог, харин бурхан ном тайлж байгаа биш болно.

Тиймээс багш чинь ном судар харж ярих тийм их дуртай биш, гэхдээ үргэлж ном судраас эш баримт хайж байж адилтгадаг, учир нь лавлагаа болон нотолгоо өгвөл хүмүүс багшийн чинь сургаал ёсыг нилээд хялбар хүлээн авах болно. Яагаад гэвэл хүмүүс ном судрыг таньж мэдээд нилээд удчихсан, бас түүнд үргэлж хүлэгддэг болохоор багш чинь ном судрын агуулгаас эшилж нотлохгүй бол тэд хүлээн зөвшөөрөхгүй. Үнэндээ багш чинь ном судар ашиглахгүй ярьж чадна, учир нь эргний жинхэнэ багш нарын сургаал ёстой угаасаа адилхан юм.

Өнөөдөр аялгууны тухай ярих болно, Библи судрынхаар яривал энэ аялгуу бол “Эзэн Бурхан” мөн, “Эхлээд Үг байсан (Аялгуу), Үг нь Бурханы дэргэд байсан, тэгэхлээр Үг нь Бурхан байж, бүх зүйл үүгээр

хийгдсэн, үүгээр хийгдэж бүтээгдээгүй юу ч байхгүй” гэж өгүүлсэн байдаг. Үүний утга нь юу бэ гэвэл орчлон дэлхий эхлэн үүсэх үеэс энэ аялгуу, энэ Үг байсан, энэ Аялгуу нь Эзэн Бурхантай хамт байдаг бөгөөд энэ Аялгуу бол Эзэн Бурхан юм, орчлонгийн хамаг бодисыг бүгдийг энэ аялгуу бүтээсэн байна. Өгүүлбэрийн бүхий л утга нь “Аялгуу бол Эзэн Бурхан” гэсэн утгатай.

Библи сударт бас бидний дотоодод Эзэн Бурхан, Диваажин байдаг гэж өгүүлсэн байна, Шагжамуни Бурхан ч гэсэн бидний дотоодод бурхан чанар байдаг, аливаа төрөлтөн бүгд л бурхан чанартай гэж ярьсан байна. Чанар гэдэг нь уг чанарыг зааж байгаа юм, аливаа төрөлтөн бүгд л бурхны хутагт хүрэх чанартай байдаг хэдий ч зөвхөн хүний биеийг олж байж л сая бурхны хутагт хүрэх тохиолтой болж чаддаг бөгөөд энэ төрөлдөө бурхны хутагт хүрч чадна. Өөр бусад төрөлтөн жишээлбэл, нохойд бурхан чанар байгаа юу? гэж зарим хүн Зоу Жа хуврагаас асуусанд “үгүй” гэж хариулжээ. Үнэндээ нохойд бурхан чанар байхгүй биш, Зоу Жа хувраг “үгүй” гэж хариулсан нь “байхгүй” гэсэн утга илтгэж байгаа биш, түүний хариулт нь хариулсан, хариулаагүйтэй адил, номын багш нарын хариулт нь ер нь хачин жигтэй байдаг, “үгүй” гэж хариулсан нь нохойд бурхан чанар байхгүй гэдгийг илэрхийлж байгаа юм биш.

Нохойд бурхан чанар байгаа гэвэл нохой бясалгал хийж, энэ төрөлдөө бурхан болж чадах уу? Бурхан болж чадвал ямар бурхан болдог бол?, “Төлөг бурхан” болдог уу? (Бүгд инээлдэв) Мэдээж тийм биш. Бурхны шинж төрхийг харахад бүгд л хүнтэй адил, тиймээс хүн л бурхан болж чадна, харин нохойн дүртэй бурхныг хараагүй, нохойд бас бурхан чанар байгаа хэдий ч бясалгал хийж, “энэ төрөлдөө бурхны хутагт хүрэх” боломжгүй, бясалгал хийж бурхны дэсэд хүрье гэвэл эхлээд хүн болж байж л бурхан болж чадна. Яагаад зөвхөн хүн л бясалгал хийж бурхан болж чаддаг бэ? Энэ нь яг л өдөр яагаад нартай, шөнө яагаад сартай, од мичидтэй байдаг вэ? гэдэгтэй адилхан, яагаад гэж асуух хэрэггүй, угаас ийм юм. Тиймээс бурхан больё гэвэл эхлээд хүн болох хэрэгтэй.

Энэ “Аялгуу” бол католик шашинд ярьдаг “Эзэн Бурхан” мөн, энэ “Аялгуу” бидний дотоодод байдаг юм бол “Эзэн Бурхан бидэнтэй хамт байдаг” гэдгийг илэрхийлж байгаа биш үү? Хэрвээ Эзэн Бурхан бидэнтэй хамт байдаг юм бол бид бас Эзэн Бурхантай ойролцоо дэсэдэй байж таарна. Хэрвээ Эзэн Бурхан бидний дотоодод оршиж, бидний аливаа үйл ажиллагааг удирдаж, гүйцэлдүүлж байдаг юм бол бид угаасаа Эзэн Бурхан мөн гэдгийг илэрхийлж байгаа биш үү? Энэ “Аялгуу” бол буддын шашны ном сударт ярьдаг “Бурхан чанар” мөн, үүнээс өөр бурхан чанар гэж байхгүй. Яагаад энэ аялгуу бол бурхан чанар мөн гэдэг вэ? Бурхан чанар гэж чухам юу вэ? Хэрвээ нэгэн Эзэн Бурхан байдаг гэвэл тэр нь чухам ямар утгатай вэ? Эзэн Бурхан бол хамгийн дээд дэс, хамгийн дээд зорилго мөн, тэр нь нэг төрлийн хамгийн дээд бодол санаа буюу үзэл, тиймээс Эзэн Бурхан бол юуг ч хийж чаддаг, үүнийг бурхны шашныхан “Ханьцашгүй Үнэхээр Туулсан Бодь Хутаг” буюу “Бурхан чанар” гэж нэрлэдэг. Эзэн Бурхан ийм утгатай юм бол аялгуу мөн адилхан, учир

нь “Аялгуу” бол “Эзэн Бурхан” мөн бөгөөд “Бурхан чанар” мөн, аливаа зүйл бүхэн энэ аялгуунаас үүсэлтэй.

Энэ тухай Буддын шашны ном судар, эсвэл Библи сударт бүгдэд нь л ярьсан байдаг, Арьяабалын номыг бясалгасны дараа үүнийг ойлгох бөгөөд бясалгах тусам улам илүү ойлгох болно, бид зөвхөн энэ аялгууг сонсдог хэдий ч бясалгасны дараа юуг ч ойлгох болж, юу л бодно, түүнийг хувилгаж чадах болно. Та нар бясалгаж суугаа үедээ багшийн чинь хувилгаан бие энд, тэнд очсоныг хардаг, заримдаа эмнэлэгт хүрч, та нарыг үзэж, заримдаа гэрт чинь хүрч, ямар нэг зүйл сургадаг, заримдаа та нарыг дагуулан диваажин, эсвэл тамын орноор очдог гэх мэт.

Энэ бүхэн нь бүгд л багшийн чинь хувилгаан бие мөн, яагаад вэ гэвэл багш чинь “Арьяабалын ном”-ыг бясалгадгаас болж байгаа юм, аливаа юм бүхэн бүгд л энэ аялгуунаас үүссэн бөгөөд багш ч гэсэн энэ аялгуу мөн, ойлгож байна уу? Энэ хүн (багш өөрийн биеэ заав) бол зөвхөн махан бие л төдий, харин багш чинь биш, багшийн чинь өмсөж байгаа хувцас төдий, багш чинь маш олон хувцас өмсдөг, жишээ нь, одоогоор ном тайлж байгаа болохоор ёс заншлыг дагаж жинхэнэ орхимж өмсөх хэрэгтэй, хэрвээ явган алхаж байгаа бол өөр хэлбэрийн хувцас өмсөж, унтахдаа бас ондоо хувцас сольдог, эдгээр нь бүгд л миний хувцас төдий. Өнөөдөр би шар өнгөтэй хувцас өмсөж, өчигдөр кофены өнгөтэй хувцас өмссөн ч багш чинь ямарар ч хувираагүй, зөвхөн хувцсаа сольсон төдий юм.

Махан бие ч мөн адилхан, тэр нь багш чинь биш, багш нь энэ аялгуу мөн, энэ махан бие нь зөвхөн багшийнх нь өмсдөг хувцас төдий зүйл, махан биеийн хувцас өмсдөг нь хүмүүст харагдахын тулд, хэрвээ зөвхөн аялгууны хэлбэрээр оршвол та нар багшийгаа яаж харж чадах юм бэ? Та нартай яаж ойлголцож чадах вэ? Та нарын дотоодод бас энэ аялгуу байдаг, гэхдээ таньж мэдээгүй байгаа, түүнийгээ нээж, хөгжүүлж чадаагүй байгаа хэрэг, та нарын махан бие чинь мөн л аялгууны хувцас мөн, “Эзэн Бурхан” гэж нэрлэдэг тийм хүчний хувцас мөн, “Эзэн Бурхан” гэж ярихгүй, харин “Бурхан чанар” гэж яривал энэ махан бие бол бурхан чанарын хувцас мөн, ойлгож байна уу?

Энэ аялгуу, эсвэл бурхан чанар бол мөнх оршдог, бид хүн, нохой, заан, луу, морь, арслан, бар гэхчилэн ямар ч төрөл авсан энэ аялгуу өнө мөнхөд бидний дотоодод оршиж байдаг, зөвхөн хүний биеийн хувцас өмссөн үедээ л энэ аялгуу, энэ бурхан чанарыг хэрэглэж чадна, бар, эсвэл өөр төрлийн амьтны биетэй хувцас өмссөн үед энэ аялгууг хэрэглэж чадахгүй, багшийнхаа санааг ойлгож байна уу?

Энэ аялгуу, эсвэл энэ хүч нь ертөнцийн хамаг бодисыг агуулж, энэ бие цогцос болон хувирч чаддаг юм чинь мэдээж өөр төрлийн бие цогцос болж хувирч чадна, тиймээс та нар заримдаа багш бол Арьяабал Бурхан, Газрын зүрхэн Бодьсадва, Очирваань Бурхан, Шагжамуни Бурхан гэх мэт болсон байхыг хардаг, үнэндээ бүгд л адилхан хэрэг, бүгд л энэ аялгуу, Эзэн Бурханы хүч, Бурханы хүч, Бурхан чанар юм, энэ хүч хамгийн Их Багшаас хувилж ирдэг, орчлонгийн хамаг бодис бүгд л түүнээс үүссэн, тэрбээр махан цогцос, хувилгаан биет бие цогцос,

“үй түмэн хувилгаан биет” бие цогцос, “Арьяабал Бурхан”, “Газрын зүрхэн Бодьсадва”, “Арван зүг, гурван цагийн Бурхан Бодьсадва” болж хувилдаг.

Авид Бурханыг бид “Цаглашгүй гэрэл” гэж хэлдэг, тэр бол мөн энэ л аялгуунаас хувилсан, гэтэл та нар Авид Бурханы судрыг унших үедээ түүний “Гүн нууцлаг гайхамшигт ном”-ыг ойлгохгүй болохоор та нарын мэддэг Авид Бурхан нь багшийн чинь ярьдаг Авид Бурхантай адилгүй байж мэднэ. Хэрэв Шагжамуни Бурхан хэн нэгэн хүн бясалгал дадуулсны дараа Авид Бурхан болж чадна гэж ярьсан бол багш чинь яагаад Авид Бурхан бол мөн л аялгуунаас үүссэн гэж ярьдаг вэ гэвэл гэрэл бол мөн л аялгуу, зөвхөн нилээд уран нарийн аялгуу, харин аялгуу бол нилээд бүдүүн тойм гэрэл юм, хоёулаа л хэлбэлзэл мөн, тиймээс Авид Бурхан бол аялгуу мөн гэж ярих нь буруу биш, Арьяабалын номыг илүүхэн шиг бясалгасны дараа үүнийг аяндаа мэдчихнэ. Энэ аялгуу нь үнэндээ дуу аялгуу биш, харин нэг зүйлийн гэрэл юм, нэг зүйлийн аялгуут гэрэл мөн, эсвэл нэг зүйлийн “Аялгуут Гэрэл” (Melodious Light) буюу “Гэрэл гялбаат аялгуу” гэж хэлж болно, хоёулаа зөв, бид түүнийг энэ бол тун “сонсголонтой гэрэл” гэж ярьж болох бөгөөд бас тун “үзэсгэлэнтэй аялгуу” гэж ярьж болно, гэрэлтэй бөгөөтөл аялгуутай, аялгуутай бөгөөтөл гэрэлтэй, тиймээс “Аялгуу ажих” гэж ярьдагаас биш, харин “Аялгуу сонсох” гэдэггүй, үүнийг чихээр сонсож чадахгүй, учир нь энэ аялгуу бол дуу аялгуу биш, анх эхлэх үедээ бид чихээрээ сонсож байж магадгүй, гэхдээ чих байж л сонсож чаддаг биш, харин багш чинь ном уламжилж байж л сая сонсож чаддаг, бясалгал дээшилж өндөрсөний дараа чихээ ашиглахгүйгээр сонсож чадна. Билгийн мэлмийгээрээ ажигж, билиг ухаанаараа ажсан “Аялгуу” гэрэл болж хувирдаг, энэ гэрэл гялбаатай атлаа гайхалтай уянгалаг аялгуут би чухам ямар үгээр дүрслэн илэрхийлэхээ мэдэхгүй байна, би өөрийн байдаг чадвараа шавхан байж чадан ядан ярьсныг минь та нар ойлгох эсэхийг би мэдэхгүй.

Гэхдээ үг хэлээр ярьсан нь тийм ч сонсголонтой биш, бас үзэсгэлэнтэй биш, учир нь ийм зүйлийг үг хэлээр ярьж чадахгүй. Жишээ нь: энэ баглаа цэцэг анхилам үнэртэй, бас үзэсгэлэнтэй сайхан, хэрвээ үгээр дүрслэн илтгэх гэвэл өнгө нь улаан, навч нь ногоон, анхилам үнэртэй гэхчилэн хагас өдөр ярьсан ч мөн л тэр багц цэцгийн бие нь биш бөгөөд ерөөс цэцэг үзэж байгаагүй хүн бол төсөөлөн бодохын ч аргагүй.

Баглаа цэцгийг үгээр дүрслэхийн аргагүй юм чинь тиймэрхүү дотоодын дээд төвшин, уран нарийн бөгөөд дүрс үгүй байдлыг үг хэлээр яаж ярьж илэрхийлж чадах билээ? Багш чинь зөвхөн боломжийнхоо хэрээр чадан ядан ярьж, та нарт жаахан ч атугай ойлголт өгч, энэ аялгуу нь их төлөв ямар байдалтай, яагаад аялгууг бясалгах хэрэгтэй вэ гэдгийг бага зэрэг л ойлгуулж чадна, ингэснээр та нар бага сага ч гэсэн “Арьяабалын бясалгал”-ын аргыг жаахан ойлгох болно.

Гэвч ярьсан зүйл маань мөн л үнэн ёс биш, үнэн ёсыг үгээр илэрхийлж чадахгүй, яагаад гэвэл үг хэл бол үнэн ёс биш, цэцгийн тухай дүрслэл нь жинхэнэ цэцэг биш, хүний тухай дүрслэл нь тэр хүний уг

бие нь биш. Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулсны дараа католик шашны Библи сударт яагаад: “Энэ аялгуу бол жинхэнэ Эзэн Бурхан, жинхэнэ бүтээгч мөн” гэж өгүүлснийг ойлгох болно, учир нь бүх юм бүгд л түүнээс бүтсэн, бүгд түүнийх юм, энэ аялгуу үгүй бол орчлон байж чадахгүй, бид өөрсдөө энэ аялгуу мөн бөгөөд энэ бие махбод бол жинхэнэ бид биш, харин энэ аялгуу л “жинхэнэ уг дүр” мөн, энэ аялгуу нь биднийг бүтээсэн биш, харин бид өөрсдөө энэ аялгуу мөн. Жишээ нь: нэг хүн улсын хаан хэдий ч хаан гэдгээ мартчихсан байвал өөр хүн хажуугаас нь: “Та чинь улсын хаан шүү!” гэж хэлэхэд итгэдэггүй, учир нь дэндүү цаг завгүй, яарахын эрхээр оюун санаа нь сүйрч, тэр ч байтугай өөрийгөө хэн болохоо мартаж, төвөг бэрхшээл тохиолдох үед харин эсрэгээрээ улсын хаанаас тусламж гуйдаг, энэ нь тун инээдтэй хэрэг биш үү?

Бид ч бас ийм, өдөржин бодол санаагаа бүгдийг нь гаднах орчны өөрчлөлт, хамаг бодисын үзэгдэл, хувьсалд хандуулж, хүмүүсийг харна, цэцэг сонирхоно, усыг шинжинэ гэсээр байгаад эцэст “Би хэн бэ?” гэдгээ мартчихаж, бүх юм бүгд биднийх, бүхий л орчлон ертөнцийг бид өөрсдөө бүтээсэн гэдгээ мартчихдаг, энэ бол маш гайхалтай нууцлаг байдал юм, бид өөрийн уг дүрээ шинээр таньж мэдье гэвэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгах хэрэгтэй, тэгэхгүй бол хичнээн жилээр хүлээлээ ч ямар ч үр дүнд хүрч чадахгүй.

Тиймээс багш чинь та нарт бурхан бодьсадвад даатгасны хэрэггүй, “Аялгуу ажих”-ыг л бясалгавал болчихно гэж хэлдэг, гэвч та нар гадуур гараад бусдад ярьж болохгүй (бүгдээрээ инээлдэв), тэд өнгөн талын явдалд дуртай, ийм ёс учрыг сонсох дургүй, тиймээс зарим хүн багшид чинь дургүй байдгийн шалтгаан нь хүмүүс дэндүү их хүлэгдэж, дадсан дадал зуршилдаа баригддагаас болж байгаа хэрэг, хэрвээ модон бурхныг нь аваад явчихвал итгэл найдвар байхгүй болж, хүлцэж тэвчихийн аргагүй болдог. (Бүгд инээлдэв)

Тэд өөрсдөө угаас хана түшиглүй эгцхэн сайхан зогсож чаддагаа мартчихжээ, заавал хана түших хэрэгтэй юм бол хана нь нурчихвал яадаг билээ? Тэгвэл түшмээр юм байхгүй болчих биш үү? Яаж эгц зогсохоо мэдэхгүй болохоор тэдэнд хана түших хэрэггүй гэж яривал уурлана. Яг л нэг хүн хар багаасаа ямар нэгэн хэв байдлаар зогсож дадчихсан байвал хэзээ нэг өдөр түүнд: та огт өөр хэв байдлаар зогсоорой! Тэгвэл гоё харагдана гэж ятгасан ч нэмэр болохгүй, учир нь ингэж зогсоод нэгэнт дадал болчихжээ. Энэ дотоодын аялгуу мөн л адилхан, авшиг хүртсэний дараа тэр дорхноо сонсож чаддаг бөгөөд хэсэг хугацаагаар бясалгасны дараа аливаа бүхнийг ойлгочихдог, бурхан бодьсадва биднийг үзэхээр ирдэг, бидэнтэй уулзахаар ирдэг. Ийм юм чинь тэр модон бурханд сүслэн мөргөж, залбиран даатгаж юу хийх юм бэ?

“Аялгуу ажих” бясалгалыг хийдэг л бол тэд бүгд ирнэ, Арьяабалын бясалгал бол хамгийн сайн даатгал мөн, сөгдөх хэрэггүй, хүж асаах хэрэггүй, сүслэн мөргөх хэрэггүй, Арьяабалын аргаар бясалгасны дараа аливаа бурхан бодьсадва бүгд ирнэ, тийм үү? үгүй юу? (Тийм гэж нэг хүн хариулав), та нар бүгд харсан, тийм үү? үгүй юу? (Ийм байдал

мэдрэгдсэн гэж нэг хүн хариулав), мэдрэгдсэн төдий биш шүү! (Бүгд инээлдэв) үнэхээр харсан, харсан хүмүүс яагаад дуугүй болчихов? (Ярьж зүрхлэхгүй шүү! Ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй гэж багш ярьсан биш үү? гэж нэг хүн хариулав). Ямар ямар бурхныг харсан гэхчилэн нарийн ширийн зүйлсийг ярьж болохгүй хэдий ч харсан эсэхээ хэлэхэд хамаагүй шүү!

Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал бурхан бодьсадваг харж чадна, сүм хийдээр явахын ч хэрэггүй, тэд өөрсдөө бидний суугаа газар ирж, бидэнтэй уулздаг, гэтэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгахгүй бол сүм хийдэд хүрч очоод залбиран даатгасан ч харж чадахгүй, зөвхөн модон бурхныг л харна. Арьяабалын бясалгалын аргаар бясалгасны дараа гуйх шаардлагагүй, бурхан бодьсадва биднийг үзэхээр ирдэг, ингэх нь тун сайн биш үү? Гэхдээ бурхан бодьсадваг харах нь тийм ч сүрхий биш, эхлэл төдий бөгөөд мөн л замын дундаа байгаа болохоор тэр бурхны дэсийг туулах л хэрэгтэй, “туулах” гэхээр бид бурхнаас өндөр дэсэд хүрчихсэн гэдгийг илэрхийлж байгаа юм биш, харин дүрстэй, хэлбэртэй бурхныг заавал даван туулж, хэлбэргүй, дүрсгүй, дуугүй, өнгөгүй дэсэд хүрэх хэрэгтэй, энэ бол миний уг санаа. Харин бид бясалгал хийсний дараа бурхнаас өндөр дэсэдэй болдог гэж яриагүй, та нар буруугаар ойлгож болохгүй, ингэхээс л би санаа зовж байна, та нар бүхнийг сайн ойлгохгүй, хагас дутуу сонсоод багшийгаа буруугаар ойлгохоос би хамгаас айж байна.

Ер нь хэлбэр дүрстэй байх нь мөн л нэгэн дүр төрх оршиж байгаа болохоор бурхан биш, гэвч тийм бурхныг харах үед ядаж л бидний хүсэл эрмэлзлэлийг жаахан ч атугай хангаж чадна, учир нь бид ер нь бурхан бодьсадвагаас тусламж гуйдаг болохоор гэрэл цацруулсан бурхан бодьсадва болон тэдний байгаа төвшнийг харж чадвал маш их баярлах биш үү? Бүр ч их итгэл төрж, тэр дуутай, өнгөтэй дэс, тэр хэлбэртэй, дүрстэй бурхныг даван туулж, түүнээс ч өндөр дэсэдэй болтлоо үргэлжлүүлэн бясалгах болно, ойлгож байна уу? Жинхэнэ бурханд бол хэлбэр дүрс гэж байхгүй, жинхэнэ бурхан гэдэг нь “Бурхан чанар”, “Аялгууны урсгал” буюу “Аялгуу”-г зааж буй юм, жинхэнэ Эзэн Бурхан гэдэг нь энэхүү “аялгуу”, “бүтээгчийн хүч” буюу “бүтээгчийн чадвар”-ыг зааж байгаа юм.

Хэрвээ бид Эзэн Бурхан юм бол, Эзэн Бурхан бидний дотоодод байдаг юм бол юунд түүнийг бариад авдаггүй юм бэ? Түүнийг бариад авбал харахад арай түргэн, бидний гарт байгаа, эсвэл торонд байгаа бяцхан шувуу удам огторгуйгаар нисэх шувуудаас илүү сайн, тийм үү? үгүй юү? Яагаад гэвэл огторгуйгаар нисэж байгаа шувууд нь бидэнд баригдахгүй байсаар байдаг, хичнээн байсан ч бидэнд хэрэг болохгүй, харин гарт баригдсан шувуу ганц байсан ч яахав, нэгэнт баригдчихсан болохоор сэтгэл хангалуун болчихно. Учир нь тэр бидний гарт орчихсон.

Үүнтэй адилаар, бидний дотоодод бурхан чанар байгаа юм чинь юунд энэ “Бурхан чанар”-аа бариад авахгүй, харин түүнээс “Та чинь хэн юм бэ?”, “Та хаана байна вэ?” гэж асуудаг юм бэ? Яагаад л гаднаас хайдаг юм? Сүм хийдээр явж, уул ус, хувхай ясанд мөргөдөг юм бэ? Энэ





Их багшийн мэндэлсэн өдөр бол хамгаас буянтай, хамгаас бэлгэ дэмбэрэлтэй өдөр мөн бөгөөд адислалын хүч асар их байдаг. Маш олон тэнгэрийн төрөлтнүүд, бодьсадва нар буун ирж тэрхүү “Амьд Бурхан”-д халуун баяр хүргэж, ерөөдөг. Хэрвээ бидний билгийн нүд нээгдсэн байвал үүнийг харж чаддаг.

(“Энэтхэг, Хятад, Япон зэрэг улсуудын даяан бясалгалын урсгалууд яагаад ондоо байдаг вэ?”-ээс)



Хүмүүст өөрсдөө сонголт хийж, хүссэн бүхнээ хийж болох эрх чөлөө байдаг. Тиймээс диваажин, тамын орон гээд бүгдийг бид өөрсдөө бүтээдэг бөгөөд хэн ч хүчээр хийлгэж чадахгүй.

(“Хувилгаан бие огт гайхалтай хэрэг биш” -ээс)

бүхэн нь бүгд л бурхан чанар биш, Эзэн Бурхан ч биш. Библи сударт: “Тэнгэрийн орон бидний дотоодод бий” гэсэн, Бурханы сударт: “Бурхан сэтгэлд бий” гэж өгүүлсэн, ийм юм бол юунд өөрийгөө бариад авдаггүй юм бэ? Ядаж л сэтгэл дэх бурхнаа зугтаалгаж болохгүй, түүнийг хүлээж байгаад гарч ирэх үеэр нь “Түүнд” сүслэн мөргөж болно.

Үнэндээ багш чинь та нарыг бурханд битгий мөргө гэсэн биш, харин модон бурхан, хуурмаг бурханд битгий мөргө гэсэн санаа билээ, багш чинь та нарт үнэн бурхан, хамгийн ойрхон бурхан, үг ярьж чаддаг бурханд мөргөхийг сургана. Модон бурхан үг ярьж чадахгүй, чулуун бурхан бидэнтэй ойлголцож чадахгүй, бидний асуудлыг шийдвэрлэж чадахгүй, гэтэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал дотоодын бурхан илэрч, бидэнтэй уулзаж, биднийг дагуулан хаа сайгүй аялан зугаална, баруун орон, зүүн орон, умард орон, өмнөд орныг харуулна, бидний асуудлыг шийдвэрлэж, бидний амьдралд тусална, бясалгалын талаар тусална.

Дотоодын бурхантайгаа уулзахаасаа өмнө багшаасаа сурсан ч тийм ч буруу зөрүүгүй бөгөөд зүгээр. Наад зах нь багш чинь та нарын асуултад хариулж чадна, та нартай ярилцаж, цай ууж чадна, бэрхшээлтэй болох үедээ багшдаа ирээд зовлонгоо ярьж болно, багшаараа загнуулж, үйл түйтгэрээ цэвэрлүүлбэл зүгээр болчихно.

Гэтэл модон бурханд зовлонгоо дэлгэвэл юу ч ярьж чадахгүй, огт хөдлөхгүй, нүдээ ч цавчлахгүй, модон бурхан амилаад хүнийг тайтгаруулж байхыг та нар харсан уу? Амилаад биднийг загнавал бид тун ч их баярлахсан, учир нь загнуулбал үйл түйтгэр цэвэрлэгдэнэ. Гэтэл загнах ч үгүй байхад хүмүүс мөн л тийм их бясалгал, жигнэмэг өргөдөг ч ямар ч нэмэр болдоггүй, үнэндээ жимс, жигнэмэг өргөдөг нь хүмүүсийг мэхэлж байгаа хэрэг, мөргөж дууссаныхаа дараа бүгдийг нь өөрсдөө идчихдэг (Бүгд инээлдэв) мөртлөө харин бурханд тахил өргөчихсөн гэж боддог.

Багш чинь угаас иймэрхүү явдлыг яримааргүй байсан, ингэж ярихаар ихэнх хүн сонсох дургүй болохоор бүгд л зугтчихдаг. Би “бурханд битгий мөргө” гэж дахиж ярихаа больё гэж бодсон, хашир суужээ. Гэвч заримдаа бас л мартаад ярьчихдаг, учир нь би бусдыг мэхэлж чадахгүй, наймаалцаж чадахгүй (Бүгд инээлдэв), хуурмаг бол хуурмаг гэж л ярина, тиймээс ихэнх хүн худалдан авдаггүй. Ингэх нь бас ач тустай, ядаж л багштайгаа наймаа хийдэг тэр хүмүүс хуурамч бараа худалдан авахгүй, багш чинь хуурмаг бурхан худалддаггүй болохоор та нарын худалдан авсан чинь “жинхэнэ бурхан” мөн.

Багшийгаа дагаж бясалгахад аливаа бүхэн нь бүгд жинхэнэ зүйл, цэцэг нь ч жинхэнэ цэцэг, жигнэмэг нь ч жинхэнэ жигнэмэг, судар нь ч жинхэнэ судар, бурхан нь ч жинхэнэ бурхан, багш нь ч жинхэнэ багш, харин хуванцар эдээр хийсэн багш биш (Бүгд инээлдэв), яагаад жинхэнэ багш гэж ярьдаг вэ гэвэл багш чинь юу ч хийж чаддаг, та нарыг жинхэнэ ёсоор туулан гэтэлгэж чаддагаас гадна бас байшин барьж чаддаг, угаалгын өрөө барьж чаддаг, хувцас оёж чаддаг, хоол хийж гэр цэвэрлэж чаддаг гэхчилэн тун олон ажил хийж чадна, хүн загнаж

чаддаг, бас сэтгэлийг нь тэгшлэн засаж чаддаг, бясалгаж суухыг зааж чаддаг, бас бурханд мөргөхийг ч зааж чаддаг, багшаасаа асуулт асуухад бас хариулж чаддаг, тиймээс зуун хувийн үнэн бодит багш мөн (Бүгд инээлдэв), та нар багштайгаа наймаа хийвэл аюулгүй бөгөөд мөнгөний алдагдалд орохгүй. (Бүгд инээлдэв)

Багахан авсан, эсвэл ихээхэн авсны аль нь ч тэр, бүгд л үнэн зүйл, том нь ч үнэн, жижиг нь ч үнэн, багш чинь хуурмаг зүйлд хамгаас дургүй, хуванцар цэцэг, дуураймал цэцэгт би тун эгдүүцдэг, цэцэггүй бол хамгаас сайн, эсвэл ядаж л жинхэнэ цэцэг байх хэрэгтэй, хувцас ч гэсэн, би хиймэл, зохиомол бараанд дургүй, харин жинхэнэ бөс бараанд дуртай, багшийн чинь одоо өмсөж байгаа хувцсыг өөр хүн худалдан авчирсан, би ерөөс юу байна, түүнийгээ л өмсдөг. Хэрвээ өөрөө худалдан авбал жинхэнэ барааг сонгоно, харин хиймэл бараанд дургүй, материалаг зүйлс ч гэсэн миний хувьд хэдий чинээ үнэн бодитой бол төдий чинээ сайн, энэ нь заавал үнэтэй эд худалдан авах хэрэгтэй гэж байгаа хэрэг биш, харин байгалийнхаараа байгаа эд зүйлсэд дуртай гэсэн санаа билээ. Жишээ нь: би шавар, шаазан бүтээгдэхүүнд дуртай, хуванцар бүтээгдэхүүн бий болохоос өмнө хүмүүс бүгд л вааран сав суулга хэрэглэдэг байжээ. Би эрт дээр үеийн амьдралд дуртай болохоор ууланд байхдаа онцгой нөхцөл байдалд л шингэрүүлсэн хийн түлш хэрэглэхээс бусад үед модоор гал түлж, хоол хийхийг хичээдэг, жишээ нь, ням гараг болон гурав, долоо хоногийн даяаны үеэр шавь нар олон цуглардаг болохоор хялбар дөхөмийг бодож жаахан шингэрүүлсэн хийн түлш хэрэглэдэг, бусад үед эрт дээр үеийн аргаар хоол хийдэг. Шавар юмуу модоор хийсэн эд зүйлсийг харахад тун аятайхан бөгөөд барихад ч гэсэн тун тааламжтай байдаг, учир нь хуванцар эд зүйлсийг хэрэглэхгүй болохоор сэтгэлд аятай, үнэн бодитой санагддаг. Хүмүүс угаас байгальд харьяалагдан бүгд л төмөр, мод, ус, шорооноос бүтсэн байдаг болохоор ийм зүйлтэй хамт байвал нилээд тав тухтай санагдана, өөрсдийнхөө амьсгалах орчноо сөрж байх шиг санагддаггүй, ойлгож байна уу?

Үүнтэй адилаар, би бурханд мөргөхдөө ч гэсэн жинхэнэ бурханд мөргөх дуртай, урьд нь би жинхэнэ бурхныг хайж олохоосоо өмнө бас хуурамч бурханд мөргөдөг байжээ, гэтэл тэр үед модон бурхан надад аль хэдийн хачин санагдаж байлаа, тухайн үед ямар нь жинхэнэ, ямар нь хуурмаг гэдгийг ер нь хэлж ярьсан хүн байхгүй, гэхдээ модон бурханд мөргөсний дараа би түүнийг харна, тэр ч намайг хардаг (Бүгд инээлдэв), харилцан ширтэлцээд хичнээн удсан ч модон бурханд ямар ч хувирал гэх юм алга (Бүгд инээлдэв), огт хөдлөхгүй, нулимсаа ширгэтгэл уйлсан ч хариу байхгүй (бүгд инээлдэв), хэдэн цагаар наманчлан даатгаж, зүрх сэтгэлээ, бүхнээ уудалсан ч модон бурхан хэвээрээ (Бүгд инээлдэв), өдөр бүр ийм.

Надад нэгэн өдөр тун ядаргаатай санагдан урам хугарч, даатгах болон ном уншихаа больж, түүнийг харж суув, тэллээ ч гэсэн тэр мөн л модон бурхан хэвээрээ байж, хайрлах сэтгэл гэмээр юмгүй, ямар ч хариу мэдрэмж мэдрэгдээгүй, тэр үеэр надад өөрийн өвдгөндөө даатгах нь илүү дээр шиг санагдсан (бүгд инээлдэв), тэгвэл ядаж жаахан хариу

мэдрэмжтэй болж, хөшсөн өвдгөө илж болно. Учир нь миний шүтэн дагасан багш маань модон бурханд гар хүрч болохгүй, харин сүслэн мөргөх хэрэгтэй гэж заасан. Тэр үед сахилын нэр байгаагүй, Арьяабалын бясалгалын аргаар бясалгаагүй байсан, гэвч нэгэнт зөв биш санагдаад байгаа болохоор модоор бүтээсэн төгс гэгээрсэн их багшийг огоорч, амьд бурхан, энэ ертөнцөд амьдран оршдог жинхэнэ багшийг хайхаар шийдсэн, ингэснээр нээрэн л хайж олсон билээ.

Хэн нэгэн хүн хэрвээ чин сэтгэлээсээ бясалгавал жинхэнэ багшийг лавтай хайж олно, зөвхөн сонинч сэтгэлээсээ, эсвэл бясалгахыг санадаг хэдий ч бясалгал гэж юу юм гэдгийг ойлгохгүй, бусдыг сохроор даган дуурайвал мэдээж жинхэнэ багшийг хайж олохгүй байж мэднэ. Гэтэл бид жинхэнээр бясалгал хийж, туулан гэтлэхээр шийдсэн байвал хэзээ ч лавтайяа хайж олдог.

Бид энэ “хүний бие”-ийг олж төрсөн нь бясалгахын төлөө болохоос биш, харин өдөр бүр хоол иднэ, унтана, ажиллана, хүүхдээ өсгөнө гэхчилэн нэг насаа эцэслэн юу ч үгүй хоосон буцахын төлөө биш билээ. Хүний биеийг олж төрсөн нь бясалгахын төлөө гэдгийг ойлгохгүй бол үнэхээр харамсмаар хэрэг. Учир нь хоол идэх, унтах, ажиллах, хүүхэд өсгөх зэрэг үйл хэргийг амьтан ч хийж чаддаг, бид зөвхөн ийм үйл хэргийг л хийж чаддаг юм бол бидний амьдрал амьтдынхтай адилхан болчих биш үү? Хүний төрлийг олчихоод мөн л амьтадтай адил байвал хүн болж төрсний хэрэг юун? Хүн бологсод өөр төрөлтнөөс эрхэм дээд байдаг гэж бид үргэлж л ярьдаг, гэтэл тэдэнтэй адилхан болчихвол эрхэм дээд гэмээр зүйл яахин байж чадах билээ?

Хүн бол хамгийн эрхэм дээд төрөлтөн, яагаад гэвэл бясалгаж чаддаг, бурхны хутагт хүрч чаддаг, бурхан чанараа хайж олдог, дотоодын эзэн бурхнаа хайж олдог, дотоодын тэнгэрийн орноо харж чаддаг, ийм болохоор нь л хүн бол хамгийн эрхэм дээд гэж ярьж болно. Хүний дотоодод тэнгэрийн орон байдаг, бурхан байдаг болохоор эрхэм дээд болж байгаа юм. Бид угаас бурхан мөн юм чинь мэдээж эрхэм дээд болно, гэтэл тэнгэрийн орноо хайж олоогүй бол мөн л эрхэм дээд болж чадахгүй, амьтдаас тийм ч их ялгаагүй, өдөр бүр хоол иднэ, унтана, хүүхдээ өсгөнө гэхчилэн нэг насаа хий хоосон, талаар өнгөрүүлдэг.

Тиймээс л багш нь хамгаас их буянтай хүн л Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж, авшиг хүртэж чаддаг гэж өчигдөр ярьсан билээ. Яагаад вэ гэвэл ихэнх хүн бүгдээрээ л өнгөн талын бурханд найддаг болохоор багшийн чинь ярьдаг сургаал ёсыг сонсох дургүй, өнгөн талын бурхныг огоорч чаддаггүй болохоор бид өөрсдөө “бурхан” мөн, бид бас Шагжамуни Бурхан шиг бясалгал хийж бурхны хутагт хүрч чадна гэдгийг ойлгодоггүй, Шагжамуни Бурхан бол хорвоод хосгүй бурхан мөн гэж үздэг, ингэж үзэх нь бурхны сургаал ёсыг сөрж байгаа хэрэг билээ. “Аливаа төрөлтөн бүгд бурхны хутагт хүрч чадна” гэж Бурхан багш айлджээ, бясалгал хийвэл энэ төрөлдөө бурхан болж чаддаг, гэвч заавал Арьяабалын аргыг бясалгаж байж л ихэд билиг нээгдэн гэгээрч чадна, бүтээгчийн дэсэд хүрч чадна, Эзэн Бурхан, Төгс төгөлдөр гүн их билиг ухааны дэсэдэй нийлж чадна.

Учир нь Арьяабалын бясалгалын арга бол энгийн арга биш, урьд нь Шагжамуни Бурхан шавь болгондоо Арьяабалын бясалгалын аргыг уламжлаагүй, тухайн үед Ананд Арьяабалын бясалгалын аргыг хараахан мэдээгүй байсан гэдгийг “Баатар явагч их хөлгөн судар”-аас ойлгож болно. Ананд нэгэнт Шагжамуни Бурханыг шадарлан дагаж нилээд удчихсан бөгөөд тухайн үе нь “жинхэнэ номтны цаг үе” байсан, гэтэл Шагжамуни Бурхан түүнд Арьяабалын бясалгалын аргыг уламжилсангүй, зөвхөн энгийн даяан бясалгалын арга болон гэлэнгийн сахил, бодьсадвагийн сахил гэх мэтийг уламжилжээ. Тиймээс тухайн үед Ананд мөн л нэгэн энгийн гэлэн байж, ихэд гэгээрч чадсангүй, иймээс л эмэгтэйчүүдэд сэтгэл татагдан сахилаа алдах шахжээ, хэрвээ Шагжамуни Бурхан гэрэл цэцруулан авраагүй бол сайхан бүсгүйд татагдан гэрлэж, гэргийтэн болчих байжээ. Тиймээс Арьяабалын бясалгалын арга бол энгийн арга биш, Шагжамуни Бурхан өөрийн хамгийн ойр дотно шавьдаа ч уламжлаагүй гэдгийг бид ойлгох хэрэгтэй.

Багш чинь Пин Хү-д байх үедээ ч гэсэн бусдад авшиг уламжлах бодол байгаагүй, учир нь одоо би нэгэнт хашир сууж, хүссэн бүхэнд авшиг өгөхөө больсон, тэд суралцах ёстой зүйлээ суралцаж дуусаад чин сэтгэлээсээ ном хайхаар ирэх үед л уламжилж болно, одоо багш чинь тийм ч хялбархнаар ном уламжлахаа больжээ, энэ тоолшгүй олон галавт ховорхон тохиолдох бясалгалын аргыг хамаг төрөлтөн нандигнан дээдлэхээ мэддэггүй. Анандад асуудал үүсэх үеэр л Шагжамуни Бурхан “Баатар явагч их хөлгөн судар”-ыг айлдсан бөгөөд Арьяабалын бясалгалын аргыг бясалгахын ач тусыг ярьсан байна, үүнээс өмнө Бурхан Багш Арьяабалын бясалгалын аргыг ерөөсөө яриагүй, тэгээд хамгийн сүүлд нь “Олонх бурхант судар”-ыг айлдах үеэр л Арьяабалын бясалгалын аргыг жинхэнээр нь танилцуулжээ.

“Олонх бурхант судар”-т Шагжамуни Бурхан: “Энэ бясалгалын арга бол яг л хамгийн эрхэм дээд, хамгийн сайн сувд эрдэнэ шиг хураан хадгалж байгаад хамгийн эцэст нь л хамгаас их буянтай хүмүүст өгдөг” гэж ярьсан байдаг. Гэтэл Шагжамуни Бурхан шиг тийм их нэр алдартай, нэгэнт бурханы хутагт хүрчихсэн хүн байсан ч гэсэн Арьяабалын бясалгалын аргыг тайлах үеэр таван мянган хүн номын хурлаас салан гарч явсан байдаг, яагаад гэвэл тэд энэ бясалгалын аргад итгээгүй, тэдний мэддэггүй бас нэгэн бясалгалын арга байдаг гэдэгт итгээгүй болохоор сонсохгүй, Арьяабалын бясалгалын аргыг сурах дургүй байжээ.

Арьяабалын бясалгалын арга яагаад тийм хамгийн дээд, яагаад тийм чухал байдаг вэ гэвэл “Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй” судар-т тэмдэглэсэнээр: Бинбисара (binbisara) гэдэг нэртэй нэгэн хаан байжээ, хөвгүүн нь түүнийг гянданд хорьж, түүнд хоол хүргэхийг хориглож, эцэг хаанаа гянданд өлсгөж үхүүлэхээр бэлтгэжээ. Гэтэл хааны хатан Войдехи хаанд далдуур хоол хүргэжээ. Үүнийг хааны хөвгүүн мэдсэнийхээ дараа ээждээ уурлаж, хааны хатныг алах ялаар шийтгэх гэж байсныг төрийн хоёр гавьяат сайд нь ятгаж байж алах ялаас нь хэлтрүүлжээ, тэгээд хатныг хэнтэй ч уулзуулалгүй эзгүй ордонд хорьжээ. Тэр үеэр хааны хатан ихэд сэтгэл шаналан уйлж Gi she

jue shan уул тийш хандаж, Шагжамуни Бурханд даатган Ананд, Молом тойн хоёрыг гянданд томилон сургахыг гуйжээ, тэгж гуйснаар Бурхан Багш тэр дорхноо хоёр шавиа нисгэж, гянданд очуулан ном тайлж хатны сэтгэлийг амирлуулсан байдаг.

Одоо бид “ниссэн” тухай явдлыг ярилцъя! Молом тойн (Модгальяана), Ананд хоёр махан биеэрээ нисэн хүрсэн ч байж мэднэ, эсвэл “хувилгаан бие”-эрээ нисэн хүрсэн ч байж магад, энэ тухай ном сударт тодорхой өгүүлээгүй. Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны

дараа бас махан биеэрээ өөр газарт нисэн хүрч чаддаг, гэхдээ өөр хүн харж чаддаггүй, биеэ далдлах аргаар, эсвэл хувилгаан биеэр нисэхийн аль нь байсан ч бүгд л тун хялбар хэрэг, зөвхөн Шагжамуни Бурхан амьд байгаа үедээ л ингэж чаддаг биш, одоо ч гэсэн зарим хүн ингэж нисэж чадна. Тиймээс зарим хүн багшийгаа олон газарт илрэхийг хардаг бөгөөд үнэн хэрэг дээрээ би өөрөө мөн л эндээ байж байдаг.

Молом тойн(Модгальяана) зөн билиг ихтэй, Ананд ч гэсэн зөн билигтэй, тэр хоёр махан биеэрээ гянданд нисэж хүрэх нь боломжгүй хэрэг биш, бясалгагч хүн маш олон үйл хэргийг хийж чаддаг, учир нь эрт дээр үед зам харилцаа сайнгүй болохоор тэд сүнсэн биеэрээ нисэх боломжтой, жишээ нь хоёрдугаар биеэрээ тэнд нисэн хүрвэл нилээд түргэн байдаг.

Тэр хоёр тун сүрхий, эрдэм чадвар их, гэвч тэр үед тэр хоёрын аль аль нь Арьяабалын бясалгалын аргаар бясалгадаггүй байжээ, учир нь “Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй судар”-ыг “Баатар явагч их хөлгөн судар” болон “Олонх бурхант судар”-аас өмнө тайлсан, гэтэл “Олонх бурхант судар”-ыг хамгийн сүүлд нь тайлсан болохоор тухайн үед Ананд Арьяабалын бясалгалын аргаар бясалгадаггүй байсныг мэдэж болно, ийм байлаа ч гэсэн тэр нисэх ид шидтэй байжээ, тийм их зөн билигтэй байсан хэдий ч мөн л эмэгтэй хүнд сэтгэл татагдсан, мөн л билиг нээгдээгүй байжээ. Тиймээс зөн билигтэй байх нь тийм ч сүрхий юм биш, Арьяабалын бясалгалын аргаар бясалгахгүй бол хамгийн дээд ач тусыг хүртэж чадахгүй гэж Шагжамуни Бурхан номложээ.

Ананд, Молом тойн (Модгальяана) хоёр ийм байхад бидний тухайд бүр ч ярих юм алга, жаахан ч зөн билиг гэж байхгүй, Бурхан Багштай ч хамт байгаагүй. Ананд өдөр болгон Бурхан Багштай хамт байж, ихийг сонссон талаараа нэгдүгээрт жагсдаг хэдий ч Арьяабалын бясалгалын аргаар бясалгасны дараа л их Кашибтай хамт ном хурж, ном судрыг эмхлэн бүртгэх ажилд оролцож чаджээ, тэгээгүй бол их Кашиб түүнд огт нүүр тал өгөлгүй хөөж явуулах байсан.

Арьяабалын бясалгалын арга маш сайн гэдэг нь ийм учиртай, зөвхөн Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж байж л амжилтад хүрч чадна, тэгэхгүй бол Бурхан Багштай өдөр бүр хамт байж, адислалын хүчийг нь хүртэж, ном тайлахыг нь сонсож байсан ч хангалттай буян хурааж чадахгүй, заавал Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал жинхэнээр үлэмж их ач буянтай болж, мөр ёсыг олж чадна. Харин өдөр бүр Бурхан Багштай хамт байснаар л мөр ёсыг олж чаддаг юм биш, эсвэл өөрийгөө эрхшээж, өөрийгөө ариусгаж чадчихдаг юм биш. Бурхан

Багштай хамт байх нь мөн л хангалттай биш, хамт байвал буянтай болдог хэдий ч энэ нь зөвхөн бусдын буяныг зээлж байгаа төдий хэрэг билээ, ойлгож байна уу?

Мөр ёсыг олчихсон нэгэн багштай өдөр бүр байнга хамт байх нь мэдээж бидэнд нөлөөлж, бага зэрэг гэрэл гэгээтэй, ариун тунгалаг ахуй орчныг олгодог, гэвч энэ нь багшаасаа зээлж байгаа зүйл, харин бидний өөрсдийнх биш, тиймээс Арьяабалын бясалгалын аргыг бясалгаж байж л бурханы хугагт хүрч чадна. Багш чинь та нарыг бурхан болгоно, багштайгаа адилхан болгож хувиргана, харин төрөл төрөлдөө багшийнхаа шавь болж, цэцэг өргөн сүслэн мөргөж, шүтэн тахих төдийхөн байлгах биш, багшийнхаа хувцсыг угаах, гутлыг нь арчих биш, энэ бол миний хүсэл эрмэлзэл биш, та нар бүгд багштайгаа адилхан болж хувирах ёстой!



## ГУРВАН ЕРТӨНЦИЙГ ТУУЛАН ГЭТЛЭХ ЦОРЫН ГАНЦ АРГА ЗАМ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Пин Ху*

*(Эх нь хятад хэлээр)*

*1987 оны 2 дугаар сарын 11*

Өнөөдөр та бүхэнтэй уулзсан маань ёстой ховорхон тохиолдол боллоо, гэхдээ та нарыг ямар ном сонсох дуртайг мэдэхгүй байна, багшийнхаа санааны аясаараа тайлах ном, эсвэл “Очироор огтлогч судар” хоёрын алийг нь сонсох дуртай байна вэ? Тайваньд хамгийн алдартай нь “Очироор огтлогч судар” билээ.

Би өөрийгөө “Их Багш” гэж хэлж байгаа нь би бол та нарын багш мөн гэх бардамнах бодол өвөрлөснөөс болсон хэрэг биш. “Ши пү” (Их Багш гэсэн утгатай) гэсэн хоёр үгийг хэрэглэсэн нь “би” гэх эгэл хүнийг ашиглаж, та нарт ном тайлах гэсэн хэрэг ч бас биш юм. Учир нь Их Багш бол “би” биш, бид тэр жинхэнэ Их Багшийг эгэл хүнтэй адилтган үзэж болохгүй. Хүн бүрийн дотоодод байх тэр Их Багш бол Багш мөн байдаг хэдий ч хүмүүс мэддэггүй, хүн бүхэн цөмөөрөө багш мөн. Энэ багшийг Будда, Бодьсадва, эсвэл Богд гэгээнтэн, Их Багш, Сайтар гэгээрэгсэд гэхчилэн юу гэж ч нэрлэсэн болно.

Тиймээс “Багш” гэж миний ярьж байгаа нь энэ үлэмж их билиг ухааныг ашиглаж, та нарын үлэмж их билиг ухаанд сонсгож байгааг л хэлж байгаа хэрэг бөгөөд харин “би” гэх эгэл хүнийг ашиглаж, “би” гэх би та нарт ном тайлж байгаа хэрэг биш юм. Бид өдөр бүр маш олон “би” гэх үзэлтэй эгэл хүмүүстэй хамт байж, замбараагүй, хэрэгцээгүй элдэв явдлыг ярьж байдаг. Тиймээс багш нь “Багш ном тайлна” гэж ярьж байгаа нь та нарыг хүндэтгэж буй хэрэг, та нарын багш болохын тулд биш юм.

Багш нь энэ гэрээс гарагчийн хувцас өмссөн учраас хэзээ, хаана ч гэсэн буддын шашны гэрээс гарагч юм. Буддын шашны үлгэр ярьж байгаа нь шашин суртахууны талаар буддын шашин, католик шашин гэж ялгаварлаж байгаа хэрэг биш. “Мөр ёсон” (Дао) угаас ганцхан байдаг ч хамаг төрөлтний дэс өөр өөр байдаг болохоор бурхан бодьсадва нар өөр өөр амар хялбар аргаар хамаг төрөлтнийг гэтэлгэдэг. Энэ талаар өнөөдөр ярихгүй.

Өнөөдөр багш нь буддын шашны үлгэрээс ярина гэж хэлбэл зүйтэй байна. Учир нь энд сууж байгаа хүмүүсийн дунд зарим нь аль хэдийн билиг нээгдсэн хүн бий, билиг нээгдсэн хүн Буддын шашин, Католик

шашин, Бумбын шашин зэрэг нь угаас бүгд адилхан утгатай, адилхан зорилготой бөгөөд адилхан бясалгалын аргыг сургадаг байж магадгүй гэдгийг ойлгоно. Гэтэл билиг нээгдээгүй хүн бол адилгүй олон өөр арга зам, мөр байдаг гэж бодож байж ч мэднэ. Адил бус зам мөр мөн эсэх тухай дараа ярья!

Угаас ямар ч төрлийн шашны сүсэгтэн, ямар ч төрлийн шашны урсгал бүлгийн хүн байлаа гэхэд хэрэв тэр хүн жинхэнэ бясалгагч, жинхэнэ мөр ёсыг хайгч бол үхэж, төрөх сансрын хүрднээс ангижирч, гурван ертөнцийг даван туулахыг л зорьдог. Одоо бид явал гурван ертөнцөөс ангижирч чадахаа мэдэх хэрэгтэй, энэ бол хамгаас чухал зүйл. Бид ямар шашин нь сайн, ямар шашин нь муу гэдгийг анхаарах хэрэггүй, энэ бол чухал биш, зөвхөн энэ “мөр”, энэ “зам”-ыг л таньж мэдэх хэрэгтэй.

“Мөр” угаас мөнхөд оршдог, харин бясалгаж байж л энэ “Мөр”-ийг хайж олдог юм биш, эсвэл энэ “Мөр”-ийг хөгжүүлж чаддаг юм биш. Энэ мөр бол “Бурхан чанар” мөн, бид угаасаа аль хэдийн “Бурхан чанар”-тай байдаг болохоор энэ хаалгыг онгойлгодог л юм бол түүнийг харж чадна. Яг л нар, сар шиг, тэд угаасаа гадна байдаг боловч хаалга хаалттай бол бид харж чадахгүй, хаалга нээгдмэгц харин тэр даруйдаа олж харж чадна. Бид хаалга хаана байдгийг мэддэг бол өөрөө онгойлгож болно, гэтэл мэдэхгүй бол хаалга хаана байгааг мэддэг хүнийг эрж олох хэрэгтэй. Тэгвэл тэр хүн бидэнд тусалж, хаалгыг нээж өгөх юмуу, яаж онгойлгохыг зааж өгөх боломжтой, эсвэл хаалга хаана байгаа, яаж онгойлговол нар, сарыг харж чадахыг бидэнд зааж өгч ч магад. Үүнийг Даяаны бүлэгт “Агшин зуур гэгээрэх” хэмээн нэрийдэж, ном сударт “Цэцэг дэлгэрч, бурхан харагдах” гэдэг, Бумбын шашинтан “Мөр бүтэх”, эсвэл “Мөр харагдах” гэх зэргээр өгүүлдэг.

Зарим хүн өөрсдөө хаалгаа нээж чадахгүй, бас хаалга хаана байгааг ч мэддэггүй болохоор бусдад тусалж, хаалгыг нь нээж өгдөг жинхэнэ Их Багшийг хайх хэрэгтэй, учир нь Шагжамуни Бурхан үй түмэн хувилгаан биеэр хамаг төрөлтийг гэтэлгэж, Авид Бурхан цаглашгүй гэрэл цацруулан хүмүүсийг гэтэлгэдэг гэхчилэн хэлдэг. Бид үнэхээр бурхныг мэдэхийг хүсвэл бурхны хутагт хүрэх хэрэгтэй, тэгж байж л сая бурхныг ойлгож, бурхан гэж юу болохыг мэдэж чадна, эс бөгөөс мэдэх аргагүй. Жишээ нь, бид Шагжамуни Бурханыг танилцуулах гэвэл зөвхөн түүний нутаг ус, амьдралын байдал, хичнээн жил бясалгасан, Бурханы хутагт хүрсний дараа хамаг төрөлтийг гэтэлгэсэн гэх зэргийг ярьж чадахаас биш бясалгалын дэс төвшнийг нь мэдэж хэлэхийн аргагүй байдаг.

Шагжамуни Бурхан амьд байх үед нэгэн бүсгүйн бяцхан хүү нь ил мэдэгдэх өвчингүй байтлаа гэнэт нас барсанд бүсгүйн сэтгэл ихэд шаналан өдөржин уйлдаг болжээ. Тэр үед Шагжамуни Бурхан тэр хавиар ном тайлж байсан тул бүсгүй Шагжамуни Бурхантай уулзан зовлонгоо тоочин гомдоллож, Бурхан Багшаас зөн билиг, ид шидийн хүч, үлэмж их билиг ухаанаараа хүүг минь дахин амилуулж болохсон болов уу? гэж гуйжээ. Тэгэхэд Бурхан Багш: “За! Би хүүг чинь дахин амилуулж болно оо, гэвч та эхлээд гэртээ хариад айл айлаар орж, тав,

зургаан үеэрээ элэг бүтэн байгаа гэр бүлийг хайж олоод хувцас хунар, гэрийн эдлэл хэрэгслээс нь надад аваад ир. Тийм зүйл авчирсаны дараа л хүүг чинь аварч чадна” гэж хэлжээ.

Үүнийг сонсоод бүсгүй өдөржин айлуудаар явж асуусан боловч тав, зургаан үеэрээ элэг бүтэн байгаа гэр бүлийг олж чадсангүй. Туйлдаж ядран горьдлого тасарсан тэрээр Бурхан Багш дээр буцаж ирэхэд нь Бурхан Багш “Таван үеэрээ элэг бүтэн байгаа гэр бүлийг хайж олов уу?” гэж асуув. Бүсгүй “Үгүй, тийм гэр бүл үнэндээ байдаггүй юм байна” гэжээ. Энэ үед л сая Шагжамуни Бурхан “Тиймээ, хүний амьдрал мөнх бус. Мөнх амьдардаг хүн гэж үгүй, энд төрсөн хэн ч бай, хэзээ нэг өдөр энэ ертөнцөөс буцах болно. Тиймээс та энэ мөнх бус махан биеийн төлөө дэндүү битгий гуньж зов доо!” гэжээ. Бурхан Багш ийнхүү үнэнийг хэлсэн даруйд бүсгүйн билиг нээгдэж, Бурхан багшийг шүтэн дагаж, үнэнч шавь нь болсон бөгөөд чармайн бясалгаж эхэлжээ.

Мөн өөр нэг үлгэр нь, нэгэн маш муухай царайтай эм чөтгөр байжээ, маш аймшигтай, та нар шиг ийм гоё сайхан биш. Тэр чөтгөр хүний мах идэхэд тун их дурладаг айхтар муу зуршилтай аж, бар яг л хүний мах идэх дуртай, энгийн хүмүүс үхэр, гахай, тахиа, нугасны мах идэх дуртай байдагтай адил юм. Тэр чөтгөр хүүхдийн мах идэх онцгой дуртай болохоор хүүхэд хармагцаа барьж иддэг, ингэснээр тосгоны хамаг хүүхдийг идэж дуусгах дөхжээ. Тиймээс энэ тосгоны хүүхдийн аав, ээж нар Шагжамуни Бурханы дэргэд хүрч ирэн аврал гуйсанд Бурхан Багш яаж шийдвэрлэснийг та нар мэдэх үү? Энэ үлгэрийг урьд нь сонссон хүн байна уу? Байхгүй юу? За, тэгвэл багш нь та нарт ярьж өгье!

Тэр чөтгөр мөн нэг хүүхэдтэй байжээ, чөтгөр байтлаа бас хүүхэд төрүүлдэг гэдэг нь үнэхээр гайхалтай хэрэг байна. Гэхдээ тэр чөтгөр өөрийнхөө хүүхдэд тун хайртай аж, яг л бар шиг, бар ямар ч амьтан, эсвэл хүнийг идчихдэг хэдий ч өөрийн бамбараа иддэггүй, их хайрладаг. Үүнтэй адил энэ чөтгөр бас өөрийн хүүхдээ ихэд хайрладаг байж. Тиймээс Шагжамуни Бурхан тэр хүмүүст: “Та нар буцаад яв, өнөө орой тэр чөтгөрийг эзгүй үед нь хүүхдийг нь чөтгөрт мэдэгдэлгүйгээр аваад нуучих. Дараа нь яах ёстойг би сүүлд хэлж өгье” гэжээ. Тэр хүүхдүүдийн аав, ээж нь чөтгөрийг гадагш гарсан үеэр амжиж хүүхдийг нь нууж гэнэ. Чөтгөр гэртээ хүрч ирээд хүүхдээ алга болсныг мэдэж, машид гашуудан шаналан зовж, газар өнхрөн унаад гаслан уйлжээ. Тэгээд эцэст нь Бурхан Багш дээр ирж аврал гуйв. Та нар хараач! Чөтгөр байтлаа бас хүндэлдэг ажээ, жинхэнэ бясалгагч мөн л бол ад чөтгөр ч гэсэн хүндэлдэг байна.

“Та өөрийн хүүхдээ маш их хайрладаг, тийм үү? үгүй юү?” гэж Бурхан Багш чөтгөрөөс асуухад “тийм” гэж хариулжээ. Бурхан Багш: “Хүүхэд чинь чиний хувьд дэлхий дээрх хамгийн эрхэм үнэтэй эрдэнэ байж таарна, тийм үү?” гэж асуухад чөтгөр мөн: “тийм” гэжээ. “Тэгвэл та хүүхдээ тэгж их хайрладаг байхад бусад хүүхдийн аав, ээж нар мөн л өөрийн хүүхдээ тэгж хайрладаг юм шүү дээ! Ийм байтал та яагаад бусдын хүүхдийг үлдээлгүй иддэг юм бэ? Хожим бусдын хүүхдийг дахин идэхээ болино гэж надад амлавал би чамд хүүхдээ эрж олоход чинь тусална” гэж Бурхан Багш хэлсэнд чөтгөр даруй зөвшөөрчээ.

Чөтгөр байтлаа билиг нээгддэг байна, тийм үү? үгүй юү? Шагжамуни Бурхан энэ ёсыг түүнд ярьсан даруй гэгээрч, дахин бусдын хүүхдийг идэж зурхлэхээ больжээ.

Бидний хувьд нялх хүүхэд гэдэг нь уг ч ярьж чадахгүй, алхаж ч чадахгүй, том хүнээс огт өөр байдаг хэдий ч тэр мөн л нэгэн төрөлтөн мөн бөгөөд хожим том болж бидэнтэй адилхан болдог. Энэ үлгэрээс бид амьтад ч гэсэн мөн нэг төрөлтөн мөн, тэд хожим ихэд бясалгасны дараа бас хүний төрөл авч болдог, бурхан болж ч чаддаг гэдгийг мэдэж болно. Тиймээс бид жинхэнэ Бурхнаас суралцаж, жинхэнэ нигүүлсэнгүй сэтгэл үүсгэв гэвэл амьтдын махыг идэхгүй гэж андгайлбал зохино.

Хүн бүхэн аяндаа билиг нээгддэг, эсвэл ухаарч ойлгож чаддаг биш гэдгийг энэ хоёр үлгэрээс мэдэж болно, заримдаа заавал өөр хүн түүнд хэлж ярьж байж л сая ойлгож чаддаг, яг л эхний үлгэр дэх бүсгүй шиг өөр бусдын хүүхэд ч гэсэн бүгд хэзээ нэг өдөр мөн л нас барж, энэ ертөнцөөс буцах болдгийг ойлгоогүй байжээ. Тэр үед нь Шагжамуни Бурхан түүнийг тайвшруулахын тулд зөвхөн ухаалаг үг хэрэглэн: “Уйлах хэрэг юун билээ? Хүний амьдрал мөнх бус гэдгийг та ойлгох хэрэгтэй, хэзээ нэгэн цагт бид ч бүгдээрээ энэ ертөнцөөс салж одно. Үйл байвал үр байна, хүү чинь муу үйл тарьсан байвал мэдээж нас барах болно, учир нь хүүд чинь буян гэмээр зүйл байхгүй юм чинь явах л хэрэгтэй болдог, тиймээс та ингэж сэтгэлээ шаналгасны хэрэггүй” гэж хэлсэн бол бүсгүй ийм зүйлийг сонсоод хүлээн авч чадахгүй байх байсан. Хэдийгээр тийм боловч иймэрхүү тохиолдолд олон хүн бусдад ингэж хэлж, тэднийг тайвшруулах гэж оролдсоор байдаг.

Харин Шагжамуни Бурхан тэгсэнгүй, бүсгүйгээр элэг бүтэн гэр бүлийг хайлгасанд мэдээж хайж олох боломжгүй зүйл билээ. Тэр үед Шагжамуни Бурхан юу ярьсан ч бүсгүй тэр тэр даруй хүлээж авна, учир нь тэрээр өөрийн биеэрээ туулж, бодитойгоор ойлгосон байна. Багшийнхаа ярьсан санааг ойлгож байна уу? Эхэндээ багш чинь бас ахуй ойлголтуудын тухай ярьдаг байсан. Хэрэв бид өөрсдөө “Мөр ёс”-ыг ухаарч чадахгүй бол заавал “Мөр ёс”-ыг мэддэг бөгөөд түүнийг хаанаас, хэрхэн олж болох тухай сургаж чаддаг нэгэн хүнийг хайж олох хэрэгтэй, тэгсний дараа бид өөрсдөө дотоод ахуй ойлголттой болж, Үнэн ёсыг ойлгож чадна. Жишээ нь, бид Авид бурханы судрыг уншвал Шагжамуни Бурхан: “Авид Бурхан бол цаглашгүй гэрэл мөн, Авид Бурхан байнга гэрэл цацруулан ирж, биднийг авардаг, Авид бурханы орон ийм тийм дүр зурагтай болон хүслэнт ахуйтай, бас тэнд болжмор шувууд уянгатайгаар жиргэж, сонсголонтой дуу хөгжим эгшиглэж байдаг, хэрвээ ийм дуу аялгууг сонсвол бидний тархи сэтгэл бүрэн тайвширч бурхан, ном, хуврагийг дурсаж чадна” гэж өгүүлсэн байдаг. Бурхан Багшийн ингэж ярьсан болон зарим хүн Төгс баясгалант оронд хүрч тийм хүслэнт ахуйд очин баясдаг гэдгийг сонсдог хэдий ч бид өөрсдөө тийм дотоод ахуй ойлголтгүй бол итгэхгүй бөгөөд Төгс баясгалант орныг жинхнээсээ ойлгож чадахгүй. Тиймээс ном тайлахыг сонсох, ном судар унших нь бүгд л бусдын ахуй ойлголтыг сонсож, бусдын өөрсдийнхөө дэс төвшнийг ярьж байгааг сонсох төдий зүйл

болж, энэ нь бидэнтэй ямар ч холбоо хамааралгүй байх болно. Билиг нээгдэж, ийм хүслэнт ахуйг жинхэнэ, бодитойгоор ойлгож мэдье гэсэн хэн ч гэсэн заавал үүнтэй адилхан ахуй ойлголттой болох хэрэгтэй, эсвэл ядаж л Төгс баясгалант орны тухай бага зэрэг ч гэсэн ахуй ойлголттой болох хэрэгтэй.

Тухайн үед Шагжамуни Бурхан хүүхдийн мах иддэг өнөөх чөтгөрт шууд л: “Та тийм харгис муу сэтгэлтэй байж болохгүй, бусдын хүүхдийг идэж болохгүй, хүүхдээ алдсан тэр аав, ээж ямар их шаналан зовж байдгийг та мэдэхгүй гэж үү? Ингэх чинь буруу шүү! Бусдын сэтгэлийг зовоохгүй байвал зохино” гэж ярьсан бол тэр чөтгөр сонсохгүй байсан ч байж мэднэ, учир нь тэр өөрөө сэтгэл шаналж үзээгүй юм чинь. Тиймээс Шагжамуни Бурхан эхлээд бусдаар түүний хүүхдийг нь хулгайлуулж, хүүхдээ алдахын зовлонг өөрт нь ойлгуулсны дараа ярьсанд чөтгөр даруй ухаарчээ. Ардын аман ярианд: “Өөрсдөө аав, ээж болохоороо л аав, ээжийнхээ сэтгэлийг ойлгодог” гэдэг.

Авид Бурханы сударт Төгс баясгалант оронд сонсголонтой сайхан дуу аялгуу, үзэсгэлэнтэй төвшин байдаг, хамаг төрөлтөн ийм төвшинд хүрч, тийм дуу аялгууг сонсож чадвал аяндаа сэтгэл огт үймрэхгүйгээр бурхан, ном, хуврагийг дурсаж чадна гэсэн байдаг. Гэвч бид өдөр бүр дурсан уншдаг хэдий ч сэтгэл төвлөрч чадахгүй, есөн шидийн юм боддог. Учир нь бид энэ төвшинтэй холбогдоогүй, ердөө л хаалгыг нь тогшоор байдаг бөгөөд дотор нь орж чадаагүй, гэрийн эзэнтэй нь үг ярьж чадаагүй, гэрийн эзэн нь хэн болохыг ч мэдээгүй болохоор түүнтэй ямар ч үйл хэрэг хийж чадахгүй, зөвхөн хаалганы цаанаас нэрийг нь дуудах төдийхөн байгаа билээ.

Та нар багшдаа юм хэлж ярьж гэвэл заавал хаалга нээж, миний өрөөнд орж ирэх хэрэгтэй, тэгэхгүй бол гаднаас: “Чин Хай Багш аа! Чин Хай Багш аа!” гэж хичнээн хашгирсан ч багш нь дууг чинь сонсоход хэцүү. Чин Хай багш сонсож чадаж ч магадгүй, сонсохгүй ч байж мэднэ, дуу чинь маш сулхан, эсвэл Чин Хай багш унтаж байх ч юм билүү. Гэхдээ та хаалгыг шууд онгойлгон өрөөнд нь орвол Чин Хай багшийн царай төрхийг харж чадах бөгөөд түүнтэй нүүр тулан ярилцаж, бясалгал хийхийг сурч болно.

Гэхдээ түүнтэй ярилцах хүсэлтэй мөртлөө харин ердөө л гаднаас дуудвал тийм ч их нэмэргүй, дуу чинь дуулдаж ч магад, дуулахгүй байж ч магад. Түүнтэй уулзаж чадаагүй бол дууг чинь лав сонсоогүй хэрэг, та нарын дууг сонссон бол тэр лав гарч ирээд уулзана. Түүнийг харж чадахгүй байгаа нь та нар зөвхөн нэрийг нь дуудаж байгаа төдийгөөс болсон хэрэг. Дууг чинь сонсоогүй байхын шалтгаан нь бид хаалга тогшоор л байгаа хэрэг бөгөөд дуу тань тун сулхан, эсвэл буруу дугаар луу залгаснаас холбогдож чадахгүй байгаа байж магадгүй. Холбогдье гэвэл утасны дугаар нь эрхбиш зөв байх, мөн цахилгаан утас нь тасраагүй байх хэрэгтэй, ингэвэл л нөгөө этгээд чинь дууг чинь сонсож, бидэнтэй ярьж чадна.

Гэхдээ та ядаж л түүн лүү утасдаж, өдөр бүр гэртээ түүний нэрийг дуудаж болно. Хэрвээ утсаар холбогдож чадахгүй бол шалтгааныг

нь олох хэрэгтэй, бидний утас, эсвэл цаадах утас нь эвдэрсэн байвал даруйхан сажаж сэлбэх хэрэгтэй, ингэвэл холбогдож чадна. Үгүй бол захидал бичиж болно, захидал бичсэн ч хариу ирэхгүй бол хаягийг нь буруу бичсэн байж мэднэ. Та зөвхөн гэртээ суугаад түүний нэрийг дуудаад байх юм бол, миний бодлоор түүнтэй уулзах боломж тун бага. Хэрэв та чин сэтгэлээсээ түүнийг эрж олох хүсэлтэй байвал найзад нь найдаж болох юм, найз нь түүний хаана байгааг мэддэг болохоор та түүнд захидал бичвэл найзаар нь дамжуулах юмуу, түүний нэр, суугаа газар, утас зэргийнх нь талаар зөв мэдээлэл олж авч болно, тэгвэл түүнтэй холбогдож, хариу захидал авч чадна.

Бидний биед нэг зүйлийн хаалга байдаг бөгөөд түүнийг онгойлгож болно. Хаалганы цаана Бурхан байдаг, Төгс баясгалант орон байдаг болохоор юунд хаалгыг нь онгойлгохгүй байгаад байна вэ? Хаалганы цаанаас дуудаад ямар хэрэг байна аа? Түлхүүр байхад хаалгаа яагаад онгойлгодоггүй юм бэ? Учир нь түлхүүр хаана байгааг мэдэхгүй, хаалга хаана байгааг ч мэдэхгүй. Өөрсдөө мэдэхгүй бол мэддэг хүнээс хаана байгааг нь асуух хэрэгтэй. Учир нь Төгс баясгалант орны тийм хөгжмийн дууг сонсож, долоон эрдэнэт нуурын найман ач буянт усыг бага зэрэг амсах юмуу, Авид бурханыг харах, өөрөөр хэлбэл “Цаглашгүй гэрэл”-ийг харах хэрэгтэй гэж ном сударт тун тодорхой өгүүлсэн байдаг. Ингэснээр л бид нэгэнт Төгс баясгалант оронтой холбогдож, бас утсаар холбогдож чадсанаа мэддэг бөгөөд нотолж чадна. Урьд нь зөв оновчтой утасны дугаар, суугаа газар, нэр овгийг нь мэдэхгүй байсан учраас буруу хаалга тогшиж, нэрийг нь буруу дуудсан болохоор хэдэн зуун жилээр хаалгыг нь тогшсон ч нээж өгсөн хүн байгаагүй аж.

Тиймээс эхлээд Авид Бурхантай танилцах хэрэгтэй, тэгвэл хожим Түүний нэрийг дуудвал ач тустай, гэхдээ заавал чамайг Авид Бурханд танилцуулах хүн хэрэгтэй. Жишээ нь: бид Америкийн ерөнхийлөгчтэй танилцахаасаа өмнө гэрээсээ түүний утас руу залгасан ч тус болохгүй бөгөөд түүнтэй ярьж чадахгүй. Учир нь тэр чамайг танихгүй, та ч түүнийг танихгүй болохоор тэд: “Та чинь чухам хэн болоод манай ерөнхийлөгчийн утас руу залгаж зүрхэлнэ вэ?” гэж асууна. Энэ нь Америкийн ерөнхийлөгч ялгаварлах сэтгэлтэй, чамтай ярих дургүйдээ биш юм, харин доорх хүмүүс нь чамайг ерөнхийлөгчтэй яриулахгүй байгаа болохоор захидал бичих, утасдахын аль нь ч нэмэргүй, “Та хэн бэ? Ерөнхийлөгчийг хайж яах гэсэн юм бэ?” гэж асууна. Учир нь энэ эртнөцд хуул гэж байдаг болохоор ерөнхийлөгчтэй ярьж гэвэл заавал зарим нэг хүнээс зөвшөөрөл авах хэрэгтэй. Тэд эхлээд таны биеийн байцаалтыг асууна, дараа нь ерөнхийлөгчтэй юу ярих, ямар зорилгоор уулзах гэж байгаа талаар асуух болно.

Үүнтэй адилаар, Төгс баясгалант орон ч бас дүрэм журамтай, луугийн сахиуст ном хамгаалагчтай, тэнгэрийн луут найман сахиустай байдаг. Бид Авид Бурхантай холбогдох гэвэл энэ хамгаалагчид бидний хүслийг тэр даруйдаа хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд тэд эхлээд заавал бидний ач буян хэр их вэ, хэр их буян үйлдсэн, Авид бурханы утас руу залгаж эрхтэй юү, үгүй юү гэдгийг харах хэрэгтэй болно. Яг л бид

Америкийн ерөнхийлөгчтэй танилцахаас өмнө аль хэлтэс нь утас авсан ч ямар ч нэмэргүй, тэд чамайг ерөнхийлөгчтэй яриулахгүйтэй адил юм.

Тиймээс Авид бурханаас юм гуйх гэвэл эхлээд Авид Бурхантай танилцах, санаагаа ойлголцох, найзлах гэх мэтээр харилцаж байж л дараа нь түүнтэй ярьж, байнга утасдаж холбогдож болно. Төгс баясгалант оронд очъё гэвэл эхлээд Авид Бурханыг таних хэрэгтэй, түүний байгаа газрыг мэдэж, цаглашгүй гэрлийг нь таньж, Түүнээс хувилсан бяцхан шувуудын эгшиг буюу Төгс баясгалант орны дуу хөгжмийг сонордон сонсож, найман ач буянт рашааныг харах гэх мэтээр ядаж л бага зэрэг нотолгоотой болж байж Авид Бурханд очихоор би нэгэнт онгоцны тийз, суудал нэг нэгийг захиалчихсан, одоо хэзээ ч явсан болно гэж ярьж болно. Одоо түүнийг танихгүй юм бол нэрээр нь дуудсан ч Тэр сонсохгүй байж мэднэ. Жишээ нь: бид гэрээсээ ерөнхийлөгчийн нэрийг өдөр бүр дуудвал тэр аль нэг өдөр хаалганы маань яг урдуур өнгөрөхдөө сонсож ч магад, гэтэл ийм тохиолдол тун ховорхон бөгөөд ийм аргаар ерөнхийлөгчтэй танилцах нь тийм ч их найдвартай биш. Учир нь ерөнхийлөгч хүн хаа очсон ч тун олон хамгаалагч дагалдан явдаг бөгөөд маш олон иргэд түүнийг хүрээлэн эргэн тойрноор нь лав шуугиан ихтэй байх болохоор бидний дууг сонсох боломжгүй байх юм.

Хятад улсын эртний хаад эгэл ардын хувцас өмсөж, өөрийгөө нууцлан далдалж, иргэдийнхээ аж байдалтай танилцсан үлгэрийг бид сонсож байсан. Гэхдээ Хятад орон тийм өргөн уудам болохоор хаан өдөр бүр өглөөнөөс орой болтол борви бохисхийлгүй насан эцэстэлээ явсан ч тийм олон хүнтэй уулзан танилцаж чадахгүй бөгөөд ард иргэд нь ч хаантай уулзах тохиолдол ч тун цөөн байх болно. Өнөөгийн ерөнхийлөгч эртний хаадаас бүр ч яаруу бөгөөд түүнд хаалганы маань өмнө хүрч ирэн бидэнтэй танилцах боломж байхгүй. Авид Бурхан, Арьяабал Бурхан, Очирваань Бурхан ч мөн л ийм байдаг. Тэд тун яаруу, хүнийг аврах гэж яарна, хамгийн их зовлонтой хүмүүсийг аврах гэж яарч байдаг. Ганга мөрний элсний ширхэг шиг олон төрөлтөн өдөр бүр өглөөнөөс орой болтол Тэднийг нэрээр нь дуудаж байдаг болохоор бидний дуудлагыг санамсаргүй сонсох тохиолдол үнэхээр ховор. Тиймээс бид өөрсдөө идэвхтэй байж, Тэдэнтэй холбогдох нь хамгийн сайн, холбогдож чадахгүй бол өөр хүнээс: Та Төгс баясгалант орныг мэдэх үү? Авид бурханыг таних уу? Таньдаг бол намайг түүнд танилцуулж чадах уу? гэж асууж болно. Авид Бурхан биднийг таньдаг байх л юм бол сая бид түүнтэй ярьж чадна. Жишээ нь, бидний нэгэн сайн найз Америкийн ерөнхийлөгчтэй тун дотно нөхөрсөг харилцаатай бол тэр биднийг түүнд танилцуулснаар бид ерөнхийлөгчтэй найз болж чадах юм, үгүй бол найзлах аргагүй.

Үүнтэй адилаар, маани тарни, ном судар унших нь бүгд л бусдын ахуй ойлголт бөгөөд бидэнтэй холбоо хамааралгүй, бид заавал өөрсдөө ахуй ойлголттой болох хэрэгтэй. Багш чинь онцгой сургаал ёсыг заагаагүй, Багш та Ариун орны бүлэгтэн үү? гэж асуувал би тийм гэж хариулна, Багш та Даяаны бүлэгтэн үү? гэж асуувал мөн л тийм гэж хариулна. Багш та Тиан тай-гийн бүлэгтэн үү? Зоотонгийн бүлэгтэн үү?,

Линчин бүлэгтэн үү? гэхчилэн асуувал би бүгдэд нь тийм гэж хариулна.

Угаас аль ч бүлэгтэн бүгд адилхан, хамгийн чухал нь эрхбиш сайтар гэгээрсэн хүмүүс удирдан дагуулах хэрэгтэй, тэрээр “зам” мэддэг, зам зөвхөн ганцхан зурвас төдийхөн нарийхан байдаг, гэтэл энэ бүлэгтний өвгө Багш нарын нэр нь ондоо болохоор л өөр өөр бүлэгтэн болж хувирчээ, эс бөгөөс аль ч шашин гэсэн онцгой гэмээр зүйлгүй, бүгд л адилхан номын арга, адилхан замыг заадаг. Учир нь зам ганцхан зураас төдийхөн байдаг, мөр ганцхан байдаг, энэ “Мөр”-ийг хайж олбол бид дээш гарч чадна. Бид түүнийг “Мөр”, “Зам”, “Бясалгалын арга”, “Бурхан чанар”, “Уг чанар”, “Уг дүр” гэхчилэн нэрлэдэг нь бүгд л адилхан утгатай. Аливаа шашны урсгал бүлэг бүгд л эхлээд энэ “Мөр”-ийг хайж олсны дараа л дээш гарч чадна гэж хүмүүст сургадаг.

Энэ “Мөр”-ийг “Баатар явагч их хөлгөн судар”-г “Арьяабалын бясалгалын арга” гэж нэрлэсэн, “Хотол зохилдогч зүйл”-д мөн “Арьяабал” гэж нэрлэдэг. Арьяабал гэдэг нь амаар “Арьяабал” гэж уншихыг хэлж байгаа юм биш, харин Арьяабалын бясалгалын аргаар бясалгахыг хэлдэг. Үүнээс гадна Ариун орны бүлгийнхэн “Цаглашгүй гэрэл” гэж нэрлэж, Даяаны бүлгийнхэн харин “Билиг ухаан”, “Дотоодын хүч” гэж ярьдаг. Бид Арьяабалын бясалгалын аргыг ашиглаж, энэ хүчтэй холбогдвол Бурханы орныг хайж олж чадна. Учир нь Арьяабалын бясалгалын арга бол энэ “Мөр” мөн, энэ “Мөр”-ийг бясалгаж байж л дээш гарч болно. Энэ мөр нь яг л байшингийн шат шиг юм, та нар гаднаас орж ирэхдээ заавал байшингийн шатаар дээш гарч байж л энд хүрч ирж чадна. Хятад хэлэнд байшингийн шат гэж ярьдаг ч бусад улсад өөрөөр хэлдэг. Хэдийгээр өөр өөрөөр нэрлэдэг хэдий ч бүгд л адилхан утгатай. Жишээ нь “ус” -ыг Хятад хэл болон Тайвань хэлээр өөр өөрөөр дууддаг, Тайвань шиг ийм жижигхэн арал байтал хоёр төрлийн хэлтэй, зарим нь Хятад хэлээр ярьж, тайвань хэлийг ойлгодоггүй, зарим нь тайвань хэлээр ярьж, хятад хэлийг ойлгодоггүй. Эгэл ертөнцийн үг хэлийг ойлгоход ч гэсэн ийм хэцүү байхад бурхны үг хэлийг ойлгоход яаж тийм амар хялбар байж таарах вэ? Ийм учраас ном судар уншаад ч бас тийм ч амархан ойлгохгүй, бурхан ойлгодог хэдий ч эгэл хүмүүс ойлгохгүй.

Учир нь Шагжамуни Бурхан маш олон хүнийг сургасан болохоор нирваандаа буцсаных нь дараа бид өөрсдийгөө буддын шашинтан гэж нэрлэжээ. Исүс Христ ч гэсэн маш олон хүнийг сургасан болохоор диваажиндаа буцсаных нь дараа бид өөрсдийгөө Христийн шашинтан гэж нэрлэжээ. Луузыг таалал төгссөний дараа шавь нар нь түүнийг хүндэтгэж, хойч үеийн хүмүүс Луузын шашин буюу Бумбын шашин гэж нэрлэжээ. Күнз тухайн үед олон газраар тойрон аялж, шавь нараа сургахдаа өөртөө ямар нэг нэр өгөөгүй байсан, гэтэл Түүнийг таалал төгссөний дараа хойч үеийнх нь хүмүүс түүнийг Күнзийн сургаалтан буюу бичгийн сургаалтан гэж нэрлэжээ.

Тиймээс Шагжамуни Бурхан нирваандаа буцсаны дараа буддын шашин болж хувирсан, Исүс Христ диваажиндаа буцсаны дараа Христийн шашин болж хувирчээ. Үүнтэй адилаар Линчингийн бүлэг,



Зоотонгийн бүлэг, Ариун орны бүлэг гэх мэт шашны олон урсгал бүлгийн нөхцөл байдал нь бүгд адилхан, бүгд л эгэл хүмүүсийн үг хэлээр бий болсон зүйл, харин угаасаа тийм төрлийн шашны урсгал бүлэг гэж байгаагүй. Шашны урсгал бүлэг гэж байдаггүй, зөвхөн “бясалгалын арга”, “Мөр” гэж л байдаг. Шашны эзэн болгон бүгд л адилхан сургаал ёсыг номлож, энэ “Мөр”-ийг хайж олоорой гэж сургажээ, гэтэл тэд нирваандаа буцаад хэсэг хугацаа өнгөрсний дараа нэгэн шашны урсгал болж хувирсан байж мэднэ. Жишээ нь, багш нь нэрд гарсны дараа “Хайн бүлэг” (бүгд инээлдэв) болж хувирсан байж ч магадгүй, нээрэн ийм болчихвол үнэхээр тун инээдтэй хэрэг болно.

Хамгийн эхэн үеийн буддын шашин нь угаас адилхан сургаал ёсыг сургаж байжээ, ямар ч ондоо зүйл байгаагүй. Гэтэл одоогийн энэ шашны бүлгийнхэн багшийг чинь өөр зүйлийг сургадаг болохоор шинэ бясалгалын аргыг сургадаг гэж үздэг бөгөөд биднийг нэгэн шинэ шашны урсгал бүлэг гэж боддог байна. Үүнд би дургүй байдаг, учир нь тийм “Бясалгалын арга”, тийм “Мөр” аль хэдийн байсан, эртнээс өнөөг болтол аливаа жинхэнэ Их Багш нар бүгд л “Арьяабалын бясалгалын арга”-ыг сургасан, үүнийг би өөрөө шинээр үүсгэн бүтээсэн биш. Шагжамуни Бурханаас өмнө ч энэ бясалгалын арга байсан бөгөөд бас зөвхөн Буддын шашинд л энэ бясалгалын аргыг хэлж ярьсан юм биш. Католик шашин, Луузын шашинд бүгдэд нь л энэ дотоодын хэлбэлзэл, дотоодын дуу аялгууг ярьсан байдаг. Гэвч бид дотоод ахуй ойлголттой болохгүй бол тэд адилхан сургаал ёс, адилхан номын аргыг ярьсан юм байна гэдгийг ойлгохгүй.

Зөвхөн буддын шашинд л гэхэд Арьяабалын бясалгалын аргыг тун олон өөр өөр нэрээр нэрлэсэн байдаг. Олонх бурханта сударт “Олонх бурханта ном” гэж, Хотол зохилдогч зүйлд “Хотлоор гэтэлгэгч бясалгалын арга” гэж нэрлэдэг. Хотол зохилдогч гэдэг нь нэгэн хаалгыг хэлдэг бөгөөд энэ хаалгаар ямар ч оронд хүрч чаддаг болохоор хотол зохилдогч гэж нэрлэжээ. “Баатар явагч их хөлгөн судар”-т “Арьяабалын бясалгалын арга” гэж ярих болжээ. Авид бурханы сударт “Ариун орны дуу хөгжим, яруу сонсголонтой дуу хөгжим, бяцхан болжмор ном тайлах” гэх мэтээр тун тодорхой өгүүлсэн байна. Шагжамуни Бурхан тийм их бясалгалын арга заагаагүй, зөвхөн ганцхан зүйлийг л ярьсан, гэхдээ адилгүй үлгэр, адилгүй хялбар аргаар хамаг төрөлтийг гэтэлгэсэн байна. Жишээ нь, багш чинь Христийн шашны нэгэн бясалгалын төвд очвол Библи судрыг ашиглаж, тэдэнд Арьяабалын бясалгалын аргыг заана, харин “Би та нарт буддын шашны “Баатар явагч их хөлгөн судар” дахь Арьяабалын бясалгалын аргыг заана” гэж хэлэхгүй. Библи судрыг ашиглаж байж л тэдэнд тайлбарлаж ойлгуулна, учир нь Библи сударт ч мөн Есүс Христ тийм бясалгалын аргыг заасан байдаг. Ийм аргаар тэднийг сургаж болно, тэд заавал буддын шашинтан болох албагүй. Бурхан, ном, хуврагийг шүтэн дагах, сахилын нэр хүртэх, орхимж өмсөх, бодьсadgeгийн сахил хүртэх гэх мэтийн зүйл байхаар л Арьяабалын бясалгалын аргыг бясалгаж чаддаг юм биш. Тэд Библи судрыг жинхэнээр ойлговол бас бидний энэ Арьяабалын бясалгалын

аргыг бясалгахад ямар ч асуудалгүй.

Ариун орныг бясалгах тун дуртай хүн байвал би Ариун орны ном судрыг ашиглаж, түүнд Арьяабалын бясалгалын аргыг сургана, эсвэл Зоотонгийн бүлгийн бясалгалын аргад дуртай хүн байвал Зоотонгийн сургаал ёсыг ашиглаж, Арьяабалын бясалгалын аргыг тайлбарлана. Харин өөрсдийн шашин шүтлэгээ заавал өөрчилж байж л сая энэ бясалгалын аргыг бясалгаж чадна гэж бусдыг албадахгүй. Зоотонгийн бүлэг, Ариун орны бүлэг, Бумбын шашин, Католик шашин, Христийн шашин гэх мэтэд дуртай хүмүүс бүгд л бясалгаж болно. Учир нь хамгийн дээд бясалгалын арга зөвхөн ганцхан байдаг болохоор хамаг төрөлтөн ямар сургаал ёсонд дуртай бол тэдний дур хүсэлд нийцүүлэн тайлбарлах хэрэгтэй. Жишээ нь: би ус уух гэвэл та нарт “шүй, шүй” (ус гэсэн утгатай) гэж хэлэх хэрэгтэй, хэрэв би Хятадаар жаахан ч ярьж чаддаггүй байлаа ч гэсэн зөвхөн “ус - шүй” гэж хэлэх л юм бол хангалттай. Өөр бусад улс оронд очвол тухайн улсын үг хэлээр ярих хэрэгтэй, тэгэхгүй бол тэд бидний ярьж байгааг ойлгохгүй. Италид очихдоо би “шүй, шүй” гэж хэлбэл тэд намайг цангаж үхэхэд хүргэнэ (бүгд инээлдэв), эсвэл “фан, фан” (хоол гэсэн утгатай) гэж хэлбэл бас намайг өлсөж үхэхэд хүргэнэ. Учир нь тэд ойлгохгүй болохоор заавал тэдний үг хэлээр яривал тэд бидэнд хоол идүүлж чадна, учир нь улс болгоны үг хэл өөр өөр байдаг.

Гэхдээ хамгийн сайн нэг төрлийн “үг хэл” байдаг ч түүнийг амаар ярих шаардлагагүй байдаг. Жишээ нь: би ус ууя гэвэл гараараа зангаж үзүүлэхэд л та нар мэдчихнэ, би цангаад ус уух гэвэл, эсвэл өлсөөд хоол идэх гэвэл ингэж дохиогоор дүрсэлж илтгэх нь хамгийн сайн үг хэл болно, тиймээс бидний сонссон “даяан үг хэл хэрэглэдэггүй” гэдэг нь мөн ийм утгатай билээ.

Жинхэнэ хоол нь энэ хоолны сав биш, жинхэнэ ус нь мөн энэ усны сав юм, гэтэл хоолны савыг ашиглаж байж л хоол аягалж чадна, усны савыг ашиглаж байж л сая ус савлаж чадна. Жинхэнээсээ хооллох, жинхэнээсээ ус уух үед юу ч ярих шаардлагагүй. Тиймээс юу гэж нэрлэсэн ч болно, хоол идэж, ус уух нь л хамгийн чухал. Ус гэж юу болох, хоол гэж юу болохыг үг хэлээр дүрслэхийн аргагүй. Хоол идэж, ус уух үедээ л ойлгож чадах юм. Жишээ нь, хоолтой, устай хүн юу ч ярилгүйгээр чамд тэр даруй ус уулгаж, хоол идүүлж чадна. Тэрээр хоол ямаршуухан тэжээлтэй, ус хэр их чухал гэж өдөржин сурталчилаад байдаггүй, өлсөж байгаа хүн байвал түүнд даруй хоол идүүлж, цангаж байгаа хүнд даруйхан ус уулгадаг. Үүнтэй адилаар “Мөр”-ийг олсон хүн, эсвэл бясалгалын аргыг мэддэг хүн байдаг л юм бол үг хэлээ ойлголцохгүй ч гэсэн бидэнд ном уламжилж болно. Учир нь та нар гараараа дүрслэн үзүүлэх л юм бол тэр чиний бодол санааг ойлгож, тэр даруй аяга, савх өгч хоол идүүлнэ.

Ном судартай шадарлаж, маш олон ном судрыг ойлгож, уран цэцэн ярьж чаддаг хэдий ч Үнэн ёсыг ойлгохгүй бол яг л бусад хоол идүүлж чаддаггүйтэй адилхан болохоор миний бодоход тийм ч их ач тустай биш. Ингэх нь яг л жигнэмэгийг ихэд сурталчилдаг хэдий ч жинхэнэ

жигнэмэгээ өгч идүүлж чадахгүй байгаатай адил юм, тэр хүмүүс өөрсдөө тэр жинхэнэ жигнэмэгийг идээгүй, бусдад бүр ч идүүлээгүй байдаг.

Гэхдээ бас ном тайлах хэрэгтэй, учир нь хүний тархи толгой нэгэнт дэндүү олон зүйлийг шингээж, маш олон үйл хэргийг мэдэж, маш олон юмыг харж, маш олон зүйлийг шүүмжилж, маш олон хэрэгцээгүй ёс учрыг сурсан болохоор хэн нэг хүн яаралтай ирж, ном уламжилж чадна гэж яривал бид түүнд итгэхгүй байж ч магад, тийм үү? үгүй юу? Тиймээс заавал тэдний дур сонирхолтой зүйлийг ярих хэрэгтэй, гэхдээ жинхэнэ хоол идэх хүртэл нь л ярина, жинхнээсээ хооллох үеэр нь юу ч ярих шаардлагагүй, даруй идэж болно, ус ууя гэсэн ч дорхноо ууж болно. Ингэх нь сайн, жинхэнээр ус ууж, жинхэнээр хоол идэж байгаа хэрэг болно.

Үгээр ярих нь мөн л хоол биш, ус биш, гэвч ярихгүй бол та нар мэдэхгүй, учир нь хэн хоол идүүлж, ус уулгадгийг мэдэж чадахгүй. Тиймээс гудамжинд: “Махгүй зонз (хулсны навчинд боосон нэг зүйлийн идээ) худалдана” гэж хашхирахыг сонсвол зонз худалдаж байгааг мэдэж болно, тэгээд бид ийм зонзыг худалдан авч иднэ. Үүнээс гадна гудамжаар мөсөн чихэр, нишингэ худалдана гэж зарладаг нь тэдэнд тийм зүйлийн юм байгаагаас болж байгаа хэрэг. Гэтэл зарим хүн юу ч үгүй байтлаа зар тараадаг нь харин хамгийн төвөгтэй хэрэг юм. Өөрт нь хоол унд байвал зар тарааж болно, тийм хүн өлссөн хүнийг цагаж, цангасан хүнд ус ойртуулахыг хүссэн болохоор хоол унд худалддаг. Зарим хүн мөнгөтэй, бас сайхан сэтгэлтэй болохоор сүм хийдийн хүмүүст мөнгө авахгүйгээр хоол идүүлж, хавийн хүмүүст ус хүргэж, шаардлагатай хүмүүст өглөг өгдөг. Тиймээс зарим хүн хоол худалдаж, зарим хүн ус худалдаж, зарим нь хоол ундаар өглөг үйлдэх гэхчилэн олон янз байдалтай байдаг. Гэхдээ заавал өөрөө юмтай байж байж л сая зар сурталчилгаа хийж болно, юу ч үгүй байж дураараа зар гаргах нь тун инээдтэй хэрэг биш үү?

Арьяабалын бясалгалын аргыг сурталчлахад заавал Арьяабалын бясалгалын аргыг мэддэг байх хэрэгтэй, тийм чадвартай бөгөөд бусдад ном уламжилж, бусдын билгийг нээж чаддаг байх хэрэгтэй. Төгс баясгалант орныг сурталчилахдаа ч гэсэн бусдад юуг “ариун орон” гэдгийг мэдүүлэх хэрэгтэй. Бусдад ном уламжилж чадах бөгөөд “Ариун орон энд байгаа, та хаалга нээмэгц харж чадна” гэж зааварлаж чаддаг байх хэрэгтэй. “Мөр”-ийг тайлбарлахдаа: “Мөр энд байгаа, та энэ мөрөөр явбал ийм тийм нөхцөл байдал тохиолдох болно, тэр бол мөр мөн” гэж бусдад ойлгуулж чаддаг байх хэрэгтэй.

Хэрвээ зөвхөн ярихаас биш, өөрөө мэдэхгүй бол миний бодлоор энэ бол гэмт хэрэг мөн, яг л худал ярихтай адил, үнэн бодит ач тусгүй, хүмүүсийн дургүйг хүргэх төдий хэрэг. Угаас нэгэнт таны ам цангаж, бүтэн өдөржин ус уугаагүй байхад дээр нь бас цагаа гарздаж, түүний “ус” гэж ямаршуухан зүйл байдаг тухай ярихыг нь сонсоно, гэсэн ч тэр танд ус уулгаж чадахгүй. Тэгэхлээр энэ нь та цагаа үрж байгаа хэрэг бус уу? Түүний ярихыг сонсож цагаа гарздаж байхын оронд өөр газарт очин бусдаас ус хаана байгааг асуух нь илүү дээр байсан боловч та тэр үед түүний усны тухай ярихыг сонсож байгаа болохоор жинхэнэ устай

хүнийг хайх завгүй байна. Тиймээс миний бодоход усгүй хүн хамгийн сайн нь усыг сурталчилахгүй байж, бусдын цагийг үрэхгүй байх хэрэгтэй.

Уг нь би бас дэндүү их яримааргүй байсан ч үүнийгээ мартчихсан болохоор ийм их зүйл ярьчихжээ, одоо ярихаа больё, дэндүү их ярьж болохгүй. Хуучин найз нараа харсандаа би тун баяртай байгаагаа хэлэх ёстой, уг нь би та хэдийн төлөө ном тайлахаар ирсэн, учир нь та нар багшийгаа Пин Хү-д дахин ирэхийг чин сэтгэлээсээ урьсан болохоор сэтгэл маань машид догдолж: “За! Та хэдийн төлөө би Пин Хү-д дахин очно” гэж хэлсэн. Тэгтэл эцэст нь нилээд олон хүн нэмэгдэж, арилжаа тун сайн, ус худалдаж эхлээгүй байгаа ч зар сурталчилгаа маш сайн хийжээ. (Бүгд инээлдэв)

**Асуулт:** Бурхныг яаж дурсвал Авид Бурхантай сүсэг барилдлагатай болж чадах вэ? Багш аа та хэлж өгөхсөн болов уу?

**Их Багш:** Одоо би эхлээд энэ “дурсах” гэдэг нь юу вэ гэдгийг ярья! Дурсах гэдгийн утга нь “Дурсан санах” болно, дурсан санахад бодол төрдөг, харин зөвхөн амаар унших төдий биш юм. Тиймээс энэ тоост хорвоод бид бурхныг “Дурсах” гэхдээ юугаараа дурсдаг вэ? Сэтгэлээрээ дурсдаг уу? Аав, ээж нь хүүхдээ дурсан санахдаа сэтгэлдээ, тархи толгойдоо дурсан санадаг.

Хятадад эрэгтэй, эмэгтэй хоёр хүн бие биенээ санан дурссан үлгэр их байдаг. Жишээ нь, Лан Шин Бүве болон Зү Интэй нарын тухай “Ший Шиян Жий” гэх зэргийн үлгэр бол бүгд л маш алдартай янаг хайрын үлгэр билээ. Учир нь энэ үзэсгэлэнт бүсгүйг хараад гэртээ харьсны дараа түүний нойр хоол нь хасагдаж, дэндүү ихээр санан дурсдаг болохоор бүсгүйтэй уулзахыг ихэд хүсэх болжээ. Гэтэл Лан Шин Бүве нь Зү Интэй-тэй танилцаагүй байсан бол тийм ихээр санан дурсах боломжгүй билээ. Анхандаа Зү Интэй эрэгтэй хүний дүрд хувирсан байсан болохоор Лан Шин Бүве түүнийг санан дурсах боломжгүй, зөвхөн найз болзолсон төдийхөн байжээ. Хожим нь түүнийг эмэгтэй хүн болохыг мэдсэний дараа бодол санаа нь даруй хувирч, санан дурсах болж, түүнтэй гэрлэх хүсэл төржээ, тиймээс асуудал үүсэж, харилцан санагалзах болов. Зү Интэй нь тийм сайн, тийм л ховорхон тохиолдох найз байсан болохоор санан дурсах болжээ.

Үүнтэй адилаар, бид Авид Бурханыг санан дурсахын тулд ядаж эхлээд Авид Бурханыг таньдаг байж л санан дурсаж чадна, Авид Бурхан гэж хэн болохыг мэдэхгүй бол яаж санан дурсах вэ? Анхандаа Авид Бурханы хөргийг харахад надад онцгой зүйл бодогдоогүй. Харин одоо Авид бурханыг тун их санан дурсах болсон байна, учир нь би нэгэнт Авид Бурхантай танилцаж, “Жинхэнэ бие”-тэй нь уулзчихсан. Гэтэл хөрөг зургийг нь харах үед тийм ч онцгой санагддаггүй юм.

Урьд нь би ном судар уншихдаа Шагжамуни Бурхан Авид Бурханы оронд ямар ямар эгшиг аялгуу хөгжим, ямар ямар хурц тод гэрэл байдаг, мөн алтан өнгийн гэрэл, шар өнгийн гэрэл, найман ач буянт рашаан гэхчилэн олон төрлийн гайхалтай хүслэнт ахуй байдаг гэж дүрслэн ярьсан байдгийг уншиж байсан ч өөрөө төсөөлөн бодохын

аргагүй байсан тул нэгэн үзүүрт сэтгэлээр Авид Бурханыг дурсан санахын аргагүй байв. Гэтэл би Багштайгаа уулзаж, Багш маань надад нэгэнт Авид Бурханыг танилцуулснаас хойш Авид Бурхан бол модоор сийлбэрлэсэн модон бурхан биш, тийм муухай дүр төрхтэй биш гэдгийг мэдэж, тэр бол “Цаглашгүй гэрэл” болохыг жинхнээсээ ойлгон таньж, Төгс баясгалант орны тийм аялгуу хөгжмийг жинхнээсээ бодитоор ойлгодог болсон бөгөөд энэ үеэс л би сая Авид Бурханыг үнэхээр санан дурсаж чаддаг болсон билээ. Жишээ нь, нэгэн эрэгтэй хэрэв нэгэн эмэгтэйтэй уулзаагүй, зөвхөн гэрэл зургийг нь харсан байвал тийм ихээр санан дурсаж чадахгүй. Гэтэл түүнтэй танилцаж, үг яриаг нь сонсоход эмэгтэйн дуу хоолой тун сонсголонтой, эерүү зөөлөн санагдсан бол, тэрээр гэртээ харьсны дараа эмэгтэйг байнга дурсан санах болно. Түүний зүс царайг хараагүй байсан ч дууг нь сонсоны дараа санан дурсаж ч магадгүй. Эрт дээр үед лимбэ сайн тоглодог нэг хүн байжээ. Хааны гүнж нэг өдөр тэр лимбэний дууг сонссоноос хойш түүнийг ихэд дурсан санах болсон ч хожим нь түүнтэй уулзахад тийм сайхан царайтай биш болохыг нь хараад урам нь ихэд хугарчээ. Та нар энэ үлгэрийг сонсож байсан уу? Энэ нь Вьетнам ардын үлгэр ч байж магад, түүний нэрийг Труонг Чи гэдэг, лимбэ тоглохдоо тун сайн тул гүнж тэр лимбэний дууг сонсоод түүнийг өдөр бүр тун их дурсан санагалзах болжээ.

Үүнтэй адилаар, бид Авид Бурхантай уулзаагүй ч Түүний ном тайлах, Түүнээс хувилсан бяцхан шувуудын дуу дуулахыг болон Төгс баясгалант орны дуу хөгжмийг сонсвол “санан дурсах” сэтгэл төрөх бөгөөд тэр үед л бид сая жинхэнэ нэгэн үзүүрт сэтгэлээр “бурхныг дурсах” болно.

Тиймээс Лан Шин Бүве нь Зү Интэй-г ихэд санан дурсанаасаа болж өвчин тусаад бүр орноосоо ч босож чадахаа больж, юуг ч тоохгүй, энэ дэлхийг ч ойшоохгүй хэмжээнд хүрчээ. Тэр их мэдлэгтэй, гэгээн саруул ирээдүйтэй, өөрөө цэцэн сэргэлэн, үзэсгэлэнтэй сайхан, олон эмэгтэй түүнд дурладаг байтал тэрээр тэднийг ер тоохгүй байдаг бөгөөд юу ч сэтгэлийг нь татаж чадахаа больжээ. Тэр үед тэр зөвхөн Зү Интэй-г л санан дурсаж, санаж бэтгэрээд өвчлөхөд хүрч, унд хоол ч идэхгүй, унтах нойр ч үгүй байсаар эцэс сүүлд нь цусаар бөөлжиж нас баржээ. Энэ бол жинхэнэ нэгэн үзүүрт сэтгэлээр санан дурсаж байгаа хэрэг болно. Хэрэв бид Авид Бурханыг үүний хагас хэртэй л санан дурсаж чадвал лавтай Төгс баясгалант оронд очиж чадна.

Гэтэл бидний санан дурсах гэдэг нь юу вэ? Зарим хүн нэг талаар “Авид Бурхан” гэж уншиж, нөгөө талаар “Та сайн уу? Нааш ирээд цай уугаарай!” гэж бусадтай мэндчилж байдаг. Зарим хүн хэдийгээр бурхан гэж уншдаг хэдий ч хүүхэд ирж түүнээс юм авах гэхэд: “Эгдүүтэй гэдэг нь! Цаашаа бай, одоо надад зав байхгүй” гээд маанийн эрихээрээ ороолгон хөөж явуулдаг. Ингэх нь жинхэнээр бурхныг дурсаж байгаа хэрэг биш, ийм аргаар бурхныг дурсвал хожим Төгс баясгалант оронд очиж чадах эсэх нь нэг том асуудал. Бид бүгдээрээ л Төгс баясгалант оронд очиж чадахгүй байхаас тун их санаа зовдог. Төгс баясгалант оронд очих нэгэн арга байдаг, гэхдээ эрхбиш эхлээд Авид Бурханыг таньж,

Түүнийг хаанаас хайж олохыг мэдэх хэрэгтэй, ингэвэл нас барахаасаа өмнө эхлээд Авид бурханыг харж чадна, Түүнтэй уулзаж чадахгүй байж магад хэдий ч байдал төрхийг нь харчихлаар Авид Бурханыг “санан дурсах” бодол төрж хангалттай чадна. Өдөр бүр илүүхэн шиг ойр байж, тодорхой шиг харж байж л жинхэнэ санан дурсаж чадах юм. Бид өдөр бүр Авид Бурхан гэж уншдаг ч сүсэг барилдлага байхгүй болохоор уншихын зэрэгцээ сэжиг төрдөг, сэжиг төрдөггүй хүн байлаа гэхэд энэ ертөнцийн санаа бодолд таагдана, энэ ертөнцийн нисваанист нөлөөнд автана, тэгээд л сэтгэл төвлөрч бурхныг “дурсан санаж” чаддаггүй. Тиймээс бурхныг “дурсах” зөв аргыг мэдэж байж л сая нэгэн үзүүрт сэтгэлээр дурсан санаж чадна.

**Асуулт:** Багш аа! Нэгэн үзүүрт сэтгэлийг яаж барьж чадах вэ?

**Их Багш:** Хамгийн түрүүнд эхлээд бие, хэл, сэтгэлээ бэлэн болгож байж л энэ үзэсгэлэнтэй сайхан сүм хийддээ (багш өөрийн бие цогцосоо заав) бурхныг урин залж чадна. Энд гэрэлтэй, үзэмжтэй, рашаан устай, бурхан сэтгэлтэй, юу л бол юу бүгд бий. Бидний бие цогцос бол хамгийн гайхамшигтай нууцлаг сүм хийд мөн, бид гадна талдаа хэчнээн их мөнгө хуримтлуулсан ч тийм сайхан сүм хийдийг байгуулж чадахгүй. Тиймээс Авид бурханыг өөрийн сүм хийдийнхээ тэргүүн ламаар урьж залъя гэвэл сүм хийдээ ариутган цэвэрлэх хэрэгтэй.

Багш чинь зөвхөн энгийн нэгэн гэрээс гарагч байтал та нар багшаараа ном тайлуулахаар залж, намайг энд долоо хоног болоход байрныхаа дээд, доод өрөөгөө гялалзтал сайхан цэвэрлэжээ. Тэгвэл бид Авид бурханыг урьж залъя гэвэл эхлээд өөрсдийгөө бүр ч илүү ариусган цэвэрлэх хэрэгтэй биш үү? Өөрийгөө ариусган цэвэрлэх гэдэг нь юуг хэлж байна вэ гэвэл “Очироор огтлогч судар”-т дурдсанаар: Өглөг үйлдэх, сахил сахих, хүлцэн тэсвэрлэх, чармайн бясалгах гэх зэргийг биелүүлж байж л даяан агуулж, билиг ухаан төрж чадна гэжээ. Даяаныг агуулах гэдэг нь нэгэн үзүүрт сэтгэлийг барихтай адил зүйл бөгөөд ялгаварлах сэтгэлээр бурхны судрыг уншиж болохгүй. Даяаныг агуулах болон нэгэн үзүүрт сэтгэлийг барих хоёр ямар ялгаатай вэ? Даяаныг агуулах гэдэг нь сэтгэл тайван болж, огт самуурахгүй байхыг хэлнэ.

Тэгвэл өглөг үйлдэх гэж юу вэ? Зарим хүн “Надад мөнгө байхгүй, яаж өглөг үйлдэх вэ?” гэдэг, гэтэл өдөр бүр өглөг үйлдэж байж л сая Авид бурханыг харж чаддаг юм биш. Мөн өглөг үйлдэх гэдэг нь зөвхөн мөнгө хандивлахыг л хэлдэг төдий биш юм, мөнгө хандивлах нь хамгийн бага хэрэг, хэн ч бай мөнгөтэй л бол тийн өглөг үйлдэж болно. Мөнгө хандивлахаас гадна бидэнд бас номын өглөг, сайн бодол санааны өглөг, юунаас ч айхгүйн өглөг гэх мэтийн өглөг байдаг. Яг л Арьяабал Бурхан шиг, хамаг төрөлтөн айж эмээх, санаа зовох үеэр Арьяабал Бурхан ирж, тэднийг тайтгаруулж, тэднийг авардаг, энэ нь “юунаас ч үл айхын өглөг” болно.

Үүнтэй адилаар, бид жинхэнэ өглөг үйлдье гэвэл амь хороохгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, худал ярихгүй, архи уухгүй гэх таван сахилыг сахих хэрэгтэй. Үүний дотор зөвхөн амь хороохгүйн сахил л жаахан төвөгтэй, бусад дөрвөн сахил нь тийм ч бэрх биш. Амь

хорооход шууд амь хороох болон шууд бусаар амь хороох багтдаг. Шууд амь хороох нь бид өөрсдөө амьтны амь тасалж идэхийг хэлнэ, шууд бусаар амь хороох гэдэг нь өөр хүн амьтан алаад бидэнд идүүлэхийг хэлнэ, гэхдээ бид идэх үедээ бас: “Сайхан амттай байна! Энэ бол дээд зэргийн үхрийн мах юм байна, үнэ нь ч бас боломжийн юм” хэмээн ярих нь шууд бусаар амь хороож байгаа бөгөөд амь хороохыг хараад даган баясах байдалд хамаарна.

Багш чинь өөрийгөө том бясалгагч гэж бодоод та нарыг сурган цээрлүүлж байгаа юм биш, надад тийм бодол байхгүй, харин та нарт лавлагаа болгож л ярьсан хэрэг. Бид үргэлж өөрсдийнхөө уг чанараа сөрсөн үйл хэрэг хийдэг хэдий ч өөрсдөө харин мэддэггүй, учир нь энэ ертөнцийн дадал зуршилд дэндүү их бохирдсон болохоор үүнийгээ харж чаддаггүй бөгөөд тодорхой ойлгодоггүй. Жишээ нь, цэргийн хүн ажлын газартаа ургамал хоол идэхэд хялбар биш, сурагч хүн ч гэсэн ургамал хоол идэх гэвэл багш нь зөвшөөрдөггүй. Хүүхэд ургамал хоол идэх гэхэд аав, ээж нь зөвшөөрөхгүй. Эхнэр нь ургамал хоол идэх гэхэд эр нөхөр нь загнадаг, эр нөхөр нь ургамал хоол идэх гэвэл эхнэр нь ээсгүүцэж, түүнд ургамал хоол хийж өгдөггүй, өөрөөр нь хийлгэх гэхэд эр нөхөр нь ургамал хоол хийж чадахгүй болохоор өлсөхийн эрхээр аргагүй дахиад л мах идчихдэг. Зарим хүүхэд мах идэх дургүй байхад ахмадууд нь мах идэхгүй бол шим тэжээл дутагдаж, бие нь өсөхгүй болно гэж санаа зовсноосоо болж албаар мах идүүлдэг.

Гэхдээ бид заан, усны үхэр, анааш, үхэр, морь зэрэг амьтан бүгд л ургамал хоолтон гэдгийг мартчихжээ. Үхэр өвс идээд тийм том биетэй болдог бөгөөд дараа нь бид алаад идчихдэг. Туулай ч гэсэн ургамал хоолтон, улаан лууван, цагаан лууван, ногоо иддэг ч харин хөөрхөн сайхан бөгөөд бондгор тарган, дугариг, гялалзсан нүдтэй, ийм хөөрхөн амьтныг бид харин алаад идчихдэг. Гэхдээ ийнхүү идэх нь бүгд л дам байдлаар уургаа нөхөж байгаа хэрэг бөгөөд тахиа, хонь, гахай зэрэг амьтны махыг идэх нь бүгд л сэг идэж байгаатай адил юм. Тиймээс амь хороохгүй байх нь хамгийн чухал, амь хороож болохгүй гэдэг энэ сахилыг маш тодорхой сахиж байж л Авид Бурхантай уулзаж чадна, хамгийн дээд номын аргыг сонсож чадна, жинхэнэ бясалгалын аргыг суралцах тохиолтой болж чадна.

Өөрсдөө сахилаа чанд сахихгүй, буян хангалттай биш бол мэдээж Авид Бурхантай уулзаж чадахгүй. Энэ нь бурхан бодьсадва нигүүлсэх сэтгэлгүй гэсэн үг биш, харин Амийг маань өршөөгөөч!, Өвчин зовлонгоос авраач!, Амар мэнд амьдруулж, гай баридаас зайлуулаач! гэж бид Арьяабал бурханд байнга даатгадаг боловч өдөр болгон амьтны амийг ихээр хороодог бол бурхан бодьсадвагийн өршөөл нь тэр төрөлтнүүдийн хувьд шударга бус болчих биш үү? Биднийг аврах нь биднээр тэр төрөлтнүүдийн амийг хороолгож байгаа хэрэг болно. Амьтад ч гэсэн Арьяабал Бурханд хандаж, Хүн төрөлтний гараас амийг минь авраач! гэж даатгавал Арьяабал Бурхан чухам алийг нь аврах юм бэ? Амьтдыг аврах уу?, биднийг аврах уу?

Маш олон үхэр, хонь, тахиа, гахай Арьяабал Бурхнаас байнга

аврал гуйна, амь хөнөөдөг хүмүүс бас Арьяабал Бурханд даатгана, тэд өдөр бүр Арьяабал Бурханыг тахиж, мах зардаг наймаа маань сайн болоосой гэж гуйна, тиймээс Арьяабал Бурхан чухам алинд нь туслах билээ? Нэг талд нь мах худалддаг хүн, нөгөө талд нь хөөрхий амьтад даатгаж байгаа, амьтад шинэхэн цэцгээр тахиж чадахгүй ч сэтгэлээрээ тахиж, чин сэтгэлээсээ даатгаж байгаа юм чинь Арьяабал Бурхан явал зохилтой билээ? Яг л дайтаж байгаа хоёр улс хоёулаа л дайнд ялахын төлөө Арьяабал Бурханд даатгадагтай адил, ингэснээр Арьяабал Бурханы тархи толгойг төөрөгдүүлж, Тэр чухам яахаа мэдэхээ больчих биш үү?

Таван сахилын нөгөө дөрвөн сахил нь бас тийм ч хэцүү биш, хулгай хийхгүй, худал ярихгүй, садар самуун явахгүй, архи уухгүй зэрэг нь бүгд л хүн бологсдын мөрдвөл зохилтой зүйл мөн бөгөөд улсын хууль дүрэмд ч бас ингэж тогтоосон байдаг. Тиймээс таван сахил гэхээр бас сахил гэмээр зүйл байхгүй, бид мартчихсан болохоор л сахил болж хувирчээ. Бага сургуульд сурч байх үеэс л багш маань бас бидэнд хулгайлж болохгүй, худал ярьж болохгүй гэж сургадаг, харин Бурхан Багш бидэнд хулгайлж болохгүй гэж ярихлаар л бид хулгай хийхгүй байдаг юм биш. Бид бусдад мөнгөө хулгайлуулах дургүй байдаг юм чинь мэдээж бусдын мөнгийг хулгайлж болохгүй. Садар самуун явахгүй гэдэг нь мөн л ийм, ганцхан эр нөхөртэй, эсвэл ганцхан эхнэртэй байх хэрэгтэй гэж улсын хуулинд аль хэдийн тун тодорхой тогтоосон байдаг. Тэгвэл архи ууж болохгүй гэдэг нь архи уувал бидний бие махбодод муугаар нөлөөлж, толгой тархийг мунхруулдаг гэдгийг бид бүгд сайн мэднэ, тиймээс сахил гэмээр зүйлгүй. Таван сахил нь зөвхөн бясалгалын талын тусламж мөн, харин сахил биш. Тиймээс үнэн хэрэгтээ сахил гэмээр зүйл байхгүй.

Таван сахилын дотор зөвхөн “амь хороохгүй”-н сахилыг л сахих нь нилээд хэцүү, үнэндээ угаас амь хороож болдоггүй, гэвч хичнээн эрин галваас нааш бид үүнийг аль хэдийн мартчихсан болохоор ургамал хоолтон болох, махан хоолтон байх нь нэгэн том асуудал болж, амь хороож болохгүй гэдэг нь нэгэн маш чухал сахил болж хувирчээ. Та нар одоогоор ургамал хоол идэхгүй, итгэхгүй, бясалгал хийхгүй бол бас хамаагүй, яарсны хэрэггүй, ном тайлахыг сонсоод ганц өнжөөд л билиг нээгдэн гэгээрэх боломжгүй. Гэвч багшийнхаа ном тайлахыг сонсох дуртай бол дахин ирж сонсоорой! Ургамал хоолтон болж бясалгал хийх эсэхээ дараа ярья! Яагаад гэвэл бид хувцас худалдан авахаасаа өмнө бас сайтар үзэж шинжиж, эхлээд тохиромжтой, тааламжтай, гоё сайхан эсэх зэрэг бүх талаар санаанд чинь нийцсэний дараа худалдан авдаг. Бясалгалын аргыг сонгоход ч гэсэн заавал хувцас худалдан авахтай адил нарийн хянамгай бөгөөд болгоомжтой байх хэрэгтэй.



## ХУВИЛГААН БИЕ ГЭДЭГ НЬ ТИЙМ Ч ГАЙХАЛТАЙ ЮМ БИШ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайвань (Формоса) Тайбэй хот  
(Эх нь хятад хэлээр)  
1986 оны 9 дүгээр сарын 24*

Хүний амьдрал гэдэг нь зөвхөн ганцхан төрөл байдаг юм биш, бидэнд тоолшгүй олон урьдын өнгөрсөн төрөл байдаг, тийм учраас гоц авьяаслаг хүүхэд дөнгөж дөрөв, таван нас хүрмэгц маш олон гайхалтай зүйлийг хийж чаддаг, энэ нь тэд урд төрлөө таг мартчихаагүйгээс болж байгаа хэрэг. Гэтэл ихэнх хүн харин өөрсдийнхөө урьдын төрлөө мартчихсан байдаг, гэвч та нар бясалгал хийсний дараа өөрсдийнхөө урьд төрлийн дурсамжаа эргэн санаж чадна. Жишээ нь, уулзалдалгүй гучин жил болсон багын найзтайгаа дахин уулзах үедээ бид нэг нэгнээ танихгүй байж мэднэ. Үүнтэй адил бид бас өөрсдийнхөө урьдын төрлөө санаж чаддаггүй, заримдаа урьд төрөлдөө бясалгал хийгээд ямар нэгэн дэсэд хүрсэн байлаа ч бид бас үүнийгээ мартчихдаг, одоо багштайгаа уулзсан байгаа нь та нар урд нь бясалгал хийж байсныг илтгэж байгаа хэрэг юм шүү. Гэвч урд нь бясалгал хийж байсан гэдэг нь одоо удахгүй Бурханы хутагт хүрнэ гэдгийг илэрхийлж чадахгүй, энэ нь та нарын бясалгалын тухай ойлголтын хэмжээ болон хувь хүний сэтгэл хэр шулуудсан байдлаас шалтгаална. Учир нь хүмүүс дорхноо туулан гэтэлж ч чаддаг, бас төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэж ч болно, энэ нь бүгд л өөрсдийн чинь сонголтоос хамаарна.

Бясалгал хийхэд маш олон зам мөр байдаг, зарим зам нь маш урт, зарим нь маш богино. Энэ нь яг л бид энэ дэлхий дээр байгаатай адилхан, энэ ном тайлах газраас багшийн чинь уулан дахь бясалгалын төв хүрэхэд хэрвээ дөт замаар явбал нэг, эсвэл хоёрхон цаг явахад хүрчихнэ, гэтэл бас хол замаар тойрвол бүтэн өдрөөр машинтай явж байж л хүрч очно, та нар аль ч замаар нь явж болно. Европын олон улс оронд хотын тойруу зам гэж байдаг, хэрвээ гарах гарцаа олохгүй бол уг замаар машинаа жолоодон тойруу замаар бүтэн өдөржингөө явж ч мэднэ. Бясалгал хийхэд ч мөн ийм байдаг, хэрвээ хамгийн төгс төгөлдөр бясалгалын аргыг хайж олохгүй бол энэ ертөнцөд нааш цааш ирж буцан үхэж, төрөх сансрын хүрдэнд байнга эргэлдэж, туулан гэтэлж чаддаггүй. Хүн бүрийн төрсний дараах нэг насны амьдралынх нь зурлага бараг тогтчихсон байдаг бөгөөд нас барсныхаа дараа дахин сансрын хүрдэнд эргэлдэж, дахин өөр нэг зүйлийн амьдралын зам мөр туулдаг, ингээд л

үргэлж өөр өөр амьдралын олон хэв маягийг үзэж туулах болдог.

Гэхдээ бас заавал үүрд мөнх ийм үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэх зовлонг амсах албагүй, хэрвээ туулан гэтлэхээр жинхэнээр зориг шулуудсан байвал нэг төрөл, эсвэл хоёр төрөлдөө үхэж, төрөх сансрын хүрднээс туулан гэтэлж чаддаг. Учир нь туулан гэтлэхийг чин сэтгэлээсээ хүсэж, эрж хайх юм бол нэгэн жинхэнэ Их Багштай уулзах бөгөөд Тэрээр биднийг удирдан замчилснаар бид энэ ертөнцөөс салж оддог, гэхдээ бид өөрсдөө хүний ертөнцөд сэтгэл тагагдсаар байвал төрөл төрөлдөө эндээс салж чадахгүй. Яагаад Шагжамуни Бурхан, Есүс Христ, Зургаадугаар Өвгө Багш Хүй Нэн гэх мэтийн Их Багш нар хамаг төрөлтнийг аврахаар энэ ертөнцөд ирэх хэрэгтэй байдаг вэ? Учир нь хүний амьдралын аливаа бүхэн цөм өөрчлөхийн аргагүй тогтчихсон байдаг биш бөгөөд хэрвээ бид дуртай бол бас өөрчилж болдог, харин үүний тулд бидэнд заавал маш хүчтэй няцашгүй зориг байх хэрэгтэй. Бидэнд чөлөөт хүсэл зорго (Free Will) байдаг болохоор тэр хуулийг өөрчлөх эсэх нь бүгд л биднээс өөрсдөөс маань шалтгаална.

Урд нэг хүн дөнгөж цэрэг болсон өдрөө нэгэн цэргийн ахмадын туслахаар томилогджээ. Энэ цэргийн дарга маш ширүүн зантай, доорх хүмүүстээ тун хатуу ханддаг бөгөөд түүний “төмөр мэт хатуу тушаал”-ыг хумсын чинээхэн ч зөрчиж болдоггүй ажээ. Цэрэг хүн угаас тушаал зааврыг “журамлан дагах” үүрэгтэй байдаг.

Нэг өдөр энэ ахмад өнөөх цэргээр байшингаа будуулжээ, будаж дууссаных нь дараа багсаа цэвэрлүүлэх гэтэл цэвэрлэх алчуур олдсонгүй. Ахмад өнөө цэргийг өөр цэргүүдийн хувцсаа тавьдаг газар очиж, аль нэг цэргийн хувцсыг авчраад багсыг арчин цэвэрлэ гэхэд нь өнөө цэрэг ингэхийг хүсээгүй тул яах учраа олохгүй арга нь барагджээ. Учир нь тэрээр даргынхаа тушаалыг дагавал заавал бусдын хувцсыг хулгайлж, алчуур болгох хэрэгтэй, гэтэл бусдын юмыг хулгайлаад мэдэгдчихвэл хууль зөрчсөн хэрэг болно, даргынхаа үгийг дагахгүй бол мөн л цэргийн дүрэм журмыг зөрчсөн явдал болно.

Өнөөх цэргийн сэтгэл баахан зөрчилдсөний эцэст бусдын хувцсыг хулгайлахгүйгээр шийдэж, даргадаа хандан эрс шийдэмгийгээр “Би явахгүй” гэж хэлжээ. Даргынхаа тушаалыг сөрж зүрхэлсэнд нь ахмад ихэд гайхан цочиж “Чи яагаад явахгүй гэж байгаа юм?” гэж асуусанд өнөөх цэрэг юу ч хэлсэнгүй, харин эрс шийдэмгий харцаар дарга луугаа харан би яасан ч бусдын юмыг хулгайлахгүй гэсэн төрх байдал харуулжээ. Ингэснээр ахмад нь өнөөх цэрэг аль хэдийн сэтгэл шулуудсаныг ойлгосон болохоор юу ч хэлж чадсангүй. Тиймээс бусдын хүндэтгэлийг олъё гэвэл эрхбиш эхлээд бусдын хүндэтгэлийг олж чадах хандлагатай байх хэрэгтэй, өөрөө өөрийгөө хүндэлж чадвал бусад хүн аяндаа чамайг хүндлэх болно. Цэргийн хууль дүрэмд бас бусдын юмыг хулгайлж болохгүй гэж заасан байдаг болохоор өнөөх цэрэг дүрмээ яасан ч зөрчиж болохгүй гэж эрс шийджээ. Гэтэл түүний хувьд тухайн үед ийм шийдвэр гаргах нь амаргүй байсан байж таарна, учир нь цэрэг хүний үүрэг хариуцлага бол тушаал зааврыг “журамлан дагах” явдал болно, тиймээс түүний “ёс суртахууны үзэл бодол” нь түүнийг зүй

зохистой, баатар зоригтой шийдвэр гаргуулжээ.

Хүмүүс чөлөөт хүсэл зорготой байдаг бөгөөд юу хийхээ өөрсдөө сонгож болно. Тиймээс диваажин болон тамын орныг бүгдийг бид өөрсдөө л бүтээсэн байдаг, хэн ч биднийг хүчээр хийлгэж чадахгүй. Хэрвээ билиг нээгдээгүй хүний үгийг дагаж юу л гэвэл түүнийг нь биелүүлбэл бусдын хүндэтгэлийг хүлээж чадахгүй, учир нь бид бие даасан санаа бодол, хүсэл зоргоор дутаж байгаа хэрэг юм.

Бясалгал хийж, туулан гэтлэхэд мөн л адилхан, заавал өөрсдөө хайх хэрэгтэй, Эзэн Бурхан бидэнд тусалж чадахгүй, Бурхан багш ч гэсэн туслахын аргагүй, хэрвээ тусалж чаддагсан бол Шагжамуни Бурхан ганц төрөлдөө, эсвэл Есүс Христ ганц удаа энэ ертөнцөд ирээд л хамаг төрөлтийг бүгдийг нь гэтэлгэчих байсан, тийм байтал одоо болтол яагаад ийм олон хүн мөн л туулан гэтэлж чадаагүй байна вэ? Учир нь хамаг төрөлтөн заавал өөрсдөө хүсэн даатгах хэрэгтэй, заавал өөрийн зам мөрөө өөрөө хайх хэрэгтэй, харин бусад хүн түүний өмнөөс хийх боломжгүй. Их Багш нар бусдыг хүчээр бясалгуулж болохгүй, Тэд Үнэн ёсыг бусдад ярьж болно, хүмүүс сонссоныхоо дараа сурах дуртай бол ирж болно, үүнийг шүтэн дагах гэх юмуу, сахил хүртэх гэж хэлдэг. Гэхдээ заль мэх хэрэглэх, эсвэл наймаалцах хэлбэрээр бусдыг хүчээр бясалгуулж болохгүй, энэ нь шид хэрэглэхтэй адил тун муу хэрэг. Гэвч шидийн хүчийг бас бурханы хүч, эсвэл бүтээгчийн хүч гэж хэлж болно, учир нь хар, цагаан шидийн аль нь ч бай, аливаа хүч нь бүгд л “хамгийн дээд” хүчнээс үүсэлтэй. Гэтэл энэхүү Хамгийн дээд бүтээгчийн хүч нь яагаад цагаан шид болж хувирдаг, бас хар шид болж хувирдаг вэ гэвэл бид хар сэтгэлтэй байх үед хар шид болон хувирч, цэвэр ариун сэтгэлтэй байх үед цагаан шид болж хувирдаг. Тиймээс хамгийн дээд бясалгалын аргыг сургахдаа заавал ном уламжлах хэрэгтэй бөгөөд шавь нараа удирдан жолоодох хэрэгтэй, тэгэхгүй бол гэд түүнийг муу зүйлд ашиглаж мэднэ, тэгвэл эргээд өөрсдийгөө хордуулж, бясалгахын зэрэгцээ гадуур гарч очин зөн билгээ хэтрүүлэн ярина, ингэснээр цаашдаа буруу номтны зам руу явж, эцэс сүүлд нь ад шүглэсэн байдалд орох болно.

Ад шүглэх шалтгаан нь зөвхөн үүнээс ч болдог юм биш, үүнээс өөр нөхцөл байдлаас шалтгаалдаг талаар би дараа ярья. Бусдыг дураараа сургаж болохгүй гэж би өчигдөр та нарт ярьсан, ингэж ярьсан нь та нарыг бусдад бүү тусал гэсэн үг биш, гэхдээ багшийн чинь сургах болон та нарын сургах нь адилгүй, энэ бясалгалын аргыг бусдад сургаж байгааг харахад тун хялбар хэрэг шиг байдаг ч үнэн хэрэгтээ өчүүхэн ч хялбар биш. Бясалгалын аргыг сургах нь зөвхөн эхлэлтийн зам төдий, дараа нь бас тун олон бэрхшээл төвөгтэй үйл хэрэг байдаг, та өөрөө асуудалгүй гэх нь өөр хүн бас асуудалгүй гэдгийг илэрхийлж байгаа хэрэг биш. Бусдыг сургахдаа анхан шатны А.Б.В-гээс эхлэн сургах хэрэгтэй, тэгээд төгстөл нь нэг нэг алхмаар заан сургаж, удирдан замчлах хэрэгтэй, гэхдээ хамаг төрөлтнийг зөвхөн энэ ертөнцөд л заан сургах төдийгүй мөн өөр бусад, бүр өндөр төвшинд хүрвэл тэнд ч адилхан заан сургаж болдог.

Багш болох гэдэг нь та нарын харж байгаа шиг тийм хялбар хэрэг

биш. Та нарын дунд байгаа зарим хүн багшийн ажилтай, тэгээд шинээр ирсэн хүмүүст багш нь бурхныг дурсахыг заахдаа сэтгэлээ магнайн голдоо байлга гэж сургахыг хараад тэд бас тэгж заадаг, гэтэл ингэж заах болон багшийн заах хоёр яахин адил байх билээ? Багш чинь бусдыг сургавал эрхбиш тэдэнтэй харилцаж, бясалгалаар ямар байсан ч бүгдэд нь тусална. Харин та нарын бусдад заах нь үүнтэй адилгүй, учир нь тэд багшийн ном тайлахыг сонсохоор ирээгүй, багшийн шууд адислалыг хүртээгүй бөгөөд бясалгалын тухай ойлголт ухагдахуун байхгүй, Яах гэж бясалгаж суудаг вэ?, Юунд бурханыг дурсах вэ? гэдгийг бүр ч ойлгохгүй, тэгээд бас ёс суртахууны тухай ойлголт байхгүй байж ч магад, тиймээс тэдэнд ярьсан ч ач тусгүй, хожим бага зэрэг зөн билигтэй болох юмуу ямар нэгэн чадвартай болбол тун муу хэрэг үйлдэж мэднэ.

Үүнээс гадна бас багшийн удирдан дагуулал байхгүй бол өндөр дээд төвшинд хүрсний дараа буцаж ирэхийн аргагүй болно, өөр бясалгалын аргаар бясалгахад мөн л ийм байдаг. Жишээ нь: энд бол бидний ертөнц, тэнд очсон ч мөн л бидний ертөнц байна. Эндээс бид энэ ертөнцийн зах хязгаарыг харж чадахгүй, мөн өөр өндөр дээд төвшинд хүрэх үед тэндхийн хаалгыг харж чадахгүй байж ч магад, тэгээд нилээд өндөр дээд төвшинд хүрсний дараа өөрийгөө харгалзаж чадахгүй бол махан биедээ буцан ирж чадахгүй болчихож мэднэ, ирлээ ч багшийн харгалзлал болон заавар жолоодлогогүй бол өөрийн олсон хүчээ өөрөө хүлцэн тэсвэрлэж чадахгүй. Энэ хүчийг зохистой эзэмдэж чадахгүй бол бясалгал тань танд муугаар нөлөөлж, бие махбод тань тавгүйрхэж, мэдрэлийн өвчтэй болох, саад бэрхшээлд ороогдох гэх мэтийн зүйл болж, ад шүглэх, эсвэл солиорох байдалд орно, энэ нь өөрсдөө сайн бясалгаагүй, нэгэн багшийг дагаж бясалгаагүй юмуу, жинхэнэ хүчтэй багшийн заавар жолоодоогүйгээс болдог.

Бясалгал хийх өөр өөр арга байдаг, бидний бясалгалын аргын тухайд би их яримааргүй байна, зөвхөн та нарт бидний бясалгалын аргаар бясалгавал хорин дөрвөн цагаар бясалгасан ч асуудал үүсэхгүй гэж л хэлье. Гэтэл өөр бясалгалын арга нь үүнтэй адилгүй, илүүхэн шиг бясалгавал солиорч мэднэ, яагаад гэвэл нөхцөл байдлыг хэрхэн шийдвэрлэхээ мэддэггүй бөгөөд дэндүү их бясалгасны дараа бясалгалын хүч нэмэгдэх үед жинхэнэ багшийн заавар жолоодлогогүй бол энэ хүчийг яаж эзэмдэхээ мэддэггүй.

Бурханы хүч, эсвэл бүтээгчийн хүч нь сайн хүнд илүү хандаж, муу хүнийг тоохгүй байдаг юм биш, бүтээгчийн хүч нь “төвийг сахидаг”, сайн, мууг хүмүүс өөрсдөө зохион бүтээдэг, бид сайнаар ашиглавал сайн болж хувирна, муугаар ашиглавал бас муу болж хувирч болдог. Тиймээс тэр бол төвийг маш чанга барьдаг болохоор таны өмнөөс тэр хүчийг эзэмдэн жолооддоггүй, харин та заавал өөрөө хянах хэрэгтэй, эсвэл багш чинь таныг адислах юмуу, энэ хүчийг хянаж байх ёстой. Бясалгахдаа дэндүү их ахуй ойлголттой болохыг хүсэж болохгүй, цаг нь болохоор аяндаа ахуй ойлголттой болно, ахуй ойлголт хэт их, бясалгалын хүч дэндүү хүчтэй болбол яаж ашиглахаа өөрөө мэдэхгүй болохоор саад бэрхшээлтэй болно.

Нэгэн сайн багш бол шавиа яаж харж харгалзахаа мэдэж, шавьдаа тусалж, энэ хүчийг тохиромжтой хэмжээнд барьж хянаж байдаг, учир нь энэ хүчний хэлбэлзэл дэндүү хүчтэй болвол хүний мэдрэлийг гэмтээж, өвчтэй хүн шиг болгон солиоруулна, эсвэл тэр хүнд мэдрэл нь муудах байдал илэрнэ. Тиймээс бясалгагч хүн дэндүү их ахуй ойлголттой болоход шунаж болохгүй, алгуур аажмаар бясалгаж бага зэрэг ахуй ойлголттой байвал болчихно, харин ганц удаад бүхнийг олохыг санаархаж болохгүй, учир нь хүн болгоны нөхцөл байдал адилгүй, зарим хүн энэ хүчийг хэрэглэж болдог, зарим хүн болдоггүй.

Би сонин уншиж байхдаа үргэлж л зөн билиг, шид увдисын тухай сурталчилгаа байхыг хардаг, гэтэл маш олон хүн тэр номын багш нар дээр очдог байна. Тэнд очсоноороо энэ хүмүүс харш саадтай болж мэдэх юм. Зөн билгийг хайх хэрэг юу билээ? Маш олон хүн солиорч, ад шүглэх байдалд орсон нь бүгд л зөн билгээс болдог юм. Зөн билиг хайх бодол төрөх үед л аль хэдийн эхэлж, зөн билигт шунах бодол орчихсон байдаг, зөн билиг нь “хамгийн дээд хүчин”-ээс үүсэлтэй биш, харин бидний толгой тархинаас үүсэлтэй, энэ нь бид нилээд доогуур дэсийн ид шидийн хүчийг ашиглахыг бодлогоос болдог. Зөн билиг нь муу биш, гэвч бас төгс төгөлдөр биш, бясалгалтан хэрвээ билиг ухаан болон хүч чадлаар хангалтгүй бол ид шидийг чадамгай ашиглаж чадахгүй, эсрэгээрээ замаа алдаж, бясалгал нь зөн билгийн төвшинд зогсонгиширч дэвшиж чадахаа больдог.

Тиймээс бусдад бясалгал заах нь бүгд сайн гэсэн үг биш юм. Бид нигүүлсэнгүй сэтгэлтэй байх нь буруу биш, гэвч нигүүлсэнгүй сэтгэл болон билиг ухаан хоёр заавал хамт уялдаж байх ёстой. Нэг хүн тун нигүүлсэнгүй, бусдад туслах дуртай байсан ч хүмүүст өөрийнхөө санаагаар эм уулгавал бусдыг хордуулахаар барахгүй бас өөрийгөө ч хордуулна. Жишээ нь: эр нөхөр нь эмч хэдий ч та өөрөө эмийн тухай сайн ойлголтгүй байтлаа харин бусдын толгой өвдөх юмуу, өвчилснийг хараад даруй эм өгч уулгадаг. Хэрвээ өгсөн эм чинь хортой эм байвал яах вэ? Эм нь хэдийгээр өвчинд тустай боловч буруу эм уувал харин төвөг болно.

Эр нөхөр нь эмч, аль эм нь ямар өвчинд тустай гэдгийг сайн мэддэг хэдий ч та өөрөө эмнэлгийн тухай мэдлэггүй юм чинь бусдын өвчнийг яахин эмчилж чадах вэ? Эм болгоны үйлдэл хэрэгцээ нь өөр өөр, толгой өвдөх, гэдэс өвдөх зэргийг бүгд өөр өөр эмээр эмчилдэг, тэр ч байтугай толгой өвдөх, гэдэс өвдөхийн шалтгаан нь тун олон янз, харин өвчин болгоныг адилхан эмээр эмнэдэггүй. Бясалгалын тухайд нөхцөл байдал мөн л ийм байдаг. Бясалгахад эрхбиш хичээн болгоомжлох хэрэгтэй, багшийнхаа бусдад ингэж заахыг хараад дуурайж санаан зоргоор хүмүүст заах нь бусдыг хорлож байгаа хэрэг бөгөөд бусдад төвөг болдог төдийгүй өөртөө ч төвөг удаж, муу үйлийн үр үүсгэнэ.

Буддын шашны ном сударт тэмдэглэсэнээр Шагжамуни Бурхан “Гуйхгүй бол ном айлдах хэрэггүй” гэжээ. Бусдын үзэл ухамсарт хэн ч гэсэн хөндлөнгөөс оролцох эрхгүй, бясалгал хийх, хийхгүйг албадаж болохгүй, үгүй бол бусдын жам ёсны хувьслын журам

горимыг алдагдуулна. Эхлээд бид түүнд юуны учир заавал бясалгал хийх хэрэгтэй вэ?, яагаад энэ аргаар бясалгаж, тэр бясалгалын аргаар бясалгах хэрэггүй вэ? гэдгийг тайлбарлан ярьж өгч болно, тэгээд тэрээр сургаал ёсыг сонсоод дуртай хүлээн зөвшөөрвөл түүнд ном уламжилж болно. Харин энэ бясалгалын арга сайн гэх учир шалтгаанаас үүдэн бусдын дуртай эсэхийг хайхралгүй өөрийн санаан зоргоор зааж яасан ч болохгүй.

Багш нь ч гэсэн бусдыг хүчээр энэ бясалгалын аргад итгүүлж болохгүй, багшийн чинь ном тайлахыг хүмүүс ахин дахин сонсохоор ирэхэд би тун дуртай, тэд дараа нь сурах эсэхээ өөрсдөө сонгож болно, хэрвэ багшийн чинь сургаал ёсыг тун сайн гэж үзээд багшаас нь сурах хүсэлтэй бол багш чинь баярлан угтана. Гэтэл өөрөө дуртайяа сонгож, сурахаар шийдсэн байлаа ч дараа нь больчихож мэднэ. Яагаад ингэж хувирдаг вэ? Учир нь нэгэн эгэл хүн учраас түүнд сурах хүсэл дөнгөж төрсөн, эсвэл тэрээр чин сэтгэлээсээ биш, дэсээр ч өндөр биш болохоор түүнд багшийн сургаал ёсонд ихэд эргэлзэх сэтгэл төрдөг, Төгс Гэгээрсэн Их Багштай уулзсан ч бас л итгэхгүй байдаг.

Ихэнх хүн бүгд л зөвхөн эрт дээр үед л Их Багш илрэн гардаг байсан гэж итгэдэг, тэгээд Хүй Нэн Багшийн нэрийг сонсмогц тэр бол нэгэн гүн билиг ухаантай Төгс Гэгээрсэн Их Багш гэж даруй итгэж, Бодьдармаа гэж сонсонгуут дорхноо тэр бол эрт дээр үеийн хамгийн сүрхий Их Номын Багш мөн гэж үздэг. Хүмүүс Шагжамуни Бурхан бурханы хутагт хүрсний дараа үлэмж их зөн билигтэй болж, үүрд мөнх чөлөөлөгдөж, шавь нар нь ч гэсэн бүгд мөрийн хутгийг олж, туулан гэтэлжээ гэж гүн итгэдэг бөгөөд Есүс Христ бол Их Бодьсадва, Ертөнцийг аврагч мөн гэж итгэдэг, гэтэл харин энэ мэтийн Төгс Гэгээрсэн Их Багш одоо цагт байдаг гэдэгт итгэдэггүй, Есүс Христ энэ ертөнцөд дахин мэндэллээ ч түүнд тийм ч хялбар итгэхгүй.

Хоёр мянган жилийн өмнө Төгс Гэгээрсэн Их Багш байсан юм бол одоо яагаад байж болохгүй билээ? Энэ нь бүгд л өнөө үед юм бүхнийг доорд үзэж, эрт дээр үеийг шүтэн дээдэлдэг сэтгэлгээнээс болжээ, бид өөрсдийн санаандаа төсөөлөн Хүй Нэн Их Багш бясалгалаар ямаршуухан байсан, дүр байдал нь хэр их сүр жавхлантай харагдаж байв, Шагжамуни Бурхан ямар ямар зөн билигтэй байж, зөн билгээ хэрхэн гарган илрүүлж байсан, мөн хэр их хүч чадалтай байсан бол гэхчилэн боддог. Гэтэл судар номд тэмдэглэснээр Шагжамуни Бурхан байнга хувилгаан биеэр өөр өөр оронд илэрч, шавь нараа гэтэлгэдэг гэсэн байна. Жишээ нь, тэр ямар нэгэн оронд ном тайлж байх үеэр шавь нь өөр нэгэн газарт асуудалтай болоод Түүнээс аврал гуйвал шавь нь мөн л багшийгаа харж чаддаг байж, энэ нь бидний ярьдаг “хувилгаан бие” мөн бөгөөд Бурхан Багш хувилгаан биеэрээ шавийнхаа байгаа газарт хүрч гэтэлгэсэн байна.

“Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй судар”-т тэмдэглэснээр нэгэн хааны хатан шоронд хоригдож байхдаа Бурхан Багшаас аврал гуйсанд Бурхан Багш хувилгаан биеэр шоронд очин түүнд ном тайлж сонсгосон гэдэг. Энэ нь Шагжамуни Бурхан махан биеэрээ шоронд очин

ном тайлсан юмуу гэвэл тийм биш, харин хувилгаан биеэрээ очсон хэрэг. Гэтэл багш нь хувилгаан биеэр ямар нэгэн газарт очиж, хэн нэгийг сургасныг сонсвол харин багшийг чинь ад, буруу номтон юм байна, тийм биш бол яагаад хувилгаан биетэй байж чадах вэ гэж сэжиглэдэг.

Тэдэнд яагаад тийм сэжиг төрдгийг би ойлгохгүй байна, хувилгаан бие гэдэг нь угаасаа тун энгийн хэрэг, тийм ч гайхалтай зүйл биш, хувилгаан бие нь энэ биеийн маань хувилсан байдал л юм. Гэтэл өөр бусад номын багш нар биеэ хувилж чаддаггүй учир шалтгааны улмаас багшийг чинь бас биеэ хувилж чадахгүй гэж ярьж болохгүй. Та нарын дотор бага сургууль, дунд сургуулийн багш нар их байна, энэ нь багш хүн зөвхөн бага сургууль, дунд сургуульд л багшилж чадахаас биш, их сургуулийн профессор болж чадахгүй гэдгийг илэрхийлж байгаа юм биш юм. Тиймээс ийм сэжиг төрөх хандлага нь тун мунхаг хэрэг болно.

Зөвхөн гэрээс гараагүй сүсэгтнүүд л ингэж шүүмжилдэг төдийгүй гэрээс гарагчид хүртэл мөн л дэмий ярьж, бусдыг гүтгэдэг, өөрсдөө биеэ хувилж чадахгүй болохоор өөр хүн биеэ хувилж чадна гэдэгт итгэдэггүй. Энэ хүмүүс Шагжамуни Бурхан үй түмэн хувилгаан биетэй, Есүс Христ, Хүй Нэн зэрэг Их Багш нар бас хувилгаан биетэй болж чадна гэдэгт итгэдэг, зөвхөн эртний хүмүүс л хувилгаан биетэй болж чаддаг, орчин үеийн хүмүүс чадахгүй гэж үздэг нь үнэхээр сонин байна.

Гэхдээ бүгд л адилхан хүний төрөлтөн, урьдын хүмүүс идэх, өмсөх, явах, суух, талаараа орчин үеийн хүмүүсээс ямар ялгаатай байсан бэ? Цорын ганц ялгаа нь гэвэл урьдын хүмүүсийн амьдрал одоогийнх шиг ийм тав тухтай биш байсан төдий л байх. Хэрэв урд нь Шагжамуни Бурхан үй түмэн хувилгаан биетэй болж чаддаг байсан юм бол одоогийн Төгс Гэгээрсэн Их Багш ч тэгж чадна. Урьдын хүмүүст зурагт, онгоц гэж байгаагүй, гэтэл орчин үеийн хүмүүс юугаар ч дутахгүй байгаа ийм нөхцөл байдалд Шагжамуни Бурханы хийж чадсан зүйлсийг одоогийн Төгс Гэгээрсэн Их Багш ч мэдээж хийж чадна.

Хэн нэгэн хүн хувилгаан биеэрээ ямар нэгэн газарт хүрч хүмүүсийг сургаж чаддаг гэдгийг сонсоод юундаа ухаангүй айж, тэр бол ад, буруу номтон гэж үзэн түүнээс бүү суралц гэж ярьдаг юм бэ? Бурхнаас суралцдаг хүн мөртлөө яагаад ийм эмзэг бодолтой байдаг юм бэ? Сэтгэл нь зөв бөгөөд маш цэвэр ариун бол ад чөтгөрөөс эмээх хэрэг юу билээ? Шагжамуни Бурхан ад чөтгөрөөс айдаггүй байхад бурхны шавь нар юундаа айж болох билээ? Ийм хүмүүст Шагжамуни Бурханы шавь болох эрх байхгүй, нэгэн нэр хүндтэй номын багш болох эрх байхгүй. Тэд хэдийгээр шар, улаан өнгөтэй элбэг орхимж биедээ өмсдөг хэдий ч сэтгэл нь харин бас олон зүйлд баригдаж, саад тотгороор дүүрэн байдаг.

Бидний бясалгаж байгаа нь угаас жинхэнэ номын арга бөгөөд тийм ч нууцлаг зүйл биш. Багшид нь ад чөтгөр шиг хоёр том соёо ургасан байна уу? Ад чөтгөр шиг харагдаж байна уу? Ургасан байлаа ч багш шиг чинь ийм ад чөтгөр байвал тун хөөрхөн биш үү? (Бүгд инээлдэв), ийм чөтгөр хүнийг хаздаггүй, тийм ийм номын багш бол чөтгөр мөн, ад мөн гэх мэтийн үг хэлээр бусдыг гүтгэдэггүй, ерөөсөө ингэж ярьдаггүй. Та нар багшаасаа айдаг уу? (Багш таныг хүндлэх сэтгэл дүүрэн байхад юунд

айх вэ гэж тайзны доор суугаа нэг шавь хариулав.) Та нар багшийгаа дагаж удтал бясалгасан ч ерөөсөө ад шүглээгүй байна, энэ бол хамгийн сайн гэрч нотолгоо мөн.

Бидний бясалгалын арга бол бусад аргаас өөр, хэдий чинээ удаан бясалгаж суувал төдий чинээ сайн, хэдий чинээ их бясалгавал төдий чинээ сайн, гэтэл өөр бясалгалын арга бол дэндүү их бясалгавал асуудал үүсдэг, учир нь дэндүү их бясалгавал бясалгалын хүч нэмэгддэг, гэхдээ тэдэнд тэр бясалгалын хүчээ хянах систем байхгүйгээс бясалгалын хүчээ тохиромжтой хэмжээний дотор хязгаарлаж чадахгүй болохоор энэ хүчийг зөв оновчтой удирдан чиглүүлэхийн аргагүй байдаг. Арьяабалын бясалгалын аргад ийм асуудал яасан ч үүсэхгүй. Багш чинь өдөр бүр их бясалгаж суудаг, бясалгал хийгээд аль хэдийн олон жил болчихсон, гэтэл одоо болтол ухаан мэдрэл хэвийн байна, хэрэв та нар багшийгаа харахад ухаан мэдрэл нь гэмтсэн байвал багшдаа хэлж, даруй мэдрэлийн эмчид хүргэх хэрэгтэй. Тиймээс ямар ч бясалгалын аргаар бясалгасан өөрөө энэ замыг туулж, хангалттай туршлага хуримтуулж байж л сая бусдыг сургаж болно.

Саяхан ярьсан хувилгаан биеийн асуудал бол үнэндээ тун энгийн зүйл, тийм ч гайхалтай юм биш, хэрвээ бусдад ярьж боломгүй нууцлаг зүйл байсан бол Шагжамуни Бурханы өвлүүлж үлдээсэн тэр олон ном сударт яагаад тун олон гайхамшигт түүхийг өгүүлсэн байдаг вэ? Жишээ нь: Шагжамуни Бурхан ямар нэгэн газарт илэрсэн, бүр өндөр дээд төвшний диваажинд хүрч, ямар ямар судрыг айлдсан, хичнээн олон хүн гэрэл харж, тийм төвшинд хүрсэн гэхчилэн маш тодорхой тэмдэглэжээ. Ийм тэмдэглэл байхгүй бол өнөөдрийн буддын шашин байж чадахгүй бөгөөд Шагжамуни Бурхан тийм их зөн билигтэй байсныг мэдэх боломжгүй, бас түүний бясалгалын дэс хэр өндөр, шавь нарынх нь бясалгалын төвшин хэр зэрэг байсныг мэдэж чадахгүй билээ.

Тийм шүү! Зарим бодьсатва хүмүүсийг нууцаар гэтэлгэж, үүнийгээ бусдад мэдэгддэггүй, өөрийнх нь дэс хэр өндөр талаар ярьдаггүй, тэд маш цөөхөн хүнд л ном уламжилдаг бөгөөд өөр хүмүүст зааж болохгүй гэж тэдэнд захирдаг, энэ нь зарим бодьсатвагийн хүмүүсийг гэтэлгэх хариуцлага нь ийм байдгаас болж байгаа юм, тэд зөвхөн тавхан хүнд л ном уламжилж мэднэ, учир нь тэдний хамгийн гол ажил нь хамаг төрөлтөнд нууцаар туслах явдал байдаг. Гэтэл зарим бодьсатва бас махан биеэр илэрч, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг, тиймээс Шагжамуни Бурхан бурханы хутгийг олсны дараа хүмүүсийг илээр сургажээ, тэрээр сүм хийдэд ном тайлаагүй, харин олон нийтийн талбайд ном тайлжээ. Шагжамуни Бурханд өөрийн гэсэн сүм хийд ч байгаагүй, хожим нь нас ахиж, олон газарт хүрч очин ном тайлж чадахгүй болсны дараа гэрээс гараагүй шавь нар нь нэгэн битүүмжлэн сууж бясалгах газар, нэгэн дотооддоо төвлөрч суух газар байгуулж, Түүнийг шавь нарынх нь хамт суулгажээ. Гэхдээ тэд өдөр болгон ном гүрэм үйлдэх юмуу, бусдыг гэтэлгэхээр яваагүй, Шагжамуни Бурхан ч гэсэн шавь нартаа өдөр болгон ном гүрэм хийж байж л бурханы хутагт хүрч чадна гэж сургаагүй, Тэрээр зөвхөн хамаг төрөлтнийг илээр гэтэлгэсэн байна.



Багш чинь бас хамаг төрөлтнийг илээр гэтэлгэдэг, энэ нь нууцлаг зүйл биш, гэтэл зарим хүн багшаас чинь суралцаад дөнгөж нэг, эсвэл хоёр долоо хоног болмогц тэр даруй бусдыг сургадаг, энэ нь тун инээдтэй хэрэг шүү, өөрийгөө бүрэн сайн гэтэлгээгүй байж бусдыг гэтэлгэхийг санаархана, гэтэл олон жилээр суралцсан байлаа ч гэсэн бусдыг сургаж чадах эсэхийг нь мэдэхийн аргагүй байдаг.

Хүн болгон найман сар бясалгасны дараа Хүй Нэн шиг болчихдог биш, Шагжамуни Бурхан байтал бас зургаан жил хатуугаар бясалгаж байж л Бурханы хутагт хүрч чаджээ, Бодьдармаа бясалгал хийгээд амжилтанд хүрсний дараа мөн л хана луу харж есөн жил бясалган суужээ, Бай Жан номын багш бас олон жилээр бясалгасан, Шэньшиу гучин жил бясалгасан байтлаа амжилтанд хүрч чадаагүй, дэсээр мөн л Хүй Нэн багшаас доор байжээ. Гэхдээ энэ нь түүний билиг бага зэрэг ч гэсэн нээгдээгүй байсан гэдгийг илэрхийлж байгаа юм биш, зөвхөн тэрээр Хүй Нэн Их Багшаас дэсээр доор байжээ.

Тиймээс хүн болгон адилгүй. Та нар багшийгаа зургаан сар бясалгасны дараа Өвгө Багш маань: “Та одоо явж бусдыг сургаж болно” гэж хэлсэн гэдгийг сонсоод зургаан сар болсныхоо дараа мөн бусдыг сургадаг, тийм үү? “үгүй юү? (Бүгдээр инээлдэв.) Энэ нь тийм санаа биш шүү! Адилхан номын арга хэдий ч ном уламжилсан багшийн дэс нь адилгүй бол шавийнх нь олох хүч ч адилгүй байх болно, хоёр хүн нэгэн зэрэг авшиг хүртэх үед ч гэсэн дэс нь адилгүй байдаг, харин хүн болгон зургаан сар бясалгасны дараа багш шиг чинь олон газарт очин цаг завгүйгээр хүмүүсийг сургаж чадчихдаг юм биш. Хэдийгээр тун олон хүн багшид нь шавилаад өчнөөн жил болсон байтал зарим нь дөнгөж шавилаад удаагүй мөртлөө дэсээр тэднээс аль хэдийн давчихсан байдаг. Ийм байхад та нар хэнийг сургаж чадах билээ?

Бусдыг сургахад дэсээр заавал тэднээс өндөр байх ёстой бөгөөд тэд бясалгаж суух үед нь сүнс нь хаа очсон ч бүгдийг мэдэж чаддаг байх хэрэгтэй. Харин багш зургаан сар бясалгасны дараа Өвгө Багш нь түүнийг хамаг төрөлтнийг гэтэлгэхээр явуулсан болохоор: За! Би бясалгаад нэгэнт найман сар илүү болчихож, багшаас ч хоёр сар илүү бясалгачихжээ, тиймээс бас багш болж болно гэж бодож болохгүй. (Бүгд инээлдэв)

Нэгэн жинхэнэ багшийн удирдан дагуулал үгүй бол бясалгаж суух үеэр сүнс нь өөр нэгэн дэсэд хүрсний дараа дахин буцаж ирж чадахгүй болж ч мэднэ, энэ махан биедээ буцан ирж чадахгүйгээр барахгүй урьдын дэсээсээ унах болно, өөрөөр хэлбэл урьдынх шиг хэвийн байж чадахгүй, яагаад гэвэл тэр хүчтэй бага сага холбогдчихсон болохоор бясалгалын хүч нэмэгддэг хэдий ч өөрөө харин хэрхэн зохицуулахаа мэддэггүй, хэрвээ сайн багшийн харгалзаа үгүй бол ширүүн зантай бөгөөд амархан уурладаг болж, тэр ч байтугай солиорч мэднэ.

Урьд Энэтхэгт гурван хүүхэдтэй нэгэн бүсгүй байжээ, тэрээр нэгэн багшаас йогийн бясалгалд суралцаад хэсэг хугацаа болсны дараа дэс нь ч дээшилжээ, гэхдээ тэр бүсгүй Арьяабалын бясалгалын аргыг бясалгаагүй, харин Энэтхэгийн йогийн эрдмийг бясалгажээ, өнөө

бүсгүй хэсэг хугацаанд суралцсаны дараа бясалгаж суух үедээ сүнс нь диваажинд хүрч, тэндхийн жаргалыг эдлэн очих болгондоо тэндхийн жаргалд согтуураад буцаж ирэх дургүй болдог, буцаж ирсэн ч гурван хүүхдээ харахаар дургүй нь хүрнэ, учир нь дөнгөж бясалгаж суун диваажингийн жаргалыг эдлэхийг завдтал бяцхан хүүхэд нь: “Ээж ээ, ээж ээ! Би өлсөөд байна!” гэж үймүүлдэг болохоор аргагүйн эрхэнд баяр жаргалтай тэнгэрийн орноос унаж ирээд хоол хийж, хүүхэддээ идүүлэх хэрэг гардаг аж. Тиймээс тэр диваажинд үүрд мөнх амьдарч, энэ ертөнцөд дахин буцаж ирэхийг хүсэхээ больж, дур гутам гэрийн ажлыг бүр ч хиймээргүй санагдсан болохоор хүүхдүүддээ тун эгдүүцэж, гурван хүүхдээ бүгдийг нь алж орхижээ.

Ийм үр дүн бол маш аймшигтай, учир нь энэ бүсгүйн багшийнх нь заасан нь хамгийн дээд бясалгалын арга биш болохоор л золгүй хэрэг үүсжээ, энэ золгүй хэрэг үүссэний дараа багш нь дахин ном уламжлахаа больсон байна.

Бидний бясалгалын аргыг харахад тийм ч их зөн билиг байхгүй бөгөөд дорхноо үр дүнд хүрчихдэггүй юм шиг байдаг, үнэндээ ахуй ойлголт байдаггүй биш, зөвхөн та нар бүгдийг нь харж чаддаггүй л төдий, заримдаа багш нь та нарын өмнөөс ахуй ойлголтыг чинь хязгаарлаж, дэндүү их харуулах дургүй байдаг, дэндүү их харвал та нарт ач тусгүй, ахуй ойлголтоосоо гарч, гэр бүлдээ буцах дургүй болж мэднэ, тэр үедээ та нар дээд төвшинд үлдэж, чанагуух ертөнцийн баяр жаргалыг эдлэхийг л боддог.

Учир нь ийм баяр жаргалыг үг хэлээр дүрслэхийн аргагүй, эгэл хүний толгой тархиар төсөөлөн бодож бүр ч чадахгүй, та нар хэрвээ өөрийгөө хэн болохоо жинхэнээр нь мэдчихвэл амиа хорлож ч мэднэ, учир нь өөрсдийн сүнснийхээ эх нутагтаа түргэн буцахыг хүсэж, энэ тоост хорвоод дахин үлдэх дургүй болдог, тэр үед энэ ертөнцийн аливаа бүхэн бүгд л хуурмаг, мөнхийн бус, хань ижил, үр хүүхэд, эд хөрөнгө, ажил үйлс, нэр төр, ашиг олз чухал биш гэдгийг ойлгодог. Нэг хүн өөрийнхөө жинхэнэ дүрийг таньж, хэн болохоо мэдсэний дараа энэ хуурмаг ертөнцийг хүлцэн тэсвэрлэж чадахгүй болоод даруйхан эндээс зугтахыг хүсэж ч мэднэ.

Үүнээс гадна бас бидний сүнс дээгүүр төвшинд хүрээд буцаж ирсний дараа “амаа барьж” чадалгүй: “Би бол тийм тийм бодьсатва шүү! Та яагаад мэдэхгүй байна вэ? Би бол Очирваань Бурхан, Арьяабал Бурхан мөн, би бол лусын охин, би бол ханхүү” гэж хүмүүст сурталчилна, ингэвэл хүмүүст итгэл төрөхгүйгээр барахгүй чамайг солиотой болчихжээ хэмээн мэдрэлийн эмнэлэгт хүргэж, тэнд хориод өдөр болгон эм уулгаж тариа хийнэ. Ингэвэл харин солиорохгүй байхын аргагүй болно.

Тиймээс бясалгахад хэрвээ зөв аргаар бясалгахгүй бол тун аймаар хэрэг болно, яагаад гэвэл бид зарим үнэн бодит байдлыг харвал биеэ барьж чадалгүй ярьчих юмуу, маш олон гайхалтай зүйлийг хийдэг. Жишээ нь: зөн билиг хэрэглэж хүмүүсийг аврах юмуу, тэдний өвчнийг эмчилж засдаг, эсвэл бусдад: Та маргааш гэрээсээ гарч болохгүй, гарвал

амь насанд чинь аюултай гэх буюу Та маргааш сургуульдаа очиж болохгүй, очвол багш чинь чамайг зодно гэхчилэн ярьдаг. Иймэрхүү зөгнөл ярих нь бүх дэлхийн дэг журмыг замбараагүй болгоно, тиймээс хамаатан садан чинь таныг мэдрэлийн эмнэлэгт хүргэх дургүй байлаа ч засгийн газар чамайг хорих болно. Учир нь таны зөгнөн хэлсэн зүйлс улс орны хууль дүрэм болон нийгмийн эмх цэгцэд нөлөөлнө.

Энэ хүн бол танай урд төрлийн чинь дайсан байсан гэх юмуу, эсвэл эр нөхөр чинь чиний ах чинь мөн гэж ярих, эсвэл ээж чинь урд төрөлдөө мэгж гахай байсан гэж яривал хүмүүс сонсоод санаа сэтгэл нь тайван биш, эмзэг болно, ингэснээр тун олон төвөгтэй асуудал үүснэ. Бусдын урд төрөлдөө юу байсныг харах хүсэлтэй хүн байна уу? Зарим хүн диваажинд очих дургүй, харин багшаасаа тамын оронд дагуулж очихыг гуйдаг, тэгэхэд нь би: “Чамайг тамд дагуулж аваачих дургүй байна, диваажинд хүрч жаргал эдлэхгүй, харин тамд очиж юу хийх нь вэ?” гэсэн. Та нар тамд очлоо ч гэсэн тэндхийн төрөлтнүүдэд тусалж чадахгүй, зөвхөн тэдний зовлон эдлэхийг л харах төдий байх болно, энэ нь яг л нэг хүн театрт очин жүжиг үзэх үед түүнд жүжгийн доторх зовлонт хүмүүст туслах арга огт байдаггүйтэй адилхан юм, тиймээс тамд очих хэрэггүй.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш бодь мөрийг хараахан олоогүй байхдаа ирээдүйд ямар үр дүнд хүрэхээ урьдчилан мэдэж чаддаггүй, мэдэж чадвал бясалгал хийсний хэрэг юу билээ? Шагжамуни Бурхан угаас бодьсадвагийн хувилгаан, түүний ажил нь энэ ертөнцөд ирж, хамаг төрөлтнийг гэтэлгэх явдал юм. Гэтэл тэрээр гуч насалтлаа өөрийнхөө хэн гэдгийг огт мэдээгүй, тэгээд зургаан жил хагуужилтай бясалгаж, өдөр болгон бясалгаж суудаг бөгөөд унтчихаас эмээж хэвтэж ч зүрхлэхгүй, идэхдээ ч гэсэн тун бага иддэг байжээ. Хожим нь бодь модны доор дөчин есөн хоног бясалгаж суусны эцэст дотооддоо шөнийн гэрэлт оддыг хараад өөрийгөө хэн болохоо бүрмөсөн ойлгожээ.

Гэтэл энгийн хүмүүс өөрийнхөө хэн гэдгээ тийм түргэн хэрхэн мэдэж чадах билээ? Мэдсэний дараа хүлцэж тэвчихийн аргагүй болно, гэхдээ цаг нь болохоор бид бас мэдчихнэ. Шагжамуни Бурхан бурханы хутагт хүрэх тэр агшинд өөрийгөө хэн болохоо бүрмөсөн мэджээ, үүнээс өмнө мөн л ертөнцийн жаргалыг эдэлж, тансаг ордонд амьдарч, үлэмж их эд хөрөнгө болон өндөр дээд байр суурь, үзэсгэлэнт хатан, хөөрхөн хүүхэдтэй, өдөр болгон дуу бүжиг, аялгуу хөгжмийн дунд мансуурч, эгэл хүн шиг жарган цэнгэж байжээ, тэгээд бясалгал хийсний дараа л өөрийгөө бурхан гэдгийг ойлгосон байна.

Бид бас адилхан, одоо мөн л энгийн хүн боловч цаг нь болмогц бас өөрийнхөө хэн гэдгээ мэдэх болно, багшийн шавь болгон хамгийн удлаа гэхэд л ертөнцөөс салж одох үедээ өөрийгөө хэн болох, хаа очихоо мэдэх болно, гэтэл зарим хүн тийм удтал хүлээх шаардлагагүй байдаг. Гэвч хүн болгон тийм түргэн ойлгож чаддаг биш, шаардлагатай үед багшийн хүч зохицуулж, бидэнд түргэхэн шиг ойлгуулдаг, шаардлагагүй бол зохицуулдаггүй.

Урьд нэгэн шавьд өөрийнх нь ирээдүй тун сонирхолтой санагдсан

тул “ирээдүй”-гээ мэдэхийг хүсжээ. Тэгээд бясалгаж суух болгондоо, дотоодын сувилгаан багшийгаа харах үедээ ирээдүйн байдлыг нь хэлж өгөхийг гуйдаг байжээ, тэгэхэд багш нь: “Хэлж болохгүй” гэв, “Яагаад хэлж болдоггүй юм бэ?” гэж шавь нь асуухад багш нь: “Нэг хүн хэрвээ ирээдүйнхээ тухай хамгийн сайн үр дүнг мэдчихвэл түүнд энэ ертөнцөд үргэлжлүүлэн амьдрахад тун бэрх болно” гэжээ. Энэ шавь нь хожим Төгс Гэгээрсэн Их Багш болсон байна, хэрвээ тухайн үед багш нь түүнд хэзээ Төгс Гэгээрсэн Их Багш болохыг нь үзүүлж, хэлсэн бол харин ийм үр дүнд хүрч чадахгүй ч байсан байж магад билээ.

Ирээдүйд болох зүйлээ урьдчилан мэдэх нь хүмүүсийн сэтгэлийг догдлуулдаг, учир нь бясалгалын хүч нь хангалтгүй болохоор сэтгэл татагдан зургаан жилийн дараах үр дүнгээ нойр хулжин хүлээж, бясалгахгүй ч гэсэн Бурханы хутгийг олох юм чинь өдөр болгон бясалгаж суухын хэрэг юу байх билээ гэж боддог. Хэзээ ч бай лавтай Бурханы хутагт хүрэх болохоор гадагш гарч: Би зургаан жилийн дараа Бурханы хутагт хүрнэ, надаас сурах хүсэлтэй хүн байвал одооноос эхлээд нэрээ бушуухан бүртгүүлээрэй! Тэгээд бүртгүүлсэн дарааллаар чинь сургана, үгүй бол хожим миний шавь дэндүү олон болсны дараа сурч чадахгүй болж ч мэднэ (Бүгд инээлдэв) гэж сурталчилдаг. Тиймээс бясалгалын хүч хангалтгүй бол “ирээдүй”-н үр дүнгээ урьдчилан мэдсэний дараа ингэж ч магад, учир нь Бодь мөрийн зэрэгт хүрэхээс өмнө мөн л эгэл хүмүүний билиг ухаантай байж, бурхны байр суурь болон дэсийг хүртэхийн аргагүй байдаг.

Эрт дээр үед вьетнамд нэгэн үед бичиг номын хүмүүсийг л хүндэтгэж, цэргийн хүнийг үл тоомсорлодог байсан тул эрэгтэйчүүд бүгд сайдын тушаалд дэвших шалгалтанд тэргүүлэхийг хүсдэг байжээ, аварга болсны дараа үлэмж их мөнгөтэй, үзэсгэлэнтэй хатантай болно. Том сайд нар бүгд л охин хүүхдээ түүнтэй гэрлүүлэхийг хүсэх бөгөөд тэр ч байтугай улсын хаан хүртэл түүнийг хамгийн өндөр тушаалд томилдог байж.

Нэгэн маш ядуу оюутан, өөрөө чухам хэзээ сайдын тушаалд дэвших шалгалтын аварга болох талаараа бодож зүрхэлдэггүй ч маш шаргуу суралцдаг байжээ. Тэр тун чармайлттай байж өдөр болгон сүм хийдэд очин цэцэн сэргэлэн, үлэмж их мэдлэгтэй болоосой гэж бурхан бодьсадвад даатгадаг, учир нь гэр бүл нь тун ядуу боловч чадан ядан түүнийг сургуульд явуулж ном эрдэмд сургадаг байж, тиймээс тэр том сайд болсныхоо дараа гэр бүлийнхээ нөхцөл байдлыг сайжруулахыг хүсжээ.

Ихэнх сүм хийдийн хаалганы өмнө ер нь хоёр чулуун арслангийн баримал босгосон байдаг. Нэгэн өдөр тэр чулуун арслангийн өмнүүр өнгөрөх үед өнөө чулуун арслан гэнэт: “Та чин сэтгэлтэй болохоор өчигдөр бурхан бодьсадва надаар танд мэдээ дамжуулсан, та ирээдүйд, энэ жилдээ лавтай сайдын тушаалд дэвших шалгалтын аварга болж чадна гэсэн, тиймээс бүр ч илүү чармайн сурах хэрэгтэй” гэж түүнд хэлжээ, үүнийг сонсоод тэр ийш тийш харсан чинь хүний бараа алга байжээ, зөвхөн чулуун арслан дөнгөж амаа хамхиж байхыг харсан

боловч чулуун арслан яахин үг ярьж чадах билээ, нээрээ сонин юм аа гэж их гайхжээ. Түүнд гайхалтай санагдсан ч тийм их итгэл төрсөнгүй тул гэртээ харьсныхаа дараа үргэлжлүүлэн чармайн суралцав. Маргааш нь тэр дахин сүмд очин бурхан бодьсадвад хандан “Хэрвээ энэ явдал үнэн юм бол өнөөдөр дахин надтай яриулаач” гэж хэлсэнд чулуун арслан үнэхээр өчигдөртэй адилаар: “Та том сайд болно, тиймээс чармайн суралцах хэрэгтэй” гэж хэлж гэнэ. Тэр даруй тун их баярласан боловч мөн л бүрмөсөн итгэж зүрхэлсэнгүй, тиймээс гэртээ хариад үргэлжлүүлэн шаргуу суралцжээ. Маргааш нь тэр жимс болон шинэхэн цэцэг худалдаж аваад сүмд очин бурхан бодьсадвад өргөл өргөж: “Би тун ядуу, ихийг сурсан хүн биш болохоор хэрхэн том сайд болж чадах вэ? Үнэндээ итгэж зүрхлэхгүй байна, чулуун арслангийн ярьсан нь нээрээ үнэн юм бол бас дахин нэг удаа надтай яриулахыг хүсье!” гэж даатгажээ. Тэгтэл чулуун арслан үнэхээр урьдах үгээ дахин хэлсэнд тэр туйлын ихээр баярлан гэртээ буцаж очсон даруйдаа энэ тухай аав, ээждээ ярьж өгчээ.

Угаасаа тэднийх тун ядуу айл боловч одоо хүү нь том сайд болно гэж чулуун арслан гурван удаа зөгнөн хэлсэн гэдгийг сонсоод аав, ээжид нь бардамнах сэтгэл дорхноо төрж, хүү минь удахгүй том сайд болж, бидний байр суурь хөрш саахалтынхнаас илүү дээгүүр болно гэж боджээ, тиймээс хөршийнхөндөө дээрэлхүү хандах болжээ. Жишээ нь, өөрийн үхрээ бусдын тарианд тууж оруулан бэлчээнэ, хэрвээ хөршийнхөн нь ирж гомдолловол: “Та дураараа ярьж болохгүй, хүү минь хожим сайд болно. Сайдын үхэр тариан дахь өвсийг чинь идэх нь та нарын буян хишиг гэж мэд! Гомдоллох хэрэг юун?” гэж хэлдэг байв. Хүү маань хожим том сайд болно гэж бурхан бодьсадва чулуун арслангаар зөгнөл дамжуулжээ гэж тэд өдөр болгон ярьдаг болохоор хөрш саахалтынхан нь бүгд л итгэл төрж, аавынх нь ёс зүйгүй ажиллагааг эсэргүүцэж зүрхлэхгүй, юу ч ярьж чадалгүй зөвхөн хүлцэн тэсвэрлэдэг болжээ, гэхдээ хүү нь үүнийг огт мэдээгүй байв.

Нэгэн өдөр тэр хүү мөн л сүмд очин бурханд мөргөжээ, тэгэхэд өнөөх чулуун арслан дахин үг ярив, гэхдээ энэ удаад сайд болно гэсэн зөгнөлийн үг хэлсэнгүй, харин “энэ жил та сайд болж чадахгүй” гэжээ. Өнөө хүү тун гайхан яагаад ийм болов гэж асуусанд чулуун арслан: “Учир нь аав чинь дэндүү муу санаатай болчихжээ, ихэд онгирч, бардам зан гарган хөрш саахалтынхнаа гутаан доромжилж, бусдын эрх ашигт халдсан болохоор чиний буян хишиг чинь улам буурчээ, тиймээс энэ жилийн сайдын шалгалтанд танаас бүр ч илүү буянтай хүн сонгогдохоор болсон” гэв.

Энэ үед өнөө сурагч тун урамгүй болж сэтгэлээр унан гэртээ хариад энэ муу мэдээг аав, ээждээ хэлснээр бүгд маш харамсан зовж, эхэр таган уйлжээ. Үүнээс хойш аав нь омгорхон бардамнаж, бусдыг гутаан доромжилж зүрхлэхгүй болов, гэсэн ч тэр жил нь өнөөх сурагч үнэхээр сайдын шалгаруулалтаас хасагджээ. Тиймээс тэр машид урам хугарч харамсан гэмшсэн болохоор өдөр болгон бурхан бодьсадвад хандан: “Аав минь харанхуй мунхагаасаа болж маш олон гэм буруу

хэрэг үйлдэж, бас миний буян хишгийг ч ихэд бууруулжээ. Тиймээс би гэртээ харьж очин аав, ээждээ гэм буруугаа гэмшин ухаарч, ач буянтай үйл илүүхэн үйлдэж, үүгээрээ урьдын алдаа буруугаа нөхөх учрыг хэлж өгөх болно” гэж даатгажээ. Ингэснээр түүний аав, ээж нь үнэхээр гэм буруугаа засаж, боломжийнхоо хэрээр сайн үйл үйлдэж, хөрш саахалтынхандаа сайнаар хандах болжээ.

Тэгээд гурван жил өнгөрсний дараа сайдын тушаалд дэвших шалгаруулалт дахин болох үеэр чулуун арслан тэр оюутныг шалгалтын аварга болно гэж зөгнөн хэлжээ. Үүнд оюутан залуу бүрмөсөн итгэж зүрхэлсэнгүй, үргэлжлэн шаргуу суралцсаар байсан бөгөөд урьдах шиг алдаа буруу гаргахаас сэрэмжилж, энэ зөгнөлийн талаар аав, ээждээ ч ярьсангүй, ингэснээр тэр жил нээрээ шалгалтын аварга болж чаджээ.

Бид ч бас адилхан, хэрвээ ирээдүйд хүрэх амжилтынхаа үр дүнг түрүүлээд мэдчихвэл тун олон саад бэрхшээлд ороогдох болно, одоо бид үзэсгэлэнтэй сайхан төвшнийг харж, хожим тэнд баяр жаргалыг эдэлж, гуниг зовлонгүй, тав тухтай амьдарна гэдгээ урьдаас мэдчихвэл энэ ертөнцөд хувцас угаах, аяга сав угаах, хоол зууш бэлтгэх гэх мэтийн дур гутам гэрийн ажил хийх юмуу, ажил хийж даргаа царайчлан бусдын гутаан доромжлохыг хүлцэн тэсвэрлэж хэрхэн чадах билээ? Нэг хүн хэрвээ диваажингийн баяр жаргалтай төвшинг мэдчихвэл энэ замбуутивийн гуниг зовуурь болон уйтгар бухимдлыг лавтай хүлцэн тэсвэрлэж чадахгүй болно. Тиймээс ирээдүйнхээ үр дүнг эхлээд харах юмуу, мэдэх нь бидний хувьд сайн биш. Энэ бол багш нь яагаад та нарт ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй, гэхдээ бичиж тэмдэглэж болно гэж байнга хэлдгийн шалтгаан юм. Одоо зарим хүн аль хэдийн багшийг чинь буруу номтон, ад чөтгөр гээд ярьчихсан байна, за юу! Тэгвэл бид ахуй ойлголтоо бүгдийг бичиж тэмдэглээд ном болгож хэвлүүлэн тэдэнд багш шиг чинь ийм “ад чөтгөр” ямаршуухан сайн гэдгийг мэдүүлье! (Бүгдээр инээлдэв.) Яагаад ийм буруу ойлголт төрж, гайхалтай ахуй ойлголттой болсныг ад чөтгөр мөн гэж үздэг хэрэг вэ? Миний шавь нарын зарим нь үлэмж их буянтай болохоороо багшийнхаа хувилгаан биеийг харж чаддаг, багшийнхаа хувилгаан биеийг харах үедээ тэр тун баярладаг биш үү? Багшийнхаа хувилгаан биеийг харах тусам баяртай болдог бөгөөд амьдралынх нь нөхцөл байдал улам сайжирч, оюун санаа нь ч урьдынхаасаа сайн, гэр бүл нь ч сайн гээд аливаа юм бүхэн нь сайн болдог, ийм сайн чөтгөрийг бид хайж олъё гэхгүй байгаагаасаа харин санаа зовбол зөв байхсан.

Тэр хүмүүс бурхны шашинд суралцаад олон жил болчихсон байж мөн л хувилгаан биеийн хэрэг явдлаас айдаг, нэгэн Их Багшийн хувьд хувилгаан бие нь тун амархан хэрэг, тийм гайхалтай, эсвэл ер бусын хэрэг биш, зарим шавь маань бясалгаад багшийнхаа дэсэд хараахан хүрээгүй хэдий ч бас хувилгаан биеэрээ хүрч очин хүүгээ аварч чаддаг, ийм байхад нэгэн Их Багш яагаад хувилгаан биетэй болж чадахгүй байх вэ? Зөвхөн зарим бодьсадвагийн дэс нь ондоо байдгаас цөөн хэдэн хувилгаан биетэй болж, хоёр гуравхан газарт хүрдэг. Шагжамуни Бурхан бол Их Бодьсадва, Их Бурхан, үй түмэн хувилгаан биетэй, хичнээн олон

шавьтай байсан ч шавь нар нь багшийнхаа хувилгаан биеийг бүгдээрээ харж чаддаг бөгөөд Бурхан Багш хувилгаан биеэрээ хаа ч хүрч чаддаг байжээ, бясалгалаар бага зэрэг өндөр энгийн шавь нь ч гэсэн бас хоёр, гурван хувилгаан биетэй болж чаддаг.

Хувилгаан биетэй болох нь үлэмж их ач буянтай бясалгагчийн хувьд хүүхдийн тоглоом шиг зүйл бөгөөд тийм ч гайхалтай хэрэг биш, хэрвээ бид үүнийг сайн ойлгохгүй, харин эвэртэй туулай үзсэн юм шиг цочирдон гайхвал өөр хүмүүс таныг элэглэн шоолох болно. Учир нь өөрийн чинь дэс доор бөгөөд Их Багшийн үйл хэргийг ойлгож чаддаггүй болохоороо түүнийг ад чөтгөр гэж гүтгэдэг юм.

Вималакирти Их Багш маш олон хувилгаан биетэй, Түүний олон янзын гайхалтай үйл хэргийг нь “Вималакирти судар”-т өгүүлсэн байдаг. Хэрвээ хувилгаан бие гэж байдаггүй бол бид судар ном уншихаараа яагаад энэ талаар мэдэж чаддаг юм бэ? Бид бясалгасны дараа ном судраас нотолгоо олж болох бөгөөд өөрсдийнхөө бясалгалын дэс хэр өндөр болохыг мэдэж болно. “Баатар явагч их хөлгөн судар”-т бясалгагч хүн ямар дэсэд хүрвэл ямар өнгийн гэрэл хардаг гэдгийг тэмдэглэсэн байдаг бөгөөд ном сударт өгүүлсэн бодьсатвагийн харсан гэрэлтэй адилтган жишиж байж, өөрсдөө ямар дэсэд байгаа, ямар үзэсгэлэнтэй байдлыг харснаа мэдэж болно. “Баатар явагч их хөлгөн судар”-аас гадна бас “Авид бурханы судар”-т тэмдэглэсэн ахуй ойлголт буюу хүслэнт ахуйгаас нотолгоо олж болно.

Төгс баясгалант оронд ямар ямар сүр жавхлантай үзэсгэлэнтэй байдал байдаг тухай Шагжамуни Бурхан ярьсан байдаг. Бурхан Багш хэрвээ тэнд хүрч чадаагүй юм бол яаж мэдэж чадах билээ? Төгс баясгалант оронд очсон болохоороо л бусдад ярьсан байна, ингэх нь ямар ч гайхалтай хэрэг биш. Яг л тайваньчуудын ихэнх нь америкт очоогүй боловч тэдний дундаас ганцхан хүн америкт очиж үзсэн байлаа ч өөрийн улсдаа буцаж ирсэний дараа америк улсын байдлыг бусдад ярьж, дүрслэн тайлбарлаж, ойлгуулж болно. Гэхдээ бид америкт очоогүй гэх нь өөр хүмүүс бас тэнд очоогүй гэдгийг илэрхийлж чадахгүй.

Үүнтэй адилаар, Төгс баясгалант оронд хүрэх болон америкт очих хоёрын ялгаа зөрүү нь зөвхөн хол ойрын ялгаанд байх бөгөөд ашигладаг зам харилцааны арга техник нь адилгүйд л байгаа хэрэг. Зарим газар очиход галт тэргэнд суух хэрэгтэй, зарим газар очиход онгоцонд суух хэрэгтэй, гэтэл зарим оронд очиход эрхбиш ид шидийн хүчийг ашиглах хэрэгтэй, сүнсээрээ хүрч очин харах хэрэгтэй, билиг ухаан, Бурхан чанараа хэрэглэх хэрэгтэй, энэ бүхэн нь цөм ашиглах зам харилцааны арга техник нь адилгүй байдаг л байгаа юм. Тиймээс хувилгаан биеийн байдал нь тийм ч гайхалтай биш бөгөөд тэгж их сүр бадруулан яримаар зүйл ч биш.

Хүмүүс багшийг чинь ад чөтгөр гэж гүжирдэн гүтгэхийг сонсоод зарим шавь маань ихэд санаа зовдог, тэд ингэж бусдыг буруушаан хараахыг та нар сонсоод сэтгэл шаналах хэрэг юу билээ? Ингэж болдог юм уу? Багшаасаа суралцвал айж эмээж болохгүй, хараах нь тэдний хэрэг, багшийг чинь хараах тусам багш нь баярлана, тийм ч их санаа

зовж эмээх хэрэг алга.

Урьд нь багш нь та нарт ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй гэж хэлдгийн учир нь ихэнх хүн ярьсныг чинь ойлгодоггүйгээс болж байгаа юм, та нарыг харахад бүгд л энгийн хүмүүс, харин багш чинь нэгэнт гэрээс гарч, буддын шашны гэлэнмаа болчихсон байна. Хэрвээ багшид чинь тийм ахуй ойлголт байвал тэд итгэл төрж мэднэ, учир нь гэрээс гарагсад ач буянтай гэх үзэлд баригддагаас болжээ. Гэтэл бас итгэхгүй байж мэдэх бөгөөд багшийг чинь гадаад номтон, ад чөтгөр гэж шүүмжилж мэднэ. Гэхдээ та нар бол гэрээс гараагүй энгийн хүн байтлаа бурхныг харж чадвал яриангүй тэд гүтгэнэ, тэд та нарыг сайшаан магтвал та нарт бардамнах бодол төрнө. Тиймээс бүгд л сайн биш, өөрсдийнхөө ахуй ойлголтыг бусдад ярихгүй байх нь хамгийн сайн, энгийн хүмүүс ийм хүслэнт ахуй байдаг гэдэгт итгэхгүй, та нар энгийн хүмүүсээс ч бүр ч энгийн харагддаг, багш чинь бас ийм, буддын шашны энгийн номын багшаас бүр ч илүү энгийн харагдана.

Урьд нь Шагжамуни Бурхан ямар ахуй ойлголттой байвал шавь нар нь ч бас тийм ахуй ойлголттой байжээ. Одоо бид бас ийм байж болно, ондоо гэмээр зүйл байхгүй, бүгд л адилхан “хүн”, гэхдээ одоо цагийн дэлхий ертөнц эрт дээр үеийнхээс илүүтэй хөгжин дэвшсэн тул хүмүүс маш олон орчин үеийн багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж ашиглан юмыг тун түргэнээр сурч чаддаг болсон. Жишээ нь, багшийнхаа ном тайлахыг сонсох гэж ирж чадахгүй хүмүүс дуу хураагч төхөөрөмж ашиглан багшийнхаа ном тайлсан хуурцгийг сонсож болно, эсвэл багшийнхаа номыг аваад гэртээ харьсны дараа уншиж болно, бас машинаар түргэн ирж, багштайгаа уулзаж болно. Гэтэл урд нь ийм тав тухтай боломж байгаагүй, Бурхан Багш хаа очих гэсэн ч заавал явган явах хэрэгтэй байв, гэтэл Түүний бясалгал тийм өндөр хэмжээнд хүрч чадсан байна. Одоо харин та нар машин унадаг хэдий ч яагаад харин тийм сайн ахуй ойлголтгүй байна вэ, үнэндээ урьдын хүмүүсээс бүр ч илүү сайн байх ёстойсон.



## ЯМАР ХҮМҮҮС ТӨГС БАЯСГАЛАНТ ОРОНД ОЧИЖ ЧАДАХ ВЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй, Цаглашгүй гэрэлт бясалгалын төв  
(Эх нь хятад хэлээр)  
1986 оны 12 дугаар сарын 7*

Би Америкт байхдаа нэгэн сүмд очлоо. Учир нь би тэр сүмийн нэгэн номын багшийг урьд нь таньдаг байсан болохоор замаараа түүнтэй уулзсан юм. Тэгээд уулзсаны дараа тэр намайг өөрийг нь хүндэтгэхээ больчихжээ гэж буруугаар ойлгосон байна, учир нь би түүнд алга хавсран мэхийгээгүй болохоор тэр тун урам муутай болж: “Та чинь одоо тун бардам зантай болчихжээ, надад яагаад мэхийсэнгүй бэ?” гэсэнд, би: “Багш аа! Би таныг хүндэтгэдэг шүү!” гээд тэр дороо түүнд алга хавсран мэхийсэн бөгөөд мөн түүний шавьд ч бас хүндэтгэл үзүүлэв, тэр тун гайхан цочиж: “Тэр чинь ердөө л банди шүү дээ! Харин та чинь гэлэнмаа байтлаа түүнд юунд хүндэтгэл үзүүлнэ вэ? Тэр дөнгөж гэрээс гарсан хүн, та түүнээс өмнө гэрээс гарсан атлаа яагаад түүнийг хүндэтгэх болов?” гэв. “Зүгээр ээ! Амьд бурхны төлөөлөгчид алга хавсран хүндэтгэх нь модон бурханд хүндэтгэл үзүүлэхээс илүү дээр” гэж би хэлээд тэндээс явсан.

Намайг явсны дараа тэдэнд ямар бодол төрснийг би мэдэхгүй, энэ гэлэнмаа үнэхээр сонин юм даа гэж бодсон ч байж мэднэ, модон бурханд алга хавсран хүндэтгэл үзүүлэхгүй, харин бандид алга хавсран хүндэтгэл үзүүлэх юм, тэдний бодлоор бандийн байр суурь нь угаас гэлэнмаагаас доор, гэхдээ хүн болгон бүгд л Бурхан чанартай, банди, эсвэл чавганц биш байлаа ч гэсэн хүн бүхэн Бурхан чанартай байхад яагаад банди юмуу, чавганц хүнд Бурхан чанар байж болохгүй байх билээ? Амьд бурхны төлөөлөгчид алга хавсран хүндэтгэл үзүүлэх нь модон бурханд алга хавсран хүндэтгэхээс илүү дээр шүү!

Нэгэн багшид шавилах эсэх нь бүгд адилхан, гагцхүү заавал өөрийн биедээ, өөртөө найдах хэрэгтэй, учир нь хамгийн дээд багш бол өөрийн чинь бие мөн, харин гадна талын багш биш, дотоодын багш ч бас биш. Гэхдээ бас дээд зэргийн дэсэд хүрэхээс өмнө заавал гэгээнтнээр удирдан замчлуулах хэрэгтэй, тийм гэгээнтнийг бид Ши Пү (Багш гэсэн утгатай) буюу Багш гэж нэрлэдэг.

Бясалгал жаахан өндөр дэсэд хүрвэл бид дотоодын багш, дотоодын гэгээнтэнтэй болдгийг бид бурхан, эсвэл бодьсадвагийн хувилгаан бие гэж хэлж болно, энэ бурхан бодьсадвагийн хувилгаан биеийг харахад

гадна талын багштай чинь адилхан, эсвэл адилгүй ч байж магад, гэхдээ дотоодын хувилгаан багшийгаа харах нь мөн л хамгийн дээд дэс биш, хамгийн эцэст бид бас дотоодын багшаасаа салах хэрэгтэй. Учир нь “Төрөл төрөлдөө бодьсадвагийн замыг мөнхөд мөрдөнө”, бодьсадва болж Бурханы хутагт хүрэхэд бурхан бодьсадвад найдаж болохгүй, заавал өөрсдөө бодьсадвагийн замаар явж, бодьсадва болох хэрэгтэй, энэ бол бясалгал хийхийн зорилго.

Мэдээж, бясалгаад амжилтанд хүрэхээсээ өмнө заавал биднээс бүр ч илүү туршлагатай нэгэн хүнд найдах хэрэгтэй. Жишээ нь: бид урьд нь ерөөсөө явж үзээгүй замд ямар саад бэрхшээл, аюул бартаа байгааг мэддэггүй болохоор хэн нэгэн замчнаар замчлуулж удирдуулах хэрэгтэй, тэгээд энэ замыг туулсны дараа замын байдлыг тодорхой мэдчихнэ. Гэхдээ замчин бол зөвхөн биднийг удирдан дагуулдаг л төдий, замыг харин бид заавал өөрсдөө туулах хэрэгтэй, өөрөө туулсны дараа дахин буцаж ирээд өөр хүмүүсийг дагуулж явна, харин явах болгондоо зөвхөн замчлагчид л найдах биш юм.

Бясалгахад бясалгалын олон арга, олон зам мөр байдаг. Яг л Каошиунаас Тайбэй хүрэх зам тун олон байдагтай адил, зарим зам нь нилээд урт, зарим зам нь нилээд богино, зарим зам нь тэгш дардан, зарим зам нь энхэл донхол ихтэй, саад бэрхшээл их, тэр ч байтугай зарим замаар нэвт гарах боломжгүй байдаг, учир нь уг замд засвар хийх шаардлагатай аюултай газар олон байдаг болохоор засгийн газраас тэр замыг хаачихдаг. Дайны үед зарим замаар явахыг хориглож, хөл хорио тогтоодог.

Тиймээс нэгэн замчлагч, эсвэл гэгээнтэн аль зам нь нилээд сайн, аль зам нь арай түргэн, аль зам нь саад бэрхшээл бага, аль замаар нэвт гардаг гэдгийг сайн мэддэг, тиймээс ийм хүнийг дагавал нилээд баталгаатай бөгөөд аюулгүй болохоор бидэнд замчлагч хэрэгтэй. Бид өөрсдөө зам хайж явж болох хэдий ч хэцүү бэрх, тун аюултай, эцэстээ замаа хайгаад олчихлоо ч гэсэн зорьсон газартаа дөхөх үед бид аль хэдийн дэндүү их ядарснаасаа болоод цааш үргэлжлэн явж чадахгүй болж ч мэднэ.

Хэрвээ бид оюун санааны хүчээ дэндүү их үрэхгүй гэвэл нэгэн замчлагчид найдах хэрэгтэй, гэхдээ түүнд найдахаас гадна бид өөрсдөө бас алхах хэрэгтэй, тийм биш бол Шагжамуни Бурхан яагаад зургаан жил шаргуу бясалгах хэрэгтэй байсан бэ? Судар номоос мэдэж болох нь Шагжамуни Бурхан бол гэрэл гэгээг хамгаалдаг бодьсадва мөн бөгөөд Тушита тэнгэрийн орноос бууж ирсэн, хувилгаан биеэр бууж ирээд хамаг төрөлтнийг гэтэлгэх нь Түүний ажил юм. Гэтэл бууж ирсний дараа мөн л хүн болох хэрэгтэй, дахин бясалгал хийх хэрэгтэй байжээ, харин аль хэдийн бодьсадва болчихсон болохоор бууж ирсэнийхээ дараа бясалгал хийх шаардлагагүй биш юм.

Гэхдээ бас өөр нэг зүйлийн нөхцөл байдал байх боломжтой, цөвүүн цаг үе бол хамгийн сүүлчийн цаг мөч болохоор хамаг бурхад, хамаг их бодьсадва юмуу, тэнгэрийн төрөлтөн тун түргэнээр хувилгаан биеэр энэ дэлхийд бууж ирээд хамаг төрөлтнийг гэтэлгэдэг ч байж

магад, тэд хамаг төрөлтийг гэтэлгэх үедээ эхийн хэвлийд оролгүй, харин хувилгаан биеэрээ ирэх юмуу, өөр хүний бие цогцосыг ашиглах ч мэднэ. Учир нь эмэгтэй хүний хэвлийг дамжин хүн болж төрөх нь дэндүү удаан, эхийн хэвлийд есөн сар болж байж л хүн болж төрөх хэрэгтэй, тэгээд том болсныхоо дараа бас сургуульд сууж, маш олон хэрэгцээгүй зүйлд суралцах хэрэгтэй бөгөөд хожим бясалгал хийсний дараа энэ хэрэгцээгүй үзэл бодлоо угааж цэвэрлэх хэрэгтэй, тэгсний дараа хэрэгцээтэй зүйл, үзэл бодлыг шингээж байж төгс төгөлдөр болох үед билиг нээгдэж, Бурханы хутагт хүрдэг, ингэснээр л сая хамаг төрөлтийг гэтэлгэж чадна.

Гэвч билиг нээгдэхээс эхлээд хамаг төрөлтийг гэтэлгэх хүртэл маш урт удаан цаг хугацаа зарцуулдаг бөгөөд энэ дунд маш олон саад бэрхшээл тохиолдоно, бясалгаад дөнгөж Бурханы хутагт хүрсэн болохоор танд итгэх хүмүүс яаж тийм олон байх вэ? тийм үү, үгүй юу? Та өөрийгөө билиг нээгдэж, Бурханы хутагт хүрсэн гэнэ, ингэж ярих нь таны хэрэг, итгэх эсэх нь харин тэдний хэрэг. Тиймээс хүн болж төрөөд аажмаар том болно, тэгээд хэрэгцээгүй зүйлд суралцсаны дараа хэрэгцээгүй үзэл бодлоо дахин угааж цэвэрлэж, хэрэгцээтэй зүйлээ шингээнэ, дараа нь Бурханы хутагт хүрч байж хамаг төрөлтийг гэтэлгэдэг, ийм үйл явц нь маш урт цаг хугацаа шаарддаг бөгөөд энэ завсар маш их цагийг талаар үрж дуусгадаг.

Тиймээс энэ цөвүүн цагт зарим хүн тун хурдан түргэн бясалгадаг бөгөөд тэд хэвлийгээр дамжих шаардлагагүй, харин шууд хувилгаан биеэр ирж хамаг төрөлтийг гэтэлгэдэг ч байж мэднэ, бясалгалаар сайн хүний бие цогцосыг ашиглаж, хамаг төрөлтийг гэтэлгэж ч магад. Тун олон бурхан бодьсадва хувилгаан биеэрээ буун ирэх боломж байдаг хэдий ч хамаг төрөлтийг тийм ч ихээр гэтэлгэж чадахгүй ч байж магад, зарим бодьсадва нь зөвхөн ганцхан хүнийг л гэтэлгэж, зарим нь арван хүнийг гэтэлгэдэг ч байж мэднэ, тиймээс асар олон бодьсадва буун ирж байж л сая хамаг төрөлтийг үй олноор нь гэтэлгэж чадна, үгүй бол гэтэлгэж чадахгүй.

Бодьсадва тоолшгүй олон хувилгаан биетэй болж, зөн билиг, ид шид ихэд үзүүлдэг боловч хамаг төрөлтөн харж чаддаггүй болохоор махан биеэр илрэн гэтэлгэх хэрэгтэй. Жишээ нь: та нар багшийгаа дагаж бясалгахдаа зарим нь багшийнх нь хувилгаан бие гэрт нь ирж тэднийг сургахыг хардаг, зарим хүн нийтийн унаанд сууж байхдаа багшийнхаа хувилгаан бие ирж, тэднийг харгалзахыг хардаг гэх мэт явдал байх нь бий. Гэтэл зарим хүн харж чаддаггүй, тиймээс мөн л махан биетэй багш ирж тэднийг сургах хэрэгтэй.

Бурхан бодьсадва энэ ертөнцөд ирэхдээ мөн л ийм, тэд яагаад махан биеэр ирдэг юм бэ? Бурхан бодьсадва хувилгаан биеэрээ ирж, зөн билиг харуулан ид шид үзүүлж, хамаг төрөлтийг гэтэлгэж чадах байтал яагаад заавал махан биеийг ашигладаг вэ гэж бид бодож магад, хамаг төрөлтөн махан нүдээрээ бурхан бодьсадваг харж чаддаггүй болохоор заавал нэг дэс доошилж махан биеэр үзэгдэх хэрэгтэй болно, хамаг төрөлтөн махан нүдээрээ бурхан бодьсадваг харж чаддаггүй болохоор

заавал нэг дэс доошилж, номлолыг нь ойлгосны дараа алгуур аажмаар бясалгуулах болно.

Бурхан бодьсадва хувилгаан биеэр энэ ертөнцөд ирэхдээ заавал нэгэн аав, ээжийн үр хүүхэд болох шаардлагагүй, яг л Есүс Христийн үлгэр шиг, бидний мэдэж байгаагаар тэр өөрөө хувилгаан биеэрээ ирж, Ариун Мари-гийн хэвлийд орж, хүүхэд болжээ, ингэж бас болно. Шагжамуни Бурхан мэдээж эцэг, эхтэй байсан хэдий ч тэдний махан биеийн харилцаагаар дамжин байж мэндэлсэн биш, яагаад гэвэл хааны хатан Мэке (Махамаяа) жирэмслэх үед зургаан соёотой цагаан өнгөтэй заан хэвлийд нь орсон байна гэж зүүдэлсэн бөгөөд хожим нь хааны хүү мэндэлжээ.

Есүс Христийн эх нь жирэмслэх үед хараахан гэрлээгүй байжээ, онгон бүсгүй жирэмсэлсэн гэдэгт ихэнх хүн итгэдэггүй, гэвч бясалгалтан хүмүүс үүнд итгэж чадна, бурхан бодьсадва нар маш их зөн билиг, ид шидтэй, олон зүйлийн чадвартай байдгийг бясалгал хийсний дараа ойлгодог, тэд юуг ч хийж чаддаг бөгөөд өөрсдөө хүн болж хувилж ч чаддаг. Гэтэл энэ материаллаг ертөнцөд заавал материаллаг системийг ашиглаж байж л сая оршин тогтнож чадна. Учир нь ертөнц болгоны дэс нь ялгаатай, хэлбэлзэл нь адилгүй болохоор өөр материалыг ашиглаж байж л сая хүний ертөнцтэй ойлголцож чадна.

Бурхан бодьсадва мэдээжээр энэ дэлхийн хууль дүрмийг өөрчилж чадна, гэвч тэд тэгэх дургүй, өөрчилсний дараа дэндүү их саад бэрхшээл тохиодог, зөвхөн нэгээхэн хэсгийг нь өөрчилдөг л юм бол бүхий л нөхцөл байдал эмх замбараагаа алдана, яг л багшийнх нь одоо хэрэглэж байгаа микрофон шиг, энэ нь цаана байгаа өсгөгчтэй холбоотой, өсгөгч нь чанга яригчтай холбоотой, тиймээс аль нэг төхөөрөмжийг нь засах гэвэл бүхий л системийг нь унтраах хэрэгтэй болно.

Энэ ертөнцөд мөн л ийм байдаг. Аль нэг төрөлтөн нь өөр бусад төрөлтөнтэй холбоотой болохоор бурхан бодьсадва энэ ертөнцөд ирэхдээ бас эндхийн хууль дүрмийг дагах хэрэгтэй, тэгэхгүйгээр олон төрлийн гайхалтай нууцлаг зөн билиг гарган хүмүүст харуулбал хамаг төрөлтөн ихэд итгэж, бүгдээрээ ирж, тэднээс суралцах болно. Бурхан бодьсадва мэдээжээр зөн билгийг ашиглан дэлхийг үндсээр нь Төгс баясгалант оронд дэвшүүлж чадна, гэвч тэд ингэж болохгүй, яагаад ингэж болдоггүйг би та нарт ярья!

Учир нь анхандаа бид юм суралцахын төлөө, хамаг төрөлтнийг ойлгохын төлөө, бурхныг ойлгохын төлөө, мөнх бусыг ойлгохын төлөө, төгс төгөлдөр гэгч юу болох, үүрд мөнх гэгч юу болохыг мэдэхийн төлөө энэ замбуутивд өөрсдөө дуртайяа бууж ирсэн байна. Өөрсдөө дуртайяа бууж ирсэн болохоор бас өөрсдөө дуртайяа буцах хэрэгтэй, бурхан бодьсадва бидний үзэл ухамсарт хөндлөнгөөс оролцож болохгүй, учир нь бид бол агуу их төрөлтөн мөн бөгөөд өөрийн гэх шүүн магадлах чадвартай байдаг, бид диваажинд очсон ч бай, тамын оронд очсон ч бай, бурхан болсон ч бай, бодьсадва болсон ч бай, хүн болсон ч бай, амьтан болсон ч бай, чөтгөр болсон ч бай хэзээд мөнх оршдог. Ямар нэгэн хүчин, ямар нэгэн хүн хичнээн өндөр дээд байлаа ч гэсэн,

бидний хэлдэг Хамгийн дээд Эзэн Бурхан, Оройн дээд төгс гэгээрлийн дээд хүрсэн байлаа ч гэсэн бидний уг дүр, жинхэнэ эзэн, жинхэнэ бие, бидний сүнсийг сөнөөж чадахгүй.

Алгуур аажимхан бясалгах, алгуур аажимхан суралцах юмуу, хурдан түргэн суралцах эсэхээ бид өөрсдөө л шийднэ, хэрвээ энэ ертөнцөд үнэнхүү хоргодох сэтгэл алга болж, чин сэтгэлээсээ жинхэнэ гэртээ буцахыг хүсэх тэр үед хэн ч биднийг хориглож чаддаггүй, адын эзэн ч биднийг саатуулж чадахгүй. Гэтэл бидний үзэл, ухамсарт энэ замбуулинд мөн л бага зэрэг хоргодох бодол байх л юм бол тун олон саад бэрхшээлтэй болдог.

Аливаа төрөлтөн бүгд л өөр бусад төрөлтөнтэй харилцаа холбоотой байдаг гэж нэгэнт ярьчихсан, тиймээс та нарын хоромхон зуурын бодол чинь маш олон төрөлтөнд нөлөөлж, маш олон төрөлтний сэтгэлийг догдлуулж, тэднийг хөдөлгөөний нэгэн бүтэц хэсэг болгочихно, яг л машины системтэй адилхан, нэг товчлуурыг дармагц машин эхлээд нийтдээ хэлбэлзэж, ажиллаж эхэлдэг шиг. Энэ ертөнцөд хоргодох тиймэрхүү маш нарийн бодлыг заримдаа бид өөрсдөө ч сэрг мэддэггүй. Унтаж байгаа үедээ бид бодлоо хянаж чаддаггүй, бидний бодолд ертөнцийн жаргал эдлэх, бусдыг хорлох, эр, эмийн харилцааг хүсэх, мөнгө хулгайлах, бусдыг мэхлэх, бусдыг гүтгэх гэх мэтийн зүйл зүйлийн дадал зуршил суусан байдаг, тэр үед бидний бодол яг л нэг ерөнхий товчлуурыг дарсан шиг болж, өөр систем аяндаа эргэлдэж, бидний бясалгалын харш саад болдог, тиймээс харш саадыг мөн л бид өөрсдөө зохиосон байдаг.

Бид “Дэлхий дахин угаас амгалан, нисваанисыг бид өөрсдөө зохиосон” гэхийг байнга л сонсдог. Мэдээж бурхан бодьсадва маш нигүүлсэнгүй, биднийг авран туслах тун дуртай хэдий ч бид бас өөрөө өөрсдийгөө аврах хэрэгтэй, бурхан бодьсадва зөвхөн биднийг заан чиглүүлж, харж харгалздаг төдий. Бид замд явах үед тэд: “Та гутал өмсөх хэрэгтэй, тэгэхгүй бол хөл чинь шархлаж, цус гарна шүү!” гэж хэлж ч магад, эсвэл замын дунд дов сондуул ихтэй, гутлаа заавал бэхлэх хэрэгтэй гэж захьдаг.

Тиймээс багш чинь: “Та нар өөрсдөө хамгийн дээд багш мөн, багш надад туслахгүй, намайг адислахгүй байна гэх мэтээр багшийгаа буруутгаж болохгүй” гэж үргэлж хэлдэг. Бурхан бодьсадва хамгийн сайнаар тусалж чадна, гэвч бид өөрсдөө чармайхгүй бол яах ч аргагүй. Учир нь энэ ертөнцөд бид өөрсдөө дуртайяа бууж ирсэн болохоор бас өөрсдөө дуртайяа буцах ёстой, хэрвээ дургүй бол бурхан бодьсадва байлаа ч биднийг хүчээр дээш татан гаргаж болохгүй, зөн билиг болон хүч чадал хэрэглэж, энэ ертөнцийг тэр чигээр нь Төгс баясгалант орон луу татан гаргаж болох боловч бидний толгой тархи бэлтгэгдээгүй болохоор тэнд очсоны дараа эсэргүүцэж, тогтож сууж чадахгүй байж мэднэ, тэндхийн амьдралд дасахгүй, мөн л мөрийтэй тоглоом тоглох дуртай хэвээр, тийм хүмүүс мөрийтэй тоглоом тоглох хань нөхдөө хайгаад олохгүй бол уурлахдаа амгалан тайван Төгс баясгалант орныг үймүүлж мэднэ.

Архи уудаг хүмүүс мөн л архиа санан архины мухлаг хайна, хэрвээ хайгаад олохгүй бол арга бодож өөрөө архи нэрж ууна, ийм байдал үүсвэл Төгс баясгалант орон ямаршуухан орон болж хувирах вэ? Архины мухлагтай, бас мөрийтэй тоглоомын газартай болж, дараа нь Төгс баясгалант орон бүрмөсөн замбуутивийн орон болж, жинхэнэ бясалгалтан оршихын аргагүй болж хувирна.

Тиймээс хамаг төрөлтөн өөрөө өөрийгөө гэтэлгэх хэрэгтэй, бурхан бодьсатва зөвхөн заан чиглүүлж, тусалж дэмжих төдий. Яг л бяцхан хүүхэдтэй адил, том болохоос нь өмнө аав, ээж нь тэжээж өсгөнө, гэвч тэд бас өөрсдөө хоол идэх дуртай байх хэрэгтэй, тийм үү, үгүй юү? Өлсөхөөрөө өлслөө гэж хэлнэ, ярьж чадахгүй бол орилохоор нь бид өлсөж байгааг нь мэдээд сүү уулгана, хэрвээ уухгүй бол том болохгүй. Бясалгал хийх ч адилхан, багшийн хүчинд нэгмөсөн найдаж болохгүй. Бясалгал хийхэд мэдээж бэрхшээл тохиолдоно, хэрвээ тийм нөхцөл байдлыг үнэхээр хүлцэн тэсвэрлэж чадахгүй бол дотоодын багшаасаа тусламж гуйж болно, дотоодын багш бол бурхан бодьсатвагийн хувилгаан, гэвч харахад махан биетэй багштай адилхан байдаг.

Яагаад адил байдгийг би ярья! Учир нь нэг хүн Бурханы хутагт хүрсний дараа түүний гаднах дүр байдал нь хувирч өөрчлөгддөггүй, энэ ертөнц дэх бие махбод нь дээд төвшин дэх бие махбодтойгоо адилхан байдаг болохоор гадна талд, эсвэл дотооддоо харсан багш бүгд адилхан байдаг, ойлгож байна уу? Бидний сонссоноор Арьяабал Бурхан замбуутивд хүний төрөл авах үеийн дүр төрх нь бараг иймэрхүү (Багш Арьяабал бурханы хөргийг заав) байсан гэдэг. Бидний бясалгаж суух үедээ хардаг Арьяабал Бурхан бол Түүний энэ ертөнцөд амьд байсан үеийнх нь дүр төрх юм, ихэнх хүний харсан нь бүгд л иймэрхүү байдалтай байдаг. Учир нь Тэрээр бясалгал хийгээд ийм төвшинд хүрэх үед Түүний гадна дүр төрх нь өөрчлөгддөггүй, жирийн үеийнхтэйгээ адилхан байдаг, Бясалгал хийгээд Бурханы хутагт хүрэх үедээ ямар төрхтэй байсан нь хожим нь ч гэсэн хувирч өөрчлөгддөггүй. Жишээ нь, Шагжамуни Бурхан бидний энэ ертөнцөд байхдаа Бурханы хутагт хүрэх үедээ ийм байдалтай (Багш Бурхан багшийн хөргийг заав) байсан бол Түүний шавь нар нь бясалгаж суух үедээ хардаг дотоодын багш нь мөн л ийм байдалтай харагддаг, гэхдээ нилээд үзэсгэлэнтэй бөгөөд гэрэл гялбаатай. Хэрвээ билгийн мэлмий чинь нээгдсэн бол Түүний махан бие нь ч тун үзэсгэлэнтэй, гэрэл гялбаатай, гоё сайхан байдгийг мэдэж болно. Тиймээс зарим багш юмуу, зарим хүн бясалгаад дээд дэсэд хүрэх үед гадаад дүр байдал нь дотоодтойгоо ижилхэн болдог. Учир нь тэр Бурханы хутагт хүрэх, бодь мөрийг олох үедээ гаднах байдал төрх нь ямар байдалтай байсан, дотоод дүр нь бас тийм байдал төрхтэй байж, хувирч өөрчлөгддөггүй.

Гэхдээ өөрчилсөн ч бас болно, гэвч ихэнхдээ өөрчилдөггүй. Тэр өөр төрхөөр хувирч чаддаг хэдий ч тэгдэггүй, яагаад вэ гэвэл түүний ажил нь зарим хүнийг гэтэлгэх явдал байдаг бөгөөд аль нэг бүлгэм, нийт хүмүүс түүний байдал төрхөд дасчихсан байвал угийн тэр төрхөө хадгалдаг. Түүний шавь, сурагч нар нь багшийнхаа байдал төрхөнд

нэгэнт дасчихсан болохоор дотоод дүр нь ондоо байдалтай болж хувирвал шавь нар нь танихаа больж, огтхон ч итгэж чадахгүй болж мэднэ.

Багшийгаа дагаж олон жилээр бясалгаж, багшийнхаа гадна төрхөнд дасчихсан байвал хэзээ нэг өдөр дотоодын багшийгаа харах үед тэрээр ондоо төрхтэй харагдвал та лавтай: “Та чинь хэн болчихов?” гэж асуух мөртлөө дургүй хүрч, итгэл алдчихаж мэднэ. Учир нь хүн гэдэг угаас ихэд баригдаж хүлээслэгддэг, бид бурхны дэсэд хүрэхээс өмнө мөн л тийм баригдмал хандлагатай байдаг, тийм үү, үгүй юү? Бид ямар нэгэн зүйлд дадчихвал тэр дадлаа өөрчлөх дургүй, бид өөрсдийн хамаатан садан болон найздаа өөр хүнээс илүү итгэдэг, тийм үү, үгүй юү? Тиймээс багш хүн заавал нэгэн тогтсон дүр байдалтай байж, шавь нартаа танигдах хэрэгтэй.

Таныг бясалгаж суух үед дотоодын багш чинь: “Одоо багшийгаа дагаж Төгс баясгалант оронд очьё!” гэж хэлбэл тэр даруй багшийгаа дагаж явдаг. Хэрвээ Бодьдармаа, эсвэл урьд өмнө нь таньдаггүй байсан Их Багш ингэж хэлбэл санаа амаргүй болж, итгэж зурхлэхгүй, ингээд үүнийг өөрийн биеийн харш саад юм байна гэж боддог, гэтэл зарим хүн дорхноо итгэчихдэг. Тиймээс бурхан бодьсадва шавь нартаа заавал урьдынхтайгаа адилхан байдал төрхөөр харагдах хэрэгтэй, гэтэл өөр хүмүүст харин ондоо байдал төрхөөр харагдаж магад, яагаад гэвэл Бурхны хутагт хүрэх үед хэлбэр дүрс байдаггүй, ямар байдал төрхөөр хувирсан ч ер болно.

Хожим та нар Бурханы хутагт хүрэхэд мөн л адилхан, одоо ийм дүр байдалтай байсан бол хожим Бурханы хутагт хүрснийхээ дараа мөн л ийм байдалтай байна, дараа нь шавьтай болох үед мөн л ийм төрхтэй байж, хувирч өөрчлөгдөхгүй, гэхдээ үс чинь жаахан урт болж мэднэ. Учир нь зарим хүн олон хоногоор бясалган суух, эсвэл битүүмжлэн бясалгахдаа гадна төрхөө огт хайхардаггүй, үсээ ч хусдаггүй болохоор урт үстэй явдаг, тэгээд мөр бүтсэний дараа мөн л ийм байдал төрхөө хадгалдаг, мэдээж тэр мөн л гэрээс гарагч хэдий ч урт үстэй явдаг, яг л Шагжамуни Бурхан шиг, Түүний үс нь маш урт, тийм үү, үгүй юү? (Багш Шагжамуни Бурханы хөргийг заав)

Энэтхэгийн зарим хувраг бас үсээ хусдаггүй, Бурхан багш шиг үсээ ороогоод уячихдаг, ингэсэн ч бас болно, учир нь тэд заримдаа хэсэг хугацаагаар битүүмжлэн суудаг болохоор үсээ хусдаггүй. Бодьдармаагийн үсийг харахад мөн л маш урт, гэвч Тэр хайхардаггүй, тэгээд Тэр Бурханы хутагт хүрснийхээ дараа мөн л тийм янз төрхтэй байжээ. Тиймээс Шагжамуни Бурхан бурханы хутагт хүрэх үеийн байдал төрх нь ямар байсан бол хожим мөн л тийм байдалтай байсан бөгөөд тэр дахин үсээ хусуулж болох байсан ч тэгсэнгүй. Тэрээр гаднах дүр байдлыг хайхардаггүй, тиймээс бидний одоо мэддэг Шагжамуни Бурхан урт үстэй, тийм биш үү.

Дөнгөж эхлэн бясалгах үедээ заавал гадна талын багш болон дотоодын багшдаа найдах хэрэгтэй. Гэхдээ бид бас өөрсдөө угаас бурхан бодьсадва мөн гэдгээ мэдэх хэрэгтэй бөгөөд энэ байр сууриндаа

дахин буцаж бурхан бодьсадва болох хэрэгтэй. Харин цаг үе болгонд, өдөр болгон зөвхөн шавь байгаад л байж болохгүй. Бясалгах нь угаас байсан бурхан бодьсдавагийн байр сууриндаа буцаж, хамаг төрөлтийг гэтэлгэхийн төлөө билээ.

Хэрвээ нэгэн бурхан бодьсадва хүний амьдралаар амьдраагүй, үхэж, төрөх сансрын хүрдэнд ерөөс эргэлдээгүй бол хамаг төрөлтийг гэтэлгэж чадахгүй, яагаад вэ гэвэл Тэр дэндүү ихээр билиг нээгдсэн болохоор Түүний бодол сэтгэлд зовлон гэж байдаггүй, зовлон гэж юу болохыг мэддэггүй, тиймээс заавал бууж ирээд хүн, амьтан, адгуус болж, үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэж байж л хамаг төрөлтийг бодол сэтгэлийг ойлгож чадна.

Бууж ирээд хамаг төрөлтийн амьдралыг амсаж туулахгүй бол хамаг төрөлтийг гэтэлгэж чадахгүй бөгөөд өөрсдөө бурхан мөн гэдгээ, мөн өөрсдөд нь ямар ямар чадвар байдаг гэдгээ мэддэггүй. Бид угаас бурхан мөн, одоо бясалгал хийж дахин бурхны дэсэд хүрнэ. Хэрвээ бурхан биш юм бол хичнээн жилээр бясалгасан ч Бурханы хутагт хүрч чадахгүй. Жишээ нь, нэг хэсэг төмрийг хичнээн жилээр хадгалсан ч шижир алт болж чадахгүй, алт бол алт, алмаас эрдэнийн чулуу бол алмаас эрдэнийн л чулуу, хоол бол хоол, элс бол элс, элсийг хичнээн удаан чанасан ч хоол болж чадахгүй.

Багш чинь хичнээн ярьсан ч ерөөсөө л адилхан зүйлийг ярьдаг, та нарт өөрсдийг чинь таниулах гэж байгаа болохоор мэдээж авшиг хүртээж, ном уламжлан сонорыг чинь нээж, билгийн мэлмийг чинь нээнэ, өдөр болгон гадна талын билиг ухааны тухай ярьж, хэрхэн бясалгах талаар та нарт зааж сургана, гэвч та нар бас өөрсдөө бясалгах хэрэгтэй, харин зөвхөн багшийн хүчинд л найдаж болохгүй.

Мэдээжээр, авшиг хүртээх үед төрөл төрлийн үйл түйтгэрийг чинь бүгдийг нь ариусган цэвэрлэдэг, учир нь бидэнд угаас үйл түйтгэр гэж байгаагүй болохоор шууд л тасалчихна. Учир нь бидэнд угаас үйл түйтгэр гэж байгаагүй болохоор замбуутивд амьдраагүй бол авшиг хүртэх шаардлагагүй, угаас үйл түйтгэр байдаггүй, гэвч энэ замбуутивд байгаа л юм бол бас заавал үйл түйтгэрийг ярих хэрэгтэй мөртлөө бас угааж цэвэрлэх хэрэгтэй, эс тэгвэл дээш гарч чадахгүй.

Бид бясалгахгүй бол дэс чинь дээшлэхгүй, дэс чинь өндөр биш бол хамаг төрөлтийг гэтэлгэж чадахгүй, бурхны дэсэд хүрч чадахгүй, зөвхөн хэрэгцээгүй бурхан, хэрэгцээгүй бодьсадва болдог. Тиймээс заавал бясалгах хэрэгтэй, бясалгаад өөрийгөө бурхан гэдгээ дахин таних үедээ л буцаж болно. Гэтэл тэр үед өөрөө нэгэн төгс төгөлдөр мөрийн хутгийг олчихсон гэж боддоггүй, бясалгал хийх нь зах хязгааргүй байдаг, хэрэв бид бясалгаад ямар нэг төвшинд хүрээд зогсчихвол тун харамсмаар хэрэг болно. Бясалгал хийхэд нэгэн дээвэр шиг эцэс сүүлчийн зорьсон газар гэж байдаг бол тэнд хүртэл бясалгасны дараа дахин урагшлахаа больчихдог, тэгвэл миний бодлоор дэндүү эрх чөлөөгүй болж, дэндүү хүлэгдчихнэ.

Одоо та нар гэрийн дээвэр шиг ямар нэгэн эцэс төгсгөлийн орон байна гэж төсөөлөн бод! Тэгээд бид тэнд хүрсний дараа үргэлжлүүлэн



дээшээ явж чадахаа болино, ийм байдал нь ялтантай адилхан болчих юм биш үү? Нирвааны шорон болж хувирдаг, энэ ертөнц бол жижиг шорон, нирваанд буцвал томхон шиг шоронтой байна, гэвч бүгд л шорон. Тиймээс бясалгал хийхдээ хичээн болгоомжлох хэрэгтэй, бясалгалд эцэс төгсгөлийн орон гэж байдаггүй. Гэхдээ бясалгах тусмаа баяр жаргалтай болдог, харин эцэс төгсгөлийн орон байхгүй гэхээр бясалгахаа больчих биш шүү, бясалгахгүй бол бид ихэд зовж шанална. Та нар баяр жаргалтай байвал бясалгах шаардлагагүй байх биз, гэтэл энд дэндүү зовлонтой, дэндүү харанхуй мунхаг, дэндүү ухаангүй тэнэг байгаа болохоор бясалгал хийж баяр жаргалын эх булгийг хайх хэрэгтэй. Хүн болсон ч заавал тийм ихээр зовж шаналж, тийм цаг завгүй, тийм харанхуй мунхаг байх албагүй, тиймээс бид бясалгал хийж бурханы хутагт хүрэх эрмэлзэл хүсэлтэй байх хэрэгтэй.

**Асуулт:** Багш аа! Энэ ертөнцөд чөтгөр гэж байдаг уу?

**Их Багш:** Байдаг, бас байдаггүй. Байдгийн шалтгаан нь бид тэдэнтэй холбоотой, тэднийг харж чаддагаас болж байгаа юм. Бясалгал хийгээд хүн болон чөтгөр алин нь ч байхгүй төвшинд хүрч болно, чөтгөр бол мөн л нэгэн төрөлтөн. Дээд дэсэд хүрсэн бясалгагчийн хувьд чөтгөр байсан ч чөтгөр биш болдог, тиймээс байдаг, гэвч байдаггүй гэдэг. Энэ нь та нарын дэсээс хамаарна.

Чөтгөр тун хөөрхөн, та хичээнгүйлэн бясалгавал чөтгөр таныг асарч харгалздаг, тэр тун ухаантай, таны өмнөөс цэцгийг чинь усалж, хашаан дахь ногоог чинь арчилж, юу хий гэвэл түүнийг чинь хийнэ, та хичээнгүйлэн бясалгадаг л бол таныг хүндлэн хайрлана, яг л та нар багшдаа тун хайртай байдагтай адил. Чөтгөр та нараас бүр ч илүү багшийг чинь хайрлаж ч магад. Чөтгөр тийм ч хэцүү биш, бидний боддог шиг тийм байдалтай биш, хэрвээ бясалгал чинь тун сайн бол чөтгөр чамд төвөг учруулахгүй, чөтгөр хэрвээ ирсэн байвал бас ч хөөрхөн шүү! Хэдийгээр харахад тун муухай байж магад ч хөөрхөн ааштай, тэгээд тэр бас бясалгал хийдэг бөгөөд хэзээ нэгэн өдөр Бурханы хутгийг олох юм. Багш чинь урд нь Америкт оройн уншлага хийж байх үед тун олон чөтгөр ирдэг байсан, бүгд л цагаан хувцастай, хэдэн зуун чөтгөр хэдэн эгнээ болж жагсдаг, тэд ирэхдээ гэмшин ухаарч, бясалгал хийж, багшийн чинь ном уншихыг сонсдог байв, үүнийг өөр хүн ч бас харсан байсан. Багш нь тэндээс явсан болохоор одоо чөтгөр тэнд очдог эсэхийг мэдэхгүй байна.

Энд бас чөтгөр байдаг, одоо бас маш олон чөтгөр ирж ном сонсдог, тэд бол тун хөөрхөн төрөлтөн, гэвч цэцэн сэргэлэн билиг ухаанаар тун бага, сонсож ойлгох чадвар тун доор, таньж мэдэх нь удаан байдаг, хүнтэй адилгүй. Заримдаа тэд муу хэрэг үйлддэг ч өөрөө мэддэггүй, тиймээс та ингэж болохгүй шүү гэж сайн сургах хэрэгтэй, хэрвээ тэр танд дуртай бол дахин муу хэрэг хийхээ болино. Нэг хүнд хэрвээ хангалттай чадвар байвал түүнийг заан сургаж чадах бөгөөд танд дуртай болж: “За, за, би дахиж тэгэхээ болино” гэж хэлнэ. Та яагаад ийм муу хэрэг үйлддэг юм бэ? гэж асуувал хүмүүст дуртай байдаг болохоороо тэгдэг гэж хэлнэ. Тэр хүмүүст дуртай боловч ингэх нь муу хэрэг гэдгийг мэддэггүй болохоор

хүмүүсийн сэтгэлийг зовоох зүйл хийдэг. Чөтгөрийн ухамсрын төвшин нь хүний дээдэй адилгүй, яг л нохой шиг, танд дуртай бол тан луу хуцах юмуу, бие дээр чинь авирч мацаж гараад хувцсыг чинь маажиж урдаг, эсвэл завааруулчихдаг. Муур ч гэсэн ийм, учир нь тэдний ухамсрын төвшин нь биднийхтэй адилгүй байдаг.

**Асуулт:** Чөтгөр бясалгал хийж болдог уу?

**Их Багш:** Болно, гэвч бясалгах нь бидэнтэй адилгүй, тэд бясалгаад дорхноо Бурханы хутагт хүрч чадахгүй бөгөөд энэ төрөлдөө бурхан болж чаддаггүй, “хүний бие”-тэй байж л энэ төрөлдөө Бурханы хутагт хүрч чадна. Тэд өөрсдийнхөө аргаар бясалгадаг, тэд сонсож чадна, үгүй бол бид өглөө, оройн уншлага хийхийн хэрэг юу билээ? Гэвч чөтгөр л сонсож ойлгодог юм биш, адгуус ч гэсэн ном сонсдог, чулуу бас сонсдог, та нар Дао Шен (Tao Sheng) номын багшийн тухай сонссон уу? Тэр ном тайлахад хүмүүс сонсохгүй болохоор нь ууланд гарч чулуунд ярьжээ, ярьж дууссаны дараа чулуунаас зөв үү, буруу юу гэж асуусанд чулуу толгой дохисон гэдэг.

Чулуу байтал бас ном сонсож чаддаг юм чинь дүрстэй төрөлтөн яагаад чадахгүй байх вэ? Гэтэл би Америкт очих үедээ нэгэн номын багшид бид ногоо идсэн ч бас муу нөлөөтэй, учир нь ногоо бас амьтай гэж ярьсан чинь намайг буруу номтны ёсыг ярьж байна гэсэн. Түүний бодлоор бол ногоонд амь нас байдаггүй аж. Хэрвээ чулуу ном сонсож чаддаг юм бол ногоонд яагаад амь нас байж болохгүй билээ? Угаас ногоог идэхгүй бол хамгийн сайн, гэвч бид махан биеэ хамгаалж, бясалгал хийхийн төлөө заавал бага зэрэг хооллох хэрэгтэй, юу ч идэхгүй бол энэ махан биеэ хамгаалж чадахгүй. Өөрөө сайн ойлгохгүй болохоор бусдыг буруу номтон гэж гүтгэдэг нь үнэхээр санаа зовмоор хэрэг шүү.

“Баатар явагч их хөлгөн судар”-г Бурхан Багш бас: “Бурхан бодьсатва нигүүлсэнгүй сэтгэлээсээ болж өвсөн дээгүүр алхдаггүй, цэцгийг дураараа тасалдаггүй” гэж хэлснийг тэмдэглэсэн байдаг, энэ нь өвс ургамал ч сүнстэй, мэдрэмж ухамсартай байдаг гэдгийг илэрхийлж байгаа хэрэг. Би ингэж хэлэхэд тэр харин багшийг чинь буруу номтон гэнэ, ийм хүнд юу ч ярьсан ойлгохгүй болохоор яах ч аргагүй.

Буддын шашны одоогийн байдлыг харахад үнэхээр санаа зовмоор байна, гадаад улс оронд очоод бага зэрэг мэдлэг сурч, сургууль төгссөн үнэмлэх аваад доктор болчихдог, тэгээд улсдаа буцаж ирсний дараа дур зоргоороо ярьдаг, гэхдээ өөрөө харин буддын шашны судар номын гүн далд нууцлаг сургаал ёсыг ойлгодоггүй. Ногоонд бас амь нас байдаг, энэ бол ерөөс өчүүхэн хэрэг, ойлгоход тун хялбар зүйл, иймхэн юмыг мэдэхгүй байж тиймэрхүү гүн далд нарийн нууцлаг номыг хэрхэн ойлгож чадах билээ? Тэгээд өөрөө ойлгодоггүй болохоор ойлгодог нэгнийг буруу номтон гэж гүтгэдэг.

Тиймээс Үнэн ёсыг сургахад тун хялбаргүй, эгэл ертөнцийн зүйлсийг сургахад тун хялбар, учир нь ихэнх хүн биет бодит зүйлийн талаар сонсоод дасал болчихсон байдаг бөгөөд тиймээс л тун харанхуй мунхаг байж жинхэнэ ёсыг мэддэггүй, бүгд л тиймэрхүү доктор, эсвэл

буддын шашны сургууль гэх мэтэд найддаг болохоор хожим нь өөр нэгэн хүн Үнэн ёсыг ярьсан ч тэд харин сонсдоггүй.

**Асуулт:** Багш аа! Тун олон Их Багш самадид орохдоо хэдэн сараар самадидаа байдаг гэж маш олон номд тэмдэглэсэн байдаг, бид энгийн үед бясалгаж суухдаа бас хэдэн сараар самадид байж чадах уу?

**Их Багш:** Байж чадна, таны бясалгалын төвшин чинь тийм байж чаддаг л юм бол, өлсөхгүй бөгөөд хөдлөх дургүй байвал самадигаасаа гарах хэрэг юун? Самадид орсон ч болно шүү! Яагаад болохгүй гэж? Өлсөхгүй бол самадигаасаа гарч, хоол идэх хэрэггүй. Тэд огтхон ч хөдлөлгүй суудаг хэдий ч сүнс нь аль хэдийн дээд төвшинд оччихсон, зөвхөн махан бие нь үлдсэн төдий л байдаг, махан бие нь байдаг ч сүнсэн бие нь байдаггүй, ухамсар нь байхгүй.

**Асуулт:** Хүн бол Гэрэл, Аялгуут тэнгэрийн орноос бууж ирсэн гэж би судар номноос харсан, гэхдээ би биологийн ухааны мэргэжил сурсан хүн, бидний мэргэжлийн номд хүн бол сармагчнаас хувирч гарч ирсэн гэж бичсэн байдаг.

**Их Багш:** Гэрэл, Аялгуут тэнгэрийн орны төрөлтөн зөвхөн нэг хэсэг хугацаанд бууж ирсэнээс биш, тэндээс энэ замбуутивд үргэлж бууж ирдэг юм биш, Гэрэл, Аялгуут тэнгэрийн орноос бууж ирсэн гэдэг нь зөвхөн тэр хэсэгхэн хугацааг л хэлж зааж байгаа хэрэг, гэтэл түүнээс бүр ч эрт үед өөр тэнгэрийн төрөлтөн бууж ирсэн ч байж мэднэ. Энэ ертөнц нь бүтэх, тогтнох, эвдрэх, мөхөх үйл явцыг нилээд хэдэн удаа туулж өнгөрүүлжээ, тэр болгонд л Аялгуут тэнгэрийн орны төрөлтөн бууж ирсэн биш. (Шавь: Хувьслын онол баримталдаг сургаалтнуудын ярьснаар хүмүүс бид бичнээс хувирч гарсан гэдэг.) Бид бараас хувирч ирсэн ч байж магад (Бүгд инээлдэв), учир нь урд төрөлдөө амьтан байсан биш үү? Бид чөтгөр, хүн, адгуус гэх мэтийн төрөл авч байсан, харин зөвхөн сармагчин л болсон төдий биш, бас бар болж байсан, буддын шашны судар номд ярьснаар бол хар санаатай хүн нас барсныхаа дараа бар болдог гэсэн, яагаад гэвэл мах их идсэн болохоор дахин төрөл авахдаа бар, арслан мэтийн хэрцгий амьтан болж, нилээд олон төрөл сольж байж л дахин хүний төрөл олдог.

Зарим хүн амьтдаа тун хэрцгий бол нас барсны дараа могой болж хувирдаг, тэгээд маш урт хугацаа өнгөрсний дараа хүн болдог, гэхдээ хүн болсон ч хар муу сэтгэлтэй хүн болдог, хэрвээ хэрцгий амьтнаас хүний төрөл авсан бол мөн л тун хэрцгий зантай байж, ер нь бусадтай маргалдан тэмцэлдэх хандлагатай байдаг.

Тэгэхлээр биологич хүн бид сармагчнаас хувирсан гэж хэлдэг нь бас буруугүй, гэхдээ зөвхөн сармагчнаас ч биш бар, арслан гэх мэтийн ямар нэг амьтнаас хувирч ирэх боломж ч байж болно, үүнийг бүтээгч зохицуулдаг. Бид наян дөрвөн мянган хэлбэрийн төрөлтний амьдралыг суралцаж байж л аливаа төрөлтний зовлонг ойлгож чаддаг, тиймээс судар номд бурхан бодьсатва амьтан болж хувирдаг нь суралцахын төлөө, ингэж байж л хожим хамаг төрөлтнийг гэтэлгэж чаддаг гэж ярьсан байдаг.

**Асуулт:** Тарни унших үедээ хэрвээ зөв дуудаж чадахгүй бол үр дүн

нь тийм сайн биш байдаг уу?

**Их Багш:** Тод унших нь мэдээж илүү сайн.

**Асуулт:** Хэрвээ бидний хамаатан саданд төвөг бэрхшээл учирч, үйл түйтгэртэй болсон бол тэднээр илүүхэн шиг өглөг үйлдүүлэх хэрэгтэй юу?

**Их Багш:** Аливаа төрөлтөн бүгд л бидний хамаатан садан мөн, харин зөвхөн аав, ээж, садан төрөл чинь л бидний хамаатан садан мөн гэж бүү бодоорой! Бидэнд хэрвээ ялгаварлаж алагчлах сэтгэл төрөхгүй бол аливаа төрөлтөн бүгд өглөг үйлдэж болно. Гэхдээ “би” өглөг үйлдэж байгаа гэж бодож болохгүй, учир нь бид маш их юмтай байвал бусадтай хуваалцаж нь зүйтэй, яг л та нар бясалгалын төвд ирэх болгондоо багшдаа олон зүйлийг өргөл болгож өргөдөг, би тэр бүх юмыг бүгдийг нь бусад хуваагаад өгчихдөгтэй адил, гэхдээ би ерөөс өглөг үйлдэж байгаа гэж боддоггүй. Энэ нь манай нийгэмд ч бас адилхан байдаг, хэрвээ хэн нэг хүнд үлэмж их эд зүйл байвал бусад хуваан өгч эдлүүлж болно, энэ дэлхийд хүн болгон илүү эд зүйлээ бусад хуваан өгдөг бол дэлхий дахин лавтай энхтайван, баяр жаргалтай болж, дайн дажин, хулгай дээрэм байхгүй болно. Тиймээс өглөг үйлдэхдээ өглөг үйлдэж байна гэж битгий бод, ингэж бодох нь тун доод дэсийн хэрэг, өглөг үйлдчих юутай юм бэ? Бид энэ дэлхийд ирэхдээ юу авч ирсэн юм? Юу ч үгүй гар хоосон ирсэн биш үү? Нэг зоос ч авч ирээгүй, ганц ч шүд байхгүй, ширхэг үс ч байхгүй, юу ч үгүй ирээд энэ ертөнцөөс хоол зээлэн идэж, хувцас зээлж өмсдөг, гар хоосон ирээд гар хоосон буцдаг юм чинь өглөг гэмээр юм юу байх билээ, өглөг гэж бид юу өгч чадах вэ? Бүгд л энэ ертөнцийн юм, бид зөвхөн зээлж хэрэглээд дахин буцааж байгаа л төдий, ингэж бодох нь л зөв, үгүй бол “би гэх үзэл” дэндүү их болж, өглөг үйлдэх болгондоо “би” үйлдэж байна гэж бодох нь ямар ч ач тус байхгүй.

**Асуулт:** Зарим хүн бусдыг мэхэлж мөнгө зээлдэг, бид хэрвээ үүнийг мэдэж байвал түүнд мөнгө зээлүүлэхээс татгалзаж болох уу?

**Их Багш:** Татгалзах хэрэгтэй, учир нь шаардлагатай үед л тусалж, шаардлагагүй бол туслах хэрэггүй. Зарим хүн үнэхээр өлссөн байвал та хоол өгч, хувцас хунар дутагдсан байвал хувцас өгч болно, өвчин тусч эмчлүүлэх мөнгөгүй үед нь түүнд мөнгө өгч болно. Гэхдээ бусад ашиглуулж болохгүй, тэгэх юм бол бид тэдний үйлийн үрийг үүрнэ, бусдыг хууран мэхэлж байгааг нь мэдэж байгаа мөртлөө мэхлүүлчихвэл тэнэг хүн болчих биш үү? Хэрэгтэй бол тусалж, хэрэггүй үед нь туслах хэрэггүй, хэзээ, хаана ч бүгд адилхан. Зарим хүн гадуур гарч гуйлгачилж явдаг ч их мөнгөтэй байдаг, гуйлгачин ч гэсэн архи ууж, гоё хувцас өмсөж, зоогийн газарт орж, амтаг идээ иддэг, тэр ч байтугай гэр байшин, машин худалдан авдаг, ийм хүмүүс мэдээж бусдыг залилан мэхлэж байдаг хэрэг. Бас зарим нь хүүхэд хулгайлан гуйлгачны дүртэй болгодог, тэр ч байтугай зэрэмдэг болтол нь зодож, дараа нь тэднийг гуйлгачин болгон бусдыг мэхлэдэг, тэд гуйлгачин болохгүй гэвэл нэн хорсолтойгоор зоддог. Тиймээс өглөг үйлдэж, бусад туслахдаа нөхцөл байдлыг нь тодорхой магадлах хэрэгтэй.

## ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС

Насан турш веган (ургамал) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “ямар үйл хийнэ, тийм үр байна” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг.

Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

## ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээх шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдэснд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл үсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар

өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ургамал хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодис хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой” гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй” гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4.5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно.

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.



## ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

## ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг

малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

## АМЬТНЫ ЗОВЛОН

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Ургамал хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

## ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар ургамал хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хувраг ургамал хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Isaiah: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол хүний үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаачид, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс ургамал хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэйвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Алберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол ургамал хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс ургамал хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, цэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

## ИХ БАГШ АСУУЛТАД ХАРИУЛЖ БАЙНА

**Асуулт:** Амьтны мах идэх нь мэдээж амь хороож буй хэрэг. Ургамал ногоо идэх нь амь хөнөөж байгаа явдал биш үү?

**Их багш:** Ургамал идэх нь мэдээж амь хороож буй бөгөөд үйлийн үртэй. Гэвч харьцангуй бага. Өдөр бүр Арьяабалын бясалгалыг хоёр цаг хагас хийвэл энэ үйл түйтгэрийг арилгаж чадна. Бид хооллох шаардлагатай тул ухамсрын түвшин доогуур, хамгийн бага зовууртай хүнсийг сонгохоос өөр аргагүй болдог. Ургамлын 90% нь уснаас бүтэх бөгөөд зовлон шаналлыг бараг мэдрэхээргүй ухамсрын түвшинтэй. Тэгээд ч бид ургамал ногооны үндсийг тасалдаггүй. Харин навч мөчрийг тасалснаар бэлгийн бус үржилд нь тусалдаг болохоор ургамалд ашигтай. Цэцэрлэгчид ургамлыг өтгөн, сайхан ургуулъя гэвэл хайчилж засаж байх хэрэгтэй гэдэг. Жимсний хувьд гэвэл боловсорсон жимс анхилам үнэр, сайхан өнгө, гайхалтай амтаараа хүмүүсийн идэх дур хүслийг төрүүлж өөртөө татдаг. Үүнийхээ ачаар жимсний мод өргөн уудам газарт үрээ тарааж чаддаг. Хэрэв бид жимсийг нь авч идэхгүй бол тэр нь хэт боловсроод газар унаад ялзарна. Үр нь модны титмийн сүүдэрт халхлагдаад ургаж чадахгүй болно. Тийм болохоор ургамал жимсийг идэх нь зүй ёсны хэрэг бөгөөд энэ нь тэдэнд огтхон ч зовлон шаналал авчрахгүй.

**Асуулт:** Цагаан хоол иддэг хүн намхан, туранхай, харин мах иддэг хүн өндөр, тэнхлүүн гэж ихэнх хүн боддог. Энэ үнэн үү?

**Их багш:** Ургамал хоолтон хүн намхан туранхай байх албагүй. Шим тэжээлээ тохируулж чадвал тэд ч бас нэгэн адил өндөр чийрэг болж чадна. Та заан, бух, анааш, усны үхэр, адуу гэх мэт том амьтад зөвхөн жимс ногоогоор хооллодгийг бодоод үз. Тэд махчин амьтадас хүчтэй, номхон дөлгөөн, хүнд тустай. Харин махчин амьтад хэргийг догшин, ямар ч тусгүй. Хэрэв хүмүүс амьтны мах их идвэл тэдний адгууслаг чанарт автана. Мах иддэг хүмүүс заавал өндөр, хүчтэй байдаггүй бөгөөд дундаж наслалт нь тун богино байдаг. Эскимосчууд бараг дан мах хэрэглэдэг. Тэд өндөр, хүчтэй, урт насалж байна уу? Үүнийг та бүхэн маш тодорхой ойлгох хэрэгтэй.

**Асуулт:** Ургамал хоолтон өндөг идэж болох уу?

**Их багш:** Болохгүй! Өндөг идэх нь бас л амьтан хороож байгаа хэрэг. Дэлгүүрт худалдаж байгаа өндөг үр тогтоогүй тул түүнийг идэх нь амьтныг хороосонд тооцогдохгүй гэж зарим хүн хэлдэг. Энэ яриа зөв юм шиг сонсогдовч тийм биш. Ерөөл барилдлага бүрдээгүйгээс үр тогтож дэгдээхэй болоогүй ч өндөг амьтай хэвээр байдаг. Тийм биш бол өндгөн эсээс бусад эсэд үр тогтохгүй биз дээ. Өндгөнд хүний биед зайлшгүй хэрэгтэй уураг, фосфор, тэжээллэг бодис байдаг гэж баталдаг ч бид буурцгаас уургаа, төмс болон бусад ногооноос фосфорыг авч болдог.

Эрт, эдүгээгийн дээд хуврагууд<sup>23</sup> мах, өндөг иддэггүй ч урт насалдаг байсан. Жишээлбэл, Их Багш Иньгуан зоог барихдаа аяга ногоо, жаахан

будаа иддэг байсан ч ная гаруй насалжээ. Өндөг нь зүрх судасны өвчин үүсгэдэг холестериньг ихээр агуулдаг. Америк, Формосад зүрх судасны өвчин нь нэг номерын үхлийн шалтгаан болоод байна. Өвчтэй хүмүүсийн ихэнх нь өндөг иддэг хүмүүс байдаг гайхах зүйлгүй.

**Асуулт:** Бид яагаад тэжээж өсгөсөн үхэр, гахай, тахиа, нугасаа идэж болохгүй гэж?

**Их багш:** Эцэг, эхчүүд ч бас хүүхдүүдээ өсгөдөг. Эцэг, эхэд үр хүүхдээ идэх эрх бий юу? Амьд амьтад бүгд амьдрах эрхтэй. Хэн ч тэдний эрхийг булааж болохгүй. Хонконгийн хуулиар амиа хорловол гэмт хэрэгт тооцогддог тул бусдыг хөнөөх талаар дурдсаны ч хэрэггүй.

**Асуулт:** Амьтан угаасаа хүмүүст идүүлэх гэж төрдөг. Хэрэв хүмүүс амьтныг идэхгүй юм бол бүх дэлхий мал адгуусаар дүүрчихнэ. Тийм биш гэж үү?

**Их багш:** Энэ чинь ямар ч утга учиргүй санаа байна. Амьтныг алахаас өмнө идүүлэхийг хүсэж байна уу гэж тэднээс асуудаг билүү? Амьтан бүхэн амьдрахыг хүсэж, үхэхээс айдаг. Бид бард идүүлэхийг хүсдэггүй байтал амьтад яагаад бидэнд идүүлэх ёстой гэж? Хүн төрөлтөн дэлхийн бөмбөрцөг дээр хэдэн аравхан мянган жил л амьдарч байна. Гэтэл тэднийг үүсэхээс өмнө маш олон төрлийн амьтан аль хэзээний оршиж байжээ. Тэд дэлхийн бөмбөрцгийг дүүртэл хэт олширсон гэж үү? Амьд амьтад байгаль экологийн тэнцвэрт оршиж байдаг. Хүнс тэжээл, амьдрах орон зай хүрэлцэхээ болиход тоо толгой нь эрс буурч тохирох түвшинд нь очдог.

**Асуулт:** Би яагаад веган хоолтон байх ёстой вэ?

**Их багш:** Миний дотоодын Эзэн Бурхан үүнийг хүссэн учраас би веган хоолтон болсон. Ойлгож байна уу? Мах идэх нь хөнөөгдөхийг үл хүсэх орчлонгийн хууль ёсыг зөрчинө. Бид өөрсдөө үхлийг хүсдэггүй, мөн өөрсдийнхөө юмыг алдахыг хүсдэггүй. Хэрэв бид бусдад ингэж хандвал энэ нь өөрийнхөө эсрэг үйлдэж байгаа хэрэг болох бөгөөд энэ нь биднийг зовоож шаналгана. Таны бусдад хийсэн хор хөнөөлтэй үйлдэл бүхэн өөрийг тань зовоодог. Та лав өөрийгөө хазаж хутгалж чадахгүй, болох ч үгүй. Үүнтэй адилаар та амь хороож болохгүй, хороовол амьдралын хуулийг зөрчсөн явдал болно. Ойлгож байна уу? Өөрсдийгөө зовоон шаналгах үйлдлийг хийх хэрэггүй. Ингэх нь өөрсдийгөө ямар нэг байдлаар хязгаарлаж байгаа хэрэг биш. Амь нас маань амьдралын бусад бүх хэлбэр лүү өргөжин тэлж байгаа хэрэг. Бидний амь нас зөвхөн энэ биеэр хязгаарлагдахгүй, харин ч амьтан хийгээд бүхий л төрөлтий амь амьдралд хүрч тэлэх болно. Энэ нь биднийг улам эрхэмсэг, улам агуу, улам баяр хөөртэй, хязгаарлашгүй болгодог. Тийм үү?

**Асуулт:** Та веган хоолны тухай ярьж болох уу? Веган хоол яагаад дэлхийд энх тайвныг авчирна гэж?

**Их багш:** Болно. Дэлхий ертөнцөд болж буй дайн дажны ихэнх нь эдийн засгийн шалтгаанаас үүсдэгийг харж байгаа биз дээ. Бид энэ бодит байдлыг илэн далангүй ярих хэрэгтэй. Ямар нэгэн улсад өлсгөлөн гарах, хүнс хоол дутагдах, эсвэл улс орнуудын хооронд хүнсийг тэгш бус хуваарилах зэрэг нь тухайн улсын эдийн засгийн хүндрэлийг улам

хурцатгадаг. Хэрэв та цаг гарган сэтгүүл уншиж, веган хоолны талаар үнэн зөв мэдээлэл хайвал үүнийг тун сайн мэдэх болно. Махны төлөө маламьдыг тэжээх нь эдийн засгийн олон салбарыг дампуурлын ирмэгт аваачиж, дэлхийн олон улсууд ялангуяа гуравдагч ертөнцийн орнуудыг өлсгөлөнд ихээр нэрвэгдүүлж байна. Энэ нь миний ч бодол биш, харин нэгэн америк хүн энэ талаар судалгаа хийж ном хэвлүүлсэн. Та нар аль ч номын дэлгүүрээс веган хоолны судалгааны болон технологийн ном материалыг уншиж болно. Жон Роббинсын “Шинэ Америкийн хоол хүнс” гэдэг номыг уншаарай. Тэр бол мөхөөлдөсний үйлдвэрийн саятан, тун нэртэй хүн. Тэрээр веган хоолны төлөө бүхнээ орхин, гэр бүлийнхээ уламжлал болон бизнесийнхээ эсрэг веган хоолны тухай ном бичсэн. Тэрбээр их хэмжээний мөнгө, нэр хүнд, бизнесээ алдсан ч Үнэний төлөө энэ бүхнийг хийсэн юм. Тэр тун дажгүй ном.

Веган хоолны тухай, веган хоол нь хэрхэн дэлхийд энх тайвныг авчирч буй талаар өгүүлсэн олон бодит мэдээлэл, баримт бүхий бусад ном, сэтгүүл олон байдаг. Үхэр бордохын тулд хоол хүнсээ үрэн таран хийж буйг та нар харж буй биз ээ. Нэг үхэр хоолны ширээн дээр зоог болохын тулд хэчнээн их уураг, эм, ус, хүн хүч, унаа хөсөг, зам тээвэр, ямар их газар гарздаж буйг та бүхэн мэдэж байгаа. Ойлгож байна уу? Эдгээр нөөцийг буурай хөгжилтэй орнуудад тэгш хуваарилсан бол өлсгөлөнгийн асуудлыг шийдэж чадах байсан. Хоол хүнсний хомсдолд орсон улс ард түмнээ аврахын тулд бусад улс орон руу түрэмгийлэл үйлдэж болзошгүй. Иймэрхүү байдал удаан үргэлжилбэл муу үр дагавартай. Ойлгож байна уу? “Үйл байвал үр байна”. Бид идэхийн төлөө бусдыг одоо хөнөөвөл хожим нь, эсвэл дараа төрөлдөө алуулж, тэдний хоол болно. Үнэхээр өрөвдөлтэй! Бид ийм ухаантай, соёл иргэншилтэй ч ихэнх маань хөрш орныхоо зовж зүдэрч буйг ойлгох чадваргүй байгаа нь ердөө л ходоодоо баярлуулах хэдхэн зүсэм махнаас болж байна. Ганц биеэ тэжээхийн тулд өчнөөн амь бүрэлгэж, олон хүнийг өлсгөдөг. Би энд амьтдын амь насны талаар дурдаагүй. Ойлгов уу? Санасан ч, санаагүй ч энэхүү гэм буруутай мэдрэмж нь бидний ухамсрын түвшнийг доош татаж, хорт хавдар, уушгины сүрьеэ, ДОХ зэрэг эдгэшгүй өвчтэй болгож байна. Яагаад танай Америкт хорт хавдрын өвчлөл хамгийн өндөр хувьтай байдаг вэ? гэж өөрсдөөсөө асуу. Учир нь америкчууд үхрийн махыг аль ч орноос илүү их иддэг. Яагаад Хятад болон бусад коммунист оронд хорт хавдраар өвчлөх нь бага байдаг вэ?. Энэ орнуудад мах олдох нь ховор. Ойлгож байна уу? Үүнийг би хэлээгүй судалгаа харуулж байгаа юм. Намайг бүү зэмлээрэй.

**Асуулт:** Веган хоолтон байснаар ямар ямар сүнслэг ашиг тусыг хүртэх вэ?

**Их багш:** Сүнслэг ашиг тусыг сонирхож байгаад чинь баярлаж байна. Ихэнх хүн веган хоолны тухай асуухдаа хооллолт, эрүүл мэнд, галбир төрхөө л боддог. Цэвэр ариун бөгөөд хүч үл хэрэглэдэг нь веган хоолны сүнслэг ашиг тус юм. Эзэн Бурхан: “Амь бүү тасал” гэж бидэнд анхааруулахдаа зөвхөн хүний амийг хөнөөж болохгүй гээгүй. Аливаа төрөлтийг бүү хөнөө гэсэн. Адгуус амьтдыг бидний анд нөхөр

болгон туслуулахаар бүтээсэн гэдгээ хэлсэн шүү дээ. Тэрээр биднийг амьтдыг харж харгалз гэсэн үг биш үү? “Тэдэнд санаа тавьж, хамааран харгалз” гэж хэлсэн. Та өөрийн ард иргэдээ захирч жолоодохдоо тэднийг алж иддэг үү? Тэгвэл хүрээлэх ардгүй хаан болно. Эзэн Бурхан яагаад ингэж хэлснийг одоо та ойлгосон байх. Бид үүнийг эргэлзээгүй дагах ёстой. Эзэн Бурхан маш тодорхой хэлсэн ч Өөрөөс нь өөр хэн Түүнийг ойлгосон юм бэ?

Иймээс Эзэн Бурханыг ойлгоё гэвэл та өөрөө заавал Эзэн Бурхан болох ёстой. Та бүгдийг Эзэн Бурхантай эргэн нэгдэж, өөрийнхөө хосгүй эзэн болохыг хүсэж байна. “Эзэн Бурханд сүсэглэн залбирах” нь Түүнийг тахин шүтэх биш харин өөрөө Эзэн Бурхан болж Түүнтэй нэгдмэл гэдгээ ухаарах явдал юм. Есүс Христ: “Би бол Эцэгтэйгээ нэгдмэл нэг” гэж хэлээгүй гэж үү? Хэрвээ Есүс тэгж хэлсэн юм бол бид ч Эзэн Бурханы хүүхэд учраас Түүний Эцэгтэй мөн л нэгдмэл нэг. Тэгээд ч биднийг Түүний хийж байгаагаас илүү хийж чадна гэж Тэр хэлсэн. Бид Эзэн Бурханаас ч илүү сайн байх боломжтой.

Бид Эзэн Бурханы талаар юу ч мэдэхгүй юм бол яагаад Түүнийг тахин шүтэх ёстой гэж? Яагаад сохроор итгэх ёстой гэж? Бид юу шүтэж байгаагаа эхлээд мэдэх ёстой. Яг л гэрлэхээсээ өмнө сүйт бүсгүй маань ямар хүн болохыг заавал мэдэх хэрэгтэй байдагтай адил. Орчин үед болзохгүй бол гэрлэдэггүй болсон. Тэгвэл бид яагаад Эзэн Бурханыг сохроор шүтэх гэж? Өөрийгөө харуулж, таниулахыг Эзэн Бурханаас шаардах эрх бидэнд бий. Бид шүтэх Бурханаа сонгох эрхтэй. Веган хоол идэх ёстойг Библид тодорхой өгүүлсэн. Эрүүл мэндийн талаас үзвэл бид веган хоол идэх ёстой. Шинжлэх ухааны олон нотолгоогоор бид веган хоолтон байх ёстой. Эдийн засгийн талаасаа ч бид веган хоолтон байх ёстой. Энэрэл нигүүлслийн үүднээс ч бид веган хоолтон байх ёстой. Мөн гараг дэлхийгээ аврахын тулд бид веган хоолтон байх ёстой. Барууны орнууд болон АНУ-д хүмүүс долоо хоногт ганц удаа веган хоол идвэл жил тутам арван зургаан сая өлсөж буй хүнийг аврах боломжтойг нэгэн судалгаанд дурджээ. Иймээс Баатар больё гэвэл веган хоол ид! Намайг дагаж энэ аргаар бясалгахгүй ч дээрх шалтгааны улмаас өөрийнхөө төлөө, дэлхий ертөнцийн төлөө веган хоол идэхийг та нараас хүсэж байна.

**Асуулт:** Бүх хүн ургамлаар хоолловол үр тарианы дутагдал үүсэх үү?

**Их багш:** Үүсэхгүй. Хүнсний зориулалттай тариалангийн талбайгаас хооллож буй хүний тоог ийм хэмжээний талбайд тарьсан тэжээлээр тэжээгдсэн мал амьтны махаар хооллож болох хүний тоотой харьцуулахад өмнөх нь 14 дахин их. Нэг акр газарт тарьсан хүнсний ургамал 800 ккал илчлэг өгөх бөгөөд үүгээр мал амьтан тэжээж мах үйлдвэрлэвэл ердөө 200 ккал болдог учраас алдагдал нь 600 ккал болно. Үүнээс харахад ургамлын гаралтай хоол хүнс нь махан хүнснээс эдийн засгийн илүү их үр ашигтай байна.

**Асуулт:** Веган хоолтон загас идэж болох уу?

**Их багш:** Та идмээр байгаа бол ид. Харин та веган хоол идэх



хүсэлтэй байвал загас бол ногоо биш.

**Асуулт:** Хүн сайхан сэтгэлтэй л байхад болно. Заавал веган хоолтон байх албагүй гэж хүмүүс байнга ярьдаг. Энэ үнэний хувьтай юу?

**Их багш:** Хэрэв сайхан сэтгэлтэй бол юунд хамаг амьтны махыг идэх вэ? Амьтны зовлонг хараад идэж зүрхлэхгүй бол сайн. Мах идэх нь энэрэл нигүүлсэлгүй хэрэг байтал юунд сайхан сэтгэл ярина вэ? Их Багш Лиэньчи: “Амийг хороож, махыг идэгчийг ертөнцийн хэлээр догшин хэрцгий сэтгэл, хорон муу санааны туйл гэх бус уу? Сайхан сэтгэл хаана байна?” гэжээ.

Мэнз: “Амьдгыг нь мэдэх бол үхэхийг нь үзэж үл түвдэх, дууг нь сонссон бол махыг нь идэж үл түвдэх. Эрхэм хүмүүн хэмээгч нь гал тогооноос хол байгтун” гэжээ.

Хүн төрөлхтний билиг ухаан амьтдынхаас илүү. Хүмүүс элдэв янзын багаж хэрэгслээр амьтдыг арга мухардуулдгаас хорсож үхдэг. Дорой буурай амьтдыг дарлан доромжлогч нь эрхэм хүн гэгдэх эрхгүй. Амьтад алагдахдаа тун их айн цочирдож, уурлан хорсогоос хорт бодис ялгаруулж махандаа шингээх бөгөөд идсэн хүнд муугаар нөлөөлнө. Үүний зэрэгцээ амьтны доогуур хэлбэлзэл биднийг доош татаж, оюуны хөгжилд муу нөлөө үзүүлдэг.

**Асуулт:** Махтай хольж чанасан ногоог идэж болох уу?

**Их багш:** Болохгүй. Хэрэв хоолоо хоронд дүрээд идвэл хордох үү, үгүй юү? “Нирваан судар”-т Махакашьяпа Шагжамуни Буддагаас: “Бадар бариад махтай хольсон хүнс олбол идэж болох уу? Үүнийг яаж цэвэрлэх вэ?” гэхэд Будда: “Эхлээд ногоог нь махнаас ялгаж усаар угаагаад идэж болно.” гэжээ. Үүнээс мах идэх нь бүү хэл, махтай хольсон ногоог ч угааж цэвэрлэхгүйгээр идэж болохгүй гэдэг нь тодорхой байна. Эндээс мөн Шагжамуни Будда болон түүний шавь нар бүгд цагаан хоолтон байсныг мэдэж болно. Гэтэл өглөгийн эзэд махаар өргөл өргөвөл идчихдэг байсан гэж Шагжамуни Буддаг гүтгэж байсан. Энэ бол үнэмшилгүй яриа бөгөөд ном судар бага уншсан, эсвэл агуулгыг нь буруу ойлгосонтой холбоотой. Энэтхэгчүүдийн ер гаруй хувь нь цагаан хоолтон болохоор шар хувцастай хүн бадар баривал тэдэнд зөвхөн цагаан хоол өгөх ёстойг бүгд мэддэг.

Тэгээд ч гэрт нь өргөл болгох мах байхгүй.

**Асуулт:** Шагжамуни Будда гахайн шийр идсэнээс гэдэс нь гүйлгэж өвдсөн гэж нэг багш ярихыг урьд нь сонссон. Энэ үнэн үү?

**Их багш:** Огт үгүй. Шагжамуни Будда нэг зүйлийн мөөг идсэнээс болж нас нөгчжээ. Мөөгний нэрийг самгарди хэлнээс үгчлэн орчуулбал гахайн шийр гэсэн утгатай ч жинхэнэ гахайн шийр биш. Энэ нь нэгэн төрлийн жимсийг “лунянь” (хятадаар луугийн нүд гэсэн үг) гэдэгтэй адил. Луугийн нүд гэх мэт махны нэртэй олон зүйл байдаг ч үнэндээ веган хүнс байдаг. Учир нь тэр мөөг гахайтай холбоотой болохоор самгардиар “гахайн шийр” буюу “гахайн баясал” гэдэг. Эртний энэтхэгт энэ мөөг ховор нандин, идээний дээд байсан тул чин сэтгэлтэй хүмүүс Шагжамуни Буддад өргөл болгодог байжээ. Энэ мөөг ил ургадаггүй тул ольё гэвэл түүнд дуртай хөгшин гахайг ашигладаг байв. Гахай мөөгийг

үнэрээр нь олоод туурайгаараа ухаж гаргана. Иймээс л энэтхэгт түүнийг “гахайн шийр” буюу “гахайн баясал” гэж нэрлэдэг. Үнэндээ энэ хоёр нь нэг л мөөгний нэр. Харин хайнга орчуулснаас, бас уг домгийн агуулгыг гүнзгий сайн ойлгоогүйгээс хойч үеийнхэн Түүнийг мах иддэг байсан мэтээр ташаа ойлгоход хүрчээ. Энэ бол үнэхээр харамсмаар зүйл.

**Асуулт:** Зарим махсаг хүн бусдын бэлдсэн махыг авч иддэгээ зөвтгөж, өөрийгөө амьтны амь хөнөөгөөгүй гэдэг. Энэ зөв үү?

**Их багш:** Энэ бол маш том алдаа. Мах иддэг хүмүүс байгаа учраас яргачид амьтан алдаг. “Ланкаватара” сударт Шагжамуни Будда: “Их билгээр үзвэл яргачдын ихэнх нь хүнд идүүлэхийн тулд амь хороодог. Хүн мах идэхгүй бол амь хороох явдалгүй болно. Тиймээс мах идэх нь амь хороохтой адил гэмт явдал мөн” гэжээ. Амьтны амийг ихээр хороосноос байгалийн гамшиг, хүний зовлон ихсэж байна. Дайн дажин дэгдэж байгаа нь ч асар их аллагын үйл лайнаас үүдэлтэй. (Эх сударт өгүүлсэн нь: “Их билгээр үзвэл аливаа аллагын ихэнх нь хүн мах иддэгээс болсон. Хүн мах идэхгүй бол аллага үгүй. Иймийн учир мах идэх хийгээд аллага үйлдэхийн ял адил болой”).

**Асуулт:** Ургамал нь шээсний хүчил, урокинез зэрэг хорт бодис үүсгэн хүний биеийг хордуулдаггүй ч пестицид (шавжийн хор) ихтэй тул биед сайнгүй гэж зарим хүн ярьдаг. Энэ үнэн үү?

**Их багш:** Хэрэв тариалангийн талбайд пестицид болон ДДТ зэргийг хэрэглэсэн бол эдгээр нь асар хүчтэй хорт бодис бөгөөд хорт хавдар, үргүйдэл, элэгний өвчин үүсгэдэг. ДДТ зэрэг нь өөх тосонд уусдаг тул амьтны өөхөнд хадгалагддаг. Та мах идэх үедээ дор хаяж 15 сар өөхөнд нь хуримтлагдсан өндөр концентрацитай пестицид болон бусад химийн хорт бодисуудыг хамт иддэг. Энэ ДДТ нь жимс ногоо, үр тарианд байх хэмжээнээс арван гурав дахин их байдаг. Ургамалд цацсан хорыг угаан цэвэрлэж болно. Харин амьтны өөхөнд хуримтлагдсан хорыг яаж ч угаасан арилахгүй. Пестицид болон бусад хорт бодисууд нь тасралтгүй хуримтлагдан ихэсдэг тул хүнсний үйлдвэрлэлийн эцсийн шатны хаан-хэрэглэгч хамгаас илүү хохирогч болдог. Айова муж улсын Их сургуульд хийсэн туршилтаар хүний бие дэх пестицидийн ихэнх нь мах идсэнээс болдгийг нотолжээ. Цагаан хоолтнуудын биед буй пестицидийн хэмжээ нь махан хоолтнуудын бие дэх пестицидийн хэмжээний талд нь ч хүрэхгүй байгааг илрүүлжээ. Үнэн хэрэгтээ маханд байгаа хорт бодис зөвхөн үүгээр тогтохгүй. Малыг тэжээх явцад маш олон химийн бордоо өгч өсөлтийг нь хурдасгах юм уу махны өнгө, амт, ширхэглэгийг сайжруулан, муудаж ялзрахаас хамгаалдаг.

Жишээ нь, нитратаас гаргаж авсан нөөшлөгч бодис нь асар хортой. 1971 оны 7-р сарны 18-ны өдрийн “Нью Йорк Таймс” сонинд “Хүнс хэрэглэгчдийн эрүүл мэндэд учирч буй асар том нуугдмал аюул бол сальмон загасны нян, пестицид, нөөшлөгч бодис, элдэв даавар, антибиотик болон бусад химийн бодисын үлдэгдэл зэрэг үл үзэгдэгч бохирдол юм” гэж мэдээлжээ. Үүнээс гадна малд тарьсан өвчнөөс сэргийлэх вакцин маханд ч бас хадгалагддаг. Харин 56% хүртэлх усанд уусдаггүй бохирдолтой махан бүтээгдэхүүнийг бодвол ястай самар,

буурцагт ургамал, үр тарианаас авч буй уураг нь илүү цэвэр юм. Дээрх хиймлээр гаргасан нэмэлт бодисууд нь хорт хавдар болон бусад өвчин, ургийн гаж хөгжлийн шалтгаан болдгийг судалгааны итгэлд дурджээ. Иймээс жирэмсэн эмэгтэйчүүд шинээр төрсөн хүүхдийн биеийн болон оюуны эрүүл мэндийг хамгаалъя гэвэл цэвэр веган хоол хүнс идэх хэрэгтэй. Та уургаа буурцагт ургамлаас, амин дэм болон эрдэс бодисоо ногоон өнгийн навчит ургамал болон жимс жимсгэнэ ахиу идсэнээр авна.

## АВШИГ ХҮРТЭХҮЙ - АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг сэтгэлийн авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон сүнслэг бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Shabd”, “Дао”, “Аялгууны урсгал”, “ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, сэтгэлийн авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Сэтгэлийн авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь сэтгэлийн авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Сэтгэлийн авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан сэтгэлийн авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг

бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Сэтгэлийн авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Насаараа веган хоолтон байх нь сэтгэлийн авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь сэтгэлийн авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал сэтгэлийн авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгаж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

## ТАВАН САХИЛ

1. Амьтны амь хөнөөхийг цээрлэнэ;\*
2. Худал хэлэхийг цээрлэнэ;
3. Хулгай хийхийг цээрлэнэ;
4. Зүй бус бэлгийн харилцааг цээрлэнэ;
5. Архи, тамхи, мансууруулах зүйл хэрэглэхийг цээрлэнэ;\*\*

\* Энэ сахилыг сахигч нь цэвэр веган хоолтон байх ёстой. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, тахиа, өндөг (үр тогтсон болон тогтоогүй өндөг, өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

\*\* Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, компьютер тоглоом тоглох зэрэг зүйлээс зайлсхийх явдал багтана.

## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр**

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-7), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Түвд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт**

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1,2) Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа**

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**

Ау Лак (1-2), Хятад (1-2)

### **1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл**

Англи (1), Ау Лак (1)

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал**

Англи (1-6), Хятад (1-6)

### **Багш үлгэр ярьж байна**

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

### **Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдийг ухаарахуй**

Англи, Ау Лак, Хятад

### **Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам**

Англи, Ау Лак, Хятад

### **Амьдралаа солонгоруулья**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

### **Эрүүл мэндээ ухаарахуй Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг**

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

Англи/Хятад (ном + CD)

**Онч мэргэн үгс (1)**

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман,

Англи/Солонгос, Англи/Япон

**Онч мэргэн үгс (2)**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрлэг зоог - Олон улсын ургамал хоолны гал тогоо**

Англи/Хятад, Ау Лак, Япон

**Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт**

Англи/Хятад

**Тэнгэрийн урлаг**

Англи, Ау Лак, Хятад

**Жинхэнэ хайр**

Англи, Хятад, DVD, MP4

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)**

Англи/Ау Лак/ Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог**

Англи/Ау Лак/Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог**

**Уран зургийн цувралууд**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрийн хувцас**

Англи/Хятад

**Шувууд миний амьдралд**

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц,

Хятад



**Эрхэм ариун амьтад**

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

**Чимээгүй нулимс**

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

**Вуузуу шүлгүүд**

Англи, Ау Лак, Хятад

**Мартагдсан дурсамж**

Англи, Ау Лак, Хятад

**Хайрга ба Алт**

Англи, Ау Лак, Хятад

**Эрвээхэйн мөрөөдөл**

Англи, Ау Лак, Хятад

**Өмнөх амьдралын зам мөр**

Англи, Ау Лак, Хятад

**Хуучин цаг**

Англи, Ау Лак, Хятад

**Эрин зууны хайр**

Англи, Ау Лак, Хятад

**Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**

Англи, Хятад, CD, DVD, MP4

**Амьдрал болоод ухамсрын тухай бодрол**

Доктор Жанезын бичсэн ном, Хятад хэл дээр

**Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс**

<http://crisis2peace.org> хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

*Бусад айлдварууд болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр хэвлэгджээ.*

## БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

### Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХУ  
(36899)  
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-  
0247, АНУ

### Суприм Мастер Телевиз

И-мэйл: Peace@SupremeMasterTV.com  
Утас: 1-626-444-4385  
Факс: 1-626-444-4386

### Ном орчуулгын групп:

И-мэйл: divine@godsdirectcontact.org  
(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд  
оролцож болно.)

### Мэдээний групп:

И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

### S.M. Celestial Co., Ltd:

И-мэйл: smclothes123@gmail.com;  
Vegann@hotmail.com  
Утас: 886-3-4601391  
Факс: 886-3-4602857  
Веб сайт: <http://www.smcelestial.com>  
<http://www.sm-celestial.com>

### Асуулт харнултын баг:

И-мэйл: [lovewish@godsdirectcontact.org](mailto:lovewish@godsdirectcontact.org)

### Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэл ХХК

И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org  
Утас: 886-2-23759688  
Факс: 886-2-23757689 <http://www.smchbooks.com>

### Онлайн дэлгүүр

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)  
Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад)

**Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр**

<http://www.lovingfood.com.tw>

**”Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ  
ресторан**

И-мэйл: [service@lovinghut.com](mailto:service@lovinghut.com)

Утас: 886-3-4683345

Факс: 886-3-4681581

Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

**Гуань Инь веб сайтууд**

Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

[https://www.godsdirectcontact.org.tw/en2/index.php#related\\_links](https://www.godsdirectcontact.org.tw/en2/index.php#related_links)

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Гуань Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэлээр “Агшин Зуур Гэгээрэхийн түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

**Суприм Мастер Телевиз**

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг:

<http://suprememastertv.com/mn1/>

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-г олон хэлээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэлээр)**

<http://sb.godsdirectcontact.net>

<http://www.direkter-kontakt-mit-gott.org/booklet>

<http://www.godsdirectcontact.com/sb/index.html>

## АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР-2

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэг Publishing Co., Ltd.

Хаяг: Тайбэй хот, Жонгжэнг дүүрэг, Жонгсьаогийн баруун зам, 1-р мухар гудам, 16 давхар барилгын 8-р давхар, 72 тоот

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл: [smchbooks@Godsdirectcontact.org](mailto:smchbooks@Godsdirectcontact.org)

<http://www.smchbooks.com>

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2015

Зохиогчийн эрх эзэмшигч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Уг номын агуулгыг дахин хэвлүүлэх нээлттэй бөгөөд, үүний тулд эхлээд нийтлэгч компаниас зөвшөөрөл авах ёстойг анхаарна уу.

2 дугаар боть:

1 дэхь хэвлэл 1987.09.01.

2 дахь хэвлэл 1988.01.25.

3 дахь хэвлэл 1992.12.15.

4 дэхь хэвлэл 1994.02.10.

5 дахь хэвлэл 1995.03.01.

6 дахь хэвлэл 1988 оны 10 дугаар сар

7 дахь хэвлэл 2002 оны 11 дүгээр сар

8 дахь хэвлэл 2009 оны 7 дугаар сар

9 дахь хэвлэл 2012 оны 6 дугаар сар

Хялбаршуулсан Хятад хэл дээр бичигдсэн хэвлэл 2015 оны 9 дүгээр сар

Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2023 оны 2 дугаар сар

Цахим хувилбар: <http://www.gegeerel.mn/> 2023 оны 4 дүгээр сар

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай) - Дахин хэвлэл-

Тайпей хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг, 1998 「Хятадын тооллоор 87 он」

1-р боть; 13x19 см

978-957-98468-7-5 (Боть 2: Хатуу хавтастай)

1. Сүнслэг дадал бясалгал      2. Оюун санааны амьдрал

192.1

87012594

Үнэн ёсыг хайх явцад туулсан өмнөх зүдгүүрт аялалаасаа шавь бид энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их Багштай уулзахад бэрх, жинхэнэ номыг хүртэхэд хэцүүг гүнзгий ухаарсан билээ. Энэ бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлан ирсэн хамгийн дээд номын судас учраас хүний уг чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн ёсыг ойлгуулна. Энэ аргаар бясалгаад бид арвин их ололтыг олсон тул Бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан айлдваруудыг эмхтгэн ном болгож, энэ төрөлдөө үхэж, төрөхийн сансрын хүрднээс гэтлэхийг хүссэн, үнэн ёсыг хайсан, амь нас, үхэж төрөх, бясалгал гэгээрэл, үнэн ёсны талаарх ойлгохгүй асуултууддаа хариулт авахыг хүссэн хүмүүст туслахыг зорилоо.